Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

Женев

ХӨДӨӨГИЙН УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ СУРГАЛТ

Хөдөөгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх сургалтын үндсэн гарын авлага (ХЭЗЧДС)

Хөдөөгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт

Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх
сургалтын үндсэн гарын авлага (ХЭЗЧДС)

Хөдөөгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт

Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын үндсэн гарын авлага (ХЭЗЧДС)

Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн газар

Зохиогчийн эрх (CD-ROM)

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2009
2009 онд анх удаа хэвлэв.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүтээлүүд Зохиогчийн эрхийн тухай Түгээмэл Конвенцийн 2-р Протоколд заасны дагуу зохиогчийн эрхийг эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Номыг дахин хэвлэх, орчуулах эрхийг авахын тулд Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) дараахь хаягаар хандана уу: International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland, элэктрон шуудангийн хаяг: pubdroit@ilo.org

Нэгдсэн Вант Улс дахь Зохиогчийн эрхийн зөвшөөрлийн агентлаг, хаяг: Tottenham Court Road, London W1T 4LP [Факс: (+44) (0)20 7631 5500, э-шуудан: cla@cla.co.uk]; АНУ дахь Зохиогчийн эрхийг баталгаажуулах төв, хаяг: 222 Rosewood Drive, Danvers, MA 01923 [Факс: (+1) (978) 750 4470, э-шуудан: info@copyright.com] болон бусад орон дахь зохиогчийн эрхийн байгууллагуудад бүртгэгдсэн номын сан, байгууллага, хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно.

Хөдөөгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт. Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын үндсэн гарын авлага (ХЭЗЧДС)
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, 2011

ISBN 978-92-2-822693-5 (CD-ROM)

Түүнчлэн англи хэлээр Rural skills training: a generic manual on training for rural economic empowerment (TREE)
(1 v. ISBN 978-92-2-122329-0 (print), ISBN 978-92-2-122330-6 (web pdf), ISBN 978-92-2-122693-2 (CD-ROM), International Labour Office. – Geneva: ILO, 2009) хэвлэгдсэн.

ILO Cataloguing in Publication Data

Нэгдсэн Үндэстний Байгууллагын журмын дагуу ОУХБ-аас хэвлэн нийтэлж буй бүтээлийг зохиоход ажиллуулсан хүмүүс болон түүнд дурьдсан материалууд нь аль нэг улс, газар нутаг, тэдгээрийн захиргааны эрх зүйн байдал болон хил хязгаарын талаар Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны зүгээс ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Зохиогчийн нэрээр хэвлэгдсэн аливаа нийтлэл, судалгаа, бусад бүтээлүүдэд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд хэвлэн нийтэлсэн нь түүнд илэрхийлсэн үзэл бодлыг ОУХБ-аас дэмжиж сайшаасан гэсэн утгыг агуулахгүй.

Бүтээлд пүүс, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдсанаар тэдгээрийг ОУХБ-аас хүлээн зөвшөөрсөн хэрэг биш бөгөөд харин ямар нэгэн пүүс, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг дурьдахгүй өнгөрснөөр тэдгээрийг үл зөвшөөрснийг илтгэхгүй.

ОУХБ-аас хэвлэн нийтэлсэн материалуудыг томоохон номын дэлгүүрүүд болон олон оронд байгаа ОУХБ-ын товчоодоос, эсвэл ОУХБ-ын хэвлэлийн газраас дараах хаягаар авч болно: ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland. Шинэ бүтээлүүдийн жагсаалт буюу каталогийг дээрх хаягаар буюу pubvente@ilo.org гэсэн цахим шуудангаар хандаж үнэ төлбөргүй авах боломжтой.

Манай вэб сайтад зочилно уу: www.ilo.org/publns.

Монголд хэвлэв.

Гарчиг

Өмнөх үг 12

Талархал 14

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

БҮЛЭГ I
ХЭЗЧДС-ын арга зүйн оршил

Оршил

I. ХЭЗЧДС-ын арга зүйн товч танилцуулга

1. ХЭЗЧДС-ын арга зүйн тодорхойлолт 20
2. ХЭЗЧДС-ын зүйг зохистой байдал 20
3. Тогтолцоо, дэвшил, үйл ажиллагаа болон арга хэрэгсэл 21
4. ХЭЗЧДС-ыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд анхаарах гол хүчин зүйлс 25
5. Байгууллага, зохион байгуулалтын тогтолцоо 27
6. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн санхүүжилт 28
7. Тогтвортой байдал 28

II. Олон улсын хөдөлмөрийн байгууллага ба бусад оролцогчдын үүрэг оролцоо

Оршил

I. Тогтолцоо болон төлөвлөлт
1. Үндэсний тогтолцоо 33
2. Орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулах тогтолцоо 34

II. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах нь

Хавсралтууд
Хавсралт 2.1 ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн бичиг баримтын агуулга 44
Хавсралт 2.2. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцөд тавигдах шаардлагын үлгэрчилсэн загвар 47
Хавсралт 2.3. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийг сонгоход санал болгож буй шалгуур үзүүлэлтүүд 50
Хавсралт 2.4. Түнш байгууллагуудтай ярилцахад санал болгож буй сэдвүүд 51
Хавсралт 2.5. Түнш байгууллагуудыг сонгоход санал болгож буй шалгуур үзүүлэлтүүд 53

БҮЛЭГ III

Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох

I. Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны зорилго

II. Нийгэм эдийн засгийн судалгааг явуулах үе шатууд
Үе шат 1. Зах зээлийн боломжийг судлах 57
Үе шат 2. Оролцогч талуудтай судалгааны үр дүнг хэлэлцэх нь 59
Үе шат 3. Нөхцөл байдлын судалгаа 61
Үе шат 4.Сургалтын хэрэгцээг судлах 63

III. Дагалдах үйл ажиллагаа

Хавсралтууд
Хавсралт 3.1. Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс 64
Хавсралт 3.2. Орон нутгийн судалгаа (үлгэрчилсэн загвар, арга хэрэгсэл) 66
Хавсралт 3.3. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа (үлгэрчилсэн загвар) 80
Хавсралт 3.4. Зах зээлийн боломжийн судалгаа (үлгэрчилсэн загвар) 86
Хавсралт 3.5 Нөхцөл байдлын судалгааны загвар (үлгэрчилсэн загвар) 100
Хавсралт 3.6 Нөхцөл байдлын судалгааны товч тайлангийн жишээ, Бангладеш 105
Хавсралт 3.7. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн боломж болон нөхцөл байдлыг тодорхойлоход санал болгож буй удирдамж 111
Хавсралт 3.8 Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны загвар асуулга 113

Хавсралт 3.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох загвар (Пакистаны ХЭЗЧДС-ын хөтөлбөр боловсруулсан загвар) 115
Хавсралт 3.10 ХЭЗЧДС-ын Энэтхэгт хэрэгжсэн хөтөлбөрийн санал болгож буй загвар 119

БҮЛЭГ IV

Сургалтын загвар, зохион байгуулалт ба сургалт явуулах нь

Оршил

I. Сургалтын дамжааны төлөвлөлт ба бэлтгэл ажил

1. Сургалтын дамжааны төлөвлөгөө боловсруулах 123
2. Сургагч нарыг тодорхойлох, сонгох, бэлтгэх 124
3. Сургагчийг бэлтгэх 125
4. Сургалтад хамрагдагчдыг сонгох 126
5. Хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон сургалтын материал бэлтгэх 127

II. Сургалтын зохион байгуулалт

1. Үйчлүүлэгчийн сургалт 128
2. Бүлгийн сургалт 128
3. Жендерийн асуудал 129
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 129
5. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 129

Хавсралтууд

Хавсралт 4.1. Сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар; Автомеханик (бензин хөдөлгүүртэй), 312 цаг (60 өдөр) 131
Хавсралт 4.2. Сургагчийн анхан шатны үйл ажиллагааны арга зүйн удирдамж 136
Хавсралт 4.3. Сургагч багшийн ур чадварын сургалтын төлөвлөгөө боловсруулах удирдамж 145
Хавсралт 4.4. Ур чадварын сургалтын төлөвлөгөөний загвар 148
Хавсралт 4.5. Ур чадварын сургалтад хамрагдагчдын бүртгэлийн загвар 149
Хавсралт 4.6. Сургалтын явцын тайлан 150
Хавсралт 4.7. Сургагчийн тайлан (төгсөлтийн тайланд хавсаргах) 151
Хавсралт 4.8 Төгсөлтийн тайлан 152

БҮЛЭГ V

Сургалтын дараа бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Оршил

I. Сургалтын дараах дэмжлэг

1.1 Сургалтын дараах дэмжлэгийн төлөвлөгөө 156
1.2 Сургалтын дараах үйлчилгээний сүлжээг хөгжүүлэх 156
1.3 Сургалтын дараах хэрэгцээг тогтмол тодорхойлох 156

II.Цалинтай хөдөлмөр эрхлэлт эхлэхэд дэмжлэг үзүүлэх нь

III. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь

3.1. Жижиг бизнесийг эхлэх үйл ажиллагааг дэмжих 158
3.2. Зээл авахад үзүүлэх дэмжлэг 158
3.3. Үйлдвэрлэл явуулах зориулалт бүхий байр олох 160
3.4. Багаж, тоног төхөөрөмж 160
3.5. Зах зээлийн дэмжлэг 160
3.6. Хууль зүйн зохицуулалтын шаардлагад нийцүүлэх 162
3.7. ХЭЗЧДС-ын төгсөгчдийн аж байдалтай танилцах 162
3.8. Хамтарсан бүлгээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх 163

Хавсралтууд

Хавсралт 5.1. Бангладешийн сургалтын дараах дэмжлэгийн загвар төлөвлөгөө 164
Хавсралт 5.2. Бичил үйлдвэрлэлийн болзошгүй зээлийн эх үүсвэрүүд 165
Хавсралт 5.3. Бичил санхүүгийн байгууллагын хүчин чадлыг тодорхойлох 166
Хавсралт 5.4. Зээлийн баталгааны сан 167
Хавсралт 5.5. Сургалтын дараах хяналт-шинжилгээ болон бичил үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах загвар (эхлэл, үйлдвэрлэл, зах зээл, санхүү) 168
Хавсралт 5.6. Бүлгийн үйл ажиллагааны загвар 173
Хавсралт 5.7. Хадгаламж зээлийн үйл ажиллагааг хамтран эрхлэх бүлгийн удирдамж 174

БҮЛЭГ VI

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, баримтжуулалт

Оршил

I. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

1.1 Хяналт –шинжилгээ 175
1.2 Үндэсний түвшний хяналт-шинжилгээ хийх 176
1.3. Орон нутгийн түвшний хяналт-шинжилгээ 176
1.4. Сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх 176
1.5. Сургалтын дамжаанд хяналт-шинжилгээ хийх 177
1.6. ХЭЗЧДС-ын сургалтын явцад хяналт-шинжилгээ хийх 177
1.7. Төгсөгчдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх 177

II. Үнэлгээ

III. Бичиг баримтын хөтлөлт

3.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн мөчлөг бүрт хамаарах тайлангууд 179
3.2. Ахиц дэвшлийн тайлан 181

Хавсралтууд

Хавсралт 6.1 Хэрэгжилтийн явцын мэдээллийн хүснэгт (үлгэрчилсэн загвар) 182
Хавсралт 6.2. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө (үлгэрчилсэн загвар) 184
Хавсралт 6.3. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ 188
Хавсралт 6.4. Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгаа 194
Хавсралт 6.5. Төгсөгчдийн үйл ажиллгааны судалгааны загвар (үлгэрчилсэн загвар) 196
Хавсралт 6.6 Үр дүнд хяналт шинжилгээ хийх судалгааны тайлангийн загвар (ХЭЗЧДС, Филиппин) 197
Хавсралт 6.7. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа жижиг үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлж байгаа төгсөгчийн нөхцөл байдлын судалгааны аргачлал 198
Хавсралт 6.8. Орон нутагт хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх (Филиппин улсад хэрэгжсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар) 204

ХОЁРДУГААР ХЭСЭГ

БҮЛЭГ VII
Жендерийн талаарх мэдлэг болон нөлөөлөл

Оршил

I. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх цалинтай хөдөлмөр эрхлэлтийн боловсрол, сургалтын явцад тулгарах жендерийн асуудал, бэрхшээлүүд

II. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд жендерийн асуудалд хандах стратеги

2.1 Хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэгч байгууллага болон төлөвлөлтийн жендерийн асуудлын гол чиг хандлага 212
2.2 Эдийн засгийн боломж, сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаан дахь жендерийн тэгш эрхийн асуудлын гол чиг хандлага 215
2.3 Жендерийн асуудлыг зохицуулсан сургалтын загвар, төлөвлөлт, зохион байгуулалт 218
2.4 Жендерийн талаарх мэдлэг, ажиллах орчны талаарч сургагчийн сургалт 218
2.5 ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй хамтран ажиллагч сургалтын байгууллагад эмэгтэй суралцагчийн тоог нэмэгдүүлэх 219

Хавсралтууд

Хавсралт 7.1 Жендерийн холбогдолтой ойлголтуудын тайлбар 220
Хавсралт 7.2 Боловсрол, сургалт, бичил үйлдвэрлэлийн хөгжил болон цалинтай хөдөлмөр эрхлэлт дахь жендерийн асуудал болон шаардлага 221
Хавсралт 7.3 Эрх тэгш байдал, ядуурлын эсрэг чиг хандлага 224
Хавсралт 7.4. Жендерийн дүн шинжилгээнд анхаарах зарим асуудал 225
Хавсралт 7.5 Бангладешийн чадавхжуулах хөтөлбөрийн хүрээн дэх Жендерийн эрхийг хамгаалах орон нутгийн оролцоонд суурилсан сургалтын төсөл: Зохион байгуулагч болон түнш байгууллагууд, орон нутгийн багуудын жендерийн талаарх мэдлэг болон нөлөөллийг нэмэгдүүлэх 226
Хавсралт 7.6. “Ажлын байр ба жендерийн асуудал” гарын авлагаас (Бангладешийн туршлага) 229
Хавсралт.7.7. Жендерийн асуудалд дундыг баримтласан мэдээлэл, жендерт хандсан мэдээллийг харьцуулах нь 230
Хавсралт 7.8 Жендер ба ур чадварын судалгааны тайланд дүн шинжилгээ хийх 231

БҮЛЭГ VIII

ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах

Оршил

I. Ерөнхий мэдээлэл болон бэрхшээлүүд 234

II. Хөгжлийн бэрхшээл ба хүний эрх 235

III. Ур чадварын сургалт болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 236

IV. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үе шат бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах 241

Хавсралтууд

Хавсралт 8.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зөвлөмж, лаглагаа 251
Хавсралт 8.2 Хамтын ажиллагаа болон дэмжсэн үйл ажиллагааны бүдүүвч 252
Хавсралт 8.3 Зохистой хэл яриа 254
Хавсралт 8.4 Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сургалтын аргууд (хүсэлт) загвар 255
Хавсралт 8.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах 261
Хавсралт 8.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд 262
Хавсралт 8.7 Нэр, томъёо 264

Өмнөх үг

Олон улсын хөдөлмөрийн 92 дугаар Чуулганаас (Женев хот, 2004 оны 6 дугаар сарын 17-ны өдөр) баталсан ОУХБ-ын Хүний Нөөцийн Хөгжил: боловсрол, сургалт болон сургалтын хэрэгцээний тухай 195 дугаар Зөвлөмж нь ядуурлыг бууруулах, хөдөөгийн ядуу иргэд болон тэдгээрийн оршин суух орон нутгийн нийгэм-эдийн засгийн чадавхийг сайжруулахтай холбогдох бусад арга хэмжээнүүдийн зэрэгцээ ур чадварыг нэмэгдүүлэхэд хандсан шинэлэг хандлагыг баримтлан ажиллахыг уриалсан. Мөн Олон улсын хөдөлмөрийн 97 дугаар Чуулганы (Женев хот, 2008 оны 6 дугаар сарын 9-ний өдөр) Ур чадварын хорооны дүгнэлтэд: ”Ялангуяа хөдөө орон нутагт боловсрол олж авах болон сургалтад хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг. Хөдөөгийн хөгжлийн тухайд: дэд бүтцийг сайжруулах, хүн амын ур чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх болон ажлын байрыг бий болгох гэсэн үндсэн гурван зорилт тусгагдсан байдаг. Энэхүү зорилтод хүрэхийн тулд боловсролын чанарыг сайжруулах аргатай хослуулах хэрэгтэй.“ гэж цохон тэмдэглэсэн байна.

ОУХБ-ын Үр өгөөжтэй ажил, ур чадвар болон ажил эрхлэлтийн газраас дээр дурьдсан санааг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын (цаашид ХЭЗЧДС гэх) гарын авлагыг аргачлалаар хангах зорилго бүхий техникийн болон зөвлөхийн туслалцааг дэмжиж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсаар ирсэн. Сургалтын энэхүү системчилсэн арга зүйг тухайн орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн боломж, улмаар ядуу эмэгтэйчүүд ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг эмзэг бүлгүүдийн оролцоог хангах, тэдгээрт хөдөлмөр эрхлэх бололцоо бий болгосноор эдийн засгийн чадавхийг нь нэмэгдүүлэхтэй уялдуулан боловсруулснаараа онцлог юм.

Гарын авлага нь ХЭЗЧДС аргачлал дээр суурилан үндэсний хэмжээний хөтөлбөрийн загварыг бий болгох, улмаар хөдөөгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх сургалтыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд чиглэл

өгөх эх сурвалж болно. Гарын авлага нь ОУХБ-ын ХЭЗЧДС-ын төслийг хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааны туршлагуудыг багтаасан бөгөөд аливаа төсөлд хамаарах ядуу иргэд болон тэдний оршин сууж буй орон нутгийн чадавхийг нэмэгдүүлэх сургалтын төлөвлөлт, загвар, хэрэгжилтийг хангах улмаар сургалтын дараах дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн чиг хандлагыг баримжаалах болон тодорхойлоход тус дэм болох зорилготой билээ. Энэ нь ХЭЗЧДС-ын аргачлал дээр суурилсан ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах энгийн, ойлгомжтой хэлбэрээр боловсруулагдсан гарын авлага юм. Тэрээр ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг ядуурлыг бууруулах болон чадавхийг нэмэгдүүлэх стратегийн нэгээхэн хэсэг болох төслийн удирдлага, хэрэгжүүлэгч түншүүдэд дэмжлэг болохуйц зааварчилгаа, аргачлал болон бусад хэрэгслийг агуулж байна. Гэхдээ, ХЭЗЧДС-ын төсөл нь хөдөлмөр эрхлэлттэй холбогдох арга зүй, хэрэгсэлтэй уялдаа холбоотойгоор ашиглавал илүү ур дүнд хүрнэ гэдгийг дурьдах нь зүйтэй. Иймээс төслийг хэрэгжүүлэхдээ ОУХБ болон бусад холбогдох байгууллагуудаас нэвтрүүлсэн ажил туршлага, арга, аргачлалыг түлхүү хэрэглэх нь зүйтэй.

Гарын авлагыг ОУХБ-ын идэвхитэй гишүүд болох Бангладеш, Пакистан, Филлипин, Камбож, Мадагаскар зэрэг орнууд түүнчлэн ОУХБ-ын байгууллагын Сургалт ба хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн, шинжээчид, түншүүдийн оролцоотойгоор бүтээсэн билээ.

Бид Гарын авлага бүтээхэд хувь нэмрээ оруулсан дээр дурьдсан байгууллага болон хувь хүмүүст туршлагаасаа хуваалцаж, биднийг зааварчилгаа болон арга зүйн зөвлөмжүүдээр хангасанд гүнээ талархал илэрхийлж байна. Энэхүү Гарын авлага нь хөдөө орон нутгагт ядуурлыг бууруулах болон эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үндэсний байгууллагуудад ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулах ба сургалтын дараах дэмжлэг туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн газрын захирал
Кристине Еванс-Клок

Талархал

ОУХБ-ын Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн газраас Орон нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын гарын авлага бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан дараах хувь хүмүүс болон байгууллагуудад талархал илэрхийлэхийг хүсэж байна. Үүнд:

Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн газрын захирал, хатагтай Кристине Еванс-Клокийн удирдлага, дэмжлэг, гарын авлагыг эцэслэн боловсруулж, хянан тохиолдуулсан хатагтай Кармела Ай, Торрес ба ноён Жеймс Винделл, хэвлэлийн өмнөх шатны форматыг эцэслэн хийсэн хатагтай Евелин Ралп нар болно.

Гарын авлага бүтээхэд ОУХБ-ын сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн зөвлөхүүд, тэр тусмаа ноён Тревор Риордан, ноён Руди Балдемор, ноён Слав Коровкин, ноён Манзуур Халик, хатагтай Жинко Накаяма, хатагтай Жозиане Капт, хатагтай Дебра Перри, ноён Гирма Агюне, ноён Кристиан Жоссеин болон ноён Афонсо Реис нар болно.

ХЭЗЧДС-ыг бүтээхэд санхүүжилтын дэмжлэг үзүүлж хамтран ажилласан АНУ-ын Хөдөлмөрийн яам, Япон улс, Бельги улс болон Люксенбургийн Засгийн газар, Шведийн олон улсын хөгжлийн нийгэмлэг, Европын зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр юм.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

I Оршил. I. ХЭЗЧДС-ын арга зүйн товч танилцуулга. II. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын үүрэг, оролцоо

ХЭЗЧДС-ын арга зүйн оршил

Оршил

Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг ОУХБ-ын Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн газар боловсруулсан бөгөөд уг хөтөлбөр нь тухайн орон нутгийн (**энэ нэр томъёог цаашид "орон нутгийн тухайн сууринд оршин суух бүлэг хүмүүст хамаатуулна**) иргэдийг хамруулсан сургалтад суурилагдаж байгаагаараа онцлог юм.

Хөтөлбөрийн зорилго нь ядуу иргэд, ажилгүй хүмүүс, албан бус эдийн засгийн салбарт ажиллагчид, эмзэг бүлгийн иргэдэд ур чадвар ба мэдлэг дээр тулгуурлан эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтийн шинэ нөхцлүүдийг бий болгох замаар тэдгээрийг эдийн засгийн чадавхитай болгоход чиглэв.

ХЭЗЧДС-ын арга зүй нь орон нутгаас гарч буй санаачлагыг удирдан чиглүүлэх, орлогын эх үүсвэрийг тодорхойлж, боломжоор хангах хоорондоо уялдаа холбоо бүхий хэдэн үйл ажиллагаанаас бүрддэг. Үндэсний ба орон нутгийн хэмжээний түнш байгууллага хоорондын тохиролцол, хамтарсан төлөвлөлтөд суурилсан эдгээр үйл ажиллагаа нь орон нутгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн боломжуудыг тодорхойлсны үндсэн дээр тухайн орон нутгийн нөхцөл байдал, онцлогт нийцэхүйц тохиромжтой сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, сургалтад хамрагдсан иргэдэд зах зээлд гарахад нь туслах зэргээр дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү Гарын авлага нь ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэгчид зориулагдсан бөгөөд нийтдээ найман бүлэг бүхий хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэг I-VI бүлэгтэй. Үүнд: нэгдүгээр бүлэг - ХЭЗЧДС-ын үе шатны талаарх дэлгэрэнгүй ойлголт; хоёрдугаар бүлэг - байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон төлөвлөлт; гуравдугаар бүлэг - эдийн засгийн боломж болон сургалтын төлөвлөгөө хийхээс өмнөх шатанд сургалтын эрэлт хэрэгцээг хэрхэн зөв тодорхойлох; дөрөвдүгээр бүлэг – сургалтын загварыг боловсруулах, түүний зохион байгуулалт болон нийтэд хүргэх арга; тавдугаар бүлэг – сургалтын дараа төгсөгчдөд ажлын байртай болгоход чиглэгдсэн туслалцаа үзүүлэх; зургадугаар бүлэг – хяналт-шинжилгээ, үнэлгээ болон баримтжуулах зэрэг сэдвүүд тус тус дэлгэрэнгүй дурьдагдах болно. Хоёрдугаар хэсгийн бүтцийн хувьд: долоодугаар бүлэг – ХЭЗЧДС-ын хэрэгжүүлэх явцад жендерийн асуудлыг хангах; наймдугаар бүлэг – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамруулах тухай байх болно.

ХЭЗЧДС-ын арга зүйн товч танилцуулга

Нэгдүгээр бүлэг ХЭЗЧДС-ын арга зүйн талаарх мэдээллийг агуулах бөгөөд ОУХБ-ын ХЭЗЧДС-тэй холбогдол бүхий төслүүдийг Ази болон Африкийн орнуудад хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан туршлага дээр суурилсан үйл ажиллагааны загвар болон аргачлал, арга хэрэгслийн талаар дурьдана. Эдгээр жишээ болон загварууд нь ур чадварыг хөгжүүлэх замаар амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах болон хөдөө, орон нутгийг эдийн засгийн хувьд чадавхижуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөлт хийж байгаа болон хамтран ажиллахаар хүч чадлаа дайчилж байгаа түнш байгууллагуудад

1. ХЭЗЧДС-ын арга зүйн тодорхойлолт

нэгдсэн ойлголт өгөхөд тус дэм болох учиртай.

ХЭЗЧДС нь хөдөөгийн ядуу иргэдийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга зүйн цогц юм. Чадавхийг дээшлүүлнэ гэдэг нь чадвар дээшлүүлэх замаар амьдрал, амьжиргааг сайжруулах үйл ажиллагаа гэж тодорхойлж болох юм. ХЭЗЧДС нь ядуус, өөрийн бодит боломжоос доогуур хэмжээний ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажилгүй болон бусад эмзэг бүлэгт хамаарах хүмүүст тэдгээрийн ур чадвар болон мэдлэгийг нэмэгдүүлэх хэлбэрээр эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн шинэ боломжуудыг нээж чадавхижуулахыг эрмэлзэж байгаа юм. Дээр дурьдсан энэ үйл ажиллагаанд хамрагдах зорилтод бүлгүүдэд нийт хүн амын хэмжээнд эмзэг бүлэг хэмээгдэх хүмүүсээс гадна ДОХ (Хүний дархлал хомсдлын хам шинж)-той, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн болон бусад бүлгийн эмэгтэй, эрэгтэйчүүд мөн орж байгаа болно. ХЭЗЧДС нь ОУХБ-ын дадлага, туршлага дээр суурилан олон төрлийн чиг хандлага бүхий үйл ажиллагаа явуулах боломжтой.[1]

ХЭЗЧДС нь дараах арга замаар хөдөөгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэл баримталдаг болно. Үүнд:

- иргэдийн амьдарч, ажил хөдөлмөр эрхэлж буй орчинд нь өөрсдийнх нь ур чадвар, мэдлэгийг бүрэн дүүрэн ашиглах боломжийг дээшлүүлэхэд туслаж, дэмжлэг үзүүлэх;
- орлого болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар амьжиргааны түвшинг ахиулах зорилгоор иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх болон бусад хэрэгцээтэй дэмжлэг, туслалцааг үзүүлэх;
- нутгийн байгууллагуудад хамтын ажиллагаа өрнүүлж, үр шимийг нь хүртэх, цаашид туслаж, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хамтын ажиллагааг улам өргөжүүлж, хөгжүүлэх зэрэг болно.

ХЭЗЧДС нь эмэгтэй, эрэгтэй ядуу хүмүүсийг ур чадвар болон мэдлэг хэмээх хэзээ ч гээгдэшгүй эх үүсвэртэй болгож, тэдгээрт өөрсдийн орлогоо нэмэгдүүлэх, ингэснээр өөрсдийн амьдарч байгаа орон нутаг, олон нийтийн шинэ дүр төрхийг бий болгоход хувь нэмэр оруулах хөгжлийн хандлага юм. Орон нутгийн хөгжил болон жендерийн асуудлыг хангах чиг хандлага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрт гол байр суурь эзэлж байгаа бөгөөд энэ нь эмэгтэй, эрэгтэйчүүдийг жигд чадавхижуулахад оршиж байгаа юм.

Олон түвшний хандлага

ХЭЗЧДС нь макро, мезо болон микро гэсэн гурван түвшинд оролцоог хангах дараах чиг хандлагыг баримталдаг. Үүнд:

- ХЭЗЧДС нь хөдөлмөр эрхлэлт болон орлого бий болгох микро түвшний боломжийг тодорхойлох зарчим дээр суурилдаг. Ур чадварыг эдийн засгийн хэрэгцээнд нийцүүлэх нь чухал, хэдий ч энэ нь дангаараа хангалтгүй юм. Эмэгтэйчүүдэд нэмэлт тусламж, дэмжлэг шаардлагатай байдаг гэдэг нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн, тухайлбал, тэдгээрийг бие даасан аж ахуй эрхлэх, өөрийгөө цалинжуулах жижиг үйл ажиллагаа явуулах түвшинд хүргэхийн тулд бичиг үсгийн мэдлэгийг нь сайжруулахын зэрэгцээ өөртөө итгэлтэй болгох хэрэгцээ байдаг;
- Шаарлагад нийцсэн сургалтыг төлөвлөж, зохион байгуулахын тулд сургалтын төвүүд болон сургалтыг зохион байгуулагчид хэрэгцээтэй бөгөөд энэ нь мезо түвшинд яригддаг. Энэ тохиолдолд зөвхөн түнш байгууллагуудын чин эрмэлзэлээс гадна тэдгээрийг чадавхижуулсан байх нь чухал. Мөн сургалтад хамрагдагчдыг бичил зээл, техникийн туслалцаа болон зах зээлийн талаарх мэдлэгтэй болгох, сургалтын дараа дэмжлэг, туслалцаа үзүүлэх нь нь орлого бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг;
- Макро түвшинд илүү өргөн цар хүрээг хамрахын тулд орон нутгийн, тодруулбал олон нийтийн оролцоо чухал байдаг. Тухайлбал, Пакистан улсад хэрэгжүүлсэн ХЭЗЧДС-ий хөтөлбөрийг үндэсний болон орон нутгийн бодлогын түвшинд хэрэгжүүлж байсан бөгөөд орон нутгийн түвшинд илүү анхаарал хандуулж байсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдийн зүгээс мэргэжлийн сургалтыг илүү түлхүү явуулах чиг хандлага баримтлаж байсан болно.

ХЭЗЧДС-ын микро-мезо-макро түвшний хувьд, эдгээрийг тус бүр нь авч үзэж, түвшин хоорондын холбоо, харилцааг нь ойлгож, зөв тодорхойлсноор чухам аль түвшинд хүндрэлүүд бий болж байгааг тогтоох боломжтой. Шаардлагатай өөрчлөлтүүд оруулах, бэрхшээлтэй асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй байсан ч авч хэлэлцэх, тухайн асуудлын шийдлийг эрэлхийлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор гарах болно. Жендерийн асуудлыг дээр дурьдсан гурван түвшинд шийдэх хэрэгцээ, шаардлага гарна гэдгийг бас тооцож, анхааралдаа авах нь чухал юм.

ХЭЗЧДС нь төрөл бүрийн түгээмэл мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдээс бүрдэнэ.

Төрөл бүрийн түгээмэл мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдтэй холбогдох үйл ажиллагааны чиг хандлага нь дараах үндсэн гурван хүчин зүйлээс хамааран тодорхойлогдоно. Үүнд:

2. ХЭЗЧДС-ын зохистой байдал

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахын өмнө орлого бий болгох боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлсон байдал;

1 ОУХБ-ын ХЭЗЧДС-ийн хөтөлбөр нь ОУХБ-ын боловсруулсан төрөл бүрийн арга хэрэгсэлүүдийг үйл ажиллагаандаа удирдлага болгохын зэрэгцээ бусад хөтөлбөрүүдтэй уялдаатай байдаг. Тухайлбал, өөрийн гэсэн бизнесийг эхлүүлж, сайжруулахад дэмжлэг үзүүлдэг “Өвсний үндэс - удирдлагын сургалт”, Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр, Хүүхдийн хөдөлмөрийг халах олон улсын хөтөлбөр гэх мэт.

- Цаашдын чиг хандлагын боломж болон хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийт болон орон нутаг дах бусад түншүүдийн оролцоо;
- Сургалтын дараах шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх боломж. Энэ нь хэрэгцээтэй технологи нэвтрүүлэх, зээл тусламж болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг авах, хөдөө орон нутагт ашиг сонирхлоороо эвлэлдэн нэгдэх болон хамтрах, сургалт явагдсан орон нутагт эмэгтэй болон эрэгтэйчүүд орлого бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт болон борлуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах зэрэг болно.

Арга зүй нь орлого бий болгох боломж мөн тэдгээрийг орон нутгийн хэмжээнд хөгжүүлэх, өргөжүүлэхэд чиглэгдсэн шаарлагатай үйл ажиллагааг зөв тогтоож, ажил хэрэг болгон хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс бүрдэнэ (Хүснэгт 1). Үүнд шаардлагатай удирдлага болон зохион байгуулалтын тогтолцоог бий болгох, төлөвлөлт хийх зэргээс эхлэх нь тухайн орон нутгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлт болон орлого бий болгох боломжуудыг тогтмол, үнэн зөв тодорхойлох; бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалтыг зохион байгуулах болон сургалтын дараа холбогдох ажиллагааг үргэлжлүүлэн явуулах; жендерийн зохистой харилцаа, тогтмол цалин, орлого бүхий хөдөлмөр эрхлэлт болон өөрийн бичил үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг хамаарах болно.

Хэдийгээр дээр дурьдсан үйл ажиллагаанууд нь хоорондоо харилцан хамааралтай боловч, эдгээрийг тодорхой чиглэл болон дэс дарааллын дагуу гүйцэлдүүлэх нь зүйтэй юм. Тухайлбал, орон нутгийн эдийн засгийн боломж болон эдийн засгийн хүрээлэн буй орчин, нөхцөл байдалд орж буй өөрчлөлтүүдийг байнга хянаж, үе үе шинээр тодорхойлж байх нь зүйтэй.

3. Тогтолцоо, дэвшил, үйл ажиллагаа болон арга хэрэгсэл

Үйл ажиллагаа 1. Тогтолцоо болон төлөвлөлт

Энэ шатны үйл ажиллагаа нь хөтөлбөрийн хамрах цар хүрээ, зорилтод бүлгүүд болон тэдгээрийн газар зүйн байршлыг тогтоох, хөтөлбөрийн хэрэгжилтийн стратегийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тохиромжтой орон нутгийн болон үндэсний хэмжээний тогтолцооны бүтцийг бүрдүүлэх, хэрэгцээтэй орон нутгийн түншүүдийг тодруулж тэдгээрийг чадавхижуулах арга хэмжээ авах зэрэг болно.

Гол үйл ажиллагаанууд

- ☐ ХЭЗЧДС-ын болзошгүй оролцогчид болон түншүүдийг тодруулах;
- ☐ ХЭЗЧДС-ын удирдлага, зохион байгуулалтын нэгжийг бүрдүүлэх, бүрэлдэхүүний үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох;
- ☐ зөвлөхүүдийн туслалцааг авч төлөвлөлтийн үйл ажиллагааг гүйцэлдүүлэх (үйл ажиллагааны төлөвлөгөө, хамрах цар хүрээ, санхүүгийн зардал болон сургалт, семинарын төлөвлөлт, хэрэгжилтийн арга хэрэгслийг сонгон авах);
- ☐ хөтөлбөр хэрэгжүүлэх орон нутаг болон зорилтод бүлгүүдийг сонгох;
- ☐ хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх түншүүдийг шалгаруулж, сонгох;
- ☐ нөхцөл байдлын дүн шинжилгээ, үнэлгээг хийх: орон нутгийн хөгжлийн стратеги болон бусад төлөвлөгөө, жендерийн харилцааны нөхцөл байдал, үндсэн хэрэгцээг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ДОХ болон цөөнхийн талаар судалгаа гаргах гэх мэт;
- ☐ түншүүд, төрийн, төрийн бус байгууллагуудын хоорондын харилцан хамтран ажиллах нөхцөл, шаардлагатай боломжийг бүрдүүлж, холбох;
- ☐ үндэсний ба орон нутгийн хэмжээний тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаарлагатай удирдлага, зөвлөмжөөр хангах нэгжийг бий болгох;
- ☐ захиргааны бүтцийг бүрдүүлэх, хэрэгжүүлэгч агентлагийн үүрэг оролцоог тогтоох, оролцогч талуудын харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;
- ☐ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох түнш байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах.

Хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэрэгсэл

- ☐ ХЭЗЧДС-ын үндсэн агуулга;
- ☐ ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэгч багийн санал, зөвлөмж;
- ☐ хөтөлбөрт хамрагдахаар сонгох орон нутагт тавигдах шалгуур үзүүлэлтийн санал;
- ☐ болзошгүй түншүүдтэй хийх ярилцлагын сэдвийн санал;
- ☐ түнш байгууллагуудыг шалгаруулахад тавигдах шаардлагын санал.

Үйл ажиллагаа 2. Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох

Орон нутаг дах түншүүдтэй нягт холбоотой ажиллах нь чухал. Уг үйл ажиллагаанд тухайн орон нутгийн ерөнхий дүр зураг болон бусад холбогдох мэдээллийг цуглуулах, боломжит хөдөлмөр эрхлэлт, орлогын олох эх үүсвэрүүдийг тогтоох, шинэ бизнес, ажлын байрыг бий болгох, нэмэгдүүлэх талаарх шинэлэг санаа гаргах, болзошгүй эдийн засгийн бололцоо болон шаардлагатай сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох зэргийг хамааруулна.

Гол үйл ажиллагаанууд

- ☐ үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний талаар мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийх, хөдөлмөрийн зах зээлийн болон эдийн засгийн салбарын судалгааг хийх;
- ☐ орон нутгийн нөөц бололцоо, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн болон орлого бий болгохтой холбогдох нөхцөл байдлын судалгааг хийх;
- ☐ тогтоогдсон эдийн засгийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлагын бололцоог судлах;
- ☐ сургалт (техникийн ур чадвар, үйлдвэрлэл, жижиг

бизнесийн менежмент гэх мэт) болон сургалтын дараа бий болох хэрэгцээ шаардлагыг тогтоох;
- ☐ холбогдох сургалтын санал боловсруулах.

Хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэрэгсэл
- ☐ орон нутгийн төлөв байдлын судалгаа;
- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа;
- ☐ зах зээлийн нөхцөл байдлын судалгаа;
- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн боломж болон цаашдын чиг хандлагын талаарх нөхцөл байдлын судалгааны удирдамж;
- ☐ нөхцөл байдлын судалгааны загвар болон үлгэрчилсэн загварууд;
- ☐ сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны загварууд;
- ☐ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сургалтын хэрэгцээний судалгаа;
- ☐ сургалтын саналын загвар.

Үйл ажиллагаа 3. Сургалтыг загвар, сургалтыг зохион байгуулах ба хэрэглэгчид хүргэх

Энэ үйл ажиллагаад зорилтод бүлгийн эмэгтэй болон эрэгтэйчүүдийн хэрэгцээнд суурилсан сургалтын загварыг боловсруулах, жендерийн ялгаа, хөгжлийн бэрхшээл болон бусад чиг хандлагыг баримжаалсан зорилтод бүлгүүдэд зориулсан сургалт явуулах сургагч нарыг сонгож сургах зааварчлах, сургалтын материаллаг баазыг бэлтгэх, сургалт явуулах газруудыг товлох, сургалтуудыг зохион байгуулах, сургагчийн үйл ажиллгаа болон суралцагчдын сургалт хүлээн авч байгаа байдалд үнэлгээ хийх зэрэг хамаарах болно. Сургалтын хөтөлбөр нь үйлдвэрлэл болон үндсэн ур чадварыг нэмэгдүүлэх агуулгатай байвал зохино.

Гол үйл ажиллагаанууд
- ☐ сургалт зохион байгуулах, явуулах байгууллага, сургагч болон сургалт явуулах газруудыг тодорхойлж, тогтоох;
- ☐ сургалтын дамжааны төлөвлөгөөг боловсруулах;
- ☐ жендерийн ялгаа, хөгжлийн бэрхшээл болон бусад онцлогуудыг харгалзан сургалт явуулах сургагч нарыг бэлтгэх;
- ☐ сургалтын материал боловсруулж, бэлтгэх, ингэхдээ зорилтод бүлгүүдийн жендерийн ялгаа, хөгжлийн бэрхшээл болон бусад онцлогуудыг харгалзан үзэж, тэдгээрийн онцлогт нийцүүлсэн байх шаардлагатай;
- ☐ сургалтын дамжааны түвшинг дээшлүүлэх;
- ☐ тусгайлан боловсруулсан удирдамжийн дагуу сургагч нарыг сонгон авах;
- ☐ сургалт зохион байгуулах газрыг сонгох, шаардлагатай бол зөвхөн эмэгтэйчүүдийг сургах байрыг тусгайлан сонгож авах;
- ☐ сургалтын төлөвлөлт болон гарах зардлыг эцэслэн тогтох;
- ☐ сургалты зохион байгуулж, зорилтод бүлгүүдэд хүргэх, сургалтын чанарт анхаарал хандуулж чанартай сургалтыг хүргэх арга хэмжээ авах, төгсөлтийн шалгалт авч, холбогдох гэрчилгээ, мэргэжлийн сертификат олгох;
- ☐ сургалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэрэгсэл
- ☐ дамжаануудын сургалтын төлөвлөгөө;
- ☐ сургалтын дамжааны загвар;
- ☐ сургагч болон суурь сургалтад тавигдах шаардлага;
- ☐ сургагч нарт зориулсан ур чадварын сургалтын хичээлийн агуулга, төлөвлөгөө, зааварчилгаа, гарын авлагыг боловсруулах ;
- ☐ ур чадварын сургалтын хичээлийн агуулга, төлөвлөгөөний загвар;
- ☐ ур чадварын сургалтын үр шимийг хүртэгчид хүртэгчдийн бүртгэлийн загвар;
- ☐ сургалтын үйл ажиллагааны явцын тайлан;
- ☐ сургагчийн тайлан;
- ☐ төгсөлтийн тайлан.

Үйл ажиллагаа 4. Цалинтай хөдөлмөр эрхлэлт болон бичил үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн сургалтын дараах үйл ажиллагаа

Энэ үйл ажиллагаа нь сургалтад хамрагдсан зорилтод бүлгүүдэд сургалтын дараа бие даан үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжихэд чиглэгдсэн үйл ажиллагаа хамаарна. Энэ үйл ажиллагаа (микро) нь санхүүгийн байгууллагууд, технологийн төвүүд болон бизнес хөгжүүлэх зөвлөгөө өгөх болон дэмжлэг туслалцаа үзүүлэгчид, ажил олгогчид болон ажил хайгчийг холбох, орон нутаг дахь ажлын байрны боломжийг бүрэн ашиглахад чиглэгдэх болно.

Гол үйл ажиллагаанууд
- ☐ ажлын байр олоход туслалцаа үзүүлэх;
- ☐ санхүүгийн үйлчилгээтэй холбох;
- ☐ менежмент, маркетинг болон технологийн гэх мэт зөвлөгөө өгөх үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх;
- ☐ орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр болон бусад албан ёсны хөтөлбөр, төсөлтэй холбох ажлыг зохион байгуулах;
- ☐ орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг нь бэхжүүлэх (хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл, хоршоолол, хадгаламж болон зээлийн бүлгүүд, бизнес төв, эмэгтэйчүүд болон залуучуудын клуб, эвлэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэг гэх мэт);
- ☐ хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамрагдсан төгсөгчидтэй эргэн уулзаж байх, цаашдын үйл ажиллагаа, чиг хандлагын талаар шаардлагатай зааварчилгаа, зөвлөгөө өгөх.

Хэрэгжилтийг хангахад шаардагдах

арга хэрэгсэл

- ☐ сургалтын дараах дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар;
- ☐ бичил үйлдвэрлэлийг дэмжих зээлийн боломжит эх үүсвэр;
- ☐ бичил санхүүгийн байгууллагуудын хүчин чадлыг судлах;
- ☐ сургалтын дараах үйл ажиллагааны хяналт-шийнжилгээ болон бичил үйлдвэрлэлүүдийн үйл ажиллагаатай танилцах, уулзалтуудыг зохион байгуулах (үйл ажиллагаа эхлэгчид, үйлдвэрлэл, маркетинг, санхүүжилт);
- ☐ хамтран эрхэлж буй үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- ☐ хадгаламж, зээлийн бүлгүүдэд тавигдах нөхцлийн шаардлага.

Үйл ажиллагаа 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бичиг баримтын бүдүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бичиг баримтын бүдүүлэлт (цаашид “баримтжуулалт” гэх) бол ХЭЗЧДС-ын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Хяналт-шинжилгээ нь төслийн явцын байдлыг хянах, учирч буй бэрхшээлүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодлого боловсруулах эрх бүхий этгээдүүд болон оролцогчдыг шаардлагатай мэдээллээр тогтмол хангах ач холбогдол бүхий үйл ажиллагаа болно. Үнэлгээ хийх нь сургалт болон сургалтын дараах үйл ажиллагаанд дүгнэлт хийхэд нилээд ач холбогдолтой юм. Баримтжуулалт нь ХЭЗЧДС-ын талаар туршлага солилцох, туршилтын журмаар хэрэгжүүлэх үе шатанд гаргасан алдаа дутагдлыг засаж залруулахад ихээхэн ач холбогдолтой.

Үйл ажиллагаануудаас хамгийн чухал зүйл нь хуримталсан туршлагыг өргөжүүлэх бөгөөд энэ нь тогтолцоог бүрэлдүүлэх болон бодлого боловсруулах үйл ажиллагааны бүхий л түвшинд хамааралтай билээ. Бодлого боловсруулах үйл ажиллагаа нь мэргэжүүлэх сургалтуудын хүрээнд тавигдсан зорилго, зорилтуудыг эргэн харж дахин тодорхойлох, сургалтын албан бус нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн бололцооны хувьд шинээр илэрч буй нөхцөл байдал, өөрчлөлтүүдтэй уялдаа холбоо бүхий сургалтуудыг зохион байгуулах, зах зээлийн бодит хэрэгцээ болон жендерийн тэнцвэртэй байдалд нийцсэн ур чадварын сургалтыг явуулах, ХЭЗЧДС-ыг хамтран хэрэгжүүлэх байгууллагууд, түншүүд, үндэсний болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, ажил олгогч, орлогын эх үүсвэрийг бий болгох гол оролцогч талуудын хамтын ур бүтээлтэй үйл ажиллагаа явуулахүйц механизм болон сүлжээ байгуулах замаар үйл ажиллагааг бэхжүүлэх зэрэгтэй холбоотой.

Гол үйл ажиллагаанууд

- ☐ хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээний төлөвлөгөөг боловсруулах;
- ☐ хөтөлбөрийн үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах;
- ☐ жендерийн тэгш эрх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал ямар түвшинд, хэрхэн шийдвэрлэгдэж байгаад хяналт-шинжилгээ хийх;
- ☐ сургалтыг зорилтод бүлгүүдэд хэрхэн хүргэж байгаад хяналт-шинжилгээ хийх;
- ☐ төгсөгчдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;
- ☐ бичил үйдвэрлэлүүдийг бий болгох төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх;
- ☐ хамтран үйл ажиллагаа эрхэлж буй бүлгүүд болон нийгэмлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;
- ☐ хуримтлуулсан туршлагыг баримтжуулах.

Хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэрэгсэл

- ☐ гүйцэтгэлийн мэдээллийн хүснэгт;
- ☐ хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний төлөвлөгөө (загвар болон үлгэрчилсэн загвар);
- ☐ сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ;
- ☐ үр дүнгийн судалгааг хэрхэн хийх аргачлал;
- ☐ үр дүнгийн судалгааны тайлангийн загвар;
- ☐ хувиараа хөдөлмөр эрхлэх болон бичил бизнесийн төслийн үйл ажиллагаанд судалгаа хийх арга хэрэгсэл;
- ☐ орон нутгийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийх аргачлал.

Анхаарлын төвд байвал зохих бүрэлдэхүүн хэсгүүд

Орон нутгийн эдийн засгийн хөгжил. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн ихэнх нь орон нутгийн хэмжээнд хэрэгжиж, орон нутгийн хөгжилтэй шууд холбоотой, нутгийн иргэд болон зорилтод бүлгүүдийг тухайн оршин сууж буй нутаг дэвсгэрийнх нь хэмжээнд чадавхижуулахаар төлөвлөгдөж байгаа тул орон нутгийн хэмжээнд тогтвортой эдийн засаг болон нийгмийн хөгжлийн нөхцлийг бүрдүүлэхүйц тогтолцоог бий болгох нь чухал юм.

Жендер. Эмэгтэй, эрэгтэй байхаас үл хамааран тухайн хүн сурсан техникийн болон бизнесийн ур чадвараа ашиглан бичил үйлдвэрлэл болон цалинтай хөдөлмөр эрхэлдэг тохиолдолд жендерийн тэгш эрх, жигд оролцооны асуудлыг орхигдуулж болохгүй. Иймд орон нутгийн түвшнээс эхлэн сургалтын төлөвлөгөө ба бусад материал боловсруулах, сургагч нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулах газрыг товлох, сургалтыг явуулах явц болон сургалтын дараах үйл ажиллагааны бүхий л үе шатанд жендерийн асуудал дээр тусгайлан анхаарах нь зүйтэй. Энэ нь тухайн асуудалтай холбогдуулан үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж, дэмжигдэж байгаа нааштай, эерэг бодлого, чиг хандлага, үйл ажиллагаандаа баримтлах тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, шаардлагатай бол бодлогын түвшинд уг асуудлыг авч үзэх, бодит хэрэгцээг тодорхойлох, түүнчлэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд цаашид нэвтрүүлж болох чиг хандлагыг хамааруулсан байна. Гэхдээ эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд хоорондоо ялгаатай, эдгээр ялгаа болон хүрээлэн буй орчны нөлөөнөөс хамааран ямарваа нэгэн хэлбэрээр ялгаварлан гадуурхагдаж болзошгүй гэдгийг анхаарах шаардлагатай. Жендер болон эрх тэгш боломжийн асуудал ХЭЗЧДС-ын хувь чухал тул эхнээс

нь авахуулаад төгстөл хүртэл яригдсаар байх болно. Уг асуудалд гарын авлагын долдугаар бүлэг зориулагдсан бөгөөд уг хэсэгт жендерийн талаарх ерөнхий үзэл баримтлалд анхаарал хандуулахын зэрэгцээ ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх явцад жендерийн асуудалд хэрхэн хандаж, түүнд нийцсэн бодлого хэрэгжүүлэх, стратегийн болон хэрэгжүүлэх аргачлалын зааварчилгаа, жишээ зэрэг тусгагдсан байх болно. Жендерийн асуудал нь дотроо ялгаатай байдаг тул тодорхой эмзэг бүлгийн хувьд илүү нухацтай авч үзэх хэрэгтэй байдаг. Энд бүлэгт хамаарах зарим тодорхой, тусгайлсан арга хэрэгслүүд байдаг. Тухайлбал, жендерийн асуудалтай хамаарах жишээ, загвар; жендерийн асуудалд дүгнэлт, дүн шинжилгээ хийх арга замууд; жендерийн асуудлаар чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр; жендерийн асуудалд дундыг баримталсан болон өвөрмөц хандсан мэдээлэл зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмээс гадуурхагдсан бусад бүлгүүд. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нь тухайн нийгмийн бүлгийн нэг хэсэг заавал болж байдаг бөгөөд хамгийн жижиг цөөнхи болдог. Ихэнх нийгмийн бүлгүүд ДОХ-той хүмүүсийг ч мөн цөөнх гэж үздэг. Нутгийн уугуул иргэд эсвэл ямарваа нэгэн үндэсний цөөнх хөтөлбөрөөс орхигдох явдал ч гардаг. Орон нутгийн хэмжээнд, нутгийн иргэдийг ХЭЗЧДС бүгдийг нь хамруулсан байх бөгөөд тухайн нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх шаардлагатай юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд, тухайн хүний физиологийн онцлогоос хамааран тусгай нөхцөл, орчныг бүрдүүлсэн байх хэрэгцээтэйн зэрэгцээ тэдгээр хүмүүс нь олон жилийн туршид нийгмээс хөндий байсан, энэ бүлгийн хүмүүс ядуурлын тухайд илүү хүндрэлтэй байдалд байдаг зэргийг харгалзан гарын авлагын наймдугаар бүлгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн ажиллах, ямар асуудлыг анхаарах, тэдний эрх ашиг, ур чадварын сургалтын явцад гарч болзошгүй хүндрэлүүд, мөн уг асуудалд хандах ХЭЗЧДС-ын хандлагын талаар дэлгэрэнгүй дурьдсан болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахад тус дэм болох хэрэгцээтэй, арга хэрэгслүүдийг бүлгийн А хавсралтаас олж харж болно.

Хүснэгт 1. ХЭЗЧДС-ын арга зүйн үйл ажиллагаа

Түншүүд болон зорилтод бүлгүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, тэднийг үйл ажиллагаанд бүрэн хамруулах нь гол хүчин зүйл юм.

Тогтолцоо болон төлөвлөлт	**Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох**	**Сургалтын загвар, сургалтыг зохион байгуулах болон хэрэглэгчид хүргэх**	**Цалинтай хөдөлмөр эрхлэлт болон бичил үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн сургалтын дараах үйл ажиллагаа**
○ Бодлогын орчин болон хэрэгцээг анхан шатны түвшинд тодорхойлох; ○ Оролцогчид болон түншүүдийг тогтоох; ○ ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх зохистой зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх; ○ Чадавхыг сайжруулах.	○ Мэлээлэл цуглуулж дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх; ○ Тухай орон нутгийн нийгэм-эдийн засгийн дүр зураглалыг бий болгох, олон нийтийн хүчийг дайчлах; ○ Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох; ○ Бодит боломжийн судалгааг хийж, сургалтын санал боловсруулах.	○ Сургалтын төлөвлөгөөний агуулга болон төлөвлөгөөг боловсруулах; ○ Сургалтад хамрагдагчдыг сонгох, сургагч нарыг сургалтад хамруулах; ○ Сургалтыг зохион байгуулж зорилтод бүлгүүдэд хүргэх; ○ Ажлын байран дахь үргэлжилсэн сургалтуудыг зохион байгуулах.	○ Цалинтай хөдөлмөр эрхлэлт эсвэл өөрийгөө цалинжуулах боломжийг хангахад дэмжлэг үзүүлэх; ○ Жижиг бизнес эхлэхэд туслах; ○ Зээлийн, зөвлөхийн болон зах зээлийн шинэ технологи нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх; ○ Бүлгүүдийг мэдээллээр хангах; ○ ХЭЗЧДС-ын төгсөгчдийн цаашдын үйл ажиллагаанд хяналт тавих.
Жендерийн *болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тусгайлан бариmтлах бодлого боловсруулах, зорилтод бүлгүүдийг орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах*			
Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний бүтцийг бий болгох			

Дасан зохицолт

ХЭЗЧДС-ыг аливаа улс эсвэл бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх явцад тухайн улс орны эсвэл бүс нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын онцлог, өвөрмөц байдалд үйл ажиллагаа болон хэрэглэх арга хэрэгслийг дасан зохицуулах шаардлага гардаг.

ХЭЗЧДС-ын зарчим болон чиг хандлагууд болох дүн шинжилгээний хэрэгцээ, орон нутгийн оролцоо, жендерийн зарчим, нийгмийн түншүүдийг дайчлах, сургалтын дараа туслалцаа, дэмжлэг үзүүлэх зэрэг нь бүх улс орон болон бүс нутагт хүчин төгөлдөр байх болно.

ХЭЗЧДС-ын бүхий л үйл ажиллагаанууд нэг системийн бүрэлдэхүүн хэсэг гэж тооцогддог бөгөөд бүгд чадваржуулах болон бусдаас илүүтэйгээр бололцоо муутай, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдрах орчныг сайжруулах гэсэн нийтлэг зорилгод чиглэгдсэн.

Сургалтуудын хувьд, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтууд нь амьдрал, ахуйн бүхий л хэсэгт хамааралтай тул ажиллах хүчний чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд сургалтын хөтөлбөр нь дараах ур чадварын өргөн хүрээг хамарсан байна. Үүнд:

- ☐ орлого бий болгох, нэмэгдүүлэх болон цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн мэргэжлийн сургалт (тухайлбал: барилгын ажилд хэрэгцээтэй ур чадвар, засвар, үйлчилгээ, хөдөөгийн аж ахуй эрхлэлт, гар урлал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, фермийн бус бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, газар тариалангийн

бүтээгдэхүүний борлуулалт болон зах зээл);

- ☐ бизнесийн ур чадвар;
- ☐ жендер болон хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхлын эсрэг үйл ажиллагаа;
- ☐ сургалтын үр шимийг илүүтэйгээр хүртэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор бичиг үсэгт сургах;
- ☐ бусад зайлшгүй ур чадвар;
- ☐ гэр бүлийн нөхцлийг сайжруулах ур чадвар (тухайлбал, гэр бүлийн төсвийг нэмэгдүүлэх, эрүүл ахуйг сайжруулах гэх мэт);
- ☐ орон нутгийн нийтийн ердийн хэрэгцээний үйлчилгээ, барилга байгууламж болон орон нутгийн бусад зүйлсийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц ур чадвар;
- ☐ орон нутгийн хэмжээний үйлдвэрлэл болон хөдөөгийн төслүүдийг дэмжих ур чадвар;
- ☐ орон нутгийн хэмжээнд бэрхшээлтэй байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахуйц бусад мэргэжлийн ур чадвар, манлайлах, зохион байгуулах болон багаар ажиллахаргад сургах.

ХЭЗЧДС-ын арга зүйн үр шимийг нь богино хугацаанд хүртэх боломж бүхий хувиар эрхлэх болон орлого бий болгох ур чадваруудыг хөгжүүлэхэд тохиромжтой.

Энэ нь бодит ажлын орчинд шууд хамаарах богино хугацааны дамжаанууд дээр суурилсан байдаг. Иймт өрлийн сургалтууд нь тухайн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, орлого олох боломж бүхий ажил эрхлэлт болон орлого нэмэгдүүлэхэд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд ихэнх тохиолдолд хэрэгцээтэй нэмэлт ур чадварыг бий болгоход чиглэгдсэн сургалтыг дамжааны явцад нэмж оруулах эсвэл давтан сургалтын хэлбэрээр зохион байгуулах боломжтой байдаг.

Сургалт болон сургалтын агуулгыг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн уян хатан байлгах хэрэгтэй гэдэг нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хямралын дараах нөхцөлд байгаа иргэдийн хувьд ур дүнтэйгээр хэрэгжих боломжийг бүрдүүлэх гэсэн үг юм.

Хэдийгээр зарим нийгэмд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-той хүмүүсийг нийтийг хамарсан сургалтад оролцох боломж олгодоггүй ч гэсэн эдгээр хүмүүсийн оролцоог хөдөлгөөнт сургалтын орчин болон уян хатан сургалтын цагийн хуваарь, хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, арга зүй болон жендерийн чиг хандлагтайгаар зохион байгуулах боломжтой юм.

4. ХЭЗЧДС-ыг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд анхаарах, нөлөөлөх гол хүчин зүйлс

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзсэн байх хэрэгтэй.

4.1. Орон нутгийн болон түнш байгууллагуудыг дайчлах

ХЭЗЧДС-ын үйл ажиллагаа нь ихэнхдээ орон нутгийн оролцоонд суурилсан байдаг тул нутгийн хэмжээнд тогтвортой эдийн засаг болон нийгмийн хөгжлийг бий болгох, орон нутгийн хөгжил, хувь хүн болон нийт оршин суугчдын тодорхой бүлгүүдийг чадваржуулах замаар орон нутгийн нөхцөл байдлыг өөрчлөх, шууд арга хэмжээ авах, шаардлагатай тогтолцоог бүрдүүлэх болон бодлогын хувьд өөрчлөлт оруулах нь чухал болно.

ХЭЗЧДС нь тодорхой зорилтод бүлгүүдэд чиглэгдсэн тул бат бөх, найдвартай түншийн харилцаа болон чадавхижуулах үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг байна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн амжилт нь тухайн орон нутгийн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн дэмжлэгийг бүрэн авах, тэдгээрийг хөтөлбөрийн төлөвлөлт болон хэрэгжилтэд аль болох өргөнөөр татан оролцуулахаас хамаардаг байна. Туршлагаас харахад, эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаанд суралцагчдыг хамруулах нь тэдний сургалтад хамрагдах, амжилттай төгсөх хүсэл эрмэлзлийг нь нэмэгдүүлдэг байна. Иргэдийн оролцоо нь орон нутгийн оршин суугчдын зүгээс сургалтын явцад дэмжлэг үзүүлэх байдлыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь эцсийн дүнд сургалтын үр нөлөөг дээшлүүлдэг.

Түнш байгууллагууд болон ХЭЗЧДС-ын оролцогчдыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд татан оролцуулах нь ХЭЗЧДС-ын үйл ажиллагааны хувьд маш чухал. ХЭЗЧДС-ын орон нутгийн тогтолцоо нь оршин суугчдын оролцоог бүрэн хангах, орон нутгийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг үнэлэхүйц болгох ач холбогдолтой. ХЭЗЧДС-ын орон нутгийн тогтолцоо нь засаг захиргаа, сургалтын байгууллагууд болон бусад үйлчилгээ хүргэгчид, эмэгтэйчүүдийн холбоо, ажил олгогчид, хөдөлмөр эрхлэгчдийн төлөөлөгчид ба эвсэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэг, ТББ болон бусад холбогдох оролцогчдоос бүрдэж болно.

4.2. Сургалтыг эдийн засгийн боломжид нийцүүлж явуулах

ХЭЗЧДС-ын арга зүй нь зөвхөн тогтсон хөтөлбөрийн хэмжээнд сургалт зохион байгуулаад зогсохгүй тухайн орон нутгийн эдийн засгийн боломжийг судалж үзсэний үндсэн дээр сургалтын бүрэлдэхүүн хэсгийг тогтоож, түүнд суурилсан сургалт явуулахыг эрмэлздэг байна.

Зохион байгуулж буй сургалтыг тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэх

ХЭЗЧДС-ыг тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт болон орлого бий болгох нөхцөл байдалд зохицуулж, уялдаа холбоотойгоор хэрэгжүүлэх боломжтой. ХЭЗЧДС-ын хөтөлбөрүүдэд тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт болон орлого бий болгох нөхцөл байдал, шаардлагад нийцүүлэн сургалтын загварыг хийх тал дээр ихээхэн анхаарсан байдаг.

ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлж буй хөдөө орон нутагт ердийн цалинтай хөдөлмөрэрхлэлтийн боломж хомс байдаг. Энэ нөхцөл байдал нь хувиараа хөдөлмөр эрхлэх болон бичил үйлдвэрлэл зэрэг албан бус эдийн засгийг илүүтэйгээр хөгжүүлэх боломжуудыг бий болгодог. Иймд сургалт болон сургалтад хамрагдагчид нь дээрх нөхцөл байдалд дасан зохицсон нь чухал. Чухамхүү ийм л учраас сургалт нь зөвхөн техник ур чадвараас гадна сургалтад

хамрагдагчдыг өөрийгөө цалинжуулах хөдөлмөр эрхлэх, жижиг бизнес болон бичил үйлдвэрлэл явуулах чадвартай болгохын тулд бизнес, зохион байгуулалт болон менежментийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг давхар зохион байгуулдаг. Яваандаа сургалтын хөтөлбөрт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процесс, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, техник тоног төхөөрөмж болон түүхий эдийг нөөцлөх, санхүүгийн нягтлан бодох бүртгэл, өртгийн болон зах зээлийн тооцоо хийхийг оруулсан байж болно.

Хувираа хөдөлмөр эрхлэх, бичил үйлдвэрлэлтэй холбогдох сургалтад хамрагдагчид нь цаашид бие даасан үйл ажиллагаа явуулах тул зээлд хамрагдах, бараа материалыг бөөндөж авах, ажлын байрыг хамтарч эзэмших, стандарт хэм хэмжээнд нийцсэн үйл ажиллагаагаа эрхлэх, аливаа асуудалд бусадтай хамтарч шийдлийг олох зэрэг хувираа эрхлэх аж ахуй болон бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй мэдлэг чадварыг олгох нь зүйтэй юм.

Сургалтад хамрагдагчдын боломж болон хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах

Сонгогдсон сургалт зохион байгуулагчид нь сургалтыг цаг хугацаа болон байршлын хувьд сургалтад хамрагдагчдад хүндрэл учруулахгүйгээр бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлсэн байна. Дамжаануудын сургалтын хөтөлбөр урьдчилан хийсэн эдийн засгийн боломжийг судлах судалгаанд үндэслэсэн байхын зэрэгцээ үргэлжлэх хугацааны хувьд харьцангуй богино, тухайн ажил мэргэшлийн болон орлого бий болгох зорилгод чиглэгдэж, зөвхөн тухайн үйл ажиллагааг эрхлэхэд зайлшгүй шаардлагатай зүйлүүдэд илүүтэйгээр анхаарал хандуулсан байна.

Сургалтын бүрдэл хэсгүүд нь сургалтад хамрагдах эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэг, боловсрол, ур чадвар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломж зэргийг харгалзсан, тэдгээрийн шаардлагад нийцсэн уян хатан байх ёстой. Жишээ нь, эмэгтэйчүүдэд зориулсан ХЭЗЧДС- ын сургалтын төлөвлөлт болон зохион байгуулалтыг эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч тухайн орон нутгийн эмэгтэйчүүдийн оролцоог хангаж сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх боломжтой байхын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг жендерийн хандлага болон уг асуудалтай холбогдох эмзэг сэдвүүдээс ангид байлгах нь хамрагдаж байгаа эмэгтэйчүүдийн хэрэгцээнд илүүтэйгээр нийцэх боломжийг бүрдүүлэх юм.

Мөн сургалтыг суурин болон явуулын хэлбэрээр зохион байгуулж болох ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдалд нийцүүлэн сургалт зохион байгуулах газрыг сонгон авахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэлцэн ирэх, сургалт явж буй байранд орох гарахад хүндрэл, саад бэрхшээл учруулахгүй байлгах нөхцөл боломжийг тооцоолсон байх нь зүйтэй.

4.3. ХЭЗЧДС- ыг мэргэжлийн сургалтын тогтолцоотой уялдуулах нь

ХЭЗЧДС-ыг тухайн сонгон авсан зорилтод орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн сургалтын тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлж болно. Үүний тулд тухайн сургалтын байгууллагын үндсэн чиг үүрэг, сургалтын агуулга нь хөдөөгийн иргэдэд зориулан сургалт зохион байгуулах үйл ажиллагааг дэмжих боломжтой эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй. Хэрэв тус сургалтын байгууллагын үйл ажиллагаа нь ХЭЗЧДС-ын арга зүйн үйл ажиллагааны үндсэн зорилттой нийцэж байвал хөтөлбөрийн зүгээс тухайн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэргээр хамтран ажиллаж болох юм. ХЭЗЧДС-ын арга зүй нь тухайн байгууллагын сургалтын тогтолцоог илүү боловсронгуй, үр дүнтэй болгох боломжтой.

4.4. Сургалтын дараа дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээг нэгдсэн сүлжээ болгож хөгжүүлэх

Сургалт нь амжилттай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зөвхөн нэгээхэн хэсэг юм. Үнэндээ сургалт нь бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэрэгсэлгүйгээр үр дүн нь хязгаарлагдмал байх юм. Жишээ нь, хэрэв хэрэгцээ байхгүй, цаг хугацаанаасаа хоцорсон загвартай, тээвэрлэлт, дэд бүтцийн хүндрэлтэй нөхцөлд хүмүүсийг оёдлын машинаар оёх болон хувцас хунар эсгэх үйлд сургана гэдэг нь зөвхөн хөрөнгө, цаг үрсэн ажил болж болох юм. Түүнчлэн зээл эсвэл түрээсийн боломж хомс байгаагаас хамааран оёдлын машин авч чадахгүй хүнд оёх арга технологи заах нь мөн л хэрэгцээгүй юм. Иймд сургалтын дараа зөвөлгөө, техникийн болон санхүүгийн туслалцааг өргөн хүрээнд үзүүлэх шаардлагатай байдаг.

Сургалтын дараах дэмжлэг, туслалцааны үйлчилгээ нь хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн чанарлаг, хямд болон хүртээмжтэй байх хэрэгтэй.

Сургалтын дараах дэмжлэгийн хэлбэрүүд:

- ☐ ажил олгогч болон ажлын байртай холбох;
- ☐ жижиг бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;
- ☐ зээлд хамрагдахад туслах;
- ☐ бизнесийг өргөжүүлэх үйлчилгээ: зах зээлтэй холбох, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх, ажлын байр ба чанарын шалгалт, шинэ технологи нэвтрүүлэх, бизнес зөвлөгөөний үйлчилгээ, тээвэрлэлт, бараа материалыг бөөнөөр худалдаж авах, загварын үйлчилгээ, татвар болон үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн зохицуулалт гэх мэт;
- ☐ албан бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бичил бизнесийг албан ёсны болгох;
- ☐ ХЭЗЧДС-ын төгсөгчидтэй уулзаж аж байдалтай нь танилцах;
- ☐ ашиг сонирхлоороо нэгдэх, хамтарч ажиллахыг дэмжих.

Дээрх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн болон хувийн хэвшлийн байгууллага, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, өөртөө туслах нийгэмлэгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудаар дамжуулан хүргэж болно.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс оролцогч түнш байгууллагуудыг сургалтын дараах үйл ажиллагаанд хамрагдах, хамтран ажиллахад хяналт тавина. ХЭЗЧДС-

ыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгж нь сургалтын дараах дэмжлэг туслалцааны үйл ажиллагааны зохицуулалтыг хийнэ.

4.5. Зохистой хөдөлмөр эрхэлэх ба хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг дэмжих

ХЭЗЧДС-ын арга зүй нь эдийн засаг болон нийгмийн хүчин зүйл, ялангуяа Нөхцөл болон орлого сайтай ажил, иргэдийн амьжиргааны түвшин нь орон нутгийн хөгжилд нөлөөлөх томоохон хүчин зүйлүүд байхын зэрэгцээ тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмэр оруулдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэвч хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэй, эрэгтэйчүүдийн ажил хүнд, баталгаагүй, орлогын хувьд бага байдгийн зэрэгцээ хүүхэд хөдөлмөр эрхлэх явдал нилээдгүй түгээмэл бөгөөд энэ нь ажлын нөхцөл байдал болон орлого сайтай хөдөлмөр эрхлэлт биш юм. ОУХБ-ын Зохистой хөдөлмөр эрхлэх хөтөлбөр, ХЭЗЧДС нь хөдөлмөр эрхлэх тэгш боломж болон нөхцөл, орлого сайтай ажлын нөхцөл бололцоог бүрдүүлэхийг эрмэлзсээр ирсэн билээ.

Зохистой хөдөлмөр эрхлэх хөтөлбөр нь дараах дөрвөн стратегийн зорилтуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг болно. Үүнд:

- ☐ хөдөлмөр эрхлэх суурь зарчим болон эрх;
- ☐ хөдөлмөр эрхлэлт болон орлогын боломж;
- ☐ нийгмийн хамгаалал;
- ☐ нийгмийн харилцаа.

Дээрх дөрвөн зорилт нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэгчид, цалингийн эсвэл хувиараа эрхлэх хөдөлмөр, үйлдвэрлэл болон оффисын ажилтнуудад хамааралтай.[2] Нөхцөл болон орлого сайтай ажил гэдэг нь үр дүнтэй болон аюулгүй (аюулгүй ажиллагаа болон ариун цэврийн баталгаа бүхий) ажил, хөдөлмөрийн харилцааны эрх тэгш байдал, хангалттай орлого, нийгмийн хамгаалал, нийгмийн харилцаа, үйлдвэрчний эвлэлийн эрх чөлөө, хамтын журмаар асуудал шийдвэрлэх болон нийтийн оролцоог хангасан зарчим зэргийн ойлголтыг агуулсан байна.

ХЭЗЧДС-ын зүгээс нөхцөл болон орлого сайтай ажил төсөлд хэрхэн хувь нэмэр оруулдаг вэ?

- зорилтод бүлгүүдийн орлогыг нэмэгдүүлэх аргаар ажил эрхлэлт болон орлого бий болгох үйл ажиллагаанд хамааралтай нөхцлүүдийг бүрдүүлэх;
- ХЭЗЧДС хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад жендерийн харилцаанд хамааралтай асуудлыг харгалзах;
- мэргэжлийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын ерөнхий нөхцөл байдал зэрэг чухал асуудлуудыг нэгтгэн сургалтын хөтөлбөрт, мөн сургалтын дараах зөвлөмжинд тусгах;
- хөдөлмөрийн эрхтэй холбогдох асуудлуудыг сургалтын хөтөлбөр болон хяналт шинжилгээний үйл ажиллагаанд тусгах;
- эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд эрх тэгш сургалтын болон хөдөлмөр эрхлэлтийн боломжийг бий болгох талаар анхаарал хандуулах;
- ажилчдыг нийгэм, зохион байгуулалт болон хэлцэл хийх ур чадвартай болгох, ялангуяа эмэгтэй ажилчдын хувьд өөрсдийн гэсэн дүр зургийг бий болгоход туслах;
- ядуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нэгдэж санал нэгтэйгээр орон нутгийн түвшинд шийдвэр гаргах явцад нөлөөлөх, тэдгээрийн орон нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дэмжих;
- байгаа ажлын байрыг эрсдэлд оруулалгүйгээр сургалтын дараах туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд албан бус эдийн засгийн нэгдмэл бүтцүүдийг албажуулахад дэмжлэг үзүүлэх;
- залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй, ДОХ-оор өвчилсөн хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлэглэлүүдийн асуудалд анхаарал хандуулах.

Тухайлбал: Мадагаскарт олон хүүхэд чулууны уурхайд ажилладаг. ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг халах олон улсын байгууллагын хөтөлбөртэй[3] хамтарч ажиллаж байгаа ОУХБ-ын Ядуусыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дээрх асуудалд анхаарал хандуулан уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн эцэг эхэд хүүхдүүдийг хөдөлмөр эрхлүүлэхийг зогсоож, сургуульд сургах талаар ухуулан сурталчилах үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон. Түүнчлэн дээрх төсөл нь тухайн орон нутгийн иргэдийн оролцоотойгоор уурхайн ажилчдын хүүхдүүдэд зориулсан өдөр өнжүүлэх байгуулсан. Энэ нь тэдгээр хүүхдүүдийг эцэг эхийнхээ ажилд оролцохоос урьдчилан сэргийлж байгаагийн зэрэгцээ тэднийг байх газартай болгож байгаа бөгөөд хүүхдүүдийн ээжүүдэд сэтгэл зоволгүйгээр ажилдаа бүрэн анхаарал хандуулж ажилласнаар хөдөлмөрийн бүтээмжээ дээшлүүлэх боломж олгосон. Дээрх өдөр өнжүүлэх төвийн барилгыг барихад орон нутгийн иргэд оролцсон бөгөөд оролцсон хүмүүс нь тодорхой хугацаанд түр ажлын байраар хангагдсан юм.

5. Байгууллага, зохион байгуулалтын тогтолцоо

ХЭЗЧДС-ын тогтолцоог бүрдүүлэх гэдэг нь цаашид уг үйл ажиллагааны тогтвортой байдлыг бий болгох урьдчилсан нөхцөл юм. Холбогдох яамд, нутгийн хөгжлийн агентлагууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, сургалтын байгууллагууд ХЭЗЧДС-ын хандлагыг өөрсдийн хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хөтөлбөрүүдтэй уялдуулах нь чухал. ХЭЗЧДС нь өөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго зэргийг бусад хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хөтөлбөрүүдтэй нэгтгэн төлөвлөлт ба хэрэгжилтийг уялдаа холбоотой зохион байгуулах нь ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх үр нөлөөтэй тогтолцоог бий болгох боломжийг бүрдүүлнэ.

ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, ХЭЗЧДС-ын бүтцэд орж хамтран ажиллах байгууллагуудад дараах шалгуурууд тавигдана. Үүнд:

2 ОУХБ /1999/ Зохистой хөдөлмөр эрхлэх хөтөлбөрийн Ерөнхий захирлын тайлан, Олон улсын хөдөлмөрийн чуулга уулзалт, 87-р чуулган, 1999, Женев хот, ОУХБ

3 Хүүхдийн хөдөлмөрийг халах олон улсын байгууллагын хөтөлбөрийн товчлол-IPEC.

- ХЭЗЧДС-тай холбогдолтой хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байх;
- ХЭЗЧДС-ын арга зүйд нийцсэн сургалтын бодлогыг шинэчилж боловсруулсан байх;
- төвлөрөлийг задлах бодлого баримтлах;
- ХЭЗЧДС-ын сургалттай холбогдолтой хөтөлбөрүүдийн үндсэн зорилго, агуулгыг баримтлах;
- бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд таатай орчныг бүрдүүлэх;
- эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсрол, сургалт болон ажил эрхлэлтийн эрх тэгш боломжийг бүрдүүлэх улс төрийн тууштай хүсэл эрмэлзэлтэй байх;
- сургалтын байгууллагууд болон сургагч бэлдэх, албан бус сургалтын чиг хандлага, бизнесийн ур чадвар болон хөдөө, орон нутгийн түвшний зөвлөх үйл ажиллагаанд хандуулсан чиглэлтэй болох;
- холбогдох бичил, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрүүдтэй холбоотой байх;
- бүх дамжааны сургалтын хөтөлбөрт бизнес болон үндсэн ур чадварыг хөгжүүлэхтэй холбогдох анхан шатны мэдлэгийн талаар тусгасан байх;
- Урт болон богино хугацааны ХЭЗЧДС-ыг уялдаа холбоотой байлгах;
- шинээр бий болж байгаа ур чадварын хэрэгцээнд нийцүүлж сургалтын хөтөлбөрийг шинэчлэх;
- алслагдсан бүс нутгуудад зарцуулагдах замын болон томилолтын зардлыг хүрэлцэхүйц хэмжээгээр олгож байх;
- тухайн орон нутгийн нийгмийн бүхий л гишүүдэд (хөгжлийн бэрхшээлтэй, ДОХ-той хүмүүс гэх мэт) үйл ажиллагаагаа хүргэх хүсэл эрмэлзэлтэй байх.

Тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагаа нь мөн орон нутгийн хэмжээнд явагдах ёстой бөгөөд тухайн орон нутгийн олон нийтийн оролцоо бол ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн чухал нөхцөл юм. Орон нутгийн олон нийтийн идэвхтэй дэмжлэг нь тухайн орон нутгийн нөхцөл байдлын талаарх бодитой мэдээлэл авах, орон нутгийн байгууллагуудтай сургалт болон сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хувь нэмэртэй байх болно.

6. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн санхүүжилт

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт нь үйл ажиллагааны бүхий л бүрэлдэхүүн хэсэгт хүрэлцэхээр төсөвлөгдсөн байх шаардлагатай. Тухайлбал, жендерийн асуудал гэх мэт нь жижиг асуудал мэт харагдах боловч нарийн төвөгтэй үйл ажиллагаануудад хангалттай төсөв тооцоологдсон байх хэрэгтэй. Төсвийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлэх боломжтой юм. Үүнд:

- улсын нэгдсэн төсөв;
- орон нутгийн төсөв;
- ядуурлын бууруулах хөтөлбөр;
- сургалтын төлбөр болон сургалтад хамрагдагчдын хийсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлого;
- олгогдож байгаа бичил зээлийн хүүгээр сургалтын санхүүжүүлэх;
- төрийн бус байгууллагын хандив;
- хувийн хэвшлийн компани, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагын хөтөлбөрийн хүрээнд орж ирэх санхүүжилт;
- гадаадаас орж ирж буй хөгжлийн туслалцааны санхүүжилт;

Сургалтын зардал эсвэл түүний тодорхой хэсгийг олгогдсон зээлийн хүүгээр нөхөн төлөх боломжтой юм. Зарим орнуудад сургалтын өртөг (сургагчийн хөлсийг оруулалгүйгээр) болон сургалтын дараах төгсөгчидтэй уулзах зардал нь олгосон зээлээр нөхөн төлөгдөж байсан бөгөөд тэр ч байтугай зээл авагчид нь зөвлөх үйлчилгээнд төлбөр төлж байсан болно. Гэхдээ зарим газар, ялангуяа хөгжиж буй орнуудад зээлийн хүү өндөр байдаг (жилд 30 хүртэлх хувьтай). Иймд зээлийн хүүг бууруулах, тогтворжуулах талаар тодорхой арга хэмжээ авагдаагүй хүүг тогтоох нь ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдийн орлого бий болгох үйл ажиллагаа болон бичил үйлдвэрлэлийг эрсдэлтэй байдалд оруулж болох юм;

ХЭЗЧДС-ын зорилтод бүлгүүд болох ядуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оруулж байгаа хувь нэмэр нь сургалт болон сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хангалтгүй байх магадлал өндөр гэдгийг тусгайлан анхааруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Эхний үед үйл ажиллагаа явуулахад доноруудын дэмжлэгийг авч болох ч, цаашид хөтөлбөрийг гадны тусламжгүйгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй юм. Иймд хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахын тулд улсын болон орон нутгийн байнгын санхүүжилт шаардлагатай болно. Хэдийгээр ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зарцуулах нийгэм, эдийн засгийн хүч, нөөц бололцоог шууд тооцоход хүндрэлтэй ч гэсэн, энэ нь ямагт Хөтөлбөр хэрэгжүүлснээс илүү өндөр өртөгтэй, үр дүн багатай байх магадлалтай.

ХЭЗЧДС-ынхөтөлбөрийгхэрэгжүүлэхголбайгууллага нь шаардлагатай хөрөнгө, мөнгийг өөрийн бололцоо эсвэл бусад байгууллагын тусламжтайгаар бүрдүүлэх чадвартай байх хэрэгтэй. Сургалтын нөөцийг үр дүнтэй ашиглахын тулд үйл ажиллагаатай холбогдох бүхий л төлөвлөлтийг холбогдох яамд, төрийн бус байгууллагууд, сургалтын үр шимийг шууд хүртэгчидхүртэгчид болон тухайн орон нутгийн оролцоотойгоор хийх нь зүйтэй. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжих үндсэн нөхцөл нь оролцогч этгээдүүдийн хамтарсан төлөвлөлт болон хэрэгжүүлэлтэд суурилна.

7. Тогтвортой байдал

ХЭЗЧДС-ын хувьд тогтвортой байдлын асуудал маш чухал. Иймээс тогтвортой байдлыг хангах, тогтвортой байдалд хяналт шинжилгээ хийх тодорхой стратегийг боловсруулсан байх нь чухал. Түүнчлэн тогтвортой байдалд үнэлгээ хийх нь алдаа дутагдлыг (дэд бүтэц, байгууллагуудын оролцоо, хөтөлбөрийн стратеги болон төлөвлөлтөд өөрчлөлт оруулах) тухай бүрд илрүүлж, засах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Тогтвортой байдалтай холбогдолтой асуудал нь шийдвэрлэхэд маш

хүндрэлтэй гэдгийг мэдэж байх нь зүйтэй. Зохистой зөв бодлого (тухайлбал, ядуу эрэгтэй болон эмэгтэйчүүдийн бодит хэрэгцээнд бүрэн нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх бодлого, бичил болон жижиг үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжсэн орчин, жендерийн эрх тэгш байдал гэх мэт) баримтлах нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ур дүнг жигд тогтвортой байх магадлалыг бүрдүүлнэ.

Тогтвортой байдал нь дараах гол хүчин зүйлүүдээс хамаарна. Үүнд:

- ☐ ХЭЗЧДС-ын зохистой тогтолцоо;
- ☐ орон нутгийн олон нийт ба түнш байгууллагуудын дэмжлэг;
- ☐ эдийн засгийн үйл ажиллагааг сонгох үр дүнтэй механизм;
- ☐ зорилтод бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалт болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа;
- ☐ сургалт болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чанар, хүртээмж;
- ☐ эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын чин эрмэлзэл;
- ☐ сургалт болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн хангалттай нөөц;
- ☐ нийгэм эдийн засгийн таатай нөхцөл (ажлын байр бий болгох, зохистой боловсрол болон сургалтын бодлого, төвлөрлийг сааруулах хандлага гэх мэт, ядуу эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хэрэгцээг бүрэн тооцсон, зохистой жендерийн харилцааг дэмжсэн гэх мэт).

Удаан хугацааны тогтвортой байдлыг бий болгохын тулд нутгийн ард, иргэд, олон нийт, орон нутгийг хөгжүүлэх эрх бүхий байгууллагуудтай нягт харилцаатай ажиллах хэрэгтэй.

Үйлчлүүлэгч (сургалтад хамрагдагчид)-ийг зөв сонгох гэдэг нь мөн тогтвортой байдалд нөлөөлөх чухал нөхцөл юм. Хэрэв тухайн сонгосон үйлчлүүлэгчид нь үйл ажиллагаанд чин сэтгэлээсээ хандахгүй, эхлүүлсэн бизнесээ үр дүн муутай эрхэлж, авсан зээлээ төлөхдөө хүндрэл учруулбал энэ нь орон нутгийн эрх бүхий байгууллага, зээл олгогч болон орон нутгийн олон нийтийн хөтөлбөрийн урт хугацааны тогтвортой байдалд итгэх итгэлийг бууруулах магадлалтай. Өөрөөр хэлбэл, зорилтод бүлэгт хамрах хувь хүний болон хамт олны эдийн засгийн үйл ажиллагаа нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн тогтвортой мөн итгэлтэй байдлыг бий болгоход шууд нөлөөлөх юм. [4]

Олон улсын хөдөлмөрийн байгууллага ба бусад оролцогчдын үүрэг оролцоо

ОУХБ нь ХЭЗЧДС-ын холбогдолтой техникийн хамтын ажиллагааны төслүүдийг дэлхийн хэмжээнд зохион байгуулж, хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн хөтөлбөр хэрэгжүүлэх эхний шатанд чиглэл өгч, тухайн улс орон болон орон нутгийн байгууллагууд нь цаашид хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэх чадвартай болтол нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой.

ХЭЗЧДС-ын арга зүйн үндсэн зорилго нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдийн чадамжтай болгох юм. Харин ерөнхий зорилго нь хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах, ядуу иргэдийг чадавхижуулахад чиглэгдсэн, үндэсний хөдөлмөр эрхлэлт болон сургалтын стратеги, хөтөлбөрүүдийн хүрээнд энэхүү арга зүйг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлж, тогтвортой байдлыг хангахад оршино.

- Иймд ОУХБ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чиглүүлэх, зөвлөхийн үүрэг гүйцэтгэж ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн агуулга, зарчмыг таниулах үндэсний хэмжээний сургалт семинарыг зохион байгуулна. Үүний тулд:
  - ☐ ядуурлыг бууруулах сургалтын үйл ажиллагаатай холбогдох шинэлэг чиг хандлагыг хэлэлцэж, хамгийн ур дүнтэй чиг хандлага, боломж болон бэрхшээлтэй асуудлуудыг тодруулж хэлэлцэх;
  - ☐ хөдөөгийн эдийн засгийг чадавхижуулах, орлогыг бий болгох болон ядуурлыг бууруулахад чиглэгдсэн ОУХБ-ын ХЭЗЧДС-ын арга зүйг танилж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцох;
  - ☐ ОУХБ-ын Өөрийн бизнесийг эхэлж, сайжруулах хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн хөгжил болон жендерийн хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийн стратегийн хэсэг болох Бичил болон жижиг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн ОУХБ-ын хөтөлбөрүүдийг танилцуулах;
  - ☐ орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих санаачлагын хэсэг болох өөрийгөө цалинжуулах орлого бий болгох үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийг танилцуулж, туршлага болон мэдээлэл солилцох форумыг зохион байгуулах;
  - ☐ ОУХБ-ын тусламжтайгаар ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн хамтын ажиллагааны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиромжтой тогтолцоо болон засаглалын хэлбэрийн талаар зөвлөгөө өгөх;
- орон нутгийн нийтийн бүлэглэлүүд, нийгэмлэгүүд, үндэсний болон орон нутгийн хэмжээний зохицуулах нэгжүүд, сургалтын байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх, сургах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;

4 Гэхдээ энэ нь үйлчлүүлэгчийг сонгож авахдаа боловсрол болон ядуурлын түвшнөөс хамааран хөтөлбөрт оролцох эрхийг хязгаарлана гэсэн үг биш юм. Учир нь ийм стратеги нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үндсэн зорилттой зөрчилдөж байгаа болно.

- тодорхой туслалцаа үзүүлэх боломжтой төрөлжсөн байгууллагууд, тухайлбал, хадгаламж зээлийн салбарын байгууллагууд, нийгмийн хамгааллын арга хэрэгсэл, бичил болон жижиг үйлдвэрлэл эхлүүлэн хөгжүүлэх, мэргэжлийн эрүүл ахуйн болон аюулгүй байдал, нийгэмлэг, төлөөлөгчийн газрыг байгуулах ба түүний удирдлагыг хэрхэн зохион байгуулах, нөхөрлөл болон бусад хэлбэрийн эдийн засгийн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийг байгуулах мөн тэдгээрийн үйл ажиллгааны менежмент, жендерийн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлагын талаар зөвлөгөө өгөх;
- сургалтын загвар болон гарын авлага боловсруулахад туслалцаа үзүүлэх;
- зарчим болон арга зүйн лавлагаа өгөх;
- тухайн орны нөхцөл байдалд нийцсэн Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалтын үндсэн гарын авлага боловсруулах (бусад орнуудад туршилтын журмаар явуулсан үйл ажиллагааны үр дүнд түшиглэсэн). Гарын авлага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй арга зүйн удирлагаар хангах үйл ажиллагааны үе шатыг дэлгэрэнгүй тайлбарласан байх бөгөөд үйл ажиллагааны үе шат, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын түвшинд хэрэглэх арга хэрэгсэл болон аргачлалын зааварчилгааг агуулсан байна.

II Оршил I.Тогтолцоо болон төлөвлөлт. II. ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэхэд оролцох түнш байгууллагуудын чадварыг нэмэгдүүлэх. Хавсралт

Байгууллага, тогтолцооны зохион байгуулалт ба төлөвлөлт

Оршил

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилт нь ерөнхийдөө хөтөлбөрийн баримт бичиг дээр суурилан явагдана. Энэхүү баримт бичиг нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улс орон эсвэл бүс нутгийн онцлогт нийцэж хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байх бөгөөд тухайн бүс нутгийн онцлогтой уялдуулсан зорилт, стратеги, тогтолцооны болон хэрэгжилтийн нөхцөл, зорилтод бүлгүүд, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжүүлэх арга хэмжээ болон хүчин чармайлт, тогтолцоог бэхжүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангах зэрэг асуудлуудыг тодорхой тусгасан байна.

→ **Хавсралт 2.1-ээс ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баримт бичгийн агуулгыг харна уу.**

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцын туршид төлөвлөлт байнга, үргэлжилсэн үйл ажиллагааны хэлбэрээр хийгдэж байх юм. Энэ бүлгийн гол зорилго нь ХЭЗЧДС-ын тогтолцоо, төлөвлөлтийг талаар дэлгэрэнгүй ойлголт өгч, таниулахад оршино. Энэ хэсэгт ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үндэсний болон тухайн хөтөлбөр хэрэгжих орон нутгийн түвшинд үйл ажиллагааг явуулах, удирдан зохион байгуулах бүтцийг бий болгох талаар дэлгэрэнгүй авч үзэх болно.

Тогтолцоо болон төлөвлөлт

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхний хэдхэн сарын дотор хөтөлбөрийг удирдлагаар хангах, зохин байгуулах тогтолцоог бүрдүүлсэн байх хэрэгтэй. Тогтолцоог бүрдүүлэх нь тус хөтөлбөрийг туршилтын журмаар тодорхой хязгаарлагдмал бүс нутгийн хэмжээнд явуулж байгаа, эсвэл үндэсний хэмжээнд бүх орон даяар, эсвэл тодорхой орон нутгийн засаг захиргааны нэгж дээр хэрэгжүүлхээс хамаарна. Түүнчлэн уг асуудал нь хөтөлбөрийг хэрэгжүүлж буй улс орны засаг захиргааны төвлөрөл, санхүүжилтийн түвшин, хөтөлбөрийн статус зэргээс хамаарна. Жишээ нь, зарим тохиолдолд үндэсний зөвлөх хороогүй байж болох юм. Харин түүний оронд засгийн газрын эрх бүхий байгууллага ерөнхий үйл ажилагааг удирдан чиглүүлж, харин орон нутгийн түвшний зөвлөлдөх хороо дээр дурьдсан үндэсний зөвлөлдөх хорооны үүргийг гүйцэтгэж болнь. Өөрөөр хэлбэл тогтолцоог бүрдүүлэх, тодорхой байгууллагад ажил хариуцуулах нь тухайн улс орны нөхцөл байдал, хэрэгцээнээс хамаарч өөр өөр байж болно гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Нэгдүгээр зурагт үзүүлсэн бүдүүвч нь зөвхөн тогтолцооны боломжит хувилбарыг харуулж байгаа бөгөөд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлбэл заавал ийм бүтэцтэй байна гэсэн үг биш юм.

Бүдүүвч 1. Тогтолцооны бүдүүвч



1. Үндэсний тогтолцоо

а). Үндэсний гүйцэтгэх нэгжийг томилох нь (ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллага)

Үндэсний эсвэл улсын хэмжээнд холбогдох яам, эсвэл агентлаг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах болон хэргжүүлэх ажлын зохион байгуулагчаар томилогдсон байх нь зүйтэй.

Үүний тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг байх ёстой. Түүнчлэн дээрх байгууллага нь үйл ажиллагаатай холбогдох талуудын хоорондын зохицуулалтыг хариуцана. Дээр дурьдсан чиг үүрэг нь бодлогын түвшинд гарсан шийдвэрт тухайн яам эсвэл агентлагийн үйл ажиллагааны үндсэн үүрэг, эрхлэх асуудлын хүрээд хамаарах талаар дурьдах нь зүйтэй. Мөн үндэсний хэмжээнд хэрэгжилтийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж бүхий нөөц, туршлага, чадвартай байх хэрэгтэй бөгөөд энэ байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнг тайлагнах үүрэг хүлээнэ.

б). Үндэсний түнш байгууллагуудыг сонгож, тэдгээрийн үйл ажиллагааг зохион байгуулах

Түншийн харилцааг хөгжүүлнэ гэдэг нь ХЭЗЧДС-ын арга зүйн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын нэг. ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь ХЭЗЧДС-ын зорилго болон зорилттой холбогдох чиг үүрэг бүхий түнш байгууллагуудтай хамтран ажиллах тохиолдолд үр дүнд хүрэх боломж илүүтэй байх болно. Түүнчлэн түнш байгууллагууд нь бодлогын хувьд бичил болон жижиг үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах санхүүжилт, зохион байгуулалт, жендерийн тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхагдсан нийгмийн бүлгүүдийг дэмжих зэргийн ядуурлыг бууруулах, хөдөөг хөгжүүлэх зорилго бүхий байвал зохистой юм. Дээрх үзүүлэлтүүд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх нөөц, боломжийг хамтран ашиглах нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Болзошгүй түнш байгууллагын чадавхид дүн шинжилгээ хийхэд дараах шинжүүдийг харгалзаж сонголт хийх хэрэгтэй. Үүнд:

- ☐ байгууллагын төрөл, үндсэн үйл ажиллагааны хамрах хүрээ, сургалт төлөвлөх, хэрэгжүүлэх болон сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий чадавхи;
- ☐ бодлогын түвшинд болон үйл ажиллагаандаа жендерийн тэгш эрхийг хангах зарчмыг баримталдаг, түүнчлэн эмэгтэй болон эрэгтэйчүүдийг боловсрол,

сургалт болон ажил эрхлэлтийн байдлаас хамааран ялгаварлан гадуурхахгүй байлгах талаар тодорхой туршлага бүхий байх;

- ☐ ядуу иргэдэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах боломжтой байгууллагын бүтэцтэй байх;
- ☐ болзошгүй түнш байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх хэрэгцээ.

в). ХЭЗЧДС-ын үндэсний зөвлөлдөх хороо

Нэгэнт үндэсний хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхойлсны дараа төлөвлөлт, хяналт, үйл ажиллагааны явц, зорилтод бүлгүүд болон хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж бодлогын түвшинд удирдлагаар хангах, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн санхүүжилт, үйлдвэрлэлийн хөгжил, жендерийн тэгш байдал, шаардлагатай тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх боломж бүхий үндэсний зөвлөлдөх хороог байгуулна. Энэхүү хороо нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ерөнхий зөвлөлдөх эрх бүхий байгууллага байх болно. (Хүснэгт 1). Мөн дээрхи үндэсний зөвлөлдөх хороо нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамаарах хөгжил, тогтолцоо болон тогтвортой байдлыг хангах бодлогын асуудал дээр засгийн газарт зөвлөх чиг үүрэгтэй байх болно.

ХЭЗЧДС-ын үндэсний зөвлөлдөх хорооны гишүүд нь хөтөлбөртэй холбогдох сургалт, хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, жендерийн тэгш байдлыг хангахын төлөө болон хөгжлийн бэрхшээлтэй эсвэл ДОХ-ын халдвартай хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, бичил болон жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хөдөө орон нутагт шинэ технологи нэвтрүүлэх, хөдөөгийн иргэдийн амьдралыг дэмжих зорилгоор зөөл олгох үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн байх нь зохимжтой.

Хүснэгт 1 ХЭЗЧДС-ын үндэсний зөвлөлдөх хороо

Үндэсний зөвлөлдөх хороо нь дараах үндсэн чиг үүргийн хэрэгжүүлнэ. Үүнд:

- ○ ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх;
- ○ хөтөлбөрийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, батлах;
- ○ хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагааны талаар зөвлөмж, чиглэл өгөх;
- ○ хөтөлбөрийн хэрэгжих хүрээ болон зорилтод бүлгүүдийг сонгох асуудал дээр зөвлөмж өгөх;
- ○ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад зөвлөмж өгөх;
- ○ ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх болон дасан зохицоход шаардлагатай нөхцөл байдлыг бүрдүүлэхэд анхаарах;
- ○ түнш байгууллагууд болон орон нутгийн оршин суугчдын дунд ХЭЗЧДС-ын арга зүйг нэвтрүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авах.

Ажилчид болон ажил олгогчдын төлөөлөл болсон байгууллагууд, хөдөө орон нутгийн хэмжээнд үйлчлэх чиг үүрэг бүхий санхүүгийн байгууллагууд (тухайлбал, ажил эрхлэлт болон бусад нийгмийн сангууд)-ын оролцоог хангах тал дээр анхаарал хандуулах нь зүйтэй.

Зөвлөлдөх хорооны гишүүд нь бодлогын хэмжээнд дэмжлэг үзүүлэх боломжтой, холбогдох байгууллагуудын хувьд шийдвэр гаргах түвшний өндөр албан тушаалтай байх нь зохиомжтой.

Хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөгч нь ихэвчлэн зөвлөлдөх хорооны даргаар томилогддог. ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгж нь үндэсний зөвлөлдөх хорооны ажлын албаны үүрэг гүйцэтгэх бөгөөд хурал зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай мэдээллийг тараах болон зар хүргэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

г). Үндэсний түвшинд зохицуулах нэгж

ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгж нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэгтэй. Үндэсний зохицуулагч нэгж нь бүс нутаг, дүүрэг, эсвэл орон нутгийн засаг захиргааны нэгжийн түвшинд ажиллах ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн туслалцаатайгаар үйл ажиллагаагаа явуулна. Хэрэв боломжтой бол дээр дурьдсан салбар зөвлөлүүдийг үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг гүйцэтгэж байгаа яам эсвэл агентлагын харьяа нэгжүүдийг түшиглэн байгуулах зүйтэй.

Үндэсний түвшинд зохицуулах нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдох үйл ажиллагааны чиглэлийг боловсруулахын зэрэгцээ санхүү болон захиргааны асуудлыг зохицуулна. Дээр дурьдсан бодлогын чиглэлийг тодорхойлох үйл ажиллагаа нь орон нутаг дах салбар зөвлөлүүдтэй санал солилцсоны үндсэн дээр боловсруулагдаж байх нь зүйтэй гэдгийг анхаарах хэрэгтэй. ХЭЗЧДС-ын үндэсний түвшинд зохицуулах нэгжийн бүтэц нь тухайн үндсэн байгууллагын бүтэц, хэрэгжүүлэх стратеги болон хөтөлбөрийн хэрэгжүүлэх цар хүрээнээс хамаарна.

Үндэсний түвшинд зохицуулах нэгжид ажиллагчид нь орон тооны байх бөгөөд хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай тодорхой ажлын дадлага туршлагатай байхын зэрэгцээ багийн гишүүн бүр хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой салбар мэргэшсэн байх нь зүйтэй.

Үндэсний түвшинд зохицуулах нэгжид дараах албан тушаалууд байж болно. Үүнд:

- ☐ үндэсний хөтөлбөрийг зохицуулагч;
- ☐ нийгэм-эдийн засгийн чиглэлийн ажилтан;
- ☐ сургалт хариуцсан мэргэжилтэн.

Үндэсний хөтөлбөрийг зохицуулагч нь хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцах бөгөөд үндэсний түвшинд зохицуулах нэгжийн дарга

байна. Дээрх албан тушаалтан нь мөн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн тэгш эрх байдлыг хангах, оролцогч байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцана.

Нийгэм эдийн засгийн ажилтан нь орон нутгийн ХЭЗЧДС-ын салбар зөвлөлийн тусламжтайгаар үндэсний хөтөлбөрийн зохицуулагчийн удирдлага дор ажиллана. Нийгэм эдийн засгийн ажилтан нь тухайн орон нутагт шаардлагатай сургалтын өмнөх судалгааг (анхан шатны судалгаа, эрэлт хэрэгцээний судалгаа, эдийн засгийн боломжийн судалгаа гэх мэт) төлөвлөх болон гүйцэтгэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангана. Мөн сургалтын дараах дэмжих үйл ажиллагааны төлөвлөлт болон хэрэгжилтийг хариуцана.

Сургалтын мэргэжилтэн нь үндэсний хөтөлбөрийн зохицуулагчийн шууд удирдлага дор ажиллах бөгөөд ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ болон үнэлгээний асуудлыг хариуцана. Дээрх ажиллагаанудад мөн сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын саналыг хянах, сургалтын хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээний үйл ажиллагааны явцад хяналт тавих, сургалтын үр дүнг тооцох, сургалтын үйл ажиллагааны тайланг гаргах зэрэг хамаарна.

Сургалтын мэргэжилтний орон тоон дээр хэд хэдэн мэргэжилтэн ажиллаж болох бөгөөд ажил үүргийн хуваарийг дараах байдлаар хувааж болно. Үүнд:

- ☐ үйлдвэрлэлийн сургалт;
- ☐ сургагчийн сургалт;
- ☐ сургалтын хөтөлбөр боловсруулах гэх мэт.

Түүнчлэн шаардлагатай тохиолдолд үндэсний түвшинд зохицуулах нэгжид дараах орон тоог нэмж болох юм. Үүнд:

- ☐ бичил болон жижиг үйлдвэрлэлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- ☐ жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- ☐ орон нутгийн хөгжил хариуцсан мэргэжилтэн;
- ☐ бичиг баримтын бүрдүүлэлт/баримтжуулалт болон үнэлгээ хариуцсан мэргэжилтэн;
- ☐ ажлын байр болон сургалтын дараах үйлчилгээг хариуцсан мэргэжилтэн.

Зарим тохиолдолд ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байдаг. Асуудлыг тусгайлан хариуцсан мэргэжилтэй байх нь нэгжийн бусад гишүүд үйл ажиллагаандаа жендерийн асуудлыг байнга тусган ажиллахад дэмжлэг болдог. Мөн жендерийн асуудал дээр анхаарал хандуулдаг сургалтын, мөн нийгэм эдийн засгийн асуудал хариуцсанмэргэжилтэнтэй байх нь ажилд эергээр нөлөөлдөг байна. Бангладеш болон Зүүн Тимморт хэрэгжиж буй төслийн нэгжүүдэд жендерийн асуудал хариуцсан тусгай багууд ажиллаж байжээ. Захиргаа болон санхүүгийн асуудал хариуцсан туслах ажилтан болон бусад үйлчилгээний (нарийн бичиг, жолооч гэх мэт) ажилтны орон тоо зарим тохиолдолд хэрэгтэй байдаг.

Жендерийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, орон нутгийн оршин суугчдын хэрэгцээ, нөөц болон хөдөө аж ахуйн бус эдийн засгийн үйл ажиллагаа, боломжийн судалгаа, макро эдийн засгийн хангамж болон эрэлт хэрэгцээний судалгаа, технологи, зээл болон зах зээлийн асуудлаар мэргэшсэн зөвлөхүүдийг ажилуулж болно. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг үндэсний түвшинд зохицуулах нэгжийн орон тоо нь хэрэгжүүлж буй үйл ажиллагааны цар хүрээнээс хамааралтай бөгөөд зарим тохиолдолд хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлж буй тохиолдолд цөөн хүнтэй цомхон баг байх боломжтой боловч, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тохиолдолд орон тоо нэмэх шаардлага гардаг. Туршлагаас харахад ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, мэргэжлийн өндөр ур чадвартай, тухайн орны иргэн байхын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд хөрвөх чадвартай боловсон хүчнийг сонгож авах нь зүйтэй юм. Тухайн улсын иргэн байх нь ХЭЗЧДС-ын чиг хандлагыг орон нутгийн нөхцөл байдалтай илүү уялдуулж, дасан зохицох чадвартайг илтгэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн асуудалд мөн жендерийн тэгш байдлыг анхаарах нь зүйтэй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндэсний түвшинд зохицуулах нэгж долоо хоног бүр хөтөлбөрийн хэрэгжилт болон цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх уулзалт хуралдаануудыг зохион байгуулж байх нь зүйтэй юм.

➔ **ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажиллагчдад тавигдах шаардлагын загварыг хавсралт 2.2-оос харна уу.**

2. Орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулах тогтолцоо

а. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх салбар зөвлөлийн чиг үүрэг, бүтэц

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх салбар зөвлөл нь хөтөлбөр хэрэгжиж буй тухайн орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй. Салбар зөвлөл нь хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зарчмаас хамааран бүс нутаг эсвэл орон нутгийн засаг захиргааны түвшинд байгуулагдсан байж болно.

Салбар зөвлөлийн орон тоо нь үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарна. Ихэвчлэн салбар зөвлөл доод тал нь 3 ажилтны орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг байхын зэрэгцээ эдгээр орон тоонд томилгоог тухайн орон нутагт хамтарч үйл ажиллагаа явуулж байгаа түнш байгууллагуудын саналыг харгалзан хийдэг бөгөөд дараах маягаар ажил үүргийг нь хуваарилдаг байна. Үүнд:

- ХЭЗЧДС-ын орон нутгийн салбар зөвлөлийн зохицуулагч (орон нутаг дах олон нийтийн зохицуулалт болон жендерийн асуудлыг давхар хариуцана);
- орон нутгийн нийгэм-эдийн засгийн асуудал хариуцсан ажилтан (сургалтын хэрэгцээг тодорхойлохоос өмнө орон нутгийн хэмжээнд явуулах нийгэм-эдийн засгийн судалгаа, сургалтын төлөвлөлт болон сургалтын дараах дэмжлэг үзүүлэх арга хэмжээ зэрэг асуудлыг хариуцана);
- орон нутгийн сургалтын ажилтан (орон нутгийн хэмжээнд явуулах сургалттай холбогдох бүх асуудлыг хариуцана).

Орон нутгийн салбар зөвлөлийн гишүүдийг ур чадвар болон ажлын дадлага туршлага дээр суурилан сонгож авах нь зүйтэй. Орон нутгийн салбар зөвлөлийн гишүүд дээрх ажлын байранд томилогдож үндсэн ажилдаа орохоос өмнө ХЭЗЧДС-ын арга зүйн сургалтад хамрагдсан байна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн өдөр тутмын үйл ажиллагааг орон нутагт зохицуулах чиг үүрэг бүхий ажилтнууд нь шаардлагатай бол хөтөлбөрт хамаарах бүхий л үйл ажиллагаанд оролцох бөгөөд хэд хэдэн газарт зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд адил түвшинд оролцох, хөрвөх чадвартай байна. ХЭЗЧДС-ын орон нутгийн салбар зөвлөлийн гишүүд нь ажлын боломжоосоо хамааран доод тал нь 2 долоо хоног тутам хамтарсан уулзалт, хурлыг зохион байгуулж, үйл ажиллагааны явц болон цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж байх нь зүйтэй.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн орон нутгийн түвшинд үр дүнтэй тогтвортой хэрэгжих нь тухайн орон нутгийн засаг захиргаа болон орон нутгийн зүгээс хөтөлбөрт хамрагдаж байгаа байгууллагуудын эрмэлзэл, идэвхтэй байдлаас хамаарах бөгөөд сургалт болон сургалтын дараах үйл ажиллагаанд дээрх байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа чухал.

Арга зүй нь бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд удаан хугацааны үйл ажиллагааны хэлбэрээр хэрэгжих ба тухайн орон нутгийн хүн хүчний нөөц нь дээрх үйл ажиллагааг явуулах туршлага хуримтлуулж, хяналт тавьж ажиллах нь чухал.

б. Орон нутаг дах ХЭЗЧДС-ын зөвлөлүүд

Орон нутгийн ХЭЗЧДС-ын багууд нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн эхлэл тавигдах үе шатанд байгуулагдсан байх ёстой. Эдгээр орон нутгийн багууд нь зорилтод бүлгүүд, орон нутгийн засаг захиргаа болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн ард иргэдийн идэвхтэй гишүүд, ажил олгогч болон үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, бие даасан ажил олгогчид, санхүүгийн байгууллагууд, орон нутгийн төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.

Дээрх зөвлөлийн гишүүнчлэл нь тухайн орон нутгийн нөхцөл байдлаас хамааралтай байж болно. Орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид энэ зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцуулах замаар засаг захиргааны болон тодорхой чиг үүрэг бүхий төрийн байгууллага, нэгжийн дэмжлэгийг хөтөлбөрийг хэрэгжих хугацааны туршид авч байх нь чухал юм. Түүнчлэн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн байгууллага, залуучуудын байгууллага, хөдөөгийн ажилчдын холбоо гэх зэрэг орон нутгийн ард иргэдийн бүлэглэлүүдийн дэмжлэг мөн адил чухал юм.

Орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлийн гишүүнчлэлийн талаарх санал:

- орон нутгийн захиргааны ажилтан (эсвэл төлөөлөл);
- орон нутгийн холбогдох төрийн байгууллагын төлөөлөл;
- орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ТББ болон шашны байгууллагын төлөөлөл;
- эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөл;
- залуучуудын төлөөлөл;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;
- хөдөөгийн хөгжилд хувь нэмэр оруулж буй санхүүгийн байгууллага;
- орон нутгийн бизнес эрхлэгчид (амжилттай бизнес эрхэлж буй) зэрэг болно.

Орон нутгийн ХЭЗЧДС-ын баг нь тухайн орон нутгийн ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх салбар зөвлөлтэй хамтран дараах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно. Үүнд:

- эдийн засгийн боломжийг бий болгоход хувь нэмэр оруулж, хөдөлмөр эрхлэлт болон орлого бий болгох боломжийн судалгааг орон нутгийн түвшинд хийхэд дэмжлэг үзүүлэх;
- жендерийн тэгш эрхийг хангах, энэ асуудалд холбогдох дүн шинжилгээ хийхэд хувь нэмэр оруулах;
- болзошгүй хөдөлмөр эрхлэлт болон орлогыг бий болгох төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлоход хувь нэмэр оруулах;
- сургалтын хэрэгцээг тодорхойлоход хувь нэмэр оруулах;
- иргэдийг сургалтад идэвхтэй хамруулах, сургалтад хамрагдах иргэдийг сонгоход дэмжлэг үзүүлэх;
- техникийн туслалцааны хэрэгцээг тодорхойлох;
- орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлийн гишүүд, түнш байгууллагуудын туслалцаа, дэмжлэгийг нэгтгэж, дайчлах;
- орон нутгийн зүгээс хөтөлбөрийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх ажил зохион байгуулах.

Орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлүүдийн зүгээс ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багтай хамтран ажиллаж, шийдвэр гаргах түвшинд зөвлөмжөөр хангах нь хөтөлбөрийн үр шимийг тухайн орон нутагт хүртэж байгаа иргэдийн эрх ашигт нийцүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн үйл ажиллагаа явуулахад тус дэм болно.

в. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийг сонгох болон сонголт хийх талаарх зөвлөмж

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг тухайн орон нутгийн тодорхой засаг захиргааны нэгж эсвэл хүн ам тодорхой хэсгийн ард иргэдийн дунд хэрэгжүүлэх эсэх асуудлыг орон нутгийг салбар зөвлөл нь үндэсний түвшинд зохицуулах нэгжэй зөвшилсөний дагуу санал болгоно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь өөрийн төлөөлөл болон ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгжийн зохицуулагчийг газар дээр нь бодит байдалтай танилцуулсны үндсэн дээр эцсийн шийдвэрийг гаргана.

Хэрэгжүүлэх газрыг сонгон шалгаруулахад тавигдах шаардлага нь хэрэгжүүлэгч байгууллага болон тухайн бүс нутгийн онцлогоос хамаарах боловч ихэнх тохиолдолд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилт ядуурлын түвшин, хэрэгцээ, иргэдийг өргөнөөр хамруулах боломж,нөөц бололцоо гэх мэт хүчин зүйлүүдээс шалтгаална.

➔ **Сонгох үйл ажиллагаанд тавигдах шаардлагын үлгэрчилсэн загварыг хавсралт 2.3-аас харна уу.**

Хөтөлбөрийг хэрэгжүүлж болзошгүй газрыг сонгон авахдаа орон нутаг, бүс нутаг болон үндэсний хэмжээнд цуглуулж болох нийгэм эдийн засгийн судалгааны дүн, үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлүүдийн талаарх мэдээлэл дээр тулгуурлаж болно. Дээрх төрлийн мэдээллүүд нь орон нутгийн болон бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, зарим ТББ-аас авч болох юм.

Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөр зэрэг нь шалгуур үзүүлэлтүүдийн тоонд орж болно. Тодорхой яам болон ТББ-ын түвшинд дараах мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийж болох юм . Үүнд:

- Худалдаа аж үйлдвэрийн яамны хувьд хөдөө орон нутагт оруулах хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн эдийн засгийн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд;
- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн талаарх мэдээлэл авч болох боловч эдгээр мэдээлэл нь тухайн орон нутаг дахь эдийн засгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн илэрхийлж чаддаггүй. Учир нь ихэнх тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн эмзэг бүлгүүдийн асуудал тэр болгон бүрэн тусгагдаагүй орхигдсон байдаг. Иймд энэ талын мэдээллийг нийгмийн хамгааллын яамнаас тусдаа авах нь зүйтэй;
- Хөдөө аж ахуйн яам ихэнх тохиолдолд хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөдөө орон нутгийн ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл хуримтлуулсан байдаг;
- Тээвэрлэлт болон холбооны яамнаас тухайн орон нутагт хүргэж дэд бүтцийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах боломжтой;
- Идэвхтэй үйл ажиллагааг явуулдаг ТББ-ууд нь үйл ажиллагаа явуулдаг орон нутгийнхаа хүн амын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байдаг. Хэдийгээр төрийн бус байгууллагуудын гишүүд тодорхой бичигдсэн эсвэл бүртгэгдсэн мэдээлэл багатай ч гэсэн тухайн орон нутгийн болзошгүй зорилтод бүлгүүдтэй холбоотой байдаг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалтай холбогдуулж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын талаарх мэдээлэл хэрэгцээтэй байж болох юм. Гэхдээ тухайн ТББ тэдгээр иргэдийг үнэн бодитойгоор төлөөлж байх шаардлагатай;
- Орон нутгийн засаг захиргааны нэгжүүдээс тухайн орон нутгийн хөгжлийн талаарх мэдээллийг авах боломжтой.

Газар дээр нь очиж, нөхцөл байдалтай нь танилцах

Урьдчилсан байдлаар ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой орон нутгийн жагсаалт гаргасны үндсэн дээр ХЭЗЧДС-ын үндэсний түвшинд зохицуулах нэгж нь очиж нөхцөл байдалтай танилцана. Газар дээр нь очиж танилцах үйл ажиллагаа тухайн орон нутгийн ерөнхий болон нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаа холбоотой хэрэгжүүлж болохуйц төслүүдийн талаар мэдээлэл авахад чиглэгдэнэ. Түүнчлэн, танилцах үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн ард иргэдийн төлөөлөл, санхүүгийн байгууллагууд, ТББ болон хөтөлбөрийн үр шимийг хүртэж болзошгүй иргэдийн төлөөлөлтэй уулзаж санал солилцох боломжийг бүрдүүлнэ. Газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцах нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- ☐ өмнө нь цуглуулсан мэдээллийн үнэн бодит байдалтай танилцаж, нэмэлт мэдээлэл авах;
- ☐ орон нутгийн ард иргэдийн төлөөлөлтэй уулзах, орон нутгийн засаг захиргааны зүгээс сургалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр явуулж буй үйл ажиллагаатай танилцах;
- ☐ хөтөлбөрт хамрагдаж болзошгүй иргэд болон тэдгээрийн талаар ойлголттой болох;
- ☐ орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх.Танилцах уулзалтыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
- ☐ нутгийн засаг захиргааны холбогдох ажилтантай уулзаж ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилт, ач холбогдлын талаар санал солилцох;
- ☐ хөтөлбөрийн талаар тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад төрийн байгууллагатай санал солилцох;

ТББ-ын төлөөлөлтэй уулзаж санал солилцох;

- ☐ орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүмүүстэй санал солилцох;
- ☐ санхүүгийн байгууллага болон бусад болзошгүй түнш байгууллагын төлөөлөлтэй уулзах;

- уулзалтийн үеэр үндэсний түвшинд зохицуулах нэгж нь орон нутгийн ХЭЗЧДС-ын салбар зөвлөл болон багийн саналыг үндэслэн хэрэгжүүлэгч байгууллага нь эцсийн шийдвэрийг гаргах болно гэдгийг мэдээлнэ.

Орон нутгийн засаг захиргаатай зөвлөлдөх

Зөвлөлдөх уулзалтууд нь орон нутгийн засаг захиргаанаас эхлэх нь зүйтэй. Уулзалтын явцад ХЭЗЧДС-ын хөтөлбөр, арга зүй болон хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сонгож болох тодорхой газрын талаар орон нутгийн засаг захиргааны төлөөлөлтэй санал солилцоно. Орон нутгийн засаг захиргааны оролцоо нь хөтөлбөрийг удаан хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, ялангуяа сургалтын дараах дэмжлэгийг зохион байгуулах, бичил болон жижиг үйлдвэрлэлийг дэмжихэд чухал ач холбогдолтой билээ. Иймд орон нутгийн засаг захиргааны сонирхолыг татаж хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах нь чухал юм.

Орон нутгийн засаг захиргаанаас авч болох мэдээллүүд

Тухайн орон нутагт байгаа засаг захиргааны нэгж болон (сум/дүүрэг, баг/хороод) тэдгээрийн хүн ам, тухайн орон нутагт зонхилж байдаг эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

- тухайн орон нутагт байгаа боловч одоогоор хэрэглэгддэггүй түүхий эд, тэдгээрийг боловсруулах шат дамжлагын талаарх мэдээлэл;
- орон нутгийн хэмжээнд боломжтой үйлчилгээ болох зээл, ур чадвар болон бизнесийн анхан шатны сургалт, нөхөрлөл хоршоодын хөгжил, зах зээлийн туслалцаа, боломжит технологийн талаарх мэдээлэл;
- нийгэм эдийн засгийн төлөвлөлт, хөтөлбөрүүд, бүс нутаг эсвэл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд одоо хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөтөлбөр, хөгжлийн чиг хандлага бүхий стратеги, бодлогын тухай мэдээлэл;
- хөдөлмөр эрхлэлтийн гол эх үүсвэр.

Бусад төрийн байгууллагуудтай зөвлөлдөх

Ихэнх төрийн байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй уялдаж болохуйц хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хариуцсан ажилтнуудтай байдаг. ХЭЗЧДС-ын арга зүйн нэг хэсэг бол тухайн орон нутгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас болзошгүй түншүүдээ сонгож авч харилцаа тогтоох, улмаар энэ харилцааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ур чадварын сургалтыг бэхжүүлэх зорилгоор ашиглах юм. Тухайлбал, төрийн байгууллагууд нийгмийн идэвх, жендерийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, зээл олгох, шинэ технологийг нэвтрүүлэх, нөхөрлөл болон хоршоодыг байгуулах, зах зээл болон бичил, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. ХЭЗЧДС-ын хэрэгжилтийг зохицуулагч баг нь дээрх байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн талаар төрийн байгууллагуудад мэдээлэл өгөх нь зүйтэй. Хэрэв ХЭЗЧДС-ын орон нутгийн салбар зөвлөл байгуулагдсан бол дээр дурьдсан төрийн байгууллагын төлөөлөлтэй харилцаа холбоотой байх асуудлыг салбар зөвлөл зохион байгуулж байх нь оновчтой юм.

Орон нутгийн зах зээлийг шинжих

Орон нутгийн салбар зөвлөл, ялангуяа нийгэм эдийн засгийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн орон нутгийн зах зээлийн нөхцөл байдлыг ажиглаж, хэрэглэгчид болон үйлдвэрлэгчидтэй санал солилцож, ингэснээр бүтээгдэхүүний чанар, эрэлт хэрэгцээ болон үнийн талаарх мэдээллийг цуглуулна.[5] (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, газар тариалан зэрэг бусад идэвхтэй явагдаж буй эдийн засгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл).

Судалгааны явцад гаднаас буюу өөр орон нутагт үйлдвэрлэгдэж, тээвэрлэгдэж ирсэн гар урлалын эд зүйлс, энгийн хүнсний бүтээгдэхүүн, саван, арьсан эдлэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэх мэт бараануудыг гаднаас авалгүйгээр орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэх боломжтой эсэхийг судлах нь чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн худалдан авагчдын бараа сонголтын талаарх судалгааг хийх хэрэгтэй.

Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах

Орон нутаг дах банк, зээл болон бусад төрлийн банк санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын төлөөлтэй уулзаж, тэдгээрийн зүгээс ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй хамтран ажиллах боломжтой байгаа тухай мэдээлж, санал солилцох.

Орон нутаг дах ТББ-ын төлөөлтэй уулзаж санал солилцох

ТББ-ууд нь хөдөөгийн иргэдийн талаар мэдээллийн эх сурвалж байж болох юм. Тэдгээрийн зарим нь ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх тал дээр үнэлэхүйц тус дэм үзүүлэхээр түншүүд байж болох юм. Төлөвлөлтийн үе шатанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай уулзаж дараах зүйлүүдийг тодруултодруулах хэрэгтэй. Үүнд:

- зорилтод бүлгүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- хөтөлбөрийн ур шимийг хүртэгчидхүртэгчдэд үзүүлэх сургалтын өмнөх болон дараах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх боломжтой эсэх;

5 Дээрх төрлийн мэдээлэл цуглуулах нь нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын талаар хэрэгцээтэй мэдээлэл өгнө. Тухайлбал, худалдаа эрхэлж байгаа эрэгтэйчүүд?, эмэгтэйчүүд?, аль аль нь?, худалдан авагч хэн бэ? Эмэгтэйчүүд мөнгөтэй харьцаж байна уу?

тэдгээр нь өөрсдийн хүчин чадал, нөөц бололцоог ашиглан ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэглэн ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэх боломжтой эсэх.

→ **Болзошгүй түнш байгууллагуудтай хийх ярилцлагын сэдвийн саналыг хавсралт 2.4-өөс үзнэ үү.**

Дээрх байгууллагын төлөөлөлтэй уулзаж, үйл ажиллагаатай нь танилцсаны дараа үндэсний түвшинд зохицуулах нэгж нь тухайн орон нутагт ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар тодорхой саналтай болсон байна. Дээрхи орон нутгийн засаг захиргааны нэгж, хүн амын төвлөрсөн суурин газрын тодорхой байршлын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэж авах нь чухал. Дээр дурьдсан уулзалтуудын үр дүнд олж авсан орон нутгийн нөхцөл байдал, зорилтод бүлгүүдийн талаарх мэдээллийг үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулах түншүүдтэй харилцан хуваалцаж санал солилцох нь зүйтэй.

г. Орон нутгийн түвшинд түншлэлийг бий болгох

Орон нутгийн хэмжээнд түншлэл бий болгох асуудал нь үндэсний хэмжээнд түншлэл бий болгохоос илүү чухал асуудал. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үндсэн болон чухал ач холбогдол бүхий онцлог нь удирдлага, төлөвлөлт, хэрэгжилтийн явцад төвлөрлийг сааруулах болно. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг бий болгохдоо тэдгээрийн хөдөө орон нутгийн зорилтод бүлгүүдэд хүрч ажиллах боломжуудыг аль болох чөлөөтэй бие даасан байдлаар зохион байгуулах нь зүйтэй. Түнш байгууллагууд нь сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, ТББ-ууд болон орон нутгийн ард иргэдийг түшиглэсэн бусад хэлбэрийн байгууллагууд, банк болон бусад хэлбэрийн санхүүгийн байгууллагууд, жижиг бизнесийн нэгдэл, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд гэх мэт байж болох юм.

Төрийн байгууллагууд нэг талаас зарим тохиолдолд зорилтод бүлгүүдээс орон зайн хувьд алслагдсан байхын зэрэгцээ төдийлөн хүрч ажиллах боломжгүй байдаг. Нөгөө талаас ТББ-ууд нь тухайн орон нутагт байнга үйл ажиллагаа явуулж, ард иргэдтэй илүү ойр байх боломжтой юм. Тэдгээр нь тухайн орон нутгийн хүндрэлтэй асуудал болон давуу талыг илүүтэйгээр мэддэг бөгөөд төрөл бүрийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, зорилтод бүлгүүдтэй шууд харилцсан үйл ажиллагааг явуулдаг байна. Зарим ТББ-ууд нь орлогыг бий болгох бичил санхүүжилтийн асуудал дээр орон нутгийн ард иргэдийн хүч чармайлтыг нэгтгэх, зохион байгуулалтад оруулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-ын халдвар авсан хүмүүс гэх мэт нийгмээс гадуурхагдсан бүлгүүдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг явуулдаг. Гэвч ТББ-ууд нь зарим тохиолдолд тогтвортой үйл ажиллагааны хувьд хязгаарлагдмал байх тул иргэд олон нийтийн оролцоо болон тэдгээрийн хүчин чармайлтыг нэгтгэх асуудал дээр орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад найдсан нь зөв байж болох юм. Тухайлбал, Мадагаскарт, хотын дарга эсвэл тосгоны захирагч нь дээр дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр үйл ажиллагаа нь тухайн албан тушаалтны ажил үүргийн хуваарьт тусгагдсан байдаг тул энэхүү албан тушаалтанд ТББ-аас илүү итгэл хүлээлгэдэг байна. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс дээрхи хотын дарга, тосгоны захирагч нарын чадавхийг нэмэгдүүлэх талаар тодорхой ажил зохиосоор ирсэн.

Орон нутгийн түвшин дэх түншлэл - орон нутгийн сургалтын байгууллагуудын үүрэг оролцоо

- ☐ сургалтын хэрэгцээг тодорхойлох болон сургалтад хамрагдагчдыгхамрагдагчдыг сонгож авахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- ☐ тухайн сургалтын байгууллагуудын багш, сургагч, зааварлагчид өөрсдийн мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулж, туршлага хуваалцах;
- ☐ сургалт зохион байгуулах газар, сургалтын материал, арга зүй, тоног төхөөрөмжийн тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- ☐ сургалтын дараах үйл ажиллагаанд сайжруулсан технологи нэвтрүүлэх, төгсөгчдөд зөвлөгөө өгөх, давтан сургалтыг зохион байгуулах гэх мэт;
- ☐ ХЭЗЧДС-ын хяналт -шинжилгээнд оролцох.

Орон нутгийн түвшин дэх түншлэл - бусад байгууллагуудын болзошгүй үүрэг оролцоо

Түнш байгууллагуудын туршлага, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлээс хамааран дараах байдлаар хэрэглэгдэх боломжтой юм:

- ☐ жендерийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих болон тухайн орон нутгийн ард иргэдэд холбогдох бусад асуудлаар хамтарч ажиллах;
- ☐ орон нутгийн ард иргэдийн хүчин чармайлтыг нэгтгэх;
- ☐ зорилтод бүлгүүд болон хөтөлбөрт хамрагдах суурин газрыг сонгож авахад туслах;
- ☐ эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг урьдчилсан байдлаар тодорхойлох;
- ☐ орон нутгийн түвшинд сургалтыг зохион байгуулах;
- ☐ сургалтад хамрагдагчдад сургалтын дараах дэмжлэг үзүүлэхэд туслах, тухайлбал, хадгаламж зээлийн үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний борлуулалтын зах зээлийг олж өгөх гэх мэт;
- ☐ ХЭЗЧДС-ын үйл ажиллагаанд хяналт –шинжилгээ хийх.

Түнш байгууллагуудыг сонгож авах

Цаашид хамтран ажиллаж болзошгүй түнш байгууллагуудыг хөтөлбөр эхлэхээс өмнөх судалгааны

түвшинд тодруулж авах нь зүйтэй. ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны чадавхи, орон нутгийн иргэд олон нийтийн оролцоон дээр суурилсан чиг хандлага бүхий хөгжлийг дэмжих үйл ажиллагааны туршлага, жендерийн эрх тэгш байдлын зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаг, үйл ажиллагаа нь элдэв доголдолгүй байгууллагыг сонгож авах нь чухал. Сургалт болон бизнесийн мэдлэгийг хослуулсан, мөн үүний зэрэгцээ жендерийн асуудалд тууштай ханддаг түнш байгууллагыг олж авахад хүндрэлтэй. Дээр дурьдсан үзүүлэлтүүдийн нэг болох жендерийн асуудлыг шийдвэрлэхийн тулд үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөр, энэ асуудлаар бусад байгууллагуудын тэргүүн туршлагыг тухайн байгууллагад нэвтрүүлснээр ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн шаардлага хангасан түнш байгууллагыг бий болгож болно. Хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-ын халдвар авсан хүмүүсийн асуудал дээр ч мөн адил дээр дурьдсаны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой юм. Хэдийгээр түнш байгууллага нь тодорхой нэг асуудалд хамаарах туршлага бага байж болох боловч үүнийг нь өөр хамтран ажиллах байгууллагын туслалцаатайгаар нөхөж, шаардлагатай сургалт болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

➔ **Түнш байгууллагад тавигдах шаардлагын саналыг хавсралт 2.5-аас үзнэ үү.**

Нэгэнт түнш байгууллагуудыг сонгон авсны дараа тэдгээрийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрт гүйцэтгэх үүрэг болон оруулах хувь нэмрийг тодорхойлох шаардлага гарна. Үүний тулд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс түнш байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хийх нь зүйтэй. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн дараа дараагийн шатанд сонгосон эдийн засгийн салбар эсвэл түнштэй хамтран ажиллах гэрээ дуусгавар болсон (үйлчилгээний чанар, бусад зүйлээс хамаарч) шинэ түншүүд орж ирэх боломжтой тул гэрээг аль болохоор уян байдлаар хийх нь зөв. Сонгогдсон түнш байгууллага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудалтай холбогдуулан хөтөлбөр хэрэгжиж буй орон нутагт тусгайлсан төлөөний этгээдийг ажиллуулж болно.

Түнш байгууллагуудын чадамжийг нэмэгдүүлэх

Чадамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад байнга явагдаж байх үйл ажиллагаа юм.

Энэхүү үйл ажиллагааг сургалт хэлбэрээр явуулах бөгөөд энэ нь түнш байгууллагуудын төлөвлөлт, сургалтын бэлтгэл ажлыг хангах, сургалт болон сургалтын дараах дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор ХЭЗЧДС-ын арга зүйг тайлбарлан таниулах явц юм. (Зураг 2)

Хөдөөгийн ард иргэдтэй ажиллах нь зөвхөн техник ур чадвараас гадна хүмүүсийн хүсэл зоригийг нэгтгэн дайчлах, багаар зохион байгуулах, жендерийн асуудалд нааштай хандах чадварыг шаардах ба төлөвлөлт, хэрэгжилт болон хяналт-шинжилгээний үйл ажиллагаа нь мөн бусад түнш байгууллагуудтай хамтран ажиллах чадварыг шаардана. Хүснэгт 2-оос харна уу.

ХЭЗЧДС-ын хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх аргачлалын талаар хэрэгжүүлэгч түнш байгууллагуудад хамтарсан сургалт, семинар хэлбэрээр зохион байгуулж таниулах, тэдгээр байгууллагын хүний нөөцөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх тодорхой үүрэг хариуцлага, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх зэргийг тайлбарлаж ойлгуулах нь чухал.

Зураг 2. ХЭЗЧДС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамрагдах хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн загвар

Хүснэгт 2. ХЭЗЧДС-ыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар

- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үндсэн зарчим, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргачлал, арга хэрэгсэл болон үйл ажиллагааны шат дараалыг сайтар ойлгосон байх;
- Зорилтод бүлгийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал болон тулгарч буй бэрхшээлүүдийг ойлгосон байх;
- Жендерийн эрхийг хангахад тулгарч буй бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлгийн гишүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай стратегийг боловсруулах чадвартай байх;
- Албан бус эдийн засгийн харилцаанд орж буй боловсрол болон ур чадвар, зарим тохиолдолд хязгаарлагдмал эдийн засгийн үйл ажиллагаа болон зах зээлийн хүрээнд байгаа зорилтод бүлгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн албан бус сургалтын арга зүйг эзэмшсэн байх;
- Даалгасан үүрэг даалгаврыг биелүүлэх техникийн болон зохион байгуулалтын чадвартай байх;
- Болзошгүй эдийн засгийн боломжийг тодорхойлох, боломжит нөхцөл байдлыг тооцоолох болон сургалтад хэрэгцээтэй техник, аргачлалаар хангагдсан байх;
- Орон нутгийн ард иргэд, холбогдох байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулах ур чадвартай байх;
- Зах зээл болон бизнесийн нөхцөл байдлын талаар практик мэдлэгтэй байж, зорилтод бүлэгтэй хамааралтай зах зээлийг тодорхойлох чадвартай байх;
- Бичил болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих, сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг явуулахуйц ажлын дадлага туршлагатай байх;
- Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд хэрэглэж болохуйц орон нутгийн санхүүгийн болон санхүүгийн бус нөөц бололцооны талаар тодорхой мэдлэгтэй байх;
- Холбогдох байгууллага, ажил олгогч, өөрийгөө цалинжуулах болон ажлын байр бий болгохуйц бизнесийг хөгжүүлэх бичил үйлдвэрлэлийн байгууллага хоорондын сүлжээг байгуулах ур чадвартай байх.

ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэгч баг болон оролцогч байгууллагын хүний нөөцөд зориулагдсан сургалт, давтан сургалтыг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тогтмол зохион байгуулж байх нь чухал юм.

Дээрх сургалтууд нь тодорхой зорилт, үйл ажиллагааны үе шат, аргачлал, ажлын арга барил болон ХЭЗЧДС-ын арга зүйн хүрээг хамарсан байдлаар зохион байгуулж болно. Тодорхой хэлбэл, сургалт нь дараах чиглэлээр зохион байгуулагдсан байвал зохино. Үүнд:

- олон нийтийн хүч, нөөц бололцоог дайчлах, эдийн засгийн боломж болон хэрэгцээг тодорхойлох;
- сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд холбогдох жендерийн асуудлыг зохистойгоор зохицуулсан чиг хандлагатай байх (Бүлэг VII);
- ур чадвар, үйлдвэрлэл эрхлэлтийн сургалтын загвар, төлөвлөлт, сургалтыг зохион байгуулах;
- сургалтын дараах дэмжлэг үзүүлэх механизмыг төлөвлөж, тогтоох.

Мэдээж бүх түнш байгууллагууд дээр дурьдсан сэдвүүдээр мэргэшсэн байхгүй нь ойлгомжтой. Гэхдээ эдгээр байгууллагууд нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэг болон ойлгоцтой байх хэрэгтэй. Тухайлбал, жендерийн талаар сургалт нь зөвхөн эмэгтэйчүүдэд зориулагдсан байх ёсгүй ба эрэгтэйчүүд ч гэсэн жендерийн эрхийг хангах үйл ажиллагаанд оролцсон байх шаардлагатай. ХЭЗЧДС-ын арга зүйн талаарх ерөнхий сургалтыг зохион байгуулахын зэрэгцээ үндэсний болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулах орон нутгийн хүний нөөц нь жендерийн асуудалтай холбогдох нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийх, үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах талаар холбогдох сургалтад хамрагдсан байвал зохино. Хэдийгээр дээр дурьдсан сургалтууд нь хэрэгтэй боловч зөвхөн анхан шатны мэдлэг өгөх тул цаашдын мэдлэг, дадлага, туршлагыг амьдрал дээр суралцах болно. Хүний нөөцийг сургахад ХЭЗЧДС-ын дадлага, туршлагатай ажиллагчдын зөвөлгөө, туршлага солилцох зэрэг бусадтай мэдлэгээ хуваалцах нь чухал. Зохион байгуулалт сайтай дадлагажих сургалт нь сургалтын чухал үр дүнтэй хэлбэр болох бөгөөд үүний явцад туршлага солилцох нь амжилттай хэрэгжиж буй чиг хандлагыг бусад бүс нутаг болон орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэхэд туслах болно. Дадлагажих сургалтын явцад сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал, зах зээлийн холбогдолтой үйл ажиллагаа, төвлөрсөн бус зохион байгуулалтын чиг хандлага болон бүтцийн зохицуулалт, бусад байгууллагуудтай хамтарч ажиллах зэргээр туршлага солилцох боломжтой юм.

ХЭЗЧДС-ын хэрэгжилтийг зохион байгуулж буй байгууллага, орон нутгийн салбар зөвлөлүүд дээр ур чадвар болон үйлдвэрлэлийн сургалт, жендерийн харилцаа, боломжит технологи, бичил болон жижиг үйлдвэрлэлийг эхлүүлэх, зах зээл санхүүгийн холбогдох материал, ном сонин хэвлэл бүхий номын сангуудыг байгуулсан байвал зохистой.

Хавсралтууд

Хавсралт 2.1. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн бичиг баримтын агуулга

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн загвар 1.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баримт бичиг[6]

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлтийн эхний үе шатанд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баримт бичиг бэлтгэх шаардлагатай. Энэхүү баримт бичиг нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ерөнхий агуулга болон түүний стратеги, тогтолцоо, хэрэгжилтийн нөхцлүүд, зорилтод бүлгүүд, зорилгууд, хүлээгдэж буй үр дүн, үйл ажиллагаа, хэрэгцээтэй нөөц, хөтөлбөрийн тогтолцоо болон тогтвортой байдлыг хангах талаар тусгасан байна.

Уг хөтөлбөр нь үндэсний хэмжээнд эсвэл туршилтын журмаар хэрэгжих, дангаар, илүү өргөн хүрээтэй хөтөлбөрийн нэг хэсэг болон хэрэгжих гэх мэт нөхцөл байдлаас хамааран хөтөлбөрийн загварыг өөрөөр боловсруулж болно.[7]

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн загвар нь макро, микро түвшний мэдээлэл дээр суурилсан байх ёстой. Загварын төслийг боловсруулагчид хөгжлийн стратеги, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, орон нутгийн засаг захиргааны одоогийн, ирээдүйн санаачилга, сургалтын байгууллагуудын шаардлагатай сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой хүчин чадалтай эсэх, орон нутгийн түвшинд шийдвэр гаргах боломж буй эсэх (өөрөөр хэлбэл төрийн эрх мэдлийн төвлөрсөн бус байдал, ард иргэдэд түшиглэсэн байгууллагууд байгаа эсэх) хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа орон нутгийн ядуурлын дүр зураг, хөдөөгийн дэд бүтэц мөн бусад холбогдох мэдлэгтэй байх хэрэгтэй.

ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэглэн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулагчид нь орон нутгийн нөхцөл байдал, холбогдох бодлого, хөгжлийн стратеги, зорилтод бүлгүүдийн зүгээс сургалт болон дэмжих үйлчилгээнд хамрагдах боломж, болзошгүй түншийн хамтран ажиллах санал, шаардлагатай холбоо, сүлжээг бий болгох боломжийн талаар тодорхой хэмжээний ойлголттой байх хэрэгтэй.

Жендерийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ болон төлөвлөлтөд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлт болон загварыг боловсруулах шатанд онцгойлон анхаарал хандуулах хэрэгтэй. Хөтөлбөрийн бүхий л шатанд эрэгтэй болон эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байх нь чухал, ингэснээр ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үр шимийг хүртэж байгаа эмэгтэйчүүдт эергээр нөлөөлөх бөгөөд энэ нь жендерийн асуудлыг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад баталгаатай хангахад тус дэм болно.

Түүнчлэн хөтөлбөрт тодорхой гадуурхагдаж болзошгүй (залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин сууршигчид гэх мэт) бүлгүүдийн оролцоог төлөвлөлт, шийдвэр гаргах түвшинд байлгах нь чухал. Эдгээр бүлгүүдийн төлөөллийг оролцуулахдаа холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөлөөр бус, шууд биет төлөөлөгчдөөр оролцуулах нь зүйтэй.

Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах асуудал нь ХЭЗЧДС-ын нэн чухал асуудал тул хөтөлбөрийн баримт бичигт тогвортой байдлыг хадгалах талаарх стратегийг агуулах ёстой бөгөөд тогтвортой байдлын асуудал нь бүхий л үнэлгээ, бодлогын түвшиндөөрчлөлт оруулах, төлөвлөлт хийх (дэд бүтэц, байгууллагуудын оролцоо) зэрэгт тусгагдсан байх ёстой. Түүнчлэн тогтвортой байдлын асуудал нь нөлөөлж болзошгүй гадаад хүчин зүйлсийн жагсаалтад орсон байх ёстой.

Дээр дурьдсан асуудал нь маш ярвигтай бөгөөд хэрэгжилтийг нь хангахад хүндрэлтэй гэдгийг дурьдах нь зүйтэй. Тогтвортой байдал мөн олон янз (тухайлбал, техникийн эсвэл санхүүгийн гэх мэт) байдаг.

Шаардлагатай бодлогыг зөв, зохистой, цаг тухайд хэрэгжүүлэх, үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах ч (хөдөлмөр эрхлэлт болон ур чадварыг хөгжүүлэх бодлого нь ядуу эрэгтэй ба эмэгтэйчүүдийн хэрэгцээтэй уялдсан байх, бичил, жижиг үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин, жендер, зам, сургалтын төв, эрүүл мэндийн байгууллагууд гэх мэт нийгмийн дэд бүтэц) тогтвортой байдлыг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна.

2. Хэрэгжилтийн стратеги

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн стратеги нь тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд хүрэх зорилтоо бодитойгоор үнэлсний үндсэн дээр боловсруулагдсан байх шаардлагатай.

Стратеги нь үндэсний хөгжлийн зорилго, ялангуяа эмзэг бүлгийн зорилтод бүлгүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих , үндэсний болон бүс нутгийн хэмжээнд ядуурлыг бууруулах зэрэг үндэсний хөгжлийн зорилтуудтай нийцсэн байх ёстой.

---

6 See http://www.ilo.orgintranet/english /region/codev/ tc_manual/index.htm for information the preparation of a project document.

7 Тухайлбал Мадагаскарт ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь “Ядуурлын эсрэг үйл ажиллагаа” хэмээх 3 том хэсэг бүхий төслийн нэг бүрэлдхүүн хэсэг байсан. Дээрхи төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэж байв. Үүнд: 1. Тогтвортой хөдөлмөр эрхлэлт нь хэрхэн эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөхийг харуулсан үр дүнтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүрэлдэхүүн хэсэг;

2, Ядуурлыг ур чадвар болон бичил ба жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх аргаар бууруулах гэсэн бүрэлдэхүүн хэсэгт ХЭЗЧДС-ын арга зүй орж байсан;

3. Орон нутгийн нөөцөө хөрөнгө оруулалтаар дэд бүтцийг бий болгох замаар тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох бүрэлдэхүүн хэсэг. Үүний бүтцэд Номхон далайн бүс нутагт залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд ХЭЗЧДС-ийн арга зүй мөн орж байсан байна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн стратеги нь хөтөлбөрийн агуулгаас хамаарна. Тухайлбал: дараах стратегийн холбогдолтой асуудлуудыг анхааралдаа авсан байвал зохистой. Үүнд:

- Эдийн засгийн боломжийг тодорхойлох, холбогдох сургалтын төлөвлөлт, загварчлал болон зохион байгуулалт, сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд түнш байгууллагууд, орон нутгийн ард иргэдийн идэвхтэй оролцоог хангах;
- Албан бус үйлдвэрлэгчид, ажилчид болон бусад нийгмээс гадуурхагдсан эмзэг бүлгүүдийн эрхэлж буй албан бус хөдөлмөр эрхлэлтийг албажуулах;
- Ядуурлыг бууруулахад бодитойгоор нөлөөлөхүйц харилцан уялдаа холбоо бүхий зорилтод бүлгүүдэд шууд чиглэгдсэн сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр нь бусад хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаатай уялдаа холбоотой бөгөөд үүнд орон нутгийн эдийн засгийн хөгжил, бичил болон жижиг үйлдвэрлэлийн хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, шинэ технологийг нэвтрүүлэх зэргийн үйл ажиллагаа хамаарагдана;
- Хөтөлбөрийн бодлогыг албан болон албан бус хэлбэрийн үндэсний мэргэжлийн сургалтын тогтолцоо, хөдөлмөрийн зах зээл дээр шинээр бий болж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн уян хатан байлгах;
- Сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн хөтөлбөрүүдийн загвар, зохицуулалт болон хэрэгжилтийг хариуцаж буй үндэсний ба орон нутгийн бүтцүүдийн чадавхийг нэмэгдүүлэх хэрэгцээ;
- Мэргэжлийн хувьд хөрвөх чадварыг дэмжсэн, эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулахад өртөг багатай сургалтын тогтолцоог бий болгох;
- ОУХБ-аас санал болгож буй орон нутгийн ард иргэдийн оролцоон дээр суурилсан, ур чадварыг хөгжүүлэх хандлага, үр дүнтэй сургалтын дараах дэмжих үйл ажиллагаа бүхий олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баримталж буй чиг хандлагыг дэмжих;
- Жендерийн хэрэгцээ, эрх тэгш байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааны стратегийн зорилтууд;
- Сургалтад зориулагдах хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, шаардлагатай хүний нөөц, материаллаг баазыг бэхжүүлэх.

3. Зорилтод бүлгүүд

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг эхлүүлэх үед болзошгүй зорилтод бүлгүүдийн талаар тодорхой ойлголттой болох хэрэгтэй бөгөөд энэ нь цаашдын төлөвлөлт болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцтай шууд холбоотой байх болно. ХЭЗЧДС-ын арга зүй нь ихэвчлэн өөрийн боломжит түвшнөөс доогуур төрлийн ажил эрхэлж буй эсвэл огт ажил эрхэлдэггүй хөдөөгийн ядуу эмэгтэй болон эрэгтэйчүүдийн чадавхийг нэмэгдүүлэхэд ерөнхийдөө чиглэгдсэн. Дээр дурьдсан ядуу хүмүүсийн бүлгүүдээс тухайн улс болон орон нутгийн онцлог, хэрэгжүүлж буй гол яам, агентлагын үйл ажиллагааны үндсэн чиглэлээс хамааран тодорхой бүлгүүдийг сонгон авах хэрэгцээ гардаг. Дээр дурьдсан тодорхой бүлгүүдэд дараах төрлийн бүлгүүд хамаарах боломжтой юм:

- ☐ сургууль завсардсан залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд ;
- ☐ насанд хүрсэн эмэгтэйчүүд;
- ☐ насанд хүрсэн эрэгтэйчүүд;
- ☐ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс;
- ☐ дүрвэгчид;
- ☐ цэргийн албанаас халагдсан хүмүүс;
- ☐ гамшгийн нөхцөл байдалд байгаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүд (цунами, газар хөдлөлт болон бусад байгалийн гамшиг, дайн, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт).

4. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг санхүүжүүлэх

Хөтөлбөрийг эхэн үеэс эхлэн хангалттай хүрэлцэхүйц санхүүжилттэй байх арга хэмжээг авах хэрэгтэй. Ерөнхийдөө, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баримт бичгийг боловсруулах үед оролцогч талууд харилцан тохиролцсон байх шаардлагатай. Дээрх санхүүжилт нь улсын төсөв, ТББ-ууд, орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн байгууллага, үйлчлүүлэгчдийн зүгээс оруулах хувь нэмрээс бүрддэг. Хөтөлбөрийг удаан хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхийн тулд дотоодын санхүүгийн эх үүсвэрийг ашиглах нь зүйтэй. Санхүүжилтийн эх үүсвэрийн дараах аргаар бүрдүүлж болно. Үүнд:

- ☐ улсын төсөв;
- ☐ орон нутгийн төсөв;
- ☐ ядуурлыг бууруулах стратегийн хөтөлбөр;
- ☐ сургалтад хамрагчдын үйлдвэрлэлийн дадлагын явцад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлого;
- ☐ сургалт зохион байгуулах зардлыг олгосон зээлийн хүүгээс олсон ашгаар нөхөх;
- ☐ орон нутгийн хөгжлийг дэмжих байгууллага, төрийн бус байгууллагуудын хандив, тусламж;
- ☐ хувийн хэвшил (аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд);
- ☐ гадаадын хөгжлийн тусламж.

Үйл ажиллагааг эхлэх анхны санхүүжилтийг улсын төсөв, доноруудын дэмжлэг, ТББ-ын хандив гэх мэт санхүүжилтээр эхэлж болох боловч, хөтөлбөрийг цаашид тогтвортой хэрэгжүүлэхийн тулд гадаадын хөгжлийн туслалцаанаас татгалзах нь зүйтэй. ХЭЗЧДС-

ын хөтөлбөрийн үндсэн зорилтод бүлэг болох ядуу иргэдийн хувь нэмрээр сургалт болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг бүхэлд нь санхүүжүүлэх боломжтой гэж үзэх нь өрөөсгөл юм. Мөн олгосон зээлийн хүүгийн ашгаар сургалтуудыг бүрэн санхүүжүүлэх гэдэг ч дээрхтэй адил өрөөсгөл байж болох тул улсын болон орон нутгийн төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгийг төсөвлүүлж авах нь хөтөлбөрийн тогтвортой үйл ажиллагааг хангахад ихээхэн хувь нэмэр болно. Гэвч ядуурлыг бууруулахад чиглэгдсэн нийгэм-эдийн засгийн бусад, өөр төрлийн арга хэмжээнүүдийн ерөнхий өртөг нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлаас өндөр байх ихтэй магадлалтай байдаг байна.

5. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлт нь үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүдэд уялдаа холбоотойгоор хийгдсэн байх ёстой. Тухайлбал, Пакистан болон Филипин улсуудад хэрэгжүүлсэн ХЭЗЧДС-ын төслүүд нь үйл ажиллагааны дараах үндсэн дөрвөн чиг хандлагаас бүрдэж байсан байна:

- ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх орон нутгийн тодорхой онцлог бүхий нийгэм-эдийн засгийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа болон арга зүйн хэлбэрүүдийг тодорхойлох;
- оролцогч түнш байгууллагуудын хүний нөөцийн ХЭЗЧДС-ын арга зүйг үйл ажиллагаандаа ашиглах чадавхийг нэмэгдүүлэх;
- Шаардлагатай сургалтын өмнөх судалгааг хийх, орлогыг бий болгох боломж, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн арга зүйгээр тодорхойлсны үндсэн дээр ур чадварын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах сургалтад зорилтод бүлгүүдийг хамруулах, сургалтын дараа дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон түнш байгууллагуудын бодлого боловсруулах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн явцын талаарх болон хэрэгжилтийн талаарх мэдээллээр байнга хангаж, зайлшгүй шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах чиглэлээр хамтран ажиллах.

6. Үйл ажиллагааны төлөвлөгөө

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ тус бүр дээр дэлгэрэнгүй гарах бөгөөд үүнтэй зэрэгцүүлэн зардлын тооцоог нарийвчлан хийсэн байх шаардлагатай.

II. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах

ХЭЗЧДС-ын хөтөлбөр болон түүний арга зүй нь амжилттай хэрэгжих нөхцөлд дараах 2 хүчин зүйл ихээхэн ач холбогдолтой болно:

- хөтөлбөрийг түншүүдэд бүрэн таниулах;
- ХЭЗЧДС-ын чиг хандлагыг оролцогч талууд бүрэн ойлгуулж ухамсарлуулсан байх.

Дээрх зорилгод хүрэхийн тулд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг тайлбарлан таниулсан уулзалт, хурал, сургалт, семинарыг оролцогч байгууллагууд болон холбогдох түншүүдийг оролцуулан үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулна. ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэгч багийн үндсэн чиг үүргийн нэг бол хөтөлбөрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг бүх түвшинд хангах, ялангуяа оролцогч байгууллагуудыг мэдээллээр бүрэн хангахад оршино. Түүнчлэн болзошгүй оролцогч байгууллагууд хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож эхлэхээсээ өмнө хөтөлбөрийн талаарх мэдээлийг бүрэн авсан байх нь чухал.

Оролцогч талуудын үүрэг хариуцлага, тэдгээрт тавигдах шаардлагын талаарх хамтарсан сургалт, семинаруудын явцад түлхүү сурталчилах, ойлгуулах, тайлбарлан таниулах нь чухал.

1. ХЭЗЧДС-ын арга зүйн талаар ойлголт өгөх сургалт

ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох байгууллагуудад зориулсан богино хэмжээний сургалт семинарын хөтөлбөрт дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- ☐ оролцогчид болон ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх багийн үүрэг оролцоо болон хариуцлага;
- ☐ холбогдох материалыг хэрхэн боловсруулах;
- ☐ суурь судалгаа, эдийн засгийн боломжийн судалгаа, цаашдын чиг хандлагын боломжийн судалгаа, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг зэргийг зохион байгуулах байгууллагууд;
- ☐ сургалтыг зохион байгуулах үе шатууд;
- ☐ ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах;
- ☐ сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

Цаашид түнш байгууллагуудын ХЭЗЧДС-ын арга зүйг хэрхэн хэрэглэх талаарх болон тухайн байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх сургалтыг тодорхой давтамжтайгаар байнга зохион байгуулж байх нь зүйтэй. (дэлгэрэнгүй зааварчилгааг хоёрдугаар бүлгээс үзнэ үү)

2. ХЭЗЧДС-ын сурталчилгааны материал

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн талаарх мэдээллийг хамтран ажиллах болон түнш байгууллагууд, оролцогч талуудад тайлбарлан таниулахын тулд шаардлагатай мэдээллийг жижиг хэмжээний гарын авлага болгон бэлтгэсэн байх нь зүйтэй.

ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь нэлээн хэдэн орнуудад (Пакистан, Филиппин, Шриланк, Мадагаскар гэх мэт) хэрэгжсээр ирсэн бөгөөд эдгээр орнуудад хэрэгжих явцад хуримтлуулсан туршлага, арга, аргачлалуудын талаар дээр дурьдсан мэдээлэл өгөх материалуудад тусгах зүйтэй.

Хавсралт 2.2. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцөд тавигдах шаардлагын үлгэрчилсэн загвар

Анхаарах зүйл: ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн бүтэц нь хэрэгжүүлэх тогтолцооны онцлог, хэрэгжүүлэх стратеги болон хөтөлбөрт хамрагдах газарзүйн цар хүрээ зэрэг хүчин зүйлээс хамаарна.

ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгж

I. Үндэсний хөтөлбөрийн зохицуулагч

Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцах, ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгжийн удирдлага байна. Түүнчлэн энэ албан тушаалтан нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг оролцогч байгууллагуудын дунд зохицуулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг биечлэн хариуцах бөгөөд ажлын байрны тодорхойлолтод дараах асуудлууд тусгагдсан байна. Үүнд:

- ХЭЗЧДС-ыг үндэсний түвшинд зохицуулах нэгжийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- хөтөлбөрийн үйл ажиллагаанд шаардагдах тухайн жилийн төсвийг батлуулах;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанд жендер, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах болон бусад холбогдох асуудлууд бүрэн тусгагдсан байх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талууд дээр дурьдсан асуудлаар шаардлагатай сургалтад хамрагдсан байх нөхцлийг бүрдүүлэх;
- хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зайлшгүй шаардлагатай арга зүй, нийгэм эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрдүүлэх техник ажиллагааг удирдах (судалгааны анкетын асуулга, хяналт-шинжилгээний загвар гэх мэт);
- бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ХЭЗЧДС-ын орон нутгийн нэгжүүдээс ирсэн тайлан, мэдээллүүдтэй танилцан шаардлагатай зохицуулалтыг хийх. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх газрыг сонгон авах, анхан шатны болон гүнзгийрүүлсэн судалгааны тайлан, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрийн санал, зохион байгуулагдсан ур чадварын сургалтын тайлан, сургалтын дараах хяналт-шинжилгээ болон эдийн засгийн төлөвлөлт гэх мэт хамаарна;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг уулзалт, арга хэмжээнүүдэд төлөөлөх, шаардлагатай мэдээлэлийг хийж, илтгэл тавих;
- орон нутгийн ХЭЗЧДС-ын багийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, хэрэгцээтэй тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээг авах, зөвлөмжөөр хангах;
- техникийн туслалцаа үзүүлэх зөвлөхүүдэд тавигдах шаардлага, үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хугацаа зэргийг батлах;
- хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар санал боловсруулах;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрт холбогдох сургалт, семинарыг удирдах;
- холбогдох дотоод хурлын товыг зарлах, хурлыг даргалах;
- хөтөлбөрийн нэгдсэн сар, улирлын мэдээ, явцын хяналт-шинжилгээний тайланг бэлтгэх;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн явцад хуримтлуулсан туршлагыг баримтжуулж авах зэрэг болно.

II. Нийгэм эдийн засгийн ажилтан

Нийгэм эдийн засгийн асуудал хариуцсан ажилтан нь үндэсний хөтөлбөрийн зохицуулагчийн шууд удирдлага, орон нутгийн ХЭЗЧДС-ын багийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулна. Тэдгээр нь сургалтын хэрэгцээг тодорхойлох болон төлөвлөх, сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт зэрэгтэй холбогдох төрөл бүрийн нийгэм-эдийн засгийн судалгаа (орон нутгийн ард иргэдийн нөхцөл байдлын зураглал, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ гэх мэт) төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалтыг хариуцана. Мөн тэдгээр нь бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нэгж, багуудыг үйл ажиллагааны чиглэлээр хангах, чиг үүрэг бүхий ажлыг гүйцэтгэнэ. Эдгээр нийгэм эдийн засгийн ажилтнууд нь сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрах, зээл олгох, зах зээлд гаргах, зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хариуцана.

III. Үндэсний сургалт хариуцсан ажилтан

Сургалт хариуцсан ажилтан нь ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, сургалтын хөтөлбөрийн бүх шатанд хийгдэх хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг хариуцана. Мөн түүний ажил үүргийн хуваарьт сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын санал боловсруулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, сургалтын үйл ажиллагаатай холбогдох тайланг гаргаж дүгнэл өгөх зэрэг орно. Сургалт хариуцсан ажилтан нь үндэсний хөтөлбөрийн зохицуулагчийн өмнө ажлаа тайлагнах бөгөөд тухайн албан тушаалд хэрэгцээ шаардлагаас хамааран тодорхой чиглэл хариуцсан 2-3 ажилтан байж болно. Тухайлбал:

Үйлдвэрлэлийн сургалт хариуцсан ажилтан;

- **сургагч бэлтгэх, сургалтыг зохион байгуулах ажилтан** (сургагчийг бэлтгэх, сургагчийг шаардлагатай тусгай сургалтад хамруулах, сургалтыг зохион байгуулах, орон нутагт тухайн чиг үүргийг гүйцэлдүүлж байгаа ажилтнуудыг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах);
- **үндэсний хөтөлбөрийн сургалтын хөтөлбөр, сургалтын үнэлгээ хариуцсан ажилтан** (бүс нутгийн, орон нутгийн сургалт хариуцсан ажилтан, сургагч нартай хамтран ажиллаж, цаг үетэй нь нийцүүлж сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, зохион байгуулсан сургалтуудад үнэлгээ өгөх).

Дээрх асуудалтай холбогдуулан мөн дараах төрлийн орон тоо байж болно. Үүнд:

- бичил болон жижиг үйлдвэрлэлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- орон нутгийг хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- бичиг баримтжуулалт, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн;
- ажил олголт, сургалтын дараа дэмжлэг үзүүлэх асуудал хариуцсан мэргэжилэн.

ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй холбогдох санхүү, тээвэрлэлт болон захиргааны асуудал хариуцсан ажилтан байж болно. Тэдгээр нь бэлэн мөнгөний зарцуулалт, тендер зарлах, хөтөлбөрийн ажилтнуудын ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, бүртгэл хөтлөх зэрэг ажлуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ үндэсний хөтөлбөрийн зохицуулагчийн удирдлага доор захиргааны туслах ажилтан нь төсвийн зарцуулалт, төлбөр хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэх боломжтой юм. Туршилтын журмаар явуулж буй жижиг хөтөлбөрт захиргааны ажилтан, санхүүгийн ажилтнууд нь ажлын албан үүргийг гүйцэтгэнэ.

ХЭЗЧДС-ын орон нутгийн багийн бүтэц

i)ХЭЗЧДС-ын орон нутгийн зохицуулагч

Эдгээр ажилтнууд нь ХЭЗЧДС-ын орон нутгийн багийг удирдах бөгөөд орон нутгийн хэмжээнд явуулах үйл ажиллагаатай холбогдох менежмент, зохион байгуулалт болон захиргааны асуудлыг хариуцана:

- ХЭЗЧДС-ын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд төлөвлөх, орон нутгийн хэмжээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
- ХЭЗЧДС-ын хүрээнд хамрагдах ард иргэдийн дунд судалгаа хийх ажлыг зохион байгуулах;
- сургагч нарыг жендер, сургалтын арга зүйн сургалтад хамруулах;
- сургалтын явц болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, байгаа нөөцийг шаардлагатай үйл ажиллагаанд зохистой ашиглахад хяналт тавих;
- хөтөлбөрийн тухайн орон нутагт хэрэгжиж байгаа байдалд хяналт тавьж, тайлан гаргах;
- ХЭЗЧДС-ын үндэсний түвшинд зохицуулах нэгжтэй харилцаа, холбоотой ажиллах;
- хөдөлмөр эрхлэлт болон ур чадварыг нэмэгдүүлэх талаар тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн ба төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Орон нутгийн нийгэм эдийн засгийн ажилтан

Эдгээр нь:

- сургалтын хэрэгцээг тодорхойлохын өмнө хийх шаардлагатай судалгаануудыг (орон нутгийн ард иргэдийн дүр зураг, эдийн засгийн боломжийг судлах суурь судалгаанууд) хариуцах;
- сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг хангах;
- төгсөгчдөд үзүүлэх сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамаарах зээл олголт, бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, зах зээлд гаргах, бүтээгдэхүүний сурталчилгаа зэрэг бичил болон жижиг хэмжээний бизнесийг дэмжих ажлыг зохион байгуулах;
- зээл, үйлдвэрлэлийг хөгжүүлэх технологи, заах зээл, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрийн ба төрийн бус сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч байгууллагууд, бусад бизнес эрхлэгчидтэй хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах;
- орон нутгийн сургалт хариуцсан ажилтантай хамтран ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төгсөгчдийн цаашдийн үйл ажиллагааны талаар бүртгэл хөтөлж, мэдээлэл цуглуулах, шаардлагатай үед хэрэгцээтэй тайлан мэдээг гаргах

iii) Орон нутгийн сургалтын ажилтан

Эдгээр нь сургалт явуулагчтай хамтран дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагааг зохион байгуулах;
- сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны дүнд дүгнэлт хийж санал боловсруулах, сургалтын төлөвлөлт, хөтөлбөр, сургагч нарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг боловсруулах;
- сургалтыг зохион байгуулахад шаардлагатай байр, техник тоног төхөөрөмж, сургалтын материал, сургагчийг сонгож авах, хэрэгжиж буй сургалтын үр дүнд хяналт-шинжилгээ хийх, ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт оролцогчдын жендерийн байдалд ажиглалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад эмзэг бүлгийн хүмүүс, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийх;
- сургалт зохион байгуулж буй байгууллагуудын зүгээс сургалтын тайлантай танилцаж сургалтууд нь төлөвлөгөөнд заасны дагуу явагдаж байгаад хяналт тавих;
- сургалтын үйл ажиллагаатай холбогдох дүн шинжилгээ болон дүгнэлт бүхий тайланг шаардлагатай үед гаргах.

Хөтөлбөрийн хүрээнд ажиллаж байгаа хүний нөөц нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилтод бүлгүүдтэй холбогдох асуудалд анхааралтай хандаж, тэдгээрийн сургалт болон бусад үйл ажиллагаанд хамрагдах идэвх зүтгэлийг дэмжинэ.

Хавсралт 2.3. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийг сонгоход санал болгож буй шалгуур үзүүлэлтүүд

Нэгдүгээр үе шат. Шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн орон нутгийг сонгон авахдаа урьдчилсан байдлаар холбогдох судалгааг хийсний үндсэн дээр тухайн орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллана.

Хөтөлбөр хэрэгжүүлэхээр сонгож авахад дараах санал болгож буй шалгуур үзүүлэлтүүдийг анхаарах:[8]

- ☐ орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал, ядуурал болон ажилгүйдлийн түвшин, орон нутгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөнүүд хэрэгжиж байгаа эсэх;
- ☐ замын сүлжээ, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн наад захын шаардлага хангагдсан эсэх;
- ☐ тухайн төлөвлөгдсөн газраас эргэн тойрон 20-30 км-ийн газраас нийтийн тээврийн хэрэгсэл, таксигаар саадгүй хүрч очих боломжтой эсэх;
- ☐ үйлдвэрлэгдэх бараа болон үзүүлэх үйлчилгээний борлуулалтын бодитой зах зээл байгаа эсэх;
- ☐ ур чадварын сургалт хэрэгцээтэй байгаа эсэх (бусад хөтөлбөр, төслийн хүрээнд ижил төстэй ур чадварыг нэмэгдүүлэх чиглэл бүхий үйл ажиллагаа явагдаж байсан эсэх);
- ☐ тухайн орон нутагт сургалтад хамрагдагчдад төгсөлтийн дараа дэмжлэг үзүүлэх боломж бүхий зээлдүүлэгч (дор хаяж 1) байгууллага (хөдөөгийн банк, зээл олгох үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага гэх мэт) байгаа эсэх;

тухайн орон нутгийн хэмжээнд хөдөөгийн ажил эрхлэлт болон орон нутгийн хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага байгаа эсэх.

8 Урьд нь явуулж байсан үйл ажиллагаануудын туршлагаас харахад дээрх саналууд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ихэнх орон нутгийн нөхцөл байдалд нийцэх боломжтой байдаг. Иймээс дээрх шалгуур үзүүлэлтүүдээс аль нь тухайн улсын хувьд илүү зонхилох үзүүлэлттэй байна гэдэгт анхаарал хандуулах хэрэгтэй. Тухайлбал, Мадагаскар, Нигер, Зүүн Тиморт зэрэг улсуудад дэд бүтэц муу хөгжсөн, алслагдсан газруудад хэрэгжиж байсан бөгөөд зах зээлд бүтээгдхүүн нийлүүлэхэд хүндрэл их учирч байхын зэрэгцээ бүс нутгийн хэмжээн дэх гамшиг, тогтвортой бус байдал, эдийн засгийн хямрал зэрэг нь иэхээхэн анхаарал, хүч хөдөлмөр зарцуулахад хүргэж байсан.

Хавсралт 2.4. Түнш байгууллагуудтай ярилцахад санал болгож буй сэдвүүд

1. Орон нутгийн эрх бүхий байгууллагуудтай ярилцлага хийх сэдвийн санал

а) *Уулзалтын гол зорилго нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг тухайн орон нутагт хэрэгжүүлэх боломжийн талаар мэдээлэл авах;*

б) *ХЭЗЧДС-ын чиг хандлагын онцлогууд:*

- тухайн орон нутгийн ард иргэдийн, ялангуяа зорилтод бүлгүүдийн оролцоог хангах, тэдгээртэй санал солилцсоны үндсэн дээр шийдвэр гаргах;
- орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нягтлаж үзэх (орон нутгийн ард иргэдийн дүр зураглал, эдийн засгийн боломж, сургалтын хэрэгцээг тодорхойлох болон бусад арга хэрэгсэл);
- хөдөөгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаандоролцожбайгаатүншбайгууллагуудыг холбож сүлжээний хэлбэрт оруулах;
- ХЭЗЧДС-ын арга зүй болон орчин үеийн хөдөөгийн сургалтын ялгаа (сургалтын дамжааг уян хатан байдалтайгаар зохион байгуулах боломж байхгүй, сургалтын төрөл болон хэрэгцээг эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн боломжит чиг хандлагад уялдуулсан, зорилтод бүлгүүдэд шийдвэр гаргахад оролцох боломж олгосон, жендерийн тэгш эрхийн хандлага, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад аливаа ялгаварлан гадуурхалыг халах);
- тухайн орон нутгийн хүн амын талаарх мэдээллийг цуглуулах, хүн ам, зонхилж буй эдийн засгийн үйл ажиллагаа, ажилгүйдэл болон боломжит байдлаас доогуур түвшний ажил эрхлэлт, боломжит нөөц бололцоо, түүхий эд, ядуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сонголт);
- орон нутгийн засаг захиргаа, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд зэрэг орон нутгийн хэмжээнд чухал ач холбогдол бүхий хөтөлбөр, төлөвлөгөө;
- техникийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын хэрэгцээ (зорилтод бүлгүүдэд зориулагдсан санал болон дамжаанууд, хөтөлбөрийн болзошгүй үр шимийг хүртэгчдийн хүсэл зориг, чин эрмэлзэлтэй байдал, ялангуяа ХЭЗЧДС-ын бодлогын тэргүүлэх чиглэл болох хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-ын халдвар авсан хүмүүс, бусад бүлгүүдийг үл ялгаварлан гадуурхах);
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг тусгайлан тодорхой тосгон эсвэл бүлэг этгээдэд зориулж өвөрмөц маягаар хэрэгжүүлэх.

в. Ур чадварын сургалт болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс оролцох нь:

- ☐ сургалтыг зохион байгуулах газар/ зохион байгуулах боломж бүхий газар;
- ☐ сургагч нарыг элсүүлж авах;
- ☐ болзошгүй хамарагчид;
- ☐ сургалтын болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлбөр (орон нутгийн хувь нэмэр);
- ☐ зээлийн нөхцөл байдал (хөдөөгийн банк, бичил санхүүгийн байгууллага, зээлийн хоршоо, төрийн бус байгууллагууд гэх мэт);
- ☐ бусад шаардлагатай сургалтын дараах дэмжлэг (нийгэмшүүлэх, зах зээлд гарах).

2. Төрийн байгууллагуудтай хийх ярилцлагын сэдвийн санал

- ☐ орон тоо (захиргааны/ захиргааны бус);
- ☐ зорилтод бүлэг;
- ☐ хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөө:
  - хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
  - ур чадварын сургалт;
  - бизнес эрхлэлтийг хөгжүүлэх;
  - хүйсийн тэгш эрхэт байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах болон ерөнхийд нь ялгаварлан гадуурхалыг зогсоох;
  - хэрэгцээтэй технологийг нэвтрүүлэх;
- ☐ санхүүжилтийн эх үүсвэр:
  - улсын төсөв;
  - гадаадын санхүүжилт;
  - иргэд олон нийтийн зүгээс оруулах санхүүжилт;
- ☐ зээлийн тогтолцоо:
  - хугацаа /нөхцөл;
- ☐ ХЭЗЧДС-тай хамтран ажиллах боломжтой салбар.

3. Санхүүгийн байгууллагатай хийх ярилцлагын сэдвийн санал

Зээлийн нөхцөл болон олдох боломж:

- ☐ зээлийн дээд хэмжээ;
- ☐ зээлд хамрагдах боломжтой эдийн засгийн үйл ажиллагааны төрөл (эсвэл зөвхөн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа);

- ☐ хөрөнгийг бэлнээр олгох эсэх;
- ☐ эргэн төлөлтийн хугацаа;
- ☐ зээлийн хүү.
- ☐ барьцаанд тавигдах шаардлага:
- ☐ газар, үл хөдлөх хөрөнгө;
- ☐ техник, тоног төхөөрөмж;
- ☐ зээлийн төрөл, баталгаа гаргагчтай;
- ☐ орон нутгийн харьяалал хамаарах эсэх.

Батлах үйл ажиллагаа:

- ☐ шийдвэр гаргах үйл ажиллагаа хэр зэрэг төвлөрсөн бус байгаа;
- ☐ зээлийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай дундаж хугацаа;
- ☐ жижиг бизнест олгох зээлийн тоо.

4. Төрийн бус байгууллагуудтай хийх уулзалтын ярианы сэдвийн санал

ТББ-ын төрөл (улс төр/ нийгмийн хамгаалал/ үйлчилгээ/ хөгжлийг дэмжих) болон товч түүх;

- ☐ орон тоо (захиргааны/ захиргааны бус) ;
- ☐ санхүүгийн эх үүсвэр;
- ☐ явуулдаг үйл ажиллагааны чиглэл:
  - газар тариаланг хөгжүүлэх;
  - аж ахуйн бус орлогыг бий болгох/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
  - зээл;
  - ур чадвар/үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжсэн сургалт.

- ☐ төрөл бүрийн зорилтод бүлгүүдтэй ажиллах туршлага:
  - эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд;
  - хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс;
  - ДОХ-ын халдвар авсан хүмүүс;
  - залуучууд;
  - өндөр настнууд;
  - тухайн орон нутгийн иргэдийн тодорхой бүлэг.

- ☐ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санал:
  - орон нутгийн боломжит нөөц;
  - тусгай технологийг хэрэглэх боломж;
  - ур чадвар болон үйлдвэрлэл эрхэлэхийг дэмжсэн сургалт.

- ☐ ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй холбогдох боломж.

Хавсралт 2.5. Түнш байгууллагуудыг сонгоход санал болгож буй шалгуур үзүүлэлтүүд

Түнш байгууллагууд нь зах зээлд чиглэсэн ур чадварын сургалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр туршлагажсан байх шаардлагатай. Тэдгээр нь доор дурьдсан шалгууруудыг аль болох өндөр түвшинд хангасан байх хэрэгтэй:

1. Улсын бүртгэлтэй хуулийн этгээд байх;
2. Эмзэг бүлгийн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт болон сургалтыг дэмждэг, тогтвор суурьшилтай үйл ажиллагаа явуулдаг, тодорхой дадлага туршлага бүхий байхын зэрэгцээ зах зээлд чиглэгдсэн ур чадварын сургалт, бичил болон жижиг үйлдвэрлэлийн хөгжил, орлогыг бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбарт 7-оос доошгүй жилийн туршлагатай байх;
3. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сонгогдсон салбарт идэвхтэй ажиллах бололцоотой, тухайн орон нутгийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, явагдаж байгаа үйл ажиллагааны талаар мэдлэг сайтай, орон нутгийн ард иргэдтэй холбоотой гэдгээ харуулах;
4. ХЭЗЧДС-ын хөтөлбөрт холбогдох тодорхой үйл ажиллагаа эрхлэх чадвар, туршлагатай хүний нөөцтэй, өөрийн гэсэн дэд бүтэц, захиргаа, тээвэрлэлтийн тогтолцоотой байх;
5. Сургалтын үйл ажиллагаа (хүний нөөц, ур чадвар) болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг (техник туслалцаа, зах зээлд гаргах, зээл олгох, бизнесийн зөвөлгөө өгөх болон технологийн гэх мэт) зохион байгуулах чадвартай гэдгээ харуулах;
6. Орон нутгийн ард иргэд, нийгмийн тодорхой бүлгийг ойлгож, тэдгээрт туслах чин эрмэлзэлтэй байхын зэрэгцээ сургалтад хамрагдагчид, ажиллагчид болон тодорхой бүлгийн хэрэгцээг хангах асуудал дээр ялгарварлан гадуурхалгүй үйл ажиллагаа явуулж чадна гэдгээ харуулах;
7. Хөдөөгийн ядуу хүмүүс үйлдвэрлэж магадгүй бүтээгдэхүүн, эрхэлж болзошгүй үйлчилгээ (түгээмэл бус зах зээл болон үйлчилгээг хамруулна)-ний зах зээлийн талаар ойлголттой байх;
8. Сургалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд жендерийн тэгш эрхийн байдлыг хангах талаар тодорхой дадлага туршлагатай байх;
9. Тодорхой хугацаанд хөтөлбөрийн тодорхой чиглэлээр зорилтод бүлгүүдийг (доод тал нь 3 хүн) бүрэн хамарсан үйл ажиллагаа явуулах чадвартай;
10. Багаар зохион байгуулах, бүлгүүдийн хүчин чармайлтыг нэгтгэх, ялангуяа зээл болон хадгаламжийн үйлчилгээг хүргэх стратегийг хэрэгжүүлэх дадлага туршлагатай байх;
11. Мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээг үзүүлэх, хадгаламж зээлийн үйл ажиллагааг эрхлэх, зах зээлийн мэдээлэл болон зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай байнгын холбоо тогтоосон байх;
12. Санхүүгийн хувьд найдвартай гэдгээ харуулсан байх;
13. Нягтлан бодох болон аудитын тогтсон үр дүр бүхий тогтолцоотой байх;
14. ХЭЗЧДС-ын зүгээс тайлан, үнэлгээний тогтолцоонд тавигдах шаардлагатай нийцсэн үйл ажиллагаа явуулах хүсэл эрмэлзэлтэй байх.

Хэдийгээр зарим байгууллагууд зорилтод бүлгүүлийн орлогыг нэмэгдүүдэх хүсэлтэй байх боловч, дараах шалтгаанаар ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохирсон түнш байх боломжгүй юм.Үүнд

- ☐ зөвхөн газар тариаланг хөгжүүлэх чиглэлд анхаарал тавьдаг;
- ☐ тэдгээрийн зорилтод бүлгүүдэд ядуу өрхүүд хамаардаггүй;
- ☐ хөтөлбөрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх боломжгүй эсвэл сонирхолгүй;
- ☐ бусад байгууллагуудтай, ялангуяа төрийн байгууллагуудтай хамтран ажиллах хүсэл эрмэлзэлгүй байх зэрэг.

Зардал хуваалцах

ХЭЗЧДС-ын арга зүйг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд түнш байгууллага болох хүсэлт гаргах, санхүүжүүлэх гэдэг нь чухал асуудал юм. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн тодорхой хэсгийг гаргаж үйл ажиллагаа явуулах нь тухайн сонгогдсон байгууллагын зохион байгуулалтын болон санхүүгийн хүчин чадлаас хамаарна.

Зарим байгууллагууд ХЭЗЧДС-ын бүтэн “сургалтын циклыг”: - сургалтыг төлөвлөхөөс эхлэн сургалтыг явуулах, сургалтын дараа зээл олгох болон хөдөлмөр эрхлэлтийг бий болгох үйл ажиллагааг дэмжих гэх мэт хүртэл санхүүжүүлдэг. Мөн зарим байгууллага нь зөвхөн сургалтын хөтөлбөрийг (ХЭЗЧДС-ын багийн гишүүдийн зөвлөмж, дэмжлэг туслалцаатайгаар) хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Болзошгүй түнш байгууллагын тодорхойлолтуудыг нэгтгэн дүгнэж сонголт хийхэд тус болохуйц загварыг үзүүлэв:

Байгууллагын нэр.....

Хаяг .....

Төв оффис.....

Орон нутгийн оффис.....

Үйл ажиллагаа явуулсан хугацаа.....

Голлох санхүүгийн эх үүсвэрүүд.....

.....

.....

Орон тоо/ хүний нөөцийн мэргэшсэн байдал.....

Захирал.....

Бусад ажиллагчид.....

.....

Үндсэн зорилго.....

.....

.....

Зорилтод бүлэг.....

.....

.....

Хэрэгжүүлж буй хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.....

.....

.....

.....

Ур чадварын сургалт болон (эсвэл бичил болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих) оролцоо эсвэл өөрөөр оролцох сонирхол.....

.....

.....

ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй хамтран ажиллах санал.....

.....

.....

.....

Цаашид авах арга хэмжээ

Бүс нутгийн ХЭЗЧДС-ын баг: .....

.....

.....

Үндэсний ХЭЗЧДС-ын баг: .....

.....

.....

Ярилцлага хийж анкетыг бөглөсөн: .....

Огноо: .....

III

I.Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны зорилго. II. Нийгэм эдийн засгийн судалгааг явуулах үе шатууд. III. Үргэлжлэл. Хавсралтууд

Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох

Эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны зорилго

ХЭЗЧДС нь урьдчилан бэлтгэсэн сургалтын хөтөлбөртэй байдаггүй. Иймээс аливаа сургалтын хөтөлбөрийн загварыг боловсруулахаас өмнө тодорхой нарийвчлсан болон системчилсэн аргачлалаар тухайн орон нутаг, хөрш зэргэлдээх нутгийн эдийн засгийн боломж, сургалтын хэрэгцээг судалж үздэг байна. Зөвхөн хангалттай мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зах зээлд чиглэгдсэн сургалтын үйл ажиллагааны загварыг бий болгож, үр дүнтэй хөдөлмөр эрхлэлт, орлогыг бий болгох болон бичил үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагааг явуулна.

Цалинтай хөдөлмөрэрхлэх боломж хөдөө орон нутагт ховор байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ боломжтой ажил хөрш зэргэлдээх хот суурин газарт байж болох юм. Ажлын байрны талаарх мэдээллээр хангах нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагын үүрэг. Хэрэв дээрх чиглэлийн үйл ажиллагааг явуулах байгууллага тухайн орон нутагт байхгүй эсвэл тухайн байгууллагын хүчин чадал хангалтгүй байвал орон нутгийн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг болзошгүй ажил олгогч болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран хөдөөгийн иргэдэд таарах ажлыг олж санал болгох боломжтой. Дээрх боломжит нөхцөл байдлууд тодорхой болсны дараа тохирсон сургалтыг зохион байгуулна.(➔ **Сургалтын хэрэгцээг тодорхойлохыг 4 дүгээр үе шат-аас харна уу.)**

II. Нийгэм эдийн засгийн судалгааг хийх үе шатууд

Эдийн засгийн боломжийг тогтоох үйл ажиллагааг 4 үндсэн үе шатаас бүрдэнэ. Хэдийгээр үе шат бүр чухал, өмнөх шаттайгаа логик дараалаар холбоотой ч гэсэн шинэ мэдээллийг боловсруулах, оролцогч талуудын санал дүгнэлтийг хүлээн авах үйл ажиллагааны явцад эдгээр асуудалд уян хатнаар хандахыг зөвлөж байна. Дээрх судалгааг хийх баг нь олон нийтийн хүч чармайлтыг дайчлах, мэдээлэл цуглуулах болон боловсруулах талаар сургагдсан байх нь зүйтэй.

Үе шат 1. Болзошгүй зах зээлийн боломжийг судлах

Зах зээлийн боломжийг судлах нь нилээд хэдэн жижиг судалгаанаас бүрдэнэ. Үүнд:

- ☐ орон нутгийн ард иргэдийн судалгаа;
- ☐ салбарчлан хийсэн судалгаа;
- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа;
- ☐ зах зээлийн боломжийн судалгаа.

Эдгээр судалгааны цогц нь зах зээлийн чиг хандлагад дүн шинжилгээ хийх, төрөл бүрийн эдийн засгийн үйл ажиллагааны эрсдэл болон боломжийн үнэлгээг гаргах зэргээс бүрдэнэ. Түүнчлэн судалгааны арга нь орон нутгийн эх үүсвэрийг ашиглан орлогыг бий болгох, орон нутгийн нөөц бололцоо, бодит хөрөнгө, хэрэгцээтэй мэргэжил, бүтээгдэхүүн болон үйлчилгээний төрлийг тодорхойлоход тус дэм болно. Мөн тухайн орон нутгаас бусад бүс нутаг, үндэсний болон тэр ч бүү хэл олон улсын зах зээлтэй холбоход нөлөөлж болох юм. Дараах хүчин зүйлсийг анхааралдаа авах нь зүйтэй:

- Хөдөөгийн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн зах зээлийн талаарх мэдээлэл авах боломж нь хомс байдаг. Энэ нь тэдгээрийн зах зээлийг хөгжүүлэх боломжид хязгаарлалт болдог. Зах зээлийн боломжийг тодорхойлох үйл ажиллагаа нь мэдээлэл өгөхөд чиглэгдсэн, шинэ зах зээлийн боломжийг сонгоход боломж олгож байгаа юм;
- Зах зээл бол хүмүүсийн худалдан авах чадвараас хамаардаг бөгөөд энэхүү худалдан авах чадвар нь хөдөө орон нутагт доогуур байдаг хэдий ч бараа бүтээгдэхүүний зардал, тээвэрлэлтийн өртөг нь өндөр байдаг. Зах зээлүүд байнга өсөж өөрчлөгдөж байхын зэрэгцээ өрсөлдөөнтэй байдаг. Өнөөдөр ашигтай бизнесийн боломж гэж тооцогдож байгаа бизнесийн боломж 6 сарын дараа нилээд эрсдэл дагуулж ч болно. Иймд дээр дурьдсан судалгаанууд нь нэг удаагийн үйлдэл биш юм. Судалгаагаар олж авсан шинэ мэдээлэл, түүнд суурилсан дүгнэлт, зөвлөмжүүд нь байнга шинэчлэгдэж байх хэрэгтэй. Тухайлбал, нэгэнт зах зээлд дэх тодорхой бараа үйлчилгээний хэрэгцээ байнга өөрчлөгдөж байдаг тул жилд дор хаяж нэг удаа шинэчлэгдэж байх нь зүйтэй юм.

Мэдээлэл цуглуулах арга, аргачлал

Орон нутгийн судалгаа

Орон нутгийн судалгаа нь эдийн засгийн боломжийг тодорхойлох үйл ажиллагааны цар хүрээг тогтоож байгаа тул энэ сэдвээр хийх ярилцлагуудыг орон нутгийн иргэдийн уулзалтуудын үеэр зохион байгуулах нь зүйтэй. Түүнчлэн орон нутгийн судалгаа нь жендерийн асуудалд дүгнэлт хийх боломжийг олгох бөгөөд жендерийн оролцоо болон нийгэм, соёлын бусад асуудлууд хоорондоо холбоотой байхын зэрэгцээ эдийн засгийн боломжийг тодорхойлоход нилээд ач холбогдолтой зүйл билээ. Түүнчлэн орон нутгийн судалгаа нь нийгмийн зүгээс ихэвчлэн ялгаварлан гадуурхагдаж байдаг хөгжлийн бэрхшээлтэй мөн ДОХ-ын халдвар авсан хүмүүс эсвэл тодорхой газар нутгийн хүрээнд оршин тогтнодог яс үндэс болон шашин шүтлэгийн хувьд бусдаас ялгардаг нийгмийн хэсгүүдийн талаарх бодитой мэдээллийг олгодог байна. Мөн орон нутгийн судалгаа нь тухайн орон нутгийн ард иргэдийн хувьд бололцоотой ур чадвар, түүхий эд гэх мэт хэрэгцээтэй мэдээллийг олж авах боломжийг бүрдүүлдэг. Орон нутгийн судалгаа нь мөн зорилтод бүлгүүд, тэдгээрийн орлого, эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хувь, тэдэнд учирч буй бэрхшээлүүдийн талаарх мэдээллүүдийг авах боломж олгодог ба хөтөлбөрийн хяналт-шинжилгээ хийхэд ихээхэн тус дэм болдог байна.

Зарим мэдээлэл газар дээр нь очиж танилцах үйл ажиллагааны явцад цуглуулагдсан байдаг. Гэхдээ нэгэнт тодорхой орон нутаг эцэслэн сонгогдсон тохиолдолд, илүү гүн гүнзгий судалгаа хийх шаардлага гардаг. Судалгааны гол сэдвүүд нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийн тухайн орон нутагт эзлэх нийгэм-эдийн засгийн статус, дэд бүтцийн хүртээмж, нийгэм болон арилжааны үйлчилгээ, орон нутгийн түүхий эд болон хоёрдогч бүтээгдэхүүн зэрэг байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн судалгаа нь тухайн орон нутгийн ард иргэд болон тэдний эдийн засгийн нөхцөл байдал, орлогыг бий болгох үйл ажиллагаанд хэрэглэж болох нөөц бололцоо, одоо эрхэлж буй бизнесийг өргөжүүлэх болон хөгжүүлэх боломж байгаа талаар мэдээлэл өгдөг байна.

Орон нутгийн гол мэдээлэгчдийг тодорхойлж авах нь чухал. Мэдээлэл өгөх хүмүүс, тэдний нэр хүнд нь ХЭЗЧДС-ын хөтөлбөр хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна. Хэн гол мэдээлэл өгөх боломжтой вэ?

- ☐ тосгоны удирдлага;
- ☐ орон нутгийн дэлгүүр эсвэл үйлдвэрийн эзэн;
- ☐ ТББ болон орон нутгийг хөгжүүлэх бусад чиглэлийн үйлчилгээ үзүүлэгчид;
- ☐ орон нутгийн байгууллага, сургуулийн ажилтан, албан хаагчид;
- ☐ зорилтод бүлгүүд.

Дээр дурьдсан мэдээлэгчдээс авсан мэдээллээс гадна тухайн орон нутгийн ХЭЗЧДС-ын багийн гишүүд, ялангуяа орон нутгийн ХЭЗЧДС-ын зохицуулагч, нийгэм-эдийн засгийн ажилтан, жендерийн асуудал хариуцсан ажилтан нь зорилтод бүлгийн төлөөлөл болгож ганцаарчлан уулзсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс тэдний нөхцөл байдал, аж амьдрал, бусад асуудлын талаар шууд мэдээлэл авах нь зүйтэй. Нийгмээс гадуурхагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ч гэсэн мэдээлэл авах чухал. Хүмүүсийн нөхцөл байдлыг дутуу үнэлж, ойлгоогүйгээс болж хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бэрхшээл гардаг нь төдийлөн ховор тохиолдол биш юм.

→ **Орон нутгийн судалгааны загвар аргачлалыг хавсралт 3.2-оос үзнэ үү.**

Салбарын судалгаа

Олон улс орнуудад яамдууд, төлөвлөлт судалгааны байгууллагууд болон бусад этгээдүүд салбарчилсан судалгаа хийдэг, тэр ч байтугай үнэт зүйлсийн гинжин холбоосын дүн шинжилгээг хийдэг байна. Дээрх

судалгаанууд болон холбогдох мэдээлэлүүд нь чухам ямар салбарт хөдөлмөр эрхлэлт болон бизнесийн боломж байгааг тодорхойлдог. Цаашилбал, чухам ямар салбарт дэмжлэг үзүүлснээр эдийн засгийн нөхцөл байдлыг дээшлүүлэхэд таатай боломжийг бүрдүүлэх талаар ч тодорхойлж чадна. Эдгээр судалгаанууд нь үндэсний, бүс нутгийн мөн орон нутгийн түвшинд хийгдсэн эсэхээс хамааралгүйгээр чухал мэдээллийн эх сурвалж болно гэдгийг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн энэхүү мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагаа явуулах салбартай холбогдох мэдээлэл байгаа эсэхийг судалж үзэх нь зөв юм.Тухайлбал, тухайн сонгогдсон орон нутаг нь бусдаас ямар нэгэн харьцангуй давуу талтай байх бөгөөд үүнийг ашигласнаар тодорхой салбарт илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа

Одоогоор дутагдалтай байгаа эсвэл огт байхгүй ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ эрэлт хэрэгцээтэй байна вэ?

Энэ судалгааны зорилго нь орон нутгийн болон бүс нутгийн (үндэсний эсвэл орон нутгийн хэмжээний байж болно) хэрэглэгчдээс тэдгээр нь чухам ямар бараа, үйлчилгээг хүсч байгааг тодруулах юм. Ялангуяа дээрх судалгаа нь дутагдаж эсвэл хязгаарлагдмал, байгаа боловч чанарын шаардлага хангадаггүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлоход оршино.

➔ **Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгааны загвар аргачлалыг хавсралт 3.3-аас үзнэ үү.**

Зах зээлийн боломжийн судалгаа

Яагаад тухайн орон нутагт үйлчилгээ болон барааны хангалт хомс байна вэ? Тийм үү? Үгүй юу? Эдгээр хэрэгцээг хөрш зэргэлдээх газраас түүхий эдийг нь авчирч үйлдвэрлэл явуулсны үндсэн дээр орон нутгаа хангах боломжтой юу? Тухайн орон нутагт үйлдвэрлэгдсэн бараа нь орон нутгаас гаднах зах зээлд борлогдох боломжтой юу? Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгааны зорилго нь орон нутгийн урчууд, үйлдвэрлэгчид, ажил олгогчид, худалдаачид, бизнес эрхлэгчид болон зорилтын үр шимийг хүртэгчдээс яагаад орон нутгийн судалгааны явцад тодорхойлогдсон орон нутгийн давуу байдал, нөөц бололцоо, түүхий эдийг ашиглаж, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, шинэ бүтээгдэхүүн болон үйлчилгээг нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн шинэ боломжуудыг нээж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаагаар тогтоогдсон шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэгцээтэй тоо, чанартайгаар байхгүй вэ? гэдгийг тодруулахад оршино.

➔ **Зах зээлийн боломжийн судалгааны загвар аргачлалыг хавсралт 3.4.-өөс харна уу.**

Цаашдын бизнес болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ санааг дараах аргаар олж болно. Үүнд:

- хоёрдогч мэдээллийн эх сурвалж болох салбарын судалгаа, демографикийн тайлан, нийгэм, соёл, боловсрол, эдийн засгийн төлөв, боломжит эх үүсвэр, одоо үйл ажиллагаа явуулж байгаа бизнес, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө, шинээр үйлдвэрлэлийг бий болгох боломж зэргийг ашиглаж болно. Эдгээр нь төрийн байгууллагууд, болон худалдаа аж үйлдвэрийн танхим, бусад байгууллагууд, нийгмийн хамгаалал, техникийн боловсрол, хүний нөөц, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-аас гаргах боломжтой мэдээлэл;
- төрийн албан хаагчид, нутгийн засаг захиргааны төлөөлөгчид болон үйлдвэрлэл эрхлэгчид, ялангуяа тухайн орон нутгийн ард иргэдийн төлөөлөл болсон иргэдтэй эмэгтэйчүүд санал солилцох;
- орон нутгийн оршин суугчид, үр шимийг хүртэгчид өөрсдийн санал, бодлоо илэрхийлэхэд боломжтой оролцоо бүхий хурал, цуглаан хийх. Эдгээр хурал, цуглааны үед эдийн засгийн дүн шинжилгээ, хөдөлмөр эрхлэлтийн боломжийн эрсдэл болон орлогыг бий болгох төслүүдийн талаар иргэд олон нийтэд тайлбарлан таниулах боломжтой юм.

Үе шат 2. Оролцогч талуудтай судалгааны үр дүнг хэлэлцэх

Судалгааны үр дүнг орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлийн ажил хэргийн уулзалт, тухайн орон нутгийн болзошгүй үр шимийг хүртэгчидтэй хийх уулзалтын үеэр дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцож болох юм. Тэд нь судалгааны үр дүнтэй танилцаж, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, чиг хандлагын талаар санал солилцох боломжоор хангагдсан байх хэрэгтэй. Гол анхаарах зүйл бол эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмээс гадуурхагдсан бусад бүлгийн гишүүд эдгээр уулзалтуудад чөлөөтэй оролцох нөхцлийг бий болгох юм. Үйл ажиллагааг зохион байгуулж байгаа хүмүүс нь эмэгтэйчүүдийн саналыг сонсох, нийт оролцогчдод санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.

Олон нийт, ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тэдэнтэй санал солилцох нь судалгааны үр дүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлогдсон арга хэмжээнүүдээс эхний ээлжинд, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгжснээр тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох арга хэмжээнүүдийг сонгон авах, ирээдүйд тулгарч болзошгүй бэрхшээл, хүндрэлүүдийг тодорхойлох боломжтой юм.

Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломж бүхий эдийн засгийн үйл ажиллагаанууд тодорхойлох тал дээр ихээхэн анхаарал хандуулах нь зүйтэй. Түүнчлэн

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлгүүдийн эрх ашгийг хамгаалах асуудлууд дээр анхнаасаа нухацтай хандаж, эдгээр бүлгүүдийн дэд бүлэг болох эмэгтэйчүүд, ядуу иргэдэд илүү ашигтай байх эдийн засгийн боломжид анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Доор дурьдсан асуултууд нь хөдөөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийг нягталж үзэхэд тус нэмэр болох болно.

Эдийн засгийн үр нөлөө

- Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдийн засгийн үйл ажиллагаа нь нэмэгдэл орлогыг бий болгох уу, хэрэв бий болгох боломжтой бол орлогыг 10, 20 эсвэл 30 хувиар нэмэгдүүлэх боломжтой юу?
- Хэрэв хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал нь зээлээс гарах бол яах вэ?
- Сургалтыг явуулахад шаардлагатай сургагч болон тоног төхөөрөмжийг олох боломжтой юу? Шаардлагатай сургалтын материал хүрэлцээтэй юу?
- Хэрэв төлөвлөгдөж буй үйл ажиллагааг ашигтай, санхүүгийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, мөн шаардлагатай сургалтыг хямд төсөр өртөгөөр хүргэх зэргийг эдийн засгийн хувьд ашигтай гэж үзэж болно;

Сургалттай холбогдох асуултууд

- Төлөвлөж буй эдийн засгийн үйл ажиллагаанд ямар сургалт хэрэгцээтэй вэ? (техникийн ур чадвар, оёдол эсгүүрийн ур чадвар гэх мэт);
- Сургалтад хамрагдаж болзошгүй хүмүүс нь хэн бэ? Тэдгээр нь ямар сонирхолтой вэ?
- Багаар суралцагчид уу эсвэл ганцаарчилсан суралцагчид уу?
- Болзошгүй сургалтыг зохион байгуулагчид болон сургагч нар нь хэн бэ? Тэдгээрийг хэрхэн элсүүлж авах вэ? Тэдгээр нь зорилтод бүлгүүдийн хэрэгцээнд нийцэхүйц ур чадвартай юу?
- Урьдчилсан байдлаар тооцоолсон сургалтын зардал хэд вэ?
- Сургалтыг зохион байгуулж буй байгууллагын зардлаар явуулах боломжтой юу? Хэрэв “үгүй” бол сургалтыг санхүүжүүлэх өөр бусад ямар арга зам байгаа вэ?
- Сургалтад шаардлагатай тоног төхөөрөмж орон нутгийн хэмжээнд олдох уу? Хэрэв “үгүй” бол шаардлагатай тоног төхөөрөмжөөр хэрхэн хангах вэ?

Түүхий эд/бүтээгдэхүүний орц

- Түүхий эдийг орон нутгаас нийлүүлэх боломжтой юу?
- Түүхий эдийн олдоцын хэмжээ, чанар, улирал, тэдгээрийг хэрэглэхэд орчин тойронд бий болгох нөлөөлөл юу вэ?
- Цахилгаан, ус, дулаан, түлш гэх мэт бусад орцын хүртээмж хэр вэ?
- Түүхий эдийг хэн эзэмшдэг вэ?
- Түүхий эд нь эдийн засгийн үйл ажиллагаа болон үр шимийг хүртэгчдэд хүртээмжтэй байх боломжтой юу?
- Түүхий эд нь ямар үнэтэй нийлүүлэгдэх вэ? (түүхий эдийн үнэ болон тээвэрлэлтийн зардал гэх мэт);
- Тухайн түүхий эдийг боловсруулах зардал нь бэлэн бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлөх үү? Хэрэв өсөхөөр бол энэ нь ашигтай байх уу?
- Үйлдвэрлэл явуулахад шаардлагатай түүхий эдийн үнэ ойролцоогоор хэд вэ? Санхүүжилтийг хэрхэн хийх вэ? Өөрийн эх үүсвэрээс үү, гадаад эх үүсвэрээс үү? (тухайлбал, нийлүүлэгчээс зээлээр авах);
- Түүхий эдийг хэрэглэж болох өөр арга зам байна уу? Хэрэв байгаа бол тэдгээр нь үнийн болон эх үүсвэрийн хувьд өрсөлдөөнийг бий болгох уу?

Үйлдвэрлэлийн технологи

- Эдийн засгийн үйл ажиллагаанд ямар технологийг хэрэглэх вэ? Энэ технологи нь механик эсвэл гар ажиллагаатай технологи уу?
- Ямар багаж, тоног төхөөрөмж хэрэгтэй вэ? Тэдгээрийг хэрхэн олж авах вэ? Үйлчилгээ, засвар, сэлбэг зэргийг яах вэ? Эдгээр нь орон нутагт олдох боломжтой юу? Хэр өртөгтэй вэ?
- Эдийн засгийн үл ажиллагаа явуулах газар нь зах зээлээс хэр зэрэг хол зайнд байрлах вэ? Үйлдвэрлэл эсвэл үйлчилгээг явуулахад хэр зэрэг том орон зай хэрэгтэй вэ? Тухайн орон зайг хэн эзэмшдэг вэ? Одоо үйл ажиллагаа явуулах боломжтой юу? Худалдаж авах эсвэл түрээслэх хэрэгтэй юу? Худалдаж авах эсвэл түрээслэх үнэ хэд вэ? Хэр зэрэг удаан хугацаанд ашиглаж болох вэ? Тухайн газар нь цахилгаан эсвэл устай байх хэрэгцээтэй юу? Хэрэв хэрэгцээтэй бол холболтууд нь хийгдсэн үү? Хийгдээгүй бол ямар өртөгөөр хийх вэ? Тусдаа байртай байх хэрэгцээтэй юм уу? Өөрийн оршин суугаа газраа үйл ажиллагаа эрхлэх боломжтой юм уу?

Менежмент

- Бизнесийг хэрхэн зохион байгуулах (хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоолол, бусад төрлийн хамтарсан үйл ажиллагааны хэлбэрээр) вэ? Хэдэн хүнтэй байх вэ? Ямар ажилчид байх вэ? (гэр бүлийн, хөлсний гэх мэт) Менежментийг хэрхэн явуулах вэ? Хэн хариуцах вэ?
- Төгсөгчдийн оролцоо хэр зэрэг байх вэ? Тэдгээрийн гэр бүлийн оролцоо? Олон нийтийн оролцоо? Тухайн эдийн засгийн үйл ажиллагааг ямар байгууллагууд дэмжих вэ? Дэмжих байгууллагууд нь дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзэлтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын нөхцөл

- Тооцоологдож байгаа анхны хөрөнгө оруулалт нь ямар өртөгтэй вэ? Үндсэн хөрөнгийн хэмжээ болон эргэлтийн хөрөнгийн хэмжээ хэд байх вэ?
- Хөрөнгийг хаанаас олох боломжтой вэ? - өөрийн хуримтлал, найз нөхөд, хамаатан садангуудаас, зээл олгогчоос, ТББ-аас, банк эсвэл санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас, эсвэл эх дээрх үүсвэрүүдийг нэгтэж.
- Зээл нь зөвхөн хувь хүнд боломжтой юу? Эсвэл хамтарч авах шаардлагатай юу? Өөр зээлийн нөхцөл байгаа юу?
- Зээлийн төрлүүдийн нөхцөлүүд нь ямар вэ? Хамтарсан зээл авах боломжтой юу? Санхүүжилтийг хэрхэн олгодог вэ? (арилжааны банкаар, тоног төхөөрөмж худалдан авсан тасалбараар гэх мэт) Төлбөрийн ямар хуваарьтай вэ? Хөнгөлөлт эсвэл урамшуулал авах боломжтой юу?
- Зээлийн хүү нь хэд вэ?
- Зээлийн гэрээнд шаардагдах бичиг баримтыг хэн бүрдүүлэх вэ?

Маркетинг/зах зээл

- Ямар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх гэж байгаа вэ? Ямар загваруудаар үйлдвэрлэх гэж байгаа вэ? Загварууд нь хаанаас ирсэн бэ? Хэрэглэхэд бэлэн үү? Хэрэв “үгүй” бол хэн загварыг бэлтгэх вэ? Бүтээгдэхүүнийг ямар хэмжээ чанарын үзүүлэлттэйгээр үйлдвэрлэх вэ? Зах зээлд борлуулах боломжтой юу?
- Ямар үнэтэй байх вэ? Өөрийн өртөг болон ашгийг тооцсоны дараа үнэ нь зах зээл дээр борлогдож байгаа ижил төстэй бүтээгдэхүүнүүдтэй үнийн хувьд өрсөлдөх чадвартай юу?
- Бүтээгдэхүүнийг хаана борлуулах вэ? Тэдгээрийг орон нутагтаа борлуулах уу? Өөр хаана борлуулах вэ? Эрэлт хэрэгцээний хязгаар хэр зэрэг вэ?
- Зорилтод худалдан авагчид нь хэн бэ? Орон нутгаас гадагш зарах тохиолдолд тээвэрлэлтийн өртөг хэд вэ?
- Тухайн бүтээгдэхүүнд чанарын хяналт байх шаардлагатай юу?
- Баглаа, боодол, сурталчилгааны зардлыг хэн төлж, хаанаас авах вэ?
- Тухайн бүтээгдэхүүнтэй өрсөлдөх бүтээгдэхүүн болон өрсөлдөгч нь хэн байх вэ? Өрсөлдөөн хаанаас ирэх вэ (тухайлбал, төгсөгчид хоорондоо өрсөлдөх)? Дотоод уу? Гадаад уу? (өрсөлдөөн) Бүтээгдэхүүн нь ямар онцлог, давуу чанартай вэ?

Бусад асуудлууд

- Төлөвлөж буй бизнест ямар нэгэн эрх зүйн шаардлага тавигдах уу?
- Ямар нэгэн тусгай зөвшөөрөл шаардлагатай юу? Тэдгээрийг олж авахад хэцүү юу?
- Тухайн үйл ажиллагаанд жендерийн талаас болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мөн бусад эмзэг бүлгийнхэнтэй холбогдолтой асуудал байгаа юу?
- Хүрээлэн буй орчны асуудал хамааралтай юу?
- Тухайн бүс нутгийн одоогийн болон ирээдүйн хөгжлийн асуудалд хамааралтай юу?
- Энэхүү бизнес нь орон нутагт ямар хувь нэмэр оруулах вэ? (бусад үйл ажиллагаатай уялдах, ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх гэх мэт)
- Тухайн бизнесийг эрхлэхэд ямар байгууллагын мэргэжлийн арга зүйн дэмжлэг хэрэгтэй вэ? Тэдгээр нь боломжтой юу? Найдвартай юу? Хүртээмжтэй юу?
- Тухайн төсөлд холбогдох төрийн үйлчилгээ байгаа юу? (хөдөөгийн хөгжлийг дэмжих байгууллагууд, үйлдвэр-сургалтын төв гэх мэт).

Дээр дурьдсан судалгаанууд болон ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн багтай уулзаж, мэдээлэл солилцсоны үр дүнд хөдөлмөр эрхлэлт болон үйлдвэрлэлийн боломжит хувилбаруудыг санал болгоно. Дээрх санал болгосон хувилбарууд дээр дахин дүн шинжилгээ, ирээдүйн чиг хандлагын талаарх нарийвчилсан судалгаа хийнэ. Зөвхөн үр дүн, ирээдүйн боломж нь тодорхой, найдвартай гэж үзсэн тохиолдолд сургалтын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг бэлтгэж эхэлнэ.

Үе шат 3. Нөхцөл байдлын судалгаа

Бичил болон жижиг үйлдвэрлэл нь иргэдийн хүсч буй бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг бий болгож, ашигтайгаар борлуулах боломжтой юу?

Ашиг олж болох эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлж, тухайн орон нутгийн хувьд хамгийн боломжит хувилбарыг сонгосны үндсэн дээр шаардлагатай дүн шинжилгээ, нарийвчилсан судалгаа хийж, тухайн орон нутгийн онцлог нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлно. Чиг хандлагын судалгааны зорилго нь тухайн сонгож авсан эдийн засгийн үйл ажиллагааг үргэлжилсэн хугацаанд тогтвортой байх талаарх тооцоог гаргаж, үр дүнгүй сургалтад хөрөнгө мөнгө, цаг зав, эрч хүч зарцуулахгүй байхын тулд хийгдэнэ. Учир нь орлогыг бий болгох үйл ажиллагаа нь тодорхой хугацааны дараа эрэлт хэрэгцээ буурах, санхүүгийн эсвэл бусад хүчин зүйлээс хамааран ашиггүй болж эхэлдэг. Сайн хийгдсэн судалгаа нь дээр дурьдсан бэрхшээл тулгарах эсэхийг тодруулахад ихээхэн ач холбогдолтой юм.

Нөхцөл байдлын судалгаа нь тухайн эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орц (хөдөлмөр, тоног төхөөрөмж, түүхий эд, зээлийн хүү гэх мэт), өртөг болон үйлдвэрлэл үйлчилгээний борлуулахаар төлөвлөж байгаа үнэ дээр суурилсан бизнесийн чиг хандлагын харьцуулсан дүгнэлтээс бүрдэнэ.

Нэгэнт ХЭЗЧДС-ын орон нутгийн ард иргэдийн амьжиргаанд хувь нэмэр оруулахаар чиглэгдсэн

тул нөхцөл байдлын судалгаа нь тодорхой хувь хүмүүсийн бизнесийн эрх ашгаас илүү тухайн бизнес хөгжснөөр орон нутаг болон ард иргэдэд ямар хувь нэмэр оруулах вэ? гэсэн өргөн хүрээтэйгээр асуудалд хандана. Нөхцөл байдлын судалгааны үр дүнг орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөл авч хэлэлцсэний үндсэн дээр сургалтын хөтөлбөрийн боловсруулна. Нөхцөл байдлын судалгааны гол бүрэлдэхүүн хэсгүүдийг доор дурьдав. Үүнд:

Ерөнхий зүйл

Санал болгож буй бизнесийн ерөнхий зураглал, бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, байршил, үйлдвэрлэгчидэд ноогдох үр шим, орон нутгийн ард иргэдэд хэрэгцээтэй байх.

Зах зээлийн дүн шинжилгээ

Аливаа бизнесийн хувьд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь бодит эрэлт хэрэгцээг хангах нь чухал. Өөрөөр хэлбэл, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь худалдан авахад бэлтгэлтэй, худалдан авах чадвартай, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн санал худалдан авагчдын нөхцөл, байдалд нийцсэн байх шаардлагатай. Мөн тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээ нь наад зах нь ижил төрлийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц үнээр зах зээл дээр гаргасан байхыг хэрэгтэй.

Зах зээлийн дүн шинжилгээ нь тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээ нь нийлүүлэгдэх гол зах зээл, худалдан авагч, өдөрт, долоо хоногт эсвэл сард хэдэн нэгж борлогдох зэргийг судална. Зах зээлийн дүн шинжилгээний гол асуудлууд болох нийлүүлэлт, өрсөлдөөн, үйлчилүүлэгч болон дэмжлэг зэрэг болно.

Техникийн боломжийн судалгаа

Техникийн боломжийн судалгаа нь үйлдвэрлэлд хэрэглэгдэх технологи, тоног төхөөрөмжийн төрөл, шаардлагатай ур чадвар, ажиллах хүчний хүчин чадал болон түүнд тавигдах шаардлага, үйл ажиллагаа явуулах нөхцөл (үйл ажиллагааны орон зай, агуулахын багтаамж, дэд бүтэц, зах зээл болон түүхий эд), тухайн нөхцөл байршилд төлөвлөсөн үйл ажиллагааг явуулахад ашигтай байгаа эсэх зэргийг судална. Дараагийн шатанд сургалтад хамрагдагчдыг сонгож, тэдгээрийн одоо байгаа ур чадвар, цаашид тухайн бизнесийг эрхлэхийн тулд хэрэгтэй ур чадвар зэргийг тодорхойлох нь мөн энэ судалгааны нэг хэсэг болно.

Менежментийн асуудлууд

Жижиг үйлдвэрлэл явуулах, бизнес эрхлэхэд зөвхөн техник ур чадвараас гадна менежментийн ур чадвар хэрэгцээтэй болдог. Өөрөөр хэлбэл бизнес эрхэлж буй хүн нь бизнесийн холбогдолтой тодорхой хэмжээний мэдлэгтэй байх хэрэгцээтэй. Үүнд: хөдөлмөрийн хуваарилалт, цаг зохицуулалт, төсөв, материал гэх мэт орно.

Шаардлагатай мэдлэгийг сургалтын дамжааны үед заах боломжтой юу? Цаашилбал хэрэв хамтарсан бизнес эрхлэхээр бол хэн, юу хийх вэ? Хэн хөрөнгө оруулж ирэх вэ? Даалгавар, хариуцлага, ашгийг хэрхэн хуваарилах вэ? гэх мэтийн асуудлууд гарч ирнэ.

Санхүүгийн дүн шинжилгээ

Аливаа үйл ажиллагааг эхлэхээс өмнө нийт өртөгийг багцаагаар урьдчилан тооцоолж, санхүүгийн дүн шинжилгээг хийх хэрэгтэй (хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны өртөг).

Санхүүгийн тооцоон дээр үндэслэн тухайн үйл ажиллагаа ашигтай байх эсэхийг тодорхойлно. Аливаа үйл ажиллагаа нь эхлэх, өдөр тутмын үйл ажиллагаа явуулах, өргөжүүлэх зэрэг үе шатанд хөрөнгийн зарцуулатыг шаарддаг. Хэрэв хөрөнгө хангалттай биш байвал зээл авч, зээлийн хүү, алданги зэргийг төлөх хэрэгтэй байдаг тул санхүүгийн дүн шинжилгээнд дээрх бүхнийг хамруулсны үндсэн дээр ашгийг тооцно.

Нөхцөл байдалд нөлөөлж болзошгүй нийгмийн хүчин зүйлсэд дүгнэлт хийх

Болзошгүй оролцогчдын ямар бизнест сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байгааг эхний үе шатанд тодорхойлно. Үйл ажиллагааг цаашид явуулахын тулд сургалтад хамрагдагчдын сонирхол, хүсэл эрмэлзлээс гадна тэдний бодит боломжийг харгалзан сургалтын хэрэгцээг тодорхойлох хэрэгтэй. Учир нь зарим тохиолдолд ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд тодорхой нэг бизнест сонирхолтой байх боловч бодит боломж нь байхгүй байх тохиолдол байдгийг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй байдал эсвэл яс үндэс, шашин шүтлэгт суурилсан нийгмийн бэрхшээлүүд байдаг бөгөөд энэ нь зарим тохиолдолд тодорхой эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэхэд хязгаарлалт болдог. Дээр дурьдсан бэрхшээлийг (ялангуяа эмэгтэйчүүдийг сургалтад хамруулах болон хөдөлмөр эрхлүүлэх асуудал дээр) даван туулахад гэр бүл, олон нийтийн дэмжлэг ихээхэн ач холбогдолтой гэдгийг анхаарах нь зүйтэй.

- **Нөхцөл байдлын судалгааны загварыг хавсралт 3.5-аас үзнэ үү.**
- **Нөхцөл байдлын судалгааны товч тайлангийн загвар, Бангладешийг хавсралт 3.6-аас үзнэ үү.**
- **Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа, зах зээлийн боломжийн судалгаа болон нөхцөл байдлын судалгааны удирдамжийг хавсралт 3.7-оос үзнэ үү.**

Төлөвлөгдөж буй эдийн засгийн ажиллагаа нь ямар төрлийнх байгаагаас үл хамааран оролцогчийг нь ур чадвартай байлгах арга хэмжээг авах хэрэгтэй.

Өөрөө өөрийгөө цалинжуулах үйл ажиллагааг эхлүүлэх, бичил үйлдвэрлэлийг байгуулах гэж байгаа үйлдвэрлэл эрхлэгч нь тодорхой хэмжээний техник болон үйлдвэрлэлийн ур чадвараас гадна менежментийн мөн бусад шаардлагатай ур чадвар, мэдлэгийг эзэмших хэрэгтэй. Үүнтэй адил цалинтай хөдөлмөрэрхлэлтийг сонирхож байгаа этгээд нь үндсэн ажлын ур чадвар болон үйлдвэрлэлтэй холбогдолтой тодорхой хэмжээний мэдлэгтэй байх шаардлагатай. Сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд шаардагдах ур чадварын хэрэгцээг тодорхойлдог ба үүнд дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ☐ сургалтад хамрагдаж болзошгүй этгээдийн шинэ мэргэжлийн ур чадварт суралцах сонирхолыг тодорхойлох, тухайн ур чадварыг олгох сургалт зохион байгуулж болох эсэх;
- ☐ хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг бий болгох;
- ☐ суралцахаар төлөвлөж буй мэргэжилд тухайн хүний одоогийн байгаа ур чадвар холбогдолтой эсэх;
- ☐ техникийн болон мэргэжлийн сургалтад хамрагдахаар төлөвлөж байгаа эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хэрэгцээнд шинэ бичил үйлдвэрлэл, өөрийгөө цалинжуулах болон бусад хөдөлмөр эрхлэлтийн боломж нийцээгүй байх;
- ☐ үйлдвэрлэл эрхлэх болон үндсэн ажлын ур чадвар манлайлах чанар дутмаг байх;
- ☐ сургалт болон хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн асуудал болон түүнийг хэрхэн шийдвэрлэх;
- ☐ хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-ын халдвар авсан хүмүүс, үндэсний цөөнх зэрэг асуудалд мэдрэмжтэй хандах.

Үе шат 4. Сургалтын хэрэгцээг судлах

Сургалтын хэрэгцээ, ур чадварыг тодорхойлох үйл ажиллагаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нөөц боломж, тэдний бодит боломжийг судалж үзсэний үндсэн дээр хөгжүүлнэ. Сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагааг нь дараах үндсэн гурван зүйл дээр суурилна. Үүнд:

- ☐ зорилго болон өөртөө итгэлтэй байдлыг бий болгох, бусад ажлын үндсэн суурилсан ур чадвар;
- ☐ мэргэжлийн тодорхой техник ур чадвар;
- ☐ үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх ур чадвар.

Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа нь сургалтад хамрагдахаар төлөвлөж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс стандарт загвараар хийгдсэн санал асуулгын дүн болон сургалтын дараа ажлын байраар хангах боломжтой ажил олгогч, хөдөлмөр эрхлэх боломжийг судалж үзэх ёстой. Түүнчлэн хэлний болон бичиг үсгийн чадвар муутай, хөгжлийн бэрхшээлийн улмаас санал асуулгад бүрэн дүүрэн хамрагдах боломжгүй хүмүүсийн асуудлыг зохицуулж, тэдний саналыг бүрэн дүүрэн тусгах талаар арга хэмжээ авч байх нь чухал юм.

→ **Сургалтын хэрэгцээг тодорхойлох асуулгын үлгэрчилсэн загварыг хавсралт 3.8-аас харна уу.**

→ **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох загварыг хавсралт 3.9-өөс харна уу.**

Санамж: Сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаа нь тогтмол явагдаж байх бөгөөд үйлчлүүлэгч, ажил олгогчийн шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Үүний тулд ХЭЗЧДС-ын баг нь сургалтад хамрагдагчид төгссөний дараа зах зээлд гарах болон эдийн засгийн үйл ажиллагаанд хэрэглэж болохуйц ур чадварыг эзэмшүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй бөгөөд ажлын байран дээрх дадлага, давтан сургалт болон ур чадвар дээшлүүлэх сургалтууд үүнд хамрагдаж болох юм.

III.Дагалдах үйл ажиллагаа

Нөхцөл байдлын судалгаа болон сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийгдэж дууссаны дараа ХЭЗЧДС-ын баг нь орон нутгийн зөвлөлтэй тохиролцохын өмнө сургалт болон сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах боломжийн талаар санал солилцсон байх хэрэгтэй. Сургалтын хувьд ХЭЗЧДС-ын баг нь орон нутгийн сургалт зохион байгуулагчидтай ярилцаж, сургалтын зорилго, зохион байгуулалт болон техникийн асуудал, сургалт явуулах, сургагч болон зааварлагчид байгаа эсэх, сургалтыг зохион байгуулах газар гэх мэтийн талаар санал солилцоно. Дээрх асуудлууд дээр эцэслэн шийдвэр гаргасны дараа орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлөөр батлуулж, сургалтын бэлтгэл ажлыг эхэлнэ.

→ **Сургалтын саналын загварыг хавсралт 3.10.-аас үзнэ үү.**

Хавсралт 3.1. Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс

Газар тариалангийн бус цалинтай хөдөлмөр эрхлэлт хомс байгаа гэдгийг бодолцон үзсэний үндсэн дээр энэ бүлэг нь хувираа хөдөлмөр эрхлэх болон бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийн асуудал дээр анхаарлаа хандуулж байгаа бөгөөд зах зээлийн боломжийг судлах үе шат, аргачлал, тухайн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн оролцоог хангах талаар зөвлөх болно.

Үүний тулд хэд хэдэн судалгааг хийх шаардлагатай. Үүнд:

- ☐ орон нутгийн ард иргэдийн ерөнхий дүр зураглалын судалгаа;
- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа;
- ☐ зах зээлийн боломжийн судалгаа;
- ☐ ирээдүйн болон цаашдын боломжийн судалгаа;
- ☐ сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа.

Дээрх судалгаанууд нь оролцогч талуудыг санал солилцох болон холбогдох сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай мэдээллүүдээр хангах болно. Тодруулбал эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тогтоох судалгаа нь дараах зорилготой болно:

- хөдөлмөр эрхлэлт, бизнес болон орлогыг бий болгох боломжийн талаар санал солилцох, дүн шинжилгээ хийх;
- үр шимийг хүртэгчдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох;
- зорилтод үр шимийг хүртэгчдэд хөдөлмөр эрхлэлт, түүнчлэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тайлбарлан таниулах;
- холбогдох сургалтын хөтөлбөрийг боловсруулах.

Болзошгүй эдийн засгийн боломжийг тодорхойлох үйл ажиллагаа нь зорилтод бүлгүүд болон тухайн орон нутгийн ард иргэдийн оролцоог хангах нь чухал. Эмэгтэй болон эрэгтэй оролцогчдоос гадна хэрэглэгч, орон нутгийн үйлдвэрлэгч бөөнөөр худалдаа эрхлэгч, борлуулагч, болзошгүй худалдан авагч, бизнес эрхлэгч, худалдаачин болон түнш байгууллагууд дээрх үйл ажиллагаанд оролцох хэрэгтэй. Дээрх бүлгүүдийн төлөөлөл нь дангаар орон нутгийн ард иргэдийг төлөөлөх боломжтой хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний эрх ашгийг хамгаалах байгууллага болон нийгмээс гадуурхагдсан хүмүүсийн төлөөлөл оролцох нь зүйтэй.

Хэдийгээр ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь орон нутгийн түвшинд тохирох арга хэрэгсэл, аргачлалыг боловсруулсан ч гэсэн өөрийн орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах чиглэл, олон улсын хөдөлмөрийн байгууллагаас боловсруулсан аргачлал, зөвлөмжийг мөн ашиглаж болно.[9]

Үе шат 1.Болзошгүй цалинтай хөдөлмөр эрхлэлтийн хувилбар

- ☐ үйлдвэрлэл болон бизнес эрхлэгчидтэй ярилцаж, цалинтай хөдөлмөр эрхлэлтийн боломж болон тодорхой ажлын орон тоо байгаа эсэхийг тодорхойлох;
- ☐ цалинтай хөдөлмөр эрхлэх ажилчдад тухайн ажлыг товч танилцуулах;
- ☐ ажлын газрын байршил;
- ☐ оролцогчид нь яагаад цалинтай хөдөлмөр эрхлэлтэд хамрагдахыг хүсээд байгаа вэ?

Үе шат 2. Техникийн нөхцөл

- **Байршил**
- ☐ оролцогчийн гэр хүртэлх зай;
- ☐ хэрэглэх тээврийн хэрэгсэл, өртөг болон замд зарцуулах хугацаа

- **Тавигдах шаардлага**
- ☐ оролцогчид тавигдах шаардлага;
- ☐ тухайн үйл ажиллагаанд шаардагдах ур чадвар;
- ☐ хэрэгцээтэй ур чадвартай болохын тулд шаардагдах сургалт;
- ☐ хэрэгцээтэй тоног төхөөрөмж/багаж.

- **Ажилд орох хүсэлтийг ажил олгогчид гаргах үйл ажиллагаа**

Үе шат 3. Менежменттэй холбогдох асуудлууд

- Байгууллагын төрөл

- ☐ төрийн, хувийн эсвэл ТББ;
- ☐ хувийн секторт хамааралтай бол хувиар эрхэлж буй бизнес эсвэл хувьцаат компани;

9. ОУХБ-ын орон нутгийн эдийн засгийн хөгжлийн агентлаг, арга зүй, аргачлал болон ОУХБ-ын орон нутгийн эдийн засгийн хөгжлийг бий болгох чиглэлээр баримтлах чиг хандлага. 2008. Ядуурлын үр дагаварыг тодорхойлох аргачлал, хөдөөгийн хөгжлийн төлөвлөлт гэх мэт.

- ☐ тухайн байгууллагад ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилчдын тоо;
- ☐ хүүхдийн цэцэрлэг, ясли, өдөр өнжүүлэх байгаа эсэх.

Үе шат 4. Санхүү Цалин болон хангамж

- үйлчилгээний журам болон ажилчдын үүрэг.

Үе шат 5. Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлс

- ☐ оролцогчийн тухайн ажилд сонирхолтой байх;
- ☐ сургалтын дараа хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлтэй байх;
- ☐ гэр бүлийн болон олон нийтийн дэмжлэг (ялангуяа эмэгтэйчүүдийн сургалт болон цалинтай хөдөлмөр эрхлэлт);
- ☐ бэрхшээлүүд болон тэдгээрийг арилгахын тулд орон нутгийн ард иргэд болон манлайлагчидтай зөвшилцөх.

Үе шат 6. Эрсдэл

- Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд хамрагдсанаар таньд тулгарч болзошгүй бүхий л эрсдлийн талаар дурьдана уу.

Үе шат 7. Сургалтын дараах дэмжлэг

- Хэрэгцээтэй техник туслалцаа

- ☐ хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл олгох;
- ☐ сургалтад хамрагдагчдыгхамрагдагчдыг цалинтай хөдөлмөр эрхлэх боломжтой холбох;
- ☐ ажлын байран дах зан харьцааны талаарх ойлголт өгөх, ажил олгогч болон ажилчин хоорондын харилцаа;
- ☐ ажилд тавигдах шаардлагатай нийцэхийн тулд ур чадвараа цаашид хөгжүүлэх;
- ☐ эрх, үүргийн талаарх мэдээлэл;
- ☐ ажлын байранд дах дагалдах үйл ажиллагаа.

Хавсралт 3.2. Орон нутгийн судалгаа (үлгэрчилсэн загвар, арга хэрэгсэл)

Суурь судалгаа

Оршил

Орон нутгийн судалгаанд тухайн орон нутгийн ард, олон нийт, эдийн засаг, орлогыг бий болгох шинэ үйл ажиллагаанд хэрэглэгдэж болохуйц эх үүсвэр, одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг өргөтгөх боломж эсвэл нөөц бололцоог ашиглан шинэ бизнес хөгжүүлэх боломж зэргийг хамруулсан байна. Энэ нь эдийн засгийн боломжийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох бөгөөд орон нутгийн ард иргэдийн хурлын хүрээнд яригдах асуудлын товыг тогтооно. Түүнчлэн энэ нь үйл ажиллагаандаа жендерийн асуудалд нааштайгаар хандах чиг хандлага баримталдаг хөтөлбөрийн хувьд тухайн орон нутгийн жендерийн холбогдолтой асуудалд дүн шинжилгээ хийж, уг асуудалд холбогдох нөхцөл байдлыг бодитойгоор дүгнэх боломж олгоно. Ингэснээр жендерийн болон бусад нийгэм, соёлын бэрхшээлүүдийг тодорхойлох бөгөөд эдийн засгийн боломжтой уялдуулан ойлгох нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн энэхүү судалгаа нь тухайн орон нутагт боломжтой байгаа ур чадвар, түүхий эдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болно. Мөн уг судалгаан дээр үндэслэн зорилтод бүлгүүдийн болон орон нутгийн нийгэм-эдийн засагтай холбогдох нэн чухал мэдээллийг (орлогын эх үүсвэр болон түвшин, эрэгтэй болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоход учирч буй бэрхшээл) олж авах боломж бүрдэх бөгөөд энэ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хяналт-шинжилгээний үндэс болж өгөх юм.

1. Судалгааны загварыг хэрэглэх удирдамж

Орон нутгийн судалгааны загвар нь дараах мэдээллийг цуглуулахад зориулагдана. Үүнд:

- **орон нутгийн дүр зураг** – орон нутгийн талаарх ерөнхий мэдээлэл;
- **жендерийн байдлын дүн шинжилгээ** – эмэгтэйчүүдийн сургалт болон хөдөлмөр эрхлэлтэд оролцоход учирч буй бэрхшээл;
- **түүхий эд болон бусад бүтээгдэхүүний орц** – бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд болон тухайн орон нутгаас авч хэрэглэж болохуйц бусад орц;
- **одоогийн орлогын эх үүсвэр -** орон нутгийн эдийн засаг, эмэгтэй болон эрэгтэйчүүд амьдрахын төлөө юу хийдэг, тэдгээрийн ур чадварын өнөөгийн нөхцөл байдал;
- **ажлын байр бий болгох боломж** –түүхий эдийг шинэ болон өргөтгөсөн үйлдвэрлэлд хэрэглэх, ур чадвар, түүнчлэн ур чадвартай ажиллах хүч шаардлагатай байгаа үйлдвэр болон төслүүдийн хөгжил.

Мэдээлэл цуглуулах

Мэдээлэл цуглуулах гол арга нь бүлгийн ярилцлага бөгөөд үүнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь чухал. Ярилцлагыг орон нутгийн ХЭЗЧДС-ын баг зохион байгуулах бөгөөд орон нутгийн ХЭЗЧДС-ын зохицуулагч, нийгэм эдийн засгийн ажилтан/ жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн байвал сайн. Ярилцлагыг судалгааны загварын дагуу явуулна. Ярилцлагад орж байгаа бүлгийн гишүүд аливаа асуудлыг нухацтайгаар авч хэлэлцэн, аль болохоор үнэн зөв, бодитой тайлбар хариулт өгөхийг хичээх ёстой. Уулзалтыг зохион байгуулж буй ХЭЗЧДС-ын багийн ажилтан нь уулзалтад оролцож буй багийн гишүүд тодорхой асуудлаар санал нэгдэж эцсийн шийдвэрээ гаргасан тохиолдолд загварад тэмдэглэл хийнэ. Уулзалтыг түргэвчлүүлэхийн тулд оролцогчдийг дор хаяж таван хүнтэй жижиг баг болгож хуваан тус тусад нь сэдэв өгч хэлэлцүүлнэ. Дээр дурьдсан хуваагдсан багуудын ярилцлагыг орон нутгийн ХЭЗЧДС-ын багийн гишүүд (зохицуулагч, нийгэм эдийн засгийн ажилтан, жендерийн асуудал хариуцсан ажилтан гэх мэт) тус тус зохион байгуулж тэмдэглэл хөтөлнө. Гол мэдээлэгчдийн өгсөн мэдээллээс гадна ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зохицуулагч, нийгэм эдийн засгийн ажилтан, жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн, зорилтод бүлгүүдэд хамаарах эрэгтэйчүүд эмэгтэйчүүд ярилцаж, анхдагч эх сурвалжийн мэдээллийг зохих журмын дагуу тэмдэглэж авсан байна. Тухайн орон нутгийн оршин суугчид, ард иргэдийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн ойлгоогүйгээс болж, хөтөлбөрийн төлөвлөлт буруу хийгдэх магадлалтай.

Багийн ярилцлага

Уг ярилцлагын багт орон нутгийн албан болон албан бус удирдлага оролцох бөгөөд эдгээр нь тухайн орон нутгийн нөхцөл байдал болон эдийн засгийн талаарх тодорхой мэдээлэл өгөх боломжтой. Түүнчлэн ярилцлаганд орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулахуйц агентлаг, байгууллагын төлөөллийг оруулах нь зүйтэй. Ярилцлагын багийн гишүүд нь 5-15 хүнтэй байхад хангалттай байх бөгөөд хэрэв оролцогчдын тоо хэтэрхий их байвал бол асуудлыг хэлэлцэх

явцыг хүндрүүлэх болно. Ярилцлагын багт дараах төлөөллийг оролцуулж болох юм. Үүнд:

- ☐ орон нутгийн удирдлага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл;
- ☐ үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл (гар урлалын нийгэмлэг гэх мэт);
- ☐ эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад нийгмийн төлөөллийн эрх ашгийг хамгаалах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцогч орон нутгийн ТББ-ын төлөөлөл;
- ☐ орон нутгийн хэмжээнд сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төлөөлөл;
- ☐ орон нутгийн нэр хүнд бүхий иргэд;
- ☐ орон нутгийн үйлдвэрлэгчид;
- ☐ эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөл.

Нэгдүгээр хэсэг. Орон нутгийн талаарх ерөнхий мэдээлэл

А. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамрагдах хүн ам

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх газрыг сонгоход тухайн орон нутгийн хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажилгүй байгаа нь бодит чадвараасаа доогуур ажил эрэлж байгаа иргэдийн хувиас хамаарна. Хэрэв ажилгүйчүүд эсвэл бодит чадвараас доогуур ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн тоо нь эрэгтэйчүүдээс их байвал зорилтод бүлэг дэх эмэгтэйчүүдэд илүү анхаарах арга хэмжээ авах нь зүйтэй.

Б. Газар зүйн байршил

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутагт хамаарах нөлөө бүхий хот, тосгон, дүрэг, сумын талаарх мэдээлэл нь тухайн орон нутгийн нөөцийн эх үүсвэр болон бүтээгдэхүүний зах зээлийн талаарх ерөнхий мэдээллийг олгоно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутаг нээлттэй (дэд бүтэц, зам тээвэр, гэх мэт) эсвэл хязгаарлагдмал байх нь бүтээгдэхүүний хүртээмж, үнэ, өртөг болон хадгалах хугацаанд нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй.

Газар, усны нөөцийн хүртээмжтэй байдал нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх эдийн засгийн үйл ажиллагааны түүхий эд, нөөцийн эх үүсвэр гэж тооцогдоно.

В. Цаг агаар, уур амьсгал

Тухайн орон нутгийн цаг агаарын нөхцөл байдал нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих хөдөөгийн ард иргэдийн эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хүчин зүйл гэж тооцогдоно. Учир нь хүмүүсийн хэзээ худалдаж авах, хэзээ нөөцлөх (тухайлбал, үрслүүлэх, хураах улирал болон загасчлах хугацаа гэх мэт) зэрэг нь байгаль, цаг уурааас хамаарна. Түүнчлэн цаг уурын нөхцөл байдал нь хөтөлбөрийн хүртээмжтэй байдалд нөлөөлж болно (тухайлбал, зарим улиралд замын нөхцөл байдалд маш хүндрэлтэй болдог).

Г. Боловсрол, сургалтын байгууллагууд

Тухайн орон нутагт боловсрол, мэргэшил эзэмшүүлэх болон бусад хэлбэрийн сургалтын байгууллага байх нь сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах зориулалтын байгууллага, байраар хангах боломжийн зэрэгцээ тухайн орон нутгийн иргэдийн боловсрол, ур чадварын ерөнхий түвшинг харуулдаг. Гэхдээ боловсролын түвшингийн тухай нэмэлт мэдээллийг тусад нь дахиж цуглуулах хэрэгтэй[10]. Учир нь сургууль эсвэл сургалтын байгууллага байна гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд, эмэгтэй, эрэгтэйчүүдт эдгээр байгууллагуудаар жигд, хүртээмжтэй үйлчлэх боломжтой гэсэн үг биш юм.

Д. Жижиг/албан бус үйл ажиллагааны зээлийн эх сурвалж[11]

Бичил үйлдвэрлэлийн хувьд тулгардаг хамгийн том бэрхшээлүүдийн нэг капитал буюу санхүүжилт олох асуудал юм. Урьдчилсан тооцоо, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, төсөвгүйгээр бичил зээл олгодог санхүүгийн байгууллага цөөн байдаг.

Зээлийн эх үүсвэр олгогч нь тухайн орлогыг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлэх эсэх талаарх мэдээллийг өгөх болно. Хэрэв тухайн үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилт олдохгүй бол ХЭЗЧДС-ын хөтөлбөр үйл ажиллагааг эхлүүлэх анхны санхүүжилтийг өөрийн эргэлтийн нөөц, орон нутгийн ард иргэдийн сангаас олгох боломжтой юм. Жижиг үйлдэрлэлд олгох зээлийг дараах эх сурвалжуудаас гаргах боломжтой. Үүнд:

- ☐ тусгай зээлийн хөтөлбөр бүхий арилжааны банк;
- ☐ төрийн байгууллага, хөдөөгийн болон хөгжлийн банк;
- ☐ бичил санхүүгийн байгууллага;
- ☐ төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хөтөлбөрийг санхүүжүүлэгч сан, санхүүжилт, зээл олгох чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага;
- ☐ хадгаламж, зээлийн хоршоод, нийгэмлэгүүд (зээлийн холбоод, санхүүгийн хоршоо болон бусад хэлбэрийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд);
- ☐ гишүүддээ үйлчилдэг нөхөрлөл, нийгэмлэгүүд;
- ☐ хувиараа эрхлэх аж ахуй, өөрийгөө цалинжуулах үйл ажиллагааг дэмжигч нийгмийн, олон нийтийн байгууллагууд (Ротару болон Лион клубууд);

10 Дээрх мэдээлэл нь сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны явцад гарч ирнэ.

11 Бичил үйлдвэрлэлийн боломжит зээлийн эх үүсвэрийн талаарх мэдээллийг сургалтын дараах дэмжлэг гэсэн зургаадугаар ботийн хавсралт 6.2. Бичил санхүүгийн хүчин чадлыг тогтоох -оос авна уу.

албан бус зээлийн эх сурвалжууд (найз нөхөд болон хамаатан саднаасаа зээл авах, хувиараа зээл олгогч болон бараа бүтээгдэхүүн тоног төхөөрөмжийг зээлээр авах гэх мэт).

Е. Одоо явагдаж байгаа үйл ажиллагаанууд

Тухайн орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь хөдөлмөр эрхлэлтэд шууд нөлөөлдөг болно. Хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь усны нөөцөөс хамааран хязгаарлагдмал байдаг. Цахилгаан эрчим хүчгүй байх нь үйлдвэрлэлийг гар аргаар явуулах тоног төхөөрөмжийг хэрэглэхэд хүргэдэг. Харин цахилгаан эрчим хүчтэй газар цахилгаан хэрэгслийн засварчны шаардлага гарч ажлын байр бий болно. Тээвэрлэлт нь түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг хэрхэн хялбар аргаар шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хоёрдугаар хэсэг. Жендерийн дүн шинжилгээ

Орон нутгийн талаарх мөн бусад судалгааны хүрээнд жендерийн асуудалд дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Учир нь тухайн орон нутагт зонхилж буй жендерийн асуудлаарх чиг хандлагад анхаарах нь жендерийн үүрэг оролцоо болон бусад нийгэм, соёлын харилцаанд учирч буй бэрхшээлийг арилгах, ингэснээр эдийн засгийн боломжийг зүй зохистой, бүрэн ашиглах нөхцлийг бүрдүүлдэг байна. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг болон хэрэгжүүлэгч түншүүд нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, уг асуудалд холбогдо бусад хүчин зүйлсийг нарийвчлан мэдэж асвны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх арга замыг олох боломжтой юм. Тухайлбал, сургалтад хамрах асуудал дээр ялгаварлан гадуурхаж хандах нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд саад болно гэдгийг байнга анхаарах хэрэгтэй.

Эмэгтэйчүүдийн тодорхой хэрэгцээнд хандсан үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн оролцогчдын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, ДОХ-ын халдвар авсан эмэгтэйчүүд, тухайн орон нутгийн хэмжээнд хүн амын хувьд яс үндэс, шашин шүтлэгээрээ ялгардаг, уугуул иргэдийн, цөөнх иргэдийн төлөөлөл болох эмэгтэйчүүдийг оролцуулж байх нь зүйтэй. Учир нь эдгээр эмэгтэйчүүд нь хөдөлмөрийн зах зээлд гарахын тулд олон давхар бэрхшээлүүдтэй тулгарч байдаг байна. Орон нутгийн судалгааны асуулгын тодорхой хэсгүүд нь жендерийн үндсэн дээр ялгаварлан гадуурхагдаж байгаа хүмүүсийн талаарх мэдээллийг цуглуулахаар тооцож хийгдсэн байдаг. Иймээс жендерийн асуудалд холбогдох энэ бүлэг нь эмэгтэйчүүдийн сургалт, хөдөлмөр эрхлэлтэд саад болж буй асуудлуудад тусгайлан анхаарах болно. Жендерийн асуудлуудын жишээнээс дор дурьдах болно.[12] Үүнд:

- боловсрол болон сургалтын хүртээмж нь охидууд, эмэгтэйчүүдийн хувьд бага, тэдгээрийн бичиг үсгийн эзэмшсэн байдал, суурь боловсролын түвшин доогуур байдгаас үүдэн техникийн болон мэргэжлийн ур чадвар эзэмших боломж хомс байдаг;
- сургалтын байгууллагууд ихэвчлэн жендерийн асуудалд мэдрэмжгүй хандаж, ядуу эмэгтэйчүүдийн хэрэгцээг харгалзаагүй хөдөлмөр эрхлэлтийн сургалтуудыг зохион байгуулдаг;
- эмэгтэйчүүд нь гэр орны ажил болон хүүхэд асрах асуудалд байнга анхаарч байх хэрэгцээтэй тул тэдгээрийн сургалт болон эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулах цаг нь хязгаарлагдмал байдаг;
- эмэгтэйчүүд гэр орны ажил, хүүхэд асрамжлах ажилд эрэгтэйчүүд тусалдаггүй, эмэгтэйчүүд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд зав зай муутайгаас үүдэн гэр орны ажлыг ихэвчлэн охидууд хийдэг бөгөөд энэ нь тэдний суралцах, боловсролтой болох боломжийг эрсдэлд оруулдаг;
- хөдөлмөр эрхлэлтийн хувьд эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалтад өртөх магадлал өндөр байдаг (гэр бүлийн байдал, жирэмслэлт, жирэмслэлтийн дараах үе, хүйс заах, илүү цагаар ажиллах);
- ихэвчлэн эмэгтэйчүүд доогуур цалин авдаг;
- газар тариалан эрхлэх, газар өмчлөх асуудалд эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалт их байдаг;
- олон эмэгтэйчүүд ба охидууд гэр бүл, нөхөр, хадам талын шахалтанд орж үйлдвэрлэл эрхлэхээс татгалзахад хүрдэг. Учир нь тэд эмэгтэй хүн тогтсон заншлын дагуу зөвхөн гэрийн ажил хийж байх ёстой гэсэн ойлголттой байдаг;
- сургалтын болон ажлын байранд хамаарах хүүхэд асрамжийн газрууд дутагдалтай байдаг.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн оролцоход саад болж буй бэрхшээлүүдийг давахад чиглэгдсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хандлага нь:

- дээрх асуудалтай холбогдуулан хамгийн бага бэрхшээл учирахуйц эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлож, сонгох;
- сургалтын хөтөлбөрт жендерт суурилсан бэрхшээлүүдийг багасгах талаар нэмэлт бүрэлдэхүүн хэсгийг оруулах, тухайлбал, эмэгтэйчүүдийг өөртөө итгэлтэй болгохын зэрэгцээ нийгмийн эмэгтэйчүүдэд хандах хандлагыг өөрчлөх.

Мэдээж дээр дурьдсан хоёр нөхцлийн хоёр дах нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үндсэн чиг зорилготой нийцэж байгаа болно.

12 Дэлгэрэнгүй мэдээллийг долдугаар ботийн хавсралт 2.*Жендерийн асуудлын жишээ болон үүнээс үүдэлтэй боловсрол олгоход тулгарах бэрхшээлүүд, бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон цалинтай хөдөлмөрэрхлэлт*-оос харна уу.

Гуравдугаар хэсэг. Түүхий эд/ үйлдвэрлэлийн орц

Эдийн засгийн үйл ажиллагаа нь түүхий эд болон бусад шаардагдах орц хомсдмол байгаа тохиолдолд хөгжих боломжгүй юм. Харин түүхий эдийн нийлүүлэлт их, үйлдвэрлэлд хэрэглэж байгаа хүн нь цөөн байгаа тохиодолд үйлдвэрлэлийн хэмжээ болон хүний тоог нэмдэг бөгөөд ингэх нь ихэвчлэн түүхий эдийн хэрэглээний ашиг бага болгодог.

Түүхий эд болон үйлдвэрлэлийн бусад орц нь гаднаас нийлүүлэгддэг бол энэ нь тухайн түүхий эд, орцыг орон нутагтаа боломжит материалаар орлуулах боломжийг эрэлхийлэхэд хүргэдэг. Тухайлбал, бордоо нь үйлдвэрлэлийн аргаар боловсруулдаг бүтээгдэхүүн. Гэвч энэ нь газар тариалан эрхлэгчдийн хувьд орц болдог. Эсвэл малын тэжээл нь үйлдвэрлэгчийн хувьд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн байхад, мал маллаж буй хүмүүсийн хувьд энэ нь орц байх болно.

Дөрөвдүгээр хэсэг. Бодит нөөц болон орлогын түвшин

Орлогын эх үүсвэрийг тодорхойлох тал дээр цуглуулсан мэдээлэл нь тухайн орон нутагт байгаа хөдөлмөр эрхлэлт харуулна. Газар тариалангийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь үйлдвэрлэх хэрэгцээтэй, болзошгүй түүхий эдийн талаарх мэдээллийг агуулна. Үйл ажиллагаа болон зонхилох бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь чухам ямар төрлийн ур чадвар байгаа, мөн оршин суугчид нь ямар төрлийн аж ахуй эрхэлж байгааг илэрхийлнэ. Эдгээр мэдээллүүд нь тухайн орон нутгийн хэмжээнд чухам ямар чиглэлийн хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны боломж байгааг харуулахын зэрэгцээ ямар ур чадварыг сайжруулах, ямар төрлийн үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэх нь зүйтэй вэ гэдгийг тодорхойлоход туслана.

Үйлдвэр (дор хаяж 5-10 ажилчидтай үйлдвэр) нь ихэнх тохиолдолд цалинтай хөдөлмөр эрхлэлтийн хамгийн боломжтой хувилбар байдаг. Үйлдвэрүүдэд нь мөн ур чадварыг дээшлүүлэх, ур чадвартай ажилчдыг авах шаардлага, хэрэгцээ ч байдаг. Зарим тохиолдолд үйлдвэрүүдийг мэргэжлийн дадлага хийх сургалтын бааз болгон ашиглаж болно.

Орлогын түвшний талаарх мэдээлэл нь амар олдохгүй байж болно. Гэхдээ орлогын түвшин, жендерээр ялгарварлан гадуурхагдсан, эдийн засгийн үйл ажиллагааны төрлийн талаарх мэдээллүүд нь ХЭЗЧДС-ын үйл ажиллагаанд хяналт хийхэд хамгийн чухал материал юм. Эдгээр нь зорилтод бүлгүүдийн сургалтын өмнөх болон дараах орлогыг харьцуулахад туслахын зэрэгцээ эмэгтэйчүүд,эрэгтэйчүүдийн хөдөлмөр хэрхэн үнэлэгдэж байгаа талаар мэдээлж, дүгнэлт хийхэд тусална.

Тавдугаар хэсэг. Хөдөлмөр эрхлэлтийг бий болгох боломж

Энэ хэсэг нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа, зах зээлийн боломжийн талаарх судалгаа, нөхцөл байдлын судалгааны явцад цуглуулсан мэдээлэлтэй харьцуулахад хэрэгцээтэй үндсэн мэдээллийг өгнө. Дээрх мэдээллийг үйлдвэрлэгч, худалдаачин, оршин суугч болон бусад гол мэдээлэгчидтэй уулзаж баталгаажуулна.

А. Хэрэглэгддэггүй/илүүдэл түүхий эдийг ашиглах

Гуравдугаар хэсэгт тухайн орон нутагт боломжтой, хэрэглэгддэггүй болон илүүдэл түүхий эдийн талаар дурьдсан. Энэ хэсэг нь дээр дурьдсан түүхий эдийг ашиглан үйлдвэрлэж болох бүтээгдэхүүнийг тодорхойлохыг оролдоно.

Б. Орон нутаг болон тухайн ойр орчинд хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөрүүд

Хөгжлийн зарим төрлийн төслүүд нь ур чадвар бүхий ажилчдыг шаарддаг. Одоо буй ажлын жагсаалт нь тухайн орон нутагт шаардлагатай гэж үзэгдэх ур чадвар байгаа эсэхийг тодорхойлж өгөх боломжтой юм.

Хэрэв хөтөлбөрийн шаардлагыг хангахуйц ур чадвартай ажилчид тухайн орон нутагт байхгүй бол хэрэгжиж эхлэж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа эсвэл, төлөвлөлтийн үе шатанд байгаа хөтөлбөрийн хүрээнд эрэгтэй болон эмэгтэйчүүдийг сургах боломжтой юм.

Хувираа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлэх зорилго бүхий хөгжлийн бусад төслүүд нь ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй хамтран ажиллах боломжтой байдаг. Эдгээр төслүүд нь дэмжлэг туслалцааны эх үүсвэр (сургалтыг санхүүжүүлэх болон ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдэд зээл олгох гэх мэт) болох магадлалтай. Мөн анхаарал хандуулбал зохистой нэг зүйл бол төлөвлөсөн төслүүдийн хэрэгжилтэнд гарч болзошгүй сөрөг үр дагаврууды тооцох асуудал юм. Ихэнх тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нь эдийн засгийн зорилтууд болон эерэг үр дагаврыг тооцоолж төслийг боловсруулдаг боловч уг төслийн хэрэгжилтээс хамааран бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг төдийлөн тооцоолдоггүй байна. Нэг жишээ дурьдахад, цагаан будааны талбайн усжуулалтын системийг сайжруулах төсөл амжилттай хэрэгжснээр ургацын хэмжээ нэмэгдсэн боловч энэ нь урьдчилан тооцоолоогүй сөрөг үр дагаварт хүргэсэн байна. Учир нь агаарын болон хөрсний чийгшилтээс болон тухайн орон нутагт шумуулын тоо эрс ихэссэн бөгөөд энэ нь малери зэрэг шумуулаар дамжин тархдаг цусны халдварт өвчнийг орон нутгийн оршин суугчдын дунд хурдацтайгаар тархахад нөлөөлсөн байна. Энэ нь сөрөг үр дагаврын нэг хэлбэр юм. Харин үүний эсрэг тусгай зориулалтын тос, шавьжны хор болон шумуулаас хамгаалах торыг орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэх боломжтой юм.

В. Үйлдвэрүүд

Энэ хэсэгт орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдэд шаардлагатай ажилчдын (ур чадвар бүхий) хэрэгцээний талаарх судалгааг гаргасан байна. Хэрэв боломжтой бол тухайн үйлдвэрүүдэд яг ямар төрлийн ур чадвартай ажилчид хэрэгтэй байгааг нарийвчлан тодорхойлно.

Г. Шинэ эдийн засгийн үйл ажиллагаанууд

Шинээр эдийн засгийн үйл ажиллагаа бий болгохдоо орон нутгийн хэмжээнд байгаа нөөцийг ашиглахыг урьтал болгоно. Ерөнхийдөө тухайн нөөц нь ойр байгаа учир, тэдгээрийг гаднаас авч ирснээс өртөг хямд, хялбар байх болно. Гэхдээ зарим тохиолдолд тухайн орон нутгийн түүхий эд багасаж байгаа тохиолдолд уг шаардлагатай түүхий эдийг гаднаас авч бизнес эрхлэх нь ашигтай байж болох юм. Зарим газар гаднаас импортолсон түүхий эд дээр суурилсан эдийн засгийн үйл ажиллагаа нь илүү ашигтай, ирээдүйг харсан чиг хандлагтай байх ч тохиолдол бий. Энэ нь түүхий эдийн чанар эсвэл бүтээгдэхүүн бий болгох шаардлагатай бусад орцын үнийн зөрүүгээс хамаарах боломжтой байдаг.

Нэгэнт тухайн бүтээгдэхүүний зах зээл нь байгаа тохиолдолд, уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд болон бусад орц орон нутагт хомсдолтой байна гэдэг нь төдийлөн том асуудал биш байж болох юм. Учир нь үйл ажиллагаа жигдрэх явцад түүхий эд болон орцыг байнга найдвартай хангах тогтолцоо бий болдог байна. Сумын газрын зах болон хотын зах хоёрын гол ялгаа нь чанарын үзүүлэлт байж болох юм. Учир нь хотын хувьд хэрэглэгчийн шаардлага өндөр байхтай хамааран бүтээгдэхүүний чанарын түвшин сумынхаас илүү өндөр байдаг.

Орон нутгийн нөхцөл байдлын судалгааны загвар

Хэрэгжих газар/орон нутаг .....

Дүүрэг/сум.....

Аймаг/ нийслэл .....

Нэгдүгээр хэсэг. Орон нутгийн ерөнхий дүр зураг

А. Хүн ам

Нийт хүн ам ..... **2, Өрхийн тоо** .....

	Эрэгтэй	Эмэгтэй
Нийт хөдөлмөр эрхлэх хүн ам (15-65)	.....	.....
Тэдгээргийн дундаас залучууд (15-24)	.....	.....
Бодит бололцооноосоо доогуур ажил эрхэлдэг/ажилгүй	.....	.....
Тэдгээрээс залуучууд (15-24).....	.....	.....
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс.....	.....	.....
Бусад холбогдох бүлгүүд	.....	.....

Б. Газар зүйн онцлог

Тухайн хөтөлбөр хэрэгжиж буй газарт нөлөө бүхий ойролцоох хот/аймгийн төв	**Зай (км)**
.....	.....
.....	.....
.....	.....
Хөтөлбөр хэрэгжиж буй газрын орйолцоох тосгон/сум	**Зай/км**
.....	.....
.....	.....
.....	.....

Оройлцоох сууринГаас хөтөлбөр хэрэгжиж буй газарт хүрэх боломж (таарах хариултыг сонго)

☐ замаар /төрлийг нь бичнэ үү ....

☐ төмөр замаар ☐ усан замаар (голоор) ☐ бусад /тодорхой бичнэ үү. .....

Газар/ усны нөөц **тайлбар**

☐ гол/ цутгал .....

☐ нуур/ далай .....

☐ хиймэл нуур .....

☐ хөдөө аж ахуйн эдэлбэр газар .....

☐ бэлчээр .....

☐ уурхай .....

☐ ой .....

Газрын ерөнхий төрх

☐ тал ☐ өндөрлөг ☐ уулархаг

В. Уур амьсгал

Улирал	Үргэлжлэх хугацаа
а) чийглэг	.....
б) хуурай	.....

Г. Боловсролын байгууллагууд

Тоо	Төрөл	Хөтөлбөр хэрэгжиж буй газар хүртэлх зай	Хүүхдийн тоо		Төгсөгчдийн тоо	
			Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
.....	Бэлтгэл сургууль	.....	.....	.....	.....	.....
.....	Бага сургууль	.....	.....	.....	.....	.....
.....	Дунд сургууль	.....	.....	.....	.....	.....
.....	Мэргэжлийн сургууль	.....	.....	.....	.....	.....
.....	Коллеж	.....	.....	.....	.....	.....
.....	*.....	.....	.....	.....	.....	.....
.....	*.....	.....	.....	.....	.....	.....
.....	*.....	.....	.....	.....	.....	.....

*Бусад: тодорхой бичих

Д. Жижиг/ албан бус үйл ажиллагаанд зээл олгох эх үүсвэр

Орон нутагт

Нэр	Төрөл *	Байршил	Тайлбар
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

Орон нутгаас гадна

Нэр	Төрөл *	Байршил	Тайлбар
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

Дараах төрлүүд байж болно:

- Тусгай зээлийн хөтөлбөр бүхий арилжааны банк;
- Төрийн байгууллага, хөдөөгийн эсвэл хөгжлийг дэмжих банк;
- Бичил санхүүгийн байгууллага;
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хөтөлбөрийг санхүүжүүлэгч сан, санхүүжилт, зээл олгох чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг ТББ;
- Хадгаламж, зээлийн хоршоод, нийгэмлэгүүд (зээлийн холбоод, санхүүгийн хоршоо болон бусад хэлбэрийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд);
- Гишүүддээ үйлчилдэг нөхөрлөл, нийгэмлэгүүд;
- Хувираа эрхлэх аж ахуй, өөрийгөө цалинжуулах үйл ажиллагааг дэмжигч нийгэм, олон нийтийн байгууллагууд (Ротару болон Лион клубууд);
- Албан бус зээлийн эх сурвалжууд (найз нөхөд болон хамаатан саднаасаа зээл авах, хувираа зээл олгогч болон бараа бүтээгдэхүүн тоног төхөөрөмжийг зээлээр авах гэх мэт).

Е.боломжит үйлчилгээнүүд

Ахуйн үйлчилгээ	Тайлбар
Ус	
а) Ахуйн хэрэгцээ	.....
б). Усалгаа	.....
Цахилгаан эрчим хүч	.....
Тээвэр	.....

Ё. Жижиг үйл ажиллагааг дэмжих эдийн засгийн болон нийгмийн байгууллагууд

.....

.....

.....

.....

Хоёрдугаар хэсэг. Жендерийн дүн шинжилгээ

Сургалт болон эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг эмэгтэйчүүдэд учирдаг түгээмэл бэрхшээлүүд	Үнэлгээ			
	Өндөр	Дунд	Доогуур	Хариулах боломжгүй
Бичиг үсэг болон суурь боловсролын доогуур мэдлэг	☐	☐	☐	☐
Техникийн болон ур чадварын мэдлэгийн хомсдол	☐	☐	☐	☐
Сургалтын байгууллагуудын жендерийн асуудалд мэдрэмжгүй хандах	☐	☐	☐	☐
Хүүхэд харах	☐	☐	☐	☐

Сургалтын газруудад хүүхэд саатуулах газар байхгүй	☐	☐	☐	☐
Гэрийн ажил их байдгийн улмаас сургалтад оролцох эсвэл эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зав муутай	☐	☐	☐	☐
Гэрийн ажлын ачааллыг нөхөр нь хуваалцдаггүй	☐	☐	☐	☐
Нөхөртөө өрхийн гол орлогыг бүрдүүлэхэд тусладаг	☐	☐	☐	☐
Уламжлалт эдийн засгийн үйл ажиллагаанууд нь эмэгтэй хүнд ашиг олгодоггүй	☐	☐	☐	☐
Эмэгтэйчүүдийг цалинтай хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхдаг	☐	☐	☐	☐
Ижил төрлийн ажлыг үнэлгээ багатайгаар хийлгэдэг	☐	☐	☐	☐
Ажил дээр хүүхэд саатуулах газар байхгүй	☐	☐	☐	☐
Эмэгтэйчүүд газар эзэмшдэггүй	☐	☐	☐	☐
Үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай сэтгэл зүйн бэлтгэлгүй	☐	☐	☐	☐
Гэр бүл, нөхөр болон хадмууд гэр бүлийн хувьд гүйцэтгэдэг уламжлалт үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэхийг шаарддаг.	☐	☐	☐	☐

Гуравдугаар хэсэг. Түүхий эд болон бүтээгдэхүүний орц

Шинэ бизнес эрхлэхэд боломжтой түүхий эдийн хэмжээ/бүтээгдэхүүний орц

(үнэлгээ өгөх оноо :1-хомс, 2-хүрэлцэхүйц, 3-хангалттай, 4-илүүдэлтэй)

Хөдөө аж ахуйн орц

1. Газар тариалангийн бүтээгдэхүү	**Оноо**	**Тайлбар**
Газар	.....	.....
Бордоо	.....	.....
Үр	.....	.....
Багаж	.....	.....
Техник	.....	.....
*	.....	.....
2. Мал аж ахуй	**Оноо**	**Тайлбар**
Мал	.....	.....
Төл мал	.....	.....
Малын тэжээл	.....	.....
Мал эмнэлэг	.....	.....
Хашаа хороо	.....	.....
*	.....	.....
3. Загасчлал	**Оноо**	**Тайлбар**
Завь	.....	.....
Загасны нөөц	.....	.....
Тор	.....	.....
Хөдөлгүүр	.....	.....
*	.....	.....

Хөдөө аж ахуйн орц

4. Ойн аж ахуй	**Оноо**	**Тайлбар**
Зөөлөн мод	.....	.....
Хатуу мод	.....	.....
*	.....	.....

Аж ахуйн бус үйл ажиллагаа

5. Хүнсний үйлдвэрлэл	**Оноо**	**Тайлбар**
Цех /тээрэм гэх мэт	.....	.....
Зоорь/хөргөгч	.....	.....
Багаж	.....	.....
Боловсруулалт хийх материал	.....	.....
*	.....	.....

6. Гар урлал	**Оноо**	**Тайлбар**
Түүхий эд	.....	.....
Багаж	.....	.....
Дэлгүүр	.....	.....
*	.....	.....

7. Оёдол	**Оноо**	**Тайлбар**
Бөс даавуу	.....	.....
Багаж	.....	.....
Дэлгүүр	.....	.....
*	.....	.....

8. Уурхай	**Оноо**	**Тайлбар**
Ашигт малтмал	.....	.....
Багаж	.....	.....
Тоног төхөөрөмж (аюулгүйн тоног төхөөрөмжийг оролцуулна.)	.....	
Хувцас	.....	.....
*	.....	.....

9. Үйлчилгээ.	**Оноо**	**Тайлбар**
Засварын цех	.....	.....
Барилга	.....	.....
*	.....	.....

10. Борлуулалт.	**Оноо**	**Тайлбар**
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

10. Борлуулалт.	Оноо	Тайлбар
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

11. Бусад: аялал жуулчлал	Оноо	Тайлбар
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

Үйлдвэр

12. Хөтөлбөр хэрэгжиж буй газарт	Оноо	Тайлбар
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

Дөрөвдүгээр хэсэг. Одоо байгаа орлогын эх үүсвэрүүд

Энэ жагсаалт нь орон нутагт байгаа орлогын эх үүсвэрүүдийг багтаасан байна. Энэ нь зөвхөн зааварчилгаа өгөх зориулалттай. Хүснэгтэд буй зай бүрийг бөглөх шаардлагагүй. Тухайн ажлыг орон нутгийн хэмжээнд хийж байгаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн ойролцоо тоо, тэдгээргийн жилийн цалингийн дундаж, (*)-бусад(тодорхой бичнэ үү).

Үйл ажиллагаа	Тухайн үйл ажиллагаанд зонхилох үүрэг гүйцэтгэх				Тухайн үйл ажиллагаанд зонхилох бус үүрэг гүйцэтгэх			
	Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого
1. Газар тариалан								
Тариа	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Ногоо	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Жимс жимсгэнэ	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
2. Мал аж ахуй								
Үхэр	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Хонь	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Ямаа	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Гахай	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Тахиа	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Туулай	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
3. Загасчлал								
Цэнгэг усны загас	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
4. Ойн бүтээгдэхүүн								
Түлээ	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Модны нгүүрс	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Жимс	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Мөөг	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

АЖ АХУЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА

5. Хүнсний үйлдвэрлэл								
Мах	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Загас	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Чихэр/амттан	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Нарийн боов	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Жимсний.ундаа.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
6. Гар урлал								
Мод/ хулс	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Чулуу	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Арьс/савхин эдлэл	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Резин	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Металл	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Үнэт металл	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Төмөр	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Лааз	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Бусад	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

7. Хувцас								
Эсгэх	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Оёх	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Захиалга засвар	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
8. Уурхай								
Элс	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Хар чулуу	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Шавар	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
9. Үйлчилгээ								
Дэлгүүр	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Тээвэр	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
Барилга	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
10. Бусад								
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Орон нутгийн иргэдэд ажил олгогч үйлдвэрүүд болон ажилчдын сарын дундаж цалин

Үйл ажиллагаа	Ур чадварлаг ажилчид				Ур чадварлаг ажилчид			
	Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого	Тоо	Жилийн орлого
11. Хөтөлбөрийн үйл ажиллагаа явуулж буй газарт								
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
12. Ойр орчинд/оршин суугчид гэртээ ирэх боломжтой								
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
*	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

13. Бусад /бүс нутгийн төв, аймагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрт

* .....
* .....
* .....
* .....

Тавдугаар хэсэг. Ажлын байр бий болгох

А. Хэрэглэгддэггүй/илүүдэл орон нутгийн түүхий эдийн ашиглах

Түүхий эд	Боломжит бүтээгдэхүүн
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

Б. Орон нутаг дах болон ойр орчинд хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөр

(Үе шатыг дараах аргаар тэмдэглэнэ үү: О-одоо, У-удахгүй, Т-төлөвлөгдөж байгаа)

Агентлаг /төсөл	Хэрэгжиж буй шат	Шаардлагатай ажлын хүч
1.	.....	.....
2.	.....	.....
3.	.....	.....
4.	.....	.....
5.	.....	.....
6.	.....	.....

В. Ажилчид хайж буй үйлдвэрүүд

(Үе шатыг дараах аргаар тэмдэглэнэ үү: О-одоо, У-удахгүй, Т-төлөвлөгдөж байгаа)

Үйлдвэрийн нэр/төрөл	Хэрэгжиж буй шат	Шаардлагатай ажлын хүч
1.**Орон нутагт:**		
А.	.....	.....
Б.	.....	.....
В.	.....	.....
Г.	.....	.....
Д.	.....	.....
Е.	.....	.....
2.**Ойр хавьд:**		
А.	.....	.....
Б.	.....	.....
В.	.....	.....
Г.	.....	.....
Д.	.....	.....
Е.	.....	.....

Хавсралт 3.3. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа (үлгэрчилсэн загвар)

Загварыг хэрэглэх зааварчилгаа

А.Удиртгал

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа нь орон нутгийн хэрэглэгчид хэрэгцээтэй эсвэл хэрэглэхийг хүсэж байгаа боловч орон нутгаас олох боломжгүй тодорхой бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг тогтоох зорилготой юм.

Б.Мэдээлэл цуглуулах

Санамсаргүй байдлаар сонгон авсан айлуудаар очиж ганцаарчилсан ярилцлагыг стандарт асуудлгын (дор 2.2-ыг үзнэ үү) дагуу хийнэ.

В.Асуулга

Асуулга нь дараах зүйлийн талаар мэдээлэл авах зориулалт бүхий асуултуудтай байна:

а) Гэр бүлийн/ахуйн хэрэгцээнд хэрэглэгддэг бүтээгдэхүүний хэрэгцээний хангалтгүй байдал

Асуулганд хөдөөгийн иргэдийн хувьд өргөн хэрэгцээний хэмээн тооцогддог (байнга хэрэглэгддэг) барааны жагсаалт байна. Ерөнхийдөө тухайн жагсаалт нь хөтөлбөр хэрэгжүүлэх орон нутгийн хэмжээнд л өргөнөөр хэрэглэгддэг бараа, бүтээгдэхүүний нэр орсон байна. Тухайн орон нутгийн хувьд эрэлт хэрэгцээгүй бараа, бүтээгдэхүүнийг жагсаалтаас шууд хасаж, оронд нь эрэлт хэрэгцээ бүхий бүтээгдэхүүний нэрийг оруулна. Жагсаалтыг урьдчилсан байдлаар орон нутгийн хэмжээнд хамтран ажилладаг түншүүдэд үзүүлж хэрэгцээтэй өөрчлөлтүүдийг оруулсны үндсэн дээр эцэслэн судалгааны асуулгад оруулах нь зүйтэй байж болох юм.

б) Хэрэглэгчийн сэтгэл ханамжгүй байгаагийн шалтгаанХэрэглэгч зарим бүтээгдэхүүний хувьд сэтгэл хангалуун бус байгаа байдлыг дараах аргаар үнэлнэ:1=Нийлүүлэлт хангалтгүй;

2=Чанарын хувьд тааруу;

3=Зохистой загвар биш;

4=Бусад (тодорхой заах).

Тухайн бараа, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хувьд зөвхөн нэг сэтгэл дундуур байдлын **гол үзүүлэлт**ийг сонгоно.

Хариултуудыг ангилахдаа дээр заасанчлан 1, 2 болон 3 гэх ба зөвхөн нэг л тоогоор илэрхийлэгдсэн байна. Хэрэв өгсөн хариулт нь дээрх гурван тооны алинд ч таарахгүй бол 4 буюу “бусад” гэдэгт хамааруулж, тайлбарыг тодорхой бичсэн байна.

Хэрэв олон төрлийн шалтгаан заасан бол чухам яг аль нь гол (сэтгэл хангалуун бус байхын шалтгаан гэж үзэх талаар лавлан асууж тодруулсны үндсэн дээр хариултыг хүлээн авна.

Г.Асуулганд хамрагдагчдыг сонгож авах

Нэгэнт уг судалгаа нь гэр бүл/ахуйн хэмжээнд хэрэглэгдэх бараа, бүтээгдэхүүний талаарх хэрэглэгчийн сэтгэл хангалуун бус байдлыг тогтоох зорилгоор хийгдэж байгаа тул гэрийн эзэгтэй эсвэл эзнийг санамсаргүй байдлаар сонгон авч асуулгын хариултыг авна. Учир нь тэдгээр нь гэр бүлийн болон ахуйн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүний шаардлага, худалдан авалт, үнэ зэргийг тодорхойлж байдаг тул холбогдох асуултад бодитой хариулт өгөх боломжтой юм.

Тэдгээрийг эзгүй байхад таарвал, дээрх асуултуудад хариулахүйц гэр бүлийн өөр гишүүнийг сонгож болно. Харин дээр дурьдсан асуултад бодитой хариулт өгөх боломжтой хүн байхгүй бол өөр боломжит хариул өгөх хүнтэй айлыг сонгож авах хэрэгтэй.

Тухайн орон нутгийн бодит хэрэгцээг зөв тодорхойлхын тулд тодорхой тооны хэрэглэгчээс асуулга авч, тэдгээрийн санал бодлыг асуулгад бүрэн тусгасан байх шаардлагатай. Судалгааны дүнг бодитой болгохын тулд 30 гэр бүлийг судалгаанд хамруулах нь зүйтэй. Дээр дурьдсанчлан асуулгад хамрагдагчдыг санамсаргүй байдлаар сонгож авах хэрэгтэй, тухайлбал, санамсаргүй байдлаар айл сонгож эсвэл зах дээр байгаа иргэдээс санамсаргүй байдлаар сонгож асуух зэргээр.

Д. Мэдээллийг боловсруулах

Асуулгын явцад хариултуудыг хүснэгтэлж, тухайн бараа, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хувьд хэрэглэгчийн сэтгэл ханамжгүй байдал нь хэр чухал байгааг тогтооно.

Хариултуудыг ялгаж, хүснэгтлэхийн тулд дараах алхамуудыг хийнэ. Үүнд:

1. Бүрэн бөглөгдсөн хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа болгон 1-30 дотор дугаар өгнө. Энэхүү дугаарыг асуулгын эхний нүүрний баруун дээд буланд бичнэ;
2. Хүснэгтийн зориулалт бүхий нүднүүдэд хөтөлбөр хэрэгжих орон нутгийн талаарх мэдээлэл болон судалгааны явцад авсан мэдээллийг оруулна;
3. Асуулга болгоны мэдээллийг оруулж дууссаны дараа шаардлагатай мэдээллийг буулгасан гэдгийг тэмдэглэхийн тулд асуулгын эхний нүүрний баруун дээд буланд тэмдэглэж, дугаарыг дугуйлна.
4. Судалгааны мэдээллийг нэгтгэсний дараа, тухайн бараа, бүтээгдэхүүний сэтгэл ханамжгүй байдлын

шалтгааныг хариултууд нь тодорхой давтамжтайгаар илэрхийлэгдэнэ (судалгааны дүнгээс мөн шинээр бий болгож болох бизнесийн боломж ч харагдах болно).

Эхний ээлжинд эрэлт хэрэгцээний шаардлага нь хангагддаагүй бүтээгдэхүүн (бараа болон үйлчилгээ)-ийг авсан нийт хариултуудынх нь дагуу жагсааж бич, ингэхдээ 1 гэсэн дугаарт хамгийн их хариулт авсныг нь бичих бөгөөд доош нь авсан хариулт багасаж байгааг харгалзан жагсаасан байна;

Жагсаалтын эхний 10-т бичигдсэн барааны нэрийг тодруулж орон нутгийн судалгааны үр дүнтэй харьцуулсан дүгнэлт хийж дээрх бараанууд ямар шалтгаанаас болж хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээний шаардлагыг хангахгүй байгааг тодруулна;

Жагсаалтад үлдсэн барааны нэрсийг тусад нь авч (3.4 дэх хэсгээс харна уу) зах зээлийн боломжийн судалгаа гаргахад хэрэглэнэ;

Судалгааны нэгдсэн дүн гармагц түүнийг Орон нутгийн түншлэлийн зөвлөлд танилцуулна.

Е. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгааны дүн болон сургалтын дамжааны загвар

Тодорхой бараа эсвэл үйлчилгээний хүртээмжтэй байдалд сэтгэл ханамжгүй байгаагийн шалтгаан нь тухайн бараа бүрийн хувьд хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хэрхэн хангах, хангахын тулд яах ёстой талаар чиглэл өгөх болно. Энэхүү мэдээллийг сургалтын агуулга болон загварыг боловсруулах үйл ажиллагаанд хэрэглэж болно. Жишээ нь, хэрэв нийлүүлэлт хангалтгүй байгаа гэсэн судалгааны дүн гарвал, нийлүүлэлтийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх аргаар нөхөж болох юм. Энэ нь ур чадварын сургалтын дамжааг төгсөгчдөд тухайн бүтээгдэхүүнийг хувиараа хөдөлмөр эрхлэх чадвартай болгоход чиглүүлнэ гэсэн үг юм.

Барааны чанар доогуур байна гэдэг нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн эрхлэн явуулж байгаа эзэд/ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэйг илтгэж байгаа байж болох юм.

Бүтээгдэхүүний загвар/хэв маяг нь хэрэглэгчдийн таашаалд нийцэхгүй байгаа гэдэг нь загвар/хэв маяг сайжруулах чиглэлийн ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийл болох юм.

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгааны загвар

Тосгон (хороо) баг .....

Дүүрэг / сум .....

Аймаг /хот .....

Огноо ..... **Судалгаа авсан хүний нэр** .....

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаа бараа

Өнгөрсөн хугацаанд таны хэрэгцээний шаардлага/эрэлт хэрэгцээг хангаагүй ямар бараа/ бүтээгдэхүүн/үйлчилгээг худалдаж авсан эсвэл худалдаж авахыг оролдсон бэ?

Ямар учраас таны эрэлт хэрэгцээг хангаагүй вэ?

/(Шалтгааныг дараах аргачлалын дагуу заана уу: 1- Нийлүүлэлт хангалтгүй, 2-Чанарын хувьд тааруу, 3-Зохистой загвар биш, 4-Бусад (тодорхой заах))

Бараа/үйлчилгээ	Сэтгэл хангалуун бус (1, 2, 3, эсвэл 4)	Бараа/үйлчилгээ	Сэтгэл хангалуун бус (1, 2, 3, эсвэл 4)
Гэр ахуйн хэрэгцээ			
Хүнсний бүтээгдэхүүн:			
дотоодын чихэр	.....	бусад	
талх	.....	хүнсний тос	.....
гоймон	.....	сүмс	.....
дотоодын нарийн боов	.....	.....	.....
Хувцас:			
Эмэгтэй хүний:	.....	өмд	.....
гэрийн даашинз	.....	богино өмд	.....
дотуур хувцас	.....	дэрний уут	.....
даашинз	.....	бусад	.....
хүүхдийн хувцас	.....	.....	.....
эрэгтэй цамц	.....	.....	.....
Бусад хувийн хэрэгцээний зүйлс:			
гутал	.....	3. бүс	.....
шаахай	.....	4. малгай	.....
сандал	.....	5. бусад	
2.цүнх /эмэгтэй цүнх/түрийвч	.....	.....	.....
		.....	.....
Ариун цэврийн хэрэгсэл:		бусад	
нүүр гарын саван	.....	.....	.....
угаалгын саван	.....	.....	.....
үсний саван	.....	.....	.....
Гал тогооны эд зүйлс			
зуух:	.....	3.сав	.....
модоор галладаг	.....	4. шүүр	.....
нүүрсээр галладаг	.....	5. наргил модоор хийсэн сав	.....
бусад	.....	6. бусад	
шанага	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

Тавилга: 1.ширээ .... 2.түшлэгтэй сандал .... 3.сандал 4.шүүгээ	5.ор (хулсан, модон, шахмал) .... 6.бусад ....
Үйлчилгээ: 1.цахилгаанчин .... 2.мужаан .... 3.өрлөгчин .... 4.сантехникч .... 5.радио телевиз засварчин .... 6.цахилгаан тоног төхөөрөмжийн засвар ..... 7.гагнуурчин 8.засалчин	жижиг хөдөлгүүрийн засвар ..... (тухайлбал моторт завь) авто засвар ..... үсчин ..... гоо сайханч ..... бусад ....
Бусад бараа/ үйлчилгээ:	....

Үйл ажиллагаа	Сэтгэл хангалуун бус (1, 2, 3, эсвэл 4)	Үйл ажиллагаа	Сэтгэл хангалуун бус (1, 2, 3, эсвэл 4)

I. Эдийн засгийн үйл ажиллагааны бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг тодорхойлох загвар

Газар тариалан	
А. Боловсруулагдсан түүхий эд: а. бордоо .... б. хортон шавьж устгагч .... в. үр	г. бусад ....
Б. Багаж/тоног төхөөрөмж: а. үрслүүлэгч .... б. хүрз .... в. тор .... г. сийрэгжүүлэгч .... д. шүршигч	е. хулсан саг .... ё. бусад ....
В. Үйлчилгээ : а. дархан /багаж тоног төхөөрөмжийн/.....	б. бусад ....

II. Туслах аж ахуй:

А. Боловсруулсан түүхий эд: а. тэжээл .... б. нэмэлт тэжээл	в. бусад
Б. Багаж /тоног төхөөрөмж а. өндөгний тэвш .... б. тэжээлийн тэвш .... в. усны тэвш .... г. халаагч	д. инкубатор .... е. бусад ....
В. үйлчилгээ: а. мужаан .... б. нарийн төмрийн дархан .... в. цахилгаанчин	г. бусад ....
Г. Бусад: а. байшин .... б. халдваргүйжүүлэлт .... в. нүүрс	г. бусад ....

III. Гар урлал

А. Боловсуурлсан түүхий эд: а. олс .... б. цавуу .... в. гинж	г. бусад ....
Б. Багаж /тоног төхөөрөмж: а. хутга .... б. цавууны багс	в. Бусад ....

IV. Загасчлал

А. Боловсуурлсан түүхий эд:
....

Б. Багаж /тоног төхөөрөмж

а. бага оврын мотор .... г. бусад
б. керосинан гэрэл ....
в. загасны тор ....

В. Үйлчилгээ:

а. завины мотор засвар .... г. бусад
б. нарийн дархан ....
в. тор нэхэгч ....

V. Чихрийн үйлдвэрлэл эрхлэх

А. Боловсуурлсан түүхий эд:

а. чихрийн нишингэ .... б. бусад
....

Б. Багаж /тоног төхөөрөмж:

а. зуух .... д. бусад
б. зуурагч ....
в. шүүр ....
г. төмөр тогоо ....

Хавсралт 3.4. Зах зээлийн боломжийн судалгаа (үлгэрчилсэн загвар)

Үйлдвэрлэгчдэд зориулсан зах зээлийн боломжийг судлах судалгааны загвар

Судалгааны загварыг хэрэглэх заварчилгаа

Оршил

Зах зээлийн боломжийг судлах зорилгоор хоёр өөр төрлийн загвар боловсруулагдсан: нэг нь үйлдвэрлэгчдэд зориулагдсан бол нөгөө нь худалдаачдад зориулагдсан бөгөөд судалгааны загварт өөгдөх асуудлууд нь ялигүй өөр өөр юм.

Мэдээллийн зорилт

Зах зээлийн боломжийн судалгаа–үйлдвэрлэгчийн загвар нь орон нутгийн эрэлт хэрэгцээний судалгаагаар тогтоогдсон тодорхой бүтээгдэхүүн/ үйлчилгээний талаарх мэдээллийг агуулна.

Зах зээлийн боломжийн судалгаа нь дараах мэдээллийг гаргаж ирэх юм:

- Орон нутгийн үйлдвэрлэгч ямар шалтгаанаас хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжгүй байгаа вэ?
- Үйлдвэрлэгч нь тухайн үйлдвэрлэл нь өргөтгөх/ сайжруулах боломжтой гэж бодож байгаа эсэх;
- Үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор холбогдох байгууллагуудаас техник болон зээлийн дэмжлэг үзүүлэх ямар эх сурвалжууд байгаа талаарх мэдээлэл.

Мэдээллийг боловсруулах

Судалгаа хийгч нь загварчилсан асуулгын загварын дагуу үйлвэрлэгчтэй ганцаарчилсан уулзалт хийж мэдээлэл авна.

Судалгаанд оролцогчдыг сонгон авах

Судалгаанд хамрагдагч нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа болон орон нутгийн төлөв байдлын судалгааны явцад хэрэглэгчдийн таашаалд нийцэхгүй бараа/үйлчилгээг хүргэж буй орон нутгийн үйлдвэрлэгч байна.

Тухайн үйлдвэрлэлийг эзэмшигч, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайн мэддэг хүн судалгаанд оролцох ёстой. Хэрэглэгчдийн таашаалд бүрэн нийцдэггүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг хоёроос гурван үйлдвэрлэлийн төлөөллийг оролцуулна.

Мэдээллийг боловсруулах

Бүх ярилцлагыг хийж шаардлагатай мэдээллийг цуглуулсны дараа зах зээлийн боломжийн судалгааны мэдээллийг доор дурьдсан загварын дагуу нэгтгэнэ.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнг тайлбарлах

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангагдаагүй бүтээгдэхүүн

Үйлдвэрлэлийн хүчин чадал нь доогуур байна гэдэг нь орон нутгийн худалдан авагчдын хэрэгцээг хангахгүй байгаагийн илэрхий шалтгаан мөн. Тухайн үйлдвэр нь зөвхөн цөөн тооны тогтмол үйлчлүүлэгчдтэй байж болох бөгөөд энэ тохиолдолд үйлдвэрийн эзэн нь бүх үйлчлүүлэгчид сэтгэл ханалуун байгаа гэж бодож болох юм.

Ихэвчлэн үйлдвэрлэгч нь үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй гэдгээ хэлж магадгүй. Ингэсэн тохиолдолд тэдгээр нь эрэлт хэрэгцээг хангахад саад болж буй тодорхой хүчин зүйлүүдийн (тухайлбал, хэдий хэмжээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэвэл эрэлт хэрэгцээ хангагдах талаар) талаар асуух хэрэгтэй.

Хэрэв санхүүгийн туслалцаа нь тухайн үйлдвэрлэлийн хүчин чадалд нөлөө үзүүлж буй үндсэн шалтгаан бол үүнийг шинэ ажлын байр бий болгохоос өмнө шийдвэрлэх нь зүйтэй. (Үйл ажиллагаа явуулж буй бизнест нэмэлт ажлын байр бий болгох эсвэл тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх зэргийн аль алинд нь хамаарна.)

Санхүүгийн асуудал нь дангаараа ХЭЗЧДС-ын сургалтын хүрээнд хамрагдах үндэслэл болохгүй. Иймээс тохиолдолд ХЭЗЧДС-ын сургалтын асуудал хариуцсан ажилтан нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахгүй өөр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай ур чадварыг олгох сургалт зохион байгуулах арга хэмжээ авах хэрэгтэй.

Орон нутгийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх /сайжруулах боломж

Зарим үйлдвэрлэгчид нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зөвхөн гэр бүлийн хүрээнд явуулахын тулд орон тоог хязгаарладаг бөгөөд тэдгээр нь гаднаас ажилчид авах дургүй байдаг. Эдгээрийн ихэнх нь хэрэв бусдад цалин төлөөд байх юм бол орлого нэмэгдүүлэх боломжгүй болно гэж үздэг. Одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг өргөжүүлэх асуудал хөндөгдсөн тохиолдолд эхний ээлжинд тухайн бизнес эрхлэгч нь бизнесээ өргөжүүлэх сонирхолтой байгаа эсэхийг тодруултодруулах хэрэгтэй. Өргөжүүлэхээр бол тухайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн

хэрэгцээнд нийцсэн нийлүүлэлтийг бий болгоход чиглэгдсэн байх ёстой.

Хэрэв үйлдвэрлэлийн эзэн нь бизнесийг өргөжүүлэх гэж байгаа бол, зах зээл, санхүү, эсвэл ажиллах хүчийг нэмэгдүүлэх бол ХЭЗЧДС-ын хөтөлбөр дэмжлэг үзүүлнэ. Хэрэв дээр дурьдсан өргөжүүлэх үйл ажиллагаа нь ажиллах хүчинд хамааралгүй бол мэргэжлийн ур чадвар олгох сургалтын дамжаа хэрэгцээгүй. Харин нэмэлт ажилчид хэрэгтэй тохиолдолд чухам ямар ур чадвартай, хэдий тооны ажилчид хэрэгцээтэй, сургалтын дараа ажлын байр баттай байх зэргээс хамааруулан ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ур чадварыг нэмэгдүүлэх/олгох сургалтыг зохион байгуулж болох юм.

Санхүүгийн болон техникийн туслалцааны эх үүсвэр

Үйлдвэрлэлүүдийн хувьд санхүүгийн болон техникийн туслалцаа хомс байдгаас болж үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байх тохиолдол байдаг. Эдгээр хүчин зүйлийг бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд харгалзан үзэх нь чухал юм.

Энэ хэсэгт ямар төрлийн санхүүгийн болон техникийн туслалцааг авч болох талаарх мэдээллийг өгнө. Энэ мэдээлэл нь шинээр ажлын байр бий болгох үйл ажиллагааг дэмжихэд ихээхэн ач холбогдолтой байна.

Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бусад үйлдвэрлэгчид

Тухайн бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн талаар мэдээлэл нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаарх ерөнхий дүр зургийг гаргаж харуулна. Бүх үйлдвэрлэгчдэд тохиолдолддог түгээмэл бэрхшээлүүд нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд хэрхэн ажлын байр бий болгох талаар санаа өгнө.

Худалдаачдад зориулсан зах зээлийн боломжийг судлах судалгааны загвар

Судалгааны загварыг хэрхэн хэрэглэх талаарх зааварчлагаа.

Оршил

Дээр дурьдсанчилан зах зээлийн боломжийн судалгааны хоёр төрлийн загвар байдаг: Нэг нь үйлдвэрлэгчдэд нөгөөх нь худалдаачдад зориулагдсан. Загварууд нь ойролцоо боловч зарим асуултууд нь арай өөрөөр тавигдах шаардлагатай. Энэ хэсэг нь худалдаачдад зориулсан зах зээлийн боломжийн судалгаанд хамаарах болно.

Мэдээллийн зорилт

Зах зээлийн боломжийн судалгааны худалдаачдад зориулсан загвар нь орон нутгийн эрэлт хэрэгцээний судалгаагаар тогтоогдсон тодорхой бүтээгдэхүүн/үйлчилгээний талаарх мэдээллийг агуулна.

Зах зээлийн боломжийн судалгааны үр дүн нь дараах мэдээллийг гаргаж ирэх юм:

- орон нутгийн худалдаачид нь тухайн орон нутгийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахуйц нийлүүлэлтийг хийж чадахгүйн шалтгаан;
- хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийлүүлэлтийг хийхийн тулд авч болох арга хэмжээнүүд /боломж;
- орон нутагт бий болгох хөдөлмөр эрхлэлтийн санал.

Мэдээллийн боловсруулах

Судалгаа хийгч нь загварчилсан асуулгын загварын дагуу худалдаачидтай ганцаарчилсан уулзалт хийж мэдээлэл авна.

Судалгаанд оролцогчдыг сонгон авах

Судалгаанд хамрагдагч нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа болон орон нутгийн дүр төрхийн судалгааны явцад хэрэглэгчдийн таашаалд нийцэхгүй бараа/ үйлчилгээг хүргэж буй орон нутгийн худалдаачид байна.

Тухайн худалдааг эзэмшигч эсвэл үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайн мэддэг хүн судалгаанд оролцох ёстой. Хэрэглэгчдийн таашаалд бүрэн нийцдэггүй тухайн тодорхой бүтээгдэхүүнийг худалдаалддаг хоёроос гурван худалдаачдын төлөөллийг оролцуулна.

Мэдээллийг боловсруулах

Бүх ярилцлагыг хийж, шаардлагатай мэдээллийг цуглуулсны дараа зах зээлийн боломжийн судалгааны мэдээллийг доор дурьдсан загварын дагуу нэгтгэнэ.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнг тайлбарлах

Бүтээгдэхүүний хангагдаагүй эрэлт хэрэгцээ

Эхний ээлжинд тодорхой барааны борлогдсон тоо хэмжээ нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцээгүй нийлүүлэлттэй харьцуулж үзэх хэрэгтэй. Борлуулалт бага байна гэдэг нь тухайн барааны эрэлт хэрэгцээ бага эсвэл нийлүүлэлт нь хангалтгүй байна гэж ойлгож болох юм. Тухайн бараг нийлүүлэгч нь цөөн хэдэн тогтмол үйлчлүүлэгчтэй тул тэдгээрийн хэрэгцээг хангасан гэж бодож байж ч болох юм. Худалдаачид

нь бүх худалдан авагчдыг хангах боломжгүй гэж болох бөгөөд энэ тохиолдолд бүх худалдан авагчдын хэрэгцээг хангахын тулд чухам хэр зэрэг нийлүүлэлт шаардлагатай тодорхойлж үзэх хэрэгтэй. (энэ нь бизнесийг хэр зэрэг өргөжүүлэх боломжтой талаар санаа өгнө.)

Мөн худалдаачид нь орон нутгийн үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд учирч буй бэрхшээлүүдийн талаар тодорхой мэдээлэл өгөх боломжтой бөгөөд энэ мэдээллийг сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаатай холбож авч үзэж болно.

Орон нутгийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх /сайжруулах боломж

Худалдаачид нь ихэвчлэн хэрэглэгч юу хүсэж байгаа ямар учраас тухайн бараа бүтээгдэхүүн хэрэглэгчдийн таашаалд нийцдэггүй талаар мэдээлэл сайтай байдаг. Тэдгээрийн орон нутгийн үйлдвэрлэлийн өргөжүүлэх эсвэл сайжруулах санал нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах боломжтой.

Ажлын байрыг бий болгох боломж

Тухайн орон нутгийн бусад бизнес эрхлэгчдийн адил худалдаачид нь ч мөн орон нутгийн хэмжээнд болзошгүй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх сонирхолтой байж болно. Худалдаачдад зориулсан зах зээлийн боломжийн судалгааны мэдээлэл нь үйлдвэрлэгчдэд зориулсан зах зээлийн боломжийн судалгааны мэдээллийн адил нэгтгэгдэнэ.

Хамтын үйлдвэрлэлийн байгууллагын боломжит төрлүүд

Хоршоолол

Хоршоолол нь хамтын үйл ажиллагааны хамгийн түгээмэл хэлбэр юм. Хоршооллууд нь олон төрөл, чиглэлийнх байх боломжтой. Жишээ нь, хэрэглэгчдийн хоршоолол, үйлдвэрлэгчдийн хоршоолол, зах зээлийн хоршоолол, зээлийн хоршоолол, үйлчилгээний хоршоолол, тээвэрлэгчдийн хоршоолол болон төрөл бүрийн үйл ажиллагааны хоршоолол гэх мэт.

Хоршооллууд нь хүмүүс ганцаарчилан бие даан хэрэгжүүлэх боломжгүй юмыг харилцан туслалцаж, хамтран хийх зорилгоор байгуулагдсан байдаг. Энэ нь ганцаарчлан бие дааж хэрэгжүүлэх боломжгүй төсөл эсвэл ганц хүн дангаар эрхлэх үйлдвэрлэл зэргийг хамтын гэрээний нөхцөл дээр шийдвэрлэдэг.

Үйлдвэрлэлийн нийгэмлэг

Зарим үйлдвэрлэлийн бизнес нь хоёр буюу түүнээс дээш тооны найз нар, хамаатнууд, хөршүүд гэх мэт харилцан холбоотой хүмүүсийн нэгдмэл зорилго, сонирхол дээр тулгуурлан бий болсон байдаг. Зарим шалтгаан, нөхцөл байдал, тухайлбал оролцогчдын цөөн тоо, сонирхол байхгүй эсвэл тодорхой хуулийн шаардлагуудыг биелүүлэх боломжгүйн үүднээс эдгээр үйлдвэрлэлүүдийг хоршоолол хэмээн албан ёсоор бүртгүүлдэггүй бөгөөд энэ хамтын үйл ажиллагаа нь албан бус хэлбэрээр явагддаг байна.

Дээр дурьдсан нөхцөл байдал нь хөгжлийн дунд шатанд ихэвчлэн тохиолддог. Зарим хамтын үйл ажиллагаа нь өсөж том бизнес болдог, харин зарим жижиг хоршооллын хэлбэртэй болдог байна.

Зарим улс орнуудад эдгээр жижиг хамтын үйл ажиллагаанууд нь бодлогын түвшинд засгийн газар болон зээл олгогч байгууллагуудын дэмжлэгээр хангагддаг байна. Банк болон бусад зээл олгогч байгууллагууд нь илүү давамгайлсан байдалтай. Энэ давамгай байдал нь харилцан хамаарал бүхий хамтын хариуцлагын зарчим бөгөөд энэ нь зээлийн эрсдлийг багасагадаг байна.

Томоохон нэгжүүд мөн илүү менежменттэй байдаг. Зарим үйлчилгээний хувьд томоохон хэмжээний цөөн тооны үйлчлүүлэгчтэй харьцах нь олон тооны жижиг нэгж эсвэл хувь хүмүүстэй харьцахаас илүү давуу байдлыг олгодог байна. ХЭЗЧДС-ын ур чадварын сургалтын үйл ажиллагааны нэг хэсэг бол төгсөгчдийн үйл ажиллагааг ямар зохион байгуулалтад оруулж өгөхөөс хамаардаг. Энэ нь ур чадварын сургалтад хамрагдагчдын ур чадвараас гадна түгээмэл орлогыг бий болгох үйл ажиллагааны менежментийг зохион байгуулах, багаар ажиллах тодорхой чадвартай болгоно.

Ашиг орлого олохын тулд хамтран нэгтгэх төсөл

Ашиг орлого олохын тулд хамтран нэгтгэх төсөл нь тодорхой орлого болон хөдөлмөр эрхлэлтийг эрэлхийлж байгаа төрөл бүрийн мэргэжил бүхий хэсгүүдийг нэгтгэж, бизнес санаачилга болон бизнесийн боломжид хөрөнгө оруулах сонирхол бүхий хөрөнгө оруулагчдыг нэгтгэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа юм. Дээрх үйл ажиллагаа нь дараах хэлбэрээр хэрэгжих болно. Үүнд:

а. Ажлыг давхар гэрээлэх

Зохион байгуулалтад орж (ХЭЗЧДС-ын төгсөгчид), тодорхой хөрөнгө оруулагчтай ажил гүйцэтгэх гэрээ хийнэ. Гэрээний нөхцөл нь тухайн хийх гэж байгаа ажлын төрлөөс хамаарна. Зарим тохиолдолд гэрээ нь зөвхөн хөдөлмөрийн хөлсний талаар байж болно, харин зарим тохиолдолд цалин болон бусад нэмэгдлийн талаар зохицуулсан байж болно. Иймэрхүү төрлийн гэрээнүүд нь (дор хаяж эхний үед)

төгсөгчдөд шаардлагатай бизнес/үйлдвэрлэл эрхлэхэд анхны хөрөнгийг хуримтуулах нөхцлийг бүрдүүлнэ. Гэхдээ хамтарч нэгдсэн эдгээр төгсөгчдийн хамтын журмаар хөрөнгө хуримтуулах, түүнд суурилсан өөрсдийн бизнес/үйлдвэрлэлийг эхлүүлэхийн тулд хадгаламжийн хөтөлбөрийг мөн боловсруулах хэрэгтэй.

б. Сүлжээний төсөл

Энэ нь тодорхой нэгэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай орцыг бий болгох шат дамжлагад хамтран нэг нэгж болж, хамтын үйл ажиллагаа эрхлэхийг хэлнэ. Энэ тохиолдолд үйлдвэрлэгч нь байнгын зах зээлтэй байх бөгөөд ерөнхий шат дамжлагын нэг үе шат тул үндсэн үйлдвэрлэгчээс тоног төхөөрөмж, түүхий эдийг авч хэрэглэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой юм.

в. Үйлдвэрлэлийн түншлэл

Энэ нь тодорхой ур чадвар бүхий хүмүүсийн бүлэглэл, хөрөнгө оруулагчид хамтран өөрсдийн хөдөлмөрийн болон хөрөнгийн нөөцийг ашиглан орлого олох зорилготой албан ёсны үйл ажиллагааг хэлнэ. Үйл ажиллагааны явцад олсон орлогыг оруулсан хувь нэмэртэй хамааруулан хуваана.

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хүрээнд төгсөгчдийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх бололцоог бүрдүүлэхийн тулд дээрх болон бусад хэлбэрүүдийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж болох юм.

Гэхдээ дээр дурьдсан хэлбэрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Төсгсөгчдийг нэгтгэж бүлгүүд болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал нь хөтөлбөрийн төлөвлөгөөнд орсон байх;
- Хамтын хадгаламж болон хөрөнгийг хуримтлуулах бүдүүвч болон бусад зохицуулалтыг хийх талаар сургалтын хөтөлбөрт тусгасан байх;
- Хамтран ажиллах түнш байгууллага/хувь хүмүүс ХЭЗЧДС-ын үйл ажиллагаатай танилцаж, хөтөлбөрийн үндсэн зорилгыг ойлгосон байх хэрэгтэй бөгөөд хамтран ажиллах түнш, ажил олгогчидтой хийх гэрээний төсөлд уг ажилд оролцох төгсөгчдийн саналыг тусгасан байх;
- Сургалтын дамжааг эхлэхээс өмнө дээр дурьдсан хамтран ажиллах сонирхол бүхий хүмүүсийн бүлгийг байгуулж тодорхой хэмжээний хамтын хуримтлалыг эхлүүлсэн байх зэрэг болно.

Үйлдвэрлэгчдэд зориулсан зах зээлийн боломжийг судлах судалгааны загвар

Хэрэгжих газар/орон нутаг .....

Дүүрэг/сум .....

Аймаг/ нийслэл .....

Огноо..... **Судалгаа авсан хүний нэр** .....

Үйлдвэрлэгч ..... **Бүтээгдэхүүн** .....

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангаагүй бүтээгдэхүүн

А.Танай бизнесийн өдрийн ((долоо хоногийн) (сарын) (улирлын)) дундаж бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хэд байдаг вэ?

Б.Энэ бүтээгдэхүүний хангагдаагүй эрэлт хэрэгцээ

Дээрх нь таны бизнесийн зүгээс болзошгүй эсвэл одоо хамтарч ажилдаг хэрэглэгч/үйлчлүүлэгчийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгааг хэлдэг үү? /хэрэв хариулт нь "Үгүй" бол үйлчлүүлэгчээс сүүлийн хэдэн долоо хоногийн нийлүүлэлтийн талаар дахин цэгнэж үзэхийг хүснэ үү. Үүний дараа хариулт мөн л "Үгүй" бол шууд II хэсэг рүү явна уу. ☐ **Үгүй** ☐ **Тийм**

Ямар шалтгаанаар дор дурьдсан хэрэглэгч/худалдан авагчийн тавьж буй тодорхой шаардлагуудыг таны бүтээгдэхүүн хангаж чаддагүй вэ?

☐ .....Хүссэн тоон хэмжээ

☐ .....Чанарын шаардлага

☐ .....Загвар/хэв маяг

☐ .....Өндөр үнэ

☐ .....бусад (тодорхой заана уу)

.....

.....

.....

Хэрэв нэгээс илүү хариулт байвал 1-5 хүртлэх оноо өгч хариулах бөгөөд1 гэсэн үнэлгээг хамгийн түгээмэл шалтгаанд өгнө үү.

Г.**Эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байдгийн шалтгаан**

Таны бодож байгаагаар болзошгүй эсвэл одоо хамтарч ажилладаг хэрэглэгч/үйлчлүүлэгчийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байдал нь ямар учраас бий болж байна?

☐ .....Түүхий эдийн хүрэлцээ хомс

☐ .....Илүү ихийг авах боломжгүй

☐ .....Түүхий эдийг тээвэрлэхэд бэрхшээлтэй байдаг

☐ .....Илүү ихийг худалдан авах санхүүгийн боломж байхгүй

☐ .....Багж/тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал

☐ .....Хуучирч/элэгдсэн тоног төхөөрөмж, хэрэгсэл

☐ .....Илүү ихийг үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн хүчин чадал байхгүй

☐ .....Хуучирсан үйлдвэрлэлийн технологи

☐ .....Бүтээгдэхүүний доогуур чанар

☐ .....Үйлдвэрлэлийн өртөг өндөр

☐ .....Загвар/хэв маяг нь зохимжгүй

☐ .....Бусад

☐ .....Нэмж худалдаж авах эх үүсвэр байхгүй

☐ .....Нэмж худалдаж авах санхүүгийн бололцоо байхгүй

☐ .....Нэмэлт ажилчид хэрэгтэй

II.Орон нутгийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх /сайжруулах боломж

А.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулах хүсэл эрмэлзэл

Та бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулахыг хүсдэг үү?

☐ Үгүй (III хэсэг рүү очно уу) ☐ Тийм (Б хэсэг рүү очно уу)

Б. Үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулахыг хувиар (%) илэрхийлэх

Хэрэв та үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулвал бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг өдөр/ долоо хоног(сар) улиралд хэдэн хувиар нэмэгдүүлэхийг хүсэж байгаа вэ?

Жилдээ нийт .....%

В.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулахын тулд авах арга хэмжээ

Хэрэв та үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулхаар бол ямар арга хэмжээнүүдийг авах вэ?

1. ..... 4. .....

2. ..... 5. .....

3. ..... 6. .....

I-В хэсгийг эргэн харж, бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нийлүүлэх боломжид саад болж байгаа шалтгаануудыг эргэн харна уу. Хэрэв хариултууд нь I-В хэсэгт өгсөн хариулттай холбогдох боломжгүй бол судалгаанд хамрагдагчаас тодруулан асууж хариу өгнө үү.

Г.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулсан тохиолдол хэрэгтэй ажилчдын хэрэгцээ

Үйлдвэрлэлийг өргөжүүлэх/сайжруулснаар танд...

☐ нэмэлт ажилчид хэрэгтэй

☐ одоо байгаа ажилчдаа сургах хэрэгтэй

☐ нэмэлт ажилчид болон сургалт шаардлагагүй (“Тийм” бол III хэсэгрүү очно уу) гэж бодож байна уу?

☐ Хэрэв нэмэлт ажилчид авбал, ямар төрлийн ажил хийх, хэдэн хүн авах вэ?

Тоо	Ажилчдын төрөл	Тоо	Ажилчдын төрөл
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

Хэрэв одоо байгаа ажилчдаа сургах хэрэгтэй бол ямар сургалт хэрэгцээтэй вэ?

Тоо	Ажилчдын төрөл	Тоо	Ажилчдын төрөл
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....

III.Санхүүгийн болон техникийн туслалцааны эх үүсвэр

1.Таны бизнесийн санхүүжилтийн талаар асуувал та дургүйцэх үү? (Судалгаанд хамрагдагч санхүүгийн бүх эх үүсвэрийг нэрлэж дууссаны хойно, эх үүсвэрүүдийн санхүүжилтийг хувиар илэрхийлэхийлж өгөхийг хүсэх хэрэгтэй.)

.....

.....

.....

.....

2.(Хэрэв нэгээс илүү эх үүсвэр байгаа тохиолдолд) Та .... эх сурвалжийг дурьдсан байна. Тус бүрийн оруулдаг хувь нэмрийг хувиар (%) илэрхийлэнэ үү?

Б.Техникийн туслалцааны эх үүсвэр

Та өөрийн бизнесийн үйл ажиллагааг сайжруулахын тулд өөр хэн нэгнээс зөвөлгөө авдаг уу?

Эх сурвалж	**Байршил**
1. Төрийн байгууллага	
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
2. ТББ	
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
3. Бусад	
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

IV.Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бусад үйлдвэрлэгчид

А.Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэгчдийн тоо

1. Танаас өөр үйлдвэрлэгчид энд байдаг уу? ☐ **Тийм** ☐ **Үгүй** .....байдаг
2. Хэрэв та мэддэг бол бусад үйлдвэрлэгчдийн нэр, хаягийг хэлж өгнө үү?

Үйлдвэрлэгчийн нэр	**Хаяг**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

Б.Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээх хангахад саад болдог бүх үйлвэрлэгчид тулгардаг түгээмэл бэрхшээл

Та өмнө нь тодорхой шалтгааны улмаас хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байдалд хүрдэг гэсэн. Бусад үйлдвэрлэгчид ч гэсэн мөн адил ийм бэрхшээл тулгардаг гэж бодож байна уу?

☐ .....Түүхий эдийн хүрэлцээ хомс
☐ .....Эх үүсвэр хангалтгүй
☐ .....Илүү ихийг худалдан авах санхүүжилт байхгүй
☐ .....Багаж/тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал
☐ .....Хуучирч/элэгдсэн тоног төхөөрөмж, хэрэгсэл
☐ .....Илүү ихийг үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн хүчин чадал байхгүй
☐ .....Худалдан авах нийлүүлэгч байхгүй
☐ .....Илүү ихийг худалдан авах санхүүгийн боломж байхгүй
☐ .....Нэмэлт ажилчид хэрэгтэй (төрлийг нь тодорхой заах)
☐ .....Үйлдвэрлэлийн өртөг өндөр
☐ .....Бүтээгдэхүүний чанар доогуур
☐ .....Загвар/хэв маяг нь зохимжгүй
☐ .....Бусад (тодорхой бичнэ үү)

Хэрэв нэгээс илүү хариулт байвал 1-5 хүртлэх оноо өгч хариулах бөгөөд 1 гэсэн үнэлгээг хамгийн ач холбогдол бүхий шалтгаанд өгнө үү.

V. Ажлын байр бий болгох боломж

А. **Хэрэглэгддэгүй /илүүдэл түүхий эдийг боловсруулж хэрэглэх талаарх санал**

1. Орон нутагт төрөл бүрийн хэрэглэгддэгүй /илүүдэл түүхий эд байдаг. Таны бодож байгаагаар эдгээрээс ямар бүтээгдэхүүн гаргаж авах боломжтой вэ?

Түүхий эд (Орон нутгийн судалгаанаас харах)	**Боломжит бүтээгдэхүүн**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

2. Хэрэв та өөр бизнес эхэлвэл эдгээрээс аль хоёр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх вэ?

Бүтээгдэхүүн	**Яагаад?**
.....	.....
	.....
	.....
.....	.....
	.....
	.....

Б. **Өөр ашигтайгаар үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүн**

Түүхий эдийн нийлүүлэлт хаанаас/яаж хийгдэхээс үл хамааран орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэж болох бусад шинэ бүтээгдэхүүнийг нэрлэнэ үү?

Бүтээгдэхүүн	**Яагаад энэ бүтээгдэхүүн хэрэгтэй вэ?**
.....	.....
	.....
	.....
.....	.....
	.....
	.....
.....	.....
	.....
	.....

Худалдаачдад зориулсан зах зээлийн боломжийг судлах судалгааны загвар

Хэрэгжих газар/орон нутаг .....

Дүүрэг/сум .....

Аймаг/ нийслэл .....

Огноо ..... **Судалгаа авсан хүний нэр** .....

Үйлдвэрлэгч..... **Бүтээгдэхүүн** .....

I. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангагдаагүй бүтээгдэхүүн

А. Танай өдрийн / долоо хоногийн / сарын / улирлын дундаж /тодорхой бүтээгдэхүүний/ борлуулалт хэд байдаг вэ?

.....

Б.Энэ бүтээгдэхүүний хангагдаагүй эрэлт хэрэгцээ

Дээрх нь таны бизнесийн зүгээс болзошгүй эсвэл одоо хамтарч ажилдаг хэрэглэгч/үйлчлүүлэгчийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгааг хэлдэг үү? /хэрэв хариулт нь "Үгүй" бол үйлчлүүлэгчээс сүүлийн хэдэн долоо хоногийн нийлүүлэлтийн талаар дахин цэгнэж үзэхийг хүснэ үү. Үүний дараа хариулт мөн л "Үгүй" бол шууд II хэсэг рүү явна уу. ☐ **Үгүй** ☐ **Тийм**

Яагаад дор дурьдсан хэрэглэгч/худалдан авагчийн тавьж буй тодорхой шаардлагуудыг таны бүтээгдэхүүн хангаж чаддагүй вэ?

☐ .....Хүссэн тоон хэмжээ

☐ .....Чанарын шаардлага худалдан авагчийн хүссэнээс доогуур байдаг

☐ .....Загвар/хэв маяг

☐ .....Өндөр үнэ

☐ .....Бусад (тодорхой заана уу)

.....

.....

.....

Хэрэв нэгээс илүү хариулт байвал 1-5 хүртлэх оноо өгч хариулах бөгөөд1 гэсэн үнэлгээг хамгийн түгээмэл шалтгаанд өгнө үү.

Г.Эрэлт хэрэгцээг хангах боломжгүйн шалтгаан

Таны бодож байгаагаар болзошгүй эсвэл одоо хамтарч ажилладаг хэрэглэгч/үйлчлүүлэгчийн хэрэгцээг ямар учраас бүрэн хангаж чадахгүй ?

☐ .....Нийлүүлэлт бага

☐ .....Нийлүүлэгч шаардлагатай хэмжээгээр нийлүүлж чаддагүй

☐ .....Илүү их хэмжээгээр худалдан авах санхүүгийн боломж байхгүй

☐ .....Нийлүүлэгч илүү сайн чанартай бүтээгдэхүүн нийлүүлж чаддагүй

☐ .....Нийлүүлэгч илүү сайн загвар/хэв загварай бүтээгдэхүүн нийлүүлж чаддагүй

☐ .....Нийлүүлэгчээс худалдан авах үнэ өндөр

☐ .....Нийлүүлэгчээс бүтээгдэхүүнийг орон нутагт авчрах тээвэрлэлтийн асуудал хүндрэлтэй

☐ .....Бусад (тодорхой бичнэ үү)

.....

.....

Хэрэв нэгээс илүү хариулт байвал 1-5 хүртлэх оноо өгч хариулахын зэрэгцээ 1 гэсэн үнэлгээг хамгийн чухал шалтгаанд өгнө үү.

Д. Бүтээгдэхүүнийг нийлүүлэгч

☐ Та хаанаас болон хэнээс бараа худалдаж авдаг вэ? ☐ Орон нутгийн үйлдвэрлэгч

☐ Орон нутгийн бөөнөөр худалдагч ☐ Ойролцоох сум(аймаг)

☐ Бүс нутгийн худалдааны төв ☐ Нийслэл

II. Орон нутгийн үйлдвэрлэлийн боломж

А.Орон нутгийн үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа

1. Таны бодож байгаагаар орон нутгийн үйлдвэрлэгчид ямар аргаар тухай бүтээгдэхүүний үйлдвэрлэл сайжруулж чадах болов уу? (хэрэв орон нутгийн хэмжээнд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч байхгүй бол III хэсэг рүү очно уу)

☐ Түүхий эдийн боломжийг нэмэгдүүлэх ☐ Илүү сайн/боловсронгуй багаж/тоног төхөөрөмж

☐ Илүү боловсронгуй үйлдвэрлэлийн технологи ☐ Илүү сайн бэлтгэгдсэн/ ур чадвартай ажилчид

☐ Сайжруулсан (цаг үед нийцсэн загвар)хэв маяг ☐ Бусад (тодорхой заах)

2. Хэрэв одоогийн байдлаар орон нутгийн үйлдвэрлэгчдэд тулгараад байгаа бэрхшээлийг арилгавал, тэдгээрийн хамтарсан чармайлтаар .... өөрчлөлт гарах уу?

☐ орон нутгийн хэрэгцээг хангахуйц бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд...

☐ орон нутгийн хэрэгцээг илүүдэлтэйгээр хангахуйц...

☐ хэрэгцээг хангах боломжгүй.

III.Ажлын байрыг бий болгох боломж

А.Хэрэглэгддэгүй /илүүдэл түүхий эдийг боловсруулж хэрэглэх талаарх санал

1. Орон нутагт төрөл бүрийн хэрэглэгддэггүй /илүүдэл түүхий эд байдаг. Таны бодож байгаагаар эдгээрээс ямар бүтээгдэхүүн гаргаж авах боломжтой вэ?

Түүхий эд (ОНС-аас харах)	**Боломжит бүтээгдэхүүн**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

2. Хэрэв та өөр бизнес эхэлбэл эдгээрээс аль хоёр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх вэ?

Бүтээгдэхүүн	**Яагаад?**
.....	.....
	.....
.....	.....
	.....

Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны явцад тодорхойлогдож гарч ирсэн шинээр хэрэгжүүлж болох эдийн засгийн үйл ажилллагааны саналыг дараах байдлаар нэгтгэвэл зохино.

Энэ загвар нь сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны үндэс болно.

Боломжит эдийн засгийн шинэ үйл ажиллагаа

Энэ загварын энэ хэсгийг шинэ үйл ажиллагааны санал болгож байгаа үйлдвэрлэлийн төлөөлөл тус бүрээр бөглөгдсөн байх ёстой.

А. Эдийн засгийн үйл ажиллагааны тодорхойлолт

Б.Эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, мөн чанар

☐ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд шинэ боловч тухайн суурин газарт үйл ажиллагаа нь явагддаг

☐ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд шинэ бөгөөд тухайн суурин газарт үйл ажиллагаа нь явагддагүй

В.Санал болгох гол үндэслэл

☐ Орон нутгийн хувьд үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас болон хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, таашаалд нийцэхгүй байгаа энэ бүтээгдэхүүний хэрэгцээ их байдаг

☐ Зэргэлдээх сум/дүүрэгийн хувьд үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас болон хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, таашаалд нийцэхгүй байгаа энэ бүтээгдэхүүний хэрэгцээ их байдаг

☐ Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн олдоц тухайн орон нутагт элбэг эсвэл нийлүүлэлтийн хувьд хүндрэлгүй

☐ Бусад (тодорхой дурьдах)

Г.Мэдээллийн эх сурвалж

Тодорхой эх сурвалж	**Холбоо барих хаяг**
1. Байгууллага	
.....	.....
.....	.....
2. Бизнесийн үйлдвэрлэл	
.....	.....
.....	.....
3. Бусад	
.....	.....
.....	.....

Д.Тухайн эдийн засгийн үйл ажиллагааг явуулах газар

Энэхүү эдийн засгийн үйл ажиллагааг явуулахад хамгийн тохиромжтой байршил нь хаана вэ?

Байршил	**Яагаад?**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

II. Зах зээл

А.Бүтээгдэхүүн

1. Энэхүү эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнд ямар тодорхой төрлийн бүтээгдэхүүн/ үйлчилгээг бий болгох боломжтой вэ?

.....

.....

.....

2.Бүтээгдэхүүн/үйлчилгээг худалдан авах хамгийн тохиромжтой худалдан авагч хэн бэ?

☐ Хувь хүмүүс/гэр бүлд (жинхэнэ хэрэглэгчид)
☐ Үйлдвэрлэлийн бизнес эрхэлэгчид
☐ Бусад (тодорхой заах)
☐ Албан байгууллагууд
.....
.....

3.Энэ бүтээгдэхүүн/үйлчилгээг худалдан авах зорилтод худалдан авагч нь хэн бэ?

☐ Хувь хүмүүс/гэр бүлүүд /жинхэнэ хэрэглэгчид/
☐ Албан байгууллагууд
☐ Гэрээт ажилчид
☐ Зуучлагчид*:
- ▫ Дундын зуучлагч
- ▫ Бөөний худалдаа эрхлэгч
- ▫ Борлуулагч
- ▫ Бусад (тодорхой заах)

.....

.....

*Ихэнх үйлдвэрлэгчид зуучлагчдаар дамжуулан борлуулалтын үйл ажиллагааг явуулдаг бөгөөд эдгээр зуучлагчид нь тухайн бараг хамгийн тохиромжтой, эрэлхийж байгаа худалдан авагчид борлуулдаг байна.

4. Зорилтод худалдан авагчид хаана байдаг вэ?

Бүс нутаг	**Тодорхой байршил**
☐ Орон нутгийн хэмжээнд	.....
☐ Орчин тойрны хил залгаа орон нутагт	.....
☐ Сумын төвд	.....
☐ Дагавар хотод	.....
☐ Аймгийн төвд	.....
☐ Бүс нутгийн худалдааны төвд	.....
☐ Зэргэлдээх бус нутагт	.....
☐ Бусад (тодорхой заах)	.....
.....	.....
.....	
.....	.....

5. Хэрэв тухайн бүтээгдэхүүнийг өөр газар үйлдвэрлэдэг бол ямар учраас орон нутгийн иргэд заавал эндээс авдаг вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

6.Өрсөлдөөн

Тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээний үйлдвэрлэгчид нь:

Бүс нутаг	Тодорхой байршил
☐ Тухайн орон нутагт	.....
☐ Ойролцоох орон нутагт	.....
☐ Сумын төвд	.....
☐ Дагавар хотод	.....
☐ Аймгийн төвд	.....
☐ Бүс нутгийн худалдааны төвд	.....
☐ Зэргэлдээх бус нутагт	.....
☐ Бусад (тодорхой заах)	.....

III.Үйлдвэрлэл

А.Түүхий эд/орц

1. Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ямар түүхий эд болон орц шаардлагатай вэ? Түүхий эд болон орцын гадаад эх үүсвэр/нөөц хаана байдаг вэ?

Шаардлагатай орц	Эх үүсвэр	Тодорхой байршил
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

2.Хэрэгцээтэй багаж/тоног төхөөрөмж

Нэр	Эх үүсвэр
а. Багаж	.....
б. Тоног төхөөрөмж	.....
в. Сэлбэг	.....
г. Засвар, үйлчилгээ	.....

Б.Үйлдвэрлэлд шаардагдах техникийн туслалцааны эх үүсвэр

Шаардлагатай ур чадвар

1. Үйлдвэрлэлийг явуулахад ямар төрлийн ур чадвар хэрэцээтэй вэ? Эдгээр нь хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хамрах орон нутгийн хүрээнд байгаа юу?

Шаардлагатай ур чадвар

.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	☐ Тийм	☐ Үгүй

2. Дээрх ур чадвартай хүмүүс тухайн орон нутгаас олдох эсэх:

а. Холбогдох ур чадвар бүхий боловч одоогоор хөдөлмөр эрхэлдэггүй, ажилгүй хүн байгаа юу? ☐ Тийм ☐ Үгүй

.....

.....

Хэрэв "Тийм" бол тодорхой тайлбар хийнэ үү.

б. Тухайн орон нутгаар шаардлагатай ур чадвартай хүн байгаа бол ур чадварыг нь сайжруулах хэрэгтэй юу?

.....

.....

В.Бүтээгдэхүүний тодорхойлолт

1. Энэ бүтээгдэхүүний үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материалын орц, багаж, тоног төхөөрөмж зэргийг ашиглан ойролцоо төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой юу?

☐ Тийм ☐ Үгүй Хэрэв "Тийм" бол тодорхой тайлбар хийнэ үү.

.....

.....

. .....

Г.Үйлдвэрлэлийн техникийн туслалцааны эх үүсвэрүүд

1.Ямар төрлийн ур чадварын сургалтыг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах хэрэгтэй вэ?

Шаардлагатай ур чадвар

..... ☐ Тийм ☐ Үгүй

..... ☐ Тийм ☐ Үгүй

..... ☐ Тийм ☐ Үгүй

..... ☐ Тийм ☐ Үгүй

IV.Санхүүжилт

А.Санхүүгийн эх үүсвэр

Өөрийгөө санхүүжүүлэхээс гадна хөтөлбөр хэрэгжих хүрээнээс гадна хаанаас санхүүжилт авах боломжтой вэ?

Хөрөнгийн эх үүсвэр	**Байршил**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

V.Хүний нөөц/менежмжент

А.Байгууллагын бүтэц/төрөл

Тухайн санал болгож буй эдийн засгийн үйл ажиллагааг явуулахад хамгийн тохиромжтой бүтцийн хувилбар:

☐ Хувиар эрхлэх .....
.....

☐ Гэр бүлээрээ эрхлэх .....
.....

☐ Хамтарч .....
.....

☐ Хоршоолол маягаар .....
.....

☐ Бусад (тодорхой дурьдах) .....
.....

Б.Тулгарч болзошгүй бэрхшээлүүд

Энэ үйл ажиллагааг эхлүүлж, цаашид амжилттай үргэлжлүүлхэд тулгарч болзошгүй бэрхшээлүүдийг нэрлэнэ үү?

1. .....
2. .....
3. .....
4. .....
5. .....

Шинээр санал болгож буй үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх нь

Шинэ үйл ажиллагаа	Санал болгох болсон гол үндэслэл	Ур чадварын сургалт шаардлагатай юу?		
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй
.....	.....	.....	☐ Тийм	☐ Үгүй

Хавсралт 3.5 Нөхцөл байдлын судалгааны загвар (үлгэрчилсэн загвар)

Төлөвлөж буй үйл ажиллагааны нэр

1.Үйл ажиллагааны товч танилцуулга болон зорилго

Хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, товч танилцуулга (үйлдвэрлэх бүтээгдэхүүн/үйлчилгээ зэргийн талаар товч дурьдах)

.....

.....

.....

Ажлын байр бий болгох, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа эдийн засгийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй ур чадварын сургалт, байршил, бүтээгдэхүүний төрөл, технологи, ажлын хүч болон болзошгүй зах зээл зэргийн талаарх товч мэдээллийг танилцуулана уу.

Тухайн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газарт энэ эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр ямар ашигтай вэ?

- ☐ Түүхий эдийн нөөц хүрэлцээтэй
- ☐ Дэд бүтэц байгаа
- ☐ Ажлын хөлс
- ☐ Боломжит зах зээл/тээвэрлэлтийн өртөг нь нөлөөлөхүйц хүчин зүйл
- ☐ Холбогдох эдийн засгийн үйл ажиллагаа

Хэрэв энэ це шатад тодорхой хүмүүсийг зорилтод бүлэг болгон тооцож байгаа бол, яагаад эдгээр хүмүүс энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаар дурдана уу.

Тэдгээрд амжилтанд хүрэхийн тулд юу хэрэгтэй вэ? (Сургалт, зээл, техникийн туслалцаа болон бусад дэмжлэг)

Тэдгээрт уг асуудалд хандахад тодорхой саад, бэрхшээл байгаа юу?

2.Асуудалд хамаарах техникийн боломжийн тухайд

Хэрэглэгдэх түүхий эд, үйлдвэрлэлийн технологи, хэрэгцээтэй багаж болон тоног төхөөрөмж:

Эдгээр нь бүх орон нутгаас олдох боломжтой юу? ☐ Тийм ☐ Үгүй

.....

.....

.....

Хэрэв “Үгүй” бол хэрхэн нийлүүлэх боломжтой талаар дурьдана уу:

3. Хэрэгцээг урьдчилсан байдлаар тооцсон байдал

Тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээ зориулагдах зах зээлийг талаар дурьдана уу:

.....

.....

.....

Шаардлагатай, тодорхой зах зээлийн стратегийг дурьдана уу:

.....

.....

Хүлээгдэж буй эрэлт хэрэгцээ

Гол зах зээл:	.....нэгж	Хоёрдогч зах зээл	.....нэгж
Бусад нийлүүлэгчид	.....нэгж	Бусад нийлүүлэгчид	.....нэгж
Зах зээлд эзлэхээр тооцож байгаа хэсэг нэгж	.....нэгж	Зах зээлд эзлэхээр тооцож байгаа хэсэг	.....нэгж
Урьдчилан тооцоолж байгаа борлуулалт	.....нэгж	Урьдчилан тооцоолж байгаа борлуулалт	.....нэгж
Нийт тооцолж буй борлуулалт:	.....	**Нийт тооцолж буй борлуулалт:**	
Тэтгэмж		Зорилго болгож буй бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал	
Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хорогдол	.....%	**Төлөвлөж буй үйлдвэрлэлийн дээд хүчин чадал**	
Оргил улирлын тэтгэмж	.....%	.....**Сар бүр үйлдвэрлэх нэгжийн тоо**	

4.Менежмент

Үйлдвэрлэлд холбогдох бүтэц, зохион байгуулалтын талаар дурьдана уу (ажилчдын тоо: бүтэн цагаар эсвэл хагас цагаар-удирдлагын зохицуулалт-бараа борлуулалт гэх мэт).

.....

.....

.....

5.Төслийн өртөг

5.1. Үндсэн хөрөнгө оруулалт. Тодорхой хэмжээний үйлдвэрлэлд шаардагдах газар, байр, багаж, тоног төхөөрөмж гэх мэтийг оролцуулсан ойролцоо өртөг. Шаардлагатай капиталын тооцоог хийх.

i.Газар..... .....

ii.Байр (түрээслэхгүй бол)..... .....

iii.Тоног төхөөрөмж болон сэлбэг (тодорхой дурьдах)

....

....

....

iv.Багаж (тодорхой заах)

....

....

....

v.Тавилга, сэнс, гэрэл болон бусад (тодорхой заах)

....

....

....

vi. Холболтын хураамжууд болон үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажлын зарлага (цахилгаан, усны холболт, техник тоног төхөөрөмжийг суурьлуулах), зах зээлийн судалгаа

....
....
....

Нийт хөрөнгө оруулалт.....

5.2.Ажлын (хөдөлмөрийн капитал) хөрөнгө. Энэ нь түүхий эд хүудалдаж авахаас эхлэн, бэлэн болсон бүтээгдэхүүнийг борлуулсан мөнгийг автал бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

(i) Түүхий эдийн зах зээлийн үн ..... долоо хоног бүрээр тодорхой заах

....
....
....
....
....

(ii) Бэлэн болсон бүтээгдэхүүний зах зээлийн үнэ ....

(iii) Худалдан авагчдад зээлээр олгох ....

Нийлүүлэгчээс зээлээр авах (хасах) ....

(iv) Хөдөлмөр .....долоо хоног бүрээр тодорхой заах

(v) Байрны зардал

- Түрээс (хэрэв өөрийн байргүй бол) ....
- Цахилгаан ....
- Цэвэрлэгээ, засвар ....
- Тусгай зөвшөөрлийн хураамж ....

5.3 Гадны санхүүжилтийн хэрэгцээ

Нийт төслийн өртөг

- Нийт үндсэн хөрөнгө оруулалт ....
- Нийт ажлын/хөдөлмөрийн капитал ....
- **Нийт төслийн өртөг** ....

ХАСАХ

- Эзний эсвэл хамтрагчийн хувь нэмэр ....
- **Зээлийн хүү** ....

6.Авахаар тооцоолж буй зээл (хэрэв хэргцээтэй бол)

- Зээлийн эх үүсвэр .....
- Зээлийн хэмжээ .....
- Хувь нийлүүлэлт .....
- Зээлийн хүү ..... % нийт хугацааны ..... долоо хоног/сараар
- Сар бүрийн татвар..... долоо хоног/сараар

7.Үйл ажиллагааны зардал

Эхний жилийн үйл ажиллагааны зардал:

i. түүхий эд (тээврийн зардлыг оролцуулан) ....

ii.ажиллах хүчний зардал (хоолны зардлыг оролуулан) ....

iii.цахилгаан болон ус гэх мэтийн хэрэглээний зардал ....

iv.байрны зардал: ....

- түрээс ....
- засвар үйлчилгээ ....
- бусад ....

v.зээлийн хүү ....

vi.элэгдэл хорогдол ....

- Байшин (нийт үнийн 5 хувь) ....
- Машин техник (10 хувь) ....
- Тавилга (6 хувь) ....

Нийт үйл ажиллагааны зардал .....

8.Борлуулалт

Үнэ = нийт үйл ажиллагааны өртөг ч үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний нэгжийн тоо:

Үнэ =.....ч..... =.....

Ашиг.....%..... =.....

Худалдахаар төлөвлөж буй үнэ =.....

9.Тухайн төслийн хүрэхээр зорьж буй хүчин чадал

Нийт үйлдвэрлэлт ....

Бага: нийт үйл ажиллагааны зардал ....

10.Шаардлагатай бусад туслалцаа

Менежментийн сургалт болон зөвлөлгөө: ☐ Тийм ☐ Үгүй

Тайлбар:

....

....

....

Техникийн сургалт: Эздэд ☐ Тийм ☐ Үгүй

Ажилчдад ☐ Тийм ☐ Үгүй

Тайлбар:

....

....

....

Техникийн туслалцааны сэдэв:

Тоног төхөөрөмж худалдаж авах	☐ Тийм	☐ Үгүй
Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчилэх	☐ Тийм	☐ Үгүй
Бүтээгдэхүүн сайжруулах болон шинэ бүтээгдэхүүний загвар	☐ Тийм	☐ Үгүй
Чанарын шалгалт	☐ Тийм	☐ Үгүй
Бүтээгдэхүүний баглаа боодол	☐ Тийм	☐ Үгүй
Маркетинг	☐ Тийм	☐ Үгүй

Тайлбар:

....
....
....

Тусгай хэрэгцээ:

☐ Бичиг үсэгт сургах

☐ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай зүйлс

☐ Гэр бүлийн болон багаар эрхлэх бизнесийг зохион байгуулахад үзүүлэх туслалцаа

☐ Бусад

.....

.....

11.Ажиглалт ба дүгнэлт

.....

.....

.....

.....

.....

.....

Дээр дурьдсан, цуглуулсан мэдээллийн үндсэн дээр дүгнэлт хийж болно. Эхлүүлэхээр сонирхож буй бизнесийн онцлох сул болон давуу талуудыг тодорхойлж техник, эдийн засаг, санхүү болон бусад талаас нь авч үзэх тухай энэ хэсэгт дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Урьд өмнө хэрэгжиж байсан (ялангуяа амжилтгүй хэрэгжсэн) иймэрхүү үйл ажиллагаа, засгийн газрын хөтөлбөр, амжилттай сургалт, мэдээллийн үнэн бодитой байдлыг хангах, тухайн орон нутгийн үүрэг оролцоо, болзошгүй хөтөлбөрт хамрагдагчдын талаарх үндсэн мэдээлэл, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, нийгмийн нөхцөл байдал зэргийг байнга тооцож, шийдвэр гаргаж байх нь зүйтэй гэдгийг хуримтуулсан туршлага харуулж байна.

Хавсралт 3.6 Нөхцөл байдлын судалгааны товч тайлангийн жишээ (Бангладеш)

Хавсралт 3.6 А. Үлгэрчилсэн жишээ: Жессорт хэрэгжүүлсэн наргил модны самрын хальсаар олс хийх үйлдвэрлэлийн цаашдын чиг хандлагын талаарх тайлан. Бангладеш (ОУХБ/НҮБын ХХ, ХЭЗЧДС-ын Бангладеш дэх төсөл)

1.Санал болгож буй бизнес

Санал болгож буй бизнес нь наргил модны самрын хальсаар олс үйлдвэрлэх бизнес юм. Хэдийгээр тухайн нутагт нэлээн хэдэн тооны ийм төрлийн үйлдвэр байдаг ч гэсэн тодорхой чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл шинэ бизнес нээх боломжтой байсан.

Зорилтод бүлэгт хамрах эмэгтэйчүүд тухайн нутагт олдоц хялбартай түүхий эд болох наргил модны самрын хальсаар олс хийх юм. Тэдгээр нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Жессорын Ноапара Базар болон ойр хавийн газарт нь зарах юм. Хэдийгээр нэлээн хэдэн үйлдвэрлэгч байдаг ч гэсэн тухайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нь эмэгтэйчүүдийг ажлын байраар хангахад хангалттай.

2.Бүтээгдэхүүний тодорхойлолт

Үйлдвэрлэхээр төлөвлөж буй олс нь болсон наргил модны самрын хальсаар хийгдэх юм. Олс нь төрөл бүрийн хэмжээтэй байж болно.

3. Зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааны дүн шинжилгээ

3.1. Эрэлт хэрэгцээний урьдчилсан тооцоо

Наргил модны хальсаар хийсэн олсны гол зах зээл бол Жессорын Ноапара Базар юм. Түүнчлэн олсыг Рапдиа, Башюэндиа болон Жессор хотод борлуулж болно. Дээрх зах зээлд ойролцоогоор 200 гаруй худалдаачид ажилладаг. Зах зээлийн судалгаанаас үзэхэд тухайн дэлгүүр болгон 17636 ТК (1ам. Доллар =69ТК)-ийн олс худалдаж авдаг байна. Төсөлд хамрагдах нутгийн 11 дэлгүүрээс судалгаа авсан бөгөөд үүний үр дүнд жил бүрийн олсны хэрэгцээг дараах байдлаар тогтоосон байна.

Зах зээлийн өрсөлдөөн

Наргил модны самрын хальсаар хийсэн олсыг Манирампурын ойролцоох тосгонд үйлдвэрлэдэг бөгөөд олсыг бөөнөөр нь Ноапара Базар дээр зардаг байна. Зарим нь тухайн өдрийн бөөний ханшаар зардаг. Дакатия, Закия болон Сианнабаи тосгоны оршин суугчид ч мөн энэхүү үйлдвэрлэлийн бизнесийн эрхэлдэг байна.

Олс нь дээр дурьдсан тосгодын оршин суугчдын өөрсдийн гэсэн уламжлалт аргаар хийгддэг байна. Энэхүү үйл ажиллагаанд ойролцоогоор 50 өрх оролцдог бөгөөд 7 хоногт дунджаар 5 кг олс үйлдвэрлэдэг байна. Үйлдвэрлэсэн 1кг олс бүрийг 65-70 ТК-аар зардаг бөгөөд 7 хоногт тэдгээр нь 350 ТК, сард 1400 ТК-ийн олс үйлдвэрлэдэг байна.

Өрсөлдөөн нь эрэлт хэрэгцээнээс давж гарах боломжгүй бөгөөд тухайн төслийн хүрээнд боловсруулагддаг олс нь нийт эрэлт хэрэгцээний зөвхөн 4 хувийг хангахад хүрдэг байна.

4.Техникийн нөхцөл

4.1. БайршилҮйл ажиллагааг Жессор-Хулна хурдны зам дагуу байрлах Падэмавила тосгонд хэрэгжүүлнэ.

4.2 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Наргил модны самрын хальсаар хийсэн олсыг үйлдвэрлэх үйл ажиллагаа нь маш хялбар. Эмэгтэйчүүд үйлдвэрлэлийг гэртээ явуулах боломжтой. Тэд дугуйтай эргүүлдэг дамраар олс томдог байна. Уг багаж нь гараар ажиллах бөгөөд түүн дээр ажиллаж сурахын тулд багаахан хэмжээний ур чадвар шаардагддаг байна.

	Жилийн хэрэгцээ
Олсны жилийн дундаж худалдан авалт	17636 ТК
Тухайн хөтөлбөрт хамарагдах олсны дэлгүүрийн тоо (Рупдиа, Башюэндиа, Ноапара)	50
Олсны жилийн ойролцоо эрэлт хэрэгцээ (ТК)	8,81 багц
Нэг жилд үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүний үнэлгээ	0,37 багц
Тухайн үйл ажиллагааны зах зээлд эзлэх хувь	4 хувь

Шаардагдаах багаж:

Үйл ажиллагааг явуулахад хэрэгцээтэй багаж:

a). алх

b). элдүүр

c). модон хэв

d). хайч

e). багс

f). эргэдэг дамар

Эдгээр багажны үнэ нь ойролцоогоор 2000 ТК байна.

4.3 Түүхий эд

Наргил модны самрын хальсаар хийсэн олсыг хийхэд шаардлагатай түүхий эд нь Жессор болон Ноапара Базарын хавьцаа элбэг байдаг. Зорилтод эмэгтэйчүүдэд уг түүхий эдийг нийлүүлэх нь ямарваа нэгэн хүндрэлгүй байдаг.

4.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал

Дунджаар 2 эмэгтэй хамтарч ажиллана гэж тооцоход өдөрт 4 цаг ажиллахад 48 кг олсыг бэлтгэх боломжтой юм. Дараа жил нь тухайн эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн бүтээмж ур чадвараас хамааран жилд 20 хувиар өсөх боломжтой юм.

5.Менежментийн зохицуулалт

5.1 Менежмент

Хоёр эмэгтэй хамтарч бизнес эхлүүлж болно. Тэдгээр нь гэрээ үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах болмжтой.

5.2 Ашиг хуваах

Дээрх хоёр эмэгтэй сар бүрийн эцэст ашгаа тооцож, хувааж авах боломжтой юм. Ашиг хуваах нь тэгш байдлын зарчим дээр суурилагддаг бөгөөд орлогын тодорхой хэсгийг бизнест хөрөнгө оруулах хэлбэрээр эргүүлэн хөрөнгө оруулдаг хийдэг байна.

6. Санхүүгийн асуудал

(Дараагийн хуудсанд байгаа хүснэгтийг харна уу)

7. Бизнесийн эрсдэл

Бизнест дараах эрсдэлүүд тулгарч болно:

- ☐ борооны улиралд түүхий эд тасалдах
- ☐ борооны улиралд наргил модны самрын хальсыг хатаахад хүндрэл гарах

зээлээр олгогдсон барааны төлбөр удаан орж ирэх

- ☐ Эмэгтэйчүүд дээр дурьдсан болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой. Тухайлбал, түүхий эдийг 1 сарын үйл ажиллагаанд хүрэлцэхүйцээр нөөцөлж авах.

8. Бизнесийн үйл ажиллагааны хамаарах цаг хүрээ

Төсөл нь дараах зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлнэ. Рюпдия Базар, Басюндия Базар болон Жессор Садар.

9. Шаардлагатай сургалт

Эмэгтэйчүүд наргил модны самрын хальсаар олс хийх сургалтад хамрагдана.

10. Сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

Эмэгтэйчүүд сургалтын дараа үзүүлэх дэмжлэгүүд:

а. Үйл ажиллагаа эхлэх хөрөнгө;

б. Маркетингийн үйлчилгээ. Үүнд: орон нутгийн болон бүс нутгийн түвшинд энэ төрлийн бизнес явуулдаг хүмүүс болон байгууллага холбоо харилцаа тогтоох;

в. Сургалтын дараах техник туслалцаанд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хяналт тавих хамаарна;

г. Техникийн давтан сургалт (1 жилийн дараа);

д. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сургалт;

е. Бизнесийн зөвөлгөө.

11. Ажиглалт болон дүгнэлт хийх

Нөхцөл байдлын судалгааны тайлан, сургалтын тайлан зэрэг нь сонгогдсон эмэгтэйчүүд нь зохих ёсны хэрэгцээтэй сургалтад хамрагдсныг харуулж байна. ХЭЗЧДС-ын сургалтыг зохион байгуулагч нь цаашдын сургалтыг Хулна дахь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн нэгжид зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Наргил модны самрын хальсаар олс хийх үйлдвэрлэлийн санхүүгийн үзүүлэлтүүд

Агуулга	Мөнгөн дүн/Така
6.1 Тооцоологдож буй үнэ	
А. Үндсэн хөрөнгө оруулалт	
Багаж	1000
Нийт үндсэн хөрөнгө оруулалт	**1000**
Б. Үйл ажиллагаа эхлэхээс өмнөх зарлага/бизнесийн үйл ажиллагааг суурилуулах зардал	
Худалдааны тусгай зөвшөөрөл	500
Худалдан авагчидтай тохиролцож сүлжээ үүсгэх	500
Нийт бэлтгэл ажлын зардал	**1000**
Нийт хөрөнгө оруулалтын өртөг	**2000**
В. Хөдөлмөрийн капитал (үйл ажиллагааны зардал сар бүрээр)	
Түүхий эд	1500
Хөдөлмөр	-
Байрны зардал (түрээс, орон сууцны үйлчилгээ, цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн засвар) тээвэрлэлт, захын татвар, бусад	1400
Тоног төхөөрөмж, тавилга, багаж хэрэгслийн элэгдэл 5%	100
Нийт хөдөлмөрийн капитал/үйл ажиллагааны зардал	**3000**
Г. Нийт бизнесийн үйл ажиллагааны зардал (А+Б+В)	**5000**
6.2 Бизнесийн санхүүгийн төлөвлөгөө	
Нийт үндсэн хөрөнгө оруулалт	2000
Үйл ажиллагааны зардал	3000
Нийт бизнесийн өртөг	**5000**
Эргэн төлөлт	
Гаднаас авах зээлийн хэрэгцээ	5000
Зээл авах байгууллага: Бридж	-
Баталгаа: хувь хүний баталгаа	
Жилийн хүү 15%	750
Төлбөр хийх төлөвлөгөө (24 сар)	Сард 208
6.3 Ашгийн дүн шинжилгээ	
Тооцож буй сарын борлуулалт	3120
Үргэлжлэх хугацаа (сараар)	12
Борлуулатын урьдчилсан тооцоо (ТК)	37440
Бага:	
Жилийн үйл ажиллагааны зардал	
Түүхий эдийн өртөг	14400
Байрны түрээс	-
Зах зээлийн зардал	1200
Зээлийн хүү	750
Нийт үйл ажиллагааны зардал	**16350**
Олох жилийн нийт ашиг (ТК)	21090
Тухайн бизнест оролцож буй эмэгтэйчүүдийн тоо	2
Эмэгтэй тус бүрийн жилийн ашиг	10445
Эмэгтэй тус бүрийн сарын орлого	879

Хавсралт 3.6.Б. Үлгэрчилсэн жишээ: Жессорт хэрэгжүүлсэн сам хорхойн загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн цаашдын чиг хандлагын талаарх тайлан. Бангладеш (ОУХБ/НҮБын ХХ, ХЭЗЧДС-ын Бангладеш дэх төсөл)

1. Төлөвлөж буй үйл ажиллагаа

Тухайн бизнес нь сам хорхойн болон загасны хоол боловсруулах үйл ажиллагаа юм.

2. Бүтээгдэхүүний тодорхойлолт

Тэжээл нь жижиг элсэн ширхэгтэй байх бөгөөд тодорхой хэмжээгээр савлагдсан байна.

3. Зах зээлийн эрэлт хэрэгцээний дүн шинжилгээ

3.1 Тооцологдож буй эрэл хэрэгцээ

Тухайн нутагт ойролцоогоор сам хорхой үржүүлэх 300 аж ахуй үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр аж ахуйнууд нь зах дээрээс загасны хоол худалдаж авдаг байна. Хамгийн алдартай төрөл нь "Саудийн загасны хоол" (үндэсний нэрийн бүтээгдэхүүн) бөгөөд орон нутгийн загасны хоолыг "Жессорын загасны хоол" гэдэг байна.

Тухайн төсөл хэрэгжих орон нутагт нилээд хэдэн загас үржүүлэх аж ахуй байх бөгөөд эдгээр нь Нарендрапюр, Шакаригати болон Гаидгаси тосгонуудад байрладаг байна. Эдгээр загас үржүүлэх аж ахуйнуудын талбай нь нийтдээ 90 га байдаг бөгөөд аж ахуй тус бүр 25000 Такагийн хоолыг 1 га-д зарцуулдаг байна. Загасны хоолны нийт хэрэгцээ болон түүнд төслийн нийлүүлэх хувийг дор дурдвал:

	Жилийн хэрэгцээ
Нэг жилд 1 акр тутамд худалдаж авах дундаж загасны хоол (1ам. доллар =69TK)	20000 TK
90 аж ахуйн хэрэгцээ	22,50 лак
Тухайн төлөвлөж буй төслийн нэг жилийн тооцоолж буй үйлдвэрлэл	324000 TK
Төслийн зах зээлд эзлэж буй хувь	15 %

Тухайн нутагт загасны хоол бөөнөөр худалддаг 4 худалдаачнаас асуулга авсан. Дунджаар жилд 6,7 кг загасны хоол борууллагддаг байна. Энэ нь загасны хоолны эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

3.2 Зах зээлийн өрсөлдөөн

Энэ зах зээл нь маш өрсөлдөөнтэй. Эмэгтэй хүний хувьд "Жессорын загасны хоол" болон "Бхаираб загасны хоол" зэрэг том нийлүүлэгчтэй өрсөлдөхөд маш хэцүү. Гэхдээ эмэгтэйчүүд жижиг зах зээлд байж болох бөгөөд тухайн орон нутагт загасны үйл ажиллагаа эрхлэх жижиг аж ахуйтай гэрээлж Бриджээс зээл авах боломжтой юм.

3.3 Үнэ

Өрсөлдөгчдийн үнэ	Жилийн хэрэгцээ Бөөний үнэ нь 1кг /12TK
Төслийн тооцоолж буй үнэ (бөөний үнээр)	15%(1кг)11,75TK

3.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал

Тухайн төсөл нь эхний жилдээ 15846 кг бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

3.5 Зах зээлийн стратеги

Төсөл нь дараах стратегийг хэрэгжүүлэнэ:

А. Түнш болох Бридж ТББ нь хэрэглэгчидтэй холбогдоход дэмжлэг үзүүлнэ.

Б. Үйлдвэрлэгчид нь тухайн үйл ажиллагаанд эмэгтэй үйлдвэрлэл эрхэлгчдэд туслах зорилготой гэж хөрш зэргэлдээх загасны аж ахуйнуудад сурталчилна.

4. Техникийн нөхцөл

4.1 Байршил

Төсөл нь нилээн хэдэн тооны загасны аж ахуй үйл ажиллагаа явуулдаг Нарендрапюр, Шакаригати эсвэл Гаидгасид байрлаж болох юм.

4.2 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Үйлдвэрлэл явуулахад дараах тоног төхөөрөмж хэрэг болно:

Тоног төхөөрөмж	Тоо	Үнэ
Загасны тэжээлийн автомат машин	1	10000 TK
Загасны тэжээлийн гар ажиллагаатай машин	1	10000 TK
Тоног төхөөрөмжийн нийт үнэ		20000 TK

4.3 Түүхий эд

Үйлдвэр нь өдөрт 50 кг бүтээгдэхүүн гаргах бөгөөд үүний тулд дараах түүхий эдийг хэрэглэнэ.

- ☐ Хайл
- ☐ Будааны нунтаг
- ☐ Гурил
- ☐ Атаа

- ☐ Загасны хоол
- ☐ Цинкийн нунтаг
- ☐ Моласс
- ☐ Амин дэм

Дээрх түүхий эдийн нэг өдрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох загасны хоолыг бэлтгэхэд 750 ТК зарцуулна. (дараах хүснэгтийг үзнэ үү)

5.Менежментийн зохицуулалт

5.1 Менежмент

Тухайн төсөлд гурван эмэгтэй оролцоно.

5.2 Гурван эмэгтэй гурвуулаа зардал болон ашгийг тэгш хуваалцана.

6. Санхүүгийн тооцоо

Агуулга	Мөнгөн дүн /Така
6.1 Тооцоолж буй өртөг	
А. **Үндсэн хөрөнгө оруулалт**	
Техник тоног төхөөрөмж	20000
Багаж	500
Тавилга	2500
Нийт үндсэн хөрөнгө оруулалт	23000
Б. **Үйл ажиллагааны өмнөх зардал**	
Худалдаа эрхлэх зөвшөөрөл	500
Тоног төхөөрөмжийг тээвэрлэх	100
Байрны түрээсийн урдчилгаа	2000
Зах зээл дэх худалдан авагчидтай харилцаа холбоо тогтоох	2000
Нийт үйл ажиллагааны өмнөх нийт зардал	4600
Нийт хөрөнгө оруулалтын өртөг 26500	
В. **Хөдөлмөрийн капитал (сар тутмын үйл ажиллагааны зардал)**	
Түүхий эд (15 өдрийн хэрэгцээ)	9346
Цалин (хөлсний ажилчин байхгүй)/	-
Байрны зардал (түрээс, орон сууцны үйлчилгээ, цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн засвар) тээвэрлэлт, захын татвар, бусад	1355
Тоног төхөөрөмж, тавилга, багаж хэрэгслийн элэгдэл 5%	375
Нийт хөдөлмөрийн капитал/үйл ажиллагааны зардал	11076
Г. **Нийт бизнесийн үйл ажиллагааны зардал (А+Б+В)**	38676
6.2 бизнесийн санхүүгийн төлөвлөгөө	
Нийт үндсэн хөрөнгө оруулалт	27600
Үйл ажиллагааны зардал	11076
Нийт бизнесийн өртөг	**38676**
Эргэн төлөлт	
Гаднаас авах зээлийн хэрэгцээ	38676
Зээл авах байгууллага: Бридж	-
Зээлийн хэмжээ	38676
Баталгаа: хувь хүний баталгаа	38676
Жилийн хүү 15%	5801
Төлбөр хийх төлөвлөгөө (12 сар)	Сард 3181
6.3 Ашгийн дүн шинжилгээ	
Жилийн борлуулалт (нэгжээр)	27000 кг
Нэгжийн үнэ	12 ТК
Тооцож буй жилийн борлуулалтын үнэ	324000ТК

Бага:

Жилийн үйл ажиллагааны зардал	
Түүхий эдийн өртөг	243000
Байрны түрээс	3600
Үйлчилгээний төлбөр	2400
Түрээсийн татвар	375
Зах зээлийн зардал	3600
Зээлийн хүү	5801
Бусад зардал	1000
Нийт үйл ажиллагааны зардал	**259776**
Олох жилийн нийт ашиг (ТК)	65224
Тухайн бизнест оролцож буй эмэгтэйчүүдийн тоо	3
Эмэгтэй тус бүрийн жилийн ашиг	21741
Эмэгтэй тус бүрийн сарын орлого	1812

7. Бизнесийн эрсдэл

Энэхүү төсөл нь санхүүгийн хувьд бага ашиг авчирна. Тухайн төслийн үйл ажиллагаа нь жижиг байвал зээлээ эргэн төлөх боломжгүй.

8. Бизнесийн үйл ажиллгааны хамаарах хүрээ

Нарендрапюр, Шакаригати болон Гаидгасид тосгоны эмэгтэйчүүд энэ үйл ажиллагааг эрхэлж бүтээгдэхүүнээ хөрш зэргэлээх загасны аж ахуйд борлуулж болно.

9. Шаардлагатай сургалт

Дээрх эмэгтэйчүүд дараах сургалтад хамрагдах болно:

а. Загасны хоол үйлдвэрлэх

б. Загасны хоолыг хадгалах

в. Чанарын хяналт болон зарлага бууруулах арга

10. Сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа:

а. Эхний хөрөнгө оруулалтыг олох

б. Зах зээлийн холбоо тогтоох, үүнд: Жессор болон Кхюлна дах бизнестэй холбогдох

в. Сургалтын дараах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй нөхцөл байдалд бэлтгэх, бүтээгдэхүүний хэмжээг өсгөх аргачлал, чанарын хяналт

г. Нэг жилийн дараа давтан сургалтад хамарагдах

д. Үйлдвэрлэл хөгжүүлэх сургалт

е. Бизнес хөгжүүлэх сургалт

ё. Худалдан авагч болон худалдагчийн уулзалт

ж. Багаж тоног төхөөрөмж болон түүхий эдийг худалдаж авахад зөвлөж дэмжлэг үзүүлэх.

11. Дүгнэлт

Энэхүү үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд зээл авсан тохиолдолд цаашид үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байх болно. Гэхдээ эмэгтэйчүүд өөрсдийн хөрөнгө болон ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж болно.

Хавсралт 3.7. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн боломж болон нөхцөл байдлыг тодорхойлоход санал болгож буй удирдамж

1. Оршил

ОУХБ-ын ХЭЗЧДС-ын гол нөхцөл бол эдийн засаг/зах зээлийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр сургалтыг зохион байгуулах билээ. Энэ нь ур чадварын сургалт болон хөгжлийн чиг хандлагыг тухайн зах зээлийн эрэлт хэрэгцээ, бизнесийн боломжид нийцүүлэх нөхцөл юм.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэд хэдэн удаагийн хэрэгжилтээс харахад хөдөөгийн ядуурлыг арилгах нь хөдөөгийн иргэдэд, орон нутгийн болон үндэсний хэмжээний том зах зээлд нэвтрэх мэдээллээр хангах нь үйл ажиллагааны гол түлхүүр гэдэг нь илэрхийлэгдсэн. Түүнчлэн нэг чухал зүйл бол хүмүүсийн боловсрол, мэргэжлийн сургалт, ур чадварын сургалтад хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд үр дүнтэйгээр нийцэх боломжийг хязгаарладаг байна. Иймээс ХЭЗЧДС-ын арга зүй нь зах зээлийн боломж болон холбогдох судалгааны хэрэгцээг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Үүний тулд орон нутгийн нөхцөл байдалд зохицох боломжтой хэд хэдэн аргачлалыг бий болгосон байна. Үүнд:

- ☐ орон нутгийн судалгаа;
- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа;
- ☐ зах зээлийн боломжийн судалгаа.

Эдгээр судалгааны дүнг бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй харьцуулна. Тухайлбал, цаашдын өсөх чиг хандлагатай салбар, үнэт зүйлсийн гинжин холбооны дүн шинжилгээ нь бусад мэдээллийн эх сурвалжид тооцогддог байна. Дараагийн үе шат бол тодорхойлогдсон эдийн засгийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлагыг судалж хэрэгцээтэй сургалтуудыг тодорхойлох явдал юм.

2. Судалгааны зорилго

- хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа болон зах зээлийн боломжийн судалгааг тодорхой орон нутгийн хэмжээнд явуулж, зорилтод бүлгүүдийн хувьд ашигтайгаар эрхэлж болох бизнес эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэх боломжуудыг тодорхойлно;
- сонгогдсон эдийн засгийн үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгааг хийх[13];
- ОУХБ-ын ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн судалгааны асуулгыг тухайн орон нутгийн хэл дээр буулгаж хэрэглэх;
- зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр зарим эдийн засгийн боломжийг тодорхойлох, ялангуяа зорилтод бүлгүүдийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг эрэлхийлэх;
- зорилтод бүлгүүдийн цалинтай, хувиараа эрхлэх хөдөлмөрийн боломжийг эрэлхийлэх аажлын хүрээнд зах зээлд шинэ төрлийн бизнеснүүдийг эрхлэх боломжийн талаар судалгаа хийх;
- хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа, орон нутгийн нөөц бололцоо, түүхий эдийг ашиглан бий болгох, шинэ, сайжруулсан бүтээгдэхүүнийг зах зээлийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэх боломжийг судлах;
- дээр дурьдсан болон үйл ажиллагаа явуулж буй бизнест тухайн орон нутгийн зах зээлд гарах, өрсөлдөхөд нь дэмжлэг үзүүлэх;
- хөдөөгийн үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллаж, зах зээлийн холбоог хөгжүүлэх сонирхолтой жижиг, том үйлдвэрүүд, бизнесийн нийгэмлэгүүд,төрийн болон ТББ-ууд мөн бусад боломжит түншүүдийг эрэлхийлж холбох;
- эмэгтэйчүүдийн зах зээлд гарах, өөрсдийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийүүлэхэд учир ч буй бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийг арилгах талаар зөвлөмж гаргах;
- бүтээгдэхүүний үйлдвэрлэлт болон үйлчилгээг зах зээлд гаргахыг дэмжих боломжтой төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбараас үзүүлэх боломжтой дэмжлэг, хэрэгцээтэй дэд бүтцийг тодорхойлох;
- дээр дурьдсан болон бусад мэдээлэл дээр үндэслэн тодорхойлогдсон эдийн засгийн боломжийн нөхцөл байдлын судалгааг хийх /ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн нөхцөл байдлын судалгааны загварыг (Хавсралт 3.5) хэрэглээнд нэвтрүүлэх;

3.Арга зүй

- судалгаанууд нь тоон болон чанарын үзүүлэлтэд суурилсан мэдээлэлд үндэслэсэн байна. Түүнчлэн судалгаа нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх салбаруудыг ямар нэгэн байдлаар тусад нь авч үзэх байдлаар ялгаварлан гадуурхсан чиг хандлага гаргаж болохгүй. Мөн судалгаанд хамрагдагчдаас шаардлагатай мэдээллийг бодитой, үнэн зөв авахын тулд тодорхой арга хэрэгслийг ашигласан байна;

13 Энэхүү судалгааг зөвхөн ийм төрлийн судалгааг хийх бодитой туршлага, шаардлагатай мэдлэг бүхий хувь хүн, байгууллагаар хийлгэнэ.

- судалгааны үр дүнг бодитой байлгахын тулд судалгааг аль болох өргөн хүрээнд, олон хүнийг хамруулан хийнэ. Тухайлбал, судалгаанд төслийн зорилтод бүлэг, хэрэглэгч, орон нутгийн зорилтод бүлэг, борлуулагч, хоршоолол, төрийн боллон төрийн бус байгууллагын төлөөлөл зэргийг хамруулбал зохино;
- багаар ярилцлага зохион байгуулах, ганцаарчилсан уулзалт хийх зэрэг судалгааны аргуудыг тодорхойлж тухайн судалгааны өвөрмөц байдал, онцлогтой нийцүүлж хэрэглэнэ;
- судалгааны асуулгын загварыг орон нутгийн ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэгч баг болон ХЭЗЧДС-ын зөвлөлөөр хэлэлцүүлж, туршилтын журмаар хэрэглэсний үндсэн дээр бүрэн хэмжээгээр ашиглана;
- судалгааны багийг бүрдүүлэхдээ жендерийн тэгш байдлыг бий болгохыг харгалзахын зэрэгцээ зах зээлийн судалгаа хийхэд мэргэшсэн судлаачийг багийн бүрэлдэхүүнд оруулах нь чухал;
- хэрэв шаардлагатай бол судалгаан дээр ажиллах багийн гишүүдийн ур чадвар тэдний арга барилыг сайжруулах чиглэлээр тусгайлсан сургалтыг зохион байгуулж болно.

4. Үр дүн

Судалгааны тайланд дараах асуудлууд тусгагдсан байна. Үүнд:

- ☐ үйл ажиллагааны нэгдсэн дүн;
- ☐ цуглуулсан мэдээллийн дүн шинжилгээ болон судалгааны явцад олдсон онцолж авахуйц шинэ мэдээлэл;
- ☐ эдийн засгийн боломжийг дэмжих болон зах зээлд тулгарч болзошгүй бэрхшээлийг хэрхэн арилгах талаарх зөвлөмж;
- ☐ ярилцлага хийсэн тэмдэглэл/мэдээлэл цуглуулсан баримт зэргийг тусгайлан хавсаргасан байх;
- ☐ судалгааны тайлангийн эцсийн хувилбарыг гаргахаас өмнө тайлангийн төслийг ХЭЗЧДС-ын зохицуулах багт танилцуулж, шаардлагатай тодруулга өөрчлөлтүүдийг хийнэ.

5. Судлаачид тавигдах шаардлага

- зах зээлийн судалгаа явуулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх талаар мэргэшиж туршлага хуримтлуулсан байх;
- зах зээлтэй холбогдох асуудлаар онолын мэдлэг, ажлын туршлагатай байхын зэрэгцээ тодорхой зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг тодорхойлох чадвартай байх;
- нөхцөл байдлын судалгааг хийх зохих дадлага туршлагатай байх;

Хавсралт 3.8 Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны загвар асуулга

Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны асуулга

Хэрэгжих газар/орон нутаг .....

Дүүрэг/сум .....

Аймаг/ нийслэл .....

Огноо ..... **Судалгаа авсан хүний нэр** .....

1. Бараа/үйлчилгээний нэр

.....

2. Судалгаанд оролцогсод нь эдгээр бараа/ үйлчилгээний талаар ойлголттой юу ?

.....

3. Эдгээр нь дээр дурьдсан бүтээгдэхүүнүүдийг өөрсдөө үйлдвэрлэж чадах уу?

.....

4. Хэрэв чадахаар бол тэдгээр нь ямар түвшний ур чадвартай вэ?

.....

5. Дээрх ур чадварууд нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн/үйлчилгээг бий болгоход хангалттай юу?

.....

6. Хэрэв үгүй бол ямар төрлийн ур чадвар хэрэгцээтэй, эсвэл ямар төрлийн ур чадварыг сайжруулах, хөгжүүлэх, дэмжих хэрэгтэй вэ?

.....

7. Болзошгүй оролцогчид нь дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээг гүйцэлдүүлж чадах сургалтад хамрагдах сониролтой байна уу?

.....

8. Тухайн бараа/үйлчилгээг бий болгоход ямар төрлийн техник (тоног төхөөрөмж) багаж шаардлагатай вэ?

.....

9. Болзошгүй оролцогчид (эмэгтэйчүүдийг оролцуулан) дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай техник (тоног төхөөрөмж) багажийг ашиглаж чадах уу?

.....

10. Хэрэв үгүй бол тэдгээрийг ийм чадвартай болгохын тулд ямар төрлийн сургалт явуулах шаардлагатай вэ?

.....

11. Хэрэв эмэгтэйчүүд дээрх бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж чадвал зах зээлд борлуулах боломжтой байх уу?

.....

12. Хэрэв үгүй бол тулгарч байгаа бэршээл нь юу вэ?

.....

13. Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн давж гарах вэ?

.....

14. Болзошгүй оролцогчийн бизнесийн ур чадварт дутагдаж байгаа зүйл юу вэ?

.....

Зөвлөмж

I. **Хамрагдах сургалтын төрөл болон сургалтын үргэлжлэх хугацаа**
а. .....
б. .....
в. .....
г. .....

ii. Сургалтыг зохион байгуулах байршлын санал
а. .....
б. .....
в. .....
г. .....

iii. Сургалтыг зохион байгуулах зохистой цаг (эмэгтэйчүүдэд голлон)
а. .....
б. .....
в. .....
г. .....

Судалгаа хийсэн: .....

Хянасан: .....

Хавсралт 3.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох загвар (Пакистаны ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн боловсруулсан загвар)

Хувийн мэдээлэл

Нэр..... **Гэр бүлийн байдал**..... **Нас:** .....

Хүйс..... **Иргэний үнэмлэхний дугаар**.....**Нийгмийн гарал**.....

Гэрлэлтийн байдал..... **Боловсрол**.....

Үргэлжлүүлэн суралцаагүй шалтгаан .....

Боловсрол эзэмших талаар цаашдын төлөвлөгөө .....

Шуудангийн хаяг .....

Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй байгаагийн шалтгаан, эмчлэгдэх эсэх, хөгжлийн бэрхшээлийн онцлог, цаашид хэрхэх, дэмжлэг үзүүлдэг хүмүүс

.....

.....

.....

Төслийн зүгээс шаардагдах дэмжлэг (тусгай тоноглол, холбоос гэх мэт)

.....

Сонирхдог салбар болон туршлага

.....

Сонирхдог салбар болон туршлага

.....

.....

Хөдөлмөр эрхлэх /хувиараа хөдөлмөр эрхлэх талаар хийсэн оролдлогууд

1. .....
2. .....
3. .....

Үр дүн

.....

Учирсан бэрхшээл

.....

.....

.....

Ирээдүйн төлөвлөгөө (дэлгэрэнгүй ярилцана уу?)

.....

.....

.....

Яагаад?

.....

Шаардлагатай нөөц

.....

Дэмжлэг үзүүлэх хүн болон хамаарал (ар гэрээс нь нэг хүн, гаднаас нэг хүн)

.....

.....

Дээрх хүмүүсийн үзүүлдэг дэмжлэгийн төрөл

.....

Ар гэрийн талаарх мэдээлэл

Ар гэрийг ахалдаг хүн хэн бэ? (хэрэв шаардлагатай бол нэмэлт загвар хэрэглэж болно)

№	Нэр	Нас	Боловсрол	Хөдөлмөр эрхлэлт			Орлогын эх үүсвэр	Сарын орлого
				Тогтмол	Ажилгүй	Боломжоосоо доогуур ажил эрхэлдэг		
1	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
2	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
3	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
4	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
5	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
6	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
7	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
8	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
9	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
10	.....	.....	.....	☐	☐	☐	.....	.....
							Нийт	

Оршин суугаа газар

Байр..... өмчилдөг/хөлсөлдөг .....оршин суусан хугацаа .....

Хэрэв хөлсөлж суудаг бол хэр удаан тэр газар амьдрах вэ? .....

Өрөөний тоо .....

Тухайн сургалтад хамрагдагч танай гэрт байнга амьдардаг уу?

Дэд бүтэц .....

Дээвэр (төмөр/ шаазан/ модон/түр) .....

Хана (шавар/ цементэн) .....

Ундны ус (гүний худаг/ ундарга/зөөврийн) .....

Бохирын холболт (газар доогуур/ил/ холболт байхгүй) .....

Хөрөнгө

Тариалангийн газар (үхэр, шар, ямаа , шувуу, зургт, хөргөгч, дугуй, мотоцикль, трактор)

.....

Ядуурлын түвшин (маш ядуу, ядуу, арай дээр, боломжийн)

.....

Нийгмийн ажилтны дүгнэлт зөвлөмж

Сургалтын хэрэгцээ

.....

.....

.....

Сургалтад хамрагдагчийн хүсэл эрмэлзэл

.....

.....

.....

Зах зээлийн нөхцөл/боломж

.....

.....

.....

Ажлын байрны баталгаажилт/түүнийг ажлын байр/ хөдөлмөр эрхлэлтээ эхлэх гэж байгаа хүн

.....

.....

.....

Ажиглалт, зөвлөлмж болон санал

.....

.....

Дэмжигчийн гарын үсэг .....

Дэмжигчийн гарын үсэг .....

Нийгмийн ажилтны гарын үсэг .....

Огноо: .....

Ярилцлагын дүнг дахин шалгалт болон эцэслэсэн зөвлөмж

Дээр дурьдсан мэдээллийг нягталсан байдал (гар гэрийн түвшинд) .....

Ажиглалтад үндэслэсэн эцсийн зөвлөмж .....

Зах зээлийн нөхцөл/боломж .....

Ажиглалт, зөвлөмж болон санал .....

Дэмжигчийн гарын үсэг .....

Дэмжигчийн гарын үсэг .....

Төслийн ажилтны гарын үсэг .....

Огноо: .....

Санамж: .....

Сургалтад хамрагдах гэж байгаа иргэн болон хоёр дэмжлэг үзүүлэгчийн иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана уу.

Тодорхой нэг газраас/сүм, зах зэргээс гэх мэт / гэр лүгээ очих замыг зурж хавсаргана уу.

Хавсралт 3.10 ХЭЗЧДС-д хамаарах Энэтхэгт хэрэгжсэн хөтөлбөрийн санал болгож буй загвар

Сургалтын саналын загварыг хэрэгжүүлэгч түнш/ ТББ бөглөж, орон нутгийн төслийн зөвлөлөөр батлуулсны үндсэн дээр сургалтын ажилтнаар дамжуулан хөтөлбөр хэрэгжүүлэх багт уламжилсан байна.

Нэр, хаяг

.....

Сургалтыг зохион байгуулагчийн нэр .....

Хаяг .....

Холбоо барих утасны дугаар .....

2.Төлөвлөж буй сургалтын нэр, гол зорилго

Сургалтын зорилт (сонгоно уу)

☐ Шинэ үйлдвэрлэлийг бий болгох

☐ Одоо байгаа үйлдвэрлэлийг өргөжүүлэх

☐ Ур чадвар, мэргэжлийн сургалт

Дэмжих бичиг баримт (сонгоно уу)

☐ Шинэ үйлдвэрлэл бий болгох төслийн санал

Бизнесийн болон төлөвлөж буй бүтээгдэхүүн, зах зээл ба ажилчдын сургагдсан байх ажилчдын тоог товч дурьдана уу?

.....

Цалинтай хөдөлмөр эрхлэлтийн боломжийн талаар дурдана уу?

.....

3.Сургалтын тодорхой зорилтууд

I. .....

II. .....

III. .....

IV. .....

V. .....

4.Сургалтын дамжааны агуулга (техникийн ур чадварын сургалт, үйлдвэрлэлийн сургалт гэх мэт)

.....

5.Сургалтад хамрагдагчдын тоо

Эрэгтэй ..... Эмэгтэй ..... Залуус .....

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ..... Нийт сургалтад хамрагчид.....

6.Сургалтын үргэлжэх хугацаа

..... Өдөр..... Цаг

7. Сургалтыг зохион байгуулах газар/явуулах байгууллага

Техникийн ур чадвар.....

Бизнес/ менежментийн ур чадвар .....

Бусад ур чадвар .....

8. Сургалтад хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийн тоо (сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн оролцогчид)

Эрэгтэй ..... Эмэгтэй..... Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Нийт сургалтад хамрагдагчид .....

9. Урьдчилсан төсөв

(Санамж: төсвийг хөтөлбөрийн журамд нийцүүлж тогтоох бөгөөд өртөг нь сургалтад хамрагдагчдын тоо болон сургалтын үргэлжэх хугацаанаас хамаарна.)

9.1 Мэргэжлийн зохион байгуулалтын төлбөр

№	Зарлагын агуулга	Өртөг
1.	Мэргэжлийн сургагч багш нарын урамшуулал	.....
2.	Зохион байгуулагчийн урамшуулал	.....
3.	Сургагч багш болон зохион байгуулагчийн хяналтын зардал	.....
	Нийт:	.....

9.2 Сургалт зохион байгуулах байр

№	Зарлагын агуулга	Өртөг
1.	Сургалтын байрны түрээс	.....
2.	Цахилгаан/ ус/ холбоо/	.....
	Нийт:	.....

9.3 Сургалтын шууд зардал

№	Зарлагын агуулга	Өртөг
1.	Сургалтын багаж болон жижиг тоног төхөөрөмж (жагсаалтыг хавсаргах)	.....
2.	Сургалтын материал (жагсаалтыг хавсаргах)	.....
3.	Бичиг хэргийн зардал	.....
4.	Дээр дурьдсан материалыг хэвлэх, түгээх зардал	.....
5.	Сургалтад хамрагсдын замын зардал болон хоолны мөнгө	.....
	Нийт:	.....
	Нэмэх 10 % - шууд зардал, гэнэтийн зардал	.....
	Нэмэх захиргааны /түрээсийн зардал	.....
	Нийт сургалтын өртөг	.....

10. Сургалтад хамрагдагчдын оруулах хувь нэмэр

(санамж: хэрэв сургалтын зардлыг орон нутаг, үр шимийг хүрэтгсэд, төрийн бус байгууллагаас гаргаж, дэмжлэг үзүүлэх боломжтой бол туслалцаа үзүүлнэ үү.)

№	Зарлагын агуулга	Өртөг
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

11. Төлөвлөгдөж буй сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

.....

.....

.....

12. Хамтран ажиллах байгууллагуудын нэрс.

Эдгээр байгууллагууд нь сургалт болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарна. Хамтран ажиллах санамж бичиг, гэрээний хувийг хавсаргана уу.

A. .....

B. .....

C. .....

Боловсруулсан : .....

Орон нутгийн зохицуулагчийн нэр

Гарын үсэг .....

огноо:

Хянасан: .....

Төслийн удирдагч: .....

Огноо

Орон нутгийн нэр .....

Дэмжихийг санал болгосон төслийн зөвлөл .....

Зөвлөлийн гишүүн: .....

Гарын үсэг

огноо: .....

Хавсралтууд:

☐ Шинээр бий болох гэж буй нөхцөл байдлын судалгаа

☐ Ур чадвар, сургалтын модуль

☐ Багаж болон тоног төхөөрөмжийн жагсаалт

☐ Сургалт нэмэлт материал болон санхүүгийн тооцоо

IV

Оршил. I. Сургалтын дамжааны төлөвлөлт ба бэлтгэл ажил.
II. Сургалтыг явуулах. Хавсралтууд.

Сургалтын загвар, зохион байгуулалт ба сургалт явуулах

Оршил

Энэ бүлэг нь эдийн засгийн боломж болон сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр (Бүлэг III-аас харна уу) ур чадварын сургалт болон үйлдвэрлэлийг хэрхэн эрхлэхийг заах сургалтын төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөх, зохион байгуулах, явуулах талаар зааварчилгаа өгөх болно. Сургалтын хөтөлбөрийн загвар нь урьдчилсан байдлаар тодорхойлогдсон сургалтын хэрэгцээн дээр суурилагдсан байх шаардлагатай. Хавсралт хэсэг нь сургалтыг зохион байгуулах арга хэрэгсэл болон жишээ зэргийг агуулсан байх бөгөөд эдгээр нь ХЭЗЧДС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чиглэл өгөх зорилготой юм.

Сургалтын загварыг боловсруулах, хэрэгжүүлэх нь цаг, хүн хүч болон бусад нөөцийг ихээхэн шаардах ба сургалтыг явуулах шаардлагатай тоног төхөөрөмж, материал болон бусад зардалтай холбоотой. Сургалтыг зохион байгуулах орчин, нөхцөл, сургалтад хамрагдах хүмүүст жигд оролцох боломжийг олгох, үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тооцох асуудал ч чухал байна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан зарим орнуудад тусгайлсан техникийн дамжаанууд тухайлбал, цахилгаанчин, мужааны сургалтын зааварчилгааг боловсруулсан байдаг. Эдгээр зааварчилгаанууд нь сургалтыг төлөвлөх, зохион байгуулахад хэрэгцээтэй мэдээллүүдийг багтаадаг..

I. Сургалтын дамжааны төлөвлөлт ба бэлтгэл ажил

Сургалтын дамжааны бэлтгэл ажил нь хэд хэдэн гол үйл ажиллагаанаас бүрдэнэ:

1. Сургалтын дамжааны төлөвлөгөө боловсруулах

Сургалтын дамжааны төлөвлөгөөг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг, ялангуяа сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нь орон нутгийн сургалт хариуцсан зохион байгуулагчтай хамтран бэлтгэнэ. Энэхүү сургалтын төлөвлөгөө нь дамжааны зохион байгуулалтад анхааралыг хандуулах бөгөөд сургалтын арга зүйг сонгох, сургалтад шаардлагатай арга хэрэгсэл, тоног төхөөрөмж болон сургалтын материалтай холбогдох асуудлыг шийдвэрлэнэ. Сургалтын агуулгыг орон нутгийн ХЭЗЧДС-ын баг, сургагч, зааварлагчид бусад холбогдох байгууллагууд хамтран боловсруулна. Үүний дараа сургалтын зардлыг тооцно.

Сургалтын төлөвлөгөөг зохион байгуулахад дараах нарийвчилсан мэдээллийг цуглуулах шаардлагатай.

Үүнд:

- ☐ сургалтын дамжааны нэр, сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа огноо, сургалтын зорилго;
- ☐ сургалтын арга зүй, шаардлагатай сургалтын материал, арга хэрэгсэл, тоног төхөөрөмж;
- ☐ сургагчийг сонгон авч, тусгайлсан сургалтад хамруулах;
- ☐ сургалтыг зохион байгуулах газрыг сонгох;
- ☐ хамтран ажиллах байгууллагууд;
- ☐ сургалтын үнэлгээг хийх санал;
- ☐ нарийвчилсан төсөв.

➔ **Сургалтын дамжааны загварчилсан төлөвлөгөөг (автомеханик) хавсралт 4.1.-ээс харна уу.**

2. Сургагч нарыг тодорхойлох, сонгох, бэлтгэх

Бэлтгэл үе шат

Сургагчийг тодорхойлох, сонгох нь аливаа сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол түлхүүр болдог. Сургагчаар сонгогдох магадлалтай хүн нь сургалтын загварыг боловсруулах, сургалтыг зохион байгуулах явцдаа зорилтод бүлгүүдийн хэрэгцээ, онцлог зэргийг ухамсарлаж, аль болох уян байх чиг хандлагыг баримтлах ёстой. Үүний тулд сургагч нь одоо явгдаж буй дамжаанууд мөн өмнөх сургалтыг зохион байгуулагч багийн сургагч нарын үйл ажиллагаатай танилцаж болох юм. Иймд сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа одоо явгдаж байгаа дамжаадад зарим шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх, орон нутгийн сургалтын байгууллагуудаас сургагч болох боломжтой бэлтгэгдсэн хүмүүсийг сургагчаар сонгож авах бодлого баримтлах нь зүйтэй.

Гэхдээ ихэнх тохиолдолд сургалтын дамжааны загварыг шинээр бий болгох шаардлага гардаг. Иймээс сургагч нар нь тухайн сургалтын загварт нийцсэн ур чадвартай, тухайн сургалтын хөтөлбөрт дасан зохицох чадвартай байх хэрэгтэй. Түүнчлэн сургагч нь албан бус сургалтын чиг хандлагыг дагах чадвартай байхын зэрэгцээ сургалтын дараа сургалтын ашиг шимийг хүртэгчдэд үргэлжлүүлэн тусламж, дэмжлэг өгөх боломжтой байх хэрэгтэй.

Мэргэжлийн дадлага туршлагатай сургагч нар ихэвчлэн орон нутгийн сургалтын байгууллагуудаас ирдэг боловч тухайн сургалтын байгууллагууд нь сургалт явуулах чиглэлээр мэргэшсэн биш байх тохиолдол байдаг. Иймээс тохиолдолд тодорхой ур чадвар сайн эзэмшсэн хүнийг бэлтгэж сургагч болгож болох юм. Эдгээр хүмүүс нь туслах сургагч, зааварлагчийн үүрэг гүйцэтгэх боломжтойн зэрэгцээ өөрийн амьдрал дээр сурсан зүйлдээ тулгуурлан туршлага хуваалцах боломжтой байдаг юм. Сургагч нарт ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааг товч танилцуулж, орон нутгийн ард иргэдийн оролцоотой сургалт семинаруудад ажиглагчаар урьж оролцуулж болох юм. Дээрх үйл ажиллагааны дараа үйлчлүүлэгчдийг сонгож сургагчид зориулсан сургалтыг зохион байгуулна. Зөвхөн сургалтад амжилттай оролцсон сургагчийг сонгож, цаашдын үйл ажиллагаанд оролцуулна. Гэхдээ сургагч нар үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөхөөсөө өмнө уг хөтөлбөр дэх оролцоо, өөрсдийн үүрэг, хариуцлагыг бүрэн ойлгож, ухамсарласан байх хэрэгтэй.

Сургагчийн оролцоо, үүрэг хариуцлага

ХЭЗЧДС-тэй холбогдох сургалтын хөтөлбөрийн үр дүн нь сургагчийн чадвар, мэргэжлийн түвшингөөс ихээхэн хамаарна. Тэдгээр нь зөвхөн ур чадвар болон техник мэдлэг заахаас гадна сургалтад хамрагдагчдын төлөв байдал болон ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх ур чадвартай байх хэрэгтэй. Түүнчлэн, эдгээр нь эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ДОХ-ын авсан хүмүүс, бусад хэлбэрээр нийгмээс гадуурхагдсан хүмүүстэй харилцах тул нээлттэй байх хэрэгтэй.

Тухайн асуудлын хувьд мэргэжилтэн байх тул сургагч нь сургалтад хэрэглэгдэх материал болон шаардлагатай тоног төхөөрөмжийн талаар зөвлөгөө өгнө. Тоног төхөөрөмжийг авах тохиолдолд тухайн эдийг сургалтад хамрагдагчид сургалтын дараа хэрэглэнэ гэсэн тооцоотойгоор авах хэрэгтэй.

Сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа газар сургагч өөрийн биеэр очиж, нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ шаардлагатай бол багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сандал, ширээ зэргийг бүрэн байлгах арга хэмжээ авна. Түүнчлэн хичээл явуулахад нэн шаардлагатай шохой, самбар, үзүүлэн зэргийг бүрэн эсэхэд анхаарсан байх ёстой. Магадгүй сургалтын тоног төхөөрөмж, сургалт зохин байгуулах байрны нөхцөл байдлыг зарим сургалтад хамрагдагчид, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэх ч шаардлага гарч болно.

Сургагч нарын мэргэжлийн ур чадвар

Сургагчид зайлшгүй байх шаардлагатай мэргэжлийн ур чадварууд гэж бий.

Хичээлийг өөртөө итгэлтэйгээр заах. Аливаа хичээлийг заахад тухайн асуудлын талаарх туршлагаас илүү мэдлэг, ур чадвар гэж үгүй. Иймд сургагчидөөрсдийн зааж буй ур чадварыг бүрэн дүүрэн эзэмшсэн байх нь чухал. Ялангуяа сургалтад хамрагдагчдыг тухайн зааж буй ур чадварт хамаарах стандарт хэрэгцээг хангахыг чиглүүлэхэд дээрх чанар чухал юм. Сургагч нар сургалтад хамрагдагчдын суралцаж буй төлөв байдлын явцын үнэлгээ болон амжилттай төгсөх зэргийг хариуцах тул тухайн ур чадварт тавигдах стандартыг сайн мэдэж, суралцаж буй хүн бүрт бодитой үнэлгээ өгөх чадвартай байх хэрэгтэй.

Багшлах ур чадвар. Ур чадвар сайтай сургагч нь хичээл бүрийг тусгайлан бэлтгэж, сургалтад хамрагдагчдын тухайн хичээлд зарцуулсан цагийг аль болохоор үр дүнтэй өнгөрүүлхийг хичээнэ.

Хичээлийг төлөвлөнө гэдэг нь тухайн хичээлийн цагт ангид болох бүхий л үйл явдлыг төлөвлөж, ангид байгаа сурагч бүрийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн сургалтыг явуулна.

Санаачилга гаргах. Хичээлийн заахарга зүй нь тухайн хүн эсвэл хичээлийн хувьд хангалттай байж болох боловч өөр нөхцөлд төдийлөн зохистой биш байж болох юм. Сайн сургагч нь сургалтад хамрагдагчид хичээлийг ойлгохгүй байх эсвэл хичээлд сонирхолгүй хандаж байгаа эсэхийг тодорхойлж, хичээлийн явцад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах чадвартай байх ёстой. Сургагч нар хичээлийг заахад дур сонирхолтой, өөрийн эрч хүч, мэдлэг чадварыг бүрэн дайчилж, түүндээ сэтгэл хангалуун байх хэрэгтэй. Хэрэв сургагч хичээл зааж буйдаа сэтгэл хангалуун биш байвал өөрсдийн мэдлэг боловсролоо бусдад төдийлөн сайн түгээж чадахгүйд хүрнэ.

Үйлчлүүлэгчдийн талаар мэдээлэлтэй байх. Сургалтыг эхлэхээс өмнө сургагч уг сургалтад хамрагдагчид, тэдний онцлог, нөхцөл байдлын талаар сайн байх ёстой. Ихэнх тохиолдол сургагч нь төгсөлт дөхсөн үед сурагчдынхаа мөн чанар, онцлогийг анзаардаг хэдий ч энэ нь хэтэрхий оройтсон байдаг. Хамгийн энгийн арга бол сургалтад хамрагдагчдын анкеттай танилцаж, тэдний сурах явцад нөлөөлж болзошгүй онцлог зан чанарыг анхааралдаа авч сургалтыг явуулахдаа дээрх онцлогуудыг тооцоолсон байх хэрэгтэй. Онцлог чанар гэдэгт нас, бичиг үсгийн мэдлэгийн түвшин, урьд өмнө нь ийм төрлийн сургалтад хамрагдаж байсан эсэх, хэл/ярианы онцлог, шашин, хөгжлийн бэрхшээлтэй байдал болон сургалтаас хүлээж буй үр дүн,сургалтад хамрагдах болсон шалтгаан зэрэг болно. (Хүснэгт 1-ийг харна уу.)

Хүснэгт 1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХЭЗЧДС-д хамруулах Буркина Фасогийн туршлагаас

Буркина Фасод ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад олон улсын хөдөлмөрийн байгууллагаас нийт оролцогчдын доод тал 10 % нь хөгжлийн бэрхшээлтэй байх ёстой гэсэн шаардлага тавьжээ. Учир нь нийт дэлхийн хүн амын 10% нь хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцоолж ийм шаардлага тавьсан байна. Гэвч орон нутгийн хөгжлийг дэмжих түншүүд нийт оролцогчдын 16 % (125-аас 20 нь) хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байхаар сонгосон байна. Эдгээр хөгжлийн брэхшээлтэй хүмүүсээс 19 нь суунги байсан бөгөөд 1 нь липроси хэмээх өвчний улмаас бараг бүх хуруу нь дутуу байв.

Тухайн орон нутгийн ард иргэд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад нийгмээс ялгаварлан гадуурхагдсан иргэдэд боломж олгох чиг хандлага барихыг хүсэж байсан бөгөөд үүний илэрхийлэл болгон аль болохоор олон тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан байна. Хөтөлбөрийн зүгээс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс гадна нийгмээс гадуурхагдсан бусад бүлгүүдэд жигд анхаарал хандуулахыг хичээдэг бөгөөд Буркина Фасогийн энэхүү чиг хандлага нь төдийлөн түгээмэл биш юм. Төсөл нь маш амжилттай хэрэгжсний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хандах хандлагад дэвшил гарсан төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тусгайлсан нөхцөл байдлын хэрэгцээ гаргалгүйгээр сургалт өндөрлөсөн байна. Дийлэнх ур шимийг хүртэгчид нь хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлгөөний төрөлхийн хязгаарлагдмал байдалтай байсан бөгөөд ярилцлага зохион байгуулах үед хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд төдийлөн хөдөлгөөн шаарддаггүй үйл ажиллагаа, тухайлбал, нягтлан бодогчийн мэргэшлийг санал болгоход бусдаас онцолсон энэ хандлагыг хүлээж аваагүй байна.

Явцын үнэлгээ. Сайн сургагч сургалтад хамрагдагчид үнэхээр юу сурч буйгаа ойр ойрхон шалгаж байх хэрэгтэй. Үүнийг асуулт асуух, сорил өгөх, ур чадварыг шалгах аргаар гүйцэлдүүлж болно. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн шалгалтын гол зорилго нь тухайн хүнийг тэнцүүлэх, сул үнэлгээ өгөхдөө биш харин юм сурч байгаа эсэхийг бодитойгоор тодорхойлоход оршино.

3.Сургагчийг бэлтгэх

Сургагч багшийн сургалтыг ХЭЗЧДС-ын орон нутгийн сургалт хариуцсан ажилтан эсвэл ХЭЗЧДС-ын хөтөлбөрт мэргэшсэн болон албан сургалтын арга зүйг эзэмшсэн мэргэжилтэн явуулна.

Сургагчийг сонгох

Сургагчийн сургалтад дараах хүмүүсийг хамруулж болно. Үүнд:

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарах зааварлагчид. Тэдхөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх сонирхолтой, ижил төрлийн мэргэжлийн болон техникийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын багш нар (мал аж ахуйн мэргэжилтэн, малын эмч, агрономч гэх мэт) эсвэл бизнес менежментийн чиглэлээр мэргэшсэн, техникийн ур чадвар бүхий төрийн бус байгууллагын ажилтан нар байж болох юм;
- Хөтөлбөр хэрэгжиж буй тухайн орон нутгийн хөгжлийн асуудал хариуцсан холбогдох ажилтны дэмжлэг авах, хамтран ажиллах зорилгоор урьж сургалтад хамруулах боломжтой юм. Эдгээр нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтнуудтай эмэгтэйчүүдийн бүлгийн сургалт, эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэх тал дээр ойр хамтран ажиллах нь зүйтэй юм;
- Хоршооллын ажилтнуудыг оролцуулах нь сургалтад хамрагдагчдад жижиг бизнесийн менежмент, анхан шатны санхүүгийн бүртгэл заалгаж болох бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны сургалтад мөн идэвхитэй оролцуулж болох юм. Түүнчлэн техникийн зааварлагч нь техникийн зааварчилгаа өгөхийн зэрэгцээ бизнесийн ур чадварыг заах боломжтой байдгийг анхаарах хэрэгтэй;
- Банкны ажилтныг сургалтад оролцуулах нь зээлийн хүсэлт гаргах, бизнесийн зориулалттай зээл авах болон авсан зээлийг хэрхэн төлөх талаар хэрэгцээтэй мэдээллийг сургалтад хамрагдагчдад өгөх давуу талтай байж болох юм;
- Орон нутгийн худалдаачид, гар урлалын үйлдвэрлэгчдийг мөн оролцуулах зүйтэй боловч эдгээрийг өрсөлдөх боломжгүй хөрш зэргэлдээ орон нутгаас авчирах нь зүйтэй.

Сургагч нарыг бэлтгэх сургалт

Анхны сургагчийн сургалт хоёроос гурван өдөр үргэлжилнэ. Сургалтыг төлөвлөх явцад болзошгүй зааварлагч/сургагчтай урьдчилсан байдлаар уулзах нь зүйтэй. Уулзалтын явцад дараах зүйлийг тодруулах хэрэгтэй. Үүнд:

- Энэ сургагч нь ямар түвшний мэргэжлийн чадвартай вэ?
- Сургагч нь богино хугацааны, албан бус мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны талаар хуримтлуулсан туршлагатай эсэх, урьд нь энэ чиглэлээр ажиллаж байсан болов уу?
- Сургагч нь хувиараа бизнес эсвэл жижиг үйлдвэрлэл эрхэлж байсан болов уу?
- Тэд яагаад ХЭЗЧДС-ын хөтөлбөрт оролцох сонирхолтой байгаа юм бол?

Агуулга

Сургалтад хамрагдах сургагч нарын тоо 10-15 байх ёстой. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургагчийн сургалтын хэсэг нь ХЭЗЧДС-ын арга зүй, сургалтын материал бэлтгэх үйл ажиллагааг хамарсан байна. Хоёрдугаар хэсэгт бизнесийн суурь мэдлэг заагдах бөгөөд ингэснээр сургагч нар төгсөгчдөд сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд хэрхэн бизнес эрхэлэх, үйл ажиллагааг явуулах, үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх, хөгжүүлэх талаар зөвлөмж өгөх чадвартай болно.

Бүх сургагч нар сургалтын хоёр хэсэгт хоёуланд нь оролцсон байх нь чухал. Мэдлэг, туршлагаас хамааран сургалтын явцад бизнес менежментийн хичээл заах боломж хязгаарлагдмал байх болно. Орон нутгийн худалдаачид худалдаа эрхлэх үйл ажиллагааны техник ур чадварын талаар заахын зэрэгцээ бизнес менежментийг ч заах боломжтой байдаг. Сургагчийн сургалт нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрднэ.

Үүнд:

- ☐ оршил, дамжааны зорилго, ХЭЗЧДС-ын арга зүйн талаарх танилцуулга, зааварлагчийн үүрэг оролцоо;
- ☐ зааварлах үйл ажиллагааны зорилго;
- ☐ сургалтын төлөвлөгөөг бэлтгэх;
- ☐ албан бус сургалтын арга зүй;
- ☐ сургалтын материал бэлтгэх;
- ☐ сурагчдын сургалтын ажлыг шалгах;
- ☐ жендер, хөгжлийн бэрхшээл болон ялгаварлан гадуурхагдсан асуудалтай хэрхэн харьцах;
- ☐ сургалтын төсөв;
- ☐ бизнес менежментийн анхан шатны зарчим;
- ☐ үйлдвэрлэлийн дадлага;
- ☐ бүлгээр ажиллах менежмент;
- ☐ тайлан гаргах.

➔ **Сургагчийн болон анхан шатны зааварчлах арга зүйн удирдамжийг Хавсралт 4.2-оос харна уу.**

4. Сургалтад хамрагдагчдыг сонгох

Сургалтад хамрагдагчид/үйлчлүүлэгчдийг цаашид жижиг үйлдвэрлэл эрхлэх боломж,цалинтай хөдөлмөр эрхлэх боломжийг нь харгалзсан шалгуур үзүүлэлтийн үндсэн дээр сонгоно. Шалгуур үзүүлэлт нь хүсэл зориг, эрмэлзэл, чадвар, дадлага туршлага, оршин суугаа болон зэргэлдээх орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн боломжийн талаар мэдлэг, үйлдвэрлэлийг ойлгох, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх нөөц, цалинтай хөдөлмөр эрхлэлтийг хийх чадвар зэрэг хамаарах болно.

Шалгуур үзүүлэлтийн зүйл бүрт хамаарах үнэлгээ нь зорилтод бүлгийн ерөнхий чиг хандлагатай нийсэн байх нь зүйтэй. Жишээ нь, хэрэв зорилтод бүлгийн гишүүд нь сургууль төгссөн залуу эмэгтэйчүүдээс бүрдэж байвал, тэдгээр нь бизнес эхлүүлэх хөрөнгө оруулалтын нөөцтэй байх эсвэл тухайн төлөвлөсөн бизнесд хамаарах туршлагатай гэдэг нь эрэгэлзээтэй байх болно. Шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхийг үнэлэхэд хэрэв ажлын туршлагыг үнэлэмжийн оноо бага байвал хөтөлбөрийн зорилтыг ойлгож ухамсарлаж байгаа чиг найдлага нь илүү өндөр оноо авах боломжтой.

Хүсэлт гаргах загвар нь суралцах хүсэлт гарах хүсэлтэй хэн ч бай орон нутгийн ХЭЗЧДС-ын багаар дамжуулан хүсэлтээ уламжлах боломжтой байлгахаар тооцож, хүртээмжтэй байх ёстой.

Хэсэг бүлэг хүн, хувь хүн дангаараа ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаснаас үл хамааран сонгох үйл ажиллагаа нь нэг л маягаар хийгдэх ёстой. Гэхдээ сонгон авахад тавигдах шалгуур үзүүлэлтүүд нь өөр өөр байдаг тул дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ☐ тухайн баг хэдий хугацаанд оршин тогтнож байгаа;
- ☐ тухайн багийн дотоод ардчилал болон манлайлал;
- ☐ багийн үйл ажиллагааны цар хүрээ (эдийн засгийн үйл ажиллагаа, уулзалт, цуглаан гэх мэт);
- ☐ багийн дотоод дүрэм байгаа эсэх, байнгын үйл ажиллагаатай хамтын хадгаламжийн хөтөлбөр;
- ☐ гишүүдийн тоо (15-аас дээшгүй) болон ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамрагдах сонирхол. Жижиг багуудын менежментийг хийхэд илүү хялбар байдаг.

Дээрхээс гадна дараах хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- **Тухайн оролцогчдийн уг хөтөлбөрт хамрагдах чин эрмэлзэл**: Тэдний зүгээс төлөвлөж буй бизнесийн хувьд ямар хувь нэмэр (материаллаг эд зүйлс, бэлэн мөнгө, хөдөлмөр) оруулах боломжтой вэ?
- **Чадвар болон туршлага**: Сургалтад хамрагдаж буй бүлэг зээлийн менежмент хийх чадвартай юү?
- **Бизнесийн санаа**: Сургалтад хамрагдаж буй бүлэгт хэрэгжүүлэхүйц бизнесийн санаа байна уу? Тэд зах зээл, нийлүүлэлт, эрэлт хэрэгцээний талаар тодорхой мэдлэгтэй байна уу?
- **Нөөц**: Бүлгийн хувьд хүний, хөрөнгийн, материаллаг, тоног төхөөрөмжийн болон капиталын нөөц бий юу?
- **Мэдээлэл болон сүлжээ**: Ямар ажлын боломж тухайн бүлэгт хүртээлтэй байж болох вэ? Ямар сүлжээ, үйлчилгээг тухайн бүлэг зохион байгуулж эсвэл хамтран ажиллах боломжтой вэ?

5. Хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын материал бэлтгэх

Сургалтын дамжаанд хэрэглэгдэх хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон сургалтын материал зэрэг асуудал сургагчийн сургалтын явцад яригдаж, тэдгээрийг хэрхэн боловсруулах, юуг анхаарах талаар зөвлөгөө, зааварчилгаа өгөгдсөн байх хэрэгтэй ба ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтнууд нь сургагч нарт дээрх баримт бичгүүдийг эцэслэн боловсруулахад тусална.

Ихэвчлэн, сургалтын *модулиар* чиг хандлага илүү тохиромжтой байдаг.Дээрх сургалтын багц нь харилцан хамаарал элементүүдээс бүрэлдсэн байх бөгөөд эдгээр нь нэгтгэгдэж нэг сэдэв болохоор тооцогдсон байна. Модулиар чиг хандлага нь уян байдаг бөгөөд энэ нь тухайн сургалтад хамрагдагч бүрийн онцлогт тохирсон байдлаар сургалтыг хүргэх боломжийг бий болгосон байдаг. Ингэснээр сургалтад хамрагдагчдад шаардлагатай ур чадвараа олж авахад харьцангуй хялбар байх болно.

Зарим тохиолдолд өмнө нь явуулж байсан сургалтын материалыг ашиглаж болох ба материалыг ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн үндсэн материал болгож болно. Бүрэн төгс, бэлэн сургалтын модуль байх магадлал багатай. Дээр дурьдсан сургалтын материалууд нь хот суурин газрын үйлдвэрлэлийн дамжааны сургалтын материалд суурилсан байх бөгөөд энэ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тухайн орон нутгийн хэрэгцээнд нийцэхгүй байж болох талтай. Иймээс шинэ материал боловсруулах хэрэг гарна. Нэгэнт хөдөөгийн иргэдэд зориулагдсан хөтөлбөр боловсруулагдсан байхад дараа дараагийн тохиолдолд бусад хөдөө орон нутагт ялимгүй засвартайгаар эдгээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, материалыг дахин ашиглах боломжтой юм.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг боловсруулах явцад дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг хүмүүсийн тодорхой хэрэгцээнд нийцүүлж уян хатан, өөрчилж болохуйцаар хийх;
- Сургалтын чиг хандлага нь суралцагч төвтэй байх ба сургалтад хамрагдагчийн нас, боловсрол, дадлага, ур чадварын түвшин, мөн хөдөлмөр эрхлэх боломжийг харгалзсан байх;
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа тухайн оролцогчийн түвшин болон менежментийн чадварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр түүний цаашдын хэрэгцээ шаардлагыг харгалзсан байна. Тухайн зорилтод бүлэгт ямар ур чадвар дутагдаж байгаа талаарх мэдээллийг зах зээлийн боломжийн судалгаа болон сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны дүнгээс харж болно;
- Сургалтын хөтөлбөр нь нэн шаардлагатай тодорхой нэг салбарт хэрэглэхүйц ур чадварыг хэрэглэхэд чиглэгдсэн байх;
- Ярилцлага, үзүүлэх сургалт, жүжигчилсэн тоглолт, нөхцөл байдлын дүн шинжилгээ, дасгал, багаар болон ганцаарчлан илтгэл тавих, үйл ажиллагаа явагдаж буй газарт очих, туршлага солилцох зэрэг албан бус сургалтын аргуудыг хослуулан хэрэглэх;
- Онолын мэдлэгээс илүүтэйгээр практикийг илүүд үзэх. Үүний тулд практик сургалт нь нийт сургалтын 82 хувь байх бөгөөд онолын сургалтын 20 хувийг эзлэхээр тооцож хэрэгтэй.

Онолын сургалтаар тухайн үйл ажиллагаатай холбогдох зарчмын асуудлуудыг тайлбарлаж өгөх бөгөөд практик сургалт нь тухайн бүтээгдэхүүнийг хэрхэн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон зах зээлтэй танилцах, бизнес төлөвөлгөө зохиох, үйлдвэрлэлийн дадлагаас бүрдэнэ.

➔ **Сургагчийн ур чадварын сургалтын төлөвлөгөө бэлтгэх зааварчилгааг хавсралт 4.3-аас харна уу.**

➔ **Ур чадварын сургалтын төлөвлөгөөний загварын загварыг хавсралт 4.4.-өөс харна уу.**

II. Сургалтын зохион байгуулалт

1. Үйлчлүүлэгчийн сургалт

Энэхүү сургалт нь үйлчлүүлэгч буюу сургалтад хамрагдагчдад бизнес эрхлэх, цалинтай хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадварыг олгох зорилго агуулна. Сургалтын хөтөлбөр нь нөхцөл байдлын судалгаа, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа, үйл ажиллагаааны дүн шинжилгээ зэрэг дээр үндэслэн тухайн үйлчлүүлэгчийн ирээдүйн үйл ажиллагааг эрхлэх салбарт хэрэгцээтэй ур чадварыг өгөхөөр боловсруулагдсан байна. Сургалтад хамрагдсаны дараа үйлчлүүлэгч нь бизнесийн төлөвлөгөөтэй байхын зэрэгцээ үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай эхний хөрөнгө оруулагчийг бэлдсэн байна. Сургалтын явцад үйлчлүүлэгч нь тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүхий л техникийн ур чадварыг олж авсан байна. Цалинтай хөдөлмөр эрхлэлтийг зорилгоо болгосон үйлчлүүлэгч нь орон нутгийн компаниуд эсвэл хөдөлмөр эрхлэлтийн сүлжээнүүдэд хамрагдсан байна. Сургалтын үргэлжлэх хугацаа нь тухайн дамжааны агуулга, бизнесийн төрөл, сургалтын төрөл зэргээс хамаарна.

Сургалтын төрөл

Менежментийн анхан шатны сургалт нь бүх сургалтуудын хэсэг байх бөгөөд үүний үр дүнд бизнес төлөвлөгөө боловсруулах ур чадвартай болно. Энэ сургалтыг холбогдох төрийн байгууллагууд, сургалтын байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна. Сургалтын зохион байгуулах газар нь бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, төрийн байгууллага эсвэл сургалтын байгууллага байж болно. Сургалтыг албан бус нөхцөл байдалд сурагч төвтэйгөөр явуулах ба сургалтын хөтөлбөр нь тодорхой үйлчлүүлэгчийн хэрэгцээ бүрд нийцсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэрхэн явуулах талаар тусгасан байна. Сургалтын үед бизнес явуулах нэн шаардлагатай ур чадвар, туршлага солилцох, үйлчилгээг явуулах, бизнесийн төлөвлөгөөг зохиох зэргийг заана.

Үйлдвэрлэлийн дадлага, сургалтын дарааx дэмжих үйл ажиллагаа нь сургалтын салшгүй хэсэг байх бөгөөд төгссөний дараа уг үйл ажллагааг үргэлжүүлэн явуулах бөгөөд дор хаяж 6 сарын туршид эдгээр үйл ажиллагаа үргэлжилнэ. (Бүлэг VI-д энэ талаар дэлгэрэнгүй дурьдсан болно)

Үйлчлүүлэгч нь хэрэгцээтэй техникийн, бизнесийн наад захын ур чадвараа хөгжүүлэх явцад сургагч багш нь байнгын анхаарал, хяналт тавьж байх болно.

Сургалт нь сургагч багш, сургалтад хамрагдагчийн сургалтыг бүрэн дүүргэсэн гэсэн баримтад гарын үсэг зурахаас нааш дууссан гэж тооцогдохгүй. Сургалтад хамрагдагч гарын үсэг зурна гэдэг нь өөртөө хэрэгцээтэй ур чадварыг шаардлагатай түвшинд хүртэл эзэмшсэн гэсэн үг юм.

Сургалтын явцад сургалтад хамрагдагч нөхцөл байдлын судалгаагаар тодорхойлогдсон цаашид эрхлэх үйл ажиллагаатай нь холбогдох бараа/үйлчилгээг гүйцэтгэж чадна гэдгээ тодорхойлох ёстой. Хэдхэн долоо хоногийн дараа суралцагч хувиараа хөдөлмөр эрхлэнэ гэдгийг мэдэж байгаа тул сургагч багш нь аливаа асуудалд хариуцлагатайгаар хандах, шийдвэр гаргах, ур дагаврыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгосон байна. Үйлчлүүлэгчийн сургалтын эцсийн үе шатанд хийсэн бүтээгдэхүүнийг зах зээл дээр гарган борлуулж болох ба төгсөгчид зах зээлийн ур чадвар болон тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан мөнгийг эргүүлж олох боломжийг олгоно.

Суралцагч нь сургалтын явцад бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд суралцахын зэрэгцээ, бизнес эхлүүлэх, бизнесийн зөвшөөрөл авах бизнесийн үйл ажиллагаа явуулах, байр түрээслэх, орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж болон түүхий эдийг хэрхэн олж авах талаар тодорхой мэдлэг олж авсан байх хэрэгтэй. Шаардлагатай бол түүнд банкны данс нээж хөрөнгө мөнгөө зарцуулах, хяналт тавих ур чадварыг ч мөн сургана. Зарим тохиолдолд суралцагч нь зөвхөн тодорхой техник ур чадварт суралцаж, сургалтын дараа хөдөлмөр эрхлэх зорилттой байж болно. Ийм тохиолдолд сургагч багш нь тухайн үйлчлүүлэгчийн боломжид нийцүүлэн онолын болон практик мэдлэгийг сайжруулахад анхаарал хандуулна. Хувиараа хөдөлмөр эрхлэх суралцагчийн хувьд сургагч багш болон суралцагчийн гарын үсэг нь тэрээр цаашид хувиараа хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадварыг бүрэн эзэмшсэн, хөдөлмөр эрлэх бүрэн боломжтой болсон гэдгийг илэрхийлж гарын үсэг зурна.

2. Бүлгийн сургалт

Бүлгийн сургалт нь ерөнхийдөө ганцаарчилсан сургалттай төстэй байна. Сургалтын явцад тухайн бүлгийн бүх гишүүдэд техникийн ур чадвар заах шаардлагагүй байж болох юм. Гэхдээ цаашдын үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэх гишүүдийн сургалтад ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй. Харин бүлгийн бүх гишүүд бизнес менежментийн ур чадварыг жигд эзэмшсэн байх хэрэгтэй.

Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны онцлогоос хамааран бүх гишүүдийг ур чадварын сургалтад хамруулахгүй байж болно. Жишээ нь, бараа борлуулах үйл ажиллагаа эрхлэх бүлэгт техникт суралцах шаардлагагүй. Учир нь бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхгүй, зөвхөн дамжуулан борлуулах үйл ажиллагаа эрхлэх юм. Үүнтэй адил

багийн үйл ажиллагаан дээр суурилсан бизнес эрхлэхэд хүн бүр тусгайлсан үүрэг оролцоотой тул үүргээ биелүүлэх ур чадвартай байх хэрэгтэй ба хүн болгоны онцлогт нийцсэн сургалтын төрөл, үргэлжлэх хугацааг шаардана.

3. Жендерийн асуудал

Хэдийгээр хөрөнгийн хязгаарлагдмал байдал, шаардлагатай бизнес, ур чадварын сургалт, зах зээлд оролцох хязгаарлагдмал боломж гэх мэт эрэгтэй, эмэгтэй үйлдвэрлэгчдэд тулгардаг түгээмэл бэрхшээлүүд байдаг ч эмэгтэйчүүдэд эдгээр бэрхшээлүүдээс гадна нийгэм эдийн засгийн, соёлын, зан заншилтай холбогдох бэрхшээлүүд давхар тулгардаг. Эдгээр асуудлуудыг сургалтын явцад хэлэлцэж, нөхцөл байдлаас хэрхэн гарах талаар авч үзсэн байх хэрэгтэй. Иймд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн арга зүйн жендерийн асуудалд тусгайлан нэг бүлэг зориулсан болно.

ХЭЗЧДС-ын арга зүй нь дээрх асуудалд онцгойлон анхаарч үздэг байна. Орлогыг бий болгох үйл ажиллагаанд чиглэгдсэн эмэгтэйчүүдийн бүлгүүд нь тухайн орон нутгийн санхүү, техник нөөц бололцоо, сургалтын бүтцийг бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой. Эдгээр бүлгүүд өөрсдийн төсөл/ үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбогдох асуудалд шийдвэр гаргах, санал бодлоо илэрхийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Нэгдсэн нэг зорилго, нийгэм эдийн засгийн ойролцоо нь эдгээр эмэгтэйчүүдийг нэгдэж хамтран ажиллахад хүргэдэг байна. Түүнчлэн туршлагаас харахад багийн үйл ажиллагаан дээр суурилсан чиг хандлага нь жижиг бизнес хөгжүүлэхэд хэрэгцээтэй зээл тоног төхөөрөмжийг авах, шаардлагатай технологийг нэвтрүүлэхэд илүү үр дүнтэй.

Дээр дурьдсанчилан ХЭЗЧДС-ын сургалтын арга зүй нь эмэгтэйчүүдийн багийн гишүүдэд сургалт хүргэж болохоор хийгдсэн байдаг. Гол ялгаа нь сургалтыг зохион байгуулах газрын байршил байдаг. Хөдөөгийн эмэгтэйчүүд тэдгээрийн ар гэрт гүйцэтгэх үүрэг, оролцооноос хамааран хол зайнд явж олон цагаар суралцах боломжгүй байдаг. Иймээс тэдгээрт зориулсан сургалтын үйл ажиллагаа нь гэрт ойр байлгахын зэрэгцээ цөөхөн цагаар оруулж байх нь зүйтэй.

Эмэгтэйчүүдэд зориулсан хичээлийн цаг нь цөөн байхын зэрэгцээ арай урт хугацаанд төлөвлөгдсөн байна. Сургалтад хамрагдагчидтай урьдчилсан байдлаар тохиролцож, хамгийн боломжтой цагийг сонгох хэрэгтэй. Түүнчлэн туршлагаас харахад эмэгтэйчүүд нь үдээс хойшхи сургалтад оролцох сонирхол их байдаг (Үдээс өмнө гэр орны ажлаа амжуулсны дараа) бөгөөд сургалтыг зах ажилладаг өдөр эсвэл хүүхдүүдийн хичээлийн улирал эхлэх үетэй давхцуулахгүй байх нь зүйтэй юм.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Бүхий л орон нутаг, зорилтод бүлгүүд нь хөгжлийн бэршээлтэй иргэдтэй байх бөгөөд иргэд ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт бусадтай адилхан оролцох эрхтэй. Эмэгтэйчүүдийн бүлгийн хувьд тусгайлсан нөхцөл байдал шаардлагатай байдгийн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч мөн тодорхой нөхцөл шаардагддаг. Хөдөлгөөний бэрхшээлтэй боломжгүй, тэргэнцэртэй иргэд тээвэрлэлт болон сургалтын байруудад орох гарахад бэрхшээлтэй байдаг. Харин сонсголгүй хараагүй иргэдийн бэрхшээл нь өөр байдаг бөгөөд тэдгээрийн шаардлага хэрэгцээ нь мөн л өөр байдаг. Түүнчлэн сэтгэл санааны болон мэдрэлийн согогтой хүмүүс ч бас л өөр төрлийн хэрэгцээ шаардлагатай байдаг байна. Дээр дурьдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд хэрхэн хандах талаар 8-р бүлэгт дэлгэрэнгүй дурьдсан болно.

Сургагч багш нар нь хөгжлийн бэрхшээлийн асуудалд мэдрэмжтэйгээр хандаж, орон нутгийн бүлэг, тухайн асуудлаар мэргэжсэн төрийн бус байгууллагаас шаардлагатай тусламж дэмжлэгийг авч ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхтэй оролцуулахад санаачилга гарган идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Тэд нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлага, ялгаварлан гадуурхах, сөрөг үйлдэл гаргах зэрэг үзэгдлүүд байдгийг анхаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэхэд илүү ажиллах хэрэгтэй. Учир нь нийгмийн хандлага нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг өөрийгөө доогуур үнэлэх, өөртөө итгэлгүй байх, өөрийгөө голох зэрэгт хүргэдэг байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд явагдах сургалтын явцад тэдэнд урам хайрлах, зоригжуулахын зэрэгцээ өөртөө ур чадвартаа итгэлтэй байх хандлагыг бий болгох хэрэгтэй.

Энэхүү гарын авлагын 8-р бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд хамаарах анхан шатны ойлголт болон сургагч багш нарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтыг хэрхэн явуулах талаар аргачлал, зөвлөмжийг агуулна.

5. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Сургалт болох газартай биечлэн танилцах

Сургагч багш нь сургалт болохоос хэд хоногийн өмнө очиж биечлэн танилцаж, шаардлагатай тодорхой нөхцлүүд болон хэрэгцээтэй зохицуулалтыг хийх эсэхийг шийдвэрлэнэ. Сургагч багш нь сургалт зохион байгуулах байранд хангалттай зайтай, хэрэгцээтэй ширээ, сандал зэрэг сургалтад хамрагдагчдын тоонд нийцсэн, тэргэнцэртэй болон бусад тусгай хэрэгцээтэй сургалтад хамрагдагчдын хэрэгцээнд нийцсэн байх зэрэгт анхаарал тавина. Зарим газарт аюулгүй байдлын арга хэмжээ авах шаардлагатай байдаг бөгөөд ийм нөхцөлд сургагч багш нь аюулгүй

байдлын арга хэмжээг авах талаар бодолцож үзсэн байх ёстой.

Сургалтын төлөвлөгөө

Сургагч багш нь тухайн өдөр болгоны хичээлд бэлтгэж, хичээлийг төлөвлөгөөний дагуу бүхий л хэрэгцээтэй сэдвүүдийг бүрэн хамруулсан байхаар зохион байгуулна. Сургалтад хамрагсад нь мэдлэг боловсролын хувьд төрөл бүрийн түвшинд байдаг гэдгийг харгалзан сургагч багш сургалтыг аль болохоор уян байлгахыг хичээнэ.

Дамжааг нээх

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зохицуулагч нь ихэвчлэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын дамжааг нээж, түүний зорилго, ач холбогдол, заагдах ур чадвар нь хөдөлмөр эрхлэлт болон жижиг бизнесийн үйл ажиллагааг явуулахад хэр ач холбогдолтой гэдгийг товч тайлбарлана. Үүний дараа ХЭЗЧДС-ын сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нь сургалт явуулах ерөнхий нөхцөл, дүрэм, журам болон сургалт явуулах газрыг дэлгэрэнгүй танилцуулна. Сургагч багш нарыг сургалтад хамрагдагчдад танилцуулах бөгөөд ялангуяа гаднаас ирсэн багш нарыг онцгойлон танилцуулна.

Үүнээс хойш сургагч багш нь санаачлагыг гартаа авч сургалтын үйл ажиллагааг явуулна.

➔ **Ур чадварын сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварыг хавсралт 4.5-аас харна уу.**

Сургалтын эхний өдөр ХЭЗЧДС-ын сургалтын ажилтан нь сургалтад хамрагдахаар бүртгэгдсэн хүмүүсийн ирцийг бүртгэж, сурагчийн картын нэгдүгээр хэсэгт тэмдэглэл хийнэ.

➔ **Зургаадугаар бүлгийн хяналт-шинжилгээ үнэлэгээ болон бичиг баримт бүрдүүлэх талаарх хэсгийг үзнэ үү.**

Сургалтын явцад ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын ажилтан нь сургалтын явцтай танилцаж, шаардлагатай зохицуулалтуудыг хийнэ.

Сургалтад хамрагдагчдын сурах явцад үнэлгээ хийх

Сургагч багш нь сургалтад хамрагдагчдын суралцаж байгаа байдал, амжилт зэргийн талаар тэмдэглэл хөтлөж, байнгын хяналт тавих бөгөөд энэ талаар сургалтад хамрагдагчдад мэдээлэл өгч байна.

Сургалтын тодорхой хэсэг дуусах болгонд явцын шалгалт авч байх бөгөөд энэ нь бичгийн болон аман шалгалтаас бүрдэнэ. Эдгээр шалгалтуудаас багш сургалтад хамрагдагчдын амжилт, дутагдлыг тэмдэглэж дүгнэл хийнэ. Сургалтад хамрагдагчдын сурлагын үнэлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй байдал, бичиг үсгийн мэдлэгийн түвшин зэргийг тусгайлан харгалзаж байх нь зүйтэй. Дамжаа дуусахад дараах зүйл хийгдсэн байх шаардлагатай.

- ☐ Сургалтад хамрагдагч нь холбогдох ур чадварыг эзэмшсэн гэсэн баримтад сургагч багш болон сургалтыг зохион байгуулж буй газрын удирдлага гарын үсэг зурсан байна;
- ☐ Үйлчлүүлэгч нь нөхцөл байдлын судалгаа, үнэ, борлуулалт зэрэгт суурилсан бизнес үйл ажиллааганы төлөвлөгөө хийсэн байна;
- ☐ Шаардлагатай тоног төхөөрөмж болон түүхий эдийн өртөг болон бусад холбогдох тооцоо хийгдэж дууссан байна;
- ☐ Үйл ажиллагаа явуулахад хэрэгцээтэй зохих зөвшөөрлийг авч, бүртгэлийг хийлгэсэн байна;
- ☐ Бизнесийн үйл ажиллагаа явуулах газрыг товлож, бэлтгэл ажлыг хангасан байна;
- ☐ Банкны данс нээсэн байна. (хэрэв шаардлагатай бол);
- ☐ Үйл ажиллагааг эхлэх анхны капиталыг гаргах асуудлыг зохцуулсан байна.

➔ **Сургалтын үйл ажиллагааны явцын тайланг хавсралт 4.6-аас харна уу.**

➔ **Сургалтын үйл ажиллагааны эцсийн тайланг хавсралт 4.7-оос харна уу.**

➔ **Сургалтын үйл ажиллагааны төгсөлтийн тайланг хавсралт 4.8-аас харна уу.**

Үнэлгээ дүгнэлт

Сургалтын явцад сургагч багш нь тухайн сургалт, дамжааны үйл ажиллагааг цаашид сайжруулах, илүү үр өгөөжтэй болгох талаар тэмдэглэлүүд хийнэ. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын асуудал хариуцсан ажилтан нь эдгээр тэмдэглэлүүдийг сургалтын тайланд оруулсан байна. Сургалтын сүүлчийн өдөр сургагч багш болон сургалтад хамрагчид хамтран сургалтын үйл ажиллагааг дүгнэж үнэлгээ өгнө.

ХЭЗЧДС-ын сургалтын асуудал хариуцсан ажилтан нь дээрх мэдээллүүдийг нэгтгэж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид сургалтыг илүү хүртээмжтэй үр дүнтэй болгох талаар санал боловсруулна. Сургалтын үйл ажиллагаатай холбогдох бүхий л мэдээллийг сургалтын дамжааны картанд тэмдэглэсэн байна.

Хавсралт 4.1. Сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар. Автомеханик (бензин), 312 цаг (60 өдөр)

Зорилгууд

Энэ дамжаа нь сургалтад хамрагдагчдад бензинээр ажилладаг тээврийн хэрэгслийг хэрхэн угсардаг, хэрхэн ажилладаг талаар мэдлэг өгөх бөгөөд сургалтад хамрагдагчид сургалтын явцад дээр дурьдсан тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн том жижиг гэмтлүүдийг засварлаж сурна. Сургалт дуусахад сургалтад хамрагдагчид дараах ур чадварыг эзэмшсэн байх болно. Үүнд:

- ☐ Тайрах тасдах багажийг зөв хэрэглэж сурсан (цахилгаан хөрөө, тасдагч, өрөм гэх мэт);
- ☐ Нарийн хэмжих багажийг хэрэглэж сурсан;
- ☐ Бензинээр ажилладаг тээврийн хэрэгслийн хэсгүүдийг задлах болон угсрах;
- ☐ Хөдөлгүүрийн ажиллах зарчмыг тайлбарлаж чаддаг байх ;
- ☐ Тухайн үйл ажиллагаанд хамаарах шинжлэх ухааны суурь зарчмын мэдлэгтэй байх;
- ☐ Хурдны хайрцаг хэрхэн ажилладаг талаарх онол практикийн мэдлэгтэй байх;
- ☐ Гидрийн системийн засвар үйлчилгээг хийж чаддаг байх;
- ☐ Тоормозын системийн засвар үйлчилгээг хийж чаддаг байх ;
- ☐ Биензинээр ажилладаг тээврийн хэрэгслийн тохиргоог хийж чаддаг байх зэрэг болно.

Мөн сургалтын явцад сургалтад хамрагдагчдад эх оронч үзэл, сахилга бат болон ажлын ёс зүй зэрэгт холбогдох сургалт явуулж, тэдгээрийг төлөвшүүлэхэд анхаарал хандуулна.

Цагийн хуваарь

Сургалтын цагийн хуваарь нь дараах байдлаар тооцологдсон байна.

Нийт сургалтын цаг	= 312 цаг,
Сургалт явагдах өдрүүд	= 7 хоногийн 6 өдөр
Нийт сургалт явагдах өдөр	= 52 өдөр

Энэхүү автомеханикийн дамжаа нь сургалтад хамрагдагчдад онолын болон практикийн мэдлэг олгох бөгөөд нийт сургалтын цагийн 80%-ийг практикийн мэдлэгт, 20 %-ийг онолын мэдлэгт тус тус зарцуулах болно.

Суралцахыг хүсэгчдэд тавигдах шаардлага

Боловсрол

Автомеханикийн дамжаанд суралцахыг хүсэлт гаргагчид нь дунд сургууль төгссөн бөгөөд тодорхой бичиг үсэг, тооны мэдлэгтэй байх шаардлагатай.

Хэл

Сургалтад хамрагдагчид нь тухайн үндсэний хэлийг сайн эзэмшсэн, унших, бичих бүрэн чадвартай байхын зэрэгцээ анхан шатны англи хэлний мэдлэгтэй байх шаардлагатай.

Мэргэжлийн түвшин

Мэдлэг

Автомеханик болохын тулд сургалтад хамрагдагчид нь сургалт дууссаны дараа дараах зарчмуудыг сайтар ойлгож авсан байх шаардлагатай. Үүнд:

- ☐ Холбогдох хэмжилтүүдийг хийх анхан шатны математикийн мэдлэг;
- ☐ Хэмжилтийн нарийн болон бусад багажийг ашиглах чадвартай байх (микрометр, цахим индикатор, компрессор, бусад багаж хэрэгслийг гэх мэт);
- ☐ Засварын газар байгаа багаж тоног төхөөрөмжийг зориулалтаар нь зөв ашиглах;
- ☐ Техникийн зургийг зурах анхан шатны мэдэгдэхүүн;
- ☐ Дотоод шаталтын хөдөлгүүрийн үйл ажиллагааг мэдэж байх;
- ☐ Хөдөлгүүрийн эд анги тус бүрийн зориулалтыг мэдэж байх;
- ☐ Хөдөлгүүрийн бүрэлдэхүүн хэсэг болох түлш, тослогоо, хөргөлтийн системийг мэдэх;
- ☐ Турбо болон супер нэмэгдлүүдийг мэдэх;
- ☐ Хүчлүүрийн үйл ажиллагааг мэдэх;
- ☐ Жолооны системийн үйл ажиллагааг мэдэх;
- ☐ Тоормозны систем;
- ☐ Хурдны хайрцагын систем;
- ☐ Дугуй зэргийн талаар нарийвчилсан хангалттай мэдлэгтэй байх.

Ур чадвар

- ☐ Автомеханикийн дамжааг төгсөгчид нь дараах ур чадварыг эзэмшсэн байна. Үүнд:
- ☐ Хэмжилтийн болон гар багажийг нарийвчлалтай үр дүнтэй хэрэглэж сурсан;
- ☐ Тасдах багажийг хэрэглэж сурсан (сурсан /цахилгаан көрөө, тасдагч, өрөм гэх мэт);
- ☐ Хөдөлгүүрийг хэсэгчлэн задлах угсрах;
- ☐ Цилиндрийн толгойг задлаж, угсарч хэмжилт хийх;
- ☐ Хөдөлгүүрийн голыг задлаж угсарч хэмжилт хийх;
- ☐ Хөдөлгүүрийн поршин, клапан, кольц зэргийг задлаж, угсрах;
- ☐ Хөдөлгүүрийн тос шахагч, шүүрийг задлаж угсарч чаддаг байх;
- ☐ Хөргөлтийн системийг задлаж угсардаг байх;
- ☐ Түлшний системийг задлаж угсардаг байх;
- ☐ Асаалтын системийг задлаж угсардаг байх;
- ☐ Хурдын хайрцагны бүрдэл хэсгүүдийг задлаж угсарч тохиргоог хийдэг байх;
- ☐ Хөдлөх эд ангийн задлаж угсардаг байх;
- ☐ Тоормозны системийг угсарч тохиргоо хийж чаддаг байх;
- ☐ Гидрийн системийг задлаж угсарч тохиргоо хийж чаддаг байх;
- ☐ Бинзен хөдөлгүүрийг дараах шалгах үйл ажиллагаанд таарсан тохиргоонд оруулах;
  - Оношлогоо хийх
  - Карбюраторын засвар, тохиргоог хйих
  - Аюулгүй байдлыг хангах

Ажлын байрны боломж

Сургалтад хамрагдсаны дараа сургалтад хамрагдагч нь автомеханикийн мэргэжил эзэмшсэн гэдэгтээ итгэлтэй байж ажлын байр хайна.

Сургалтад хамрагдагч одоо байгаа ажлаа үргэлжүүлэн хийх эсвэл шинэ ажлын байр хайх сонголт хийх боломжтой болсон байна. Учир нь сургалт нь түүнийг автомеханикийн (бензин) шаардлагатай бүхий л ур чадвар, онолын мэдлэгийг өгсөн байх болно.

Сургалтыг бүрэн дүүргэсэн автомеханик нь автотехникийн дараах ажлын эрхлэх боломжтой болно.

- ☐ Хувираа хөдөлмөр эрхлэх (засвар, үйлчилгээний төвүүдэд ажиллах);
- ☐ Автомашины худалдааны гэрээт төлөөлөгч болох (дилер);
- ☐ Авто сэлбэгийн үйлдвэрлэлд ажиллах;
- ☐ Хувийн засварын газар нээх;
- ☐ Авто машин үйлдвэрлэгчдийн засвар үйлчилгээний ажилд ажиллах;
- ☐ Үйлчилгээ бүхий бензин түгээгүүрийн газарт ажиллах;
- ☐ Автомашины жижиг үйлчилгээний газарт ажиллах.

Сургалтын аргачлал

Сургалтын явцад насанд хүрсэн хүнийг сургах сургалтанд төрөл бүрийн арга хэрэглэнэ. Зарим сургалтын аргачлалыг доор санал болгож байна. Үүнд:

- ☐ Онолын мэдлэг (танхмийн хичээлийн журмаар);
- ☐ Сэтгэн бодох;
- ☐ Жижиг үлгэр ажиллах үйл ажиллагаа;
- ☐ Үйл ажиллагааны холбогдолтой илтгэл тавих;
- ☐ Бодлого бодох;
- ☐ Туршлага солилцох;
- ☐ Үйлдвэрлэлийн дадлага;
- ☐ Тусгай даалгаварууд;

Дамжааны хөтөлбөр болон үргэлжлэх хуагцаа

Онолын хичээлүүд

Нийт = 62 цаг

1. Үндсэн мэдлэг (10 цаг)

- ☐ Үндсэн нэгж;
- ☐ Гар багж болон тэдгээрийн хэрэглээ;
- ☐ Хэмжилтийн төхөөрөмжүүд;
- ☐ Засварын газрын аюулгүйн ажиллагааны зааварчилгаа.

2. Засварын ширээг ашиглах (12 цаг)

- ☐ Дүүргэх, тааруулах;
- ☐ Хуурайдах/өнгөлөх;
- ☐ Өрөмдөж нүхлэх;
- ☐ Хөрөөдөх/таслах;

3. Хөдөлгүүр (15 цаг);

- ☐ Дотоод шаталтын хөдөлгүүрийн тухай ойлголт;
- ☐ Дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаа;
- ☐ Хөдөлгүүрийн 4 болон 2 дугаар үйл ажиллагааны зарчим;
- ☐ Хөдөлгүүрийн бүтэц;
- ☐ Хөргөлтийн систем;
- ☐ Тосолгооны систем;
- ☐ Асаалтын систем;
- ☐ Түлшний систем;
- ☐ ИФАЙ систем;
- ☐ СИНДЖИ систем;
- ☐ Яндан болон утаа гадагшлуулах;
- ☐ Хөдөлгүүрийн гэмтэл, оношилгоо, туршиж ажиллуулах.

4. Хурдны хайрцаг болох хүч тамжуулах (12 цаг);

- ☐ Араа;
- ☐ Хурдны хайрцаг;
- ☐ Тахир гол;
- ☐ Диферециал;
- ☐ Явах анги, дугуй.

5. Их бие, удирдах/жолооны механизм болон тормоз (13 цаг)

- ☐ Доргилт багасгагч /амартизатор;
- ☐ Даац/пүрш/ нум;
- ☐ Энгийн жолооны механизм;
- ☐ Хүчлүүртэй жолооны механизм;
- ☐ Механик тормоз;
- ☐ Паскалийн хууль;
- ☐ Гидро тормоз;
- ☐ Мастер цилиндр;
- ☐ Хүчлүүртэй тормоз.

Практик хичээлүүд

Нийт = 250 цаг

1. Ерөнхий мэдлэг (20 цаг)

- ☐ Багаж, хэрэгсэлийг хэрэглэх зааварчилгаа (түлхүүр, бахь, атвёртк, өргөгч, тасдагч гэм мэт)
- ☐ Хэмжүүрийн багаж тоног төхөөрөмжүүдийг хэрэглэх зааварчилгаа(микрометр, мультиметр, цахим тоолуур гэх мэт)

2. Засварын ширээг ашиглах (25 цаг)

- ☐ Дүүргэх, тааруулах;
- ☐ Хуурайдах/өнгөлөх;
- ☐ Өрөмдөж нүхлэх;
- ☐ Хөрөөдөх/таслах.

3. Хөдөлгүүр (30 цаг)

- ☐ Циллиндрийн блокуудыг шалгах хэмжих;
- ☐ Цилиндрийн толгойг шалгаж хэмжих;
- ☐ Цилиндрийн толгойны жийргэвч солих;
- ☐ Цилиндрийн толгойны боолтыг чангалж суллах;
- ☐ Хөдөлгүүрийн поршиныг солих;
- ☐ Поршиныг солих суурилуулах;
- ☐ Поршины тохиргоог хийх;
- ☐ Хөдөлгүүрийн голыг солих;
- ☐ Хөдөлгүүрийн голын тохиргоог хийх;
- ☐ Ремен/гинжийг солих;
- ☐ Ремен /гинжний тохиргоог хийх;
- ☐ Асаалтыг эргэлтийг тааруулах;
- ☐ Хөргөлтийн системийн эргэлтийг тааруулах;
- ☐ Хөргөгч, термостат, помпны засвар үйлчилгээ;
- ☐ Хөдөлгүүрийн тос солих;
- ☐ Хөдөлгүүрийн шүүлтүүр солих;
- ☐ Хөдөлгүүрийн тосолгооны цэгүүд;
- ☐ Утаа гадагшлуулах систем;
- ☐ Хөдөлгүүрийг задлах угсрах дадлага.

4. Түлшний систем (25 цаг)

- ☐ Карбютраторын засвар үйлчилгээ;
- ☐ Механик болон цахилгаан бензиний шахуурга;
- ☐ Цахилгаан бинзен шахуурганы эд ангиуд болон түлш тооссруулах механизмын төрлүүд;
- ☐ Оношлогооны кодуудыг тайлж унших;
- ☐ Карбюратортай хөдөлгүүрийн эвдрэл оношлогоо, засвар үйлчилгээ.

5. Хөдлөх анги

- ☐ Арааг засах тохиргоо хийх;
- ☐ 4 хурд бүхий хурдны хайрцагны засвар үйлчилгээ;
- ☐ Хурдны хайрцагны хэсгүүдийг салгах угсрах;
- ☐ Хурдны хайрцагны тохиргоо.

6. Руль, тоормоз болон даац (25 баг)

- ☐ Доргилт сааруулагчийг салгах угсрах болон шалгах;
- ☐ Залуурын гидрийн механизм;
- ☐ Өндгөн тулгуур болон бусад холбоосууд;
- ☐ Залуурыг тэнцвэржүүлэх;
- ☐ Залуурны тохиргоог хийх;
- ☐ Тоормозны гишгүүрийг тохиргоо;
- ☐ Гидрийн системийн үйлчилгээ;
- ☐ Тоормозны хий авах;
- ☐ Хүчлүүртэй тоормозны үйлчилгээ;
- ☐ Тоормозны накладканий тохиргоо.

7. Хөдөлгүүрийг шалгах болон хэмжилт хийх (25 цаг)

- ☐ Хөдөлгүүрийн бэтүүмжлэлийг шалгах;
- ☐ Хөдөлгүүрийн даралтыг шалгах;
- ☐ Хөдөлгүүрийн утааг шалгах;
- ☐ Хөдөлгүүрийг шалгах хэмжилтийн багажтай ажиллаж сурах.

8. Засвар үйлчилгээний орчин (25 цаг)

- ☐ Автомашины үйлчилгээ болон тосолгоо;
- ☐ Засварын газрын бүртгэл, дотоод журам.

Үйлдвэрлэлийн дадлага (25 цаг)

Нэг долоо хоногийн туршид сургалтад хамрагдагчид нь хүлээн зөвшөөрөгдсөн стандартын шаардлага хангасан мэргэжлийн байгууллагад үйдвэрлэлийн дадлага хийнэ.

Бизнесийн менежментийн ур чадварын сургалт

Сургалтын хөтөлбөрийн нэгээхэн чухал хэсэг бол 4 өдрийн бизнес менежментийн ур чадварын сургалт юм. Үүний зорилго нь сургалтад хамрагдагчдыг жижиг үйлдвэрлэл эрхлэхэд хэрэгцээтэй бизнес менежментийн наад захын мэдлэгтэй болгоход оршино. Энэ бизнес менежментийн сургалт нь дараах агуулгатай байна. Үүнд:

- ☐ бизнес менежментийн ур чадварын сургалт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үндсэн зарчим;
- ☐ жижиг бизнесийг хэрхэн эхлүүлэх вэ?- бизнес төлөвлгөөг бэлтгэх;
- ☐ бизнесийн зохицуулалт;
- ☐ бизнес/ үйлдвэрлэлийн үйл ажиллагааны амжилт болон дампуурал;
- ☐ бизнесийг хэрэгжүүлэх эхний жилд олж авсан туршлагууд;
- ☐ жижиг бизнесийн үе шат;
- ☐ эхний шатанд юу чухал вэ?
- ☐ таны бизнес мөнгө хийх үү?
- ☐ зах зээл болон үйлдвэрлэлийг өргөжүүлэх;
- ☐ төсөл бүрийн санхүү техникийн онцлог;
- ☐ нягтлан бодох болон санхүүгийн менежмент.

Шалгуур үзүүлэлт

Сургалтад хамрагдагчдыг сонгож авахдаа бичиг үсгийн мэдлэг, хэлний чадвар, гэр бүлийн орлого, өрхийн гишүүдийн тоо, гэр бүлийн бусад гишүүдийн мэргэжил, тогтвор суурьшилтай байдал, өрхийн дэд бүтэц, ядуурлын түвшин, өмнө нь хийж байсан оролдлогууд, ирээдүйн төлөвлөгөө, шаардлагатай нөөц байгаа эсэх, сургалтад хамрагдагчийг тодорхойлсон байдал, хүсэл эрмэлзэл, оршин суугаа газрын зах зээлийн чиг хандлага, хөдөлмөр эрхлэлтийн боломж зэргийг харгалзана.

Сургалтыг зохион байгуулах газар

Сургалтыг зохион байгуулах газар нь эрэгтэй болон эмэгтэй сургалтад хамрагдагчдын шаардлагатай наад захын зүйлээр хангагдсан байна. Амьдрах өрөөнд хоёр хүн хэрэв боломжгүй бол гурван хүн хамтран байж болно. Түүнчлэн сургалтын байранд дараах үйлчилгээг үзүүлэх болмжтой байна. Үүнд:

- ☐ өглөөний цай;
- ☐ үдийн цай;
- ☐ өдрийн хоол;
- ☐ оройн хоол;
- ☐ индүү;
- ☐ сонин;
- ☐ нийтийн өрөө;
- ☐ мөргөл үйлдэх газар;
- ☐ усны өрөө;
- ☐ халуун ус (хүйтний улиралд).

Байранд амьдарч байгаа сургалтад хамрагдагчдад дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

Өрөөнд тамхи татахыг хориглоно, 18 болон түүнээс дээш насны сургалтад хамрагдагчид нь зөвхөн зориулалтын газар тамхи татна.

Дараах эрүүгийн гэмт хэргийн шинж чанартай үйлдлүүдийг хийх.

- ☐ хориотой мансууруулах бодис хэрэглэх;
- ☐ бусадтай зүй бусаар харьцах;
- ☐ насанд хүрээгүй бол тамхи татах;
- ☐ хулгай хийх;
- ☐ нийтийн өмчийг сүйтгэх;
- ☐ хог хаях;
- ☐ мөрийтэй тоглох;
- ☐ хууль бус цуглаан болон арга хэмжээ зохион байгуулах;
- ☐ зодолдох.

Дээрх жагсаалтанд дурьдаагүй бусад хууль бус нийгмийн хэв журмыг алдагдуулсан үйл ажиллагааг үйлдсэн тохиолдолд цагдаагийн байгууллагуудаар шийдвэрлүүлнэ.

3. 20 цагаас хойш зочид хүлээн авахыг хориглоно. Зочид ирсэн явсан цагаа хамгаалалтын албанд бүртгүүлэх бөгөөд зөвхөн нийтийн өрөөнд байна. Зочдыг унтлагын өрөөнд дагуулж орохыг хориглоно.
4. Оршин суугч нь ирсэн зочдод сахилга бат, нийгмийн хэв журмыг зөрчсөн үйлдэл гаргахгүй байлгах тал дээр хариуцлага хүлээнэ.
5. Оршин суугчид нь бие биетэйгээ хүндэтгэлтэй харьцана.
6. Өрөөнүүдэд хоол хийхийг хориглоно
7. Өрөөнд хүн байхгүй тохиолдолд гэрэл, сэнсийг унтраасан байна.
8. Өрөөнүүдийн түлхүүрийг хувилахыг хориглох бөгөөд бусдын өрөөнд зөвшөөрөлгүй орсон тохиолдолд ноцтой зөрчилд тооцогдоно.

Унших материал

Сургалтын дамжааны хэрэгцээ шаардлага дээр үндэслэн сургалтын байгууллага нь дараах төрлийн гарын авлагаар хангана:

- ☐ Сэдэвт хамааралтай номууд;
- ☐ Хичээлийн тэмдэглэлийн хувиуд;
- ☐ Тусгайлсан гарын авлага.

Бичиг хэргийн хэрэгсэл

Бүх сургалтад хамрагдагчдад сургалтын явцад шаарддагдах үзэг, цаас харандаа, зургийн цаас зэргийн хэрэгцээ шаардлагыг харгалзан олгоно.

Гэрчилгээ олгох

Манай сургалтын хөтөлбөрт хамрагдаж төгссөн сурагчдад дараах төрлийн гэрчилгээ олгогдоно. Үүнд:

Техникийн болон Мэргэжлийн Сургалтын Байгууллага (ТМСБ);

- Үндэсний Хүний Нөөцийн Сургалтын Институт, Исламабад;
- Үндэсний Шинжлэх Ухаан Техникийн Боловсролын Институт;
- Ур Чадварыг Хөгжүүлэх Зөвлөл,Исламабад.

Хавсралт 4.2. Сургагчийн анхан шатны үйл ажиллагааны арга зүйн удирдамж

Нэгдүгээр хэсэг. Шаардагдах анхан шатны заах арга зүй

1. Хувь хүний үзүүлэлтүүд

Сургалтын өвөрмөц загвар болон зорилгоос хамааран сургагч багшид тодорхой нэмэлт шаардлагууд тавигдах болно. Үүнд:

1.1. Сургагч багш нь сургалт явуулах салбартай холбогдох бүхий л талын мэдлэгтэй байна. Тэдгээр нь орлогыг бий болгох үйл ажиллагааны талаар тодорхой мэдлэг дадлага туршлагатай байна. Сургалтад хамрагдагчдын идэвх сонирхол нь багшийн тухайн салбарын мэдлэгийн түвшнээс хамааралтай байна. Сургагч багш нар нь үлгэр жишээ байж сургалтад хамрагдагчид болон тухайн орон нутгийн ард иргэдийн итгэл хүндэтгэлийг олж авсан байна;

1.2. Сургагч багш нь бусдыг сургах чин эрмэлзэлтэй байна. Хичээл заах дур сонирхолтой байхаас илүү ямар ч мэдлэг боловсрол багшийг илүү сайн багш болгож чадахгүй. Багш гэдэг нь номлогчийн төрөл юм. Тэдгээр нь бусдад туслах хүсэлтэй байхын зэрэгцээ сурагчиддаа суралцах нөхцөл, орчныг бүрэн бүрдүүлэхийг хичээнэ;

1.3. Багш нь аливаа асуудалд санаачлагатай байна. Нэг хүнд тохирсон эсвэл нэг тохиолдолд асуудлыг шийдвэрлэсэн арга нь дараагийн удаа төдийлөн хангалттай биш байж болно. Сайн багш нь бусдын асуудлыг ойлгохгүй, эргэлзэж байгаа, сонирхолгүй байгаа зэргийг даруу тодорхойлж чаддаг байх хэрэгтэй дээр дурьдсан шинж тэмдгүүд илэрсэн тохиолдолд өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, илэрсэн шинж тэмдгүүдийг арилгах арга хэмжээ авна. Сургагч багш нь насанд хүрсэн хүмүүстэй харилцаж, тэдэнд хичээл зааж байгаа гэдгээ ухамсарлан заах арга зүй, чиг хандлагаа тодорхойлсон байна. Учир нь залуу хүмүүс суралцах явцдаа идэвхтэй байх, шинийг эрэлхийлэх, авъяасаа тодруултодруулах, сонирхолоо илэрхийлэх зэрэг нь насанд хүрсэн хүмүүсийн хувьд энэ араншин дутмаг байдаг тул энэ хандлагыг анхаарах хэрэгтэй;

Сургалтыг явуулах явцад мэдлэг, харьцуулан дүгнэх, сургалтын бусад үндсэн техникүүдийг зохистой хэрэглэх нь сургалтыг үр дүнд хүргэх магадлалтай. Сургалтыг явуулах явцад хичээлийг зөвхөн онолын талас бус дадлага, туршлага, хэрэв шаардлагатай бол бодит болсон үйл ажиллагаануудын жишээг татаж тайлбарлах хэрэгтэй.

1.4. Сургагч багш нь сургалтын төлөвлөгөө болон стратегийг бэлтгэхдээ дараах зүйлийг анхаарсан байна.

1.4.1. Сургах явцад дээд зэргийн оролцоотой, сонирхолтой байх нь чухал;

1.4.2. Сургалтад хамрагдагчдын цагийг хамгийн үр дүнтэйгээр ашиглах;

1.4.3. Сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа сургалтын дараах үйл ажиллагаа, зорилготой уялдуулах;

1.4.4.Сургалтын төлөвлөлт нь сургалтад хамрагдагчдын сонирхол, эрмэлзэлд нийцсэн уян хатан байна;

1.4.5. Насанд хүрсэн сургалтад хамрагдагчид нь өөрсдийн гэсэн хэрэгцээ эрх үүрэгтэй гэдгийг анхаарах;

1.5. Сайн багш нь суралцагчдад шаардлагтай мэдлэг, ур чадварыг үнэхээр эзэмшиж байна уу гэдэгт байнгын анхаарал тавина. Үүнийг мэдэхийн тулд аман болон бичгийн асуултуудыг хэрэглэж болно;

1.6. Сургагч багш нь төслийн ажилтан, орон нутгийн удирдлага, оролцогч болон түнш байгууллага, бусад хамтран ажиллагчидтай хамтран багаар ажиллах чадвартай байх хэрэгтэй. Сургагч багш шинийг эрэлхийлэх, аливаа асуудлаас гарц олох, сургалтад хамрагдагчдад чин сэтгэлээсээ туслах зэрэг чанаруудыг эрхэмлэдэг байх хэрэгтэй;

1.7. Сургагч багш нь хөдөөгийн хөгжил, орон нутгийн нөхцөл байдлыг бүрэн ойлгосон байх хэрэгтэй;

Сургагч багшийн тухайн орон нутагт хандах хандлага сургалтад хамрагдагчаар дамжуулан илэрхийлэгдэх болно.

2. Заах арга зүйг ойлгох

2.1. Сайн заах гэдэг нь зөвхөн шалтгаан бус тэвчээртэй байдлаас мөн хамаарахаас гадна суралцагчдыг суралцах урам зоригтой байлгахаас гадна тэдэнд хэрхэн суралцах талаар заана. Энэ нь та өөрийн гар урлалыг бүтээж байгаатай адилхан бөгөөд ихээхэн хэмжээний тэвчээр сэтгэл зүрхийг шаардах бөгөөд та энэ бүхнйг сурагчиддаа дамжуулах болно;

2.2. Хичээл сайн заана гэдэг нь мэдлэг олохыг эрмэлзэж байгаа суралцагчдыг хэрэглэгч, үйлчлүүлэгч гэж хандахыг хэлнэ. Энэ нь та зааж байгаа хичээл, хамааралтай унших материал, тухайн заж байгаа сэдэвт хамаарах бусад мэдээллийг өөртөө байгаа бүхий л нөөц бололцоог дайчлан бусдад хүргэхийн хэлнэ. Сайн багшлах гэдэг нь мөн онол практикийн хооронд дутагдаж байгаа зүйлийг илрүүлж, холбоос бий болгон бусдад ойлгуулахыг хэлнэ;

2.3. Сайн багшлах гэдэг нь сонсох, асуух, хариулах болон суралцагч бүр, анги бүр өөр гэдгийг байнга санаж байхыг хэлнэ. Энэ нь ярианы ур чадварын хувьд тааруу дуу цөөнтэй хүүхдийг чөлөөтэй өөрийгөө илэрхийлэх боломжтой болгохтой адил үйл явц юм. Багш нь суралцагчдыг чинээнд нь тултал шахаж байхын зэрэгцээ, тэдэнд хүмүүнлэг хүндэтгэлтэй, мэргэжлийн үүднээс хандана;

2.4. Сайн багшилна гэдэг нь тодорхой төлөвлөгөө бүдүүвчинд баригдаж яг цав байна гэсэн үг биш юм. Сайн багш сурагчдынхаа, ангийнхаа цагийн нөхцөл байдалд дүгнэлт хийж шаардлагатай шийдвэрүүдийг тухайн цагт гаргах чадвартай байх хэрэгтэй;

2.5. Сайн багш байна гэдэг нь хэв загварай холбоотой асуудал юм. Сайн багш бусдын сонирхлыг татах чадвартай байх хэрэгтэй юу? мэдээж тийм,. Сайн багш нь хичээл заах явцдаа суралцагч тус бүрд хүрч ажиллахыг эрэмлээзэнэ. Жишээлбэл, багш гэдэг нь удирдаач бөгөөд суралцагчид нь хөгжимчдийн оронд байж болох юм. Ийм тохиолдолд суралцагч бүр өөр өөрийн гэсэн зэмсэг дээр ажиллах бөгөөд тэднийг зөвхөн багш-удирдаач л нэгтгэж чадна;

2.6. Дараах зүйл нь маш чухал–үр дүнтэй багшлах гэдэг нь хөгжилтэй зантай байхыг ч мөн хэлнэ. Энэ нь өөрийгөө хэт цэгнэсэн, төвлөрсөн байдлаас гарч бусадтай чөлөөтэй харилцах нөхцөл байдлыг бий болгоно. Хөгжилтэй байна гэдэг суралцагчдын биеэ барьсан, зайгаа барьсан байдлыг арилгахын тулд санаандгүй байдлаар хошин байдлыг өрнүүлж багш суралцагч хоёрын хооронд зөөлөн уур амьсгал бий болгохыг хэлнэ. Гэхдээ хошин байна гэдэг нь хэн нэгний шоолох, басамжлах явдал биш бөгөөд өөрийн амьдралд тохиолдсон зааж буй хичээлийн сэдэвт хамааралтай болсон үйл явдал дээр тулгуурлана;

2.7. Сайн багшилна гэдэг нь бусдын санаа бодол авъяасыг хөгжүүлэх, тэдний төлөө санаа тавьж, чин сэтгэлээсээ хандахыг хэлнэ. Сурагцагч бүрд цаг, сэтгэлээ зарцуулахыг хэлэх бөгөөд үүний тулд багш нь сургалтын хөтөлбөр боловсруулах, материал бэлтгэх бөгөөд тухайн ангийн хүн бүрт тааруулсан хандлагыг баримтлана;

2.8. Сайн багшилна гэдэг нь бусдыг удирдаж манлайллыг гүйцэлдүүлэхийг хэлэх бөгөөд үүний тулд нөөц бололцоо хэрэгтэй бөгөөд зарим тохиолдолд энэ нь зөвхөн хувь хүнээс хамааралгүй бүхэл байгууллагын хүчин чармайлтаас хамаарах тохиолдол ч бий;

2.9. Сайн багшилна гэдэг нь багаар ажиллах, багийн гишүүдийн ашиг сонирхлыг нэгтгэж тэдгээрийг хооронд нь зохицуулахыг хэлнэ;

2.10. Эцэст нь сайн багшилна гэдэг нь эрхэлж байгаа ажилдаа сэтгэл ханамжтайгаар хандаж, өөрийн бүхий л бололцоог шавхаж, бусдад мэддэг, чаддаг бүхнээ дамжуулах бөгөөд сайн багш нар өөрсдийн ур чадварыг мөнгөний төлөө бус харин үнэн сэтгэлээсээ энэ ажлыг хийх дуртай байхыг хэлнэ.

3. Насанд хүрсэн хүнийг ойлгож харилцах

3.1. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн сургалтад хамрагдагчид нь ихэнх тохиолдолд насанд хүрсэн хүмүүс байдаг бөгөөд тэд өөрсдийн амьдралын дадлага туршлага дээр суурьлаж амьдралыг өөрийн гэсэн байр сууринаас харна. Иймд сургагч багш нь насанд хүрсэн сургалтад хамрагдагчидтай хэрхэн харилцах талаар тодорхой мэдлэгтэй байх хэрэгтэй.

3.2. Насанд хүрэгчид гэдэг нь амьдралын туршлага бүхий мэдээлэл ихтэй байдаг. Тэдгээрийг сургалтад хамрагдаж байгаа шалтгаан нь зөвхөн мэдлэг дутагдснаас бус харин сурах зорилго нь хөтөлж ирсэн. Анги дотор харилцан яриа үүсгэж санал бодлоо солилцох, туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Та өөрийгөө багш гэдгийг санаж байх хэрэгтэй. Гэхдээ багш байна гэдэг нь бүхий л асуултын хариултыг мэднэ гэсэн үг биш юм. Та тухайн асуудлаар хаашаа явах, хэнд хандах хэрэгтэйг л мэдэж байх хэрэгтэй. Ингэсний үр дүнд суралцагчид бие биендээ тулгарсан мэдэхгүй асуултын хариуг хаанаас авахыг танаар заалгахыг зөлвөх болно;

3.3. Насанд хүрсэн хүмүүс нь өөрсдийн гэсэн тогтсон үнэт зүйлс, итгэл үнэмшил, санал бодолтой. Тэд өөр итгэл үнэмшил, шашин шүтлэг, үнэт зүйлс болон амьдралын хэв маягийг хүндэтгэн үзэж байгаа гэдгээ харуулдаг. Сураглцагчид өөрсдийн гэсэн тогтсон үнэт зүйлс, итгэл үнэмшил болон санал бодолтой байж болох боловч тухайн өрөөнд байгаа хүн бүр түүнийг хуваалцах ёстой биш гэдгийг тэдэнд ойлгуулах хэрэгтэй. Үүний тулд тэдний дунд харилцан яриа, мэтгэлцээн зэргийг зохион байгуулж болох юм;

3.4. Насанд хүрсэн хүмүүсийн суралцах хэв маяг болон арга барил нь ихэвчлэн өөрчлөгдсөн байдаг. Иймд жижиг бүлгүүд болгон хуваж, асуудал шийдвэрлэх, санал дэвшүүлэх гэх мэтийн сургалтын агуулгуудыг хэрэглэх хэрэгтэй. Түүнчлэн аудио, видео болон оролцоог хангасан бусад сургалтын аргуудыг хэрэглэх нь зөв юм. Тэдгээр нь аливаа сэдвийг ойлгох, хүлээн авах хугацаа нь бага байж болох ч тэдгээр нь суралцах чадвараа алдсан гэсэн үг биш юм. Ихэнх насанд хүрсэн хүмүүс лекцээс бусад сургалтын аргыг таашаадаг;

3.5. Насанд хүрэгчид нь өөрсдийн шинэ мэдлэг болон мэдээллийг өөрсдийн мэддэг зүйлс, туршлагатайгаа харилцан хамааруулж хүлээж авдаг. Хичээл бүрийн эхэнд сэдэв, хөндөгдөх асуудлын талаар тодорхой тайлбарлаж өгөх хэрэгтэй ба оролцогчдын туршлага, мэдлэгээс хальсан асуудлыг хөндөх нь үр дүнд хүрдэггүй байна;

3.6. Насанд хүрэгчдийн бие махбод нь чилэх магадлал өндөр байдаг тул хичээлийн явцад тодорхой завсарлагууд авч байх нь зүйтэй. Нэг удаагийн хичээл нь 45-60 минут байхад болох бөгөөд зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд 60-90 минутаар үргэлжүүлж болно;

3.7. Насанд хүрсэн хүмүүсийн зан чанарын онцлогоос хамааран суралцагч бүрийг хувь хүн гэдэг талаас нь хандаж байх нь зүйтэй. Хэрэв хүмүүс асуулт

асуугаад үүний улмаас эвгүй байдалд орох, ямар нэгэн байдлаар өөрийн үнэлэмжээ алдана гэж бодсон тохиолдолд сургалтын явцад идэвхтэй оролцохгүй. Иймд суралцагч ямар нэгэн байдлаар асуултад хариулсан зөв санал гаргасан тохиолдолд түүнийг магтаж сайшааж байх хэрэгтэй;

3.8. Насанд хүрсэн хүмүүс нь өөрсдийн гэсэн чиг хандлагатай болсон байдаг. Иймээс сургалтын явцад хэн нэгнийг аливаа асуудал дээр бүрэн дүүрэн хүлээж авна гэж тооцоолох хэрэггүй;

3.9. Хүмүүс хоорондын хувийн зан чанар, амьдралын хэв маяг, цаг зарцуулах зэрэг нь насны эрхээр өөрчлөгдсөөр ирдэг ба үүний үр дүнд хувь хүн бүр өөрийн гэсэн хэв загварай болсон байдаг. Иймд үүнийг ч гэсэн анхаарах хэрэгтэй;

3.10. Насанд хүрсэн хүмүүс аливаа асуудалд хандахдаа бэршээлд суурилсан хандлагаар ханддаг. Иймд сургалтын явцад тэдэнд аливаа асуудалд гарц хайх, жишээ өгч түүн дээр яриа хэлэлцүүлэг өрнүүлж, хичээлийг зохион байгуулах нь зөв юм. Насанд хүрсэн хүмүүс ихэвчлэн шинээр олж авсан мэдлэг ур чадвараа тухайн үеийн нөхцөл байдалд шууд хэрэгжүүлэх сонирхолтой байдгийг анхаарах нь зүйтэй;

3.11. Насанд хүрсэн хүмүүс ч зарим тохиолдолд хүүхэд шиг ааш гаргадаг. Тэдгээр нь дандаа насанд хүрсэн хэвээрээ байдаггүй. Ийм тохиолдолд тэдэнтэй зөрчилдөхийн оронд тэр хэвээр нь зөнгөөр нь орхисон нь дээр байдаг.

4. Дөрвөн үе шат бүхий сургалтын арга зүйг боловсруулах нь

ХЭЗЧДС-ын арга зүйн сургалтын хөтөлбөр нь ихэвчлэн насанд хүрэгчдэд зориулсан байдаг бөгөөд албан бус сургалтын чиг хандлагыг баримжаална. Үүнээс гадна сургагч багш нар сургалтын ерөнхий зарчим болон хандлагад дараах дөрвөн үе шат бүхий сургалтын арга зүйг хэрэглэхийг зөвлөдөг.

4.1. Оршил.Арга зүйн эхний шат бол сургалтад хамрагдагчдыг үйл ажиллагаанд бэлтгэх юм. Энэ үе шатанд багш нар суралцагчдын анхаарлыг өөртөө татан төвлөрүүлэхийн зэрэгцээ тухайн хичээлийн сэдвийг ойлгуулахыг оролдоно. Хэрэв суралцагчдын санаа бодол нь төвлөрөхгүй ”өөр газар” байгаа бол сургалтын материалыг тэдэнд ойлгуулан тайлбарлахад маш хүндрэлтэй байх болно.

Энэ үеийн туршид сургагч багш өнгөрсөн хичээлүүдийг одоогийн хичээлтэй уялдуулан тайлбарлахыг хичээх бөгөөд хичээлийн зорилго, суралцагсдын төлөвийг тодорхойлох нь чухал юм.

4.2. Илтгэл.Сургалтад хамрагдагчид өөрсдийн анхаарлаа төвлөрүүлж хичээлийн зорилго сэдвийг хүлээж авсны дараа сургагч багш нар нь тухайн өдөрт заахаар төлвөлөсөн хичээлд орно. Хичээлийг гурван үндсэн аргаар зааж болно.

- ☐ Лекц;
- ☐ Биетээр үзүүлэх;
- ☐ Ярилцлагын хэлбэрээр явуулах зэрэг болно.

Мөн энэ үе шатад багш дараагийн хэрэглэх сургалтын техникийн бэлтгэсэн байх болно. Үүнд:

- ☐ Асуулт асуух;
- ☐ Самбар дээр тэмдэглэх;
- ☐ Бодуулах;
- ☐ Төрөл бүрийн аудио, видео хэрэгслүүдийг ашиглах.

4.3. Тодруулга хийх.Хичээлийн явцад суралцагчид заасан хичээлийг ойлгосон эсэхийг шалгах хэрэгтэй бөгөөд үүнийг асуулт асуух, бодлого өгөх, дасгал хийлгэх эсвэл жижиг сорилоор тодорхойлох боломжтой юм.

4.4. Дуусгах.Хичээл бүрийг нэгдсэн санаа эсвэл дүгнэлтээр дуусгаж байх нь зөв юм. Ингэснээр суралцагчид нь хичээлийн явцад олж авсан чухал мэдээлэл, үйл баримт зэргийг эрэгцүүлэн бодох боломжтой болно. Хичээл бүрийг сургалтын ерөнхий зорилт, зорилготой уялдуулах бөгөөд суралцагчид тухайн өдрийн заасан хичээлийг үндсэн зорилгодоо хүрэх алхам гэж ойлгох хэрэгтэй.

5. Сургалтын заах арга зүйн ерөнхий хүрээг бий болгох

5.1. Сургалтын үндсэн заах арга зүйн техникүүдийг хэрэглэхээс гадна. Сургагч багш нь эдгээр техникүүдийг сургалтын нөхцөл байдалд хэрхэн хэрэглэх талаар хэв маягийг боловсруулсан байх шаардлагатай. Сургалтын техникүүд нь тухайн хичээлийн онцлогоос хамааран өөрийн гэсэн онцлогуудтай байдаг. Үүнд:

- ☐ Лекц. Энэ аргыг суралцагчидтай ярих хичээлийн сэдэвтэй холбогдох онол, зарчим, хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж, аюулгүйн ажиллагааны зааварчилгаа гэх мэт тухайн ур чадвартай холбодох мэдээллийг өгөхөд хэрэглэнэ;
- ☐ Биетээр үзүүлэх. Энэ аргыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зарим нэгэн үйлчилгээг хэрхэн гүйцэтгэхийг бодитоор үзүүлж ур чадварыг хөгжүүлэхэд зориулна;
- ☐ Ярилцах, санал бодлоо солилцох. Энэ арга нь асуух, санал солилцох, санал бодлоо илэрхийлэх зэргээр суралцагсдын оюуны ур чадварыг нэмэгдүүлэхэд тохиромжтой бөгөөд энэ аргыг хэрэглэж байгаа үед бэрхшээлийг шийдвэрлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, төлөвлөлт хийх талаар сэдэвчилсэн ярианууды өрнүүлж байх нь зүйтэй;
- ☐ Асуулгын арга. Энэ аргыг өмнө нь заасан материалыг хэрхэн ойлгосон, одоо зааж буй хичээлтэй хэрхэн уялдаатай ойлгон хүлээж авч байгаа, өнгөрсөн хичээлийг дахин сануулах зорилгоор хэрэглэнэ;
- ☐ Сургагч багш нар нь сургалтад хамрагдагч төвтэй сургалтын техникийн хэрэглэж байх нь зүйтэй юм.

5.1. Сургагч багш нар нь өөрсдийн сургалтын ур чадвараа дээшлүүлэх арга хэмжээг сургалтын явцад байнга авч байх хэрэгтэй. Хэрэв шаардлагатай бол тэд тольны өмнө сургуулилалт хийж, дүгнэлт өгөхийн зэрэгцээ сургалтын арга барилаа дээшлүүлэх чиглэлээр бие дааж суралцах хэрэгтэй.

Хоёрдугаар хэсэг. Зааварчилгааны анхан шатны арга зүй

Оршил

Энэхүү удирдамжийг ХЭЗЧДС-ын арга зүйн сургагч багш нарын сургалтад зориулж бэлтгэв. Сургагч багш нарын заах тодорхой үйл ажиллагаанд холбогдох хичээлүүд нь хэрэв холбогдох зааварчлах ур чадваргүй бол төдийлөн сургалтад хамрагдагчдад үр өгөөжөө өгөх нь ховор. Уг асуудал мөн үйлдвэрлэлийн хөгжүүлэх болон бусад бүх төрлийн сургалтад хамаарна. Дор сургалт болон зааварчлагааны цар хүрээг танилцуулж байна. Энэ арга зүй нь сургагч багшид хандсан суралцагчид төвтэй хандлага юм. Сургагч багш нар энэхүү арга зүйн хүрээнд өөрсдийн сургалтын техникийг боловсруулна.

Техник 1. Лекц

Тодорхойлолт

Лекц гэдэг нь сургагч болон суралцагчдын харилцах сувгуудын нэг юм. Энэ нь их хэмжээний шинэ мэдээллийг хурдан дамжуулах боломж олгох бөгөөд өндөр түвшний оролцоог шаардах, ялангуяа лекцийг хоёр талтай асуудлын хэлбэрээр явуулбал улам үр дүнтэй байх болно.

Хэрэглээ

Лекцийн гол зорилго нь тухайн асуудалтай холбогдох онол, үндсэн багаж тоног төхөөрөмж, аюулгүй байдлын талаарх мэдээллийг өгөхөд зориулагдана. Лекцийг бэлдэхэд маш их хүч хугацаа шаардагдана. Лекц нь сургалтын хөтөлбөрт заасны дагуу тодорхой хэсэг даалгаваруудаас бүрдэж болно.

Явц

1. Оршил- багш нь лекцийн зорилгыг тайлбарлана.
2. Илтгэх – багш мэдээллийг танилцуулна.
3. Тодруулга –багш заасан зүйлийн талаар асуулт тавих бөгөөд ялангуяа тодорхой бус байж магадгүй гэсэн хасгүүдийг хөндсөн асуултыг тавина.
4. Дуусгах – багш лекцийг дүгнэж гол гол хэсгүүдийг онцолж тэмдэглэнэ.

Сургалт болон заварчилгааны арга зүйн хүрээ

Багшид хандсан арга зүй	Хавсарсан арга зүй	Суралцагчид төвтэй арга зүй
Лекц: заах, тухайн сэдэвт холбогдох онол болон мэдлэгийн талаар суралцагчдад танилцуулж ярилцах	Асуух техник	Дасгал эсвэл төсөл бэлтгэх: - холбогдох сэдвээр бие даан даалгавар биелүүлж ур чадвар болон мэдлэгээ нэмэгдүүлэх боломж олгох
Биетээр үзүүлэх: туханй ур чадварын бүрэлдэхүүн хэсгүүдийн биечлэн үзүүлэх	Самбарын техник Бодуулах техник	Газар дээр нь очиж танилцах:- суралцагчдад тухайн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хэрхэн хийгдэх үйл ажиллагааг практик дээр үзүүлэх
Ярилцлага: суралцагчдыг асуух, лавлах маягаар холбогдох сургалт болон ур чадварын талаарх мэдээллийг сэргээж, суралцагчдад өөрсдийн санал дүгнэлтээ хэлэх боломж олгох	Төрөл бүрийн туслах материал ашиглаж заах техник	Нөхцөл байдал бодит жишээг судлах болон жүжигчилсэн тоглолт: - суралцагчдад амьдралын бодит жишээнээс сургамж авах, туршлага хуваалцах боломжийг олгоно.

Лекцийг бэлтгэх

1. Лекцийг бэлтгэсний дараа шаардлагатай үзүүлэнгүүдийг бэлдэх бөгөөд лекцийн явцад тэмдэглэлийг уншихгүй үзүүлэнг удирдлага болгон хичээлийг явуулна.
2. Хэрэв тараах материал бэлдсэн бол лекцээс өмнө тараах хэрэггүй. Учир нь суралцагчид түүнийг уншаад таныг сонсохгүй байх талтай. Харин тэмдэглэл хийхийг санал болго. Тараах материалыг лекцийн дараа тарааж бай.
3. Лекцийг харилцан ярилцах, дасгал хийх зэрэг бусад заах арга зүйтэй хослуулан хэрэглэж болно.

Сургалтад хамрагдагчид зөв байрлалд суусан, та тэднийг элдэв саад тотгоргүйгээр бүгдийг нь харах боломжийг бүрдүүл.

Лекцийн талаарх зөвөлгөө

Хэрэв заах арга зүйн нөхцөл байдалд нийцээгүй байх юм бол маш сайн бэлтгэгдсэн багш ч гэсэн зохион байгуулалтгүй мэт харагдах болно. Иймд лекц унших талаар дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

1. Лекцийн явцад суралцагчдын оролцоог хангахын тулд үе үе асуулт тавьж хариулт авч бай. *Асуулт асуух техникийг боловсруулах хэрэгтэй.*

2. Самбарыг аль болохоор их ашиглаж гол зүйлүүдийг самбар дээр тэмдэглэж бай. *Самбарын техникийг боловсруул.*
3. Тэмдэглэлүүдийг бичихдээ ойлгогдохоор, гэхдээ шууд гүйлгэж уншихгүй байх бүтцээр бич
4. Аль болох анги руу нүүрээ харуулж бай. Самбар луу харж ярихаас зайлсхий.
5. Зөвхөн урдаа байгаа суралцагчдаас гадна ангид байгаа бүх суралцагчид руу хандаж ярих
6. Хоолойны өнгө болон биеийн хөдөлгөөнөө түлхүү ашигла. Суралцагчдын нүд рүү харж ярьж бай. Ингэснээр тэдгээрийн ойлголтын түвшинг дүгнэх, өөрийгөө итгэл үнэмшилтэй харагдуулж чадна.
7. Нэг тогтсон хэллэг болон чухал мэдээлэл өгөх шаардлагатай зүйлсийг дахин дахин хэлэхээс бүү ай. Суралцагчид нь ихэвчлэн өөр зүйл бодсон өөр зүйл анхаарсан байдаг тул нэг юмыг 3-4 удаа давтахаас бүү ай.
8. Удаан ярь. Ингэснээрээ та суралцагчдад тэмдэглэл хийх эсвэл ойлгоогүй зүйлээ асуух боломж олгоно. Суралцагчдын мэдэхгүй нэр томъёог яриандаа бүү хэрэглэ. Шинэ үгнүүдийг тухай бүрд нь тайлбарлаж бай.
9. Суралцагчдын үгээр илэрхийлээгүй үйлдлүүдийг анзаарч бай. Толгой сэгсрэх, уулга алдах, бодлогоширох зэрэг нь заагдаж буй материалыг хүлээн авахгүй байгаагийн шинж.
10. Ямар нэг алдаа гаргасан тохиолдолд шууд тайлбарлаж, дараагийн үе шатанд орон хичээлээ үргэлжлүүлж бай.
11. “мм”, “ аа”, “тийм”, “за” гэсэн үг нь олон давтагдсан чихэнд чийртэй сонсогдож, үүний оронд богино хэмжээний завсарлага авсан нь дээр,
12. “ойлгомжтой”, “амархан” болон “мэдээж” гэсэн үгнүүдийг хэрэглэхээс зайлсхий.
13. Бусдаас илүү онцлон сайн сурч байгаа суралцагчидтай харилцан илүү анхаарал хандуулах нь бусад суралцагчдын хувьд тааламжгүй байдалд оруулж тэдгээрийг бухимдуулахад хүргэнэ гэдгийг санаж бай.
14. Хичээлийн сүүлд, хичээлийн явцад юу үзсэн, дараагийн хичээлд юу үзэх тухай дэлгэрэнгүй тайлбарлаж бай.

1.5. Тайван нөхөрсөг өөртөө итгэлтэй байж сур.

Сургалтад ашиглах үзүүлэнгүүд

Самбар хэрэглэхээс гадна төрөл бүрийн үзүүлэнгүүдийг ашиглаж болно. Үүнд:

1. Хүснэгтүүд
2. Гараар бэлтгэсэн үзүүлэнгүүд
3. Ханын самбар
4. Видео бичлэгүүд

Зөвхөн цөөн тооны багш нар дээрх санал болгосон зүйлийг байнга хэрэглэх боломжтой. Сургалтын арга зүй хэв маягийг өөрчлөхийн тулд таны хичээлийг байнга ажиглаж байдаг хүмүүстэй ярилцаж, зөвлөгөө авч бай. Бас нэг арга бол хичээлийн явцад бичлэг хийж дараа нь түүнийг үзэж дүгнэлт хийх явдал юм.

Техник 2. Биетээр үзүүлэх арга

Тодорхойлолт

Биетээр үзүүлнэ гэдэг нь суралцагчдад аливаа зүйл нь хэрхэн хийгдэх ёстой гэдгийг үзүүлэхийн хэлнэ. Энэ сургалтын арга нь хүний олон байгалиас заясан шинж чанарыг хэрэглэхэд хүргэдэг. Энэ аргын онцлог нь чухал хэсгүүдийг хэлж тайлбарлах бус шууд үзүүлэхэд оршино.

Хэрэглээ

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд сургалтын явцад ур чадварыг хөгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга нь биетээр үзүүлэх юм. Энэ арга нь механик үйлдлүүдээс гадна хэмжилт хийх, хэмжүүрийн багаж хэрэгсэл ашиглах, тооцоолох зэргийн оюуны ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгддэг болно.

Биетээр үзүүлэх үйл ажиллагаа нь цөөн тооны хүнтэй зөвхөн жижиг бүлгүүдэд зориулагдана.

Явц

1. Оршил - Биетээр үзүүлэх гэж буй зүйлийг тайлбарлаж уг үйл ажиллагааны зорилтыг таниулна. Түүнчлэн энэхүү үйл ажиллагаа нь суралцагсдын мэддэг мөн нь хийсэн, мэдэх шаардлагатай зүйлүүдтэй хэрхэн холбоотой байгааг ойлгуулна.
2. Үзүүлэх- энэ үйл ажиллагаа нь дараах гурван үйлдлээс бүрдэнэ:
   - **а. Үзүүлэх-** тухайн үйлдлийг хэрхэн ямар дарааллаар хийдгийг дэлгэрэнгүй харуулна.
   - **б. Тайлбарлах-** тухайн үйлдэл яах гэж хийгдэж байгааг, үйлдлийг хийхдээ юу анхаарах зэргийг дэлгэрэнгүй тайлбарлана.
   - **в. Дадлагажуулах-** суралцагчдаар хийсэн үйлдлийг давтаж биетээр хийх боломжийг олгоно.
3. Тодруулга: суралцагчдад асуулт асуух боломжийг олгож үзүүлсэн зүйлийг бэхжүүлэхийн тулд өөрөө асуулт асууна.
4. Дуусгах – түрүүнд нь хийсэн үйлдлээ ойлгоогүй хүмүүст дахин үзүүлэх зорилгоор давтаж хийнэ.

Биетээр үзүүлэхэд бэлтгэх нь

Дор дурьдах зүйлс нь биетээр үзүүлэх техникийг хэрэглэхэд чухал ач холбогдолтой.

Биетээр үзүүлэхээс өмнө хэрэгцээтэй бүхий л багаж тоног төхөөрөмж, материал зэргийг бэлтгэсэн байна.

1. Биетээр үзүүлэх үйл ажиллагааг шуурхай богино нэг удаагийн үйлдлээр үзүүлнэ.
2. Хичээлийн үндсэн зорилтыг тайлбарлана.
3. Ажиглаж байгаа суралцагчид нь таатай орчинд байгаа эсэхэд анхаарал хандуул.
4. Тоног төхөөрөмж болон суралцагсдын байршил нь суралцагч бүр саадгүйгээр харахаар тооцоол.

Биетээр үзүүлэх үйлдлийг хийх

1. Биетээр үзүүлэх үйлдлийн зорилтыг дэлгэрэнгүй тайлбарлах бөгөөд суралцагчдад нь тэдний мэддэг өмнө нь хийсэн, мэдэх шаардлагатай зүйлүүдтэй хэрхэн холбоотой байгааг ойлгуулна.
2. Хийж буй үйлдлүүдээ тодорхой дарааллын дагуу хийнэ.
3. Биетээр үзүүлэх үйлдлийг тухайн суралцагчаар хэрхэн хийлгэмээр байгаа тэр загвараар үзүүл. Ингэхдээ удаан, тодорхой үйлдлүүдээр хийнэ.
4. Үйлдлүүдийн завсар түр амсхийж суралцагч ойлгож байгаа эсэх талаар лавлаж асууна.
5. Тайлбар хийхдээ суралцагчдийн мэддэг үг хэллэгийг хэрэглэж шинээр хэрэглээнд орж буй үг хэллэгийг тодорхой тайлбарлана.
6. Суралцагчдад асуулт асуух боломж олго.
7. Үйлдэл хийхэд шаардлагатай аюулгүй ажиллагааны дүрэм журмыг анхааруул.
8. Биетээр үзүүлсний дараа суралцагчдаар гол үйлдлүүдийг давтаж хэлүүл
9. Суралцагчдад үйлдлийг өөрөө бие дааж хийх боломж олгохын зэрэгцээ буруу үйлдэл хийсэн тохиолдолд даруй зас.
10. Үйлдлийг сурч амжаагүй хүмүүст дахин үзүүл.

Техник. 3. Ярилцлагын аргачлал

Тодорхойлолт

Ярилцлага гэдэг нь багшийн удирдлага доор явагдах олон сувагт харилцааны хэлбэр юм. Мэдлэг, санал, үзэл бодол нь оролцогчдын хооронд чөлөөтэй солилцоно.

Хэрэглээ

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт энэ аргыг үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх, ялангуяа суралцагчид үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх явцад түлхүү ашиглана. Бизнесийн стратеги, зах зээл, капиталыг бий болгох, бизнесийн зохион байгуулалт зэрэг оролцогчдыг өргөнөөр идэвхтэй оролцуулах хэрэгцээтэй сэдвүүдийг тайбларлахад хэрэглэнэ.

Явц

1. **Оршил-Хичээли**йн сэдэв зорилго болон бусад зааварчилгааг тайлбарлана. Ихэнх тохиолдолд ярилцлагын үед хэлэлцэх сэдвийг асуулт хэлбэрээр өгнө.
2. **Ярилцлага-Ярилцлагын** арга зүйг дараах хоёр чиг хандлагад хувааж болно.
   - ☐ Ангийн бүх суралцагчид оролцох бөгөөд багш чиглүүлэгчээр ажиллана.
   - ☐ Ангийг жижиг багуудад хувааж тус тусад нь сэдэв өгөх бөгөөд багш ярилцлагыг чиглүүлэх суралцагчийг томилно.
3. **Тодруулга-Ярилцлагын төг**сгөлд багш эсвэл чиглүүлэгч хийсэн суралцагч ярилцлагын үр дүнг тодорхойлно. Үүний дараа тодруулга хийх асуулт хариулт явагдана.
4. **Дуусгах-**Оролцогчид ярилцлагын үед гарсан саналыг нэгтгэж дүгнэлт хийнэ.

Ярилцлагын техникийг хэрэглэх нь

1. Суралцагчдад тухайн сэдвийн хүрээнд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно. Суралцагч болгонд ярих, оролцох боломж олгоно.
2. Ярилцлагын сэдвийг багш өмнө нь үзсэн хичээл, дадлага зэрэг дээр үндэслэн сонгож авна.
3. Ярилцлагын үндсэн сэдвийг хадгалж байгаад анхаарал хандуул, хэрэв өөр сэдэв рүү хазайвал ярилцлагыг зогсоо.
4. Багш ярилцлагын дундаас гарч ирж буй санааг тодруултодруулах, эмх цэгцтэй санаагаа илэрхийлэх зэрэг дээр хяналт тавина.
5. Нэгтгэж дүгнэх явцад багш гол санаануудыг самбар дээр бичих шаардлага гарч магадгүй.

Техник 4. Дасгал болон төсөл бэлтгүүлэх аргачлал

Тодорхойлолт

Дасгал гэдэг нь шинээр сурсан ур чадвар, мэдлэгийг ялангуяа биетээр үзүүлэх болон лекцийн дараах сорил эсвэл дадлагажуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэ үйл ажиллагааны явцал суралцагчид нь тодорхой даалгавар биелүүлэх эсвэл энгийн төсөл боловсруулах замаар холбогдох материалыг хэрхэн ойлгосноо харуулна. Дасгалуудыг ихэвчлэн бүлгийн бүтэцтэйгээр зохион байгуулна.

Хэрэглээ

Дасгал хийх явцад багш нь суралцагчид лекц болон биетээр үзүүлэх хичээлүүдээс хэр зэрэг ур чадвар олж авсныг шалгах боломжтой. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт аргыг тодорхой төсөл хэлбэрээр шалгаж үнэлдэг болно.

Явц

1. Оршил – холбогдох сэдэв дасгалын зорилтыг багш тайлбарлана.
2. Дасгал – суралцагчдыг тодорхой даалгавар биелүүлэх эсвэл сургалтын хөтөлбөрт хамаарах төсөл бичихийг хүснэ.
3. Илтгэл- суралцагчид нь даалгаврыг хэрхэн биелүүлснээ танилцуулж илтгэл тавина.
4. Тодруулах- багш тодорхой бус асуудлуудыг тайлбарлаж, бусад суралцагчдад ойлгуулна.

Дасгалын аргачлалыг хэрэглэх зөвлөмж

1. Хэрэв боломжтой бол суралцагчдыг бүлэг болгон хуваана. Ингэснээр тухайн бүлгийн гишүүд хоорондоо мэдлэгээ хуваалцаж, мэдээлэл солилцох боломжтой болно.
2. Тусгайлан даалгавар өгөх шаардлагатай бол багш тухайн өгч буй дасгал эсвэл төсөл нь суралцагчийн сонирхолд нийцэж цаашдийн үйл ажиллагааны чиг хандлагатай уялдаатай байлгах тал дээр анхаарал хандуулна.
3. Суралцагчдад өөрийнх хийсэн зүйл бол өөрийнх хүчин чармайлтаар бий болсон гэдгийг ойлгуулах хэрэгтэй.
4. Өгч байгаа даалгавар эсвэл төсөл нь зүгээр л нэг цаг нөөц бололцоо үрсэн зүйл биш байлгах хэрэгтэй.
5. Дасгал болон төслийн үр дүнг сургалтын ерөнхий зорилготой холбож дүгнэлт хийх

Техник 5. Асуух техник

Сурна гэдэг нь хоёр талтай үйл ажиллагаа юм.

Танхимд суралцана гэдэг нь харилцан хамааралтай үйл ажиллагаа юм. Суралцах гэдэг нь хоёр талын үйл ажиллагааны бүтээгдэхүүн бөгөөд энэ тохиолдолд багш орцыг бэлтгэж суралцагч түүнийг шингээж авна. Суралцах аргын гол бүрэлдэхүүн хэсэг нь асуулт байх бөгөөд асуулт тавьснаар багш тухайн суралцагчид мэдлэг олж авах боломжийг нэмэгдүүлэх бөгөөд суралцагч багшаас мөн асууж ойлгоогүй, мэдэхгүй зүйлээ асууж тодруултодруулах хэрэгтэй.

Багш асуулт асуух нь

1. **Хаалттай төгсгөлтэй бус нээлттэй төгсгөлтэй асуултыг асуух** – хаалттай төгсгөлтэй асуулт гэдэг нь “тийм”, “үгүй” гэсэн хариулт авах асуултууд байдаг. Харин нээлттэй төгсгөлтэй асуултууд нь тодорхой тайлбартай хариултуудыг шаарддаг.
2. **Лавласан асуултууд-** Үүнд “та санал нэгтэй байна уу ?” “Та ингэж бодож байна уу?” гэх зэргийн асуултууд орно. Энэ асуултуудыг тухайн суралцагчийн холбогдох сэдвээр бодож байгаа ойлгосон зүйлийг лавлах зорилгоор асууна.
3. **Суралцагчдын дунд яриа өрнүүлэхийг дэмжих-** өмнөх хоёр жишээ бол хоёр хүний хоорондын харилцаанд хэрэглэх зориултай бөгөөд энэ тохиолдолд багш суралцагч хоёр ярьж анги сонсоно. Багш аль болохоор суралцагчдыг идэвхтэй оролцуулахын тулд хүн болгоны сонирхсон асуултуудыг асууж санал бодлоо илэрхийлэхийг уриална.
4. **Асуулт асуулгах асуулт-**хэрэв та суралцагчдаас юм асуулгамаар байвал тэдэнд боломж олго. Тодорхой асуудлыг тайлбарлах явцдаа чухал хэсэг дээр нь түр зогсож “Асуух асуулт байна уу”, “Надтай санал нэг байна уу?” эсвэл “Өөр хэлэх юм байна уу? “ гэж асуух нь зүйтэй. Ингэж асуулт асуусны дараа суралцагчдад өөрсдийн асуултыг бэлтгэх богино хугацаа олгоно.

Суралцагч асуулт асуух нь

1. **Хариулт асуултууд** – хэрэв та суралцагчдыг асуулт асуугаасай гэж хүсэж байгаа бол тэдний асуултад эргэж асуулт авахаар хариултуудыг хэлэх хэрэгтэй. Иймд суралцагчдын зүгээс асуусан асуултуудыг үл тоомсорлох, хариуг нь удаах зэргээр суралцагчийн асуулт асуух сонирхлыг бууруулж болохгүй.
2. **Суралцагчдын асуултад бүрэн хариулах-** суралцагчийн асуултад зөвхөн хариулах нь хангалттай биш юм. Та тухайн хүний асуултад бүрэн дүүрэн нийцсэн хариулт өгч байх ёстой. Түүнчлэн тухайн хүний асуултыг чухал асуулт, хэрэгцээтэй асуулт гэж анхаарал хандуулж байгаагаа илэрийлэх хэрэгтэй. Тухайлбал “Энэ асуулт бол маш сонирхолтой/чухал асуулт байна, би цаг гарган тусгайлан хариулья” гэх мэтээр хариулна.
3. **Суралцагчийн асуулт, тайлбарыг сонсох-**тухайн тавьсан асуулт, хариултыг хэрхэн хүлээж авч буй байдал чинь тухайн суралцагчид хэрхэн хандаж байгаа байдлыг илэрхийлнэ. Иймд асуулт асууж байгаа хүн рүү харж, түүний ярьж байгааг хүлээн авч байгаа гэдгээ илэрхийлэх хэрэгтэй. Түүнчлэн шаардлагатай бол зөв ойлгосон эсэхээ лавлаж байх хэрэгтэй.
4. **Хариултыг мэдэхгүй бол, түүнийгээ хүлээн зөвшөөр-** хэрэв та аливаа асуултын хариултын мэдэхгүй бол түүнийгээ хэлэх хэрэгтэй. Гэхдээ шууд мэдэхгүй гэж хэлэхийн оронд тайлбарлаж хэлэх нь зүйтэй. Тухайлбал, “мэргэжилтнүүд уг асуудал дээр ...”, “миний санаж байгаагаар ... би ахин нэг тодруулж харъя” гэх мэтээр.

Ярианы техник

1. Хүлээх, завсарлах болон чимээгүй байх нь ангийн хувьд зохисгүй үйлдэл гэж тооцогдохгүй. Зарим багш нар хичээлийн явцад дуугаа хураах, чимээгүй байх зэрэг нь буруу гэж үзэн үүнээсээ болж сандралд ордог. Хэрэв эдгээр багш нар хичээл заах явцдаа бичлэг хийж байсан бол суралцагчдын чимээгүй байсан хугацаа нь ихэвчлэн 5 секундээс бага хугацаанд үргэлжилдэг байна. Иймд багш нар ангид зогсолтгүй ярих нь заавал шаардлагатай биш гэдгийг ойлгох нь зүйтэй.
2. Хүлээх, суралцагчдад бодох хугацаа өг.- Асуулт асуусны дараа богино хугацаанд асуулт асуугдсан суралцагчид асуултаа бэлтгэх хугацааг өгнө. Иймд асуулт хэдий чинээ хүнд байна тэдий чинээ урт бодох хугацаа өгч байх нь зүйтэй байна.

Техник 6. Самбар хэрэглэх

Туршлагаас харахад самбар хэрэглэж заасан хичээлийн үр дүн илүү байдаг ажээ. Яагаад тэгдэг юм бол? Ихэнх суралцагчид нь харах болон сонсох үйлдлийг зэрэг хийснээр илүү сайн ойлгож тогтоодог байна. Самбарыг үр дүнтэй хэрэглэх нь тухайн хичээл ямар бүтэцтэй, асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжтой талаар илүү ойлголт авах боломжийг өгдөг байна.

Самбар хэрэглэхэд хэрэгцээтэй зөвлөмж

1. Самбарыг хэрэглэхдээ өмнө нь байсан бичээсүүдийг бүрэн арилгана. Учир нь өмнө нь бичээстэй байсан зүйлийн үлдэгдэл, өмнөх хичээлийн үлдэгдэл зэрэг нь төөрөгдөл үүсгэнэ.
2. Самбарын дээрээс доош нь бичнэ. Бичилтийг хийхдээ та ямар хэлбэрээр суралцагчдад ойлгуулах хүсэлтэй байгаатайгаа нийцүүлж бичнэ.
3. Баруун гараараа бичдэг багш нар самбарын зүүн талыг төдийлөн үр ашигтай ашиглаж чаддаггүй бөгөөд ямар ч байсан бичсэн зүйлийнхээ өмнө бүү зогс.
4. Хэрэв суралцагчид 2-оос илүү эгнээгээр сууц байгаа бол самбарын доод буланд бичихээс татгалз. Учир нь хойд эгнээд сууж байгаа хүнд бичвэр харагдахгүй.
5. Самбар дээр бичсэн зүлийг хэт хурдан битгий арилга. Суралцагчдад тэмдэглэл хийх боломж олго.
6. Хэрэв боломжтой бол хүснэгт болон зургуудыг зурж бай.
7. Суралцагчид ихэнх тохиолдолд таны ярьсан зүйлийг тэмдэглэж авдаггүй ч самбар дээр бичсэн зүйлийг тэмдэглэж авдаг гэдгийг анхаар.
8. Суралцагчдад шаардлагатай сануулах, цээжлүүлэх, анхааруулах зүйлийг гадуур нь хайрцаглаж тэмдэглэж бай.
9. Самбар дээр бичигдсэн зүйл нь цэвэрхэн ойлгомжтой байх бөгөөд үсгийн хэмжээ нь 5 см-ээс багаггүй байна. Түүнчлэн хэтэрхий том бичих нь зохисгүй бөгөөд та мөдхөн зайгүй болно.
10. Зааж буй зүйлээ бүхэлд нь самбарт битгий даатга. Бусад ашиглаж болох зүйлүүдийг ашиглаж бай.

Техник 7. Бодит жишээ судлах

Бодит жишээ судлах гэдэг нь суралцагчдад аливаа зүйлийг ойлгуулах гэсэн утгатай. Жишээн дээр суурилан тухайн бодитой нөхцөл байдлыг суралцагч хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргуулна. Ихэвчлэн тухайн бодитой жишээг шийдвэрлэх явцад нэгдмэл санаанд хүрэх нь ховор байдаг бөгөөд хүн бүр өөрийн аргаар уг асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

Хэрэглээ

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хувьд бодит жишээг үйлдвэрлэл хөгжүүлэх аргачлалыг заахад ихэвчлэн хэрэглэдэг. Багш тодорхой жишээ дурьдахаас гадна бодит амьдралд үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчийг урьж, бодит жишээ болгож болох юм.

Явц

1. Тухайн жишээ эсвэл түүхийг ангид танилцуулна. Оролцогчдын сонирхлыг илүү их болгохын тулд бодит бизнес эрхлэгчийг урьж, бодит жишээ болгож болох юм. Түүнчлэн хичээлийн зорилгыг тайлбарласан байна.
2. Нөхцөл байдлыг тодорхойлох –багш суралцагчдаас тухайн жишээнд хамаарах нөхцөл байдалд ач холбогдол бүхий баримтуудыг асууж тодруулна.
3. Үүссэн бэрхшээлийг тодорхойлж суралцагчид түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал бодлоо солилцоно.
4. Дуусгах- ихэвчлэн хүн бүр өөрийн гэсэн бодолтой байдаг тул ярилцлагыг нэгтгэн дүгнэж, дүгнэлт хийдэггүй байна. Гэхдээ багш асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг дурьдаж ярилцлагыг дуусгана.

Бодит жишээ судлахад хэрэгцээтэй зөвлөмж

1. Урьдчилсан байдлаар тараах материал бэлдсэн байна.
2. Тухайн асуудалд яригдаж байгаа бэрхшээл болон чухал нөхцөл байдлыг тодорхойлж чадахгүй байгаа суралцагчдад туслалцаа үзүүлэх
3. Ярилцлагыг хаахдаа бодит жишээг үзсэн сэдэв эсвэл цаашид үзэх сэдэвтэй холбоос хийж үлдээж байх

Техник 8. Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх

Сэтгэн бодох чадварыг хөгжүүлнэ гэдэг нь тухайн суралцагчийн оюун санааг төвлөрүүлж шинэ санаа гаргахыг хэлнэ. Сэтгэл судлаачдын хэлж байгаагаар хүний тархи зүүн, баруун гэсэн хоёр тархинаас бүрддэг. Зүүн тархи нь шалтгааныг боддог бөгөөд баруун тархи шинэлэг зүйлийг сэтгэдэг байна. Энэ ур чадвар нь зөвхөн чөлөөтэй нээлттэй сэтгэх болон байнгын дасгал сургуулиар бий болдог. Энэ тал дээр бизнес эрхлэгчийг урьж, бодит жишээ гаргаж болох юм.

Хэрэглээ

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх арга нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх сургалтын нэг хэсэг болдог байна. Суралцагч нь үйлдвэрлэлийн зах зээлийн капиталын болон бизнес стратегийн хувьд тулгарч буй бэрхшээлүүдийг хэрхэн давах талаар бодож, сэтгэн бодох чадвараа хөгжүүлдэг байна.

Энэ аргыг хэрэглэх үед сурагцагсад нь өөрсдийн туршлага дээр тулгуурлан шийдвэрлэх арга замыг хайдгийн зэрэгцээ маш идэвхтэйгээр оролцохыг шаарддаг байна.

Явц

1. **Оршил**-тодорхой бэрхшээл эсвэл асуулт тавигдана.
2. **Илтгэл**- тухайн бүлгийн гишүүдэд өгөгдсөн бэрхшээл эсвэл асуудлыг шийдвэрлэх, аль болох олон хувилбаруудыг санал болгох даалгавар өгнө. Энэхүү аргачлалыг хэрэглэх үндсэн дүрэм нь бол тухайн хүнээс гарсан ямар ч санаа ямар ч шийдлийг шүүмжлэхгүйд оршино. Асуудлыг шинэлэг сонирхолтой аргаар шийдвэрлэх нь чухал. Багш нь суралцагчдаас гарсан санааг үнэлгээг шүүмж өгөхгүйгээр тэмдэглэж авна

3. **Дүн шинжилгээ** – бүх оролцгчид санаагаа хэлж дууссаны дараа багш болон суралцагчдын болгосон саналуудад нэгтгэж дүн шинжилгээ хийнэ.
4. **Дуусгах**- шигшигдэн үлдсэн санаануудыг тусгайлан авч үзнэ.

Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх хууль

Санаа гарга битгий устга! Жагсааж бич хэлэлцэх хэрэггүй! Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхийн үндсэн зорилго нь суралцагчдыг аль болох өргөнөөр оролцуулах юм. Суралцагчид нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд үзэл бодлоо нэмэрлэх сонирхолтой байх болно. Хэрэв саналыг тусгаж аваагүй бол суралцагчид нь саналаа хамгаалах эсвэл өөрсдөдөө хадгална. Энэ үйл ажиллагааны гол онцлог нь чанартай шийдлүүдийг олохдоо биш зүгээр л гэнэтийн шийдлүүдийг олоход оршиж байгаа юм.

Техник 9. Жүжигчилсэн тоглолт

Жүжигчилсэн тоглолт гэдэг нь бодит амьдрал дээр учирч болзошгүй нөхцөл байдлыг жүжигчилсэн хэлбэрээр гаргаж хэлэхийг хэлнэ. Суралцагчдад дүрүүд өгөх бөгөөд эдгээр дүрүүд бодит амьдралд учирч болзошгүй тухайн нөхцөл байдалд гаргах шийдвэрүүдийг жүжигчилсэн хэлбэрээр танилцуулна. Жүжигчилсэн тоглолтын үеэр гарсан шийдлүүдийг дараа нь авч хэлэлцэж дүн шинжилгээ хийнэ.

Хэрэглээ

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хувьд жүжигчилсэн тоглолтыг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийг зохион байгуулах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэнэ. Дүрд тоглосон суралцагч нь тухайн дүрд тоглосон туршлагаа бодит амьдралд хэрэгжүүлж өөртөө итгэлтэй байх боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн дүрд орсон суралцагч нь бодит амьдралд тулгарч болзошгүй бэрхшээлийг газар дээр нь шийдвэрлэж буй байдлаар шийдвэрлэх бөгөөд энэ нь дээрхтэй адил нөхцөл байдалд орсон тохиолдолд өөртөө итгэлтэйгээр зохих шийдлийг хайж шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.

Явц

1. **Бэлтгэл ажил:**- төлөвлөлт бол маш чухал. Багш нь тоглолтын явцад үүсэх шийдэл гаргах шаардлагатай нөхцлийг нарийн тооцож боловсруулна.
2. **Зааварчилгаа**: –багш нөхцөл байдал, зорилгыг тайлбарлаж, оролцогчдыг сайн дурын үндсэн дээр сонгоно. Оролцогчид өөрсдийн хуваарилагдсан дүрд гарах нөхцлийг судлана.
3. **Тоглолт**: – оролцогчид нь шууд дүрдээ орж тоглоомыг эхлүлнэ.
4. **Дуусгах**:- суралцагчид нь өөрсдийн дүрүүдэд тулгарсан бэрхшээл, гаргасан шийдвэрүүдийн талаар дүгнэлт хийж, хичээлийн сэдэвтэй холбож тайлбарлана.

Жүжигчилсэн тоглолтын зөвлөмж

1. Сайтар төлөвлөсөн жүжигчилсэн тоглолтыг зохион байгуулахад хялбар.
2. Оролцож буй суралцагчдад асуудлыг шийдвэрлэх цагийг хязгаарлана.
3. Дүрд тоглож буй суралцагчийн гаргасан шийдлийг эерэг талаас нь шүүмжилж бай.
4. Жүжигчилсэн тоглолтыг төгсөлт дөхсөн үед зохион байгуулах нь ач холбодолтой байдаг.

Техник 10. Газар дээр нь очиж танилцах

Тодорхойлолт

Газар дээр нь очиж танилцах үйл ажиллагаа нь ангиас гадуур явагдах бөгөөд энэ явцад суралцагчид нь бодит ажлын нөхцөлтэй танилцах боломжоор хангагдана. Энэ үйл ажиллагааг ихэвчлэн сургалтын дундуур зохион байгуулах бөгөөд тэд багштайгаа хамт бодит ажил, бүтээгдэхүүн үйлчилгээ хэрхэн явагддагийг үйлдвэр, дэлгүүр аж ахуйн нэгж гэх мэт газруудад очиж үзэх болно.

Хэрэглээ

Газар дээр нь очиж танилцах үйл ажиллагаа нь ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хамгийн үр дүнтэй арга гэж тооцогдоно.

Явц

Газар дээр очиж танилцах үй ажиллагаг нилээн нарийвчлалтай зохион байгуулах нь зүйтэй бөгөөд дараах үйл ажиллагааг үүнд хамруулна. Үүнд:

1. Суралцагчид нь учрах асуудал болон бэршээлийг сонгож авна.
2. Суралцагчид нь очиж үзэх сонирхолтой компани, аж ахуйн нэгжийг сонгоно.
3. Багш тухайн байгууллагатай холбоо тогтоож холбогдох тохиролцоог хийнэ.
4. Багш нь урьдчилсан байдлаар тухайн суралцагчид юу үзэх, ямар зүйл сонирхож байгааг тайлбарлаж, тухайн үйл ажиллагааг зохион байгуулах хүмүүстэй санал солилцоно.
5. Суралцагчид тухайн байгууллагад ирсний дараа хүлээн авагч байгууллагын төлөөллийг танилцуулна.
6. Хүлээн авагч байгууллагын алба тушаалтан бүгдийг нь дагуулж үйлдвэрлэл, байгууллагын бүтэц зохион байгуулалттай танилцуулна.
7. Суралцагчид ажиглалт хийж тэмдэглэл хөтөлнө.
8. Тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцсаны дараа үзсэн зүйл, хийсэн тэмдэглэлээ харилцан ярилцаж, санал солилцоно.

Хавсралт 4.3. Сургагч багшийн ур чадварын сургалтын төлөвлөгөө боловсруулах удирдамж

ХЭЗЧДС-ын арга зүйн ур чадварын сургалтын бүрэлдэхүүн хэсэг нь сургалтын төлөвлөгөө загвараар боловсруулагдсан байдаг. Сургагч багш нар нь сургалтын хөтөлбөрийг тодорхой заасан загварын дагуу бэлтгэнэ.

Ур чадварын сургалтын төлөвлөгөө нь суралцагчид, сургагч багш нар, сургалтын ажилтнууд эсвэл олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хийгдсэн байна. Энэхүү баримт бичиг нь сургалтын хөтөлбөрийн задаргааг харуулах бөгөөд тухайн ур чадварыг мэдэхэд шаардлагатай мэдлэг, сургалтын арга зүй, аюулгүй ажиллагааны асуудал зэрэг сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөг агуулна.

1. Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл

Сургалтын төлөвлөгөө нь тухайн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг үзүүлэхэд суралцах шаардлагатай мэдлэг, ур чадварыг хэрхэн олгох талаар дэлгэрэнгүй агуулсан байна. Иймээс сургалтын төлөвлөгөө нь тухайн бүтээгдэхүүнийг хэрхэн үйлдвэрлэх вэ? Эсвэл тухайн үйлчилгээг хэрхэн зөв зохистой үзүүлэх вэ? гэдэгт анхаарал хандуулсан байх ёстой.

1.1 Төслийн нэр

Энэ мэдээлэл нь хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон байдлаар өгөгдсөн байна. Ихэнх тохиолдолд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны ерөнхий нэрээр нэрлэсэн байна. Жишээ нь нарийн боов гэх мэт.

1.2. Сургалтын дамжааны нэр

Энэ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчид нь нарийвчлан эзэмших, урч чадварыг нарийвчлан заасан байна. Сургалтын дамжааны нэр нь төслийн ерөнхий нэртэй давхцаж болно. Жишээ нь нарийн боов хийх, талх барих

1.3 Сургалтын байгууллага/зуучлагч

Энэ хэсгийн мэдээлэл нь сургалт явуулахаар тохирсон байгууллага, агентлаг эсвэл сургалтын байгууллагын талаарх мэдээллийг агуулна. Хэрэв тусгайлсан байгууллага байхгүй бол мэргэжлийн сургагчийг хөлсөлж болно. Жишээ нь, Своад цаашдын хяналт шинжилгээ хийх зорилгоор тухайн байгууллагын хаяг байршлийг сайтар тэмдэглэж авсан байна. Жишээ нь, 12 Dhammaratana Mawatta, Mavatha.ampra гэх мэт.

1.4 Сургалтын зорилго

Сургалтын зорилго нь суралцагч, сургагч багш сургалтыг зохион байгуулж буй байгууллага болон оролцогч талуудын эцсийн зорилгыг агуулсан байна. Зорилго нь СМАРТ шаардлагыг хангасан байна. Энэ нь Энгийн, Зохицуулах Боломжтой, Зохистой, Бодитой, болон Цаг хэмнэсэн байх юм. Жишээ нь, 10 хоногийн сургалтын дараа суралцагчид нь зах зээлд нийлүүлж ашиг олж болохуйц таван төрлийн талхийг зохих багаж тоног төхөөрөмжийг ашиглаж хийж сурсан байна.

1.5 Суралцагчдын тоо болон тодорхойлолт

Суралцагчдын тоо болон тодорхойлолт нь хяналт шинжилгээ болон үнэлгээний үйл ажиллагаанд шаардлагатай чухал мэдээлэл юм. Сургалтын дараа 3-6 сарын дотор ХЭЗЧДС-ын төсөл нь төгсөгчдийн аж байдалтай танилцаж, тухайн сургалтыг суралцагчдад нөлөөлсөн байдлыг шалгана.

1.6 Сургалтын хугацаа

Энэ нь сургалтыг дуусгахад шаардлагатай тодорхой өдөр, 7 хоног, сарын хугацааг заасан байна. Сургалтын хугацааг тодорхой заах нь дараах ач холбогдолтой.

- Сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх;
- Гол сургалтын үйл ажиллагааг төлөвлөх;
- Сургалтын дараах үйл ажиллагааг төлөвлөх;
- Суралцагчид болон бусад оролцогчдын бүртгэл хөтлөх *Жишээ нь, 15 хоног эсвэл 125 цаг гэж хөтөлнө.*

1.7 Сургалтын хуваарь

Энэ нь сургалтын үйл ажиллагааг 7 хоногт хэдэн өдөр, өдөрт хэдэн цагаар зохион байгуулахыг тодорхой заана. Сургалтын хуваарийг сургалтад хамрагдагчдын саналыг авч тэдний цаг завийг харгалзсан байдлаар хийгдсэн байна. Жишээ нь хагас бүтэн сайн өдөр бүрийн өглөөний 8-12 цаг хүртэл өдрийн 2-оройн 5 цаг хүртэл

2. Сургалтын загвар

2.1. Төлөвлөж буй сургалтын дамжааны нэр-

Сургалтын нэр нь сургалтын хөтөлбөр дээр заасантай адил байна.

2.2. Сургалтын үр дүнд үйлдвэрлэх бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний нэр

Энэ нь сургалтын явцад суралцагчийн ур чадварыг чухам ямар тодорхой бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээг явуулахад шаардлагатай ур чадварыг олж авах гэж байгаагаас хамааран тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний нэрийг тодорхой бичнэ. Тодорхой нэг төрлийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний ур чадварт суралцах гэж байгаа бол тухайн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний нэрийг шууд бичнэ. Харин хэд хэдэн бүтээгдэхүүн /үйлчилгээний ур чадварт суралцаж байгаа бол сургалтын нэртэй адилхан ижил нэр бичиж болохгүй. Жишээ нь сургалтын дамжааны нэр-талх хийх, бүтээгдэхүүний нэр зөөлөн талх

2.3 Үйл ажиллагаа

Энэ хэсэгт суралцагчийн тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай үйл ажиллагаа бүрийг тоочсон байна. *Жишээ нь, төрөл бүрийн зөөлөн талх хийх эсвэл холбогдох ажиллагаа:*

- ☐ *Зөөлөн талх хийх материалыг бэлдэх;*
- ☐ *Материалыг холих;*
- ☐ *Зууханд хийхэд бэлтгэх гэх мэт.*

2.4 Үйл ажиллагааг нарийвчлан задлах

Энэ хэсэгт дээр дурьдсан үйлдлүүдийг тус бүрээр нарийвчлан задлан дурьдсан байна. *Жишээ нь : үйлдэл 1-материал бэлтгэх үе шат*

- ☐ *Материалыг сонгох*
- ☐ *Зааварчилгааны дагуу материалыг хэмжих*
- ☐ *Хэмжсэн материалыг холих төхөөрөмжид хийх гэх мэт*

2.5 Шаардагдах ур чадвар

Энэ хэсэгт тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үе шат бүрд суралцагчаас шаардагдах ур чадварыг дэлгэрэнгүй дурьдана.*Жишээ нь, үе шат –материал бэлтгэх. Шаардлагатай ур чадвар:*

- ☐ *Материалыг хэрхэн сонгох*
- ☐ *Хэмжих төхөөрөмжүүдийг хэрхэн ашиглах*
- ☐ *Хэмжилтийг хэрхэн хийх болон зуурах багажийг хэрэглэх*
- ☐ *Хэрхэн зуурах гэх мэт*

2.6. Холбогдох мэдлэг.

Энэ хэсэгт тухайн үйл ажиллагаатай холбогдох суралцагч мэдсэн байвал зохих мэдлэгийг дурьдсан байна. *Жишээ нь, талх зуурах үе шат болон шаардлагатай ур чадвар- материал бэлтгэх. Холбогдох мэдлэг:*

- ☐ *Төрөл бүрийн талх хийх материал*
- ☐ *Хэмжих төхөөрөмжүүдийн багтаамж*
- ☐ *Зуурах багажийг зөв хэрэглэх гэх мэт*

2.7 Сургалтын материал

Сургалтын төлөвлөгөөнй энэ хэсэг нь тухайн үйл ажиллагааг гүйцэлдүүлэхэд шаардлагатай сургалтын материалын жагсаалтыг агуулсан байна. Жишээ нь, үйл ажиллагаа- материал бэлдэх сургалтын материал:

- ☐ *Гурил*
- ☐ *Элсэн чихэр*
- ☐ *Хэмжигч аяганууд*
- ☐ *Холих багаж*

2.8. Сургалтын арга зүй

Сургагч нь хэд хэдэн сургалтын арга зүй болон чиг хандлагатай байх хэрэгтэй. Сургалтын явц бүр тусгайлсан арга зүйг шаардана.

Жишээ нь:

- ☐ *Лекц*
- ☐ *Биеэр үзүүлэх арга*
- ☐ *Самбар дээр заах арга*
- ☐ *Төсөл*
- ☐ *Багаар ажиллах*
- ☐ *Газар дээр нь очиж танилцах*
- ☐ *Бүтээгдэхүүний дээж авах гэх мэт*

2.9. Гол нөхцлүүд

Гол нөхцлүүд нь сургалтын үйл ажиллагааны үе шатуудтай амраах дүрэм, журам, санамж зэрэг зохицуулалтаас бүрдэнэ. Эдгээр нь сургагч багшаас тухайн суралцагчдад шаардлагатай ур чадварыг олгоход хийх үйл ажиллгааны цар хүрээг тогтооход чиглэгдэнэ. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн гол нөхцлүүдийг дараах байдлаар товчлон томъёолж болно.-СПЕКС буюу:

- **Хурд**–аливаа өгөгдсөн даалгавар болон ажил нь тухайн үйл ажиллагаа хэрэгжүүлэх тохирсон цаг хугацаанд л хийгдсэн байна.
- **Журам**- бүх ажил болон үйлдвэрлэл нь эсвэл үйлчилгээ нь холбогдох систем болон журмын дагуу хийгдсэн байна.
- **Хэмнэл**- бүтээгдэхүүний үйлдвэрлэх болон үйлчилгээ үзүүлэх үйл ажиллгаа нь аль болох хамгийн бага материалын зарлагаар хийгдсэн байна.
- **Чанар**- бүх бүтээгдэхүүн бараа эсвэл үйлчилгээ нь хэрэглэгчийн шаардлагыг хангасан чанартай хийгдэнэ.
- **Аюулгүй байдал**- бүх зүйлийг холбогдох аюулгүйн дүрэм журам зааварчилгааны дагуу хийгдэж хүн болон өмчийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

2.10 Сургалтын цагийн хуваарь

Энэ хэсэг нь сургалтын бүрэлдэхүүн хэсэг бүрд хамаарах дэлгэрэнгүй цагийн хуваарийг агуулсан байна.

Жишээ нь: үйл ажиллагаа-материал бэлтгэх

Сургалтын цагийн хуваарь: даваа гараг: 2.00-4.00 цаг, үргэлжлэх хугацаа 2 цаг

Хавсралт 4.4. Ур чадварын сургалтын төлөвлөгөөний загвар

1. Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл

(Санамж. Тухайн бүтээгдэхүүн болон үйлчилгээ тус бүр ур чадварын сургалтын төлөвлгөө шаардлагатай байж магадгүй)

Төслийн нэр: .....

Сургалтын хөтөлбөрийн нэр (бүтээгдэхүүн болон үйлчилгээний нэртэй холбогдсон байх ёстой.)

.....

Сургалт зохион байгуулах газар ..... **Байршил**.....

Сургалтын зорилго.....

Суралцагчдын тоо: ..... Сургалтын үргэжлэх хугацаа ..... цаг /өдөр. Эхлэх .....дуусах.....

Сургалтын хуваарь (гараг, өдрийн тодорхой цаг).....

2. Сургалтын загвар

(Энэ загвар нь шаардлагатай хуудсаар бэлтгэгдэнэ)

Сургалтын дамжааны нэр.....

Сургалтын зорилго болсон бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний нэр.....

Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны үе шат	Ур чадварын шаардлага	Холбгдох мэдлэг	Сургалтын материал	Сургалтын арга зүй	Гол журмууд	Сургалтын хуваарь
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Сургалтын дамжааны нэр.....

Сургалтын зорилго болсон бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний нэр.....

Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны үе шат	Ур чадварын шаардлага	Холбгдох мэдлэг	Сургалтын материал	Сургалтын арга зүй	Гол журмууд	Сургалтын хуваарь
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....
.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....

Бэлтгэсэн (сургагчийн нэр, гарын үсэг) .....

Хянасан (сургалтын хяналт) .....

Хавсралт 4.5. Ур чадварын сургалтад хамрагдагчдын бүртгэлийн загвар (ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн загвар загвар, Пакистан)

ОУХБ-ын төсөл

Хөдөөгийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн бүртгэлийн загвар

Санамж. Таны гэрт хүрэх замыг загварын ар талд тодорхой зурна уу. иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана уу

Огноо .....

Нэр..... **Нас/боловсрол/Тосгон/зөвлөл**.....

Муж/ дүүрэг..... **Шуудангийн хаяг** .....

Утас/холбоо барих хүн .....

Одоо эрхэлж буй ажил.....

Одоо эрхэлж байгаа ажил дээр тулгарч буй бэрхшээл

.....

.....

.....

Цаашдын төлөвлөгөө

.....

.....

.....

ХЭЗЧДС-ын хөтөлбөрөөс хүсэж буй дэмжлэг

.....

.....

.....

Хавсралт 4.6. Сургалтын явцын тайлан *(сургалтын дунд цед тайлагнах)*

Сургалтын дамжаа .....

Байршил/сургалт зохион байгуулах газар .....

Сургалт эхлэх огноо..... **сургалт дуусахаар төлөвлөж буй огноо**.....

Сургалт үргэлжэх өдөр /цаг .....

Сургалт эхлэснээс хойш сургалт явуулсан өдрүүд ..... **үлдсэн өдрүүд** .....

№	Үйл ажиллагааны үе шат	Хэрэгжилтийн байдал		Багшийн тэмдэглэл
		Гүйцэтгэсэн	Үргэлжилж байгаа	
1	.....	☐	☐	Техникийн:
2	.....	☐	☐	.....
3	.....	☐	☐	.....
4	.....	☐	☐	.....
5	.....	☐	☐	Захиргааны:
6	.....	☐	☐	.....
7	.....	☐	☐	.....
8	.....	☐	☐	.....
9	.....	☐	☐	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
10	.....	☐	☐	.....
11	.....	☐	☐	.....
12	.....	☐	☐	.....
13	.....	☐	☐	Зөвлөмж
14	.....	☐	☐	.....
15	.....	☐	☐	.....
16	.....	☐	☐	.....

Бэлтгэсэн .....

Сургагч багшийн гарын үсэг болон огноо .....

Хяналт тавьсан ажилтны гарын үсэг, огноо .....

Баталсан (сургалт зохион байгуулж буй байгууллагын удирдлагын гарын үсэг, огноо) .....

Хавсралт 4.7. Сургагчийн тайлан *(төгсөлтийн тайланд хавсаргах)*

Сургалтын дамжаа .....

Байршил/сургалт зохион байгуулах газар .....

Сургалтын нийт үргэлжсэн өдөр цаг .....

Сургалтын үр дүн .....

Нийт суралцагчдынтоо ..... **тэнцсэн суралцагчдын тоо** .....

Тэнцээгүй суралцагчдын тоо ..... **бэлтгэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний тоо**

1. Сургалтын эерэг талууд

.....
.....
.....

2. Тулгарсан бэрхшээл

.....
.....
.....

3. Авсан арга хэмжээ

.....
.....
.....

4. Зөвлөмж

.....
.....
.....

Бэлтгэсэн .....

Сургагч багшийн гарын үсэг болон огноо .....
.....

Хяналт тавьсан ажилтны гарын үсэг, огноо .....
.....

Баталсан (сургалт зохион байгуулж буй байгууллагын удирдлагын гарын үсэг, огноо)

.....
.....

Хавсралт 4.8.Төгсөлтийн тайлан *(Сургалт дууссаны дараа 2 хоногийн дотор тайлагнаж дууссан байна)*

Дамжааны нэр ..... **Байршил/сургалт явагдах газар**.....

Сургалтын үргэлжлэх хугацаа Цаг/өдөр .....Эхлэх .....Дуусах.....

Нийт суралцагчдын тоо Эрэгтэй..... Эмэгтэй..... Хөгжлийн бэрхшээлтэй.....32-оос доош 32-оос дээш

№	Суралцагчдын нэр	Ур чадвар		Үйлдвэрлэлийн сургалт		
		Тэнцсэн	Тэнцээгүй	Төсөл боловсруулсан	Төсөл боловсруулаагүй	Төслийн нэр
1.	.....	.....	.....	.....	.....	.....
2.	.....	.....	.....	.....	.....	.....
3.	.....	.....	.....	.....	.....	.....
4.	.....	.....	.....	.....	.....	.....
5.	.....	.....	.....	.....	.....	.....
6.	.....	.....	.....	.....	.....	.....
7.	.....	.....	.....	.....	.....	.....
8.	.....	.....	.....	.....	.....	.....
9.	.....	.....	.....	.....	.....	.....

Бэлтгэсэн .....

Сургагчийн нэр, гарын үсэг, огноо нутгийн зохион байгуулагчийн нэр, гарын үсэг, огноо

Хянасан/сургалт хариуцсан захирлын гарын үсэг, огноо .....

V

Оршил. I. Сургалтын дараах дэмжлэгийг төлөвлөх. II.Цалинтай хөдөлмөр эрхлэлтийг эхлэхэд дэмжлэг үзүүлэх. III. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Хавсралтууд

Сургалтын дараа бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Оршил

Сургалт нь амжилттай хөдөлмөр эрхлэхийг дэмжих хөтөлбөрийн нэг хэсэг. Үнэндээ дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэглэхгүй бол сургалт нь дангаараа амжилтанд хүрэхгүй. Жишээ нь, эрэлт хэрэгцээгүй, зохистой загвар, хэв маяг байхгүй, зах зээлд хүргэж өгөх, тээвэрлэх боломжгүй бол хүмүүст юм оёхыг заах хэрэггүй. Түүнчлэн хэрэв сургалтад хамрагдсан хүн нь оёдлын машин авах боломжгүй бол түүнд оёхыг заах ч хэрэггүй.

Иймд сургалтад хамрагдаж төгссөний дараа нэмэлт дэмжлэг хэрэгтэй байдаг. Сургалтын дараах дэмжлэг нь хөдөлмөр эрхлэлтэнд (хувиараа хөдөлмөр эрхлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлт, жижиг бизнесийн үйл ажиллагаа) хүрч тухайн сургалтын явцад олсон ур чадвараа ашиглахад тус дэм болно. Сургалтын дараах дэмжлэгийг үзүүлэхийн тулд тухайн үйлчилгээг хүргэж байгаа байгууллага нь хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн чанар болон шаардлагын хувьд хэрэглэгчдийн таашаалд нийцсэн үйлчилгээг явуулж байх ёстой.

1. Сургалтын дараах дэмжлэг

Энэ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн бусад үйл ажиллагаатай адил жендерийн үндсэн дээр ялгаварлан гадуурхахын эсрэг чиглэгдсэн үйл ажиллагаа байна. Хөдөөгийн ядуу эмэгтэйчүүдийн хувьд ихээхэн чухал юм.

Сургалтын дараах дэмжлэг нь дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- ажил олгогчтой холбоо тогтоож ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх;
- жижиг бизнесийг эхлэхэд туслах;
- зээл авахад туслах;
- зах зээлтэй холбох, чанар шалгах, бизнесийн зөвлөгөө өгөх, тээвэрлэлтийг зохицуулах, барааг бөөнөөр худалдаж авах, технологийг нэвтрүүлэх, татвар, загварын үйлчилгээ зэрэг бусад бизнесийг хөгжүүлэхэд нэн чухал шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх;
- албан бус бусад бизнесийн үйл ажиллагааг албажуулах;
- бизнесийг өргөжүүлэхийн тулд орон нутгийн бүтцийг тогтворжуулах;
- орон нутгийн эдийн засгийг хөгжлийн программтай холбож өгөх гэх мэт.

Эдгээр үйлчилгээг дараах байгууллагууд үзүүлэх боломжтой. Үүнд: төрийн болон ТББ, орон нутгийн байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэл, ажилчдын холбоо, өөртөө туслах нийгэмлэг болон ХЭЗЧДС-ын хөтөлбөр өөрөө.

1.1 Сургалтын дараах дэмжлэгийг төлөвлөх

Сургалтын дараах дэмжлэгийн бэлтгэл үйл ажиллагаа нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлтийн үед эхлэнэ. Үүний тулд орон нутгийн хэмжээний түнш байгууллагуудыг тодруултодруулахын зэрэгцээ нөхцөл байдлын судалгаа нь сургалтын дараах дэмжлэгийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллээр хангана. Сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөхөд суралцагчид ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зөвлөл болон бусад түнш байгууллагуудын оролцоо чухал.

1.2 Сургалтын дараах үйлчилгээний сүлжээг хөгжүүлэх

Үр дүнтэй сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь дараах гурван чухал хэсгээс бүрдэнэ:

- ☐ шаардлагатай байгууллагууд байгаа эсэх;
- ☐ үйлчилгээг нэгдсэн зохицуулалтын байдалтай, үр дүнтэй байлгах;
- ☐ Дээр дурьдсан үйлчилгээг хялбар хямд үнэ өртөгөөр нийлүүлэх боломжтой байх.

Гэхдээ хөдөөгийн нөхцөл байдалд дээрх шаардлагууд ховорхон нийцдэг. Сургалтын дараах дэмжлэг нь орон нутгийн түншүүдийн хүсэл эрмэлзлийг нэгтгэж, хамтран ажиллах сүлжээг бий болгох замаар хэрэгждэг зүйл. Иймд сургалтын дараах дэмжлэгийг эхлэх эхний алхам нь болзошгүй түншүүдтэй холбоо тогтоох юм.

Түншүүдийн сул талыг илрүүлж, шаардлагатай чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах, шинэ түншүүдийг хайх нь зүйтэй. Жишээ нь, ОУХБ –н “Өөрийн Бизнесийг Эхлүүл, эсвэл Өөрийн Бизнесийг Сайжруул” хэмээх төслүүдийн туршлагыг хэрэглэж болох юм. ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэлт, орлогыг бий болгох боломжийг тодорхойлж, түүнд үндэслэсэн сургалтыг зохион байгуулах, сургалтын дараа дэмжлэг үзүүлэх зэргийг нарийвчлан зохицуулахыг шаарддаг. Иймд ХЭЗЧДС-ын баг нь холбогдох төрийн болон ТББ-уудын санаачилга, хөтөлбөрийг дэмжиж, хамтран ажиллах хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чиг хандлага, дал айцыг ХЭЗЧДС-ын хөтөлбөр, түнш байгууллагууд нь эдийн засгийн боломж, хэрэгцээг тодорхойлох үе шатанд харилцан тохиролцсон байх хэрэгтэй.

1.3 Сургалтын дараах хэрэгцээг тогтмол тодорхойлох

Сургалтын үйл ажиллагаа дууссаны дараа төгсөгчдийн сургалтын дараах хэрэгцээг яаралтай шинэчлэн тодорхойлж, тогтоох хэрэгтэй. ХЭЗЧДС-ын баг орон нутгийн хүний нөөцийн асуудал хариуцсан хүмүүс, холбогдох ур чадварын сургагч нар болон бизнес сургалтын дамжаанууд, түнш байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн баг нь төгсөгчидтэй уулзаж сургалтын дараах хэрэгцээг шинэчлэн тогтоож, сургалтын дараах дэмжлэгийн төлөвлөгөөг боловсруулна. Ингэхдээ дараах зүйлд анхаарал хандуулна:

- ☐ төгсөгчдийг цалинтай хөдөлмөр эрхлэлтэд хамруулахад шаардлагатай дэмжлэгийг тогтоох;
- ☐ бизнес эхлүүлж тогтвортой болгоход шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох;
- ☐ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эсвэл бичиг үсгийн боловсролгүй иргэдэд шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох;
- ☐ төгсөгчдийн аж байдалтай танилцах үйл ажиллагааг төлөвлөх.

→ **Бангаладешийн сургалтын дараах дэмжлэгийн загвар төлөвлөгөөг хавсралт 5.1-ээс харна уу**

II.Цалинтай хөдөлмөр эрхлэлтийг эхлэхэд үзүүлэх дэмжлэг

Зарим оролцогчид нь цалинтай хөдөлмөр эрхлэхий төлөө сургалтын хөтөлбөрт хамрагддаг. Дээр дурьдсан албан ёсны цалинтай хөдөлмөр эрхлэх боломж хөдөө орон нутагт хомс байх боловч ойролцоох хот суурин газарт ажлын байр байж болно. Энэ тохиолдолд ХЭЗЧДС-ын баг нь тухайн ажлын байрыг өөрийн төгсөгчиддөө нөөцлүүлэх арга хэмжээг авна. Үүний тулд дараах үе шат бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Хөдөлмөрийн зах зээлийн судалж, болзошгүй ажил олгогч/үйлдвэрлэлийн жагсаалтыг гаргах

Ажлын байрны талаарх мэдээлэл гаргах нь хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарна. Хэрэв хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хүн хүчний нөөцийн дутагдлаас болж нь тухайн орон нутагт боломжтой байгаа хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг гаргаж өгөх боломжгүй бол ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг тэдэнд дэмжлэг үзүүлнэ. Үүний нэг жишээ бол Мадагаскар юм. (**Хүснэгт 1-ийг харна уу**.) Хэрэв тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулах байгууллага байхгүй бол ажил олгогч, бусад холбогдох байгууллагатай шууд харилцаа тогтоож хөдөлмөр эрхлэлтийн боломжийг судална. Эдгээр хөдөлмөр эрхлэлтийн боломжийг судлах, ажлын байрыг хайх үйл ажиллагаа нь орон нутгийн судалгаа, сургалтын хэрэгцээг тодорхойлох үе шатанд давхар хийгдэх ёстой. Ажил олгох боломжтой гэж хариу өгсөн ажил олгогчдыг жагсаалтын эхэнд тавина.

Хүснэгт 1. ХЭЗЧДС Мадагаскарт

Мадагаскарын ХЭЗЧДС-ын төсөл нь бүсийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэргэжлийн сургалтын танхим, бусад оролцогчидтой хамтран бүсийн хэмжээнд мэргэжлийн сургалтын мэдээлэл, зааварчилгааны тогтолцоог бий болгохоор хамтран ажилласан. Уг үйл ажиллагааны хүрээнд 14 хүнийг (8 эмэгтэй, 6 эрэгтэй) тусгайлан бэлтгэж, сургалтад хамруулж мэргэжлийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл зааварчилгааны зөвлөхүүд болгосон байна. Эдгээр нь бүс нутгийн мэргэжлийн сургалтын сүлжээний зөвлөхүүд болох бөгөөд Мадагаскарын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт, эрэлт хэрэгцээг холбож өгнө.

Сургалтын дамжааг эхлэхээс өмнө оролцогчидтой хамтран төлөвлөлт хийх

Дамжааг эхлэхээс өмнө оролцогчид цалинтай хөдөлмөр эрхлэлт, тухайн ажилд тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарлана. Сургалтын явцад тэд ажил олгогчийн үйл ажиллагаатай танилцана. Энэ нь тэдний өөртөө итгэх итгэлийг төрүүлэхийн зэрэгцээ ирээдүйн ажлын талаар мэдээлэл өгөх болно.

Суралцагчдын ур чадварыг шалгах

Сургалтын явцын дунд болон төгсгөлд суралцагчдын ур чадварын түвшинг шалгаж, ирээдүйн ажил олгогчийн тавьсан шаардлагад нийцэх эсэхийг тодорхойлно.

Ажлын байр

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, сонирхлоо илэрхийлсэн ажил олгогч, бусад сургалтын дамжаануудын талаарх мэдээллийг тогтмол өгч байх хэрэгтэй. ХЭЗЧДС-ын баг нь дээр дурьдсан ажил олгогчдыг урьж тэдэнд ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааг танилцуулна. Энэ нь эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэлтийн боломж олгохоос татгалзах асуудалд эерэгээр нөлөөлнө. Ямар ч тохиолдолд хувийн сектор нь сургалтын дараах дэмжлэгт чухал ач холбогдол гүйцэтгэнэ. Хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2. Орон нутагт суурилсан сургалтын төсөл/ ХЭЗЧДС-ын ажлын байр олох туршлага.

Зүүн Тиморт хэрэгжсэн ажил хайж буй ажилгүйчүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд ажлын байран дээр ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Энэ ажлын хүрээнд орон нутгийн оролцогчидтой хамтарч ажил хайгчдыг бүртгэх болон ажлын байраар хангах тогтолцоог бий болгосон байна. Түүнчлэн "Нэгдсэн сургалтын үйлдвэрлэл" төслийг эхэлсэн нь ур чадварын сургалт, хөдөлмөрийн зах зээлийг холбох гүүр болсон байна. Тухайлбал, зарим ажил хайгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажлын байр хайж, туслах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ТББ-д ажилд орсон байна.

Пакистанд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн нэгэн түншийн байранд хуулийн этгээдийн бүртгэлийн газар ажилладаг нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төгсөгчдөд ажлын байр олоход тус нэмэр болдог байна.

Түүнчлэн ажил олгогч байгууллагуудтай хамтарч тэдгээрийн хэрэгцээнд нийцсэн сургалтыг явуулж, суралцагчдыг тухайн ажил олгогч байгууллага дээр үйлдвэрлэлийн дадлага хийлгэж тэнд нь ажилд оруулж болох юм. Зарим ажил олгогчид нь эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эсвэл ДОХ-ын халдвар авсан хүмүүсийг ажилд авах сонирхолтой байдаг. **Хүснэгт 3-аас харна уу.**

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгогчдийн сүлжээ

Шриланка дах Цейлоны Ажил олгогчдын холбоо "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгогчдийн сүлжээ"-г 2000 онд байгуулсан бөгөөд энэ байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлд байгаа тэдэнд тохирсон ажлын байрыг санал болгох үйл ажиллагаа эрхэлдэг байна. Тус сүлжээ нь сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авахыг уриалах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ажил олгогчдын уулзалдуулах, энэ асуудлаар үндэсний хэмжээний үйл ажиллагааг зохион байгуулах, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх чиглэлээр багагүй ажлыг хийсэн байна. Уг сүлжээ нь сүүлийн жилүүдэд өргөжин үндэстэн дамнасан, үндэсний компаниудыг эгнээндээ нэгтгэж, төрийн болон ТББ-тай хамтран ажилладаг байна.

Төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээл болон ажлын байрны шаардлагад нийцүүлж сургах, био мэдээллийг бэлтгэх

Ур чадварын сургалтын дараа төгсөгчид нь цалинтай хөдөлмөр эрхлэлтийг хайж байгаа хүмүүсийн жагсаалтад бичигдэнэ. Орон нутгийн ХЭЗЧДС-ын баг нь тэдгээрт био дата бүхий анкет/мэдүүлэг бэлтгэхэд туслаж зааварчилна. Хэрэв төгсөгч нь залуу хүн байвал түүний эцэг эхтэй уулзаж саналыг нь авна. Түүнчлэн зарим орнуудад дээрх саналыг эмэгтэй хүний нөхөр эсвэл эцгээс нь авах шаардлагатай байж магадгүйг анхаарна уу. **Хүснэгт 4-аас харна уу.**

Хүснэгт 4. Хувь хүмүүсийг ажилд бэлтгэх нь

Бангладешд хөдөлмөр эрхлэлтийн зааварчилгаа, жендерийн асуудалтай холбогдуулан эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн ердийн нөхцөлийг бүрдүүлэхэд зориулж сургалтын гарын авлагыг хослуулан гаргасан байна. Дээрх зааварчилгаанууд нь ажил хэрхэн олж болох талаар зөвлөхийн зэрэгцээ ОУХБ-ын холбогдох конвенц, гэрээнүүд, үндэсний хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хууль тогтоомжуудыг агуулсан байна. Эмэгтэйчүүдийн эрх, эрүүл мэнд, мэргэжлийн аюулгүй байдал, хувийн болон гэр бүлийн хариуцлага, өөртөө итгэлтэй байдал, шийдвэр гаргах талаар дээрх гарын авлагад дурьдсан байна.

ОУХБ ын Кени улс дах төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ажил хайх зааварчилгааг гаргасан нь ажил хайж буй эмэгтэйчүүд, залуучуудаас бусад хүмүүс ч мөн үүнийг хэрэглэж болох байна. "Ажилтай болов"- ажил хайгчийн гарын авлага, түүний дагалдах зааварчилгаануудыг азийн орнуудад нэвтрүүлээд байгаа бөгөөд түүнийг одоогийн байдлаар ази африкийн орнуудад хэрэглэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 8-р ботиос авна уу.

Ажил олгогчтой хийх ярилцлагыг зохион байгуулж ажилд орох үйл ажиллагааг эцэслэх

Бэлтгэл ажлын дараа ХЭЗЧДС-ын баг нь оролцогсдод ажил олгогчидтой ярилцлага хийх, бусад ажилд ороход шаардлагатай үйл ажиллагааны талаар дэмжлэг үзүүлж, зааварчилна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажиллаж байгаа байдалтай танилцаж, хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хөтлөх

ХЭЗЧДС-ын баг нь хөдөлмөр эрхэлж буй төгсөгчидтэйгээ тогтмол холбоотой байж, ажилд орсноос хойш 6 сарын дараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааг явуулан үүн дээр тулгуурлан төсгөгчийн хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой байгаа эсэх талаар дүгнэлт гаргана. **(Хүснэгт 5-аас харна уу)**

Хүснэгт 5. **Компьютерийн операторын ажил, Бангладеш**.

Зах зээлийн судалгаа дээр үндэслэн 10 эмэгтэйг компьютерийн операторааp бэлтгэж сургалтад хамруулсан байна. Сургалтад хамрагдагчдын тоо нь хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны хязгаарлагдмал байдлаас болон цөөн байсан байна. Сургалтын явцад ХЭЗЧДС-ын төслийн зүгээс зарим сонирхсон ажил олгогчдод суралцагчдын сургалт болон ур чадварыг харуулахаар уулзалт зохион байгуулжээ. Төгсөгчдөд ажлын байрны нөхцөл байдлын талаар товч танилцуулж, төгсөлтийн дараа сургалтад хамрагдагчид нь ажил олгогчдын жагсаалтад багтсан байгууллагуудад өөрсдийн био мэдээллээ хүргүүлсэн байна. Ажил олгогчид нь төгсөгчдөөс тодорхой мэрэгжлийн ур чадварыг шалгасан шалгалт авсны үндсэн дээр ажилд авсан байна. Төслийн зүгээс дээрх төгсөгчдийг ажлын байртай болгохыг тулд ажилд орох бүхий л үе шат дээр эрчимтэй дэмжлэг үзүүлсээр ирсэн байна. Төсөл нь зарим ажил олгогчтой нягт холбоотой байж ажилд орсон төгсөгчдийнхөө үйл ажиллагаанд байнгын хяналт тавьдаг байна.

III. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг

Албан ёсны цалинтай хөдөлмөр эрхэлтийн боломж нь орон нутагт хомс байдаг. Зарим тохиолдолд хувиараа хөдөлмөр эрхлэх болон бичил үйлдвэрлэлийг бий болгох нь цорын ганц орлого олох боломж байдаг. Иймд ХЭЗЧДС-ын арга зүй нь зорилтод бүлгүүдийн гишүүдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ур чадвартай болгох, тэдэнд ашиг орлоготой, тогтвортой бизнесийн менежментийг хявуулах ур чадварыг олгох зорилгоор сургалтуудыг зохион байгуулдаг. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь ХЭЗЧДС-ын багийн чухал үүргүүдийн нэг болно. Боломжтой тохиолдолд дээрх үйл ажиллагааг түнш болон бусад мэргэжлийн үйлчилгээний байгуулагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна. Дээр дурьдсанчлан боломжтой санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдтэй хамтран ажиллах нь чухал юм.

3.1. Жижиг бизнесийг эхлэх үйл ажиллагааг дэмжих

ХЭЗЧДС-ын баг нь төгсөгчдийн сургалтын явцад олж авсан бизнесийн ур чадвар нь цаашид тэдгээрийг өөрийн гэсэн бизнесийг эхлэх үргэлжүүлэхэд зориулагдахад анхаарал тавина. ХЭЗЧДС-ын баг нь оролцогчдод зах зээлийн эрэлт хэрэгцээ, хөгжил, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэгчдийн таашаалд нийцэх үйлчилгээг хүргэх, жижиг бизнесийн төлөвлөгөөг боловсруулахад туслана.

3.2. Зээл авахад үзүүлэх дэмжлэг

Бичил үйлдвэрлэлийг явуулахад шаардагдах эхлэх эхлэлийн болон ажлын капиталтай байх явдал юм. Гэвч капитал гэдэг нь ихэнх ядуу хүмүүс ялангуяа залуу хүмүүс, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд хязгаарлагдмал нөөц юм. Хөтөлбөрийн үндсэн тодорхойлолтын дагуу уг хөтөлбөрийн цар хүрээнд хамрагдах зорилтод бүлгүүдийн гишүүд нь ядуу хүмүүс байдаг тул тэд өөрсдийн гэсэн бичил, жижиг бизнесийг эхлэх хөрөнгөгүй байдаг. Иймээс тэд гаднаас зээл авах шаардлагатай болдог.

Эдгээр зорилтод бүлгийн хүмүүст хамгийн ашигтай, хамгийн хямд нөхцлөөр олдох, тэдний хэрэгцээнд нийсэн зээлийг авахад ХЭЗЧДС-ын баг туслалцаа үзүүлэх бөгөөд үүний тулд дараах үе шатыг хэрэгжүүлнэ. Үүнд:

а. ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчтэй хамтран санхүүгийн үйлчилгээний хэрэгцээг тогтоох;

б. санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлтийг тодорхойлох;

в. санхүүгийн үйлчилгээ явуулагчтай холбоо тогтоох;

г. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдийг түнш байгууллагатай холбох;

а. ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчтэй хамтран санхүүгийн үйлчилгээний хэрэгцээг тогтоох

Дээр дурьдсан хэрэгцээг тодорхойлоход дараах асуултуудыг хэрэглэнэ. Үүнд:

- ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдэд ямар төрлийн санхүүгийн үйчилгээ шаардлагатай байна вэ? (урт эсвэл богино хугацааны зээл, хадгаламжийн үйлчилгээ, даатгал)
- Эдгээр зээлийг юунд хэрэглэх вэ? (үйлдвэрлэлээ өргөжүүлэх, эрсдэл багасгах гэх мэт). Энэ асуулт нь тухайн зээлийг чухам юунд зарцуулахыг тодруултодруулахаас гадна, тухайн зээлийг хэмжээ, хугацаа зэрэг мэдээллийг шаардана.
- ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчид санхүүгийн байгууллагатай харьцаж байсан туршлагатай юу?
- Тэд зээлийн талаар ямар санал бодолтой вэ?
- Бүх ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдэд зээл, бусад санхүүгийн үйлчилгээ хэрэгтэй юу?

Санамж: Зээлийн хэмжээг аль болохоор бууруулсан байх хэрэгтэй бөгөөд үүний тулд анхны капиталын хэмжээг багасгах (Тухайлбал: бүтээгдэхүүнийг бага хэмжээгээр үйлдвэрлэх, хямд багаж худалдан авах гэх мэт), төгсөгчдөөс өөрсдөөс нь оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Учир нь жижиг зээл аваад түүнийгээ төлсний дараа дараагийн зээлийг нэмэгдүүлж авах нь зүйтэй байдаг.

б. Санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлтийг тодорхойлох

Одоо үйл ажиллагаа явуулж буй зээл олгодог байгууллагууд, тэдгээрийн санхүүгийн менежмент, дэмжлэг үзүүлэх туршлага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдэд хамгийн тохиромжтой гарц гэж үзэж байна. Санхүүгийн үйлчилгээг хүргэх түнш байгууллагыг тодорхойлохын тулд санхүүгийн үйлчилгээний зах зээлийг судлах хэрэгцээ гардаг. Дараах асуултууд судалгаанд туслах болно.

- ХЭЗЧДС-ын хөтөлбөр хэрэгжүүлж буй нутагт ямар байгууллага санхүүгийн үйлчилгээг санал болгодог вэ?
- Эдгээр байгууллагууд нь ямар төрлийн санхүүгийн үйлчилгээг санал болгодог вэ?
- Тэд ямар үйлчлүүлэгчдэд үйлчилдэг вэ?
- Тэдний үйлчилгээ хэрэгцээтэй байгаа бас нэг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл эмэгтэйчүүдэд үйлчилгээг үзүүлж өөрдсийн үйл ажиллагаг өргөжүүлэх сонирхолтой байна уу?

→ **Бичил үйлдвэрлэлийн болзошгүй зээлийн эх үүсвэрүүдийн талаарх мэдээллийг хавсралт 5.2-оос харна уу.**

- Дээрх байгууллагууд хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдах эсэхийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн дараах шалгуур үзүүлэлтээр тогтооно.

☐ хөтөлбөр хэрэгжиж буй орон нутагт салбар сүлжээ байгаа эсэх;

☐ зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, бусад үйлчилгээг орон нутагт үзүүлэх ажилд төлөөлөгчтэй эсэх;

☐ хөдөөгийн ядуу иргэдэд зориулсан хадгаламж зээлийн хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай эсэх;

☐ санал болгож буй үйлчилгээний цар хүрээ;

☐ зээлийн бодлого, богино, дунд хугацааны зээл олгох үйл ажиллагаа нь уян хатан байх;

☐ зарим шаардлагуудыг бууруулж, багаар баталгаа гаргах, орон нутгийн дэмжлэг зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэх боломжтой эсэх;

☐ бодитой зээлийн хүүтэй байх;

☐ жижиг хадгаламжийн бүтцийн туршлагатай байх;

☐ хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байх.

→ **Бичил санхүүгийн байгууллагын хүчин чадлыг тодорхойлох талаар хавсралт 5.3-аас харна уу.**

в. Санхүүгийн үйлчилгээг явуулагчтай холбоо тогтоох

Хамтран үйл ажиллагаа явуулах түнш байгууллагуудыг тогтоосны дараа ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь дээрх байгууллагуудтай хамтран ажиллах нөхцлийг тохиролцоно. Хамтын ажиллагааны нөхцлүүдийг дараах асуултын үндсэн дээр тогтоож болно:

- Яагаад тухайн байгууллага нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилтод бүлгүүдэд өдий хүртэл үйлчилэхгүй байсаар ирсэн бэ?
  - ☐ Эрсдэл ихтэй юу?
  - ☐ Гүйлгээний үнэ өндөр үү?
  - ☐ Зорилтод бүлгүүдийн хэрэгцээний талаарх мэдлэг дутмаг уу?
- Санхүүгийн байгууллагуудын санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд ХЭЗЧДС-ын зорилтод бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна уу?
- Энэ бэрхшээлийг арилгахад юу хийх хэрэгтэй вэ?
  - ☐ Тэдгээрийн бүтээгдэхүүн эсвэл ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцүүлэхэд шаардлагатай санхүү/техникийн туслалцаа;
  - ☐ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг гадуурхагдсан бүлгүүдийг дэмжих талаар уриалах, сургалтад хамруулах;
  - ☐ ХЭЗЧДС-ын үйлчлүүлэгчдийн зарим хэрэгцээг хангахад үзүүлэх дэмжлэг, тухайлбал, байрны түрээс, сургалтын зардал гэх мэт
  - ☐ Эрсдэлийг хуваалцах механизм/баталгаа;

→ **Зээлийг батлагаажуулах хөрөнгийн талаар хавсралт 5.4-өөс харна уу**

Зээлийн санхүүжилт тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөс гарах хэрэгтэй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь өөрийн санхүүжилтээс гаргасан хөрөнгө ОУХБ-аас хэрэгжүүлж буй уг төслийг тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлнэ.

ХЭЗЧДС-ын хөтөлбөр болон түнш санхүүгийн байгууллага хоёрын хооронд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах нь зүйтэй бөгөөд энэхүү санамж бичигт түншлэлийн нөхцлийг тусгасан байна.

Хэрэв ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тохирох санхүүгийн үйлчилгээ олдохгүй бол ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зээлийн санг бий болгохыг бодолцох нь зүйтэй. Гэхдээ өмнөх туршлагаас харахад ийм төрлийн зээлийн санхүүжилт нь үйл ажиллагааны тогтвортой байдалд муугаар нөлөөлөх хандлагатай байдаг тул уг алхмыг маш болгоомжтой хийх хэргэгтэй.

г. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдийг түнш байгууллагатай холбох

Санхүүгийн байгууллагууд нь зээл авагчдад тодорхой хэмжээний шалгуур үзүүлэлтийг тавьдаг. Түүнчлэн зээлийг тодорхой хэлбэрээр (бэлэн мөнгөөр, шилжүүлгээр,

тоног төхөөрөмж худалдаж авах гэх мэт) олгодог. Эдгээр нөхцлүүдийн талаар харилцан ойлголцлын талаарх санамж бичигт дурьдсан байх хэрэгтэй. ХЭЗЧДС-ын баг нь зээл авч буй төгсөгчдөд зээлийн нөхцөл, хамрах цар хүрээ зэргийг бүрэн ойлгуулсан байх хэрэгтэй.

Төгсөгчдөд тавигдах шалгуур үзүүлэлтүүд

- ХЭЗЧДС-ын баг нь сургагчтай хамтран тухайн төгсөгчийн сургалтын явцад гаргасан сургалтын явцын байдалд үнэлгээ өгнө:
  - ☐ Ур чадвар- хийсэн бүтээгдэхүүн, чанар, зарцуулсан цаг;
  - ☐ Бизнесийн сургалт- бизнес төлөвлөгөө, төсөл гэх мэт
  - ☐ Ерөнхий байдал-ааш зан, ирц гэх мэт
  - ☐ Зээл хүсэх загварыг бөглөсөн байх
- ХЭЗЧДС-ын баг нь тухайн бизнес явагдахаар төлөвлөгдөж байгаа газар дээр очиж биечлэн танилцана.

Хэрэв дээр дурьдсан шалгуур үзүүлэлтэд тэнцэж байвал ХЭЗЧДС-ын баг түүнд зээл авах тодорхойлолтыг олгож болно. **(Хүснэгт 6- г харна уу)**

Хүснэгт 6. Санхүүгийн байгууллагатай холбох нь

Бангладешд ХЭЗЧДС-ын төсөл нь Читтагонгийн худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогчдын холбоо, Бангладешийн бизнес эмэгтэйчүүдийн танхим, бусад байгууллага, бизнес эрхлэгчдийн хооронд холбоо тогтоосон байна. Эдгээр байгууллагуудын нэг болох ПФСФ нь дээрх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаануудад зээл олгохыг санал болгосон байна.

3.3. Үйлдвэрлэл явуулах зориулалт бүхий байр олох

Дийлэнх тохиолдолд бичил үйлдвэрлэл эрхлэгч нь үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор үйлдвэрлэлээ өөрийн гэрт явуулдаг. Эмэгтэй бичил үйлдвэрлэл явуулагчдын хувьд үйлдвэрлэл болон гэрийн ажлаа хослуулж байгаа нь харагддаг. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь үйл ажиллагаагаа мөн л гэртээ явуулдаг байна. Бизнесийн төрлөөс хамааран зарим тохиолдолд үйл ажиллагааг зах зээлд ойрхон эсвэл түүхий эдийн эх сурвалжид ойрхон байлгах нь зүйтэй. Үйлдвэрлэл явуулах байрыг сонгохдоо тоног төхөөрөмж байрлуулах зай, түүхий эд, бүтээгдэхүүнийг нөөцлөх, хадгалах боломжтой эсэхийг харгалзах нь зүйтэй. Хэрэв шаардлагатай бол орон нутгийн ХЭЗЧДС-ын баг хэрэгцээ шаардлагад нийцсэн байр олох ажилд дэмжлэг үзүүлж, шаардлагатай гэрээ хэлцлийг хийхэд туслана.

3.4. Багаж, тоног төхөөрөмж

Сургалт болон сургалтын дараа дэмжих ажиллагааны төлөвлөгөөг хийх явцад ХЭЗЧДС-ын баг нь үйл ажиллагаанд шаардагдах багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан байна. Багаж тоног төхөөрөмжийг явуулахаар төлөвлөж байгаа үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн авах бөгөөд оролцогчийн ур чадвар, боломжид нийцүүлсэн байна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр худалдан авч маш бага үнээр өөрийн төгсөгчдөд түр хэрэглүүлэхээр өгч болно. Ийм тохиолдолд төгсөгч болон ХЭЗЧДС-ын хөтөлбөр хооронд гэрээ хийгдсэн байна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлгийн иргэдэд багаж тоног төхөөрөмжөөр тусалцаа үзүүлэхээр бол эдгээрт бусад гишүүдээс илүү хөнгөлөлттэйгөөр үзүүлнэ.

3.5. Зах зээлийн дэмжлэг

Тухайн зах зээлд шинээр орж ирж буй ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төгсөгчдөд энэ чиглэлийн дэмжлэг хэрэгтэй болно. Зах зээл гэдэг нь сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чухал хэсэг бөгөөд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс төгсөгчдийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргах, танилцуулах зэрэг асуудал тусгайлан анхаарал хандуулна. Түүнчлэн зах зээлийн асуудалд эмэгтэйчүүдэд ялгаварлан гадуурхаж хандаж байгаа эсэхэд анхаарал тавьж, эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

3.5.1. Зах зээлийн талаарх мэдлэг олгох

Сургалтын эхэн үед суралцагчдын бизнес менежмент, зах зээлийн талаарх ойлголт мэдлэгийг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн зах зээл дээр очих ирээдүйн болзошгүй худалдан авагчидтай ярилцах уулзалт зохион байгуулна. Энэхүү чадвар нь бизнесийг эхлэсний дараа бизнесийн зөвлөгөө, орон нутгийн бизнесийн хүрээнд орсноор нэмэгдэх болно.

3.5.2. Зах зээлийн стратегийг хөгжүүлэх

Маркетингийн сайн ур чадвар, үүнтэй холбогдох мэдлэгтэй байх нь тогтвортой бизнес эрхлэхэд чухал ач холбогдолтой. ХЭЗЧДС-ын баг нь төгсөгчдөд зах зээлийн төлөвлөлт, стратеги боловсруулахад туслах бөгөөд үүнд дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

- ☐ бүтээгдэхүүний орц, нийлүүлэгчид, томоохон худалдаачид, худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг компаниудтай зах зээлийн холбоо тогтоох
- ☐ сурталчилгаа, урамшуулалт худалдаа;
- ☐ бараа бүтээгдэхүүнийг шинэчилж байх;
- ☐ зах зээлийн сувгийг сонгох.

3.5.3. Зах зээлийн холбоог хөгжүүлэх

ХЭЗЧДС-ын баг нь хамтарч ажиллаж болох зах зээлийн түншийг тодорхойлж, харилцаа холбоо үүсгэхэд дэмжлэг үзүүлнэ. ХЭЗЧДС-ын баг нь болзошгүй худалдан авагчдын жагсаалтыг гаргасны дараа бүтээгдэхүүнийг сурталчилах зорилгоор тэднийг урьж, шинээр бичил үйлдвэрлэл эхэлсэн талаар мэдэгдэж, бараа бүтээгдэхүүнийг танилцуулна.[1]

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг нь үйлдвэрлэгч, том үйлдвэрлэгчийн хооронд давхар гэрээ хийхийг дэмжсэн үйл ажиллагаа явуулна. Энэ үйл ажиллагааг Мадагаскарт хэрхэн хэрэгжүүлсэн талаар хүснэгт 7-оос харна уу.

Хүснэгт 7. Мадагаскарт хувийн хэвшлийн салбарт холбоо тогтоосон талаар

ХЭЗЧДС-ын төсөл нь ногоон вандуйны экспортын үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшилтэй харилцан холбоо тогтоосон. Энэ нь тухайн орон нутгийн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг давхар гэрээний үндсэн бүтээгдэхүүн нийлүүлэхээр болсон бөгөөд тэдэнд шаардлагатай ур чадварыг олгосон байна. Энэ үйл ажиллагаа нь орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг олон улсын зах зээлд гарах боломжтой болгосны зэрэгцээ өөрсдийн бүтээгдэхүүний илүү том зах зээл дээр, илүү үнээр борлуулах боломжтой болгосон байна. Тус төслийн зүгээс жендерийн асуудалд мэдрэмжтэй хандсаны үндсэн дээр эрэгтэй болон эмэгтэйчүүд хамтран сургалтад оролцож хэд хэдэн үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, үйл ажиллагааг явуулах байрны барилгыг хамтдаа барьсан байна.

3.5.4. Сурталчилгаа, урамшуулалт худалдаа

Барааг сурталчилах нь байнгын тодорхой давтамжтай үйл ажиллагааг шаарддаг. Тухайлбал, сурталчилгааны компанит ажлыг зохион байгуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг нь үүнд хамаарна. Шриланкийн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төсөл нь “Бүтээгдэхүүний үзэсгэлэн” –г зохион байгуулж, бичил үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ сурталчлах боломжийг олгосон байна. (Хүснэгт 8.)

3.5.5. Бараа бүтээгдэхүүнийг шинэчилж байх

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл үйлчилгээг хүргэх гэдэг нь зөвхөн тоног төхөөрөмж, багаж ашиглахыг хэлдэггүй юм. Зах зээл дээр өрсөлдөхүйц байхын тулд дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.

- ☐ үйлчлүүлэгчийн таашаал- загвар, өнгө, материал;
- ☐ үнэ;
- ☐ бүтээгдэхүүний чанар, сав баглаа боодол;
- ☐ бүтээгдэхүүнийг чанар, тоон хэмжээг эрэлт хэрэгцээнд нийцүүлж байх;
- ☐ Эхэлж буй бизнесээ өргөжүүлэхийн тулд эсвэл тогтвортой байлгахын тулд бүтээгдэхүүнээ байнга шинэчилж байх.

Хүснэгт 8. Шриланкад зохион байгуулсан бүтээгдэхүүний үзэсгэлэн

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын дараах үйл ажиллагааны хүрээнд Шриланкийн төслийнхөн төсөлд хамрагдагчдад зориулж, гурван удаагийн бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулсан байна. Уг үйл ажиллагаа нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бичил үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа иргэд харилцан холбоо тогтоож хамтарч ажиллах, зах зээлтэй харилцаж сурах, технологийн шаардлага, бичил санхүүгийн талаар тодорхой мэдлэгтэй болоход ихээхэн түлхэц үзүүлсэн байна.

Эхний үзэсгэлэнг төслийн эхний ээлжийн үйл ажиллагаанд хамрагдсан 18 үйлдвэрлэгч, хоёр дах нь 56 үйлдвэрлэгч оролцсон бөгөөд 3 дах үзэсгэлэнг Хөдөөгийн үйлдвэрлэл, хувираа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих яамтай хамтран зохион байгуулжээ. Энэхүү 3 дах үзэсгэлэнд 73 байгууллага оролцож, бүх үзэсгэлэнд орон нутгийн засаг захиргаа, Худалдаа аж үйлдвэрийн танхим, орон нутгийн банкууд идэвхтэй оролцсон байна. Үзэсгэлэнгүүдийн үр дүнд 92 гишүүн бүхий Орон нутагт суурилсан үйлдвэрлэлийн холбоог ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр байгуулсан байна. Тус холбооны гишүүд нь одоогоор нэгдсэн нэг байранд үйл ажиллагаа явуулж байгаа, бүх гишүүддээ санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна.

Дээрх үзэсгэлэнгүүд нь ОУХБ, Засгийн газраас зохион байгуулсан цунамигийн хохирогчдын санхүүгийн нөхцөл байдлыг сэргээх хөтөлбөр, уг хөтөлбөрийн хүрээнд ур чадвар, бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих дэмжлэг үзүүлэх төсөлд идэвхтэй оролцож ирсэн байна. Дээрх амжилтууд нь Худалдаа аж үйлдвэрийн танхим идэвхтэй дэмжиж, туслалцаа үзүүлэн, Засгийн газрын зүгээс орон нутагт суурилсан сургалтуудыг үндэсний хэмжээнд бодлогын түвшинд авч хэлэлцэх шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн байна. Үзэсгэлэнгийн бүтээгдэхүүн нь хүнсний үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, ургац хураалтын дараах үйлчилгээ, гэр ахуйн бараа гэх мэт олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг хамруулж байсан бөгөөд нийтдээ 92 байгууллагын 32 төрлийн бараа, үйлчилгээг үзэсгэлэнгээр дамжуулан танилцуулжээ.

Үйлдвэрлэлийн бүлгүүд нь үзэсгэлэнг Каимюнаи дах нэг давхар зах, Ампарагийн ТББ-ын туслалцаатайгаар тус тус зохион байгуулсан байна. Зарим тохиолдолд оролцогчид олон улсын зах зээлтэй холбогдох, үнэт зүйлсийн гинжин холбоог бий болгосон байна. Оролцогчид нь орон нутгийн технологийг ашигласан бөгөөд, ялангуяа хүнсний үйлдвэрлэлд орон нутгийн технологийг түлхүү ашиглажээ.

Орон нутгийн ХЭЗЧДС-ын баг нь үйлдвэрлэгчдэд зах зээл дэх үйлчлүүлэгчийн хэрэгцээ, зах зээлийн цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн хүргэдэг байх хэрэгтэй бөгөөд үйлдвэрлэгч дээрх мэдээлэл дээр үндэслэн өөрийн бараа бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, сайжруулах зэрэг арга хэмжээг авна. Энэ нь тодорхой үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх, үнэ хаялцах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд хүргэнэ.

Нэгтгэж хэлбэл ХЭЗЧДС-ын төслийн хөтөлбөр нь иргэдэд дараах байдлаар туслана:

- ☐ бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үнийг тогтоох;
- ☐ түүхий эд, сэлбэг, үйлчилгээний шинэ үнэ хэмнэсэн эх үүсвэрүүдийг олох;
- ☐ бүтээгдэхүүнийг шинэчлэх, сайжруулах;
- ☐ чанарын шалгалт хийх;
- ☐ үйлдвэрлэх шинэ бүтээгдэхүүнийг тогтоох;
- ☐ шинэ зах зээлийг тогтоох, үүнд орон нутгийн гаднах зах зээл ч хамрагдаж болно.
- ☐ тодорхой бүтээгдэхүүн эсвэл зах зээлд зориулсан шаардлагатай ур чадварыг нэмэгдүүлэх.

[1] ОУХБ ын “Сурталчлах ур чадвараа сайжруулах нь”

3.5.6. Зах зээлийн сувгийг сонгох

Зах зээлийн тухай мэдээлэл, мэдлэгтэй байх нь зах зээлийн сувгуудыг мэдэж байх нь амжилттай үйл ажиллагааны түлхүүр юм. Бүтээгдэхүүнийг борлуулах төрөл бүрийн суваг байдаг, өөрийн дэлгүүрээс шууд борлуулах, байшингаас байшин хооронд дамжин санал болгож борлуулах, бөөний худалдаа эрхлэгч эсвэл зуучлагчаар дамжуулж борлуулж болох юм. Борлуулах аргын сонголт нь бүтээгдэхүүн, санхүүгийн нөхцөл байдлаас хамаарах бөгөөд бичил үйлдвэрлэгчдэд төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн борлуулах нөхцлүүд байж болно.

Зах зээлийн борлуулагч төлөөлөгчтэй байх нь томоохон үйлдвэрлэгч эсвэл бөөнөөр нэгдэж нийлсэн үйлдвэрлэгчдийн хувьд ашигтай байна. Иймээс борлуулалтын стартегийг боловсруулж, зах зээл дээр шударга үнэ тогтоож, зах зээлийн томоохон хэсгийг мэдэлдээ оруулж авах нь чухал юм.Нэгэнт бизнес тогтвортой явж эхэлсэн тохиолдолд маркеттингийн үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар өөрсдөө шийдэж болно. **Хүснэгт 9-ийг үзнэ үү.**

Нэгэнт бизнесийн үйл ажиллагаа тогтворжиж бичил үйлдвэрэл эрхлэгчид нь зах зээлийн үйл ажиллагааг ойлгож эхлэсний дараа тэдгээр нь зах зээлд цааш нь нэвтрэх эсэхээ шийдэж болно.

Хүснэгт 9. Бангладешийн зах зээлийн зуучлал

Бангладешийн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан эмэгтэйчүүдийн бүлэгийн үйлдвэрлэж байсан цаасан хайрцаг зах зээл дээр танил болсон байна. Гэхдээ эмэгтэйчүүдийг худалдаа эрхлэхийг хориглох, хавчдаг тул тэдгээр эмэгтэйчүүд өөрсдийн бүтээгдэхүүнээ зах зээлд байнгын үйл ажиллагаа эрхэлдэг эрэгтэйчүүдэд өгч борлуулсан байна.

3.6. Хууль зүйн зохицуулалтыг шаардлагад нийцүүлэх

Төгсөгчид нь бизнес, худалдааны үйл ажиллагааны зөвшөөрөлтэй холбогдох эрх зүйн зохицуулалтын шаардлагын талаар тодорхой мэдлэгтэй байх хэрэгтэй. Сургагчид нь дээрх мэдээллийг сургалт, сургалтын дараах дэмжих ажиллагааны явцад холбогдох мэдээллийг байнга өгч байх хэрэгтэй бөгөөд төгсөгчид нь энэ төрлийн мэдлэгтэй байх ёстой.

3.6.1. Орон нутгийн захиргаанаас үйл ажиллагааны зөвшөөрөл авах

Бизнесийн үйл ажиллагаа нь хүлээн зөвшөөрөгдөж хууль ёсны дагуу байх ёстой гэдгийг ойлгох нь чухал. Төгсөгчдөд шаардлагатай зөвшөөрлийг бизнес эрхлэхээсээ өмнө авахад ХЭЗЧДС-ын баг туслана. Хэрэв шаардлагатай бол оролцогч, ХЭЗЧДС-ын баг, орон нутгийн төлөөлөл бүхий уулзалтыг зохиож болно.

3.6.2. Стандарт хэмжил зүйн байгууллагын зөвшөөрөл авах

Зарим бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэхэд хангасан байхыг шаарддаг стандарт байдаг. Ялангуяа хүнсний бүтээгдэхүүнүүдийн тодорхой хэмжээний стандарт шалгууруудыг хангасан байдлыг тусгай мэргэжлийн байгууллагуудаар шалгуулдаг. Иймд тухайн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэхээс өмнө энэ талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй болсон байх ёстой. Дээрх төрлийн зөвшөөрлийг авахад цаг зав их зарцуулагддаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

3.7. ХЭЗЧДС-ын төгсөгчдийн аж байдалтай танилцах

Бичил, жижиг бизнесийн үйл ажиллагаа нь дампуурах эсвэл ашиггүй ажиллах нь холбогдох бизнесийн зөвөлгөө дутагдснаас болдог. Энэ нь ихэвчлэн анх удаагаа бизнес эрхэлж байгаа хүнд тохиолдох бөгөөд ялангуяа эхний 3 жилийн хугацаанд түгээмэл байдаг байна. Төгсөгчдийн эрхэлж буй үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд, ялангуяа эхний хэдэн сарын туршид тогтмол хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж байх нь зайлшгүй шаардлагатай байдаг. Шинэ өрсөлдөгчид, бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээний уналт, бизнесийн менежментийн үйл ажиллагааны хангалтгүй байдал нь эрсдэлд хүргэж болно. Сургалт дууссаны дараа ХЭЗЧДС-ын багийн гишүүд, сургагч нар төгсөгчдийн эрхэлж буй үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцана. Ингэж танилцах үйл ажиллагаа нь дараах зорилготой байна.

- бичил үйлдвэрлэлийг явуулахад суралцсан ур чадвараа ашиглан хяналт шинжилгээ хийх, үйл ажиллагаанд учирч байгаа саад бэрхшээлүүдийг тодорхойлж зөвөлгөө өгөх;

- үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа байдлыг нь итгэлтэй болгох, бизнесийн зөвлөгөө өгч, дараах бизнест хөтлөгдөх шардлагатай бичиг баримтыг хөтлөх талаар анхааруулах;
  - ☐ мөнгөний гүйлгээг бүртгэсэн бэлэн мөнгөний бүртгэл;
  - ☐ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жагсаалт;

- үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндээ хамгаалах, технологийг зөв хэрэглэх талаар зөвөлгөө өгөх;

- хэрэв үйлдвэрлэлд хөлсний ажилчид ажилладаг бол тэдгээрийн ажлын нөхцөл, цалин хөлсний асуудалд анхаарал хандуулна.

Дээр дурьдсан зөвөлгөө өгөх асуудлыг тухайн орон нутагт амжилттай бизнес явуулж байгаа хүнээр өгүүлэх нь зүйтэй бөгөөд ХЭЗЧДС-ын баг нь ийм хүмүүстэй урьдчилсан байдлаар уулзаж хамтран ажиллах талаар тохирсон байх хэрэгтэй.

Дээр дурьдсан зөвөлгөө өгөх хяналт шинжилгээ өгөх замаар төгсөгчдийг эргэж очих үйл ажиллагаа 6 сарын турш тогтмол хийгдэж байх хэрэгтэй бөгөөд үүний үр дүнд цуглуулсан мэдээллийг сургалтын дараах дэмжлэг, хяналт-шинжилгээний загварын дагуу хөтөлсөн байна.

→ **Сургалтын дараах хяналт-шинжилгээ бичил үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах загварыг хавсралт 5.5-аас үзнэ үү.**

Дээр дурьдсан зөвлөгөө өгөх, танилцах үйл ажиллагаа, холбогдох тэмдэглэлийг ХЭЗЧДС-ын баг, орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлтэй хамтарч үйлдэнэ. Тэмдэглэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шаардлагатай бол сургалтын хөтөлбөр, заах арга зүйд холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж, дутмаг байгаа ур чадварыг сайжруулах талаар дараа дараагийн сургалтад илүү анхаарах арга хэмжээ авна.

3.8. Хамтарч бүлгээр үйл ажиллагаа явуулахад үзүүлэх дэмжлэг

Бичил үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ихэнх тохиолдолд бие даасан үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн боломж муутай байдаг. Орон нутгийн тодорхой салбарын үйл ажиллагаа эрхэлдэг хоршоолол, нийгэмлэгүүд нь бараа бүтээгдэхүүнийг бөөнөөр авах, үнэтэй тоног төхөөрөмжийг авах, шинэ технологийг нэвтрүүлэх, зээл авах зэрэг үйл ажиллагаанд хамтарч оролцох нь ашигтай байдаг.

Төгсөгчид нь тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд үйлдвэрлэлийн багуудыг бий болгож, зах зээлд хамтран гаргах, хамтарч зээл авах зэрэг саналуудыг дэвшүүлж болно.

Ийм тохиолдолд зарим зүйлүүд дээр хэмнэлт гаргаж болно. Тухайлбал, дундын өмчлөлийн тоног төхөөрөмж, багажтай байх нь ашигтай байдаг. Түүнчлэн түүхий эдийг бөөний үнээр хамтарч авах нь ашигтай байдаг бөгөөд хэд хэдэн үйлдвэрлэл нийлсэн тохиолдолд хүчээ нийлүүлж том захиалга авах, захиалгыг цаг тухайд нь нийлүүлэх боломж бүрддэг.

Тэдгээрийн хамтран байгуулсан нийгэмлэг нь тухайн орон нутгийн хувьд зонхилох байр суурь эзэлж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж болно. Ингэж нэгдэж бүлэглэлүүд байгуулсан тохиолдолд төрийн болон ТББ, санхүүгийн байгууллагын дэмжлэг туслалцааг авахад дөхөм болно.

Гэхдээ хамтарсан үйлдвэрлэл нь зарим гэсэн сөрөг талтай байдаг. Хамгийн гол учирч болзошгүй бэрхшээл нь орлогыг хэрхэн хуваах тал дээр бий болж болно. Учир нь тал болгоны оруулсан хувь нэмрийг үнэлэх үнэлэмж өөр өөр байна. Тухайлбал, тоног төхөөрөмжийн, бэлэн мөнгөний, оюуны хувь нийлүүлэлтийн төрлүүд байж болох юм.

Сургалтын дараах дэмжлэгийн хүрээнд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн баг нь дээр дурьдсан хамтын ажиллагааны бүлэглэлүүдийг бий болгох үйл ажиллагааг дэмжих бөгөөд шаардлагатай, нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх үйл ажиллагаанд мөн оролцож болно.

→ **Бүлгийн үйл ажиллагааны загварыг хавсралт 5.6-аас харна уу.**

→ **Хадгаламж зээлийн бүлгийн удирдамжийг хавсралт 5.7-оос харна уу.**

Хавсралтууд

Хавсралт 5.1. Бангладешийн сургалтын дараах дэмжлэгийн загвар төлөвлөгөө

Сургалт	Сургалтын дараах дэмжлэг	Хариуцах мэргэжлийн байгууллага
Цаасан хайрцаг, тор бэлдэх үйлдвэрлэлийн сургалт Сургалт нь 2005 оны 4-р сарын 12-ноос 2005 оны 5-р сарын 29-ний хооронд явагдах бөгөөд сургалтад хамрагдагчид нь цаасан хайрцаг, тор үйлдвэрлэж сурахын зэрэгцээ, бизнес менежмент, жендерийн асуудлаарх сургалтад давхар хамрагдана. Сургалтын үргэлжлэх хугацаа – нийт 39 өдөр, оролцогчдын тоо -15	Үйлдвэрлэл, зах зээлд хамтран ажиллах бүлгийг зохион байгуулах: ◦ “Шатата бизнес групп” байгуулж бүртгүүлэх, бичил санхүүгийн байгууллагаас зээл авах нөхцлийг бүрдүүлэхийн 3 долоо хоногийн хугацаа хэрэгтэй. Үүнд **2 сарын бизнес инкубаторын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:** ◦ Суралцагчид нь хайрцаг, тор үйлдвэрлэх ур чадвар болон мэргэжлийн дадлагаа 2 сарын туршид бизнес инкубаторт сайжируулна. ◦ Сургагчийн хяналтан доор тоног төхөөрөмж бүхий түрээсийн байранд туршин үйлдвэрлэл явагдана. ◦ “Шатата бизнес групп” нь өөрсдийн бизнесийн хэрхэн явуулахыг зохион байгуулна. Гишүүд нь зээл авахад шаардлагатай нөхцлийг бүрдүүлнэ. Мөн тэдгээр нь орон нутгийн захиргаанаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авна. ◦ 2 дах сарын эцэс гэхэд тэдгээр нь бизнес үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон байна. **Зах зээлийн холбоос:** ○ Түнш байгууллагууд нь хайрцаг борлуулах зах зээлд холбоос тогтооход нь туслана. ○ Хөрш зэргэлдээх хотын болзошгүй худалдан авагчдад зориулж бүтээгдэхүүн сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулна. **Зээл авах:** ○ Зээл авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ○ Зээлийн хугацааг түнш байгууллагын тусламжтайгаар сунгах ○ Баг нь зээл авна ○ Хяналт-шинжилгээ болон зээлийн менежмент **Хяналт –шинжилгээ:** ○ Бэлтгэгдсэн загварын дагуу бизнес үйл ажиллагаанд тогтмол хяналт шинжилгээ хийх	Төслийн баг/түнш ТББ Төслийн баг/түнш ТББ “Шатата бизнес групп” Төслийн баг/түнш ТББ “Шатата бизнес групп” Төслийн баг/түнш ТББ “Шатата бизнес групп” Төслийн баг/түнш ТББ “Шатата бизнес групп” Төслийн баг/түнш ТББ “Шатата бизнес групп”

Хавсралт 5.2. Бичил үйлдвэрлэлийн болзошгүй зээлийн эх үүсвэрүүд

а) Арилжааны банкууд

Энгийн арилжааны банкууд нь хөдөө орон нутгат үйл ажиллагаа явуулдаг бөгөөд зээл авахын тулд биет барьцааны зүйлийг нэхдэг. Дийлэнх банкууд том зээлийг жижиг зээлээс илүүд үздэг бөгөөд зээл хөөцөлдөхөд хугацаа шаарддаг. Мөн дээрх банкууд нь хөдөөгийн ядуу иргэд ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудыг эрсдэл бүхий үйлчлүүлэгч гэж тооцдог байна. Нэгэнт ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төгсөгчид нь ихэвчлэн барьцаанд тавих эд зүйлгүй байдаг тул арилжааны банкнаас зээл авна гэдэг нь төдийлөн боломжтой зүйл биш юм. Гэхдээ зарим тохиолдолд дээрх банкууд нь албан бус үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байдаг бөгөөд үүний хүрээнд бичил зээлд хамрагдах боломжтой.

б) Төрийн байгууллагууд

Ихэнх орнууд төрөөс ивээн тэгтгэсэн зээлийн сүлжээтэй байдаг бөгөөд эдгээр нь хөдөөгийн хэрэглэгчдэд хөнгөлттөй нөхцөлөөр олгогддог. Хэдийгээр эдгээр зээлүүд нь боломжтой зээлийн эх үүсвэр гэж тооцогдох боловч зээлүүдийг ихэвчлэн тодорхой нэг салбарыг хөгжүүлэхэд зориулсан байдаг.

Түүнчлэн төрийн санхүүжилт нь тодорхой улс төрийн зорилгоор зөвхөн тодорхой зорилтод бүлгүүдэд олгогдох нөхцөлтэй байх талтай.

Төрийн зээлд хамрагдана гэж тооцохоос өмнө ХЭЗЧДС-ын төгсөгчид нь эдгээр зээлүүдийн талаар тодорхой мэдээлэлтэй байх хэрэгтэй. Ялангуяа зээлийн бодлого болон зээл авагчид тавигдах шаардлагуудыг нарийвчлан судлах хэрэгтэй.

в). Бичил санхүүгийн байгууллага

Эдгээр байгууллагуудад нь нийгмээс гадуурхагдсан ядуу иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байна. Нийгэмд хандсан, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулдаг дээрх байгууллагууд нь хөтөлбөрийн найдвартай түншүүд байдаг. Бичил санхүүгийн байгууллагууд нь төрийн бус байгууллага, зээлийн хоршоо, (гишүүдэд үндэслэсэн байгууллага, банк, банк бус санхүүгийн байгууллага гэх мэт) хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

Төрийн бус байгууллагууд (ТББ)

ТББ нь зарим тохиолдолд жижиг зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр хөтөлбөрүүд нь ихэвчлэн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна. ТББ нь ихэвчлэн богино хугацааны жижиг зээлүүдийг олгодог нь бичил худалдааны үйл ажиллагаа явуулахаас илүү зүйлд хүрэхээргүй байдаг.Түүнчлэн ТББ-аас олгогдох зээл нь ихэвчлэн банкнаас өндөр хүүтэй байдаг. Учир нь тэд жижиг зээлүүдийг олгодог ТББ-ын захиргааны зардал өндөр байдаг байна. Ер нь эдгээр байгууллагуудаас зээл авахдаа хэсэг бүлгээрээ авч байх нь ашигтай. 3-5 хүний хамтарч авсан зээл нь бичил үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах наад захын бэлтгэл хангахад хүрэлцээтэй байж болох юм. Гэхдээ туршлагаас харахад ТББ-аас зээл авна гэдэг нь тийм амар биш юм. Учир нь эдгээр байгууллагууд нь тодорхой хүрээний үр шимийг хүртэгчдэд зориулж зээл олгодог бөгөөд эдгээрт нь тухайн нутгийн ядуус болон бусад амьжиргааны түвшин доогуур иргэд хамаардаг байна.

Хадгаламж зээлийн хоршоод

Хадгаламж зээлийн хоршоодын хөрөнгө нь гишүүдийн хадгаламжаас бүрддэг. Эдгээр хоршоодын гишүүд зээл авахын тулд эхлээд тодорхой хугацааны туршид хадгаламж нийлүүлсэн байх хэрэгтэй байна.

г) Албан бус зээлийн эх үүсвэрүүд

Албан бус зээлийн эх үүсвэрүүд нь жижиг үйлдвэрлэгчийн хувьд маш чухал байдаг. Албан бус зээлийн хэлбэрт найз нөхөд, хамаатан садан, мөнгө хүүлэгч, нийлүүлэгчээс зээлээр тоног төхөөрөмж, түүхий эд авах зэрэг хамаарна.

Албан бус зээлийн эх үүсвэрүүдийн гол асуудал нь тэдгээрийн хүү өндөр байдагт оршдог нь бизнесийг дампуурууулах боломжтой юм. Хэрэв энэ төрлийн зээлийг авахаар бол тооцоог маш нарийн хийсэн байх шаардагатай.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зээлийг олгох журам

Зээлийг ашигтай, тогтвортой эдийн засгийн үйл ажиллагаанд олгоно. Зээлийн хүү энэ тохиолдолд төдийлөн гол асуудал биш. Жижиг хэмжээний үйлдвэрлэл гэдэг нь заавал үйлдвэрлэгч нь хямд зээл авна гэсэн үг биш юм. Зээлийн хүү бага байх нь ашиггүй эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой хэмжээнд явуулах боломжийг олгох боловч удаан хугацааны дараа энэ нь нилээд томоохон хэмжээний хүндрэл болдог.

Цаашдын үйл ажиллагааг зээлээс хамааралтай байлгахгүй байхын тулд үйл ажиллагааг эрхлэгчид өөрсдийн боломжийн хэрээр эхний хөрөнгө оруулалтыг өөрсдөө гаргаж байх нь зүйтэй юм.

Эцэст нь хэлэхэд зээл авахтай холбогдуулан дараах зөвлөмжүүдийг өгье.

- Зээлийн нөхцөл байдлыг эртнээс судалж эхлэх
- Хэрэв зайлшгүй шаардлагатай зээл олох боломж, нөхцөлбайдалбүрдээгүйболсургалтыгхойшлуулахад бэлэн бай.
- Арай хямд багаж тоног төхөөрөмжийг авах боломжтой технологийг хэрэглэх,
- Өөрөө тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийх замаар зээлийн хэмжээг бууруулах
- Эхний үед жижиг хэмжээний зээл авч, дараагийн удаад зээлийн хэмжээг нэмэгдүүл
- Хамтаар авсан зээл нь шууд хамтын хариуцлагыг бий болгоно гэсэн үг биш юм.
- Бизнес үйл ажиллагаа нь энгийн арилжааны зээлийн хүүг төлж болохуйц байх ёстой.
- Богино, дунд хугацааны зээл олгохдоо уян хатан бодлого баримталдаг уу?
- Зээлийн барьцааны шаардлага, бүлгээ олгох зээлийн барьцаа, орон нутгийг дэмжих, нийгмээс гадуурхагдсан иргэдэд үйлчлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа эсэх,
- Боломжийн зээлийн хүүтэй
- Жижиг зээлийн сүлжээний туршлагатай
- Хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийг дэмжих сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байгаа.

Хавсралт 5.3. Бичил санхүүгийн байгууллагын хүчин чадлыг тодорхойлох

Наад захын шаардлага

- *Зорилго:* Тухайн байгууллага нь тодорхой зорилготой юу? Зорилго нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилготой нийцэж байна уу? Зорилго нь нийгэм, эдийн засгийн зорилтуудыг нэгтгэж байна уу? Энэ байгууллага нь ХЭЗЧДС-ын зорилтод бүлгүүдтэй хамтарч ажиллах хүсэлтэй байна уу?
- *Стратеги:* Энэ байгуулага нь санхүүгийн ямар бичил хөтөлбөрийн стартегитэй вэ?
- *Тогтвортой байдал:* Энэ байгууллага нь удаан хугацааны зорилготой юу? Тогтвортой байдлын төлөвлөгөөтэй юу? Тодорхой санхүүжилтын боломжоос гадна өөр төлөвлөгөөтэй юу?
- *Менежмент:* Энэ байгууллагын бичил санхүүгийн хөтөлбөрийг удирдах чадавх нь хэр зэрэг вэ? Удирдлага байгууллагын зорилго, зорилт, стратегийг дэмждэг үү?
- *Туршлага:* Энэ байгууллага нь бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулах туршлагатай юу? Хөдөөгийн ядууст зориулсан хадгаламж зээлийн үйлчилгээ үзүүлэх туршлагатай юу?
- *Нэр хүнд:* энэ байгууллага нь бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулах тал дээр бусдаас ямар үнэлгээ хүртсэн бэ? Зээлийн хүү нь хэр зэргийн хэлбэлзэлтэй вэ?
- Хөтөлбөр хэрэгжиж буй орон нутагт салбар сүлжээтэй юу?
- Орон нутагт зээлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх болон бусад сүлжээг явуулах хүний нөцтэй юу?
- Бусад үйлчилгээ нь санал болгож байгаа үйлчилгээ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдийн шаардлагад нийцэх үү?
- Санал болгож байгаа үйлчилгээ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйлчлүүлэгчдийн шаардлагад нийцэх үү?

Тусгайлан тавигдах шаардлага

Түнш бичил санхүүгийн байгууллага нь мөн дараах шаардлагуудыг хангасан байх бөгөөд гэхдээ дараах шаардлагуудыг чадавхийг сайжруулах үйл ажиллагааны үр дүнд бий болгож болно.

- *Үйлчилгээний төрлүүд*: Энэ байгууллага нь хадгаламж зээлээс гадна бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг үү? Эдгээр үйлчилгээ нь ХЭЗЧДС-ын зорилтод бүлгүүдэд хүртээмжтэй байх боломжтой юу?
- *Хүний нөөц*: Байгууллагын хүний нөөц нь хэр зэрэг ур чадвартай вэ? ажиллагчдын ур чадварыг хөгжүүлэхэд байгууллагын зүгээс хир зэрэг анхаарал тавьдаг вэ? Ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмж хир зэрэг вэ?
- *Үйл ажиллагааны үр дүнг үнэлэх*: Байгууллага нь тогтвортой байдал, үр дүнтэй ажиллагаа зэргийн хувьд өнгөрсөн хугацаанд ямар амжилтад хүрсэн бэ? Хэрэв өнгөрсөн хугацааны үйл ажиллагаа нь доогуур гэж үнэлэгдсэн бол үүнийг тухайн байгууллагын зүгээс хэрхэн хүлээж авч байна вэ? Байгууллага нь үйл ажиллагааны үр дүнгээ хэрхэн хянадаг вэ?
- *Дотоод хяналт*: Байгууллага нь залилан, луйвараас өөрийгөө хэрхэн хамгаалдаг вэ?
- *Санхүүжүүлэгч байгууллагын талаар*: Хичнээн донор байгууллага ямар зорилгоор энэ байгууллагын үйл ажиллагааг дэмждэг вэ? Нэгээс дээш донортой байх нь зохимжтой. Гэхдээ хэт олон донор байх нь үйл ажиллагаа нь цалгардах талтай. Донорын талаар тавих шаардлага нь харьцангуй байдаг.

Хавсралт 5.4. Зээлийн баталгааны сан

Зарим тохиолдолд зээлийн баталгааны сантай байх нь зээл авах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Олон бичил, жижиг үйлдвэрлэлүүд ашигтайгаар хэрэгжиж болохуйц сайн бизнесийн төлөвлөгөөтэй байх боловч зээлийн баталгаа байхгүй гэсэн үндэслэлээр шаардлагатай зээл авч чаддаггүй. Зээлийн баталгааны сан нь банкнаас зээл авахад шаардлагатай баталгааг хуримтуулах зорилгоор байгуулагддаг. Зөв загвараар байгуулагдсан баталгааны сан нь эрсдлийг хамтран үүрэх механизмтай. Өөрөөр хэлбэл сан болон банк нь найдваргүй зээлийн хариуцлагыг хуваж төлдөг байна.

Зээлийн баталгаа нь үнэгүй байдаггүй. Үйлдвэрлэл эрхлэгч нь зээлийн баталгаа хэрэглэсний хувьд тордорхой хэмжээний төлбөр төлдөг. Зээлийн баталгааны сантай болгоомжтой харьцах дараах үндэслэлүүд бий:

- **Ёс зүйн хувьд:** Зээл нь баталгаатайгаар гаргагдсан учир үйлдвэрлэгч нь эргэн төлөх асуудалд харьцангуй хайхрамжгүй чиг хандлагтай байдаг.
- **Үйл ажиллагааны өндөр өртөг:** ихэвчлэн банк, баталгааны сан хамтарч үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, зээлийн зарцуулалтад хяналт тавина.
- **Тогтвортой байдал:** Зээлийн баталгааны санг зөвхөн баталгаанаас авсан хураамжаар санхүүжүүлж үйл ажиллагааг нь явуулна гэдэг нь хэцүү.

ХЭЗЧДС нь зээлийн баталгааны сан байгуулахаар бол энэ нь орон нутгийн нөхцөл байдалд таарсан, урьдын туршлага дээр үндэслэх зэрэг нөхцлүүдийг хангасан байх ёстой.

Хавсралт 5.5. Сургалтын дараах хяналт-шинжилгээ, бичил үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах загвар (эхлэх, үйлдвэрлэл, зах зээл, санхүү)

Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах загвар

1. Үйл ажиллагаа эхлэх шат

Үйлчлүүлэгч .....
Бизнес .....
Замд явах хугацаа .....
Танилцах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа .....

Зөвлөх .....
Дүүрэг .....
Огноо .....
Ажиллагчдын тоо .....

Эрхлэх үйл ажиллагаа	Үнэлгээ	Тийм үгүй хариулах боломжгүй
1.Байр олсон, төлбөр төлөгдсөн, холбогдох гэрээнүүд хийгдсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
2.Шаардлагатай зөвшөөрлүүийг авсан байна уу?	.....	☐ ☐ ☐
3.Аюулгүй байдлыг хангасан уу?		
4.Зах зээлийн төлөвлөгөөг боловсруулсан байна уу?	.....	☐ ☐ ☐
5.Бүх шаардагдах тоног төхөөрөмж байна уу?	.....	☐ ☐ ☐
6.Шаардлагатай материал хангалттай байна уу?	.....	☐ ☐ ☐
7.Тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн хадгалах зайтай байна уу?	.....	☐ ☐ ☐
8.Тогтсон үйл ажиллагааны цагийн хуваарьтай байна уу?	.....	☐ ☐ ☐
9.Бүтээгдэхүүнийг үзэмжтэйгээр үзүүлэн болгож байрлуулсан байна уу?	.....	☐ ☐ ☐
10.Хяналт шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх хуваарийг мэдэж байна уу?	.....	☐ ☐ ☐
11.Бизнесийн үйл ажиллагааны хаяг байна уу?	.....	☐ ☐ ☐
12.Ажиллах орчин нь шаардлага хангасан байна уу?	.....	☐ ☐ ☐

Үйлчлүүлэгчийн гарын үсэг ..... **Зөвлөхийн гарын үсэг** .....

Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах загвар

2. Үйлдвэрлэл

Үйлчлүүлэгч ..... **Зөвлөх** .....

Бизнес ..... **Дүүрэг** .....

Замд явах хугацаа ..... **Огноо** .....

Танилцах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа ..... **Ажиллагчдын тоо** .....

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	Үнэлгээ	Тийм үгүй хариулах боломжгүй
Түүхий эд		
1.Материал олдоцтой байна уу?	.....	☐ ☐ ☐
2.Хүрэлцэхүйц хэмжээтэй юу?	.....	☐ ☐ ☐
3.Үний хувьд боломжтой юу?	.....	☐ ☐ ☐
4.Чанарын шаардлага хангаж байна уу?	.....	☐ ☐ ☐
5.Материалыг зөв бүртгэсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
6.Материалыг зөв хураасан байна уу?	.....	☐ ☐ ☐
Багаж, тоног төхөөрөмж	.....	☐ ☐ ☐
7.Шаардлага хангаж байна уу?	.....	☐ ☐ ☐
8.Засвар үйлчилгээг хийсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
Үйлдвэрлэлийн дамжлага		
9.Тоног төхөөрөмж дээр ажиллаж байгаа хүмүүс хангалттай ур чадвартай байна уу?	.....	☐ ☐ ☐
10.Үйлдвэрлэлийн шат дамжлагыг сайн зохион байгуулсан байна уу?	.....	☐ ☐ ☐
11.Ажлын хуваарь байрандаа байна уу?	.....	☐ ☐ ☐
12.Бүтээгдэхүүний чанар шаардлага хангаж байна уу?	.....	☐ ☐ ☐
13.Бүтээгдэхүүний үйлдвэрлэгдсэн тоо хэмжээ хэрэгцээ хангаж байна уу?	.....	☐ ☐ ☐
14.Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй нөхцлийг хангасан байна уу?	.....	☐ ☐ ☐
15.Хөлсний ажилчид байна уу? Тэдгээр нь бичгээр гэрээ хийсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
16.Ажилчдад олгож байгаа цалин хууль тогтоомжид хүрсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
17.Ажилчдад цалин хөлсийг тэгш байдлаар олгох зарчим байна уу?	.....	☐ ☐ ☐

Үйлчлүүлэгчийн гарын үсэг ..... **Зөвлөхийн гарын үсэг** .....

Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах загвар

3. Зах зээл

Үйлчлүүлэгч ..... **Зөвлөх** .....

Бизнес ..... **Дүүрэг** .....

Замд явах хугацаа ..... **Огноо** .....

Танилцах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа ..... **Ажиллагчдын тоо** .....

Зах зээлийн үйл ажиллагаа	**Үнэлгээ**	**Тийм үгүй хариулах боломжгүй**
1.Хэрэглэгчийн хэрэгцээний талаарх мэдлэг?	.....	☐ ☐ ☐
2.Хэрэглэгч сэтгэл хангалуун байна уу?	.....	☐ ☐ ☐
3.Шинэ хэрэглэгчид байна уу?	.....	☐ ☐ ☐
Бүтээгдэхүүн		
4.Чанарын шаардлага хангасан байна уу?	.....	☐ ☐ ☐
5.Тооны шаардлага хангасан байна уу?	.....	☐ ☐ ☐
6.Бүтээгдэхүүн үр дүнтэй байна уу?	.....	☐ ☐ ☐
7.Худалдан авалт ихэссэн байна уу?	.....	☐ ☐ ☐
Багассан байна уу?	.....	☐ ☐ ☐
Бизнес		
8.Байршлын хувьд зохистой юу?	.....	☐ ☐ ☐
9.Хүмүүс байршлыг нь мэдэж байна уу?	.....	☐ ☐ ☐
Үнэ:		
10.Үнэ боломжийн байна уу?	.....	☐ ☐ ☐
11.Үнэ өрсөлдөхүйц байна уу?	.....	☐ ☐ ☐
12.Ашиг нь хангалттай юу?	.....	☐ ☐ ☐
Сурталчилгаа:		
13.Үйлчлүүлэгч нь барааны тухайн мэдэж байна уу?	.....	☐ ☐ ☐
14.Сурталчилгааны самбарууд байна уу?	.....	☐ ☐ ☐
15.Бүтээгдэхүүнийг зөв танилцуулсан байна уу?	.....	☐ ☐ ☐
16. Ажиллагчид нь хугацаандаа цалингаа авч байна уу?	.....	☐ ☐ ☐
17.Өртэй хүмүүс цагтаа төлж байна уу?	.....	☐ ☐ ☐
18. Хугацаа хэтэрсэн авлага байна уу?	.....	☐ ☐ ☐
19.Бусад	.....	☐ ☐ ☐

Үйлчлүүлэгчийн гарын үсэг ..... **Зөвлөхийн гарын үсэг** .....

Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах загвар

4. Санхүү

Үйлчлүүлэгч .....
Зөвлөх .....

Бизнес .....
Дүүрэг .....

Замд явах хугацаа .....
Огноо .....

Танилцах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа .....
Ажиллагчдын тоо .....

Санхүүгийн үйл ажиллагаа	Үнэлгээ	Тийм үгүй хариулах боломжгүй
1.Тэмдэглэл хөтөлж байна уу?	.....	☐ ☐ ☐
2.Зээлээ төлж байна уу?	.....	☐ ☐ ☐
3.Бэлэн мөнгөний бүртгэл байна уу?	.....	☐ ☐ ☐
4.Бэлэн мөнгөний бүртгэлийг зөв хөтөлж байна уу?	.....	☐ ☐ ☐
5.Бүх бизнесийн гүйлгээг бүртгэсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
6.Бусад	.....	☐ ☐ ☐
Төсөв:		
7.Төсөв байна уу?	.....	☐ ☐ ☐
8.Төсөвийн дагуу үйл ажиллагаа явуулж байна уу?	.....	☐ ☐ ☐
9.Бүтээгдэхүүний өртгийг тооцсон байна уу?	.....	☐ ☐ ☐
10.Бүтээгдэхүүний үнийг тавьсан байна уу?	.....	☐ ☐ ☐
11.Хангалттай эргэлтийн хөрөнгө байна уу?	.....	☐ ☐ ☐
12.Бусад	.....	☐ ☐ ☐
Зээл/авлага		
13.Зээл олгогчдод төлбөр хийгдсэн байна уу?	.....	☐ ☐ ☐
14.Зээлийг хугацаанд нь төлсөн байна уу?	.....	☐ ☐ ☐
15.Байрны түрээсийг төлсөн байна уу?	.....	☐ ☐ ☐
16.Бүтээгдэхүүнүүдийг олоход амархан байна уу?	.....	☐ ☐ ☐
17.Дээж бүтээгдэхүүнүүдийг үзүүлэнд тавьсан байна уу?	.....	☐ ☐ ☐
18.Бусад	.....	☐ ☐ ☐

Үйлчлүүлэгчийн гарын үсэг .....
Зөвлөхийн гарын үсэг .....

Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах загварыг бөглөсөн загвар

4.Санхүү

Үйлчлүүлэгч ..... **Бизнесийн нэр** .....

Бизнесийн байрлал..... **Огноо** .....

Санамж: 1-4-р долоо хоногт зөвлөхүүдээр бөглөгдсөн байна

Туслах аж ахуй	Тайлбар
Эхлэх	
1.Тахиа болон засварын байрыг цэвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж байна.	.....
2.Шаардлагатай тэжээл, ус байна.	.....
3.Тэжээл, эмчилгээний болон бусад зүйлс хангалттай нөөцлөгдсөн байна.	.....
4.Тогтсон ажлын цагийн хуваарьтай байна	.....
5. Өндөг, тахиа зарах тухай бизнесийн зар гаргасан байна.	.....
6.Зээлийн эхний төлбөрийг хийсэн байна.	.....
Бүтээгдэхүүн	
1.Өндөгний үйлдвэрлэл хангалттай	.....
2.Тахианы арчилгаа хангалттай	.....
3.Ажлын нөхцөл байдал, аюулгүй байдлын шаардлага хангасан байна уу?	.....
4.Хөлсний ажилчид байна уу? Тэдгээр нь бичгээр гэрээ хийсэн байна уу?	.....
5.Ажилчдад олгож байгаа хууль тогтоомжид хүрсэн байна уу?	.....
6.Аж ахуйд зориулж худалдаж авсан болон хэрэглэгдэж буй материаллаг эд хөрөнгө	.....
7.Багаж тоног төхөөрмжийн завсар үйлчилгээ хийгдсэн	.....
8.Өндөр чанартай өндөг	.....
Зах зээл	
1.Бүтээгдэхүүний зах зэл тодорхойлогдсон	.....
2.Үнэ өрсөлдөхүйц	.....
3.Ашиг хангалттай	
4.Үйлчлүүлэгчид сэтгэл хангалуун байгаа харагдаж байна	.....
Санхүү	
1. Зээлийг төлөвлөгөөний дагуу төлж байна уу?	.....
2. Бэлэн мөнгөний бүртгэлийг сайн хөтөлсөн байна	.....
3. Төсөвт бэлтгэгдсэн байна	.....
4. Бүх бүтээгдэхүүн үнэлэгдсэн байна	.....
5. Эргэлтийн хөрөнгө хангалттай банйа	.....
6. Зээл олгогчид төлбөрөө авсан байна.	.....
7. Авлагатай хүмүүсээс цаг тухайд нь авлага авч байна	.....

Бусад тайлбар.....

.....

Үйлчлүүлэгчийн гарын үсэг ..... **Зөвлөхийн гарын үсэг** .....

Хавсралт 5.6. Бүлгийн үйл ажиллагааны загвар

Багаар ажиллах үйл ажиллагааг зохистой хэрэглэхийн тулд дараах зүйлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- ☐ багийн гишүүд нь оршин суух газрын хувьд ойролцоо байна;
- ☐ нэгдсэн нэг зорилго зорилттой байх;
- ☐ хамтарч ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх;
- ☐ бие биедээ итгэлтэй байх;
- ☐ бүлгийн хэмжээнд оролцох сонирхол бүхий оролцогсод, харилцан хамаарал, хөрөнгө оруулалтын хэмжээ, бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрны багтаамж зэрэг олон нөхцлөөс хамаарна;
- ☐ жижиг бизнесийн үйл ажиллагаанд 5 гишүүнтэй бүлэг байхад хангалттай гэж тооцогддог;
- ☐ 15-аас дээш хүнтэй бүлгийн хувьд, бүлгийн удирдагчид ачаалал ихээр ирдэг;

Хэрэв орон нутгийн захиргаанаас шаарддаг бол бүлэг зохих журмын дагуу албан ёсоор бүртгүүлсэн байх ёстой. Бүлэг нь өдөр тутмын үйл ажиллагаа, зах зээл, менежемент, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг гишүүдэд жигд хуваарилна. Гишүүн бүр өөрийн гэсэн үүрэгтэй байх боловч нийтийн үүрэг хариуцлагыг давхар хүлээсэн байна.

Хэрэв зөрчилдөөн гарвал ХЭЗЧДС-ын баг яаралтай оролцож тухайн асуудлыг шийдвэрдлэхэд туслалцаа үзүүлнэ. Туршлагаас үзэхэд ихэнх оролцогчид нь сайн дурын үндсэн хамтран ажиллагчдаа сонгосон байдаг байна.

Хавсралт 5.7. Хадгаламж зээлийн үүйл ажиллагааг хамтран эрхлэх бүлгийн удирдамж

Пакистанд ОУХБ –ын ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хэрэглэсэн загвар

Хөдөө орн нутгийг хөгжүүлэхэд тухайн орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоо чухал байдаг. НРСП- нь төрийн бус, ашгийн бус, хөдөөгийн хөгжлийг дэмждэг байгууллага юм. Энэ байгууллага нь ядуурлыг бууруулах, ядуусын амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

НРСП- нь ядуу иргэдийг чадавхижуулах, орон нутгийн хэмжээнд эвлэлдэн нэгдэж өөрсдөө өөрсдийнхөө асуудлыг боломжит нөөцөө ашиглан шийдвэрлэхийг уриалдаг болно.

Үүний тулд НРСП- нь ОУХБ-тай хамтарч дараах зорилт бүхий төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

1. Эдийн засаг нийгмийн нөхцөл байдлаа өөрчлөхийн тулд ур чадвараа нэмэгдүүлэх сургалтад хамрагдах хөдөлмөр эрхлэлтийн боломжийг эрхэлхийлэх замаар хамгийн ихэд ялгарлан гадуурхагдсан бүлгүүдийн (эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд) чадамжийг нэмэгдүүлэх

2. Бичил санхүүгийн зэрэг шаардлагатай үйлчилгээнүүдийн хүртээмжийг сайжруулах

3. Тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай холбоосуудыг бий болгож зөвлөмжөөр хангах

Түншлэлийн нөхцөл

Огноо _____

Бид хадгаламж зээлийн бүлгийн/хоршооны (С энд СЖ) гишүүд бөгөөд үүнтэй дагалдаж ирэх хариуцлагаа хүлээх болно. Дор дурьдах түншлэлийн нөхцлүүдийг анхааралтай уншиж сонссон бөгөөд бүх гишүүд санал нэгтэй байна. Түншлэлийн нөхцлүүдийг доор үзүүлэв.

1. Хадгаламж зээлийн хоршоо нь сард нэг удаа тогтсон өдөр тогтсон цагт цуглаан хийх болно. Цуглаанд оролцох нь гишүүдийн хариуцлага болно.

2. Гишүүд хамтран хадгаламж цуглуулж хөрөнгийг бий болгоно.

3. Гишүүд нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хийж, түүнийгээ хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

4. Байгууллагын зардлаар техникийн сургалтад хамрагдсан гишүүд нь өөрсдийн ур чадвараа ашиглаж зөвлөгөөний болон бичил санхүүгийн үйлчилгээ эрхлэнэ.

5. Бүх гишүүд бие биендээ эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход туслана.

6. Хоршоо нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн зах зээлд гаргах төлөвлөгөөг хийх бөгөөд үүний тулд холбогдох сүлжээ, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг авна.

7. Тохиролцсоны үндсэн дээр ерөнхийлөгч, менежерээ сонгоно.

8. Аливаа гишүүний авсан зээл нь тогтсон хугацаанд үйлчилгээний хөлсний хамт төлөгдсөн байна. Тэгээгүй тохиолдолд түүний батлагаа гаргагч эсвэл хоршоо төлбөрийг хийнэ.

9. Байгууллага нь зээлийг хувь хүн болон бүлэг этгээдүүдэд олгох эрхтэй.

10. Хоршоо нь төрийн болон ТББ-ын хөгжлийн хөтөлбөр, үйлчилгээнд хамаарна.

11. Хоршоо нь тодорхой шалтгааны улмаас төсөлд хамрагдаж чадаагүй иргэдэд туслалцаа үзүүлнэ.

12. Эдийн засгийн үйл ажиллагааны зориулалтаар бусад байгууллагаас авсан эсвэл бусад байгууллагаар дамжуулан авсан тоног төхөрөмжийг буцаан өгнө. Буцааж өгөх боломжгүй бол төлбөрийг төлнө.

13. Аливаа хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх болсон тохиолдолд хоршоо, гишүүд бусад байгууллагад эсвэл шүүхэд хэрэг маргаангүй байгаа эсэхийг нягталж шалгана.

14. НРСП, бусад байгууллагуудтай хамтран хөгжлийн хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх явцад гарсан алдагдлыг НРСП хүлээхгүй болно.

15. Шийдвэрийг олонхийг зарчмаар гаргах бөгөөд нэгэнт гарсан шийдвэрийг бүгд дагана.

16. Хэн нэгэн гишүүний санаачилгаар буруу шийдвэр гаргасан бол хоршоо шийдвэрийн үр дагаварыг хүлээнэ.

17. НРСП хамтын ажиллагааны гэрээнд нээлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд тэгсэн тохиолдолд гишүүд нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрнө.

18. Хурлын үед 2 хүнийг олонхийн саналаар хурлын тэргүүлэгчээр сонгох нь бизнесийн үйл ажиллагаанд хоршоог төлөөлөх бөгөөд хоршоо нь эдгээр хүмүүсийн найвартай байдлыг хангасан байна.

Нэр дэвшигч №1 _____

Гарын үсэг _____

Нэр дэвшигч № 2 _____

Гарын үсэг _____

VI

Оршил. I. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө. II. Үнэлгээ. III. Бичиг баримт хөтлөлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, бичиг баримтжуулалт

Оршил

Хяналт-шинжилгээ, бичиг баримтын хөтлөлт, үнэлгээний үйл ажиллагаа нь аливаа хөтөлбөрийн хэрэгжилтийн салшгүй хэсэг ба ихэвчлэн тэдээрийг хөтөлбөрийн боловсруулалт, төлөвлөлтийн үед нарийвчлан тооцсон байдаг. ХЭЗЧДС-ын үйл ажиллагааны явц, ололт, дутагдал, цаашдын үйл ажиллагааны чиглэл, тогтвортой байдал, хувираа хөдөлмөр эрхлэх, цалинтай хөдөлмөрэрхлэх үйл ажиллагааны амжилт зэрэг нь дээрх хяналт-шинжилгээ, баримт бичгийн хөтлөлт, үнэлгээний үйл явцаас ихээхэн хамаардаг билээ. ХЭЗЧДС-ын явцад үе шат бүрийг хяналттай байлгаж, хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлж байх хэрэгтэй болдог. Бичиг баримтын хөтлөлт нь үйл ажиллагааны дутагдалтай тал, өнгөрснөөс сурах боломжийг бүрдүүлэх бөгөөд үүн дээр үндэслэн цаашдын үйл ажиллагааг амжилттай болгох арга хэмжээг авдаг.

I. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

1.1.Хяналт-шинжилгээ

Хяналт –шинжилгээ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн менежментийн чухал арга хэрэгсэл бөгөөд энэ нь хөтөлбөрийн үйл ажиллагааны зааварчлах, зохицуулахад шаардлагатай бүхий л мэдээллийг өгдөг. Зөвхөн үйл ажиллагаатай болон тулгарч буй бэрхшээл, тэдгээрт дүн шинжилгээ хийх зэрэг мэдээлэл байгаа тохиолдолд үйл ажиллагааг сайжруулах төлөвлөлт хийгдэх боломжтой байдаг.

Хяналт –шинжилгээ гэж юу вэ?

Хяналт –шинжилгээ гэдэг нь тогтмол, тодорхой давтамжтайгаар хөтөлбөрийн шийдвэр гаргалт, менежмент, хяналт зэрэгтэй холбогдох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээг хийхийн зэрэгцээ, үйл ажиллагаа нь төлөвлөсний дагуу явагдаж байгаад хяналт тавихыг хэлнэ.

ХЭЗЧДС-ын баг нь дараах үйл ажиллагаанд тогтмол хяналт-шинжилгээ хийнэ.

Төлөвлөлтийн үешатад:

- ☐ шалгуурт нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийг сонгох;
- ☐ судалгааны бэлтгэл ажил, зохион байгуулах, хийх;
- ☐ зохион байгуулах шаардлагатай ур чадварын сургалтын хөтөлбөр
- ☐ сургалтад хамрагдагчдыг сонгох;
- ☐ сургагчдыг сонгох;
- ☐ сургалтын дамжааны бэлтгэл ажил.

Хэрэгжилтийн явцад:

- ☐ сургалтын багаж тоног төхөөрөмж болон материалын хүрэлцээтэй байдал;
- ☐ сургалтыг зохион байгуулах газрыг бэлтгэх;
- ☐ сургагч нарыг бэлтгэх;
- ☐ сургалтын дамжааг хичээллүүлэх;

Сургалтын дараа:

- ☐ ажилд орохыг дэмжих үйлчилгээ, зээл, зах зээлийн дэмжлэг зэрэг сургалтын дараах дэмжлэгийн үйлчилгээ болон туслалцаа;
- ☐ сарын дундаж орлогын өсөлт болон чадваржиж байгаагийн үр нөлөө;

Хяналт-шинжилгээний үндсэн зорилго нь тухайн хөтөлбөрийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй төлөвлөлт, хэрэгжилтийн явцад өөрчлөлт хийх бөгөөд уг өөрчлөлтүүдийг урьдчилан сэргийлэх, дутагдлыг арилгах зорилгоор хийнэ. Тодорхой асуудлаар хүндрэл гарсан тохиолдолд мэдээллийг тухайн асуудлыг хариуцах, зохицуулах, шаардлагатай өөрчлөлтийг хийх эрх бүхий ХЭЗЧДС-ын нэгжид шууд мэдээлнэ.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний төлөвлөгөө (ХШТ) нь ХЭЗЧДС-ын арга зүйн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийх загвар юм. ХШТ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжих хэрэгжилтийн явцад зорилтод хүрэхэд заавал хийх үйл ажиллагаануудад хяналт тавих боломжтойгоор хийгдсэн.

Хяналт-шинжилгээ, бичиг баримтын хөтлөлтөд дараах үйл ажиллагаа хамаарна:

- ☐ сургалтын явц;
- ☐ үйл ажиллагааны дараах судалгаа, үүнд төгсөгчдийн орлогын өсөлт мөн хамаарна.
- ☐ орон нутгийн бүлгүүдийн үйл ажиллагаа;
- ☐ суралцагчдын сургалтын хөтөлбөрт оролцож байгаа байдал;
- ☐ суралцагчдын хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагааны сайжирч байгаа байдал

ХЭЗЧДС-ын ХШТ нь тусгайлан зориулсан загвар, арга хэрэгслийг хяналт-шинжилгээ хийхдээ хэрэглэдэг.

→ **Хэргэжилтийн мэдээллийн хүснэгт (үлгэрчилсэн загвар)-ийг Хавсралт 6.1-ээс харна уу.**

→ **ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө (үлгэрчилсэн загвар)-г Хавсралт 6.2-оос харна уу**

1.2. Үндэсний түвшинд хяналт-шинжилгээг хийх

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хяналт-шинжилгээг ХЭЗЧДС-ын баг хийнэ. Тайлангийн шаардлагаас хамааран ХЭЗЧДС-ын үндэсний хөтөлбөрийн зохицуулагч, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны тайлан нь улирлын эсвэл хагас жилийн байдлаар нэгтгэгдсэн байж болно. Дээрх мэдээлэл нь толгойлон хэрэгжүүлж буй байгууллага, үндэсний зөвлөл, түнш байгууллагуудын үйл ажиллагааны талаарх дүр зургийг харуулах зорилго агуулна. Тухайн улс орны нөхцөл байдлаас хамааран үндэсний зөвлөлдөх хороо байх хэрэгтэй эсэхийг шийдвэрлэнэ.

1.3. Орон нутгийн түвшний хяналт-шинжилгээ

Орон нутгийн түвшний хяналт-шинжилгээг ХЭЗЧДС-ын орон нутгийн ажилтан, дамжааны багш, сургагч нар, орон нутгийн зөвлөлийн гишүүд хийнэ. Зарим улс орны хувьд хяналт-шинжилгээг үндэсний хэмжээнд хийснээс орон нутгийн хэмжээнд хийсэн нь илүү чухал байдаг. Орон нутагт хийгдэж буй хяналт-шинжилгээнд дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:

- ☐ ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтан, сургагч нь үйл ажиллагааны явцтай газар дээр нь очиж тогтмол танилцаж байх
- ☐ Зээл нь зориулалтаараа ашиглагдаж буй эсэхэд хяналт тавих, зээлийг хугацаанд төлж байгаа эсэхийг шалгах
- ☐ Шаардлагатай үед төрийн болон ТББ-ууд, салбарын байгууллагууд хэрэгцээтэй техникийн туслалцаа, оролцоог үзүүлж буйд хяналт тавих
- ☐ Үйлдвэрлэгчид тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг олох

1.4. Сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх

Сургалтын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх тусгайлсан загварууд байдаг бөгөөд эдгээрийг сургалтыг тайлагнахад ч мөн ашигладаг байна.

- ☐ суралцагчдын бүртгэлийн загвар;
- ☐ ирцийн бүртгэлийн загвар;
- ☐ үйл ажиллагааны явцын хяналт;
- ☐ үйлчлүүлэгчийн мэргэшсэн байдлын бүртгэл;
- ☐ сургагч нь дамжааны үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт;
- ☐ суралцагчийн дамжааны үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт;

1.5.Сургалтын дамжаанд хяналт-шинжилгээ хийх

Сургалтын дамжааны явц, суралцагчдын суралцах байдал зэргийг боловсронгуй дүгнэхийн тулд холбогдох загвар, мэдээлэл бүхий компьютерийн программыг ашиглаж болно. Энэхүү загвар нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтад хамрагдагчдын талаар дараах мэдээллийг агуулж болно:

- ☐ суралцагчдын хувийн мэдлээлэл (үйлчлүүлэгчийн анкет);
- ☐ суралцагчдын суралцаж буй дамжаа;
- ☐ төгсөгчидтэй уулзсан байдал болон тэдний үйл ажиллагааны талаарх тэмдэглэл;
- ☐ суралцагчдын нэрсийн жагсаалт (төгссөн болон төгсөөгүй);
- ☐ сургалт зохион байгуулсан газар сургагч болон сургалтын материалын талаарх мэдээлэл;
- ☐ захиргаа, сургалтын багаж, тоног төхөөрөмж;

Эдгээр нь хөтөлбөрийн сургалтын төлөвлөлт, сургалтын үйл ажиллагааны анхан шатны хяналт-шинжилгээг хийхэд шаардлагатай наад захын мэдээллээр хангана. Дээрх мэдээллүүдийг цаг тухайд шинэчилж байх нь ХЭЗЧДС-ын төслийн багийн хариуцлага юм.

1.6 ХЭЗЧДС-ын сургалтын явцад хяналт —шинжилгээ хийх

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрт хяналт–шинжилгээ хийх 3 үе шат байдаг бөгөөд эдгээр нь тус бүр нь өөрийн гэсэн стандарт загвартай.

Үе шат 1. Сургалтын өмнө

Сургалтын өргөдлийн загвар. Дээрх загвар нь сургалтад хамрагдах хүсэлт гаргачдын нийгэм, эдийн засгийн, хувийн мэдээлэлд хамаарах анкет юм. Мэдээлэл нь тухайн хүсэлт гаргагч нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилтод нийцсэн ядуусын хүрээнд хамаарах, туслалцаа үзүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлоход туслана. Мөн дээрх мэдээлэл нь тухайн гэр бүлийнсургалтад хамрагдахаас өмнөх орлогын хэмжээний талаарх мэдээллийг агуулах бөгөөд үүнийг сургалтын дараах харьцуулсан дүгнэлт хийхэд ашиглана.

Элсэлтийн бүртгэлийн загвар: Тодорхой төрлийн сургалтад хамрагдахаар сонгогдсон суралцагчдын бүртгэлийг энэ загварын дагуу бүртгэнэ. Тус бүртгэлийн загварт тусгагдах хувь хүнтэй холбогдох мэдээллийг сургалтын өргөдлийн загвараас авч оруулсан байна.

Үе шат 2. Сургалтын явцад

Сургалтын үйл ажиллагааны тайлангийн загвар. Сургалтын үйл ажиллагааны явцыг сургалтын үйл ажиллагааны тайлангийн загварын дагуу бүртгэж хяналт тавина. Дээрх бүртгэл нь сургалтын бүхий л үе шат, даалгавар, бусад мэдээллийг агуулна. Ур чадварын сургалтын даалгаварыг сургалтыг удирдан явуулж буй сургагч багш боловсруулж бэлтгэсэн байна. Сургалтын явцын тайлан нь мөн гүйцэтгэсэн даалгавар эсвэл хэрэгжих шатандаа явж байгаа даалгаврын талаар тэмдэглэлийг агуулна.

Үе шат 3. Сургалт дууссаны дараа

Төгсөлтийн тайлангийн загвар. Уламжлал ёсоор сургалтын хөтөлбөрүүд нь хаалтын эсвэл төгсөлтийн арга хэмжээгээр өндөрлөнө. Зарим зорилтод бүлгүүдийн хувьд тухайн сургалтын үргэлжлэх хугацаа 1 долоо хоногийн эсвэл 1 сарын хугацаатай байхаас үл хамааран төгсөлтийн өдөр нь чухал ач холбогдолтой. Сургалтад хамрагдагчдын хувьд сайн сайхан амьдралын төлөө хүч чармайлт гарган ажилласан, өөрсдийн хүсэл мөрөөдлийг биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэгтэй болох чухал юм.

Сургагчийн тайлангийн загвар. Хэрэв төгсөлтийн тайлангийн загвар нь тухайн суралцагчид нь сургалтад хамрагдаж төгссөн, шаардлагатай ур чадварыг эзэмшсэнийг батлах гэрчилгээг авсан гэдгийг илэрхийлж байгаа бол тухайн сургагч багш сургалтын хөтөлбөртэй холбогдох өөрийн хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн гэж үзнэ. Гэрээт сургагч багш нарын хувьд энэ нь гэрээгээр хүлээсэн техникийн болон захиргааны харицлага нь дуусгавар болсныг илэрхийлэх бөгөөд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг авах нөхцөлийг бүрдүүлнэ.

➔ **ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээг хийх талаар Хавсралт 6.3-аас харна уу?**

1.7 Төгсөгчдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх

Сургалтын дараах хяналтын судалгаа. ХЭЗЧДС-ын хөтөлбөр, аргачлалын дагуу сургалт дууссаны дараа төгсөгчдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээг хэдэн сарын туршид хийнэ. Энэхүү хяналт –шинжилгээний үр дүнг түнш байгууллагууд, засгийн газрын байгууллага болон бусад байгууллагуудад хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээлэл өгөхөд ашиглана.

➔ **Сургалтын дараах хяналтын судалгааг хэрхэн хийх талаар Хавсралт 6.4-өөс үзнэ үү·**

➔ **Сургалтын дараах хяналт(үлгэрчилсэн загвар)—ыг хавсралт 6.5-аас үзнэ үү.**

II. Үнэлгээ

Үнэлгээ гэж юу вэ?

Үнэлгээ гэдэг нь тухайн хөтөлбөрийн явцын байдалд дүн шинжилгээг хийж, уг хөтөлбөр нь зорилтодоо хүрсэн эсэхийг тодруултодруулах, сайжруулах үйл ажиллагааны талаар санал дүгнэлт өгөхийг хэлнэ.

Сургалт дууссаны дараа дараах асуултуудад хариулна:

- Сургалтын чанар нь тооцоолж байсан түвшинд хүрсэн үү?
- Дамжаанууд нь төлөвлөсний дагуу явагдсан уу?
- Төгсөгчдийн болон сургалтын явцад сургалтийг орхисон хүмүүсийн тоо хэд байсан бэ?
- Төгсөгчид нь сургалтад хамрагдаж олж авсан ур чадварынхаа дагуу бизнес эсвэл хөдөлмөр эрхлэхэд бэлэн болсон уу?
- Орлого хэрхэн сайжирсан бэ? Орлого нь тогтвортой байж, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд нэмэр болж чадаж байна уу?
- Ийм төрлийн хөдөөгийн сургалтын зардалаар хөтөлбөрийг өөр орон нутагт хэрэгжүүлэх боломжтой юу?
- Сургалтын дамжаануудыг шинэчлэх шаардлагатай юу?

Энэ үнэлгээг үндэсний ХЭЗЧДС-ын баг хийнэ.

III. Бичиг баримтын хөтлөлт

Бичиг баримтын хөтлөлт гэж юу вэ?

Бичиг баримтын хөтлөлт гэдэг үйл ажиллагааны явц, хэрэгцээг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн явцад хуримтлагдсан тайлан, холбогдох загварыг нэгтгэн цуглуулсныг хэлнэ. Энэ нь мөн тодорхой судалгаа хийгдсэний үндсэн дээр төслийн хэрэгжүүлэх явцад гарсан шинэ туршлага болон арга хэрэгслийг олж авахад туслана. Төрөл бүрийн орон нутаг, тэдгээрийн онцлогт нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснийг баримтжуулах нь нийт хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц туршлагыг хуримтуулахад нэмэр болно. Төсөл, хөтөлбөр нь дээр дурьдсан загваруудад хамааралгүй өөрсдийн үйл ажиллагааны явцад олж авсан туршлагыг мөн баримтжуулж болно.

3.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат бүрд хамаарах тайлангууд

Хөтөлбөрийн явцад гаргаж байх нилээн хэдэн ХЭЗЧДС-ын тайлангийн төрөл байдаг. Гэхдээ тайлангийн төрөл, ангилал нь тухайн хөтөлбөр, донор байгуулагуудын шаардлагаас хамааран өөр өөр байж болно. Тухайлбал:

- ☐ хөтөлбөрийг хэрэгжүүлэх газрыг сонгох
- ☐ эдийн засгийн боломж, судалгааны тайлан
- ☐ нөхцөл байдлын судалгаа
- ☐ сургагч нарыг бэлтгэх дамжаа
- ☐ сургалтын дамжааны тайлан
- ☐ сургалтын дараах үйл ажиллагааны тайлан

(i) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх газрыг сонгох

Энэ тайлан нь тухайн орон нутгийг сонгох үйл ажиллагаанд тавигдсан шаардлага, газар дээр нь очиж танилцсан байдал, нөхцөл байдлыг хэрхэн үнэлсэн талаарх мэдээллийг агуулах бөгөөд дээр мэдээлэл нь дараах зүйлийг агуулсан байна. Үүнд:

- ☐ хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр сонгогдсон орон нутгийн голлох шинж тэмдэг (байршил, хүн ам, гол эдийн засгийн үйл ажиллагаа, чухал үйлчилгээнүүд)
- ☐ орон нутгийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход хэрэглэгдэж болох түүхийн эдийн талаарх мэдээлэл
- ☐ боломжтой, хэрэгцээтэй техник ур чадвар, холбогдох зорилтод бүлгүүдийн ур чадварын сургалтуудад хамрагдах сонирхол, хүсэл эрмэзлэл
- ☐ орон нутгийн зүгээс хүлээгдэж буй дэмжлэг
- ☐ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ууд, тэдэнтэй хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар.

(ii) Эдийн засгийн боломж болон хэрэгцээний судалгааны тайлан

Холбогдох судалгааг хийж орон нутгийн зөвлөлтэй дүнг хэлэлцсний дараа судалгааны тайланг нэгтгэж гаргана. Энэхүү судалгааны тайлан нь нөхцөл байдлын судалгаа хийх хэрэгцээтэй эдийн засгийн үйл ажиллагааны талаар санал агуулсан байна.

Судалгааны тайлан судалгааг хийж дуусмагц аль болохоор богино хугацаанд бэлтгэгдсэн байх хэрэгтэй. Түүнчлэн судалгааны тайланг үндэсний ХЭЗЧДС-ын багт явуулж сургалтад хамаарч болох эдийн засгийн үйл ажиллагааны талаарх саналыг авах нь зүйтэй. Тайлан нь дараах хэсгээс бүрдсэн байвал зохино:

- ☐ **Арга зүй**
  - судалгааны ажлыг явуулсан судлаачдын тоо, ур чадвар, сургалтад хамрагдсан байдал;
  - судалгаанд хамрагдагчдын тоо, аргачлал;
- ☐ **Орон нутаг:**
  - орон нутгийн эрэлт хэрэгцээний судалгаа;
  - бизнесийн боломж;
  - сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны дүн;
- ☐ **Онцлох уулзалт, ярилцлагууд:**
  - ур шимийг хүртэгчдийн чухалчилж буй асуудлууд;

- нөхцөл байдлын судалгаанд хамрагдахаар сонгогдсон эдийн засгийн үйл ажиллагаа;
- орон нутгийн болон ТББ-уудын дэмжлэг;

☐ **Сургалтын дараах үйл ажиллагаа:**

- шаардлагатай сургалтын дараах үйл ажиллагаанд оролцох хүмүүс, хуваарь;

(iii) Нөхцөл байдлын судалгаа

Тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг бий болгох боломжтой салбарыг эсвэл тодорхой үйл ажиллагааг сонгож орон нутгийн зөвлөлтэй санал солилцсоны дараа тухайн үйл ажиллагааны ашиг, тогтвортой байдлыг судлах зорилгоор нөхцөл байдлын судалгааг хийх бөгөөд үүнд дараах зүйл хамрагдана.

☐ зах зээлийн дүн шинжилгээ;

☐ техник тодорхойлолт;

☐ менежментийн асуудал;

☐ санхүүгийн дүн шинжилгээ;

(iv) Сургагч нарыг бэлтгэх дамжаа

Сургагч багшийг бэлтгэх дамжааны үйл ажиллагааг тухайн сонгосон эдийн засгийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлагын судалгааг хийсний дараа зохион байгуулна. Дамжааг дууссаны дараа сургалтын ажилтан дамжааны явц, үр дүнгийн талаар тайлагнах бөгөөд уг тайлан дараах асуудлуудыг хөндсөн байна.

☐ сургагч нарыг сонгож авсан талаар;

☐ дамжааны агуулга;

☐ сургагч нарыг шалгасан;

☐ үйлчлүүлэгчдэд зориулсан сургалт явуулахад шаардлагатай сургалтын хөтөлбөр бэлтгэхэд шаардлагатай аргачлал, дамжааны нэр, зорилтуудыг гүйцэлдүүлэх хугацаа, арга зүй, сургалтын материал, тоног төхөөрөмж, өртөг болон үнэлгээ өгөх зэрэг болно.

Сургагч нарыг бэлтгэх дамжааны зардлын төсвийг сургалтын тайланд хавсаргах бөгөөд үүнийг үндсэн үйлчлүүлэгчид зориулсан сургалт эхлэхээс өмнө ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үндэсний багийн удирдлагаар хянуулсан байна.

(v) Сургалтын дамжааны тайлан

Ур чадварын дамжааны үйл ажиллагааг явуулах явцад тодорхой хэмжээний хяналт-шинжилгээний загварыг сургалтын хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор бөглөсөн байна.

Сургалтын үйл ажиллагааны тайлан нь дээр дурьдсан загварууд дах мэдээллийг нэгдсэн маягаар гаргана. Холбогдох Сургалтын дамжааны тайланг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн багийн гишүүн дамжааг дуусмагц боловсруулж бэлэн болгоно.

Сургалтын дамжааны тайлан нь тухайн дамжааны төлөвлөгөөтэй харьцуулсан байдлаар гаргана. Өөрөөр хэлбэл сургалтын дамжааны онцлох үйл ажиллагаа, сургалтад хамрагдагчдын сургалтын үзүүлэлт, тулгарсан бэрхшээл зэргийн талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Тайланд цаашид сургалтын дамжааны хөтөлбөрт оруулж болох өөрчлөлтүүдийнг талаар санал тусгасан байх бөгөөд уг тайлан дараах сэдвүүдийг хөндсөн байна:

☐ сургалтын арга зүй, агуулга, сургалтын материалтай холбогдуулан өгсөн үнэлэгээ;

☐ сургагчын үйл ажиллагаа, мэргэжлийн ур чадварын үнэлгээ, тогтвортой байдал;

☐ сургалтад хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж, бусад материалын тогтвортой байдал;

☐ суралцагчидтай хийсэн ярилцлага;

☐ сургалтыг зохион байгуулсан газар, цагийн хуваарь, бусад үйл ажиллагаатай холбогдох асуудал;

☐ ур чадарын сургалтын өртөг:

- багшийн ажлын хөлс;
- сургалтын материал;
- сургалтын багаж тоног төхөөрөмж;
- тээврийн зардал;
- нийт өртөг, суралцагч тус бүр оногдох зардал.

☐ суралцагчдын санал хүсэлт, тэдний хөдөлмөр эрхлэлт, бизнесийн талаарх хэтийн төлөвлөгөө;

☐ амжилт, тулгарсан бэрхшээлийн талаарх ерөнхий дүгнэлт.

(vi) Сургалтын дараах үйл ажиллагааны тайлан

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн эцсийн тайлан бол сургалтын дараах үйл ажиллагаанд хэрхэн бэлтгэсэн болон хүргэсэн талаарх тайлан юм. Энэ тайлан нь сургалтын дамжаа дуусаад 3 сар болсны дараах төгсөгчдийн үйл ажиллагаатай танилцсаны үндсэн дээр бэлтгэгдэнэ. Төгсөлтийн дараах үйл ажиллагааны тайлан нь дараах зүйлийг агуулсан байна.

- сургалтын үйл ажиллагааны нөлөө, үр дүн, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт болон орлого нэмэгдэж байгаа талаар мэдээлэл, тулгарч буй мэдээлэл, үр шимийг хүртэгчдийн талаарх эцсийн дүгнэл;
- сургалтын дараах дэмжлэгийн үйлчилгээний туршлага- эдгээр үйл ажиллагаанууд нь төлөвлөгөөний дагуу явж байна уу? Нөхцөл байдал нь хэр байна вэ? Оролцогч байгууллагуудын практик туршлага?

3.2. Ахиц дэвшлийн тайлан

Дээрх төрлийн тайлан нь хөтөлбөр хэрэгжүүлсэн орон нутаг бүрд гаргах бөгөөд үүнд:

- ☐ төлөвлөгдөж байсан сургалт;
- ☐ сургалтын үр дүн;
- ☐ сургалтын үр дагавар;
- ☐ сургалтын талаар хамтарч ажиллаж, сүлжээ тогтоосон бусад байгууллагуудын талаар;
- ☐ сургалтын өртөг;

→ **Хувиараа хөдөлмөр эрхлэлт, жижиг бизнес/үйлдвэрлэлийн төслийн дүн шинжилгээ, үнэлэгээ өгөх аргачлалыг Хавсралт 6.7-оос харна уу.**

→ **Хамтарч ажиллаж буй орон нутгийн багуудын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх талаар хавсралт 6.8.-аас харна уу**

Хавсралтууд

Хавсралт 6.1. Хэрэгжилтийн явцын мэдээллийн хүснэгт (үлгэрчилсэн загвар)ХЭЗЧДС-ын Төсөл

Үзүүлэлт		Суурь	Зорилт	9/04	3/05	9/05	3/05	Нийт
Хөгжлийн зорилт: Зорилтод газруудад эдийн засгийн боломж, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх								
Тэргүүлэх зорилт 1.Зорилтод бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгэдүүлэх								
Орлогыг бий болгохын тулд ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн оролцогчид	Эмэгтэйчүүд	0	%		#%	#%	#%	#%
	Залуучууд	0	%					
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	0	%					
	Нийт	0	%					
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								
Тэргүүлэх зорилт 2. Зорилтод бүлгүүдийн мэдээллийн болон санхүүгийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх								
Мэдээллийн нэгтгэж байгаа бизнесийн байгууллагууд эсвэл зорилтод бүлгүүдийн бусад эх сурвалжууд		0	%	#%	#%	#%	#%	#%
Зорилтод бүлгүүдэд санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрдүүлж өгч байгаа хадгаламж зээлийн үйлчилгээ эрхлэдэг байгуулагууд		0	%	#%	#%	#%	#%	#%
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								
Үр дүн 1. Бизнес хамтын ажиллагаа, хадгаламж зээлийн чиглэлийн менежментийн зохион байгуулалт, үйл ажиллагааны менежмент								
Бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр суралцсан ажилтан		0	#					
Хадгаламж зээлийн чиглэлээр суралцсан ажилтан		0	#					
Үзүүлэлт		Суурь	Зорилт	9/04	3/05	9/05	3/05	Нийт
Үр дүн 2. Бизнесийн болон хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд, удирдлага , орон нутаг, түүний гадна зах зээл, үйлчилгээг үзүүлэгчид, бусад байгуулагуудын оролцоо								
Бизнесийн болон хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрэлдэг байгууллагууд, удирдлага нь өөрийн орон нутаг, түүний гадна зах зээл, үйлчилгээг үзүүлэгчид , бусад байгуулагуудын газар дээр нь ирж зохион байгуулсан уулзалт		0	#					
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								

Үзүүлэлт		Суурь	Зорилт	9/04	3/05	9/05	3/05	Нийт
Дэд зорилт 1. Зорилтод бүлгүүдийн мэргэжлийн, үйлдвэрлэлийн, менежмент, бичиг үсгийн ур чадварыг нэмэгдүүлэх								
Өөрсдийн суралцсан ур чадварыг эзэмшсэн гэдгээ харуулсан суралцагчид		0	% #	#%	#%	#%	#%	#%
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								
Үр дүн 3. Зорилтод бүлгүүдийн гишүүдээс мэргэжлийн, үйлдвэрлэлийн, менежмент, бичиг үсгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамрагдсан хүмүүс								
Зорилтод бүлгээс ... хүн Зорилго 2400		0	#					
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								
үзүүлэлт		Суурь	зорилт	9/04	3/05	9/05	3/06	Нийт
Дэд зорилт 2. Зорилтод хүн ам д ур чадварын сургалтын загварыг боловсруулж, сургалт явуулах түнш байгууллагуудын чадвахийг нэмэгдүүлэх								
... Хэрэгцээнд суурилсан сургалтын программын загвар, түнш сургалтын байгуулагуудын санал	Байгууллага 1	0	"					
	Байгууллага 2	0	"					
	Байгууллага 3	0	"					
	Байгууллага 4	0	"					
	Байгууллага 5	0	"					
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								
Үр дүн 4. Төслийн арга зүйд суралцсан түнш байгууллагуудын хүний нөөц								
Төслийн арга зүйд суралцсан түнш байгууллагуудын хүний нөөц		0	"					
Үр дүн 5. Түнш байгууллагууд, бусад болзошгүй оролцогч талуудын дунд хөтөлбөрийн үйл ажиллагааг таниулж сурталчилсан байдал								
... хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцаж, хамтарч ажиллахаар болсон түнш/оролцогч байгууллага		0	"					
Дүн шинжилгээ хийх нарийвчилсан мэдээлэл								

Хавсралт 6.2. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө (үлгэрчилсэн загвар)

Үйл ажиллаганы үзүүлэлт		Мэдээллийг олж авах				Дүн шинжилгээ, тайлан	
Үйл ажиллагааны үзүүлэлт	**Үзүүлэлтийн тайлбар болон хэмжих нэгж**	**Мэдээллийн эх сурвалж**	**Мэдээлэл цуглуулах арга зүй чиг хандлага**	**Давтамж**	**Хариуцах**	**хуваарь**	**Хариуцах**
Хөгжлийн зорилт: Зорилтод газруудад эдийн засгийн боломж, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх							
Дэд зорилт 1. Зорилтод бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгэдүүлэх							
.. .Орлогыг бий болгохын тулд ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн оролцогчид Зорилтод бүлгээс гадуурхагдсан Зорилго ... -ийн 70 %	Зорилтод бүлгүүдээс хамрагдсан оролцогчид(эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд) ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь төслийн бүх сургалтын хөтөлбөрийг оролцуулна (мэргэжлийн, үйлдвэрлэлийн, менежментийн болон бичиг үсгийн). Орлогыг бий болгох үйл ажиллагаанд бүх төрлийн хөдөлмөр эрхлэлт хамаарна (цалингийн, хувирааа хөдөлмөр эрхлэлт, багцалсан, эсвэл цагийн) Залуучууд гэдэг нь -15-35 насныхан байна. Нэгж: оролцогчид	Орон нутгийн төслийн баг	Төслийн оролцогч бүрийн бөглөж өгсөн төслийн хяналт-шинжилгээ үнэлгэний загвар	Улирлаар	үндэсний хөтөлбөрийн зөвлөл	Хагас жил тутамд /2 болон 8-р сард/	Үндэсний хөтөлбөрийн зөвлөл
Дэд зорилт 2. Зорилтод бүлгүүдийн мэдээллийн болон санхүүгийн эх сурвалжийн хүртээмжийг сайжруулах							
...мэдээллээр хангасан бизнесийн байгууллагууд болон бусад эх сурвалжууд Зорилго:	Хадгаламж зээлийн байгууллага болон орон нутгийн бусад гишүүд зэргээс бүрдсэн Төслийн хүрээнд байгуулагдсан бизнесийн түншлэлүүд, менежмент технологийг өргөжүүлэхэд чиглэгдсэн бусад холбоо зэрэг Нэгж: байгууллагууд	Орон нутаг дах төслийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутам	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл

Үйл ажиллаганы үзүүлэлт		Мэдээллийг олж авах				Дүн шинжилгээ болон тайлан	
үйл ажиллаганы үзүүлэлт	үзүүлэлтийн тайлбар, хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй чиг хандлага	Давтамж	Хариуцах	хуваарь	Хариуцах
Зорилтод бүлгүүдэд санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгосон санхүүгийн байгууллагуудын тоо Зорилго:	Хөтөлбөрийн хүрээнд хамрагдаж суралцсан хамтын бөгөөд хамтарсан зээл авах хүсэлт гаргасан (нэг тосгоноос 3 хүнийг) санхүүжүүлсэн хадгаламж зээлийн байгуулага Нэгж... байгууллага	Төслийн болон НРСП-ийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар болон НРСП-ийн зээлийн бүртгэл	6 сар тутам	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл
Үр дүн 1. Бизнесийн зохион байгуулалт,үйл ажиллаганы менежментэд суралцсан бизнес, хадгаламж зээлийн байгууллагын ажиллагчид, гишүүд							
Сургалтад хамрагдсан хүний тоо ... Зорилго .. бизнесийн байгууллага ... хадгаламж зээлийн байгууллага ...	Бизнес болон хадгалмж зээлийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдох менежментийг заах сургалт	Орон нутгийн төслийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл
Үр дүн 2. Бизнесийн болон хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрэлдэг байгууллагууд, удирдлага, орон нутаг, түүний гадна зах зээл, үйлчилгээг үзүүлэгчид, бусад байгууллагуудын оролцоо							
Дээрх чиглэлээр зохион байгуулсан уулзалт, Зорилго: ..	Зөвөлгөө, зөвлөмж өгсөн бизнесийн болон хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд, удирдлага, орон нутаг, түүний гадна зах зээл, үйлчилгээг үзүүлэгчид, бусад байгууллагууд	Орон нутгийн төслийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл

Үйл ажиллагааны үзүүлэлт		Мэдээллийг олж авах				Дүн шинжилгээ болон тайлан	
Үйл ажиллаганы үзүүлэлт	Үзүүлэлтийн тайлбар болон хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй чиг хандлага	Давтамж	Хариуцах	хуваарь	Хариуцах
Дэд зорилт 1. Зоритот бүлгүүдийн гишүүдээс мэргэжлийн, үйлдвэрлэлийн, менежмент, бичиг үсгийн ур чадварыг нэмэгдүүлэх							
... Өөрсдийн суралцсан ур чадварыг эзэмшсэн гэдгээ харуулсан суралцагчид	Сургалтын дараа тухайн оролцогч бүрийн ур чадварыг тодорхой нөхцөл, бүрдүүлсэн практик, онолын шалгалт сургагч авна.	Орон нутгийн төслийн баг	Ур чадварыг шалгах загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл
Үр дүн 3. Зоритот бүлгүүдийн гишүүдээс мэргэжлийн, үйлдвэрлэлийн, менежмент, бичиг үсгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамрагдсан хүмүүс							
Зорилтод бүлгээс сургалтад хамргадсан бүлгийн хүний тоо... Зорилго ...	Дор хаяж нэг ур чадварын сургалт, үйлдвэрлэл, менежмент, бичиг үсгийн сургалтын дамжаанд хамрагдаж төгссөн хүмүүсийн тоо.. Нэгж.. .. Суралцагчид	Орон нутгийн төслийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл
Дэд зорилго 2. Зорилтод хүн ам д ур чадварын сургалтын загварыг боловсруулж, сургалт явуулах түнш байгууллагуудын чадвахийг нэмэгдүүлэх							
... Хэрэгцээнд суурилсан сургалтын программын загвар, түнш сургалтын байгуулагуудын санал Сургалтын байгууллаар: Тогтоох шаардлагатай:	Орон нутгийн холбогдох байгуулагуудтай санал солилцсоны үндсэн дээр хэрэгцээнд суурилсан сургалтын программ Ердийн сургалтыг мэргэжлийн сургалттай харьцуулбал ур чадварын сургалт нь тухайн орон нутгийн эдийн засгийн боломжид суурилсан байдаг Сургалтын дамжааны төрөл нь богино танилцуулагын хэлбэрээр танилцуулагдсан байна. Нэгж: ...хөтөлбөрийн тоо	Орон нутгийн төслийн баг болон төслийг хэргжүүлэгч баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл

Үйл ажиллагааны үзүүлэлт		Мэдээллийг олж авах				Дүн шинжилгээ болон тайлан	
Үйл ажиллаганы үзүүлэлт	Үзүүлэлтийн тайлбар болон хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй чиг хандлага	Давтамж	Хариуцах	хуваарь	Хариуцах
Үр дүн 4. Төслийн арга зүйд суралцсан түнш байгууллагуудын хүний нөөц							
Сургалтад хамрагдсан хүний нөөц .. Зорилго ...	Олон нийтийн хүчин чармайлтыг нэгтгэх, хэрэгцээг тодорхойлох, сугалтыг зохион байгуулах болон сургалтын дараах үйлчилгээ Орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага зэрэг болно. Нэгж:... албан хаагчид болон техник үйлчилгээний ажилтнууд	Орон нутгийн төслийн баг	Төслийн хяналт-шинжилгээний загвар	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл
үр дүн 5. Түнш байгууллагууд болон бусад болзошгүй оролцогч талуудын дунд хөтөлбөрийн үйл ажиллагааг таниулж сурталчилсан байдал							
... хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцаж, хамтарч ажиллахаар болсон түнш/оролцогч байгууллага	Түнш болон бусад хамтран ажиллах байгууллагуудын хүний нөөцийн чдавхийг дээшлүүлэх Нэгж :... хүн	Төслийн ажиллагчид	Төслийн тайлан	6 сар тутамд эхэлнэ	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Хагас жил тутам дах техникийн дэвшлийн хяналт	Хөтөлбөрийн үндэсний зөвлөл

Хавсралт 6.3. ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ

ХЭЗЧДС-ын сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээг гурван үе шаттайгаар хийнэ. (*хавсралт загваруудыг харна уу*)

Үе шат 1. Сургалт явуулахаас өмнө

- суралцагчдыг сонгон авах
- сургалтад хамрагдах хүсэлт гаргах
- сургалтад хамрагдагчийн бүртгэл

Үе шат 2. Сургалтын явцад

- сургалтын явцын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх
- сургалтын тайлан гарсаны дараа

Үе шат 3. Сургалт дууссаны дараа

- төгсөлт
- төгсөлтийн тайлан гарсаны дараа
- сургалт дуусгасан тухай тайлан гарсаны дараа

Үе шат 1. Сургалт явуулахаас өмнө

ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь сургалтын үйл ажиллагааг эхлэхээс нь өмнө холбогдох зориулалтын загваруудын дагуу хяналт шинжилгээ хийнэ.

Суралцагчдын сонгон авах

Суралцагчдын мэргэшсэн байдал. ХЭЗЧДС-ын төсөлийн түнш, бусад оролцогч байгууллагуудын зүгээс орон нутгийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулагчдаар дамжуулан сургалтад тодорхой сургалтын хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг сонгож, бүртгэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдээс дараах шаардлага хангасан иргэдийг хөтөлбөрт хамруулахаар сонгож авна. Үүнд:

- Хөтөлбөр явуулах зорилгоор судалгаа хийгдсэн газрын оршин суугч байх;
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ядуу иргэд бүхий зорилтод бүлэг хамааралтай байх;
- Жендер, улт төр болон шашин шүтлэгээр нь гадуурхахгүй байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэн түрүүн сонгож авах бодлого баримтлах.

Сургалтад хамрагдах хүсэлт гаргах. Сургалтад хамрагдах тухай хүсэлт гаргах хугацаа, сургалтад хамрагдах хүсэлт гаргагчийн тухай ямар тодорхой мэдээлэл шаардлагатай талаар бүртгэлийн загварт дэлгэрэнгүй дурьдсан байх ба сургалтад хамрагдах хүсэлтэй иргэн дээрх загварыг үнэн зөв бөглөсөн байх шаардлагатай.

Сургалтад хамрагдагчийн бүртгэл. ХЭЗЧДС-ын төсөл нь бүртгэлийн материалаас тухайн сургалтад хамрагдах хүсэлт гаргагч нь хөтөлбөрийн шаардлага хангасан эсэхийг сургалтад хамрагдагчдын бүртгэлээр тогтооно. Уг бүртгэлийг сургагч хариуцах бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага хяналт тавна.

Сургалтад хамрагдах хүсэлт гаргах загвар (Хавсралт 6.3. (а)-г харна уу)

ХЭЗЧДС-ын төслийн зүгээс уг загварыг бөглөсөн байхыг шаардлага тавих хэд хэдэн шалтгаан байна:

- Сургалтад хамрагдах зорилтод бүлэг болон гишүүдийн хувийн болон эдийн засгийн нөхцөл байдалтай танилцаж, бусад холбогдох мэдээлэлтэй байх;
- Тухайн сургалтын хөтөлбөрт хамрагдах иргэдийг сонгон авахдаа холбогдох шалгууруудыг харгалзан авсан эсэх;
- Сургалтад хамрагдагчид нь үнэхээр уг сургалтад хамрагдах хэрэгцээ, сонирхолтой байсныг нотлох баримттай болох;

Сургалтад хамрагдах загвар нь сургалтад хамрагдагсдын зүгээс бүрдүүлэх болон мэдүүлэх зарим нэгэн ач холбогдол бүхий мэдээллийг агуулна. Хэрэв сургалтад хамрагдагч тухайн шаардлагуудын хангасан мэдээлэл өгөх боломжгүй бол орон нутгийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийн зохион байгуулагч байгууллагын ажилтанд туслалцаа үзүүлнэ.

Хамрагдахаар хүсэлт гаргасан сургалтын дамжаа. Энэ нь тухайн сургалтад хамрагдах хүсэлт гаргагчийн сонирхож байгаа сургалтын дамжааг хэлнэ. Дээрх хүсэлтийг гаргаж буй иргэн орон нутгийн эдийн засгийн шаардлага, сургалтын хэрэгцээг тодорхойлох ажлын хүрээнд хийгдсэн орон нутгийн иргэдтэй уулзах уулзалтад оролцож нь хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааны хамрах хүрээний талаар тодорхой мэдлэгтэй болсны үндсэн дээр хүсэлт гаргаж байна гэж ойлгоно.

Тухай орон нутгийн нэр, хаяг. Үүнд хөтөлбөрт хамрагдаж байгаа тухайн орон нутагт хамаарах мэдээллийг ойлгоно.

Хувийн мэдээлэл. Сургалтад оролцохоор хүсэлт гаргагчтүүний ар гэр, боловсрол болон бусад холбогдох ерөнхий мэдээллийг хэлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн байдал. Сургалтад хамрагдах хүсэлт гаргагч нь загварын холбогдох: одоогоор ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эсвэл цалинтай хөдөлмөрэрхлэлт гэх мэтийн өөрт нь хамаарах холбогдох заалтыг сонгож бөглөнө.

Хийж буй ажлын талаарх мэдээлэл. Хэрэв сургалтад хамрагдах хүсэлт гаргагч нь тодорхой ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бол, ажил олгогч, эрхэлж буй ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Бусад орлогын эх үүсвэр. Сургалтад хамрагдах хүсэлт гаргагч нь дээр дурьдсан ажлаас гадна бусад орлогын эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй дурдана.

Гэр бүлийн сарын дундаж орлого. Цалингийн болон хувираа эрхэлсэн хөдөлмөрөөс олсон ашгаас гадна бүхий боломжит эх үүсвэрээс олдог гэр бүлийн сарын нийт орлогын хэмжээг хэлэх бөгөөд орлогын дараах байдлаар ангилж авч үзнэ:

- 1000 Р-ээс доош
- 1001-3000 Р-ийн хооронд
- 3001-5000 Р-ийн хооронд
- 5000 буюу түүнээс дээш

Хариуцлага. Загварын бөглөх эцсийн шат бол: тухайн сургалтад хамрагдахад тавигдах шаардлага,бусад нөхцлүүдийг хүлээн зөвшөөрч, сургалтад идэвхи зүтгэлтэй оролцоно гэсэн үүрэг хүлээснийг илэрхийлж дармалдаж бичсэн нэрийнхээ дээр гарын үсэг зурна.

Сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварыг бөглөх

Сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварыг сургалтад хамрагдах хүсэлт гаргагчийн мэдүүлсэн сургалтад хамрагдах хүсэлт гаргах загварын үндсэн дээр сургагч бөгөлнө. Хэрэв сургалтад хамрагдах хүсэлт гаргагчийн мэдүүлсэн загвар нь зохих журмын дагуу хийгдээгүй бол сургагч үүнийг засах арга хэмжээ авч холбогдох сургалтыг хэрэгжүүлж буй байгууллагад энэ талаар мэдэгдэх бөгөөд энэ нь сургалтын загвар, төлөвлөгөөг бэлдэхэд ач холбогдолтой байна.

Сургалтыг зохион байгуулах газар. Сургагч нь сургалт болох газар, сургалтын нэрийг маш тодорхойгоор загварны зориулалт бүхий зайнд оруулж бичсэн байна. Энэ мэдээлэл нь ХЭЗЧДС-ын төсөл, түншүүдийн хийх хяналт-шинжилгээнд чухал хэрэгтэй.

Сургалтыг эхлүүлэх. Энэ хэсгийг сургалт эхлэх тодорхой хугацааг заасан байх ёстой бөгөөд энэ бичиг баримт бүрдүүлэлт, захиргааны/санхүүгийн талаасаа заавал байх ёстой шаардлага.

Сургалт дуусах ойролцоо хугацаа. Сургагч нь энэ хэсэгт сургалтыг дуусгавар болгохоор тооцож буй хугацааг бичнэ. Ингэхдээ сургагч нь дамжааны хугацаа, хичээлийн орчин, захиргааны болон техникийн нөхцөл байдлыг харгалзаж үзсэн байх хэрэгтэй.

Сургалт үргэлжлэх нийт өдөр/цаг. Сургагч багш нь сургалтын санал дээр үндэслэж сургалт үргэлжлэх хугацааг өдрөөр/ цагаар тооцож гаргана. Сургалтын хугацаа нь сургагчдын тоо, сургагч нарын цалин хөлсөөс, тухайлбал цагаар цалинждаг эсвэл өдрөөр багцалж цалинжиж байгаа эсэхээс хамаарна.

Суралцагчдын нэр. Суралцагчдын бүтэн нэрийг баганад үнэн зөвөөр оруулсан байна. Хяналт-шинжилгээний үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор суралцагчдын нэрийг цагаан толгойн дараалаар, хүйсээр ялгаж бичнэ.

Хувийн мэдээлэл. Хувийн мэдээлэл оруулахад зориулагдсан бусад багануудад дах хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, нийгмийн байдал, боловсрол зэргийн мэдээллийг сургалтад хамрагдах хүсэлт гаргах загвараас авч бичнэ.

Эдийн засгийн мэдээлэл. Эдгээр гурван баганад тусгай анхаарал хандуулах хэрэгтэй. Сургагч нь энэ хэсэгт орох мэдээллийг шалгаж, хэрэв шаардлагатай бол залруулга хийнэ.

- Гэр бүлийн гишүүдийн тоо: энэ мэдээлэл нь сургалтын дараах судалгаанд чухал ач холбогдолтой ба уг сургалтын хөтөлбөр тухайн гэр бүлийн хувьд хэр зэргийн нөлөө үзүүлснийг тогтооход хэрэглэгдэнэ;
- Хөдөлмөр эрхлэлтийн байдал: Энэ мэдээлэл нь сургалтад хамрагдагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд тус сургалтын хөтөлбөр хэрхэн нөлөөлсөн талаар дүгнэлт хийхэд ач холбогдолтой байх болно;
- Гэр бүлийн сарын дундаж орлого: энэ мэдээлэл нь сургалтын дараах болон өмнөх тухайн гэр бүлийн орлогыг харьцуулахад хэрэгцээтэй.

Үе шат 2. Сургалтын явцад

Сургалтын явцын үйл ажиллагааны хяналт шинжилгээ

ХЭЗЧДС-ын төсөл нь сургалтуудыг цаг хугацаанд нь чанартай хүргэгдэж буй байдалд хяналт-шинжилгээ хийнэ. Сургалтын үйл ажиллагааны явцыг сургалтын үйл ажиллагааны тайлангийн загварын дагуу хийх бөгөөд энэ загварт сургалтын бүхий л хэсэг холбогдох даалгавар эсвэл бүрэлдэхүүн хэсэгтэй үйл ажиллагааг нягт бүртгэж тайлагнасан байна.

Нэгэнт энэ нь тайлагнах үйл ажиллагаа тул сургагч нь төлөвлөгдсөн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, тулгарч буй бэрхшээл, бусад техникийн болон, захиргааны холбогдолтой асуудлуудын талаар тусгасан байна. Гэхдээ ХЭЗЧДС-ын төсөл нь мөн хэрэгжүүлсэн арга хэмжээ, эсвэл сургагчийн эсвэл сургалтад хамрагдагчдын санал хүсэлттэй холбогдох мэдээллийг авч хяналт-шинжилгээ үнэлгээ хийхийг зорьдог болно.

Тайлан сургагч сургалтын дунд үед бэлтгэж хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад эсвэл бусад эрх бүхий этгээдэд танилцуулсаны үндсэн дээр ирүүлнэ.

Сургалтын явцын үйл ажиллагааны тайланг гаргах нь.Сургагч нь зориулалтын загварыг доор дурьдсан мэдээлэл, зааварчилгааны дагуу бэлтгэнэ.

Сургалтын дамжаа. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварт бичигдсэн сургалтын нэр бичигдэнэ.

Сургалтыг зохион байгуулах газар. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварт бичигдсэн сургалт зохион байгуулах газар бичигдэнэ.

Эхлэх болон дуусах хугацаа, нийт сургалт үргэлжлэх хугацаа/цаг. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварт бичигдсэн сургалтын хугацаа бичигдэнэ.

Зарцуулагдсан өдрүүдийн тоо

Энэ хэсэгт сургалт эхэлснээс хойш тайлан гаргах өдрийг хүртэл хичээллэсэн өдрүүдийг хамруулна.

Үлдсэн өдрүүдийн тоо. Энэ хэсэгт сургалтыг дуусах хүртэл хичээллэхээр үлдсэн өдөр, цагийг бичнэ.

Хийгдэх даалгавар. Энэ баганыг ур чадварыг сургахад шаардлагатай сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан даалгавар бүрийг хичээлийн нэгж, бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нарийвчлан гаргаж бичсэн байна.

Статус (хийгдсэн болон үргэлжилж байгаа). Энэ хэсэг нь тухайн сургалтын бодит явцыг ХЭЗЧДС-ын төсөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Сургагчийн тэмдэглэл. Энэ баганад сургагч нь тулгарч буй бэрхшээл, тодорхой асуудал, тэдгээрийг шийдвэрлүүлэхээр авсан арга хэмжээ, цаашид төслийн зүгээс анхаарах асуудал зэргийн мэдээллийг ХЭЗЧДС-ын төсөлд өгөх зориулалттай болно.

- Техник үйл ажиллагаатай холбогдуулан – сургалтын загвар, сургах материал, сургалтын багаж, түүхий эд, тоног төхөөрөмж гэх сургалтын үйл ажиллагааны техник ажиллагаатай холбогдох асуудал.
- Захиргаа – үүнд сургалтын цагийн хуваарь, ирц, үргэлжлэх хугацаа зэрэг хамаарна. Түүнчлэн үүнд санхүү, тээвэрлэлт зэрэг асуудлууд хамаарч болно.

Үе шат 3. Сургалт дууссаны дараа

Уламжлалт ёсоор сургалт нь хаалтын эсвэл төгсөлтийн үйл ажиллагаагаар дуусгавар болно. Төслийн зорилтод бүлгүүдийн хувьд төгсөх өдөр нь сэтгэл хөдлөм байдаг. Төгсөгчдийн хувьд сургалт нь сайн сайхан амьдралын хүч хөдөлмөр, хичээл зүтгэл гарган мөрөөдлийг нь биелүүлэхэд хэрэгцээтэй ур чадвар, мэдлэгийг олж авах боломжийг бүрдүүлснээрээ онцлог байх болно. Энэ өдөр тэдгээр нь мөн сургалтад амжилттай оролцсоны нотолгоо болох гэрчилгээ авна. ХЭЗЧДС-ын төслийн хувьд харин төгсөлтийн өдөр бол сургалтын үр дүнг дүгнэж, хэрэгцээтэй цаашдын үйл ажиллагаанд анхаарах зүйлүүдийг тодруулах зорилгоор хяналт-шинжилгээ хийх цаг юм. Төслийн хувьд төгсөлтийн болон сургагч багшийн тайлангууд нь чухал байр суурь эзэлдэг. Дээрх хоёр тайланг дор хаяж төгсөлт хийснээс хойш хоёр өдрийн дотор сургагч нар нь бэлтгэж гаргаж өгсөн байвал зохино.

Төгсөлтийн тайланг бэлтгэх

Төгсөлтийн тайлан нь суралцагчдын үзүүлэлт, суралцагчид нь гэрчилгээнд заагдсан сургалтын болзлыг хангасан гэх мэтийн сургалтын дамжааны талаарх мэдээллийг агуулна. Төгсөлтийн тайлангийн загварт дараах мэдээллийг оруулсан байна:

Сургалтын дамжаа. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загвар, сургалтын үйл ажиллагааны явцын тайланд бичигдсэн сургалтын нэр бичигдэнэ.

Сургалтыг зохион байгуулах газар. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загвар, сургалтын үйл ажиллагааны явцын тайланд бичигдсэн сургалт зохион байгуулах газар бичигдэнэ.

Эхлэх болон дуусах хугацаа, нийт сургалт үргэлжлэх хугацаа/цаг. Энэ хэсэгт сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загвар, сургалтын үйл ажиллагааны явцын тайланд бичигдсэн сургалтын хугацаа бичигдэнэ.

Нийт суралцагчдын тоо. Энэ хэсэгт сургалтад хамрагдахаар орсон, сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварт бүртгэгдсэн тоог бичнэ. Гэхдээ суралцагчдыг эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, насаар нь ангилж бичсэн байх бөгөөд сургалтад хамрагдагчдын бүртгэлийн загвараас уг мэдээллийг авна. .

Суралцагчдын нэр. Энэ мэдээллийг сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загвараас авна.

Ур чадварын сургалт. Энэ багананд сургагчийн аван шалгалтанд унасан эсвэл тэнцсэн гэж ангилан бичнэ. Мэдээллийг оруулахдаа холбогдох багануудад оруулах бөгөөд тухай бүр сургагч багш холбогдох үнэлгээг тавьсан байна.

Үйлдвэрлэлийн сургалт. Энэ багануудад дээрхийн адил тэнцсэн тэнцээгүй гэж мэдээллийг хуваж оруулах бөгөөд гол үнэлгээг цаашдын үйл ажиллагааны төслийн төлөвлөгөөг хийсэн байдлыг харгалзан өгсөн байна.

Төслийн нэр. Энэ хэсэгт суралцагч сургалтад хамрагдах явцдаа хийж бэлтгэх ёстой байсан цаашид хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөөний бүтэн нэрийг бичнэ. Дээрх мэдээлэл нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс төгсөгчдийн цаашдын үйл ажиллагаанд хяналт тавихад хэрэгтэйгдэнэ.

Төгсөлтийн тайлан. Уг тайланг сургагч бэлтгэх бөгөөд сургалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцсан нэгжийн дарга эсвэл түүний эрх олгосон этгээд хянасан байна.

Сургагчийн тайланг бэлтгэх нь. Төгсөлтийн тайлан нь тухайн суралцагчийг төгссөн гэрчилгээний болзлыг хангахуйц амжилт үзүүлснийг харуулах зорилготой бол сургагчийн тайлан нь тухайн сургагчийг сургалтын үйл ажиллагаагаа дуусгасныг илэрхийлнэ. Энэ тайлан нь сургагчийн техник, захиргааны хариуцлага дуусгавар болж ажлын хөлсөө авах нөхцлийг бүрдүүлнэ. Сургагчийн тайлан дараах мэдээллийг агуулсан байна:

Сургалтын дамжаа. Энэ хэсэгт өмнө нь бөглөсөн загваруудтай адилхан мэдээллийг оруулсан байна.

Сургалтыг зохион байгуулах газар. Энэ хэсэгт өмнө нь бөглөсөн загваруудтай адилхан мэдээллийг оруулсан байна.

Сургалт үргэлжилсэн өдөр/цаг. Энэ хэсэгт өмнө нь бөглөсөн загваруудтай адилхан мэдээллийг оруулсан байна.

Сургалтын үр дүн. Энэ хэсэгт сургалтын төгсөлтийн тайлангаас холбогдох мэдээллийг оруулна.

Сургалтын амжилттай талууд. Энэ хэсэгт сургагч нь сургалтын явц, загвар, суралцагсдын хэрэгцээг хангасан, ХЭЗЧДС-ын хөтөлбөр, арга зүйн үндсэн зорилгод нийцсэн эсэхэд мэргэжлийн үнэлгээ өгсөн байна.

Тулгарсан бэрхшээл. Энэ хэсэгт сургагч нь сургалтын явцад учирсан бэрхшээл, бусад асуудлын талаар дурьдах бөгөөд үүнд техник, захиргааны шинж чанартай бэрхшээлүүд орно. Мөн энэ хэсэг нь сургалтын үйл ажиллагааны явцын тайланд орсон саад бэрхшээлүүдийн талаар дурьдсан байна.

Авсан арга хэмжээ. Энэ хэсэгт сургагч нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрт тухайн төслийг цаашид хэрэгжүүлэхэд хэрэглэж болохуйц төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор санаачлан авсан арга хэмжээний талаар бичнэ.

Зөвлөмж. Энэ хэсэгт сургагч нь төслийг хэрэгжүүлэх явц, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, өөрийн санал зэргийг тусгана.

Хавсралт 6.3. (а). Сургалтад хамрагдах хүсэлт гаргах загвар

I. **Хамрагдахыг хүсэж байгаа дамжаа**

II. **Орон нутаг, хаяг**

III. **Хувийн мэдээлэл**

Овог /нэр .....

Хаяг .....

Гэрлэлтийн байдал: ☐ Ганц бие ☐ Гэрлэсэн ☐ Бэлэвсэн ☐ Тусдаа амьдардаг

Хүйс: ☐ Эр ☐ Эм ☐ Хөгжлийн бэрхшээлтэй

Нас ..... **Гэр бүлийн гишүүдийн тоо** .....

Боловсролын дээд түвшин

☐ Бага /жил ☐ Дунд/жил ☐ Коллеж /жил

☐ Мэргэжлийн сургалт /жил ..... сургалтын байгууллагын нэр .....

Хөдөлмөр эрхлэлтийн байдал

☐ Ажилгүй ☐ хувиараа хөдөлмөр эрхэлдэг ☐ цалинтай хөдөлмөр эрхэлдэг

Хэрэв хөдөлмөр эрхэлдэг бол мэргэжил/ажил .....

Өрхийн сарын дундаж орлого /Песопоор/

☐ 1000-аас доош ☐ 1001-3000 ☐ 3001-5000 ☐ 5001-ээс дээш

Барьцааны үүрэг

Хэрэв би сургалтын хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд сургалтын ирцийг хангаж, сургалтын бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцохоо илэрхийлж, дамжааг төгсөх, сургалтын явцад бэлтгэх, хийж дуусгах үйл ажиллагааг шаардлагад нийцсэн байдлаар гүйцэтгэж, сургалтын дараа холбогдох үйл ажиллагааг эрхэлж, өөрийн амьдарч буй орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц гишүүн байхаа ухамсартайгаар ойлгож илэрхийлж байна.

Суралцах хүсэлт гаргагчийн дармалдаж бичсэн нэр болон гарын үсэг .....

Хавсралт 6.3. (б). Сургалтын үйл ажиллагааны явцын тайлан
(сургалтын дунд цед тайлагнагдсан байна)

Сургалтын дамжаа .....

Байршил/сургалт явагдах газар .....

Сургалт дуусах ойролцоо хугацаа .....

Сургалт явагдах өдөр/цаг .....

Сургалт явагдсан хугацаа ..... **Сургалт явагдах үлдсэн хугацаа** .....

№	Даалгавар үр шат бүрээр (сэргэлтын хөтөлбөр) сургалтын загварын дагуу	Явц (сонгоно уу) Гүйцэтгэсэн	Явц (сонгоно уу) Хэрэгжих шатандаа	Багшийн тэмдэглэл
1.	.....	☐	☐	Техник:
2.	.....	☐	☐	.....
3.	.....	☐	☐	.....
4.	.....	☐	☐	.....
5.	.....	☐	☐	.....
6.	.....	☐	☐	Захиргааны:
7.	.....	☐	☐	.....
8.	.....	☐	☐	.....
9.	.....	☐	☐	.....
10.	.....	☐	☐	.....
11.	.....	☐	☐	Авсан арга хэмжээ
12.	.....	☐	☐	.....
13.	.....	☐	☐	.....
14.	.....	☐	☐	.....
15.	.....	☐	☐	.....
16.	.....	☐	☐	Зөвлөмж:
17.	.....	☐	☐	.....
18.	.....	☐	☐	.....
19.	.....	☐	☐	.....
20.	.....	☐	☐	.....

Бэлтгэсэн

Сургагчийн нэр, гарын үсэг, огноо .....

Хяналт тавьсан

Нэр, гарын үсэг, огноо .....

Баталсан /сургалтын байгууллагын дарга, гарын үсэг, огноо .....

Хавсралт 6.3 (в). Сургагчийн тайлан
(Төгсөлтийн тайлантай хамт бэлтгэгдэнэ.)

Сургалтын дамжаа .....

Байршил/сургалт явагдах газар .....

Нийт сургалт явагдсан өдөр/цаг .....

Сургалтын үр дүн .....

Нийт суралцагчдын тоо ..... **Тэнцсэн суралцагчдын тоо** .....

Тэнцээгүй суралцагчдын тоо. ..... **Үйл ажиллагааны төсөл бичсэн суралцагчдын тоо** .....

1. **Сургалтын амжилттай талууд.**

   .....

   .....

   .....

2. **Тулгарсан бэрхшээл.**

   .....

   .....

   .....

3. **Авсан арга хэмжээ.**

   .....

   .....

   .....

4. **Зөвлөмж.**

   .....

   .....

   .....

Бэлтгэсэн: Сургагчийн нэр, гарын үсэг, огноо

.....

Хяналт тавьсан: Нэр, гарын үсэг, огноо

.....

Баталсан: /сургалтын байгууллагын дарга, гарын үсэг, огноо .....

Хавсралт 6.4. Төгсөгчдийн үйл ажиллгааны судалгаа

1. Судалгааны мөн чанар болон зорилго

ХЭЗЧДС-ын арга зүй нь төгсөгчид, сургалтад хамрагдаж шинээр олж авсан ур чадварыг цаашдын үйл ажиллагааны төлөвлгөө, зорилгод хэрхэн нийцүүлэн ашиглаж байгаа, төлөвлөсөн төслийн хэрэгжилтийн явцын байдалтай танилцах зорилгоор дээрх судалгааг хийнэ.

Судалгааны үр дүнг бодит байлгахын тулд судалгааг сургалт дууссаны дараа 3-4 сарын хооронд хийнэ. Мөн судалгааг төгсөгчдийн багцаар нь хийсэн тохиолдолд дүн шинжилгээг хийж нэгдсэн дүгнэлт гаргахад хялбар байх болно.

2. Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгааны бэлтэл ажил

Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгааны загвар. Судалгааны явцад хэрэглэх арга хэрэгсэл нь төгсөгчдийн үйл ажиллагааны судалгааны загвар юм. Загвар нь энгийн, төгсөгч бүрт тавигдах нэг хуудас асуултаас бүрдэнэ.

Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгаанд хамрах сургалтын хөтөлбөрийг тодорхойлох ХЭЗЧДС-ын төслийн ажиллагчид нь сургалтын хөтөлбөрүүдэд хяналт шинжилгээ хийсний үндсэн дээр 3-4 сарын өмнө дууссан сургалтын хөтөлбөрүүдийг сонгож, судалгаа хийнэ.

Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгаанд хамрах төгсөгчдийг тодорхойлох. Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгаанд хамрах сургалтад хамрагдсан төгсөгчдийн нэрсийн жагсаалтаас судалгаанд хамрагдах Суралцагчдыг сонгож авна.

Үндсэн мэдээллийг оруулах. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтан нь тухайн төгсөгчийн мэдээллийг судалгааны загварт сургалтад хамрагдах хүсэлт гаргах загвар, сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загваруудад бичигдсэн хувийн мэдээллийг оруулна.

Ярилцлага, судалгааг хийх этгээдийг сонгох. Судалгааг ярилцлага хэлбэрээр үйлдэнэ. Судалгаа нь дараах хоёр аргаар хийгдэх боломжтой. Үүнд:

- Хэрэв сургалтын хөтөлбөрийг түнш хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжүүлсэн бол ярилцлагыг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтан хийнэ;
- Хэрэв сургалтын хөтөлбөрийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрөөс шууд хэрэгжүүлсэн бол хөндлөнгийн хараат бус судлаач эсвэл түнш байгууллагын төлөөллөөр хийлгэнэ. Энэ тохиолдолд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтан ярилцлагыг хийх дэлгэрэнгүй зааварчилгааг өгсөн байна.

3. Ярилцлагын явц

Сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл. Судлаач нь юуны түрүүнд сургалтын хөтөлбөрийн талаарх холбогдох мэдээлэлтэй танилцана. Үүнд сургалтын санал, сургалтад хамрагдах хүсэлт гаргах загвар,сургалтад хамрагдагчийн бүртгэлийн загварууд, сургалтын үйл ажиллагааны явцын тайлан, ялангуяа суралцагчийн бэлтгэсэн цаашдын үйл ажиллагааны төслийн төлөвлөгөө зэрэг хамаарна. Эдгээр мэдээлэл нь судлаачид төгсөгчидтэй ярилцахад хангалттай мэдээлэл болно.

Зуучлагч. Судлаач нь хөтөлбөр хэрэгжсэн тухайн орон нутгийн төлөөлөл, тухайн төгсөгчийн үйл ажиллагаа явуулж байгаа газарт оршин суудаг, холбогдох мэдээлэл бүхий хүнээр зуучлуулан сургалтад хамрагчидтай холбогдвол хялбар байх бөгөөд дээр дурьдсан зуучлагчдад дараах хүмүүс хамаарч болно.

- ☐ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон орон нутгийн сургалт, хөдөлмөр эрхлэлт хариуцсан зохиуцуулагч;
- ☐ хэрэв боломжтой бол сургагч;
- ☐ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч түнш байгууллагын төлөөлөгч;

Төгсөгчдийг олох. Судалгааны гол хамрагсад нь төгсөгчид байх болно. Дээр дурьдсан сургалт, төгсөгчдийн талаарх мэдээллээс тэднийг хаана байгааг олж мэдэх боломжтой. Төгсөгчид нь тодорхой үйл ажиллагаа эрхэлж байгаа бол тэдний бэлтгэсэн төслийн төлөвлөгөөнөөс байршлыг нь мэдэж болно.

Багийн ярилцлага. Хэрэв боломжтой бол төсгөгчдийг нэг газарт цуглуулж ярилцлага хийвэл энэ нь хамгийн зөв арга болно. Энэ арга нь судалгаанд хамрагдах мэдээллийг нэг дор цугуулах боломжийг бүрдүүлнэ.

Гол мэдээлэгчид. Сургалтад хамрагчидтай уулзах боломжгүй байгаа тохиолдолд гол мэдээлэгчид нь тэдний эцэг эх, ах дүүс, ойрын хамаатнууд байж болох бөгөөд эдгээрээс боломжтой мэдээллийг цуглуулж болно.

Асуулга. Ярилцлага авагч нь асуултад байгаа асуудлуудыг дугаар тус бүрийнх нь дарааллаар асууна:

- Оршил – энэ хэсэгт ярилцлага авагч нь судалгаа ХЭЗЧДС-ын төслийн арга зүй, зорилгод нийцэж байгааг, судалгаа хийх нь зайлшгүй шаардлагатай гэдгийг ярилцлагад оролцогчид тайлбарлаж өгнө**.**
- Төгсөгч нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа юу? Энэ асуултад “тийм”, “үгүй” гэсэн хариулт авахад хангалттай.
- Хэрэв хариулт нь “үгүй” байвал, шалтгаан нь юу вэ? энэ асуултын хариултанд ярилцагч нь төгсөгчөөс төлөвлөсөн үйл ажиллагаа, суралцсан боломжоо хэрэглэж чадахгүй байгаагийн бодит шалтгааныг тодруулна. Асуултын гол нь хувийн, хүрээлэн буй

орчинд хамаарах шалтгаануудыг тодорхойлоход оршино.

- Хэрэв хариулт нь “тийм” бол, ямар эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа вэ? энэ асуултын хариултыг ярилцлага авагч нь дараах гурван төрлөөр задална. Үүнд:

1. Цалинтай хөдөлмөр эрхлэлт – хэрэв төгсөгч нь цалинтай хөдөлмөр эрхэлж байгаа бол холбогдох хэсгийг бөглөнө. Түүнчлэн тухайн ажил нь орон тооных (орон тооны гэдэг нь ажил олгогчийн үндсэн ажилтан хэлбэрээр ажиллах бөгөөд өөр аливаа ажил эрхэлдэггүй), цагийн ажилтан (цагийн ажилтан гэдэг нь тогтмол ажилладаггүй дуудлагаар эсвэл түр зуурын гэрээний үндсэн дээр ажилладаг), эсвэл багцынх (энэ нь тухайн тодорхой ажлыг дуустал ажиллахыг хэлнэ), бусад (дээрх гурван төрлийн алинд нь ч хамаарахгүй) төрөлд хамаарах эсэхийг тодруулж, эрхэлж буй ажлын талаар дэлгэрэнгүй тодруулна.
2. Хувиараа хөдөлмөр эрхлэх-хэрэв төгсөгч нь бие даан орлого бий болгох үйл ажиллагааг эрхэлдэг аливаа ажил олгогчоос хамааралгүй бол (зарим тохиолдолд ажил олгогч гэр бүлийн гишүүдийг ч үүнд хамааруулна) энэ хэсгийг бөглөх бөгөөд тухайн гэр бүлийн хэдэн гишүүн дээрх үйл ажиллагаанд оролцож байгааг тодруулна.
3. Хамтарсан үйлдвэрлэл - энэ хэсгийг төгсөгч нь тодорхой бүлэг хүмүүстэй эсвэл төгсөгчид хамтран үйл ажиллагаа явуулж, ашиг, алдагдлаа хамтран хариуцаж байгаа тохиолдолд бөглөх бөгөөд тухайн үйл ажиллагаанд хэдэн хүн хамтарсан талаар тодруулна.

   - Одоо эрхэлж буй эдийн засгийн үйл ажиллагаа нь таны хамрагдсан сургалтын хөтөлбөрт холбоотой юу? Энэ асуултаар тухайн төгсөгчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь сургалтын явцад заагдсан ур чадвар мэдлэгийн хэрэгцээ байгаа эсэхийг тодорхойлно. Асуултын хариулт нь “тийм” эсвэл “үгүй” байна.

   - Тухайн гэр бүлийн сургалтын дараах буюу одоогийн сарын орлого- үүнд төгсөгчийн гэр бүлийн тухайн сарын нийт орлого хамаарна.

   - Эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд нь юу вэ? Уг асуулт нь ажил эсвэл үйлдвэрлэлтэй холбогдох асуудал, бэрхшээлүүдийг тодруулахад чиглэгдсэн байна. Ярилцлага авагч нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төсөл, арга зүй нь уг асуудалд ямар хамааралтай байгааг тодруулахыг хичээнэ.

   - Сургалтын үр дүнд бий болсон нааштай өөрчлөлтүүд – ярилцлага авагч нь төгсөгч, түүний гэр бүлд сургалтад хамрагдснаар орлогын эх үсвэр бий болохоос гадна нийгэм гэр бүлийн хүрээнд шинээр бий болсон эерэг нөхцөл байдлуудын талаар тодруулахыг хичээнэ.

Ярилцлагыг дүгнэх. Асуултуудыг асууж дууссаны дараа судлаач нь ярилцлагад оролцсон хүмүүсээр гарын үсэг зуруулсны дараа гарын үсгийг зурж баталгаажуулна.

Судлаач нь ярилцлага дууссаны дараа оролцогсдод талархал илэрхийлэх бөгөөд аливаа амлалт эсвэл тайлбар хийхгүй болно.

4. Төгсөгчдийн үйл ажиллгааны судалгааг нэгтгэх

Судалгааны дүнг тус судалгаа явуулсан судлаач дүгнэнэ. Үүний тулд:

Төгсөгчдийн үйл ажиллгааны судалгааг нэгтгэх загварыг (Хавсралт 6.5) ашиглана.

Дүн шинжилгээ хийх шаардлага. Судалгааны асуултуудыг дүн шинжилгээ хийх зорилгоор нэгтгэнэ. Дүн шинжилгээ нь ХЭЗЧДС-ын төслийн бодлого, чиглэл, шаардлагатай өөрчлөлтүүдтэй холбогдох шийдвэр гаргах явцад хэрэглэгдэх болно.

Сургалтуудыг багцалж нэгтгэх. Асуулгуудыг сургалтуудаар нь багцалж гаргавал илүү дүр дүнтэй байна. Ингэх нь ХЭЗЧДС-ын төслийн зүгээс захиргааны, техник үйл ажиллагааг хийхэд хялбар болно.

Хүснэгтлэх. Мэдээ, мэдээллийг холбогдох хүснэгтэд оруулна. Загварын хүснэгтүүд дэх оруулсан мэдээллийг нэгтгэж дүгнэсэн байх шаардлагатай.

Ерөнхий дүн. Загвар нь ерөнхий дүн эсвэл дундаж үнэлгээ гаргах зориулалт бүхий хүснэгттэй бөгөөд дэлгэрэнгүй тайланд орох ач холбогдол бүхий тоонуудыг тэдгээр хүснэгтэд оруулсан байна.

Дэлгэрэнгүй тайлан. Төслийн шаардлагаас хамааран донор, түнш, ХЭЗЧДС-ын төсөл нь тайланг загварын загвараас гадна тайланг дэлгэрэнгүй хэлбэрээр гаргах хүсэлт тавьж болно.

Дээр дурьдсан судалгаа нь зөвхөн төгсөгчдийн байгаа дүр зургийг гаргах зориулттай биш. Энэ тэдний цаашдын үйл ажиллагааг тогтвортой болгох баталгаа биш юм. Хөтөлбөрийн нөлөө нь удаан хугацааны явцад илрэх бөгөөд төгсөгчид нь өөрсдийн үйл ажиллагааг амжилттай үргэлжүүлэхийн тулд тухайн орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагаатай уялдаатай ажиллах хэрэгтэй.

Хавсралт 6.5. Төгсөгчдийн үйл ажиллагааны судалгааны загвар (үлгэрчилсэн загвар)

1. Сургалтын дараах мэдээлэл (судалгааны судлагдахуун)

Овог нэр .....

Хаяг.....

Хамрагдсан сургалт .....**Сургалт дууссан хугацаа**.....

Сургалт болсон газар ..... **Гэр бүлийн байдал**.....

Хүйс ..... **Нас** ..... **Хөгжлийн бэрхшээлтэй эсэх**.....

Боловсролындээдтүвшин......

Сургалтынөмнөхгэрбүлийнсарындундажорлого.....

Хөдөлмөр эрхлэлт/төгсөгчийн сургалтад хамрагдахаас өмнөх орлогын эх үүсвэр.....

1. **Төгсөгч нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа юу?** ☐ тийм ☐ үгүй
2. **Хэрэв хариулт нь "үгүй" байвал, шалтгаан нь юу вэ?.....**
3. **Хэрэв хариулт нь "тийм" бол, эдийн засгийн ямар үйл ажиллагаа явуулж байгаа вэ?**

   ☐ Цалинтай хөдөлмөр эрхлэлт /ажил олгогчтой
   Ямар төрлийн ажил эрхэлж байгаа вэ?
   - Орон тооны
   - Цагийн
   - Багцалсан
   - Бусад

   ☐ Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа (дангаар үйлдвэрлэл эрхэлж байгаа эсвэл гэр бүлээрээ)

   - үйл ажиллагааны чиглэл
   - Гэр бүлийн хичнээн гишүүн энэ үйл ажиллагаанд оролцдог вэ?

   ☐ Хамтарсан үйлдвэрлэл

   - Хамтарч байгаа түншүүд сургалтад нэг ангид байсан уу? тийм үгүй
   - Хамтарсан үйлдвэрлэл нь хэдэн гишүүнтэй вэ?

4. **Одоо эрхэлж буй үйл ажиллагаанд сургалтын явцад олсон ур чадвар мэдлэг хэрэглэгддэг үү?** ☐ тийм ☐ үгүй
5. **Одоогийн гэр бүлийн сарын дундаж орлого**
6. **Төгсөгчдөд тулгарч буй бэрхшээлүүд юу вэ?**
7. **Сургалтын үр дүнд ямар нааштай өөрчлөлтүүд гарсан бэ?**

Төгсөгч эсвэл гол мэдээлэгчийн нэр, гарын үсэг .....

Ярилцлага авсан судлаачын нэр, гарын үсэг, огноо .....

Хавсаралт 6.6. Үр дүнд хяналт шинжилгээ хийх судалгааны тайлангийн загвар (ХЭЗЧД, Филиппин

№	Сургалтын нэр	Хаяг	Сургалтад оролцогчдын тоо	Хүйс		Хөгжлийн бэрхшээлтэй	Залуу хүмүүс	Гэр бүлийн сарын дундаж орлого/сургалтын өмнө	Боловсролын дээд түвшин						Гэр бүлийн гишүүдийн тоо	Үйл ажиллагаа			Сургалтын дараах гэр бүлийн сарын нэмэлт орлого	Сургалтад хамарсан чиглэлээр эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэх	
				Эрэгтэй	Эмэгтэй											Цалингийн хөдөлмөр эрхлэлт	Хувиараа хөдөлмөр эрхлэлт	Хамтарсан үйлдвэрлэл		Тийм	үгүй
1	Bakeshop Operation	Pagagawan, Maguindanao	**12**	3	9	0	6	2'291.66	1	4	0	1	0	6	**29**	0 0 *0 0*	0 0 *0 0*	3 9 *2 0*	1'000.00	✔	
2	Bakeshop Operation	Dulangan, Nituan, Parang, Mag.	**16**	9	7	0	3	1'300.00	4	1	8	2	1	0	**80**	0 1 *1 0*	1 1 *0 0*	0 0 *0 0*	5'500.00	✔	
3	Food Processing	Pagalungan, Maguindanao	**19**	0	19	0	11	3'852.63	5	2	2	2	4	4	**61**	0 1 *1 0*	0 2 *0 0*	0 0 *0 0*	1'500.00	✔	
4	Furniture & Cabinet Making	Layog, Pagalungan, Mag.	**14**	14	0	0	11	2'375.00	0	0	4	6	2	2	**33**	1 0 *1*	13 0 *0 0*	0 0 *0 0*		✔	
5	Draperies/Garments	Brgy. Gang, Sultan Kudarat	**7**	0	7	0	0	2'400.00	3	1	1	1	1	0	**44**	0 0 *0 0*	0 *7 0 0*	0 0 *0 0*	2'914.00	✔	
6	Mat Weaving	Damabalas, Datu Piang, Mag.	**20**	0	20	0	3	3'104.15	4	13	4	0	0	0	**74**		20 *3*		3'660.00	✔	
7	Pottery	Dasawao, Datu Piang, Mag.	**17**	3	14	0	10	2'647.06	14	0	1	2	0	0	**72**		3 1 *3*	2 11 *7*	3'682.35	✔	
8	Furniture Making	Datu Pinguiaman, D.O.S.,	**15**	15	0	0	6	2'266.67	1	3	1	7	0	2	**46**	*7* 0 *1 0*	8 0 *3 0*	0 0 *0 0*	386.67	✔	
9	Bakeshop Operation	Datu Paglas, Maguindanao	**13**	3	10	0	8	3'242.60	0	1	0	1	0	4	**40**	3 3 *5 0*	0 0 *0 0*	0 6 *3 0*	1'025.61	✔	
10	Dressmaking	Matanog, Maguindanao	**20**	1	19	0	11	1'876.58	0	3	0	5	0	4	**94**	0 0 *0 0*	0 0 *0 0*	1 19 *11 0*	400.00	✔	
11	Sala Set Making	Nalil, Bongao, Tawi-Tawi	**5**	3	2	0	2	2'700.00	0	0	1	1	1	2	**28**	1 0 *0 0*	2 2 *0 0*	0 0 *0 0*	6'900.00		✔
12	Pumpboat Making	Sibakloon, Tandubas	**10**	10	0	0	6	390.00	3	0	4	1	1	1	**71**	0 0 *0 0*	10 0 *0 0*	0 0 *0 0*	670.00	✔	
13	Bakeshop Operation	Lamion, Bongao, Tawi-Tawi	**10**	10	0	0	9	1'640.00	0	0	0	5	2	3	**53**	0 0 *0 0*	0 0 *0 0*	10 0 *0 0*	510.00	✔	
14	Tempel Construction	Kasanyangan, Bongao	**6**	6	0	0	2	3'166.00	2	0	4	0	0	0	**17**	0 0 *0 0*	0 0 *0 0*	6 0 *2 0*	2'666.67	✔	
15	Furniture & Cabinet Making	Balabagan, Lanao Sur	**13**	13	0	0	6	2'692.31	0	1	8	2	1	1	**83**	12 0 *6 0*	1 0 *0 0*	0 0 *0 0*	538.46	✔	
16	Bakeshop Operation	Camilol, Malabang, L.S.	**6**	6	0	0	4	1'350.00	1	0	3	0	0	2	**24**	0 0 *0 0*	0 0 *0 0*	4 2 *4 0*	1'250.00	✔	
17	Dressmaking	Daguan, Kapatagan, L.S.	**13**	1	12	0	6	2'808.00	3	0	4	0	6	0	**69**	1 9 *0 0*	0 3 *0 0*	0 0 *0 0*	496.00		
18	Bakeshop Operation	Bangon, Marawi City	**6**	0	6	0	0	1'666.67	15	0	0	0	5	0	**43**	0 0 *0 0*	0 0 *0 0*	0 6 *0 0*	417.00	✔	
19	Enterprise Management	Cotabato City	**34**	16	18	0	5	1'500.00	4	0	8	12	5	5	**61**	8 10 *0*	0 0 *3 4*	3 13 *2*	1'000.00	✔	
20	Dressmaking	Brgy. Digal, Buluan	**16**	0	16	0	10	1'300.00	0	0	8	4	4	0	**53**	0 0 *0*	0 0	0 16 *10*	2'000.00	✔	
21	Fish Processing	Bago Aplaya, Davao City	**15**	2	13	0	6	3'000.00	0	0	6	3	2	4	**30**	0 0 *0*	0 0	2 13 *6*	2'500.00	✔	
22	Fish Processing	Dumoy, Davao City	**15**	2	13	0	4	3'000.00	0	0	2	8	4	1	**27**	0 0 *0*	0 0	2 13 *4*	2'100.00	✔	
23	Slippers Making	Brgy. 76-A, Bucana, Dvo. City	**30**	5	25	0	18	2'000.00	0	0	15	3	8	4	**39**	0 0 *0*	0 0	5 25 *18*	2'700.00	✔	

24	Bolo Making	Brgy. Digal Buluan	**20**	2	18	0	15	3'000.00	2	5	8	3	0	2	**43**	0	0	*0*	*0*	0	0			2	18	*15*		1'400.00	✔	
25	Bakeshop	Daguan, Kapatagan, L.S.	**20**	2	18	0	12	1'500.00	0	0	6	6	2	6	**33**	0	0	*0*		0	0			2	18	*12*		1'000.00	✔	
26	Bag Making	Sultan Kudarat	**10**	0	10	0	2	1'000.00								0	0	*0*		0	0			0	10	*2*		1'600.00	✔	
	TOTALS		**382**	126	256	0	176	**2'233.44**	48	34	98	75	49	53	**1247**	33	24	***15***	***0***	38	36	***12***	***4***	42	179	***98***	***0***	**1'839.11**		

Суурь мэдээлэл:

Дүн шинжилгээ:

Тухайн өрхийн сарын дундаж орлого нэмэгдсэн байдал :

Сургалтад хамрагчид суралцаж байхдаа эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоогүй байгаагийн шалтгаан:

1. Үйл ажиллагаа эхлэх капитал байхгүйн улмаас
2. Зах зээлд тухайн бүтээгдэхүүнийг гаргаж борлуулах боломж байхгүйгээс
3. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлогдохыг хүлээж байгаа бөгөөд дараагийн шатны үйл ажиллагаанд орно.
4. Үйлдвэрлэлийн менежментийн албан ёсоор явуулахад бэлэн бус байгаа
5. Үйл ажиллагаа явуулдаг орон нутагт амгалан тайван байдал алдагдсан

Хавсарлт 6.7. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа, жижиг үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлж буй төгсөгчийн нөхцөл байдлын судалгааны аргачлал

I. Үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл

1. **Үйлдвэрлэлийн нэр** .....
   Үйл ажиллагаа эхэлсэн огноо .....
2. **Үйлдвэрлэлийн байршил** .....
3. **Үйлдвэрлэлийн төрөл**
   ☐ Төгсөгч ганцаараа эрхэлдэг ☐ Хамтарч эрхэлдэг
4. **Сургалтад хамрагдсан үйлдвэрлэлийг хамтран эрхлэгчдийн тоо болон нэр**
5. **Эхний капиталын хэмжээ** .....
6. **Одоо байгаа үндсэн хөрөнгө (Хавсралтаар жагсаалтыг гаргана уу?)** .....
7. **Үйлдвэрлэлийг эхлэх капиталын эх үүсвэрийг хаанаас гаргасан бэ?**
   7.1. ХЭЗЧДС-ын (багаж, тоног төхөөрөмж болон бусад) .....
   7.2. Бусад донор:

- Донорын нэр .....
- Нөхцөл .....
- Учирч буй бэрхшээл .....
  7.3. Зээлийн хэмжээ .....
  - зээл олгогчийн нэр .....
  - үндсэн нөхцөл
    ☐ барьцаа (барьцааны хөрөнгө) ☐ зээлээр тоног төхөөрөмж авсан
    ☐ төлөх хугацаа ☐ жилийн хүү
- бусад нөхцөл .....
- тулгарч буй бэрхшээл .....

7.4. Бүтээгдэхүүн (хэрэв бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж байгаа бол)

Бүтээгдэхүүний нэр	**бүтээгдэхүүний тоон хэмжээ**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

7.5. Үйлчилгээ /хэрэв үйлчилгээ явуулж байгаа бол

үйлчилгээний нэр	**үйлчлүүлэгчдийн тоо**
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

II. Бизнесийн үйл ажиллагаа

А. үйлдвэрлэл /үйлчилгээний материал:

1. Үйлдвэрлэлийн түүхий эд нь юу вэ?

.....

.....

2. Тэдгээрийг хаанаас худалдаж авдаг вэ? материалын эх үүсвэрийг тодорхой заана уу?

.....

.....

3. Түүхий эдийг авахад ямар бэрхшээл учирдаг вэ?

.....

.....

4. Эдгээр бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Б. Үйлдвэрлэлийн технологи

1. Ямар төрлийн технологи хэрэглэгддэг вэ? ☐ гар аргаар ☐ механик аргаар
Хэрэв механик арга хэрэглэгддэг бол ямар төрлийн багаж механизм хэрэглэдэг вэ? (жагсаалтыг хавсаргана уу?)
Багаж, мехнанизмыг хаанаас авдаг вэ? ☐ дотоодын ☐ гадаадын ☐ үйлдвэрлэсэн

.....

.....

В. Маркетинг

1. Бүтээгдэхүүн/ үйлчилгээний худалдан авагчид хэн бэ?

☐ дотоодын ☐ гадаадын ☐ холимог

2.Ямар орлогын түвшинд тэд хамаарах вэ?

☐ ядуу ☐ дунд ☐ дээд ☐ бусад/тодорхой бичнэ үү/

1. Бүтээгдэхүүнийг экспортлдог уу? Ямар улсад?
2. Бүтээгдэхүүнийг хэрхэн сурталчилдаг вэ?

радио сонин зурагт өөрийн худалдагчаар ам дамжин бусад

3. Бүтээгдэхүүн нь ямар баглаа боодолтой вэ?

☐ хайрцаг ☐ цаас ☐ уут

Эсвэл баглаагүй юу ? ☐ тийм ☐ үгүй

4. Бүтээгдэхүүн нь ямар худалдааны тэмдэгийг хэрэглэдэг вэ? (хэрэв байгаа бол)
5. Бүтээгдэхүүнийг хаана худалдах /эсвэл сураталчилдаг вэ? Тодорхой байршлыг заана уу?
(Бүтээгдэхүүнийг борлуулдаг газрыг хэн эзэмшдэг вэ? Мөн бүтээгдэхүүний борлуулалтыг диаграммаар үзүүлнэ үү?)
6. Үйлдвэрлэлийн өрсөлдөгчид бий юу? Тэдгээр нь хаана байдаг вэ? Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд өрсөлдөгчдийнхөөс юугаараа давуу талтай вэ? Өрсөлдөгчдийнх юугаар давуу талтай вэ? (тодорхой тайлбар хийнэ үү?)

.....

7. Бүтээгдэхүүний үнийг хэрхэн тогтоодог вэ?

.....

.....

Г. Үйлдвэрлэлийн тогтолцоо, холбоос

1. Үйлдвэрлэл нь "үйлдвэрлэлийн систем, зарчим эсвэл үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, орон нутгийн хувьд дэвшилтэд эсвэл хуучирсан чиг хандлагатай гэж тооцогддог уу?

☐ тийм ☐ үгүй ☐ Хэрэв тийм бол дараах асуултад хариулна уу?

Үйлдвэрлэлд шаардлагатай орц, түүхий эдийг хаанаас авдаг вэ?

.....

.....

Үйлдвэрлэл нь бүтээгдэхүүнээ хэнд борлуулдаг вэ?

.....

.....

Үйлдвэрлэл нь капиталынхаа шаардлагыг хаанаас авдаг вэ?

.....

.....

2. Олж авсан ашигтай талууд юу вэ?

.....

.....

3. Тулгарч буй хүндрэлүүд юу вэ?

.....

.....

4. Ямар санал зөвлөмж байна вэ?

.....

.....

Д. Санхүүгийнм менежмент

1. Бүтээгдэхүүний үнийг хэрхэн тогтоодог вэ? (Бүтээгдэхүүний үнийг тооцдог аргачлалыг томъёолно уу?)

.....

2. Бизнесийн санхүүгийн асуудлыг хэн хариуцдаг вэ?(Хариуцдаг хүнтэй нь ярилцлага хийх)

.....

3. Санхүүгийн бүртгэл хөтөлдөг үү?(хэрхэн бүртгэдэг, энгийн жишээ)

.....

4. Мөнгийг банканд хадгалуулдаг уу? ☐ тийм ☐ үгүй хэрэв тийм бол ямар банкинд хадгалдаг вэ?

5. Санхүүгийн төлөвлгөө, төсөв, орлого, зарлагын төлөвлөлтийг хэрхэн хийдэг вэ?

.....

.....

6. Үндсэн капиталаас гадна нэмэлт хөрөнөг оруулалт хийсэн байна уу? .....

Хэр зэрэг нэмэлт хөрөнөг оруулалт хийсэн бэ? .....

Мөнгийн хаанаас авсан бэ? .....

Нэмэлт хөрөнгө оруулалтыг чухам юунд хийсэн бэ? .....

Е. Асуудал, бэрхшээлүүд

Ямар төрлийн асуудал, бэрхшээлүүд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгарч байсан бэ?

1. ур чадварын .....
2. капитал .....
3. хадгаламж .....
4. маркетинг .....
5. үйдвэрлэл .....
6. санхүүгийн менежмент .....
7. бизнес мненежмент .....
8. бусад /төрийн дэмжлэг гэх мэт .....

(Тулгарсан бэрхшээлүүдийг шаардлагатай бол хавсралтаар үзүүлнэ үү?)

Ё. Хүсэл эрмэлзэл, зорилго

1. Тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулахад төгсөгчийг ямар хүсэл эрмэлзэл, зорилго уриалан дуудаж байна вэ?

.....

2. Үйлдвэрлэлийн тодорхой ямар асуудлаар сэтгэл хангалуун байдаг вэ? .....
3. Тэдгээр нь өөрсдийн хүүхдүдийг ижил үйлдвэрлэлийн төсөл эсвэл энэ үйлдвэрлэлийг үргэлжүүлэхийг хүсэж байна уу? Хэрэв үгүй бол, яагаад? Хэрэв тийм бол, яагаад?
4. Хэрэв өөр боломж олдвол тэд энэ үйлдвэрлэлийг дахин сонгох уу?

   Хэрэв үгүй бол, яагаад? .....

   Хэрэв тийм бол, яагаад? .....

Ж. Ирээдүйн төлөвлөгөө, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ирээдүйн төлөвлөгөө юу вэ?

(Санамж: асуудал, бэрхшээлээс харж чиглэл авна уу?)

.....

.....

.....

.....

III. Илрүүлсэн зүйл, цаашдын үйл ажиллагааны талаарх зөвлөмж (зөвлөмж нь ХЭЗЧДС-ын арга зүйн хүрээнд сургалтын дараах дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаатай уялдуулсан байна.)

.....

.....

.....

.....

... .

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Төгсөгч эсвэл гол мэдээлэгчийн нэр, гарын үсэг .....

Ярилцлага авсан судлаачын нэр, гарын үсэг, огноо .....

Хавсралт 6.8. Орон нутагт хамтран эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй бүлгийн үйл ажиллагаанд (цаашид "нэгдэл" гэх) дүн шинжилгээ хийх (Филиппин улсад хэрэгжсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн загварын үлгэрчилсэн загвар)

1. Ярилцлага/дүн шинжилгээ хийгчид

- Дүн шинжилгээ хэн хийх вэ? нэгдлийн үйл ажиллагаанд дүн шинжилгээнд хэрэгтэй мэдээллийг ярилцлагын хэлбэрээр цуглуулах бөгөөд үүнийг орон нутгаас сонгогдсон хараат бус зөвлөх ийнэ.
- Ярилцлага авах зөвлөхүүдийг холбогдох сургалтад хамруулах бөгөөд тэдгээрт ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн арга зүйн үйл ажиллагааны талаар төслийн ажиллагчид дэлгэрэнгүй тайлбарлан таниулсан байна. Ингэснээр ярилцлага хийх зөвлөхүүд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилго зорилтын талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болсон бөгөөд энэ нь хөтөлбөрийн зарчим арга зүйд нийцсэн тайлан бэлтгэхэд үндэс суурь болно.

2. Дүн шинжилгээг хийх нэгдлийг сонгох

- Байнгын үйл ажиллагаа явуулж байгаа нэгдлийг сонгоно. Энэ нэгдэл нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн чадавхийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хөрөнгө санхүүгийн зохицуулалт хийх холбогдох сургалтад хамрагдсан байх бөгөөд үйл ажиллагаа эхлэх капиталтай байхын зэрэгцээ дор хаяж нэг жилийн туршид хамтарсан санхүүгийн нөхцөлтэйгөөр үйл ажиллагаа явуулсан байх хэрэгтэй.
- Зуучлагчийг сонгон авах. Хэрэв тухайн үйлдвэрлэлийн төсөлтэй шууд холбоо тогтоох боломж бүхий хүнээр зуучлуулж, тэднийг ярилцлагад урина. Зуучлах боломж бүхий хүмүүсийн мэдээллийг орон нутгийн ХЭЗЧДС-ын төслийн багаас авч болох бөгөөд үүнд:
    - орон нутгийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийн зохицуулагч
    - хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл.
- Зорилтод бүлгүүд. Дээр дурьдсан зуучлагчид нь тухайн нэгдлийн гүйцэтгэх зөвлөл эсвэл гүйцэтгэх захиралтай уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Нэгэнт дээр дурьдсан албан тушаалтнуудтай уулзсан байхад бусад хүмүүстэй уулзалт зохиоход хялбар байх болно.

3. Ярилцлага хийх

- Ярилцлагын хэрэгсэл: Дээрх төрлийн ярилцлага хийх зааварчилсан удирдамжийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрөөс боловсруулсан байх бөгөөд үүнийг **орон нутагт хамтран эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй бүлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх аргачлал** гэнэ. Уг хэрэгсэл нь дараах хоёр төрлийн ярилцлагын аргачлалаас бүрдэнэ. Үүнд:
    - хамтарсан санг хариуцсан ажилтантай хийх ярилцлагын арга- энэ арга нь тухайн нэгдлийн хамтын сангийн бүдүүвчийг судлахад хэрэглэгдэнэ.
    - Нэгдлийн гишүүдтэй ярилцлага хийх арга- тухайн сонгогдсон үйл ажиллагааны гишүүдээс холбогдох мэдээллийг авахад зориулагдана.
- Ярилцлагын стратеги: Ярилцлагыг өөр өөр бүлгүүдэд зориулсан асуултуудын үндсэн дээр явуулна. Үүнд:
    - хамтарсан санг хариуцсан ажилтан, тухайлбал гүйцэтгэх зөвлөлийн дарга, сангийн зохицуулагч эсвэл түүнтэй адилтгах санхүүгийн асуудал хариуцсан гол оролцогч
    - үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хариуцсан, тодруулбал тухайн сангийн санхүүжилтээр явуулдаг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хариуцсан зохицуулагч
    - Иймд холбогдох хүмүүстэй хийх уулзалтыг зөв, бүлэглэж зохион байгуулж, тухай бүрд зөв асуулт тавьж мэдээлэл цуглуулах нь ярилцлага хийх ажлыг хялбар болгоно.
- Ярилцлагыг эхлэх: Ярилцлага авах хүмүүс нь өөрсдийгөө танилцуулна. Үүний дараа ярилцлагад оролцогчдод ХЭЗЧДС-ын төсөл, арга зүйн талаар товч танилцуулга хийж судалгааны зорилгыг тайлбарлана. Ярилцлагыг хийх үйл ажиллагаа нь албан бус, нөхөрсөг нөхцөлд хийгдэх бөгөөд энэ нь үнэн бодит мэдээллийг авахад хэрэгтэй.

I. Нэгдлийн ажиллагчдаас ярилцлага авах

1. Ерөнхий мэдээлэл

Ярилцлагын энэ хэсгийг гүйцэтгэх зөвлөлийн дарга эсвэл сангийн менежертэй хийх бөгөөд дараах асуудлуудад анхаарал хандуулсан байна:

Тухайн нэгдлийн үйл ажиллагааны байршил, тодорхой хаягт хамааралтай асуултуудыг асуух бөгөөд хаяг нь гудамж, хороо, хороолол, дүүрэг гэх мэт маш тодорхой байх

1.2. Тухайн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа гишүүд болон нийт гишүүдийн тоо

1.3. Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн огноо

1.4. Бүртгэлийн ажиллагааг үйлдсэн байгууллагын нэр, хаяг

1.5. Үйл ажиллагааг эхлэхэд нийлүүлсэн хөрөнгө

1.6. Үйл ажиллагааг эхлэхэд шаардлагатай байсан хөрөнгө

1.7. Үйл ажиллагааг эхлэхэд дэмжлэг үзүүлсэн донорын эх үүсвэр болон нэр, хаяг

1.8. Дэмжлэгийн төрөл, нөхцөл. Эдгээрийг: буцалтгүй тусламж, хүүгүй зээл, хадгаламж эсвэл зээл гэж ангилна:

- буцалтгүй тусламж –донорын зүгээс аливаа нэг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр хандивласан мөнгө
- хүүгүй зээл – донор нь тодорхой хэмжээний санхүүжилтийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тодорхой хугацаанд хэрэглүүлэхээр олгосон хөрөнгө
- хадгаламж –гишүүд, оролцогч байгууллагуудын мөнгөн хадгаламж
- зээл- донороос олгогдсон тодорхой хугацааны дараа хүүтэйгээр эргэн төлөгдөх хөрөнгө

1.9. Донорын зүгээс тавьсан шаардлага нөхцлүүдийг дэлгэрэнгүй дурьдсан байна.

1.10. Нэгдлийн хөрөнгийг байршуулсан банк эсвэл өөр төрлийн санхүүгийн байгууллагын нэр хаяг

1.11. Нэгдлийн үндсэн хөрөнгө. Үүнд: (үл хөдлөх, бусад өмч)

2. Хамтарсан сангийн үйл ажиллагаа

Ярилцлагын энэ хэсгийг хамтарсан сангийн зохицуулагч, ерөнхий нягтлан эсвэл нягтлан бодогч нартай хийнэ. Үүнд:

1.1. Сангийн нэр дээр банкинд хийсэн мөнгөн хадгаламжийн нийт дүн

1.2. Бэлэн мөнгөний хэрэгцээ, дундаж гүйлгээ

1.3. Нийт хөрөнгөөс үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, санхүүжилт хийхээр зориулагдсан санхүүгийн хэмжээ

1.4. Сангийн хөрөнгөөс гишүүддээ олгосон зээл, одоо олгоод байгаа зээлийн хэмжээ

1.5. Нэгдлийн нийт мөнгөн, бусад хөрөнгийн хэмжээ

1.6. Хөгжлийн санхүүжилт, бичил зээлд хамрагдсан гишүүд ямар төрлийн үйл ажиллагаанд энэ зээлийг авсан зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авна. Зээл авагчдыг: -хувь хүн, бүлэг, нэгдлийн, бусад гэж ангилна.

- хувь хүн- тухайн төслийг хэрэгжүүлэгч нэг хүн эсвэл гэр бүлийн гишүүдтэйгээ хамтарсан үйл ажиллагаа явуулдаг
- бүлэг- хоёр буюу түүнээс дээш нэгдлийн гишүүд хамтран үйл ажиллагаа явуулж байгаа
- нэгдлийн – нэгдлийн зүгээс орлого олох, гишүүдэд үр шимийг нь хүртээхийн төлөө хийж буй үйл ажиллагаа
- бусад- нэгдлийн оролцоотойгоор хэрэгжиж буй бусад олон нийтэд хамааралтай төсөл, нэгдэл шууд зохицуулж, зохион байгуулж байгаа ашгийн бус, гишүүдэд үр шим нь хүртэгдэх үйл ажиллагаа

2. Тулгарч буй асуудлууд болон бэрхшээлүүд

Ярилцлагын энэ хэсэгт хамтарсан сангийн менежер, сангийн үйл ажиллагаанд тодорхой хяналт тавьдаг ажилтнууд, аудитын гишүүдийг оролцуулна.3.1 Үйл ажиллагааны тогтолцоо, шат дамжлага, гишүүнчлэл, ажиллагчид, олон нийт, бусад хамтарсан сангийн үйл ажиллагаанд хамрагдах хүмүүстэй холбогдох асуултуудыг зонхилон тавина. Үйл ажиллагааны тогтолцоо, шат дамжлага гэдэгт: зээл олгох, зээлийн эргэн төлөлт, бүртгэл болон сангийн менежмент зэргийг хамааруулна. Үүнд:

- зээл олгох- энэ нь зээл олгохтой холбогдох зээлийн хүсэлт гаргах, зээл олгох боломжийн судалгаа, зээлийг зөвшөөрөх, олгох шат дамжлагыг хэлнэ
- зээлийн эргэн төлөлт- зээлийн үйл ажиллагаатай холбогдох аудит, эргэн төлөлт болон зээлээс олсон ашгийг хуваах зэрэг үйл ажиллагаа нь үүнд хамаарна.
- бүртгэл – олгогдсон зээл, туслалцаа, төлөлт, эргэн төлөлт болон хандив зэрэг нь үүнд хамаарна.
- сангийн менежмент- хөрөнгийг зарцуулах тэргүүлэх чиглэлийг тогтоох, хөрөнгө гаргах санхүүгийн үйл ажиллагаа, бусад холбогдох үйл ажиллагаа үүнд хамрагдана.

3.2 Авсан арга хэмжээ, зөвлөмж. Тухайн тулгарсан саад бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд авсан арга хэмжээ, цаашдын үйл ажиллагаатай холбогдох санал зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал

II. Гишүүдтэй ярилцлага хийх

Ярилцлагын энэ хэсгийг сангаас санхүүжилт, дэмжлэг авсан гишүүдтэй хийнэ. Ярилцлага хийх хүмүүсийг сангийн бүртгэлээс сонгож авах бөгөөд мэдээллийн үнэн бодит байдлыг хадгалахын тулд дээр дурдагдсан хүмүүсийн 20-оос доошгүй хувьтай нь ярилцлага хийнэ.

1. Нэгдлийн нэр хаягийг хүн бүртэй хийсэн ярилцлагын тэмдэглэлд тодорхой заасан байна.
2. Хувийн мэдээлэл. Энэ мэдээллийг нэгдлийн бүртгэлээс авсан байх бөгөөд ярилцлагад хамрагсдаас лавлаж тодруулсан байна. Ингэх нь ярилцлагын илүү нөхөрсөг албан бус байдалд хийх боломжийг бүрдүүлнэ.

3. Хамтарсан сангаас авсан туслалцаа. Энэ мэдээллийг ярилцлага болохоос өмнө урьдчилсан байдлаар сангийн зохицуулагчаас авсан байх бөгөөд ярилцлагын явцад шаардлага зүйлүүд, тухайлбал мөнгө дүн, тоон үзүүлэлт зэргийг тодруулж асуух хэрэгтэй.
4. Сангаас авсан хөгжлийн санхүүгийн туслалцаа. Энэ мэдээлэл нь тодорхой эдийн засгийн үйл ажиллагаа, орлого олох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сангаас авсан хөрөнгөтэй холбогдолтой асуудалд хамаарна.
5. Үйл ажиллагааны нэр, төрөл, тодорхойлолт. Энэ мэдээлэл нь сангаас авсан тухайн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар байна. Үйл ажиллагаа нь: хувийн (өөрөө эсвэл гэр бүлээрээ), бүлгээр (хэд хэдэн гишүүд хамтарсан). Түүнчлэн тухайн үйл ажиллагаа нь ямар хугацаанд идэвхтэй үргэлжилж байгаа талаар мэдээлэл авна.
6. Санхүүгийн туслалцааны хэмжээ. Үүнд зөвхөн хамтарсан сангаас авсан хөрөнгийн хэмжээ орох бөгөөд бусад санхүүгийн эх үүсвэрүүдийн талаарх мэдээллийн авах шаардлагагүй . Түүнчлэн хамтарсан сангаас авсан санхүүжилтийг бүрэн төлсөн эсвэл эргэн төлөлт хийгдэж (хүү төлөгдсөн, үндсэн зээл төлөгдсөн, хүүгийн үлдэгдэл байгаа гэх мэт) байгаа талаар.
7. Бичил зээлийн туслалцаа. Үүнд ахуйн, гэр бүлийн хэрэгцээнд зориулахаар авсан зээлийн талаарх мэдээллийг тусгана. Энэхүү мэдээллийг мөн ангилж хуваасан байна. Түүнчлэн зээлийг бүрэн төлсөн эсвэл эргэн төлөлт хийгдэж (хүү төлөгдсөн, үндсэн зээл төлөгдсөн, хүүгийн үлдэгдэл байгаа гэх мэт) байгаа талаар.
8. Нэгдлийн үр шим. Судалгааны энэ хэсэг нь тухайн нэгдлийн үйл ажиллагаанаас гишүүний хувьд өөртөө, гэр бүлдээ хэрэгцээтэй үр шимийг хүртсэн талаарх мэдээллийг цуглуулах зорилго агуулна. Иймд дээрх асуудлыг бүрэн тодруулахын тулд асуултуудыг хэсэгчилэн төрөлжүүлсэн байна. Үүнд:
   - орон байрны нөхцөл сайжирсан
   - ахуйн хэрэгцээ сайжирсан
   - хүнсний хангамж нэмэгдсэн
   - хувийн хэрэгцээ сайжирсан
   - хүүхдүүдийн сурч боловсрох нөхцөл сайжирсан
   - эрүүл мэндээ хамгаалах нөхцөл сайжирсан
   - чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдсэн
   - нэгдлийн гишүүн байснаар орлого олох, хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдсэн
9. Тулгарч буй бэрхшээлүүд, зөвлөмж. Ярилцага хийгч нь оролцогчдоос тулгарч буй асуудал, бэрхшээлүүдийн талаар дэлгэрэнгүй лавлаж мэдээлэл авах бөгөөд оролцогчдын зүгээс дээр дурьдсан бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмжийг тэмдэглэж авна. Эдгээр санал зөвлөмжийг ХЭЗЧДС-ын төслийн зүгээс судалж, боломжтой бол цаашдын үйл ажиллагаанд холбогдох шийдвэрүүдийг бодлогын төлөвлөлтийн хэрэгжилтийн түвшинд хэрэгжүүлэхэд анхаарал тавьж, шаардлагатай зохицуулалтыг хийнэ. Түүнчлэн тухайн нэгдэл нь өөрийн оршдог орон нутгийн хөгжилд хэрхэн оролцох талаар төлөлвлөж байгаа чиг хандлагын талаарх мэдээллийг ярилцлагын явцад авсан байна.

III. Ярилцлагыг дуусгах нь

Ярилцлага хийгч нь оролцогчдоос асуух тодруулах зүйл байвал тодруулж, аливаа авах шаардлагатай мэдээллийг орхигдуулаагүй эсэхийг шалгана. Үүний дараа оролцогчдод талархал илэрхийлнэ.

1. Ярилцлагад оролцогчийн нэр, гарын үсэг. Ярилцлагын тэмдэглэлд оролцогчийн гарын үсгийг зуруулж баталгаажуулсан байна.
2. Ярилцлага хийгчийн нэр, гарын үсэг. Ярилцлагын тэмдэглэлд ярилцагчийн гарын үсгийг зуруулж баталгаажуулсан байна.
3. Ярилцлагын огноо . Ярилцлага болсон өдрийн огноог тодорхой бичнэ.

IV.Тайланг бэлтгэх

Ярилцлага хийсэн судлаач нь дэлгэрэнгүй тайланг бэлтгэнэ. Тайлан нь ХЭЗЧДС-ын төсөл болон арга зүй, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго зэрэгт тухайн нэгдлийн үйл ажиллагаа нийцэж байгаа, тэдгээртэй холбогдох үзүүлэлтүүд чиг хандлага зэрэгт дүгнэлт хийсэн, холбогдох санал зөвлөмжийг агуулсан байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

VII

Оршил. I. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлтийн боловсрол, сургалтын явцад тулгарах жендерийн асуудал, бэрхшээлүүд. II.ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд жендерийн асуудалд хандах стратеги.

Жендерийн талаарх мэдлэг, нөлөөлөл

Оршил

ОУХБ-ын ерөнхий зорилго бол эрх чөлөө, эрх тэгш байдал, аюулгүй орчин, хүний нэр хүндийг дээдэлсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх юм. ОУХБ-ын Сайн ажил хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хүний эрхийг хангах үндсэн дөрвөн стратегийн зорилтын нэг нь жендерийн асуудалтай холбоотой бөгөөд хөдөлмөр эрхлэх нөхцлийг хүйсийн хувьд эрх тэгш байлгахад оршино.

Жендерийн тэгш байдал, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш харилцаа нь эрх тэгш байх эрхтэй хамааралтай бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд жендерийн ялгаагүйгээр өөрсдийн хувийн боломжийг бүрэн ашиглаж, хэрэгцээтэй шийдвэрийг аливаа дарамт шахалтгүйгээр хийх боломжоор хангагдах, бүрэн эрхтэйгээр нийгмийн хөгжилд оролцож, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бололцоогоор хангагдсан байхыг хэлнэ. Энэ нь мөн тэдгээрт харилцах, тэдгээрийн аливаа үйлдэлд үнэлэмж өгөх асуудалд ч хамаарна. Жендерийн тэгш байдал нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш бөгөөд эрэгтэйчүүд ч мөн хамааралтай юм. Түүнчлэн энэ нь эмэгтэй болон эрэгтэйчүүд адил гэсэн ойлголт биш бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүний эрх, хариуцлага нь тэдгээрийн эр, эм хүйстэй төрсөн байхаас үл хамаарна гэсэн утгатай.

Эрэгтэй, эмэгтэй хүн хоорондын эрх тэгш байх асуудал нь хүний эрхийн асуудал бөгөөд хүн төвтэй тогтвортой хөгжлийн урьдчилгаа нөхцөл юм. Жендерийн эрх тэгш байдал нь эрхийг өөр өөр байхыг хүлээн зөвшөөрнө.

ОУХБ-ын “Хүний эрхийн хөгжил: Боловсрол, сургалт болон насан туршид хэрэглэгдэх мэдлэг” нь 2004 оны 195 дугаар Зөвлөмжөөр батлагдсан. Энэ Зөвлөмж нь боловсрол болон сургалт нь хүн бүр оролцох боломжтой эрх гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Зөвлөмж нь ялангуяа, эмэгтэйчүүд эрэгтэйчүүд, эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших, сургалтад хамрагдах, амьдралын түршид хэрэгцээтэй байх мэдлэгээ олж авах, нийгмээс гадуурхагдсан иргэд ч мөн боловсрол, сургалт авах боломжоор хангагдсан байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Цаашилбал, 1999 оны Олон улсын хөдөлмөрийн чуулган нь ОУХБ-ын бүх хөтөлбөр, техникийн хамтын ажиллагаанд жендерийн эрх тэгш байдал, эрх тэгш бололцоогоор хангах тухай шийдвэрийг гаргасан байна. 2008 онд ОУХБ-ын удирдлага болох нэгж нь эмэгтэйчүүдийн эрхэлдэг үйлдвэрлэлийг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг дэмжих, эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан бөгөөд энэ жендерийн тэгш байдлыг бэхжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж байгаа юм.

Олон улс орнуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ур чадварын сургалт нь нийгмээс гадуурхагдсан иргэдэд хүртээмжгүй эсвэл зөвхөн суурь боловсрол бүхий тодорхой бүлгийн хэрэгцээ, шаардлагад нийцдэггүй. Харамсалтай нь эмэгтэйчүүд ихэвчлэн эдгээр гадуурхагдсан бүлгийн хүрээнд хамаардаг. Ихэнх тохиолдолд тэдгээр нь хөдөлмөрийн зах зээл дээр доогуур үнэлэгдэхийн зэрэгцээ суурь, мэргэжлийн сургалтын хувьд зөвхөн доод түвшинд л хамрагддаг байна. Түүнчлэн сургалтын байгууллагууд нь эрэгтэй

суралцагчдад хандсан сургалт явуулдаг бөгөөд энэ нь ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдийг гадуурхагдахад хүргэдэг байна.

Хэдийгээр ХЭЗЧДС нь орон нутгийн (хөдөөгийн) доогуур орлого бүхий бүлгүүдэд хүрч ажиллах, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэхэд ерөнхий үйл ажиллагаагаа чиглүүлдэг боловч хөтөлбөрийн үйл ажиллагааны бүхий л алхам, үе шатад зорилтод бүлгүүдийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хамруулж ажиллуулахын тулд хүчин чармайлт тавьсаар ирсэн.

Бүх үйл ажиллагаанд хүйсийн эрх тэгш байдлыг хангах энэ чиглэлийн Жендерийн гол чиг хандлага гэнэ. Энэхүү гол чиг хандлага нь үнэн хэрэгтээ жендерийн эрх тэгш байдлыг хангах үндсэн стратеги юм. Гол нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг нэг бүлэгт нэгтгэхдээ биш тэдгээрийг хэрэгцээнээс нь хамааруулан төрөлжүүлэхэд гол зорилго оршино.

Бүлгийн зорилго

Энэ бүлгийн зорилго нь ХЭЗЧДС-ын хэрэгжүүлэгчдийн жендертэй холбогдох асуултуудад хариулах, жендерийн асуудлыг шийдвэрлэх, эрх тэгш байдлыг бий болгохын тулд жендерийн асуудлын талаар тодорхой мэдлэг олгох юм.

Бүлэг нь ХЭЗЧДС-ын төслийг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан жендерийн асуудалтай холбогдох туршлага, үйл ажиллагаандаа хэрэглэх арга хэрэгсэлийн талаар дурьдах болно. Жендерийн асуудалтай холбогдох гол ухагдахуунууд энэ ботийн Хавсралт 7.1.А-д дэлгэрэнгүй тайлбарлагдсан болно. Хэрэглүүштэй жишээг Бангладешт хэрэгжүүлсэн *Техник сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дээшлүүлэх арга замаар ядуу эмэгтэйчүүдийн ур чадварын сургалт болон хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх* төслийн зүгээс 2005 онд эмхэтгэн бэлтгэсэн гарын авлагаас олж болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1.Бангладешт хэрэгжүүлсэн Техник сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дээшлүүлэх аргаар ядуу эмэгтэйчүүдийн ур чадварын сургалт, хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх төслийн талаар

Төсөл нь техник, бизнесийн сургалтын зэрэгцээ жендерийн асуудалд нааштай чиг хандлага бүхий орчныг бүрдүүлэх чиглэлийг үйл ажиллагаандаа давхар баримтласан байна. Бангладеш улсын хувьд жендерийн асуудлыг хувиараа хөдөлмөр эрхлэх, цалинтай хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан жендерийн асуудалтай холбогдон тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлж, шийдвэрлэх гэдэг нь нийгмийн чиг хандлагын хувьд чухал ач холбогдол бүхий асуудал гэж үздэг байжээ. Жендерийн асуудалд нааштай хандах чиг хандлага нь бодлогын шийдвэр гаргалтын хувьд орон нутаг/гэр бүлийн түвшинд, хэрэгжүүлэгч байгууллагууд, сургалтын байгууллагууд, түнш ТББ болон бусад хувийн хэвшлийн байгууллагуудын түвшинд яригддаг байна.

Иймд, эхний ээлжинд сургалт, хөдөлмөр эрхлэлтэд жендерийн асуудалтай холбогдон тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлон дүн шинжилгээ хийх хандлагыг баримтласан байна. Жишээ нь, жендерийн тэгш байдал, хөгжил гэсэн зарчим нь олон улсын хэмжээнд сургалт хөтөлбөр, төсөлд агуулагддаг. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн жендерийн асуудал, ажилчдын эрхийн талаар хичээл заах бүлэг жендерийн асуудлаар мэргэшсэн сургагчдыг бэлдсэн байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийг тогтсон төрлийн орлого олох үйл ажиллагаанаас гадна, өөр аргаар орлого олох боломжийг нэмэгдүүлэх талаар тодорхой хэмжээнд анхаарал хандуулах хүчин чармайлт гаргасан байна. Төслийн хүрээнд үйлчлүүлэгчдийн цаг зав, боломж зэрэгт нийцсэн жижигхэн урамшуулал бүхий сургалтыг зорилтод бүлэг зохион байгуулсан байна. Дээрх дурьдсан, мэдээлэл, туршлагыг нэгтгэж ном болгон гаргасан. Дээрх зөвлөмжийн ном, гарын авлагуудыг хөтөлбөр хэрэгжих хэл дээр хөрвүүлэх ажил хийгдэж, олон нийтийн хүртээл болгосний зэрэгцээ гарын авлагад дурьдсан туршилтуудыг ч амжилттай хэрэгжүүлсэн тухай баримтууд байна.

Жендерийн асуудалд хариуцлагатай хандах талаар төслийн явцад гарч ирсэн санаачлагууд

Гол анхаарлыг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, шинэ төрлийн, уламжлалт бус үйл ажиллагаа, мэргэжлийн хувьд хэрэглэгдэх техник ур чадвар, бизнесийг хөгжүүлэх арга зам, өөртэй итгэлтэй байх ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Жендерийн асуудлаарх холбогдох сургалтыг эмэгтэй оролцогчдод орсон бөгөөд сургалтын сэдэвт гэр бүл, олон нийт гэсэн сэдвүүдийг ч мөн хамруулсан байна. Үйл ажиллагаа нь багаар нийлж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд зайлшгүй шаардлагатай үнэ хаялцах, тохиролцох чадварыг нэмэгдүүлэх, сургалтын дараах дэмжлэгийн хүрээнд зах зээлтэй холбох, зээл авах зэргийг хамруулсан байна. Сургагчдын “үндсэн баг” —ийг бэлтгэх зорилгоо холбогдох сургалтын байгууллагууд, ТББ-ууд хамтран ажилласан. ТББ-ын зүгээс орон нутгийн хэмжээнд нийгмийн хүсэл эрмэлзлийг нэгтгэх нөлөөллийг нэмэгдүүлэх; сургагч, бусад холбогдох хүмүүс (зааварлагч, бүсийн нийгмийн ажилтнууд хөтөлбөрт хяналт тавих эрх бүхий хүмүүс, ТББ-ын идэвхтэй гишүүд) жендерийн талаарх мэдлэг, ажлын орчинд жендерийн асуудалд таатай нөхцлийг бий болгох талаар зааварчилсан. Хөтөлбөрийн эмэгтэй зааварлагч сургагч нарт зорилтод бүлгийн гишүүдтэй жендерийн холбогдох асуудлаар илүү зоригтой шийдэмгий хандах, хэрэгцээтэй сургалтын материал зөвлөмжөөр хангах асуудалд мөн ихээхэн анхаарал хандуулсан. Түүнчлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа жендер, эмэгтэй суралцагчдын асуудалд хэрэгцээтэй зохицуулалтыг (сургалтын цагийн хуваарь, зохион байгуулах газар, хүүхдүүдийн өдөр өнжүүлэх гэх мэт) урьдчилан төлөвлөсөн.

Сургалтын үед сургалтын байранд хүүхдийн өдөр өнжүүлэхийг байлгах асуудал нь бодлогын түвшинд зохицуулагдаж, онцгой анхаарал хандуулах хэрэгцээг байгаа нь илэрхий байсан бөгөөд цаашдын үйл ажиллагаанд энэ талаар зохицуулалт хийх шаардлагыг оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн сургалтын явцад өмчлөлийн эрх, бараа худалдан авах, эмэгтэйүүдийн зээл авах, бие даан бизнес эрхлэх шийдвэр гаргах, тэдэнд учирч буй саад бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй авч үзсэн болно.

I. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлтийн боловсрол, сургалтын явцад тулгардаг гол жендерийн асуудал, бэрхшээлүүд

Албан ёсны цалинтай хөдөлмөр эрхлэлт ховор байдаг, ихэнх тохиолдолд эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд шаардагдах ур чадвар, мэргэжлийн мэдлэг байдаггүй. Тэдгээрийн хувьд хувиараа хөдөлмөр эрхлэх, бичил үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр хөдөлмөр эрхлэх нь цорын ганц сонголт байдаг. Ядуу эмэгтэйчүүдийн хувьд ихэнх тохиолдолд ар гэрийн ачааллаас болон эдийн засгийн боломжид хүрэх нөхцөл нь хязгаарлагдмал байдаг. Хувиараа хөдөлмөр эрхлэх нь ар гэрийн ажлыг давхар амжуулах боломж олгодог. Харин бичил үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэх нь цалинтай хөдөлмөр эрхлэлтийг бодвол илүү их эрсдэл дагуулдаг, гэхдээ цалинтай хөдөлмөр эрхлэлт удаан хугацаанд үргэлжлэх магадлал нь бага байдаг.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн түншүүд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар онцлогийг ойлгодог байх нь чухал, ингэснээр тэдгээр нь жендерийн асуудал дээр нааштай, ур дүн бүхий бодлого баримтлах боломж, чиг хандлагатай болгоно. Сургалтын явцад жендер дээр суурилсан гадуурхлыг арилгах нь хөдөлмөр эрхлэхийг дэмжих цаашдын үйл ажиллагаанд нилээд чухал үүрэг гүйцэтгэх болно. Эмэгтэйчүүдийн хувьд тодорхой нийгэм, гэр бүлд эзлэх байр суурь нь хөдөлмөр эрхлэлтэд ихээхэн нөлөөлдөг бөгөөд энэ нь улмаар эдийн засгийн боломжинд ч мөн нөлөөлдөг байна. Эмэгтэйчүүдийн хувьд бизнесийн үйл ажиллагаанд оролцоход нь олон саад тотгор учирдаг байна. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг туршилтын журмаар олон улс орнуудад хэрэгжүүлж байсан туршлагаас харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дутахгүй хүсэл эрмэлзэл гаргадаг нь илэрхий байдаг, гэхдээ эмэгтэйчүүд боломж, дэмжлэг олдох нь хомс байдаг байна. ХЭЗЧДС-ын багуудын газар дээр нь очиж байдалтай нь танилцах, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сургалтын дараах үйл ажиллагааны явцад жендерийн холбогдолтой бэрхшээл, саад бүхий асуудлууд, хандлагууд ихээхэн таарч байсан байна. Эдгээрээс заримыг нь доор дурьдсан болно.

Эдийн засгийн бэрхшээлүүд

– Харьцангуй доогуур боловсрол, бичиг үсгийн мэдлэг болон ерөнхий боловсролын доогуур түвшин

– Техник болон мэргэжлийн ур чадварын дутагдал

Уламжлал/ нийгмийн хэм хэмжээний бэрхшээлүүд

- Олон охид, эмэгтэйчүүдэд гэрээсээ гадуур ур чадвар эзэмшиж, үйл ажиллагаа эрхлэнэ гэх зориг, өөртөө итгэлтэй байдал дутагддаг.
- Эмэгтэй бизнес эрхлэгчид нь амжилтанд хүрэхийн тулд сэтгэл санааны дотоод, гадаад хүчин зүйлүүдтэй тэмцэх байнгын хэрэгцээ гардаг.

Ур ашигтай эх үүсвэртэй байх

- Зээл, зах зээл, техник, сургалт, бизнесийг дэмжих үйлчилгээ зэргийн хязгаарлагдмал байдал
- Өмчлөх эрхтэй холбогдолтой тодорхой асуудлууд (газар, тоног төхөөрөмж, багаж)

Хууль эрх зүйн асуудлууд

- Зээл авахад нөхрийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд энэ нь хүндрэл учруулж болох юм. Гэхдээ энэ нь нөхөр нь эхнэрийнхээ зээлийн талаарх боломжийг судлах, ярих эрхийг хязгаарлах шаардлагагүй.
- Эмэгтэйчүүд бизнесийн гэрээ хэлцэл хийхдээ шийдэмгий бус байдаг бөгөөд энэ нь аливаа хууль эрх зүйн асуудалд хойрго хандахын нэг хэлбэр юм.

Нийгмийн, гэр бүлийн бэрхшээлүүд

- нийгэм эмэгтэй хүнийг уламжлалт гэрийн ажлаас нь өөр ажил эрхлэхийг хүлээн зөвшөөрдөггүй.
- эмэгтэйчүүд гэрийн асуудлыг хойш тавихгүй гэрийн ажилд өөрийгөө зориулах ёстой, эмэгтэй хүн бизнес эрхлэх ёсгүй гэсэн хадам, нөхөр, гэр бүлийн гишүүд, хөршүүд, нутгийн иргэдийн шүүмжлэл
- нийгмийн, шашны хүчин зүйлээс хамааран гэрээсээ гарч хөдөлгөөнтэй байхад тавигдах хязгааралалт
- нөхөр, бусад гэрийн эрэгтэй гишүүдийн хуваалцдаггүй гэр орны ажил

Дэд бүтцийн бэрхшээлүүд

- сургалтын орчинд хүүхэд асрах байгууллага байхгүй.
- сургалт болж буй газарт очиход хэт хол
- эмэгтэйчүүд гэрээсээ ажилд явахыг хязгаарласан зан заншлийг үгүйсгэсэн хориглосон эрх зүйн зохицуулалт байхгүй.

Бизнесийн бэрхшээлүүд

- бизнес эрхэлж үйл ажиллагааг нь үргэлжүүлэх шаардлагатай ур чадвар хомс
- эмэгтэйчүүд зах зээл, үйлдвэрлэлийн зах зээлийн талаар мэдлэг багатай байх
- эмэгтэйчүүд ихэвчлэн тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахдаа зөвхөн эмэгтэй хүн гэдгээсээ хамааран тогтсон үнээр худалдаж авах боломжгүй байдаг.
- зах зээлийн харилцаанд ороход эрэгтэй борлуулагчид, худалдан авагчидтай харилцаа тогтооход хүндрэлтэй байдаг бөгөөд бараа бүтээгдэхүүн түүхий эдийг худалдаж авах үйл ажиллагаанд биечлэн оролцож байгын хяналт тавих хэрэгцээ гардаг.

- үйлчлүүлэгчид нь шинэ, ялангуяа эмэгтэй үйлдвэрлэгчээс бараа худалдан авахдаа хойрго байдаг.
- эрэгтэй үйлдвэрлэгч нь эмэгтэй үйлдвэрлэгчтэй түнш байхаас татгалзах хандлагатай байдаг.

Байгууллагын бэрхшээлүүд

- сургалтын байгууллагуудын жендерийн асуудалд мэдрэмжгүй хандах хандлага, ядуу эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалт хомс эсвэл хязгаарлагдмал
- сургалтад хамрагдахад тавигддаг тэгш бус шаардлага

Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд тулгардаг бэрхшээлүүд

- Эмэгтэй хүмүүс нь боловсрол, ажил хөдөлмөр эрхэлж байгаагүйн шалтгаанаар цалингийн хөдөлмөр эрхлэлтийн утга учрыг бүрэн ойлгодоггүй
- цалинтай хөдөлмөр эрхлэлтэд шаардлагатай ур чадвар хомс
- ихэнх ажил олгогчид ялангуяа уламжлалт бус ажил гүйцэтгэх орон тоон дээр эрэгтэй хүнийг ажилд авах сонирхолтой байдаг.
- ажлын байрны аюулгүй нөхцөл байдал хангалтгүй байх
- ажлын байрны ойролцоо хүүхэд асрах газар байдаггүй.

Эрэгтэйчүүд зарим тохиолдолд мөн дээр дурьдсан бэрхшээлүүд тохиолддог (тухайлбал зээл авах боломж). Гэхдээ ихэнх тохиолдолд дээр дурьдсан саад бэрхшээлүүд нь эмэгтэй хүнд илүү учирдаг. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүнд хөгжлийн бэрхшээлгүй эмэгтэй хүн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүнээс илүү саад бэрхшээл учирдаг. Учир нь дээрх бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд давхар давхар учирдаг байна.

→ **Жендерийн асуудал, боловсрол, сургалт, бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлтийн явцад тулгарч болзошгүй жишээнүүдийг талаар хавсралт 7.2-оос харна уу.**

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад давхар анхаарал хандуулах

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд туршилтын журмаар хэрэгжүүлж байсан төслүүдийн туршлагаас үзхээд ХЭЗЧДС-ын арга зүйтэй холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд *жендерийн асуудалд онцгой анхаарах хэрэгцээ* шаардлага байдаг нь илэрхий байсан. Энэ хэсэг нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад улс орнуудын хувьд түгээмэл байдлаар хэрэглэж, стратеги, аргачлалыг танилцуулах болно.

II. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүрээнд жендерийн асуудалд хандах стратеги

2.1.Хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэгч байгууллага болон төлөвлөлтөд жендерийн асуудлын гол чиг хандлага *(Бүлэг II-оос дэлгэрэнгүйг харна уу)*

Хөтөлбөрийн загвар

Жендерийн асуудлыг зөв тусгах нь үнэлэмжийг нэмэгдүүлнэ.

Эрх тэгш байдал, ядууралтай тэмцэх зэрэг асуудлуудад хандаж тодорхой хэмжээний арга хэмжээ, үйл ажиллагааг явуулахад жендерийн зохицуулалтыг зөв хийх нь тухайн үйл ажиллагааны үнэлэмжийг нэмэгдүүлнэ. Жендерийн асуудал нь үр шимийг хүртэгчдэд тодорхой хэмжээнд заавал хамааралтай байдаг бөгөөд үүнийг тэдгээрийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлсэн байх шаардлагатай, учир нь оролцогчид нь тодорхой хэмжээнд өөрсдийн гэсэн үүрэг оролцоотой байдаг. Мэдээж үр шимийг хүртэгчдийн үүрэг оролцоо, хэрэгцээ, сонирхолыг бодит зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн боломжтой харьцуулж үзсэн байх хэрэгтэй.

Эхлэх цэг-жендерийн дүн шинжилгээ

Жендерийн асуудалд хандах хандлагыг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн загварыг бий болгох үед харгалзан үзсэн байх шаардлагатай. Энэ нь ерөнхийдөө дүн шинжилгээний ажил байх бөгөөд ур чадварыг хөгжүүлэх, мэргэжлийн сургалт түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн боломжийг тодорхойлохдоо жендерийн асуудлыг орхигдуулахгүй байх боломжийг бүрдүүлнэ.

Жендерийн дүн шинжилгээ нь ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн үүрэг оролцоо, хэрэгцээ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд бүрэн тусгагдсан байна. Энэ нь холбогдох үе шат бүрт хамаарах мэдээ мэдээллийг хүйсээр зааглаж нарийвчлан авч үзэх, хөтөлбөрийн хүйс болон нийгмийн байдлаас хамааран хэрхэн хуваагддагыг ойлгосон байхыг шаардана. Түүнчлэн хөдөлмөрийг хэрхэн үнэлдэг нь дээрх асуудалтай хамааралтай болно. Жендерийн асуудалд наастай хандахуйц

зохицуулалт бүхий ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг зохион байгуулж хэрэгжүүлэхийн тулд тухайн үйл ажиллагаанд хамрагдах эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог нарийвчлан гаргахын тулд дараах арга зүйг хэрэглэнэ. Үүнд:

- оролцогчдод төлөвлөж буй уулзалт сургалтын талаар зар хүргэхдээ ялангуяа эмэгтэйүүдэд зарыг шуурхай зөв хүргэх асуудалд илүү анхаарах
- сургалт, уулзалтууд зохион байгуулагдах газрыг товлохдоо эмэгтэйчүүд ойр, дөхөм байлгахыг бодолцох хэрэгтэй. Учир нь эмэгтэйчүүд хөдөлгөөний орон зайн хувьд хязгаарлагдмал байдаг юм. Хэрэв шаардлагатай бол аливаа үйл ажиллагааг нас, хүйс, нийгэм эдийн засгийн категор зэргээр хуваан зохион байгуулж болно.
- оролцогчдыг санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжихийн зэрэгцээ хэт их ярьж байгаа хүмүүсийн ярих цагийг хязгаарлах.

Ингэхдээ аливаа хүний санал бодлоо илэрхийлэх тухайн асуудалд холбогдолтой зүйлийг дутуу яриулах, шүүмжлэх гэх мэтээр санал бодлоо илэрхийлэх эрхийг нь боогдуулахгүй байх.

Жендерийн талаар дүн шинжилгээ хийхэд тавигдах асуудлууд

Асуултууд	Зорилт
1. Хэн юу хийдэг вэ? Хэний төлөө?	үйл ажиллагаа
2. Хэрхэн?	ямар утгаар
3. Тэдгээрийг хэн эзэмшдэг вэ?	Эх үүсвэр
4. Хэнд юу хамааралтай вэ? Хэн юуг хянадаг вэ?	Эрх мэдэл
5. Хэн юуг хариуцдаг вэ?	Хариуцлагатай байдал
6. Хэн юу оруулдаг вэ?	Орлого
7. Хэн юуг зарцуулдаг вэ?	Зарлага
8. Хэнд юу ноогддог вэ?	Эрх /норм
9. Хэн юунаас таашаал авдаг вэ?	ур нөлөөлөл
10. Хэн хожиж, хэн нь алддаг вэ?	

Олон түвшинт хандлага

ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь макро, мезо, микро түвшний оролцоог хангадаг. Үүнд:

- ХЭЗЧДС-ын микро түвшинд хөдөлмөр эрхлэлт, орлогыг бий болгох боломжийг тодорхойлсны үндсэн дээр үйл ажиллагааг явуулдаг. Эдийн засгийн хэрэгцээнд ур чадварын сургалтыг нийцүүлэх гэдэг нь дангаараа хангалттай зүйл биш юм. Эмэгтэйчүүд илүү их дэмжлэг хэрэгтэй байдаг гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн. Жишээ нь, тэдгээрт цалинтай хөдөлмөр эрхлэлт эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэхэд дор хаяж бичиг үсгийн ур чадвар эсвэл өөртөө итгэлтэй байдал дутмаг байдаг.
- Хэрэгцээтэй сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалтыг зохион байгуулах нь сургалтын төвүүд, бусад сургалтын байгууллагуудаар дамжуулан мезо түвшинд хэрэгжигддэг. Иймд түнш байгууллагуудын хүсэл эрмэлзэл, тэдний чадавхийг хөгжүүлэх асуудал гарч ирдэг. Сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь техникийн туслалцаа, зах зээлийн талаарх мэдээллээр хангах зэрэг нь орлогыг бий болгох тогтвортой үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байдаг.
- Макро түвшинд дэх үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдаатай байдаг бөгөөд энэ нь холбогдох орчин, нөхцлийг бүрдүүлж өгдөг. Хэрэв үндэсний хэмжээний сургалтын байгууллагатай хамтарч ажилаж байгаа тохиолдолд инноваци, зорилтод бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн санаачлагыг бодолцож үзэх хэрэгтэй бөгөөд дээрх бүгд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн байх хэрэгтэй. Жишээ нь, Пакистанд хэрэгжүүлсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг үндэсний, мужийн түвшинд иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн нь төслийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ерөнхий загварыг бий болгож тухайн улсад нэвтрүүлэхэд хувь нэмэр болсон юм.

Жендерийн эрх тэгш байдлын асуудлыг дээрх гурван түвшний аль алинд анхаарч авч үзсэн байх шаардлагатай. Хэрэгцээтэй ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн боломжид жендерийн дүн шинжилгээ хийх нь дээрх гурван үе шатад жендерийн асуудлыг зохицуулахад туслана. ХЭЗЧДС-ын тухайн нөхцөл байдлыг макро-мезо-микро гэсэн түвшингүүдэд тодотгож хардаг нь тухайн түвшингүүдэд тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлоход хялбар болдог.

Техникийн хамтын ажиллагаан дах жендерийн асуудал

Жендерийн тэгш байдлын асуудалд хандах байр суурь нь жендерийн асуудлаар тусгайлан үйл ажиллагаа явуулдаг төсөл хөтөлбөрүүдээс тусгаарлагдаж болно. Гэхдээ жендерийн чиг хандлагын бүрэлдэхүүн хэсэгт оруулсан төслүүдийг тодорхойлоход хялбар болдог.

Жендерийн асуудлыг харгалзсан үйл ажиллагаа явуулдаг төслүүд. Эдгээр төслүүд нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийг зорилтод бүлгүүд болгон авсан байдаг. Ихэнхдээ дээрх төслүүд нь тодорхой асуудалд (зөвхөн эмэгтэй эсвэл зөвхөн эрэгтэй) анхаарал хандуулсан байдаг. Эдгээр төслүүд нь өнгөрсөн үеэс одоог хүртэл дамжин ирсэн жендерийн гадуурхалттай тэмцдэг. Тусгайлсан жендерийн төслүүд нь мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг сургалтын үйл ажиллагаанд хамтран оруулах боломжгүй тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд төлөвлөгдсөн байдаг.

Жендерийг асуудлыг чухалчилсан төслүүд. Ийм төрлийн төслүүдийн бүхий л үйл ажиллагаа жендерийн эрх тэгш байдлын асуудалд хувь нэмэр оруулахаар тооцогдсон байдаг. Жендер чухалчилсан биш тохиолдолд эмэгтэйчүүдийн асуудлыг тусгайлан авч үзэхгүй зөвхөн тоон үзүүлэлтээр авч үздэг бөгөөд энэ нь эмэгтэйчүүд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, тэдний онцлогыг харгалзах, тэдэнд

зориулсан тусгай сургалт зэргийг орхигдуулдаг байна. Жендерийн асуудлыг чухалчилсан төслүүдийн хувьд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн асуудалд чиглэсэн үйл ажиллагаа нь ялгаатай байх, тэдний бодит хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг.

Жендерийн бүрэлдэхүүн хэсэгтэй төслүүд. Эдгээр төслүүд нь жендерийн эрх тэгш байдлыг тусгасан бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг нь тухайн төслийг бусад төслөөс онцлог болгож хүрэх үр дүнг илүү жигд хүртээмжтэй болгох боломжийг бүрдүүлдэг байна. Эдгээр төслүүд нь жендерийн асуудалд мэдрэмжтэй ханддаг бөгөөд дор хаяж жендертэй холбогдолтой асуудлуудыг ерөнхий үйл ажиллагаанаас салгаж бие даасан бүрэлдэхүүн хэсэг болгож ажилладаг байна.

Бодит хэрэг дээр төслүүд нь дээр дурьдсан гурван чиг хандлагыг нийлүүлж хавсарсан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой. Жендерийн дүн шинжилгээ нь төлөвлөлтийн үед хийгдсэн байх бөгөөд төслийн үйл явцад жендерийн холбогдолтой асуудалд шийдвэр гаргахад тус дэм болох, төслийн явцад чухам ямар төрлийн жендерийн чиг хандлагыг баримтлахыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг өгөх болно.

Тавигдах шаардлага

Жендерийн эрх тэгш байдлын асуудал зөвхөн бэлгэдэл төдий яригдаж байх үед ур чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд жендерийн асуудлыг бодитойгоор хөндөж үздэггүй байсан. Ихэнх тохиолдолд" ур чадварын сургалт нь жендерийн мэдрэмжтэй байх хэрэгтэй" гэдгийг зөвхөн тодорхой тохиолдлуудад эмэгтэйчүүдийг боловсрол, сургалт, үр дүнтэй хөдөлмөр эрхлэлтэд татан оролцуулахыг уриалахын тулд хэрэглэж байжээ. Бусад тохиолдолд сургалтын байгууллагууд нь жендерийн асуудалд анхаарал тавина гэдэг эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын тоог тэгш байлгах гэж ойлгодог бөгөөд эдгээр сургалтын байгууллагууд нь сургалтын агуулгад заагдаж байгаа зүйлийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатай байдаг. Хүлээгдэж буй үр дүн, нөлөө болон үр дагаврыг харгалзахдаа тухайн ур чадварыг хөгжүүлэх, ажлын байрыг бий болгохдоо жендерийн асуудлыг тооцоолж үзсэн байх хэрэгтэй. Доор жендерийн асуудлыг тодорхойлох үзүүлэлтүүдийн талаар тусгайлан дурьдсан болно.

Жендерийн асуудалд зориулах санхүүгийн нөөц

Жендерийн асуудалд зориулан тодорхой нэмэлт өртөг, зардал гаргах магадлалтай. Тухайлбал, эмэгтэйчүүдийн сургалтын ирцийг хангахын тулд хүүхэд саатуулах үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага гарна. Хэрэв сургалтын цагийн хуваарийг уян хийхээр бол, тодорхой дасгалыг хийх оролцогчдыг хүйсээр ангилах шаардлага гарвал эсвэл түнш байгууллагын зүгээс хүйсийн асуудлыг зохицуулахтай холбоотой асуудал гарвал гэх мэт, дээрх үйл ажиллагаанууд нь нэмэлт хөрөнгө болон хүний нөөцийг шаардана. Гэхдээ хүйсийн асуудлыг зөв зохицуулаагүйгээс болж нуугдмал болон нэмэлт хөрөнгө гардаг байна. Учир нь хүний нөөцийг зохистой хэрэглээгүй байгаа тохиолдолд энэ нь тодорхой хугацааны дараа эдийн засаг болон нийгэмд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг байна.

Зарим тохиолдолд техникийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэхэд жендерийн асуудалд тодорхой хэмжээний хөрөнгийг төсөвлөж байх нь зүйтэй юм. Дээрх жендерийн төсөв нь зөвхөн шилжилтийн арга хэмжээнд зарцуулагдана гэж тооцвол буруу болно. Жендерийн асуудал гэдэг нь бүх үйл ажиллагаанд эрэгтэй эмэгтэйчүүдийг хамтран оруулахаас гадна хүйс тус бүрийн онцлогт нийцсэн нөхцлийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагийг хэлнэ.

Байгууллагын дүн шинжилгээ

Сургалтын, бизнесийн мэдлэг, чадвартай эдгээр чиглэлээр хосолсон үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ жендерийн асуудалд мэдрэмжтэй хандах түнш байгууллагыг олно гэдэг нь хүндрэлтэй асуудал мөн. Гэхдээ хэрэв тухайн байгууллага нь ямар нэгэн хэлбэрээр жендерийн эрх тэгш асуудалд илэрхий сөргөөр ханддаггүй тохиолдолд уг асуудалд зохицуулалт хийж, эрэгтэй эмэгтэйчүүдийг жигд сургалтад хамруулах боломжтой байдаг.

Жендерийн тэгш байдлыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон орон нутгийн байгууллагаас болзошгүй түнш байгууллагын чиг хандлагын талаарх мэдээллийг авахын зэрэгцээ жендерийн тэгш байдлыг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг байгууллагаас уг асуудалд холбогдох туршлагыг бусад түнш байгуулагуудад нэвтрүүлэн хэрэгжүүлснээр жендерийн тэгш байдлын харилцаанд суурилсан үйл ажиллагааг явуулдаг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн түнш байгууллагыг бий болгож болно.

Байгууллагын зохион байгуулалт

Зарим тохиолдолд ХЭЗЧДС-ын төсөл нь жендерийн асуудлаар мэргэшсэн ажилтныг байгууллагын бүрэлдэхүүнд оруулдаг тусгайлсан ажилтантай байх нь нийт үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах чиг хандлагыг баримтлах боломжтой нөхцлийг бий болгодог. Түүнчлэн жендерийн асуудалд мэдрэмжтэй ханддаг сургалтын ажилтан нь мөн тодорхой хувь нэмэр оруулах боломжтой. Мадагаскарын ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн асуудал хариуцсан ажилтан нь бүх л сарын турш үндэсний төслийн зохицуулагч, орон нутгийн зөвлөхтэй тулж ажилласан. Мөн зарим төслүүд, тухайлбал Бангалдеш, Зүүн Тиморын төслүүд тусгайлсан жендерийн багуудтай байсан байна.

Хүснэгт 2. Төслийн жендерийн баг

Зүүн Тиморт хэрэгжүүлсэн Орлоготой хөдөлмөр эрхлэлтийн төлөөх ур чадварын сургалт төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын яаманд жендерийн багийг бүрдүүлэн ажилласан байна. Тус баг нь цалингийн, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах сургагч нарт жендерийн асуудалд хэрхэн хандах чиглэлээр зөвлөмж зааварчилгаа өгч ажилласан байна. Жендерийн баг нь үндэсний жендер, эрх тэгш байдлын ажилтан, яамны хоёр ажилтан, төслийн жендерийн ажилтан зэргээс бүрдэж байсан байна.

Чадавхийг хөгжүүлэх: хэрэгжүүлэгч байгууллага ХЭЗЧДС-ын түнш, үндэсний болон орон нутгийн ХЭЗЧДС-ын багуудын жендерийн талаарх мэдээлэл, нөлөөлөлийг сайжруулна.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн оролцогч тал бүр жендерийн асуудалд анхаарал хандуулж тодорхой хэмжээнд хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ оролцогч болгонд ижил төрлийн шаардлага тавихгүй бөгөөд зарим байгууллагын ажиллагчдын жендерийн асуудлын тодорхойлох ур чадвар бусад өөр байгууллагынхтай харьцангуй адил бөгөөд зарим байгууллагын хувьд жендерийн нөлөөллийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтэд тусгах ур чадвартай байх хэрэгцээтэй байхад зарим хүмүүсийн хувьд уг асуудлын хувьд мэдрэмжтэй хандаж ерөнхий чиг хандлагыг баримталж байхад хангалттай.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн уг асуудалд баримтлах чиг хандлага нь тухайн хөтөлбөр бүрийн оролцогч, хэрэгжилтийн явцаас хамаарах бөгөөд ОУХБ –ын ажиллагчид, ХЭЗЧДС-ын зөвлөлийн гишүүд, төрийн байгууллагын төлөөлөл,ТББ-ууд, ажил олгогчид, ажилчдын байгууллагууд, хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид, нийгэм, соёл, улс төрийн нөхцөл байдал орно.

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийн үр шимийг хүртэхийг дэмжихэд таатай орчинг бүрдүүлэхийн тулд жендерийн талаарх мэдээлэл, нөлөөллийг сайжруулах нь хөтөлбөрийн жендерийн асуудалд баримтлах гол стратеги юм. Үүний тулд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага, ХЭЗЧДС-ын зөвлөлүүд, орон нутгийн багууд, зорилтод бүлгүүдийн хувьд жендерийн асуудалд эергээр хандах хандлагыг бий болгох хэрэгтэй. Ялангуяа ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамрагдагчдад зориулсан сургалтыг жендерийн мэдрэмжтэйгээр зохион байгуулах нь чухал. Гэхдээ жендерийн тэгш байдлын талаарх бодлогыг дэлгэрүүлнэ гэдэг нэг удаагийн үйл ажиллагаа биш бөгөөд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хэрэгжих явцад тогтмол хийгдэхийн зэрэгцээ тухайн орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулах хэрэгтэй.

ХЭЗЧДС-ын арга зүйн талаарх мэдээлэл өгөх сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд жендерийн асуудлыг тодорхой хэмжээнд хөндөж оруулж байх ёстой. Тухайлбал, Бангладешид хэрэгжүүлсэн *Техник сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дээшлүүлэх аргаар ядуу эмэгтэйчүүдийн ур чадварын сургалт, хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх төслийн* явцад жендерийн талаарх мэдээлэл болон нөлөөлөлийг сайжруулах үйл ажиллагаа тогтмол хийгдэж байсан байна.

Жендерийн талаарх мэдээлэл, нөлөөллийг сайжруулахад:

1. Орон нутгийн багууд (орон нутгийн зөвлөл, нийгмийн ажилтнууд, бусад холбогдох ажиллагчид)-ад зориулсан сургалтын хөтөлбөрт уг асуудлыг тусгах
2. Сургагчийн сургалтад уг асуудлыг тусгайлан тусгах, орон нутгийн баг, сургагчдын дунд “Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг” –ийг бий болгох
3. Оролцогч эмэгтэйчүүд,эрэгтэйчүүдэд жендерийн асуудлаар сургалт зохион байгуулах
4. Эмэгтэй суралцагчдийн эрэгтэй хамаатнууд, суурин газрын оршин суугаа иргэдийг хамруулсан жендерийн талаарх мэдээлэл, нөлөөлөлийн талаарх сургалтыг зохион байгуулах

Зан заншлийн хувьд мэдрэмжтэй байх

Зүүн Тиморт “Эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бизнесийн төлөө ажиллах” уриаг сургалтад оролцож байсан, дийлэнх нь эрэгтэй оролцогчид хүлээн авч дэмжсэн бөгөөд үүний үр дүнд төслийн хүрээнд “Эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлээс эдийн засгийн оролцоо хүртэл” гэсэн уриа гарсан байна. Хэдийгээр эрэгтэй оролцогчид нь жендерийн талаарх асуудлыг тодорхой хэмжээний болгоомжлолтой хүлээж авч байсан ч гэсэн үүнийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь зан заншлийн хувьд эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зарим асуудлыг зөөлрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Хэдийгээр уг уриа нь эмэгтэйчүүдийн чадавхийг нэмэгдүүлэхэд шууд чиглэгдсэн байсан боловч үүнийг зөв зүйтэй хэлбэрээр ойлгуулж чадсан нь бусдад хүрсэн байна.

2.2. Эдийн засгийн боломж, сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл ажиллагаан дах жендерийн тэгш эрхийн асуудлын гол чиг хандлага *(Бүлэг III-т дурьдсагдсан асуудал хамаарна.)*

Ур чадварыг хөгжүүлэх нь нэмэлт орлогыг бий болгох боломжид чиглэсэн байна. Энэ нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд зах зээлийн харилцааны өөрчлөлтүүдэд зохицох боломжийг бүрдүүлж өгөх ёстой. Ур чадварын сургалт нь хөдөлмөр эрхлэлтийн нөөц, эрэлт хэрэгцээний хооронд холбогч байхын зэрэгцээ үр шимийг хүртэгсдийн хувьд эдийн засгийн боломжуудыг нээж байх нь зүйтэй. Сургалтын хөтөлбөрүүд нь жендерийн дүн шинжилгээнд үндэслэж оролцогчдын тус бүрийн хэрэгцээг нарийвчлан тогтоосон байх бөгөөд үүний тулд дараах алхмуудыг хийнэ.

1. Зорилтод бүлэг, орон нутагт байгаа эдийн засгийн, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг тогтоох
2. Тодорхойлогдсон эдийн засгийн боломжийн нөхцөл байдлын судалгааг хийж ажил олгогчдын эрэлт хэрэгцээг тодорхойлно .
3. Цаашид хөгжих боломжтой бизнес, хөдөлмөр эрхлэлтийн боломжид нийцүүлж сургалтыг зохион байгуулах

Зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэх

Зах зээлийн хэрэгцээг хэд хэдэн төрлийн судалгааны үр дүнд дүгнэлт хийх, гол мэдээлэгч болох тухайн орон нутгийн эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдтэй ярилцлага хийснээр тодорхойлно. Судалгаанууд нь :

- ☐ хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний судалгаа
- ☐ зах зээлийн боломжийн судалгаа
- ☐ нөхцөл байдлын судалгаа

Үүнээс гадна орон нутгийн судалгаа, хоёрдогч судалгааны нэг хэлбэр болох салбарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. ОУХБ –аас ХЭЗЧДС, бусад хөтөлбөрүүдэд зориулж нөхцөл байдлын судалгаа, үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги үр чадвар, зах зээлийн эрэлт хэрэгцээг тогтоох судалгааны аргачлалыг боловсруулсан.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувьд эн тэргүүнд тодорхойлох зүйл бол зах зээл эсвэл хөдөлмөр эрхлэлтийн боломж юм. СТАГЕ төсөл нь дээрх асуудалтай холбогдох жишээг үзүүлж байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Зах зээлийн түргэвчилсэн судалгаа

Зүүн Тиморт хэрэгжүүлсэн Орлоготой хөдөлмөр эрхлэлтийн төлөөх үр чадварын сургалт төслийн хүрээнд " Орон нутгийн зах зээлийн түргэвчилсэн судалгаа"-ны аргачлалыг үр чадварын сургалтын өмнө бизнесийн боломжийг судлах зорилгоор боловсруулсан байна. Зах зээлийн судалгааг хийж буй хүмүүс нь эхний ээлжинд жендерийн чиг хандлага бүхий бизнесийн чиг хандлагыг тодорхойлоход анхаарлаа хандуулсан байна. Судалгааны явцад эмэгтэйчүүд уламжлалт үр чадвар: хоол хийх, оёх, гар урлал хийх, харин эрэгтэйчүүд: механик, техникийн үр чадвар шаардагдах бизнесийг илүү сонирхдог нь тодорхойлогдсон байна. Үүний дараа судаачид нь эмэгтэйчүүдтэй уулзаж, тэдгээрийн бизнесийн санал ашиг авчрах талаар ярилцаж санал солилцсон байна.

Мэдээлэл цуглуулах явцад жендерийн хувьд мэдрэмжтэй хандах нь давуу талыг бий болгодог байна. Эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлага, сургалтад хамрагдах хүсэл зэргийг тодорхойлохын тулд зарим санаачлагыг гаргах хэрэгтэй. Иймд эмэгтэйчүүдт шаардлагатай үр чадварыг тодорхойлохдоо эрэгтэйчүүдээс арай өөр асуултыг асуух хэрэгтэй бөгөөд эмэгтэйчүүдийн санал дээр үндэслэн уг хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байх хэрэгтэй.

Ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдийн хэрэгцээг тодорхойлоход тусгайлан санаачлагтай хандах хэрэгтэй байдаг. Жишээ нь, *Мадагасгарын зарим бүс нутгуудад иргэдийг хурал цуглаанд дуудахад хонх дуугаргадаг бөгөөд гэхдээ хуралд зөвхөн эрэгтэйчүүд оролцдог байна. Йим уламжлалт аргаар хүмүүсийг хуралд оролцуулахын өмнө ХЭЗЧДС-ын зүгээс гудамжинд тусгайлан зарлал нааж холбогдох нийгэмлэг, байгууллагууд, орон нутгийн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зөвлөл, зарим тохиолдолд шууд эмэгтэйчүүдт хандаж, уулзалтын зорилго зорилтыг тайлбарлаж, ирж оролцохыг уриалсан байна.*

Зарим тохиолдолд эмэгтэй хамаатантай нь ярилцахын тулд эрэгтэй хүнээс зөвшөөрөл авах шаардлага гардаг. *Жишээ нь, Миндинаогийн лалын автономит мужид, Филлипинд хэрэгжиж байсан ОУХБ-ын ХЭЗЧДС-ын төслийн ажилтнууд хэрэгцээг тодорхойлох судалгааг хийхийн тулд зөвхөн эрэгтэйчүүдтэй уулзаж байсан бөгөөд тэдгээрийн тогтоосноор эмэгтэйчүүдтэй уулзаж, тэдний сургалтын хэрэгцээг тодорхойлохын тулд эхлээд эрэгтэйчүүдтэй нь уулзаж зөвшөөрөл авах хэрэгтэй болсон байна. Зан заншилд тогтсон энэ уламжлалыг дагаж зөвшөөрөл авсны дараа эмэгтэйчүүдтэй сургалтын хэрэгцээг тодорхойлсон нь амжилттай болсон байна.*

Сургалтын хэрэгцээг тодорхойлох нь

Тодорхой зорилтод бүлгүүдийн ур чадварын хэрэгцээг тодорхойлохдоо хэдийгээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг хоёр бүлэг болгон тодорхойлсон ч гэсэн тэдгээрийг дотор нь дахин ангилж байх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийг ангилах хамгийн энгийн арга бол: ганц бие, гэрлэсэн, бэлэвсэн, жирэмсэн, хүүхэд хөхүүлж байгаа, настайвтар, залуу охид, мөн хөгжлийн бэрхшээлтэй гэх зэргээр ангилах юм. Түүнчлэн эдгээр ангилсан ангилалын дотор боловсролын түвшин, нийгэм эдийн засгийн нөхцөл, нас, хөдөлмөр эрхлэх боломж, сонирхож буй эдийн засгийн үйл ажилагааны төрөл, цаашид өөрийн бизнесийг хөгжүүлэх хүсэл эрмэлзэл гэх мэт дахин дотор нь хуваах болно. Дээр дурьдсан бүхий л хүчин зүйлүүд сургалтын хөтөлбөрийг боловсруулахад чухал ач холбогдолтой. Жендер дээр суурилсан судалгаа нь зорилтод үйл ажиллагааны оролцогчдыг зөвхөн "үр шимийг хүртэгчид" гэж ерөнхийд нь нэг бүлэг болгон хуваах болохгүй гэдгийг харуулж байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбох нь

Мадагаскарт худалдааны чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг нэхмэлийн үйлдвэр нь ХЭЗЧДС-ын сургалтад хамрагдсан залуу эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийг ажилд авах

сонирхолтойгоо илэрхийлж холбоо тогтоосон. Тэдгээр нь хөтөлбөр, сургалтыг зохион байгуулагчидтай ойр ажиллаж чухам ямар ур чадвар хэрэгтэй байгаа талаар саналаа өгсөн. Сургалтыг эхлэхээс өмнө сургалтад хамрагдахаар бүртгэгчдийг тухайн үйлдвэр дээр авч ирч ажлын орчин нөхцлийг танилцуулсан.

Анхаарал хандуулах шаардлагатай гол асуудлууд

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтууд, орлогыг бий болгох үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулж жендерийн тэгш байдлыг дэмжих чиг хандлагатай байдаг боловч дараах зүйлд тусгайлан анхаарал хандуулах хэрэгтэй.

- Бүлэг бүр ХЭЗЧДС-ын үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцоно.
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үр шимийг эмэгтэй болон эрэгтэйчүүдэд үзүүлнэ гэж тооцох
- Хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрчлөлтүүд нь орон нутгийн хувьд хэрхэн нөлөөлөхийг тооцох
- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн явуулж буй сургалт болон бусад үйл ажиллагаа нь оролцогч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ижил төрлийн боломжийг хүртээмжтэй байх

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн техник ур чадварыг шинэ, уламжлалт бус мэргэшил эзэмшихэд дэмжлэг болохоор зохион байгуулах

ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд мэргэшлийн шинэ нөхцлүүдийг тодорхойлж санал болгодог. Энэ нь хөдөөгийн эмэгтэйчүүдийг уламжлалт үйл ажиллагаанаас нь салгаж шинэ зах зээлд хандсан боломжуудаас үр шим хүртэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Бангадешийн эмэгтэйчүүдийн хувьд уламжлалт бус мэргэшил эзэмших боломж нээгдсэн нь

Жишээ нь: *Эмэгтэйчүүд нь цахилгаан холбох, гэр ахуйн тоног төхөөрөмж, радио телевиз засах, компьютерийн ур чадвар, төмрийн үйлдвэрлэл, тэргэнцэр угсрах болон задлах, оёдлын машин засах болон бусад үйл ажиллагаанд суралцаж бэлтгэгдсэн байна. Дээрх ур чадваруудыг суралцахад нийт суралцагсдын эмэгтэй хэсэг нь илүү сонирхолтой идэвхтэй оролцож байсан байна. Эмэгтэй төгсөгчдийн дийлэнх нь сурсан ур чадвараа ашиглаж цаашид хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд энэ нь тэдний хувьд өөрсөддөө өөрсдийн чадварт бүрэн төгс итгэх итгэлийг олгосон байна.*

Гэхдээ эмэгтэйчүүдийг уламжлалт бус хөдөлмөр эрхлэх асуудалд татан оролцуулах нь хүндрэлтэй асуудлуудын нэг хэвээр байсаар байна. Нэг талаар эмэгтэйчүүд нь зөвхөн бүтээгдэхүүнийг цуглуулж үйлчилгээ үзүүлэх маягаар зах зээлд гарч орлого олох хэрэгцээ нь байгаа, нөгөө талаас сургалтын байгууллагууд нь тодорхой мэргэжлээр тодорхой хүйс заан сургах чиг хандлагаа баримталсаар байна. ОУХБ-ын зүгээс эмэгтэй болон эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг зааглаж хуваадаг энэхүү чиг хандлагыг өөрчлөх болсон гэж үзэж байна.

Эмэгтэй хүн эрхэлж болно гэсэн үйл ажиллагаа эсвэл болохгүй гэсэн үйл ажиллагаа гэсэн жендерт суурилсан энэ чиг хандлагыг солихын тулд цаг хугацаа шаардлагатай. Эмэгтэй хүний уламжлалт бус хөдөлмөр эрхлэлтэд оролцох оролцоо нь ёс жаяг соёлын бэрхшээлүүдийг давах хэрэгцээг бий болгож байна. Эмэгтэй хүнийг зөвхөн тодорхой нэг салбарт ажиллах ёстой гэсэн нийгмийн чиг хандлагууд нь ур чадварын сургалтын үр дүнг цаг хөрөнгө зарцуулсан хэрэгцээгүй үйл ажиллагаа болгон хувиргаж байна. Иймд эмэгтэйчүүд уламжлалт бус ур чадварыг эзэмших нь зүйтэй гэж нийгэмд ухамсаруулж ойлгуулах шаардлага хэрэгцээ гарч байна. Чухам ийм л учраас ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд эмэгтэйчүүд өөрдсөө, тэдний гэр бүл, нутгийн иргэд, түнш байгууллагуудыг өргөнөөр оролцуулахыг эрмэлзэдэг байна. Ялангуяа ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь нөхрүүд, гэр бүлийн гишүүдийг жендерийн тэгш байдлын асуудалд анхаарал хандуулж түлхүү оролцуулахыг хичээдэг. Мөн уг асуудал нутгийн, орон нутгийн удирдлагуудын дэмжлэг чухал.

Бангладешт хэрэгжүүлсэн төслийн явцад эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа дах байр суурийн талаарх шинэ хандлагыг орон нутгийн удирдлагуудад таниулж, тэдгээрийн дэмжлэгийг авахад ихээхэн анхаарал хандуулсан байна. Энэхүү дэмжлэг нь сургалтын болон сургалтын дараах үйл ажиллагааны аль алинд нь ихээхэн хэрэгцээтэй байсан. Филиппиний ХЭЗЧДС-ын хөтөлбөр ажил олгогчтой ойртож ажилласны ур дүнд засварчны сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийг ажилд авах асуудлыг шийдвэрлэлүүлсэн байна. Харин Камбожид мотор засдаг механик эмэгтэйчүүдт үйлчлүүлэгчид итгэхгүй байсан бөгөөд үүний ур дүнд бизнес нь дампуурсан байна. Иймд мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь эмэгтэйчүүдийг радио засвар зэрэг эмэгтэй хүний хувьд уламлалт бус мэргэжлээр сургахын зэрэгцээ оёдол, хатгамал, ээрмэл зэрэг уламжлалт мэргэжилд сурахыг санал болгодог.

Сургалтад хамрагдаж тухайн бүлгийн бүх эрэгтэй суралцагчдаас илүү үзүүлэлт үзүүлж авъяас чадвартайгаа илэрхийлж чадсан эмэгтэй сургалтын дараа засварын газар байгуулсан боловч эмэгтэй хүн иймэрхүү ажил эрхлэх боломжгүй, чадваргүй гэж үзэж үйлчлүүлэхгүй байсны улмаас дампуурсан байна.

Мадагаскарт болсон нэгэн үйл явдал ажил мэргэжлийг жендерийн мэдрэмжтэйгээр сонгох шаардлагатай гэдгийг харуулсан бөгөөд энэ тохиолдолд эрэгтэй хүн эмэгтэй хүний ажил гэгдэх мэргэжлийг сонгосонтой холбоотой байжээ: *Мадагаскарт хэрэгжсэн уг төслийн явцад ойролцоо байх чөлөөт худалдааны бүсийн*

оёлдын үйлдвэрд ажиллуулахаар оёдолчны сургалтыг зохион байгуулж, залуу эмэгтэй эрэгтэйчүүдийг сургасан байна. Дамжааны эхний багцад 29 (26 эмэгтэй, 3 эрэгтэй) оролцчид хамрагдсан бөгөөд уг мэргэжлийг эрэгтэй хүнийх биш гэж үзэн 2 эрэгтэй нь сургалтыг орхиж явсан байна. Зөвхөн нэг эрэгтэй хүүхэд уг сургалтыг төгсөж ажил хөдөлмөр эрхэлж, гэр бүлдээ тус нэмэр болжээ.

2.3. Жендерийн асуудлыг зохицуулсан сургалтын загвар, төлөвлөлт, зохион байгуулалт

“Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг”-ийн чадамжийг нэмэгдүүлэх

Бангладешт сургагч нарын сургалтын хөтөлбөрт тухайн шаардлагатай ур чадвар, технологи, төлөвлөлт, зохион байгуулалт, сургалтыг хэрхэн явуулах талаар тусгахаас гадна “Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг”-ийн чадамжийг нэмэгдүүлэх сургалтыг мөн давхар зохион байгуулсан байна. Үүнд зориулан тусгайлсан гарын авлага бэлтгэсэн бөгөөд 11 өдөр үргэлжилсэн сургалтад 30 гаруй түнш сургалтын байгууллагуудын сургагч нар оролцсон байна. Эдгээр сургагч нар нь уг гарын авлагын ашиглан бусад сургагч нарт хичээл орж, жендерийн талаарх мэдлэг, нөлөөллийн асуудлыг сургалтын төлөвлөгөө, зохион байгуулалт, ур чадвар олгох сургалтын явцад хэрхэн анхаарах талаар дэлгэрэнгүй зааж өгсөн байна.

2.4.Жендерийн талаарх мэдлэг, ажиллах орчны талаарх сургагчийн сургалт

Мэргэжлийн, бусад ур чадварын сургагч нар жендерийн асуудлаар тодорхой мэдлэгтэй байж энэ талаар өөрсдийн сургалтад оруулж байх шаардлагатай. Иймд сургагч нарт зориулсан дээрх сэдэв бүхий сургалтыг зохион байгуулна:

- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн асуудалд хандах чиг хандлагыг мэдэж байх.
- Уг асуудлаар албан бус сургалтыг зохион байгуулах арга зүйн мэдлэг, ур чадвартай байх.
- Үндэсний хөтөлбөрийн тайланд тусгаж байх
- Сургалт болон сургалтын дараах явцад суралцагчдын дунд жендерийн асуудал хэрхэн тавигдаж байгаад хяналт шинжилгээ хийх ур чадвартай байх

Бангладешийн техник сургалтын төвийн жендерийн асуудалд хандах туршлагаас

Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө сургагч нар нь уламжлалт мэргэжлийн сургалтын чиг хандлагыг баримталж, албан сургалтын арга зүйг ашиглаж байжээ. Сургагч нар нь жендерийн асуудлаар мэдлэг хомс байсан бөгөөд албан бус сургалт жендерийн тэгш байдлыг хангах талаар маш хязгаарлагдмал но–хау-тай байжээ. Төслийн хүрээнд хэрэгжсэн сургагч нарын сургалтын үр дүнд тэдгээр нь жендерийн асуудлын талаар тодорхой мэдлэгтэй болжээ.

Ихэнх тохиолдолд сургагч нар дээрх асуудалтай холбогдох мэдлэг шаардлагагүй, боловсролын түвшин доогуур хөдөөгийн ядуу иргэдийн дунд ажиллаж амьдардаг байна. Түүнчлэн тэдгээр нь төдийлөн эмэгтэй Суралцагчдад хичээл зааж үзээгүй байдаг байна. Иймээс Мадагаскарт ирээдүйн суралцагчдыг сургагчийн сургалтад урьж, оролцуулсан бөгөөд ингэснээрээ сургагчдад эмэгтэй суралцагчдад хичээл заах талаар тодорхой ойлголт өгсөн байна.

Сургалтын агуулга

ХЭЗЧДС-ын хөтөлбөрт ур чадварын сургалт нь зөвхөн тухайн тодорхой мэргэжилд шаардагдах ур чадварыг заахаас гадна, орчин үеийн хөдөлмөрийн зах зээлд хэрэгцээтэй байдаг ур чадварыг олгохыг хичээдэг. Манлайлал, нөлөөлөл болон зохион байгуулах ур чадвар зэрэг нь ядуу хүмүүст эдийн засгийн, нийгмийн тэгш бус харилцаа болох ажлын нөхцөл, жендер, нас, яс үндэс, каст зэргээр ялгаварлан гадуурхалтыг даван туулахад шаардлагатай чадварыг олгохыг мөн хичээдэг байна.

Дотоодын болон гадаадын бизнест эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өөртөө итгэлтэй байх, бусадтай харилцаж тохиролцоо хийж чаддаг байх, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, жендерийн тэгш байдлын талаар тодорхой чадвар мэдлэгтэй байх шаардлага гардаг. Зарим улс оронд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад бизнес эрхлэх чиг хандлага илүү бөгөөд энэ тохиолдолд эмэгтэйчүүдэд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийг менежментийг хөгжүүлэх сургалтыг илүү түлхүү явуулах шаардлага гардаг.

Өөртөө итгэлтэй байдлыг бий болгох

Бангладешт хэрэгжүүлсэн төслийн оролцогчдын нэг болох Разия: “Манай тосгонд хэн ч эмэгтэй хүний үйлдвэрлэсэн хайрцагийг авахгүй гэдэгт итгэлтэй байсан. Мөн хүмүүс эмэгтэй хүн иймэрхүү төрлийн бизнесийг явуулж чадахгүй гэдэг байсан.“ гэж хэлж байсан боловч тэрвээр одоо өөр 6 эмэгтэйтэй хамтран орон нутгийн сарины дэлгүүрт хайрцаг нийлүүлэх хоршоололыг нээхээр төлөвлөж байна. “Эхлээд би зах дээр очиж дэлгүүрийн эздэд манайхаас хайрцаг аваач гэж хүсэлт тавих талаар боддоггүй байсан бол одоо би тэгэх боломжтой гэж өөртөө итгэлтэй байдаг болсон.”

Бичиг үсгийн болон тооны сургалт

Ихэнх албан бус үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн нь ерөнхий боловсролын түвшин доогуур, ялангуяа бичиг үсгийн хангалтгүй мэдлэгээсээ болж хүнд байдалд ордог. Тухайлбал, тэдгээр нь худалдан авсан тоног төхөөрөмж, үйл ажиллагаандаа хэрэглэх сэлбэгийг хэрхэн ашиглах талаар заавар, зааварчилгааг уншиж чаддаггүй байна. Мөн ихэнх тохиолдолд охидууд бага байхдаа сургуулиас завсардсан байдаг тул тэдгээрт бичиг үсгийн, тооны сургалт явуулах шаардлагатай байдаг.

Пакистаны баруун хойд, Пенжаб мужид хэрэгжсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн гол бүрэлдэхүүн хэсгийн нэг нь бичиг үсэг, тооны ур чадварын сургалт байсан. Энэ сургалтын зорилтод бүлгүүд нь ихэвчлэн эмэгтэйчүүд байсан.

Чадавхийг нэмэгдүүлэх сургалт нь нийгмийн, бизнесийн яриа хэлэлцээр хийх ур чадварыг үйлдвэрлэлийг сайжруулах ур чадвартай хамт хослуулан явуулна. Ямар ч тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийг хөгжүүлэх ур чадвар,өөртөө итгэлтэй байх ур чадварыг хамтатган эзэмшүүлэх ёстой. Магадгүй тодорхой хязгаарлагдмал хугацаанд явагдах техникийн хамтын ажиллагааны төслөөс хэтэрхий их үр дүн хүлээгдэж байж болох юм.

Гэхдээ сургалтын үйл ажиллагаа нь гэр орны ажил ихтэй эрэгтэй хүнээс гурав дахин бага завтай, өөрийн боломжоосоо доогуур ажил эрхэлж байга эмэгтэй хүний хувьд нилээд бэрхшээлтэй байж болох юм. Хэрэв эмэгтэй хүн тухайн үйл ажиллагаанд оролцсноороо ямар нэгэн байдлаар сэтгэлийн дарамтад орж, амжилтанд хүрэх магадлал буй эсэхэд эргэлзсэн тохиодолдолд сургалтыг орхих тохиолдол их байдаг боловч хэрэв дээрх үйл ажиллагаа нь санхүүгийн хувьд нилээд өндөр хэмжээний ашигтай гэж үзвэл оролдоод үзэхэд бэлэн байдаг. Өнгөрсөн хугацаанд суралцагчдыг сонгон авах, ялангуяа мэргэжлийн сургалтын байгуллагуудын зүгээс сонгон авч байгаа тохиолдолд оролцогсдын тоо бага байх хандлагатай байсан бөгөөд учир нь сургагч нар сонголт хийх явцад тухайн болзошгүй сурагчийг урьдчилсан байдлаар дүгнэн цаашдын үйл ажиллагааг нь үргэлжүүлэх эсэхэд дүгнэлт гаргаж хасдаг байсан байна. Гэвч төслийн гол зорилго бол эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэрэгцээг хангаж, тэдгээрийг зах зээлд гаргахад бэлэн болгох гэдгийг анхаарах хэрэгтэй.

2.5.ХЭЗЧДС-ын хөтөлбөртэй хамтран ажиллагч сургалтын байгууллагуудад эмэгтэй сургагчдын тоог нэмэгдүүлэх

Энэ стратегийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээлтэй асуудал бол сургалтын байгууллагуудад эмэгтэй сургагч нар цөөн байдаг, ялангуяа уламжлалт бус мэргэжлийг заах эмэгтэй багш нар маш ховор байдаг. Хэдийгээр эмэгтэй сургагч багш байгаа боловч тэдгээрийн хувьд гэр бүлд гүйцэтгэх ажил үүрэгтэй холбогдуулан гэрээс хол эсвэл удаан хугацаагаар хол явж хичээл заах боломжгүй байх нь их.

Туршлагаас харахад эмэгтэй сургагчид богино хугацааны сургалтад оролцох сонирхолтой байдаг. Иймээс ХЭЗЧДС-ын баг нь сургалтыг зохион байгуулагч байгууллагуудын хэмжээнд эмэгтэй сургагчдын сүлжээг байгуулах хэрэгтэй.

Түүнчлэн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс сургалтын байгууллагуудад эмэгтэй сургагч нарыг илүү авч техникийн болон бусад чиглэлээр сургагч бэлтгэх шаардлагатай гэдгийг ухамсарлуулах хэрэгтэй. Мэдээж үүнд цаг хугацаа шаардагдах болно.

Эмэгтэйчүүд,эрэгтэйчүүдийн гэрийн дотор, гэрээс гадуур гүйцэтгэх үүрэг, хариуцлага өөр өөр байдаг. Өөр байх зарим нөхцөлүүд нь биологийн онцлогоос хамаардаг ба зөвхөн эмэгтэй хүн л хүүхэд гаргаж, хөхүүлж чаддаг. Гэхдээ ихэнх тохиолдолд холбогдох ажил үүргийг зохицуулан хуваарьлах боломжтой байдаг. Жендер –эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгмийн ялгаа, харилцааны ялгааг хэлдэг бөгөөд эдгээр ялгаанууд нь шашин шүтлэг, ёс жаяг, зан заншил, цаг хугацааны эрхээр өөрчлөгдөх чиг хандлагатай байдаг. Дэлхийн зарим хэсэгт тухайлбал, Зүүн өмнөд Азид эмэгтэй хүн зам засах ажил хийж байгаа нь ердийн үзэгдэл боловч бусад газарт энэ нь зөвхөн эрэгтэй хүний ажил хэмээн тооцогддог байна. Үүнийг жендерийн ялгаа гэнэ. Зарим нийгэмд ганц бие эмэгтэй хүн түүний боловсролын түвшингээс үл хамааран эрэгтэй хүнтэй хамт нэг өрөөнд сууж хичээллэх боломжгүй байдаг нь шашин шүтлэгтэй холбоотой шаардлага юм. Харин эрэгтэй хүний хувьд түүний гэр бүлийн байдлаас үл хамааран түүний сургалтад оролцох байдалд аливаа хориг тавигддаггүй байна.

Эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо нь тодорхой асуудлын хувьд өөр өөр гэдгийг тодорхойлсны үндсэнд чухам ямар учраас жендерийн асуудалд тусгайлан ач холбогдол өгөөд байгаа нь ойлгомжтой болно. Харамсалтай нь ихэнх тохиолдолд мэргэжлийн сургалт болон боловсрол нь жендерийн хувьд дундыг баримталсан үйл ажиллагаа гэж тооцогддог бөгөөд үүнээс улбаалан, бодлого болон санаачлагын талд жендерийн асуудлыг орхигдуулах хандлага байдаг. Төрөл бүрийн шалтгаанаас хамааран тухайн этгээд эрэгтэй эсвэл эмэгтэй гэдэгт түүний сургалт, хөдөлмөр эрхлэлтийн боломж хязгаарлагддаг байна.

Хавсралт 7.1 Жендерийн холбогдолтой ойлголтуудын тайлбар

Жендерийн асуудалд холбогдолтой нэр томъёо

Жендер- гэдэг нь эрэгтэй хүн болон эмэгтэйчүүдийн хоорондох нийгмийн ялгаа болон харилцааг хэлэх бөгөөд энэ нь соёл, зан заншлын хүрээнд өөр өөрөөр тодорхойлогдож цаг хугацааны эрхээр өөрчлөгддөг байна. Жишээ нь, зарим соёлын хувьд эмэгтэй хүн болон охидууд замын барилгын ажил хийж болох боловч зарим соёлын хувьд зөвхөн эрэгтэй хүн, эрэгтэй хүүхэд энэ ажлыг хийх боломжтой юм.

Секс- гэдэг нь эрэгтэй болон эмэгтэй хүний хүлээн зөвшөөрөгдсөн биологийн өөр өөр байдлыг илэрхийлэгдэнэ.

Жендерийн үүрэг – тухайн нийгэм, хүмүүсийн дунд эрэгтэй болон эмэгтэй хүний эрхлэхээр тусгайлан заасан үйл ажиллагааны нөхцлийг хэлнэ. Эрэгтэй хүн болон эмэгтэй хүн, эрэгтэй, эмэгтэй хүүхэд зэрэгт гүйцэтгэвэл зохистой ажил гэж байх бөгөөд үүнд мөн нас анги, арьс өнгө, гарал үүсэл, соёл, шашин, үзэл санаа зэрэг нь нөлөөлөх бөгөөд эдгэр нь газар зүйн байршил, эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдлаас хамаарна. Жишээ нь, зарим орнуудад нэхмэл хийх нь зөвхөн эрэгтэй хүний ажил байхад харин зарим улс орнуудад нэхэх болон даавуу хийх нь эмэгтэй хүний ажил гэж тооцогддог байна.

Жендерийн тэнцвэртэй байдал– аливаа асуудлыг шийдвэрлэх,зохицуулахад жендерийн байдлыг харж түүнд үндэслэн шийдвэр гаргадаг байхыг хэлнэ.

Жендерийн дүн шинжилгээ- энэ нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийн тодорхой үйл ажиллагаа, нөхцөл, хэрэгцээ, шаардлага болон нөөцийг хянах, хөгжлийн үр шимийг хүртэх болон шийдвэр гаргах нөхцөлд дүн шинжилгээ өгөхийг хэлнэ. Дээр дурьдсан асуудлуудаас гадна жендерийн дүн шинжилгээнд нийгэм, эдийн засаг, улс төр, хүрээлэн байгаа орчны нөлөөг авч үзнэ.

Жендерийн тэгш байдал- өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын тэгш эрхийн зарчим бөгөөд энэ нь эрх хариуцлага, боломж зэрэгт илрэн гардаг байна. Түүнчлэн жендерийн тэгш байдал нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийг өөрсдийн хүйсээс үл хамааран ажил мэргэжил, шашин шүтлэг болон бусад асуудалд бие даан сонголт хийхийг хэлж байгаа юм. Жендерийн эрх тэгш байдлын асуудал нь зөвхөн эмэгтэй хүнд хамаарахаас гадна эрэгтэй хүнд ч мөн хамаарна.

Жендерийн эрх тэгш байдал гэдэг нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нийгмийн, хувийн амьдралын бүхий л асуудалд эрх тэгш оролцоно гэсэн үг юм. Жендерийн эрх тэгш байдал гэдэг нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүд нь бүх зүйлд ижил байна гэсэн утга агуулахгүй бөгөөд тэдгээрийн эрх, үүрэг, боломж нь тэдгээрийн эрэгтэй эмэгтэй болж төрснөөс үйл хамаарна гэсэн үг. Эрэгтэй болон эмэгтэй хүний эрх тэгш байдал нь хүний эрх болон хүн төвтэй хөгжлийн суурь болно. Жендерийн эрх тэгш байдал гэдэг нь өөр байх эрхийг мөн өөртөө агуулна.

Жендерийн мэдрэмжтэй байх - гэдэг нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийн хооронд байгаа ялгааг ухамсарласан гэсэн утга агуулна. Нэгэнт ухамсарласан гэх тохиолдолд ур чадварын сургалтууд нь жендерт суурилсан байх бөгөөд энэ нь тухайн хүйсэнд шаардлагатай онцгой хэрэгцээ шаардлагад нийцсэн эсвэл тэдгээрт нийцүүлэхээр зорилт тавьсан үйл ажиллагааг хэлнэ.

Жендерийн чиглэл - жендерийн чиглэлтэй байна гэдэг нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийн оролцоог хангасан аливаа үйл ажиллагааг төлөвлөхдөө тэдгээрийн эрх ашгийг бодолцсон байхыг хэлэх бөгөөд үүнд хууль тогтоомж, бодлого, тухайн асуудалд хамаарах төсөл хөтөлбөрүүд орно. Энэ нь аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ болон үнэлгээ хийх явцад асуудлуудад жендерийн эрх тэгш байдлын талаар хэрхэн хангасан байгаад хяналт тавихыг хэлнэ.

Жендерээр ялгаварлан гадуурхах - гэдэг нь тухайн хүний жендерийн төрлөөс нь болон ямар нэгэн байдлаар гадуурхах, суралцах, боловсрол олох, хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлах гэх мэт

Жендерийн асуудал - гэдэг нь эмэгтэй болон эрэгтэйчүүдийн хувьд нийгэм эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдалд тэгш бус байдал гаргахтай холбогдох тодорхой асуудлыг хэлнэ.

Жендерийн мэдрэмтэй үзүүлэлтүүд - нь нийгэмд гарч буй жендертэй холбоотой өөрчлөлтүүдийг хэмжихэд хэрэглэгдэнэ. Төслийн хувьд үзүүлэлтүүд нь зорилго болон үр нөлөөг тодорхойлох, хэмжихэд зориулагдана.

Чадваржуулах - нь чадамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэн нэгэн өөрийнхөө амьдралыг хянах боломжийг нэмэгдүлэх үйл ажиллагааг чадваржуулах гэнэ

Ажлыг хязгаарлах - гэдэг нь эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хооронд ялгаатай ажил хөдөлмөр эрхлэхийг хэлнэ. Дэлхийн бүх л улс орнуудын нийгэмд залуу эрэгтэй болон эмэгтэйчүүдийн сурах, ажиллах, амьдрал болон нйигэм дэх үнэт зүйлүүдийг жендер дээр үндэслэн хуваасан байдаг. Жишээ нь: зарим соёлуудад байдаг эмэгтэй хүүхдийг эрт хүнтэй сууулгана гэдэг нь түүний боловсролыг тасалдуулж ирээдүйд хөдөлмөр эрхэлж хараат бус байдлыг үгүй болгож байдаг. Дэлхий нийтийн хэмжээнд эмэгтэйчүүд нь гараар, гэрийн нөхцөлд даавуу үйлдвэрлэх, цахилгаан бараа,бусад жижиг бүтээгдэхүүнийг угсардаг. Ажлыг иймэрхүү маягаар хүйс дээр үндэслэн ялгаварлан хуваах нь зан заншлаас ихээхэн хэмжээнд хамаардаг байна.

Тогтсон хандлага- энэ нь нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүний тодорхой шинжүүдийг урьдчилсан загвар болгож хүлээн авахаар тайлбарлагдана.

Хавсралт 7.2. Жендерийн асуудал, боловсрол, сургалт, бичил үйлдвэрлэлийг хөгжил, цалинтай хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн асуудал болон шаардлага

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн түнш байгууллагууд нь зохистой аргаар шийдвэрлэхийн тулд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл болон тэдгээртэй холбогдох асуудлуудыг сайн мэдэж ойлгосон байх нь чухал. Боловсрол, сургалтын явцад тэгш бус байдлыг бий болгох нь цаашдын хөдөлмөр эрхлэлтийн өсөх, албан тушаал ахих явцад нөлөөлөх боломжтой байдаг. Түүнчлэн эмэгтэйчүүдийн нийгмийн тодорхой байр суурь, гэр бүлийн асуудал нь тэдгээрт эдийн засгийн боломжийг хүртээхэд нөлөөлөхүйц хүчин зүйл байдаг. Эмэгтэйчүүдийн бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлүүд их тулгардаг бөгөөд эдгээрээс жендерийн холбогдолтой гардаг асуудлуудын жишээг дор дурьдах болно.

Сургалт, боловсролтой холбогдон гардаг асуудлууд

- Боловсрол, сургалтын хүртээмжтэй байдал
- Эмэгтэй хүүхдүүдийн боловсролын нийгмийн үнэлэмж бага байдаг (эрэгтэй хүүхдүүдийн боловсролыг гэр бүлийн түвшинд илүү авч үздэг);
- Боломж нь эмэгтэй хүүхдийн хувьд боловсролтой дүйцэх үнэ цэнэтэй байхад эрэгтэй хүүхдийн хувьд энэ нь илүү үнэ цэнэтэй. Учир нь эмэгтэй хүүхэд гэр орны ажилд илүү хувь нэмэр оруулдаг байна;
- Эмэгтэй хүн нь гэр бүлд давхар орлого оруулдаг гэж тооцогддог байна. (Иймд тэдгээрийн боловсрол, сургалтад хөрөнгө оруулалт хийх шаардлага байхгүй);
- Гэр бүл дотор сургалтын болон орлогын эх үүсвэрийн талаар тохиролцох эрх мэдэл хязгаарлагдмал байдаг;
- Дэд бүтцийн бэрхшээлүүд. Сургалтын төв болон сургуулиуд нь ихэвчлэн эрэгтэй суралцагчдад зориулалттай байдаг бөгөөд эмэгтэй суралцагсдын хэрэгцээг тав тух нөхцөл байдлын хувьд хангах тал дээр хангалтгүй байдаг. Мөн энэ асуудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч гэсэн хамааралтай байдаг;
- Сургалтын байгуулагуудын хувьд- хэт өндөр элсэлтийн шаардлага, хичээлийн цагийн хуваарь гэх мэт;
- Газар зүйн бэрхшээлүүд- сургалтын байгуулагууд нь хол байрладаг, нийтийн тээврийн үйлчилгээ хангалтгүй;
- Сургалтын төлөвлгөө, сургалтын материал нь жендерийн мэдрэмжгүй байдаг бөгөөд голлон нэг хүйст (эрэгтэй) зориулагдсан байдаг;
- Сургагч багш нар нь жендер дээр суурилсан ялгаварлан гадуурхах шинж бүхий зан авир гаргах;
- Эрэгтэйчүүд давамгайлан эрхэлдэг ур чадварын салбарт эмэгтэй сургагч нар ховор байдаг нь уг сургалтад эмэгтэй хүн оролцохоос зайлсхийхэд хүргэдэг;
- Эмэгтэйчүүд гэр бүлийн ажил, хүүхдийн асуудлыг хариуцдаг тул тэдэнд сургалт, эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулах цаг зав бага байдаг;
- Ажил олгогчдын харилцаа, гэрээний нөхцөл зэрэг нь эмэгтэйчүүдийг үйлдвэрлэлийн сургалтад хамруулахыг дэмжихүйц бус байдаг;
- Орлого, үр шим нь боловсрол, сургалтын нөхцөл байдлаас хамааран багасдаг.

Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд тулгардаг асуудлууд

- Эмэгтэйчүүд ажилд ороход ялгаварлан гадуурхагдах магадлал илүү байдаг. (гэр бүлийн байдал, жирэмслэлт, хүүхэд асрах, жендер, ажлын уртасгасан цаг гэх мэт);
- Ижил түвшний боловсролтой эрэгтэй эмэгтэй хоёр хүн нэг салбарт ажиллаж байгаа тохиолдолд эмэгтэй хүн нь тус салбарт эсвэл дэд салбарын түвшинд ур чадвар бага шаардагдах, өсөх магадлал бага, цалин багатай ажилд томилогддог;
- Босоо тогтолцоотой салбарт ажиллаж байгаа эмэгтэй хүн ихэвчлэн албан тушаалын шатын доод түвшинд байх бөгөөд “үл үзэгдэгч тааз” түүнд албан тушаал ахиж өсөж дэвшихэд саад болдог. Эмэгтэй хүний хувьд хүртээмжтэй ажил ихэвчлэн гэр орны ажилтай холбоотой ур чадвар шаардсан үр дүн,орлого багатай ажил ч байдаг;
- Эмэгтэй хүнд ихэвчлэн олддог ажил нь дотоодын ажилчин, цалингүй гэрийн ажилчин, гудамжны цэвэрлэгч зэрэг байх бөгөөд дээр дурьдсан ажил албан бус эдийн засгийн үйл ажиллагаатай хамааралтай ажлууд байдаг;
- Эмэгтэй хүний ажил ихэвчлэн тухайн ажил мэргэжлийн хязгаарлагдмал хүрээнд байдаг байхад эрэгтэй хүний ажил мэргэжил нь ажил болон зах зээлийн нөхцөлд хамаагүй өрсөлдөөнтэй боломж нь нээлттэй нөхцлүүдэд байдаг;

- Эмэгтэйчүүд ихэвчлэн ур чадвар бага шаардагддаг ажилд томилогддог;
- Эмэгтэй хүн ижил төрлийн үнэлгээтэй ажил хийсэн мөртөө бага цалин авдаг;
- Гэр бүлийн үндсэн ажлын ачааллаас болон эмэгтэй хүний цалинтай хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг зав бага байдаг, иймд тэдгээр нь тухайн ажилд эрэгтэй хүнээс бага цаг зарцуулдаг;
- Дээр дурьдсантай адил үндэслэлээр ажилтай холбоотой албан болон албан бус үйл ажиллагаанд (уулзалт, үдэшлэг, үйлдвэрчний эвлэлийн цугларалт, ажлын дараах хамт олны цугларалт, бусад нийгмийн үйл ажиллагаанд) оролцох магадлал бага байдаг бөгөөд үүнээс болон нийгэмших, харилцаа холбоо шинээр бий болгох боломж багатай байдаг нь цаашдын карерт нөлөөлдөг;
- Эмэгтэй хүний олон төрлийн үүрэг хариуцлага үүрдэг нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулдаг;
- Эмэгтэй хүнд үйл ажиллагаа, орлогыг хянах боломж бага байдаг;
- Үйлчилгээний салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд үр бүтээлтэй ажлынх дийлэнх хэсэг нь үнэлэгддэггүй өнгөрдөг;
- Албан бус эдийн засгийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн үр бүтээлтэй ажлынх дийлэнх хэсгийг нь үнэлэлгүй өнгөөрдөг;
- Газар тариалан болон газар эзэмших асуудал дээр эмэгтэйчүүд ихэвчлэн ялгаварлан гадуурхагдаг бөгөөд ялангуяа үр шим сайтай сортын үр хүрэлцээгүй байдаг.

Хувираа хөдөлмөр эрхлэх, бичил үйлдвэрлэл эрхлэхэд тулгарах асуудлууд

- Албан ёсны цалинтай хөдөлмөр эрхлэлт хомс бөгөөд эмэгтэй хүмүүс ихэвчлэн хөдөлмөрийн зах зээлд тавигддаг боловсрол, ур чадварын шаардлагыг хангах боломж багатай байдаг. Зарим тохиолдолд бичил үйлдвэрлэлийг эрхлэх, хувираа хөдөлмөр эрхлэх нь орлого олох цорын ганц боломж байдаг. Түүнчлэн ядуу эмэгтэйчүүд эдийн засгийн боломжид оролцоход хүндрэлтэй нь тэдний ар гэртээ гүйцэтгэх үүрэгтэй холбоотой юм. Гэхдээ бичил үйлдвэрлэл болон хувираа хөдөлмөр эрхлэх нь цалинтай хөдөлмөр эрхлэхээс харьцангуй эрсдэл ихтэй юм.

Бангладешт туршилтийн журмаар хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтээс харахад хөдөөгийн ядуу эмэгтэйчүүд өөр газар очиж мөнгө хийж, орлого олох сонирхолтой байдаг.

Суурь судалгаа, зах зээлийн судалгаа, сургалтын хэрэгцээг тогтоох судалгаа, орон нутгийн байдалтай биечлэн танилах явцад эмэгтэй бизнес эрхлэгчдэд тодорхой хэмжээний бэрхшээлүүд учирдаг нь илэрхий ажиглагдаж байв. Дээрх бэрхшээлүүдийг дор дурьдав:

Боловсролтой холбоотой бэрхшээлүүд

- харьцангуй доогуур боловсролын түвшин;
- бичиг үсгийн;
- ерөнхий боловсролын суурь мэдлэг мөн доогуур;
- Техникийн болон мэргэжлийн ур чадварын хангалтгүй байдал.

Зан заншилтай холбоотой бэрхшээлүүд

- Олон эмэгтэйчүүд, залуу бүсгүйчүүд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхээс жийрхсэн байдаг бөгөөд энэ тэдгээрийн нөхөр, хадам талаас өгөгдсөн ойлголтууд байна
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг эмэгтэй хүн амжилтанд хүрэхийн тулд дотоод, гадаад эргэлзээтэйгээ байнга тэмцэх шаардлага гардаг.

Нөөц, эх сурвалжийн хязгаарлагдмал байдал

- Зээл, зах зээл, техник, бусад сургалт, бизнесийн дэмжлэгийн үйлчилгээний хязгаарлагдмал байдал;
- Өмчлөл, хөрөнгийн холбоотой хязгаарлалтууд (газар, тоног төхөөрөмж).

Эрх зүйн асуудлууд

- Зээл авах нь зарим тохиолдолд нөхрийн зөвшөөрөл шаардлагатай байдаг бөгөөд энэ хүндрэлтэй байж болох юм;
- Эмэгтэй хүний хувьд бие даасан бизнесийн гэрээ хийх нь хүндрэлтэй байдаг бөгөөд энэ нь ерөнхийдөө бие даасан эрх зүйн үйл ажиллагаа явуулахад хязгаарлагдмал гэсэнтэй ижил утгатай юм.

Нийгмийн болон гэр бүлийн бэрхшээл

- нийгэм нь эмэгтэй хүнийг үндсэн гэр бүлийн ажлаасаа холдсон байхыг харахыг хүсдэггүй;
- бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн хадам, нөхрүүд нь эмэгтэй хүн гэрээсээ гадуур ажиллаа гэж дургүйцдэг нь гэр бүлийн гишүүд, хөршүүд, нутгийн хүмүүсийн шүүмжлэлд өрттөг;
- эмэгтэй хүн нийгмийн, шашны хүчин зүйлээс хамааран гэрээсээ гадуур үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг.
- ар гэрийн ажлын ачааллыг нөхөр, гэр бүлийн бусад эрэгтэй гишүүд хуваалцдаггүй.

Дэд бүтцийн бэрхшээлүүд

- сургалтын байгууллагууд, ажлын газарт хүүхэд асрах газар байдаггүй;
- сургалт болж буй газар гэрээс хол байдаг;
- эмэгтэй хүн ажилдаа явахад аюулгүй байх хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй.

Бизнесийн бэрхшээлүүд

- бизнес эрхэлж үйл ажиллагааг нь үргэлжүүлэх шаардлагатай ур чадвар хомс;
- эмэгтэйчүүд зах зээл, үйлдвэрлэлийн зах зээлийн талаар мэдлэг багатай байх;
- эмэгтэйчүүд ихэвчлэн тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахдаа зөвхөн эмэгтэй хүн гэдгээсээ хамааран тогтсон үнээр худалдаж авах боломжгүй байдаг;
- зах зээлийн харилцаанд ороход эрэгтэй борлуулагчид, худалдан авагчидтай харилцаа тогтооход хүндрэлтэй байдаг бөгөөд бараа бүтээгдэхүүн түүхий эдийг худалдаж авах үйл ажиллагаанд биечлэн оролцож байнгын хяналт тавих хэрэгцээ гардаг;
- үйлчлүүлэгчид нь шинэ, ялангуяа эмэгтэй үйлдвэрлэгчээс бараа худалдан авахдаа хойрго байдаг;
- эрэгтэй үйлдвэрлэгч нь эмэгтэй үйлдвэрлэгчтэй түнш байхаас татгалзах хандлагатай байдаг.

Байгууллагын бэрхшээлүүд

- сургалтын байгууллагуудын жендерийн асуудалд мэдрэмжгүй хандах хандлага, ядуу эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалт хомс эсвэл хязгаарлагдмал;
- сургалтад хамрагдахад тавигддаг тэгш бус шаардлага.

Цалинтай хөдөлмөр эрхлэлтэд тулгардаг бэрхшээлүүд

- эмэгтэйчүүд нь боловсролгүй, ажил хөдөлмөр эрхэлж байгаагүйн шалтгаанаар цалингийн хөдөлмөр эрхлэлтийн утга учрыг бүрэн ойлгодоггүй;
- цалинтай хөдөлмөрэрхлэлтэд шаардлагатай ур чадвар хомс;
- ихэнх ажил олгогчид эрэгтэй хүнийг ажилд авах сонирхолтой байдаг;
- ажлын байран дах аюулгүй нөхцөл байдал хангалтгүй байх;
- ажлын байрны ойролцоо хүүхэд асрах газар байдаггүй.

Хавсралт 7.3 Эрх тэгш байдал, ядуурлын эсрэг чиг хандлага

(i) Эрх тэгш байдал

Эрх тэгш байдал гэдэг нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүд өөрсдийн хэрэгцээнд нийцсэн зүйлийг авахад хамааралтай шударга, тэгш байхын ерөнхий зарчмыг илэрхийлнэ. Энэ нь тэдгээрт тэгш хандах эсвэл хэдий өөр ч гэсэн тухайн эрх, үр шим, үүрэг, боломжид тааруулан жигд хандахыг хэлнэ. Энэ нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүд яг ижил болно гэсэн үг биш бөгөөд тэдний эрх, үүрэг, боломжийг харгалзсаны үндсэн дээр тэдний ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, сургалтад хамруулж цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг хэлнэ.

(ii) Ядуурлын эсрэг

Хөгжиж буй олон оронд ядуурлыг бууруулах үндэсний стратегийг боловсруулж батлуулсан. Эдгээр стратегиуд нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хангах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Учир нь эдгээр орнуудын хувьд ядуу амьдарч байгаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийн тоотой харьцуулбал байнгын нэмэгдсэн байдаг. Эдийн засгийн хүчин зүйлээс гадна жендерийн харилцаанаас үүссэн эмэгтэйчүүдийн боловсрол, сургалт, үр дүнтэй нөөцийг хэрэглэх боломж хязгаарлагдмал байдаг нь *Ядуурлын Феминизашн* гэх зүйлд хүргээд байна. Ядуурал нь зөвхөн бүтцийн асуудалд бус ядуу иргэдийн шийдвэр гаргах түвшинд мөн авч үзэх шаардлагатай болсон нь илэрхий байна.

Иймд ядуурлын эсрэг чиг хандлага нь эмэгтэйчүүдийг ур чадвартай болгож тэдгээрийн хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх нь илүү үр дүнтэй байна гэсэн байр сууринаас хандаж байна. Учир нь энэ чиг хандлагын хувьд ажилчдын ялангуяа эмэгтэй ажилчдын орлого нэмэгдэх нь тэдний аж амьдралд шууд нөлөөлнө гэж үзэж байна. Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай байгаа ур чадварт эмэгтэйчүүдийг сургах нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн хувьд бие даах байдалд хувь нэмэр оруулна.

(iii).Үр дүн

Эмэгтэйчүүдийн ур чадварыг хөгжүүлэхээс татгалзаж, эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн бололцоог бууруулах нь хүний, санхүүгийн нөөцийн хувьд ашиггүй гэж үздэг байна. Жендерийн тэгш байдлыг хангах нь хүний нөөцийг илүү үр дүнтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ. Ажил олгогчийн хувьд нэгэнт сургалтад хамрагдаж тодорхой ур чадварыг олсон ажилтан авах нь илүү ашигтай бөгөөд шинээр авсан ажилтныг сургах, элдэв нэмэлт зарлага гаргахгүй байх боломжтой.

Техникийн хамтын ажиллагааны төслүүд зорилго, стартегийн хувьд нийгэмд тогтсон хувь хүн, байгууллага, бодлогын хувьд тогтсон хэм хэмжээ, чиг хандлагыг өөрчлөх чиглэлтэй. Аливаа ур чадварыг хөгжүүлэх нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондох ур чадварын ялгааг арилгах чиг хандлага агуулаагүй бөгөөд зөвхөн уг ур чадварын үндсэн дээр жендерийн хооронд гараад байгаа ялгаа, заагийг арилгах, ингэснээр хүний нөөцийг зохистой хэрэглэх, зөв зүйтэй зохион байгуулахын хичээнэ.

Хавсралт 7.4. Жендерийн дүн шинжилгээнд анхаарах зарим асуудал

Жендерийн холбогдолтой судалгаанд хамрагдах зарим чухалчилж авч үзэх шаардлагатай асуудлуудыг дор дурьсан болно. Үүнд:

- Тухайн хүний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг авч үзэхэд 1-ээс дээш боломж эсвэл ажлын байрыг бодолцож үзэж байх нь чухал. Залуу гэрлэсэн эмэгтэй нь гэрийн ажил хийдэг, тодорхой эрхэлсэн ажилгүй бөгөөд ажил хайх, улирлын чанартай газар тариалангийн ажил ч хийдэг байж болно. Өөр бас нэг боломжит хувилбар бол тухайн эмэгтэй өөрсдийн ургуулсан ногооноос борлуулж гэрийн эдийн засагт хувь нэмэр оруулдаг байж болох юм. Иймэ тохиолдолд тус эмэгтэйн нөхөр, хамаатнууд нь тэр ч бүү хэл тэрбээр өөрөө өөрийгөө зөвхөн гэрийн ажил хийдэг гэж бодохын зэрэгцээ, гаднаас харсан хүн “тэр ажил хийдэггүй” гэх бөгөөд энэ нь тухайн өрхийн эдийн засагт хувь нэмэр оруулдаггүй, эдийн засгийн хувьд идэвхигүй гэсэн ойлголт төрүүлдэг. Дээрх жишээнээс харахад олон төрлийн үйл ажиллагаанд зэрэг орж байгаа хүний үйлдлүүдийг нарийвчлалтай хэмжихэд хэцүү байдаг ажээ;
- Судалгааны асуултад хамаатнуудынхаа хамт гэрийн ажилд оролцдог эсвэл гэртээ ажил хийдэг охины талаарх мэдээлэл оруулж үзье. Гэр орны ажил нь тухайн охины боловсрол, сургалтад зарцуулах цагаас ихээхэн хороодог. Өөрийн өрхийн ферм эсвэл газар тариалангийн ажилд цалин хөлсгүйгээр оролцдог хүүхдүүдийн ажлыг мөн хэмжихэд хэцүү. Цалин авдаггүй гэрийн гишүүний хувьд хийсэн ажил ихэнх тохиолдолд ажил гэж тооцогддоггүй. Гэхдээ ажил гэж тооцогддоггүй энэ ажил нь хүүхдүүдийн боловсрол болон сургалтад хамрах боломжоос хороосоор л байдаг;
- Хэрэв охидыг тодорхой төрлийн мэргэжлийн сургалтад хамруулах хэрэгцээтэй эсэхийг түүний эцэг эх, асран хамгаалагч зөвшөөрсөн эсэхээс үл хамааран тэдгээрээс өөрсдөөс нь шууд асууж судалгаанд хамруулж, тэмдэглэх нь зүйтэй;
- Жирэмсний шалтгаанаас, гэрийн ажил, хүүхэд харах шалтгаанаар сургууль завсардсан эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулахдаа ямар учраас ерөнхий боловсрол эзэмшээгүй талаар заавал дурдаж тэмдэглэж байх хэрэгтэй;
- Судалгааны асуулгаас мөн хүүхдүүд ердийн газар тариалангийн үйл ажиллагаанд эсвэл бэлэн мөнгөөр, (зарим хүүхдүүд өөрсдийн хамаатнуудад зөвхөн хоногийн хоол, хоноглох газрын төлөө ажил хийдэг байна.) тэр ч бүү хэл хууль бус үйл ажиллагаанд хутгалдаж, бэлгийн мөлжлөгт өртсөн эсэхийг тодруулахад хүндрэлтэй байдаг;

Залуу хүмүүсээс тэдгээрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар судалгаа авч байгаа тохиолдолд тэднийг хэт залуу, төлөвшөөгүй, өөрсдийн бизнес эрхлэх түвшинд хүрээгүйг анзаардаггүй байна. Зарим тохиолдолд залуу эмэгтэйчүүд бизнес эрхлэнэ хэмээн төлөвлөсөн мөртөө жирэмсэн эсвэл дөнгөж хүнтэй суусан байдаг нь бизнес эрхлэхэд төдийлөн тохиромжтой үе биш юм. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд залуу хүмүүс хэрэгцээтэй ур чадвар эзэмшиж, том хотуудад ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой байдаг. (хөдөө, орон нутагт үлдсэнээс)

Жендерийн талаар дүн шинжилгээ хийхэд тавигдах асуудлууд

Асуултууд	Зорилт
1. Хэн юу хийдэг вэ? Хэний төлөө?	Үйл ажиллагаа
2. Хэрхэн?	Ямар утгаар
3. Тэдгээрийг хэн эзэмшдэг вэ?	Эх үүсвэр
4. Хэнд юу хамааралтай вэ? Хэн юуг хянадаг вэ?	Эрх мэдэл
5. Хэн юуг хариуцдаг вэ?	Хариуцлагатай байдал
6. Хэн юу оруулдаг вэ?	Орлого
7. Хэн юуг зарцуулдаг вэ?	Зарлага
8. Хэнд юу ноогддог вэ?	Эрх /норм
9. Хэн юунаас таашаал авдаг вэ?	үр нөлөөл
10. Хэн хожиж, хэн нь алддаг вэ?	

Хавсралт 7.5 Бангладешийн чадавхжуулах хөтөлбөрийн хүрээн дэх Жендерийн эрхийг хамгаалах орон нутгийн оролцоонд суурилсан сургалтын төсөл: Зохион байгуулагч болон түнш байгууллагууд, орон нутгийн багуудын жендерийн талаарх мэдлэг, нөлөөллийг нэмэгдүүлэх

Техникийн хамтын ажиллагааны байгууллагын хөгжлийгнэмэгдүүлэхгэдэгчигхандлагынбүрэлдэхүүн хэсэгт тухайн байгууллагын жендерийн эрх тэгш байдалд хандах хандлага, чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа эсэхийг судалж үзэх хэрэгтэй. **Зарим байгууллагуудын хувьд эмэгтэйчүүдийн эсрэг үйл ажиллагаа нь эрэгтэйчүүдийн нийгэм дэх тогтвортой байр суурийг хамгаалах гэсэн чиг хандлагатай байдгийг санаж байх нь зүйтэй.** Жендерийн асуудлын хувьд дундыг баримталсан сургалтын, төрийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөр эрхлэлтийн газрууд нь жендерийн харьцааны тогтвортой байдлыг алдагдуулж, улмаар тэр нь жендерийн тэгш бус байдлыг бий болгодог байна. Байгууллагын дотоод албан болон албан бус үнэт зүйл, хэм хэмжээ, дүрэм журам нь жендерийн эрх тэгш байдлыг дэмжихэд саад тотгор болдог. Тухайн байгууллагын жендерт хандах хандлагын бүрэн тодорхойлоогүй тохиолдолд төслийн үйл ажиллагаа төлөвлөсний дагуу явагдах боломжгүй юм.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн оролцогч тал бүр жендерийн асуудалд анхаарал хандуулж, хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ оролцогч болгонд ижил төрлийн шаардлага тавигдахгүй. (зарим байгууллагын жендерийн асуудлыг тодорхойлох ур чадвар бусад өөр байгууллагынхтай харьцангуй адил, зарим байгууллагын хувьд жендерийн асуудлыг илүү анхаарах шаардлагатай байх, зарим хүмүүсийн хувьд уг асуудлын хувьд мэдрэмжтэй хандаж ерөнхий чиг хандлагыг баримталж байхад хангалттай).

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн уг асуудалд баримтлах чиг хандлага нь тухайн хөтөлбөр бүрийн оролцогч, хэрэгжилтийн явцаас хамаарах бөгөөд үүнд, ОУХБ –ын ажиллагчид, ХЭЗЧДС-ын зөвлөлийн гишүүд, төрийн байгууллагын төлөөлөл, ТББ, ажил олгогчид, ажилчдын байгууллагууд, хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид, нийгэм, соёлын, улс төрийн нөхцөл байдал орно.

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийн үр шимийг хүртэхийг дэмжихэд таатай орчинг бүрдүүлэхийн тулд жендерийн талаарх мэдээлэл болон нөлөөллийг сайжруулах нь хөтөлбөрийн жендерийн асуудалд баримтлах бодлого юм. Үүний тулд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд (ХЭЗЧДС-ын зөвлөлүүд, орон нутгийн багууд, зорилтод бүлгүүд) -ын түвшинд жендерийн асуудалд эергээр хандах хандлагыг бий болгох хэрэгтэй. Ялангуяа ХЭЗЧДС-ын ур чадварын сургалтыг жендерийн мэдрэмжтэйгээр зохион байгуулах нь чухал. Гэхдээ жендерийн тэгш байдлын талаарх бодлогыг хэрэгжүүлэх нь нэг удаагийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тогтмол хийгдэхийн зэрэгцээ тухайн орон нутгийн нөхцөл байдалтай зохицуулах хэрэгтэй.

Бангладешт ХЭЗЧДС-ын *төслийг* хэрэгжүүлэх явцад жендерийн талаарх мэдээлэл болон нөлөөллийг сайжруулах үйл ажиллагаа тогтмол хийгдэж байсан байна. Үүнд:

Орон нутгийн дэмжлэгийн багууд (орон нутгийн зөвлөл, нийгмийн ажилтнууд, бусад холбогдох ажиллагчид)-ад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах

Сургагчийн сургалтад уг асуудлыг тусгайлан тусгаж, орон нутгийн баг, сургагчдын дунд “Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг” –ийг бүрдүүлэх

Суралцагч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд жендерийн асуудлаар сургалт зохион байгуулах

Эмэгтэйчүүд, эрэгтэй хамтаатнууд, оршин суугаа суурин газрын иргэдийг хамруулсан жендерийн талаарх мэдээлэл, нөлөөлөлийн талаарх сургалтыг зохион байгуулах

1. Орон нутгийн дэмжлэг үзүүлэх багт зориулсан танилцуулах сургалт (Орон нутгийн ХЭЗЧДС-ын зөвлөлийн гишүүд, нийгмийн идэвхтнүүд, бусад холбогдох хүмүүс)

Орон нутгийн ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зөвлөлийн гишүүд, зарим тохиолдолд орон нутгийн идэвхтнүүд, зорилтод бүлгүүдийг хөтөлбөрт идэвхтэй оролцох тал дээр зонхилох үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр хүмүүс нь оролцогч, тухайн орон нутгийн ард иргэдтэй ойр ажилладаг бөгөөд эдгээрийг чадваржуулах асуудал чухлаар тавигддаг. Эдгээр хүмүүс нь шинэ зах зээлд чиглэгдсэн сургалтын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн оролцоог хангахад шаардлагатай гэр бүл, нутгийн оршин суугчдыг ухуулах хөтөлбөрийн зорилтыг таниулах ажлыг зохион байгуулах боломжтой юм. Эдгээр нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн нөлөөллийг тэлэхэд тус нэмэр болох бөгөөд тэдэнд зориулж, тусгайлсан сургалтыг зохион байгуулах шаардлагатай. Сургалтын хөтөлбөрт дараах сэдвүүдийг оруулж болно.

- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зорилго болон үйл ажиллагааны талаар;
- ХЭЗЧДС-ын арга зүй дэх жендерийн асуудал, түүнд хандах зарчим;

- орон нутгийн иргэд, зорилтод бүлгийн ар гэрийнхнийг идэвх санаачлагатай байлгах;
- орон нутагт суурилсан албан бус сургалтын чиг хандлага;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэдгээрийн оруулах хувь нэмэр;
- хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,(жендерийн холбогдолтой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нь хамаарна);

Нийгмийн идэвхтнүүд

Туршлагаас үзэхэд энэхүү сургалтын дараа нийгмийн идэвхтнүүдийн ХЭЗЧДС-ын арга зүйн талаарх мэдлэг мэдэгдэхүйц өссөн байна. Тэдгээр нь оролцогчид, оролцогч эмэгтэйчүүдийн гэр бүл, нутгийн иргэд, тосгоны оршин суугчдад уг хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй хандах хандлагыг бий болгох боломжтой. Практик дээр тэд илүү ур чадвартай болсон бөгөөд гэр бүлийн асуудлыг зохицуулж, нутгийн удирдлагуудтай зуучлах боломжтой болжээ.

2. Орон нутгийн дэмжлэгийн баг, сургагчдад зориулсан жендерийн талаарх сургалт

Ажлын байран дээрх жендерийн талаарх асуудлыг хэрэв эмэгтэйчүүд нь хувираа хөдөлмөр эрхэлдэг бол орон нутгийн хэмжээнд, цалинтай хөдөлмөр эрхэлдэг бол ажлын байран дээр нь тусгайлан сургалт зохион байгуулах нь зүйтэй бөгөөд зохион байгуулагч байгууллага, бусад түнш байгуулагуудын идэвхитэй оролцоог хангах талаар тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй.

Иймд “Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг” –ийг шаардлагатай ур чадвар, чадамжаар хангаж, тодорхой төлөвлгөөний дагуу “А*жлын байр болон жендерийн асуудал”* сэдвээр оролцогч эмэгтэйчүүдэд зориулж зохион байгуулах хэрэгтэй. Ингэхийн тулд сургагч нарыг сургах хандлагыг мөн боловсруулах хэрэгтэй.

Жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын баг

Бангладешт сургагчийг сургах хөтөлбөрийг тусгайлан зохион байгуулсан нь жендерийн асуудлаарх үндсэн сургагчдын багийг шаардлагатай ур чадвар, арга зүйгээр хангахад чиглэгдсэн байсан бөгөөд үүний үндсэн дээр дагуу “А*жлын байр, жендерийн асуудал”* сургалтыг сургалтад хамрагдагч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хийсэн байна. Сургагчдийн сургалтын явцад сургагчдад ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн асуудалд хандах хандлага, бодлогын талаар дэлгэрэнгүй тайлбарлан таниулсан байна. 11 өдөр үргэлжилсэн сургалтад 30 гаруй сургагч нар оролцсон байна. Эдгээр сургагч нар нь гарын авлагыг ашиглан сургалтад хамрагдагчдад жендерийн талаарх мэдлэг, нөлөөллийн асуудлын талаар хичээл орсон байна. Үүнд:

- ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн жендерийн асуудалд хандах чиг хандлагыг мэдэж байх;
- уг асуудлаар албан бус сургалтыг зохион байгуулах арга зүйн мэдлэг, ур чадвартай байх;
- жендерийн талаарх мэдлэг, уг асуудлаар ажлын байрны нөхцөл байдлын талаар зорилтод бүлгүүдэд зориулсан хичээл явуулах ур чадвартай байх;
- сургалт явуулахад зориулагдсан сургалтын гарын авлага, бусад материал, аудио, видео үзүүлэнгүүдийн ашиглах;
- сургалттай холбогдох тайлангуудыг бичих;
- зорилтод оролцогчдын дунд жендерийн асуудал хэр байгаа талаар дүн шинжилгээ хийх, сургалтын явцад, сургалтын дараа жендерийн асуудлаар тусгайлан хичээл заах ур чадвартай болох,

3. Сургалтад оролцож буй эмэгтэй эрэгтэйчүүдэд жендерийн талаар мэдлэг олгох

Сургагчийн сургалтад хамрагдсан сурагч, орон нутгийн дэмжлэг үзүүлэх багийн гишүүд нь сургалтад хамрагдагч эмэгтэйчүүд,эрэгтэйчүүдэд жендерийн асуудлаар сургалт явуулна. Бүх эмэгтэй оролцогч нь 2-3 өдрийн жендерийн сургалтад бүрэн хамрагдах бөгөөд уг сургалт нь тэдгээрт жендерийн талаар мэдлэг олгохын зэрэгцээ цаашид ажил хөдөлмөр эрхлэхэд өөртөө итгэлтэй байх ур чадварыг мөн олгоно.

ХЭЗЧДС-ын туршлагаас үзэхэд ур чадварын сургалттай зэрэгцүүлэн бие дааж ажиллах чадвар, өөртөө итгэлтэй байх, бизнесийн сургалтуудыг зохион байгуулах нь тэдний цаашдын үйл ажиллагаанд хувь нэмэр болох, цаашдын амжилтанд нь нөлөөлдөг.

4. Зорилтод эмэгтэйчүүдийн нөхрүүдэд зориулсан жендерийн талаарх

Эмэгтэй сургалтад оролцогчдын амжилттай сургалтад хамруулахын тулд тэдний эрэгтэй хамаатнуудыг хөтөлбөрийн үйл ажиллагаанд татан оролцуулах нь чухал юм. Үүнийг олон нийтийг хамарсан уулзалт зохион байгуулах хэлбэрээр хийж болно. Ихэвчлэн дээрх төрлийн уулзалтуудын зорилго нь хөтөлбөр, түүний зорилго, үйл ажиллагааны талаар танилцуулах, сурталчилах зорилгоор хийнэ.

Мөн дээрх уулзалтын явцад сургалтад оролцогч эмэгтэйчүүдийн эрэгтэй хамаатнууд, ар гэрийнхэнд эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохын ач холбогдол, тэдгээрийн ар гэрээс тодорхой дэмжлэг үзүүлэх хэрэгтэй талаар сурталчилна. Түүнчлэн уг уулзалтын үеэр орон нутгийн иргэд, удирдлагын зүгээс тодорхой хэмжээний дэмжлэг байх нь хөтөлбөрийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нөхцлүүдийн нэг болно гэдгийг тайлбарлан таниулна.

Орон нутгийн хэмжээнд тайлбарлан таниулах үйл ажиллагааг явуулж байгаа тохиолдолд аливаа нэг орон нутгаас уг үйл ажиллагаа хэрхэн болсон талаар саналыг нь авч, дараа дараагийн ийм төрлийн үйл ажиллагаанд тусгана. Туршлагаас харахад сургалтын материалыг бэлдэж, дэмжигчдэд тарааж, урьдчилсан байдлаар тухайн үйл ажиллагаа явагдах газарт хүргүүлсэн байна.

Хавсралт 7.6. “Ажлын байр ба жендерийн асуудал” гарын авлагаас (Бангладешийн туршлагаас)

Сургалтын хөтөлбөрийн загвар, сургалтын агуулга

Сургалтын хөтөлбөрийн нэр нь *Жендер, хөгжил.*

Сургалтын хөтөлбөр *нь Жендерийн талаарх мэдлэг, Ажлын байрны орчин* гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэгдүгээр хэсэг:

- ☐ орон нутгийн сургалтын зарчим, арга зүй;
- ☐ хөгжлийн зарчим ба хөгжлийн үзүүлэлт;
- ☐ жендерийн зарчим ба секс, жендерийн ялгаа;
- ☐ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгэм дэх хөдөлмөрийн хуваарилалт;
- ☐ нийгэм дэх жендерийн үүрэг солигдож байгаагийн шалтгаан;
- ☐ жендерийн үүргийг эрх тэгш байлгах стратеги;
- ☐ нийгэмших үйл явц дах жендер;
- ☐ жендерийн хэрэгцээ (практик, стратегийн хэрэгцээ);
- ☐ төрөл бүрийн зорилт, асуудлуудад нийцүүлэх нь / хувиараа хөдөлмөр эрхлэх, төрөл бүрийн мэрэгжил дэх жендерийн асуудал/;

Хоёрдугаар хэсэг.

- ☐ эрх тэгш боломжийн бодлого: олон улсын болон үндэсний хэмжээнд;
- ☐ Бангладешийн хөдөлмөрийн хууль ба үйлдвэрлэлийн хууль;
- ☐ ажлын байранд дах аюулгүй байдал;
- ☐ гэр бүлд, ажлын байранд хэрхэн шийдвэр гаргах;
- ☐ хэрхэн өөртөө итгэлтэй байх вэ?
- ☐ өөртөө итгэлтэй байдлыг ажил дээр хэрэглэх нь;
- ☐ мэргэжлийн өвчин, аюулгүй байдал;
- ☐ ДОХ;
- ☐ зохион байгуулах: үйлдвэрчний эвлэл, тэдгээр нь эмэгтэй ажилчдын төлөө юу хийж чадах вэ?

Нэгдүгээр хэсэг- ур чадварын сургалтын эхэнд бүх суралцагчдад зориулж зохион байгуулна.

Хоёрдугаар хэсэг- ур чадварын сургалтын сүүл хэсэгт зохион байгуулах бөгөөд зөвхөн цалинтай хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэгдэж байгаа Суралцагчдад хамаатай. Өөртөө итгэлтэй байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, шийдвэр гаргалт гэх мэт холбогдох сэдвүүд нь хувиараа хөдөлмөр эрхлэх эмэгтэйчүүдэд ч хамаатай. Зарим эмэгтэйчүүд цалинтай хөдөлмөр эрхлэлтээс хувиараа хөдөлмөр эрхлэх шийдвэр гаргах тохиолдолд тэд сургалтад хамрагдаж болно.

Хавсралт.7.7. Жендерийн асуудалд дундыг баримтласан мэдээлэл, жендерт хандсан мэдээллийг харьцуулах

Жендерийн асуудалд дундыг баримтласан мэдээллийг жендерт хандсан мэдээлэл болгох боломжийн талаар дор дурьдах болно.

Мэдээлэл...	Жендерийн асуудалд дундыг баримталсан мэдээлэл	Жендерт хандсан мэдээлэл болгохын тулд:
Тухайн нутгийн хүмүүсийн нөхцөл байдал.	Мэргэжил, ажил, боловсрол, бичиг үсгийн түвшин, анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээнд хүрэх боломж, хөрөнгө, орлого, хадгаламж, ашиг, эрхийн тоо, өрхүүдийн хэмжээ, тусгаарлагдсан бүлгүүд	○ Хүйсийн хувьд ялгарварлан гадуурхагдсан хүмүүсийн мэргэжил, ажил, эрүүл мэндийн үйлчилгээ, хэн хөрөнгийн эзэмшдэг вэ?, хэн тухайн орон нутагт орлоготой, хадгаламж болон ашиг, боловсрол, бичиг үсгийн түвшин, анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээнд хүрэх боломж, хөрөнгө, орлого, хадгаламж, ашиг, өрхийн тоо, өрхүүдийн хэмжээ, ганц бие өрхүүд, яс үндэс эсвэл соёлын хувьд бусдаас хязгаарлагдсан ...
Тухайн орон нутагт хэн ажил хийдэг вэ?	Цалингийн хөдөлмөр эрхлэлт, хувиараа эрхлэх хөдөлмөр, машин техникийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, хөдөлмөр, тээвэр, зах зээл гэх мэт	○ Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн хуваарилаж хэнд юу ноогдуулсныг тодорхойлох, өрх доторх өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах үүрэг хариуцлага, өрх эсвэл жижиг хэмжээний үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл, зах зээл, цалинтай хөдөлмөрэрхлэлт
Нөөцийн хүртээмжтэй байдал...	Зээл, тоног төхөөрөмж, газар, ус, судалгаа, боловсрол, сургалт	○ Албан, албан бус зээл, тоног төхөөрөмж, газар ус, судалгаа, боловсрол, сургалтын бололмж зэрэгт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн алинд нь илүү хүртээмжтэй байдаг вэ?
Тухайн нутгийн хүмүүст учирч буй саад бэрхшээлүүд	Санхүүгийн, зээлийн, бичиг үсгийн, технологийн, сургалтын	○ Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд учирдаг өөр өөр бэрхшээлүүдийг тогтоох. Үүнд: Цаг, чөлөөтэй хөдлөх боломж, санхүү, зээл, барьцаа, бичиг үсгийн мэдлэг, хөрөнгийн өмчлөл, технологи, сургалт дутагдах, гэр бүлийн хариуцлага, соёлын, шашины хязгаарлалтууд
ОУХБ —ын төслийг хэрхэн хөгжүүлж, эерэг үр дагаврыг нэмэгдүүлж, сөрөг үр дагаврыг багасгах вэ?	Өмнөх болон одоо хэрэгжиж буй төслийн үр нөлөө, саяхан болсон өөрчлөлтүүд (тухайлбал орлогыг багасгасан эсвэл байхгүй болгосон, эдийн засгийн хямралууд)	○ Сүүлийн үед хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа ОУХБ-ын төсөл эсвэл бусад доноруудаас хэрэгжүүлсэн төслүүд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн, саяхан болсон үйл явдлууд нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн орлого / алдагдалд хэрхэн нөлөөлсөн ○ Шинэ ур чадвар, шинэ технологийг нэвтрүлсэн нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн нь ○ Өмнө хэрэгжиж байсан төслүүд нь эрэгтэйчүүд,эмэгтэйчүүдийн ажлын ачаалал, гэр бүлийн хариуцлага зэрэгт хэрхэн нөлөөлсөн

Хавсралт 7.8. Жендер ба ур чадварын судалгааны тайлан

Шалгуур	Тйим	Үгүй	Зарим тохиолдолд	Хангалттай мэдээлэл байхгүй	Хариулах боломжгүй	Тайлбар
Дээрх баримт бичигт жендерийн эрх тэгш байдлын асуудлыг тодорхойлон дурьдсан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Жендерийн эрх тэгш байдлын тухай дурьдсан байдлыг та хэлбэрийн төдий гэж үзэж байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Дээрх баримт бичиг нь зөвхөн:	☐	☐	☐	☐	☐	
Эмэгтэйчүүдийн тухай	☐	☐	☐	☐	☐	
Эрэгтэйчүүдийн тухай	☐	☐	☐	☐	☐	
Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн жендерийн харилцааны тухай	☐	☐	☐	☐	☐	
Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусгаарлаж хандах асуудал дээр анхаарал хандуулсан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Дээрх баримт бичиг нь жендерийн чиг хандлага, жендерийн эрх тэгш байдал гэх зарчмуудыг тодорхой тайлбарласан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичиг нь хүйсээр ялгаварлан гадуурхсан шинжиийн мэдээлэлийг агуулж байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Хүйсээр ялгарварлан гардуурхсан баримтын талаар аливаа зөвлөмжийг тодотгож тусгасан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичиг нь жендерт мэдрэмжтэй үг хэллэгийг хэрэглэсэн байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичиг нь эмэгтэй суралцагчийн талаар жишээ авсан эсвэл эмэгтэйчүүдэд хамааруулан амжилттай хэрэгжүүлсэн зүйлийн талаар дурьдсан байна уу? (эрэгтэйчүүдийн талаар мөн адил)	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичиг нь сургалтын санаачилга эрэгтэйчүүд, эмэгтэйдэдчүүд өөр өөр үр нөлөө үзүүлж байгаа талаар дурьдсан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичиг нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл бодлогыг тусгасан байна уу?	☐	☐	☐	☐	☐	
Баримт бичигт жендерийн эрх тэгш байдлын асуудлыг зөвхөн “нэмэлт” маягаар дурьдсан байна уу? эсвэл холбогдол бүхий зайлшгүй шаардлагатай зүйл гэсэн байна уу?	☐	☐	☐	☐	☐	

VIII

Оршил. I.Ерөнхий мэдээлэл, бэрхшээлүүд . II.Эрх болон хөгжлийн бэршээл
III. Ур чадварын сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс.
IV. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үе шат бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах. Хавсралтууд

ХЭЗЧДС-д хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах

Оршил

Орон нутаг бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг бөгөөд зорилтод бүлгүүд: эмэгтэйчүүд, залуу хүмүүс эсвэл ахмад дайчид байдаг бөгөөд эдгээрийн дунд ч мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд байда. Хөгжлийн бэрхшээл бол бодит байдал. Хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй төрдөг, эсвэл амьдралыг эхний үед эсвэл нас бие гүйцсэн хойноо өвчин, ажил, осол, дайн болон бусад хүчин зүйлээс болон хөгжлийн бэрхшээлтэй болдог. Зарим газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо бусдаасаа илүү их бөгөөд, үүнд амин дэмийн дутагдал, нэн ядуурал, гамшиг, зэвсэгт мөргөлдөөн болон бусад шалтгаануд нөлөөлдөг байна. Хөгжиж байгаа орнуудын хувьд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ойролцоогоор 80 хувь нь хөдөө амьдардаг байна. Бүх орнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь ядуу байхын зэрэгцээ нийгмээс гадуурхагдсан байдаг. Эдгээр иргэдийн олонх нь хөдөлмөр эрхэлдэг, жижиг үйл ажиллагаа явуулдаг эсвэл орлого бий болгох үйл ажиллагааг эрхэлдэг байна, гэхдээ сая сая нь ажил олох боломжгүй бөгөөд байнгын хүндрэл бэрхшээлүүдтэй нүүр тулдаг байна. ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хөгжлийн бэршээлтэй хүмүүсийг хамруулснаар тэдгээрт тулгарч буй бэрхшээл хүндрэлүүдийг жаахан ч гэсэн хуваалцах зорилго агуулж байгаа юм.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн ажилтан нь энэ талаар тодорхой мэдлэгтэй байх хэрэгтэй бөгөөд учир нь ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь нийгмээс ялгарварлан гадуурхагдсан иргэдэд хандсан үйл ажиллагаа явуулдаг тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй тулж ажиллах нь гарцаагүй. Жишээ нь, хэрэв зорилтод бүлэгт сургууль төгссөн залуу эмэгтэйчүүд байхгүй бол оронд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болох олноор нь хамруулах хэрэгтэй юм. Дайнд оролцогчдын зорилтод бүлэгт мөн олон тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусад нь зорилтод бүлэг болгох боломжийг бодолцох нь зүйтэй. Гэхдээ уг асуудалд маш болгоомжтой хандах хэрэгтэй, тусад нь бүлэг болгоно гэдэг нь тэдгээрийг бусдаас тусгаарласан гэсэн ойлголт төрүүлэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгай үйлчилгээ шаардлагатай гэсэн илэрхийлэл болгох магадлалтай. Тэдэнд тусгай үйлчилгээ төдийлөн шаардлагагүй. Тэдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүсүүсийг ерөнхий зорилтод бүлэг оруулан сургалтад хамруулах нь хамгийн зөв зүйтэй алхам юм. Мөн хүний эрхийн талаасаа ч гэсэн боломжтой бүх үйл ажиллагаанд оролцож байх ёстой. Үүнийг дор тусгайлан тайлбарлах болно.

Зарим ХЭЗЧДС-ын байгууллагууд, хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах нь шинэлэг байж болох бөгөөд харин бусад байгууллагуудын хувьд тэдгээр нь өмнө нь тодорхой төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан байж болох юм. Ажлын дадлага туршлагаас гадна хөтөлбөрийг төлөвлөж байгаа хүмүүс болон сургагч нар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад иргэдтэй адил сургалтад хамрагдаж хөдөлмөр эрхлэх эрхтэй гэдгийг ойлгосон байх хэрэгтэй. Мөн зарим тохиолдод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгай тоноглол, дэмжлэг

үзүүлж байх хэрэгтэй гэдгийг мартаж болохгүй. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлтийн, оролцооны, түншлэлийн зарчимд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах чиг хандлагыг зохистойгоор баримтлаж байх нь чухал. Дээрх зорилтод хүрэхийн тулд сургалтын үйл ажиллагааг төлөвлөх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг бодолцсон байх хэрэгтэй. Төлөвлөлт нь холбогдох ажиллагчид, сургагч нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах, тэдгээрт холбогдсон нөхцөл байдлыг бүрэлдүүлэх зэрэгтэй холбогдох нэмэлт зардлыг тооцсон байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад оролцогчдын адил ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үе шат бүрт оролцуулж байх чухал. Эцэст нь бусад байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох үйл ажиллагаа эрхэлдэг бүлгүүдийн тусламжтайгаар шаардлагатай мэдлэг болон нөөцийн дутагдлыг нөхөж болох юм. Энэ бүлгийн хавсралт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хандахад хэрэг болох арга хэрэгсэл, зааварчилгааг дэлгэрэнгүй хавсаргасан. Энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлийн талаарх тодорхой мэдээлэл, зарчим, зааварчилгаа өгөгдсөн байх бөгөөд үүнийг ХЭЗЧДС-ын үе шат бүрд даган мөрдөж байх хэрэгтэй.

I. Ерөнхий мэдээлэл болон бэрхшээлүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өвөрмөц бүлэг юм. ОУ-ын Эрүүл мэндийн байгууллагын үзэж байгаагаар дэлхийн хүн амын ойролцоогоор 12 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй. Энэ нь дэлхийн хэмжээнд 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа гэсэн үг бөгөөд эдгээрээс 470 сая нь хөдөлмөр эрхлэх насных. НҮБ- нь хүн амын 10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх боловч хөгжиж буй олон оронд нийт хүн амын 17-20 хувь нь ямар нэгэн хэлбэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэсэн тоо бий. Түүнчлэн НҮБ-ын үзэж байгаагаар нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ойролцоогоор 80 хувь нь хөгжиж буй орнуудад амьдардаг бөгөөд тэдний ядуурлын доод түвшинд амьдардагийн зэрэгцээ дэлхийн ядуу хүмүүсийн 20 хувийг эзэлдэг байна. Ядуурал,хөгжлийн бэрхшээл нь холбоотой байдаг. Учир нь хөгжлийн бэрхшээл нь дорой байдлыг дагуулдаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалтад суух, хөдөлмөр эрхлэх боломж олгосноор хөгжлийн бэрхшээл болон ядуурлын харилцан хамаарлыг эвдэж болох юм. Энэ нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн нэг суурь бөгөөд ядуурал, нийгмийн эмзэг байдлыг ур чадварыг бий болгосноор арилгах, ялангуяа хөдөө орон нутагт байгаа ядуурлыг устгах нь чухал бөгөөд дээр дурьдсанчлан хөгжиж буй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнх нь хөдөө орон нутагт амьдардаг гэдгийг мөн бодолцох хэрэгтэй. Өргөн утгаар хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөтөлбөрт хамруулах нь тэдгээрийн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг дээшлүүлж, бусад тус дэмжлэг үзүүлэх, нийгмийн амьдралд татан оролцуулахад оршино. Энэ нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ширээнд урих”-аас илүү зүйл бөгөөд тэдгээр нь ширээнд уригдаж сууснаар өөртөө тулгарч буй саад бэрхшээлүүдийг шийдвэрлэх боломжийг олгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг бэрхшээл олон төрөл байх бөгөөд энэ нь тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн мөн чанараас хамаардаг байна. Хөгжлийн бэрхшээлүүд нь:

- Физиологийн (тулгуур эрхтний болон хөдөлгөөний);
- Мэдээлэл болон харилцааны (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сургалтад зориулсан формат болон чиг хандлага байдаггүй);
- Бодлогын болон эрх зүйн (хууль тогтоомж болон бусад зохицуулалтын дутмаг байдал);
- Байгууллагын (бодлогын хэрэгжилт болон хүний нөөцийн дутмаг байдал);
- Зан байдлын (сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалт).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулахад тулгарч буй саад нь яваандаа эрх тэгш бус жендерийн харилцааг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй охид бүсгүйчүүдийг боловсрол, сургалт болон хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд, хөвгүүдээс эсвэл бусад иргэдээс дорд үзэх байдалд хүргэдэг байна.

ХЭЗЧДС-ын зохион байгуулагчид, ажиллагчид, түнш байгууллагуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлага, тэдэнд учирч болзошгүй саадуудыг урьдчилан тооцож, шийдвэрлэх арга замыг олсон байх нь чухал. Тухайн хүний хөгжлийн бэрхшээлтэй байдлыг ойлгож саад тотгорыг арилгасан байх нь түүнийг сургалтад хамрагдахад нэг алхам ойртуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж хэн бэ?

ОУХБ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дараах байдлаар тодорхойлсон: физиологийн болон оюун санааны дутагдлаас чадвар нь үлэмж хэмжээнд багассан гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн шалтгааны улмаас тодорхой хөдөлмөр эрхлэлтэд шаардагдах нөхцлийг хангах боломжгүй хүнийг хэлнэ. (ОУХБ-ын Мэргэжлийн Нөхөн Сэргээлт болон Хөдөлмөр Эрхлэлтийн Конвенц(Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, (№159), 1983).

НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Конвенцид: Удаан хугацааны физиологийн, оюун санааны, сэтгэхүйн эсвэл мэдрэмжийн дутагдлаас болон өөрсдийн бүрэн хүчин чадлаар нийгмийн амьдралд бусадтай адил эрх тэгш байдлаар оролцох боломжгүй гэж тодорхойлсон байна. (НҮБ-

ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Конвенцийн Нэгдүгээр зүйл).

Улс орон бүр хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох өөрийн гэсэн тодорхойлолттой байдаг бөгөөд энэ нь тухайн шаардлага зорилгоосоо хамааран олон төрлөөр тодорхойлогдох боломжтой байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй байдлын хэмжигдэхүүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүлэг болгон ерөнхий байдлаар тодорхойлох боломжгүй юм. Эдгээр нь тус бүртээ бусад хүмүүстэй адил өөрийн гэсэн онцлогтой. Тэдгээр нь хөгжлийн бэрхшээлээс хамааран тодорхой нийтлэг зүйлтэй байдаг. Тэдгээртэй ажиллах тохиолдолд тэд нь хязгаарлагдмал байдлыг зөв тодорхойлох нь чухал бөгөөд энэ талаар дор дурьдсан болно.

1. Хөгжлийн бэрхшээлтэй байдлын төрөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийг тухайн бэрхшээлтэй байдлын трөлөөс хамааран олон янзаар ангилж болно. Хавсралт 8.2.-т тодорхой төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай сургалтын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийн талаар дэлгэрэнгүй зөвлөмж өгсөн болно.

2. Хөгжлийн бэрхшээлийн зэрэг

Хөгжлийн бэрхшээлийн зэрэг нь мөн анхаарал хандуулж бодолцох шаардлагатай асуудлын нэг юм. Мэдээж тодорхой хэмжээний гэмтэл бэртлийн улмаас хүн дунд зэргээр хөдөлгөөний чадвараа алдсан байж болох ч энэ нь түүнийг ажил эрхлэх эсвэл суралцах нөхцөл байдалд нөлөөлөхүйц нөхцөл биш байж болох бөгөөд эдгээр хүмүүсийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрт хамруулахад төдийлөн асуудал гарахгүй. Зарим хүмүүс нуруу нугасны гэмлээс болж биеийн доод хэсэг нь хөдөлгөөнгүй болоход хүрсэн байдаг. Ийм тохиолдолд тэдэнд зориулсан тусгай тоноглол, тоног төхөөрөмж, суралцах орчин, ажлын байр шаардлагатай байх болно. Сэтгэхүйн болон оюун санааны төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд сургалтын өөр орчин, арга зүй, нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг.

3. Төрөлхийн

Зарим хүмүүс төрөхөөс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй байдаг бөгөөд заримынх нь хүүхэд насанд, заримынх нь насанд хүрсэн хойно нь илэрдэг байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээл нь өөрийн гэсэн онцлогтой байдаг. Жишээ нь, зарим нь гаргүй байх бөгөөд ийм тохиолдолд ихэвчлэн тухайн нөхцөл байдалд зохицон өөр эрхтэнээр түүнийг оруулах чадвартай байдаг. Харин насанд хүрсэн хойно гараа алдвал түүндээ зохицохын тулд нэлээн удаан хугацаа шаардах болно. Төрөлхийн хөгжлийн бэрхшээл нь тухайн хүнд их дарамт болох бөгөөд амьдрал өөрчлөгдөхөд мэдрэмжтэйгээр хүлээж авна.

4. Харах эрхтний бэрхшээл

Зарим хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийг хараад мэдэх боломжтой эсвэл мэдэгдэхгүй байдаг. Жишээ нь: тэргэнцэрт сууж байгаа эсвэл хараагүй хүнийх бол илт мэдэгддэг. Харин татаж унадаг, ухаан алддаг хүнийх бол унасан эсвэл ухаан алдсан тохиолдолд мэдэгддэг. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тусгайлсан тоноглолыг шаарддаггүй. Гэхдээ ихэнхийнх нь тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрөл болон түвшнөөс хамаарахын зэрэгцээ тэдгээр нь ямар төрлийн мэргэжлийн сургалтад хамрагдаж буйгаас хамаарна. Сургалтыг зохион байгуулагч сургагч нь тэдэнд шаардлагатай туслалцааг үзүүлэхэд бэлэн байх ёстой.

II. Хөгжлийн бэрхшээл ба хүний эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусадтай адил иргэд байдаг. Тэдгээр нь бусадтай л адил төрөхдөө ижил тэгш эрхтэй төрдөг. Гэхдээ өнгөрсөн хугацаанд тэд бусадтай адил эрх эдэлж чаддаггүй байсан. Мөн одоо ч зарим тохиолдолд эрхээ эдэлж чадахгүй байгаа. Учир нь тэдгээрийн бусдын адил эрх тэгш сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагдмал байдаг. ХЭЗЧДС-ын гүйцэтгэгч байгууллагууд нь тухайн орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах эрх зүйн зохицуулалтыг нарийн судлахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст холбогдох олон улсын стандартыг баримталж байх нь чухал.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлагад гарч буй өөрчлөлтүүд

Сүүлийн жилүүлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлагад мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гарсан. Зарим тохиолдолд тэдгээрийг өрөвдсөн байдал илэрхийлэгдэж эхэлсэн. Гэхдээ зарим орнуудад тэдгээр асуудалд бодитойгоор хандаж, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, нийгмийн хамгааллыг нь сайжруулах, нийгмийн зүгээс тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хандлага ч мөн анзаарагдаж байна. Гэвч тэдэнд зориулагдсан сургалт, боловсролын арга хэмжээнүүд нь маш хязгаарлагдмал, явцуу хүрээнд явагдаж байгаагийн зэрэгцээ санхүүжилтийн хувьд хангалтгүй байна. Барууныг чиглэсэн чиг хандлага хэмээх олон улсын норм нь нийгэмд суурилсан загвар юм. Энэ загварын гол санаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа саад, бэрхшээлүүдийн гол шалгаан нь тухайн хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй байдал бус харин нийгмийн харилцааны буруу тогтолцооны үр дүн гэж үздэг байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад болж буй эдгээр бэрхшээлүүдийг арилгасан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийгмийн бусад гишүүдийн адил нийгмийн амьдралд бүрэн оролцож, өөрсдийн хувь нэмрийг нийлүүлэх боломжтой болох байна.

Олон Улсын стандарт

ОУХБ-ын бүх стандартууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд,эрэгтэйчүүдэд хамааралтай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтад хамруулах үзэл баримтлал нь ОУХБ-ын Мэргэжлийн Нөхөн Сэргээлтийн талаарх Зөвлөмж (Хөгжлийн бэрхшээлтэй хүн) 1983, (№99) анх дурьдагсан байсан бөгөөд (ОУХБ-ын Мэргэжлийн Нөхөн Сэргээлт болон Хөдөлмөр Эрхлэлтийн Конвенц(Хөгжлийн бэрхшээлтэй хүн, (№159), 1983) болон Зөвлөмж (№99) -өөр бүрэн баталгаажсан. Эдгээр баримт бичгүүд нь хөгжлийн бэрхшээлтэй ажилчдад адил тэгш хандах, тэдэнд эрх тэгш боломжийг олгох, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг эрх тэгш байлгах баталгаа болсоор ирсэн. ОУХБ-ын Хүний Нөөцийг Хөгжүүлэх Зөвлөмж (№195) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад тусгай хэрэгцээтэй залуу хүмүүс, ур чадвар доогуур иргэд, үндэсний цөөнхийг ур чадварын сургалтад хамруулж чадавхжуулах шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн байна.

ОУХБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг бүр мөсөн шийдвэрлэхэд НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийг Хамгаалах Конвенци чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ Конвецид нэгдсэн орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон бусад хэлбэрийн сургалтад хамрагдах нөхцөл бололцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд гарган ажиллах хүчээр тооцож тэдгээрт “нээлттэй, тохиромжтой болон боломжтой” ажлын орчныг бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

Наад захын шаардлагад нийцсэн орчин

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн суралцах боломжийг холбогдох олон улсын стандартад нийцүүлэн бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Зарим тохиолдолд тусгай хэрэгсэл гэдэг ухагдахуун нь зөвхөн тодорхой бүлэг эсвэл хувь хүмүүст хамааралтай байж болох юм.

Наад захын шаардлагад нийцсэн орчин гэдэгт сургалт явагдах, болон дадлагажих газар хэрээс хэтэрсэн илүү зардал, хүндрэлгүйгээр тухайн хүний наад захын шаардлага хангасан нөхцлийг бий болгохын ойлгоно. Эдгээр шаардлага, хэрэгцээг хангах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын адил сургалтын үйл ажиллагаанд боломжийн хирээр чөлөөтэй оролцож эрхээ эдэлж, эрх чөлөөтэй байх,бусад шаардлагатай нөхцлүүдийг бүрдүүлэхэд оршино. Энэ тохиолдолд тэд сургалтад бусадтай эн зэрэгцэн оролцох боломж юм.

Сайн сургагч өөрийн суралцагчдад хэрэгцээтэй багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх нөхцлийг бүрдүүлж, тэдэнд багаж, тоног төхөөрөмжийг хэрхэн зөв, аюулгүй байдлыг бүрэн хангасан байдлаар ашиглахыг төрөл бүрийн сургалтын чиг хандлага, арга зүйг ашиглан заана.

ОУХБ-ын төслийн зүгээс 1990 оны үед Камбожийн хөдөөгийн сургалтын төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалтад хамруулах, тэдгээрийг хэрхэн сургах талаарх тусгай бүрэлдэхүүн хэсгийг төслийн хөтөлбөрт оруулсныг дор дурьдсан болно:

- Сургагчдад зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээлэл;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж бие засах өрөө, орц-гарцыг шинэчилэн тоноглох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй тусгайлан хамтран ажиллах ажиллагчидыг томилож сургалтад хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй сургалтад хамрагсадад зориулж сургалтын явцад хэрэглэх тусгай тоноглол болон зарим тоног төхөөрөмжийг бэлтгэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд зарцуулагдах унаа, тоноглол бусад зардалын асуудлыг шийдвэрлэж өгөх;
- Сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд тэдгээрт өөрийн бизнесийг эхлүүлэх буцалтгүй тусламжийг олгох;
- Хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагаанууд үүнд хамаарсан байна.

Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн мужид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөтөлбөрт хамрагдах оролцоо 5-15 хувь болтол өссөний зэрэгцээ нийт төгсөгчдийн 67 хувь нь хөдөлмөр эрхлэлтэд хамрагдсан эсвэл орлогыг бий болгох үйл ажиллагаа эрхэлж чадсан байна.

Үндэсний хууль тогтоомж болон бодлого

Сүүлийн арван жилд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хамаарах хөдөлмөр эрхлэлт, хүний эрх болон ур чадварын сургалтыг дэмжих чиглэлээр ихээхэн өөрчлөлтүүд гарсан. ХЭЗЧДС-ын зохион байгуулагчийн хувьд тухайн үйл ажиллагаа явуулж буй улс орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст холбогдох хууль, тогтоомж болон эрх зүйн зохицуулалтууд, бодлогын чиг хандлагыг сайн мэдэж байх нь чухал.

III. Ур чадварын сургалт ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

а) Томоохон асуудлууд ба саад бэрхшээл

ХЭЗЧДС-ын хөтөлбөрүүд нь олон нийтэд нээлттэй байх шаардлагатай ба орон сууцнуудыг тодорхой хувь хүн болон бүлэг хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн барих ёстой. Тухайлбал эмэгтэйчүүдийг тусгайлан авч үзсэн, тодорхой шашны бүлэглэлийн хоолны дэгийн өөрчлөлт, бичиг үсгийн боловсрол муутай хүмүүст таарсан мэргэжлийн сургалтын арга барил зэргийг харгалзан үзсэн орон сууц барьж болох юм. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг ч мөн хамруулж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амын нэг хэсгийн хувьд тэднийг тусгайлахгүй байх нь маш чухал юм. Хүн бүр хувь хүн мөн. Харин дор дурдагдах зүйлс нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн бүхий л үе шатад нөлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дадлагажуулахтай холбогдсон нийтлэг асуудал болон бэрхшээлүүд юм. Сонирхолтой нь эдгээр нийтлэг асуудал, бэрхшээлүүдийн ихэнх нь ямар нэг байдлаар хөтөлбөрт хамрагдалгүй үлдсэн нийгмийн бүлгүүдэд ч хамааралтай байна.

Хандлага ба итгэл үнэмшил

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, сургагч болон ажил олгогчдын хандлагыг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Учир нь тэднийг олон жил нийгмээс тусгаарласнаас үүдээд тэдний өөрсдийн чадвартаа итгэх итгэл буюу итгэл үнэмшил үгүй болсон байдаг. Магадгүй тэдэнд урам хайрлаж, эерэг байдлаар дэмжих хэрэгтэй байж болно. Түүнчлэн тэд ажлын байрны зах зээл буюу тэд юу хийх боломжтой байгааг мэдэхгүй байж болох тул тэднийг ажил мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж, боломжуудыг нээж өгөх хэрэгтэй. Ингэснээр тэд ирээдүйнхээ төлөө илүү сайн сонголт хийх боломжтой болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлийнх нь гишүүд тэднийг хамгаалах үүднээс хэт болгоомжлох эсвэл санаа нь зовж болох тул тэднийг ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанд татан оролцуулах нь зүйтэй.Үр дүн бүхий жишээ болох хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, хөгжлийг бэрхшээлтэй хүмүүсийн эцэг, эхийг оролцуулах нь хөтөлбөрийн үр дүнд сайнаар нөлөөлнө.

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний гэр бүлийн гишүүд нэлээд эерэг хандлагатай байж болно. Эсвэл зарим нь хөтөлбөрт оролцож, амжилтад хүрэх маш их хүсэл эрмэлзэлтэй байж болно. Зарим нь эрх мэдэлтэй, чадварлаг дэмжигчид байдаг. Гэр бүлийн гишүүд анд нөхөд байж, гэр бүлээ оролцуулахыг чармайж, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээс суралцаж, бизнесээ эхлэхэд нь тусалдаг.

ХЭЗЧДС-ын зохион байгуулагчид, ажилчид, сургагч нар өөрсдийнхөө хандлагыг ч мөн адил судалах хэрэгтэй. Учир нь тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийнхээ сөрөг хандлага болон андуу ташаа ойлголтыг өөрчлөх чадвартай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөтөлбөрт оролцуулах нь хэрэгцээгүй хүнд ачаа юм байна гэсэн бодол ХЭЗЧДС-ын зохион байгуулагчдад төрж болох юм. Ийм хандлагыг хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтад хөндөж авч үзэх хэрэгтэй. Удирдагч орон нутгийн бүх зохион байгуулагч болон хамтрагчдад эерэг хандлагыг түгээх нь хамгийн чухал. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний чадвар, боломжийн талаар бүгд эерэг хандлагатай байх ёстой.

“Санасандаа хүргэх төсөл” нь нийтэд тархсан ойлголт. Сургалтын явцад, зааварлагч хэн нэгнийг амжилтанд хүрэхгүй гэж урдаас бодох эсвэл эсрэгээр нь сургагчийн өмнө зайлшгүй гарч ирэх энгийн биш зүйлсийг даван гарах чадвартай гэж хэт итгэх нь тухайн хүний амжилт, уналтад нөлөөлдөг.

Нийтлэг тохиолддог өөр нэг төрөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ийм л төрлийн ажлыг хийж чадна гэсэн хэвшмэл ойлголттой холбоотой байдаг. Тухайлбал, хараагүй хүн зөвхөн массажийн төрлийн ажил хийж чадна гэх буюу дүлий хүн тэртээ тэргүй сонсохгүй юм чинь дуу чимээ ихтэй ажил хийх хэрэгтэй гэх мэтийн хэвшмэл зүйл бий. Дэлхий даяар бараг бүхийл төрлийн ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хийж чадаж байна. Тухайн хүний амжилт, түүний согог гэхээс илүүтэйгээр боловсрол, мэргэжлийн сургалт, орон байр, боломжоос ихээхэн хамаардаг. Тиймээс анхаарлаа тухайн хүний хөгжлийн бэрхшээлтэй байдалд бус чадварт нь төвлөрүүлэх шаардлагатай.

Зөв төлөвлөлт хийх, туршлагатай, уян хатан, нээлттэй, бүтээлч ажилтан ажиллуулах, хөдөлмөрийн чадвараа алдах гэж юу болох талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулах, амжилтанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг жишээ болгох нь эерэг хандлага руу чиглэсэн стратеги юм.

Ажил олгогчид нь тухайн орон нутгийнхан, нийгмийн нэг хэсэг болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар андуу ташаа ойлголт төрүүлэх гэсэд байдаг учраас энэхүү хүчин зүйлийг ч мөн адил харгалзах шаардлагатай.

Гэхдээ ихэнх хүмүүс эерэг хандлагатай байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан ажил олгогчид ийм хүмүүсийг ажилд авах, нийгмийн хамтын хариуцлага үүрч буйгаа ухамсарлах чадвартай байдаг. Ангид хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцахад тухайн ангийн ухамсарын төвшин дээшилдэг болохыг олж тогтоосон байна. Сургалтын өөр нэг арга бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд таарсан аргыг сонгох явдал юм. Тухайлбал сонсголын бэрхшээлтэй болон удаан суралцагчдад зориулсан үзүүлэнгүүдийг түлхүү хэрэглэх нь сургалтын өөр нэг арга. Энэ тохиолдолд анги нийтээрээ ижил төвшинд суралцах боломжтой болно.

Боловсролын түвшин доогуур болон бичиг үсгийн чадвар сул байх

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тоо бодох, бичиг үсэг сайн мэддэг байхыг шаарддаг мэргэжлийн сургалтад нэг их хамрагдаад байдаггүй. Учир нь тэд бусадтай адил боловсрол олж авах боломж муутай байдаг. Өөр ямар нэг байдлаар ийнхүү нийгмээс тусгаарлагдсан хүмүүс үүнтэй адил ялгаварлан гадуурхалттай тулгарах нь элбэг болохоор тэднийг ч гэсэн ХЭЗЧДС-ын хөтөлбөртөө хамруулах хэрэгтэй. Ингэхдээ голчлон боловсролын түвшинг жигдрүүлэх, тэдэнд тохирсон сургалтын арга техник ашиглахад түлхүү анхаарах хэрэгтэй.

Энэхүү хэсгийн төгсгөлд хэд хэдэн сургалтын боломжит бүтцийг санал болгох бөгөөд эдгээрийг бичиг үсэггүй буюу бичиг үсэгт муу тайлагдсан

хүмүүст хэрэглэж болох юм. Харин ажлын сонголтод илүү бодитоор хандах нь чухал. Тоо бодох, бичиг үсэг сайн мэддэг байхыг шаарддаггүй олон төрлийн ажил бий. Гэр бүлийн эсвэл хамтын хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд дээр дурьдсан шаардлагыг чаддаг нэг нь гүйцэтгээд байж болно. Харин сургалтад амьдралд хэрэгтэй, дадал олгосон буюу боловсрол шаардаад байхгүй тийм аргуудыг хэрэглэж болно. Тэгээд ч ажиллах явцад чадвар нэмэгдэхийн хамтаар бичиг үсэгт сайжирдаг.

Үндсэн мэдлэг чадвар

Хөгжлийн бэрхшээлтэй, ямар нэг байдлаар нийгмээс тусгаарлагдсан хүмүүс амьдралынхаа явцад нийгмийн харилцаанаас олж суралцдаг наад захын чадваргүй байх нь элбэг байдаг. Тодруулбал, тэд хүнтэй харилцах, багаар ажиллах, шийдвэр гаргах, цагаа зөв хуваарилах зэрэг олон чадварт суралцаагүй байдаг. Ер нь богино хугацаанд тэдэнд ийм арга барил эзэмшүүлэх боломжгүй ч албан ба албан бус ажлын байрны аль алинд нь энэ асуудал маш чухал. Эхлээд ямар чадвар эзэмшсэн байгааг мөн тэр нь хэр сайжирч байгааг тогтооход анхаарлаа хандуулах хэрэгтэй. Сургалтын явцад мөн дараа нь дүрд тоглуулах, даалгавар өгөх, удирдагч, дасгалжуулагч гаргаж өгөх, туршилтын ажлаар хангах болон ажлын байр дээр нь сургах, дадлагажуулах зэрэг нь хөдөлмөрийн чадвар суулгахаас гадна үндсэн чадвар эзэмшүүлэхэд тусална.

Эсрэгээр нь зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс асуудлыг шийдэх чадвар сайтай байдаг. Тэд саад бэрхшээлийг даван туулах, аливаа юмыг хэрхэн хийх тал дээр асар их туршлага хуримтлуулсан байдаг. Ийнхүү хуримтлагдсан чадварыг сургалтын болон ажиллах орчинд нь зөв шилжүүлж өгөх хэрэгтэй.

Мэдээлэл, харилцаа

Нэгэнт ХЭЗЧДС-ын хөтөлбөр нь олон нийтийн оролцоо, шийдвэр гаргалт дээр үндэслэдэг болохоор эхнээсээ авхуулаад үе шат бүртээ бүх хамтран оролцогчдод хүрч үйлчлэх, холбоотой байх, мэдээлэл тараах зэрэг асуудлууд маш чухал байдаг. Ялангуяа харилцаа холбооны тусгай формат шаардлагатай тодорхой төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нийгмээс хэт тусгаарлагдсан хүмүүсийг сайн анхаарах хэрэгтэй.

Ер нь радио нь нийт хүн ам болон харааны бэрхшээлтэй хүмүүст хүрэх сайн арга боловч сонсголын бэрхшээлтэй хүнд хүрч чаддаггүй. Тухайн хэсгийн мэдээллийн самбар болон тусгай сувгаар тэмдэг, мэдээ түгээх нь тэдгээрийг уншиж чаддаг хүмүүст мэдээлэл хүргэх сайн арга байж болох ч хараагүй, бичиг үсэгт тайлагдаагүй хүмүүст хүрч чадахгүй. Мэдээлэл хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүрлээ ч гэсэн түүнд агуулагдах мэдээ тодорхой байх ёстой. Мэдээлэл хүргэх аргуудын үр нөлөө, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрсэн эсэхийг нягтлах ажил урт замыг туулдаг.

Туслах хэрэгсэл, хүртээмж, орон байр

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалтад хамруулахаас өмнө тэднийг туслах хэрэгсэл болон тусгай сургалтад хамруулах шаардлага гардаг. Зарим нэг туслах хэрэгслийн жагсаалтыг Хавсралт 8.2-т дурьдсан байгаа. Тахир дутуу хүний тэргэнцэр нь үүний нэг жишээ юм. Сонсголын бэрхшээлтэй хүний хувьд дохионы хэл тохиромжтой боловч улс бүр албан ёсны нийтлэг нэг дохиолол ашигладаггүй ба хэлний ийм сургалт тэр бүр түгээмэл байдаггүй. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийг зохион байгуулагчид хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг сайтай, орон нутгийнхантай хамтран ажиллаж, тэднээр шаардлагатай байгаа тусгай хэрэгсэл гаргуулах, сургалт зохион байгуулах, түүнчлэн орон байраар хангуулах арга хэмжээ авч болно. Ялангуяа ажилчдыг магадлах асуудлыг хөтөлбөр орхигдуулсан бол орон байраар хангуулах асуудал үүсч болох юм.

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн хүртээмж зарим нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөтөлбөрт татан оролцуулж чадаж байгаа эсэхээр тодорхойлогдоно. Жишээ нь, тахир дутуугийн тэргэнцэртэй хүмүүсийн хувьд хурал цуглаан, сургалтад оролцох газар нь тэдний байдалд тохирч байж хүртээмжтэйд тооцогдоно. Хэрэв хараагүй хүн компьютер сурах гэж байгаа бол түүнийг “ярьдаг” программ хангамжаар зайлшгүй хангах хэрэг гарч болно. Харааны согогтой ч бичиг үсэг сайтай хүнд томоор хэвлэсэн материал тохиромжтой ба хурал цуглаан, сургалтын үед тэднийг урд суулгаж шийдвэр гаргах явцад идэвхтэй оролцуулах хэрэгтэй.

Тухайн орон нутгийн онцлог, сургалтын байрны байрлал, тахир дутуугийн зэрэг янз бүрийн нөхцлөөс хамаарч тээврийн хэрэгслийн хүртээмж хүндрэл учруулж болно. Иймд ямарваа нэг хурал цуглаан, сургалт зохион байгуулахдаа тухайн орон нутгийнханд ойр байлгахад анхаарах нь зүйтэй. Алс бөглүү газарт оршин суудаг хүмүүст зориулан хөдөлгөөнт эсвэл мэдлэгтэй нэг нь нөгөөгөө сургах сургалтын арга техник ашиглаж болох юм. Яг юу шаардлагатай байгааг тогтоох хамгийн шилдэг арга бол ямар нэг арга хэмжээнд идэвхитэй оролцоход юу хэрэгтэй байгааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс асуух явдал.

б) Сургалтын бүтэц

Хөгжлийн бэрхшээлтэй хүний чадварыг хөгжүүлэхтэй холбогдсон олон тооны сургалтын бүтэц байдаг. Бичиг үсэгт тайлагдсан байдал, тээврийн хэрэгсэл, хүртээмж, тахир дутуугийн зэргээс болоод уламжлалт чиг хандлагыг ашиглах боломжгүй бол уламжлалт бусыг нь үйл ажилдаа нэвтрүүлж болно. Дор дурьдах зүйлс нь хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмээс ямарваа нэг байдлаар тусгаарлагдсан хүмүүсийг мэргэшүүлэхэд хэрэглэж болох сургалтын бүтэц юм.

Тэгш хамруулах тохиргоо

Тэгш хамруулах мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн тогтолцоо нь дараах шинжийг[1] агуулдаг.

- Нэгдсэн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл хүмүүсийг нэгтгэсэн байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг уг тогтолцооныхоо бүхий л асуудалд оролцуулж байх. Үүнд хөтөлбөр төсөл санаачлах, боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургагч, багш зэргээр ажиллах ч мөн адил хамаарна.
- Саадаас ангид орчин - бүх саад бэрхшээл буюу ялангуяа сэтгэл зүйн дарамтыг арилгасан байх. Дэд бүтцийг төлөвлөж барихдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байхаар бодолцох, байгаагаа шинэчлэх хэрэгтэй. Эрүүл гэлтгүй хараагүй, дүлий зэрэг бүх хүнд хүртээмжтэй орон байр, тээврийн хэрэгсэл болон бусад системийг бий болгох.
- Үр нөлөөтэй заах арга зүй болон сургалтын хэрэгслийн сургалтад ашиглах.
- Ажил мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах. Ингэснээр хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс зөв сонголт хийх боломжтой болох. Үүнд суралцагчдын чадварын үнэлгээг хүн бүр дээр хийх, хөдөлмөрийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлсэн удирдамж тус тус багтана.
- Зах зээлд суурилсан чиг хандлага нь сургалтын чанарыг дээшлүүлж, ажил олголтыг нэмэгдүүлдэг. Ажил олгогчдын идэвхтэй оролцоо нь тэдний хэрэгцээнд нийцсэн чадвар хөгжүүлэх хүч болдог.
- Эерэг хандлагыг дэлгэрүүлэхийн ач холбогдлыг ойлгох – ялангуяа хөгжлийн бэрхшээлгүй суралцагч, ажилчдын хандлага энд хамаарна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжсэн халуун дулаан уур амьсгал бий болно.
- Байгууллагын арга зүй, техникийг эзэмшсэн сургалтын ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг дэмжигч ажилтантай байх. Ингэснээр эрүүл саруул гэлтгүй хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бүр мэргэжил үйлвэрлэлийн дадал чадвараа хөгжүүлж чадна.
- Хангалттай эх үүсвэртэй байх. Ингэснээр бүх суралцагчын сургалтыг дэмжинэ.
- Сайн сургаж, дадлагажуулахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сайтар бэлтгэх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахын тулд ХЭЗЧДС-ын зохион байгуулагч, гүйцэтгэгч, хамтрагч нар дараах алхмуудыг хийх хэрэгтэй. Үүнд:

1. **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах бодлого, стратеги боловсруулж, мөрдөх.** Бодлого нь бүх суралцагчдын ач холбогдлыг баталгаажуулаад зогсохгүй мөн нэмэлт дэмжлэг, эх үүсвэр шаардлагатай сурагцагчдыг бусдаас дутахааргүй дэмжихээ бататгах хэрэгтэй. Түүнчлэн байгууллага энэхүү бодлогоо хэрэгжүүлэхэд шаардлагатай стратегийг тодорхойлсон байна.
2. **Туслалцаа шаардлагатай байгаа хүмүүсийн тоо болон ямар төрлийн туслалцаа вэ гэдгийн талаарх мэдээллийг цуглуулах.** Энэ бол хөтөлбөрийн зорилтын нэг өн. Систем нь энэхүү мэдээллийг холбогдох албан хаагч, зөвлөгчдийн бүлэг болон орон нутгийн ахлагчид хүргэхээр байх ёстой.
3. **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан сургалтын хөтөлбөр боловсруулах:** Иймхөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүн болон түүний мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн багшид нь давхар ачаа болохооргүй байх ёстой. Түүнчлэн хөтөлбөр нь шаардлагатай чадварыг тодорхойлсон байх хэрэгтэй ч түүнийг хэрхэн эзэмших вэ гэдгийг хязгаарлах ёсгүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан сургалтын хөтөлбөр шаардлагагүй боловч хичээлийн даалгавар болон энэ хэсэгт дурьдсан сургалтын бүтэц, арга барилыг нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй.
4. **Сургалтын байгууллага, гэр бүл эсвэл дэмжигч, орон нутгийнхнийг холбох:** Гэр бүл, дэмжигчид, орон нутгийнхний (ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүсүүсийн холбоо) дэмжлэг сургалтын ахицад нөлөөлдөг.
5. **Байгууллагын ажилтнуудын мэдлэг, чадварыг сайжруулах:** Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургагч нарт дүгнэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, багшлахад нь нэмэлт мэдлэг чадвар шаардагдаж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулснаар сургагч нарт дөхөм болох ба сайн үлгэр дууриалал болдог.

Шинжээч, нөөцийн мэргэжилтэн нар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд мэргэжлийн сургалтыг нийцүүлэх талаар мэргэжлийн удирдлагаар хангах болон нэмэлт дэмжлэг үзүүлж чаддаг. Нөөцийн мэргэжилтэнтэй болсноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой олон талын үүргийг гүйцэтгэдэг. Мөн ХЭЗЧДС-ын төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг түгээж, ийм төрлийн хүмүүсийн сургалтын үр дүнг сайжруулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлах тохиргоо

Өмнө нь хэлсэн шалтгаанаас болоод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлах аргыг ер нь санал болгоод байдаггүй бөгөөд тусгаарлах хэрэгтэй гэсэн мэдээлэл тэр бүр явуулаад байдаггүй. Учир нь ийм хүмүүс амьдралынхаа туршид нийгмээс тусгаарлагдсаар ирсэн. Гэхдээ зарим тохиолдолд, энэ тохиргоо хамгийн тохиромжтой нь байж болно. “Зарим тохиолдол”-д дараах зүйлс багтана:

- Хэрэв энэ нь өөртөө туслах бүлэг эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбооны сонголт байвал;

1 ДХБ:Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах талаарх шинжээчдийн хурлын дэг, хуудас 17-18.

- Хэрэв оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийг тусгай сургалтын арга болон дасан зохицох чадвараас нь хамааранд “бүгдийг хамруулах сургалтын хөтөлбөр”-т оролцуулах боломжгүй бол;
- Бүлэг хүмүүс (жишээ нь дохионы хэлмэрч)-т тусгай анхаарал, үйлчилгээ шаардлагатай байгаа бол. Гэхдээ газарзүйн өөр өөр бүст оршин суудаг хүмүүс үүнд хамаарахгүй.

Тусгаарлах арга хэмжээг онцгой тохиолдолд авах хэрэгтэй. Энэхүү арга хэмжээ нь суралцагчдийг өөр сургалтад хамрагдах боломжид нөлөөлөхгүй ба тэдний ажлын байраа сонгох эрхийг нь хязгаарлахгүй. Жишээ нь хараагүй хүмүүсийг зөвхөн массажистын сургалтад хамруулаад компьютерийн сургалтад хамруулахгүй байхыг хэлнэ.

Уг тохиргоог хэрэглэхдээ зарим асуудлыг бас бодолцох шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зааварлагчтай байх хэрэгтэй. Сургагчид нь тэдний асуудлыг мэддэг, дадлагажсан байвал зүгээр. Тэднийг сайн сургахын тулд хүн бүрийг орон байраар хангах хэрэгтэй. Мөн бизнесийн хөгжлийн сургалт, ажлын байраар хангах зэрэг бусад асуудалд нь анхаарлаа хандуулаарай.

Тусгаарласан сургалтын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай нэгтгэхийг аль болох хичээх хэрэгтэй. Тухайлбал хөдөлмөрийн дадал олгох, ажлын байртай танилцах зэрэгт бүгдийг ялгалгүй хамруулвал сургалтын явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэхэд тустай байдаг.

Албан бус сургалт, өв залгасан сургалт

Албан бус сургалт нь ихэвчлэн засаг захиргааны хамгийн бага нэгжийн хэмжээнд гэр бүлийн нэг гишүүн нөгөөдөө, тосгоны нэг хүн нөгөөдөө багшлах хэлбэрээр илэрдэг. ОУХБ ийм төрлийн сургалтын хэлбэрийг Камбожийн жишээ дээр судалжээ. Эцэст нь энэ сургалтын төрөл нь саад бэрхшээл ихтэй бусад төрлийнхөөс хамаагүй үр дүнтэй болохыг олж тогтоосон байна. Орон нутагт үйлдвэрлэл эрхэлдэг, бусдыг орлого олох үйл ажиллагаа буюу жижиг бизнестээ мэргэшүүлэх сонирхолтой амжилттай ажиллаж байгаа үйлдвэрлэгчдийг оролцуулснаар эхэлнэ. Үүнд хамгийн чухал нь тухайн үйлдвэрлэгч ашигтай ажилладаг байх бөгөөд тухайн бизнесийн салбарт бусад ижил түвшний үйлдвэрлэлийг шингээхүйц өргөн байх явдал юм. Ийм төрлийн бизнес ихэнхдээ тухайн орон нутаг буюу хөдөөгийн зах зээлийг хангадаг.

Сургалт ерөнхийдөө богино байхаас гадна мэргэшсэн хүмүүсийн хяналтад байна. Дээрх төрлийн сургалтуудыг бизнесийн болон техник үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар түлхүү анхаарч зохион байгуулахийн зэрэгцээ албан ёсны бизнес явуулах үйл ажиллагаанд илүү анхаарал тавьдаг байна. Дээрх сургалтууд нь бичиг үсгийн чадвар муутай эсвэл бичиг үсгийн чадварын хувьд хязгаарлагдмал хүмүүст илүү хэрэгцээтэй байсан бөгөөд сонгсолын бэрхшээлтэй хүмүүсийн хувьд харин нэг бүрчлэн тулж ажиллах шаардлага гарч байсан байна. Түүнчлэн сургалт нь гэр орноосоо холдоход хүндрэлтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, унаа тээврийн зардал гэх мэт илүү зардал гаргахгүйгээр зохион байгуулах боломжтой байсан нь зарим хүмүүсийн таашаалд нийцсэн байна. Зарим тохиолдолд хэрвээ тухайн суралцагч шаардлагатай тохиолдолд тухайн үйлдлийг ур чадварын дутмаг байдлаас болон хийж чадахгүй байсан үед гэр бүлийн гишүүд нь туслаж байсан байна. Сагс нэхэх багийн үйл ажиллагаа нь бусад үйл ажиллагаанаас илүү сонирхолтой байсан бөгөөд учир нь сэтгэл санааны хөгжлийн бэрхшээлтэй залуу эмэгтэй энэ үйл ажиллагаанд суралцаж чадсан байна.

Үйлдвэрлэлийн дадлага

Үйлдвэрлэлийн дадлага нь бусад суралцах багуудыг бодвол харьцангуй үр дүнтэй энгийн гэж тооцогддог. Энэ арга нь ангид сууж ур чадварыг заах нөхцлийг шаарддаггүй бөгөөд тухайн шаардлагатай ур чадварыг хүн шууд газар дээр нь практик дээр суралцах шаардлагатай юм. Зарим төрлийн оюуны болон сэтгэхүйн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд шууд газар дээр нь харж суралцах нь илүү үр дүнтэй бөгөөд энэ арга тэдний хувьд боломжтой гэж тодорхойлогддог. Энэ төрлийн сургалтад ажил олгогч байгууллага оролцож, үйлдвэрлэлийн сургалтын хөтөлбөрийг зохион байгуулахад туслаж болно.

Ажил дээр сургах

Энэ нь үйлдвэрлэлийн дадлагаар сургах арга зүйн нэг хэлбэр юм. Энэ тохиолдолд тухайн ажилд мэргэшсэн сургагч нь нэг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг эсвэл жижиг багийг дагалдуулан өөрийн ур чадвараа үзүүлэх байдлаар сургах боломжтой. Ихэнх тохиолдолд сургагч нь өөрөө тухайн ажлыг эхэлж сурсны үндсэн дээр бусад суралцагчдыг тухайн үйл ажиллагаандаа татан оролцуулдаг. Нэгэнт суралцагч нь шаардлагатай ур чадварыг сурсаны дараа сургагч нь тухайн ажилд оролцохгүйгээр суралцагчийг бие даан цааш нь үргэлжүүлэх боломжийг олгоно. Гэхдээ сургагч нь суралцагчийн хажууд байж шаардлагатай зөвөлгөөг өгөн, шинэ ур чадварт сургахад бэлэн байна. Сургалтын энэ арга нь сэтгэхүйн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургахад ихэвчлэн хэрэглэгддэг байна. Зарим улс орнуудад тухайн компанид ажиллаж байсан эсвэл тэтгэвэрт гарсан ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт явуулах ажлыг хариуцдаг байна.

Ханг Хатчын жишээ. 44 настай ноён Ханг Хайч нь 4 настайдаа осолд орж хараагүй болжээ. Одоо тэрбээр эхнэр, 4 хүүгийн хамт Камбожийн Пурсат мужийн нэгэн тосгонд амьдардаг байна. Олс хийгчийн сургалтад хамрагдахаас өмнө тэр ямар нэгэн орлогогүй, өөрийн будааны талбайд ажилладаг өөрийн хүүхдүүдийн бүрэн асрамжинд гэртээ байдаг байв. Тосгоны ахлагч нь хөтөлбөрийн ажилтнуудыг Ханг Хатчитай уулзуулж түүний хийж чадах зүйлийг тодорхойлж өгөхийг хүсчээ. Камбож нь газар тариалангийн орон бөгөөд малыг будаа тариалах ажилд хэрэглэдэг байсны зэрэгцээ тэдгээрийг уях уяа байнга хэрэгцээтэй байдаг байв. Цагаан будааны ишээр уяа хийх нь тухайн орон нутагт түгээмэл сайн бизнес байжээ. Төслийн ажилтан нь өөр тосгонд уяа хийдэг хүн олсон бөгөөд тэр Хатчид уяа хэрхэн хийхийг заасан байна. Сургалтын үргэлжлэх хугацаа нэг долоо хоног бөгөөд сургалтын төлбөр нь маш бага байв. Төслөөс түүнд түүхий эдийг авах бага зэр мөнгийг өгснөөр тэрбээр өөрийнхөө бизнесийг эхэлж, амьдралдаа анх удаагаа мөнгө олох боломжтой болсон. Хэдийгээр тэр хараагүй ч гэсэн авхаалжтай ухаантай нэгэн тул хэдхэн сарын дараа чадварлаг олс хийгч болсон байна. Ихэнх өдөрт тэр 10 олс хийж тосгондоо зардаг эсвэл түүний хөвгүүдийн нэг нь зах дээр олсоо зардаг байна. Сард хэдэн өдөр ажилласнаас хамааран Хатчи сард ядуурлын түвшингөөс дээгүүр орлого олдог бөгөөд энэ нь гэр бүлийн ерөнхий орлогод тодорхой хувь нэмэр болдог байна. Тэр өөрийн байдалд сэтгэл ханглуун байгаагаа илэрхийлж "шинээр төрсөн мэт санагдаж байна" гэж ярьдаг байна.

IV. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үе шат бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах

ХЭЗЧДС-ын төсөл нь зорилтод орон нутгийн эмзэг бүлгийн иргэдийг сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн боломжоор хангах зорилт тавьж ажиллахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ч бас хамруулдаг. Дор дурьдсан хэсэг хөгжлийн бэрхшээлтэй холбогдох асуудлыг хөтөлбөрийн үе шаттай уялдуулахад хамааралтай юм.

Үе шат 1. Байгууллагын зохион байгуулалт, төлөвлөлт

- ХЭЗЧДС-ын нэгдүгээр үе шат үндэсний болон орон нутгийн хэмжээний байгууллагын зохион байгуулалт, орон нутагт дах түншлэлийг хөгжүүлэх, тэдгээрийн чадавхийг нэмэгдүүлэхэд оршино. Энэ үе шатад хөгжлийн бэрхшээлтэй холбогдуулан дараах асуудалд анхраал хандуулах шаардлагатай. Оролцогч байгууллагын болон тэдгээрийн ажиллагсдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эергээр хандахад чиглэгдсэн арга хэмжээ авах, өөрөөр хэлбэл тэдний чадавхийг нэмэгдүүлэх
- Хөгжлийн брхэшээлтэй хүмүүсийг ХЭЗЧДС-ын төлөвлөлт, сургалтын загвар болон зохион байгуулалтад оролцуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох уулзалт, үйл ажиллагааг төлөвлөх;
- Зохистой түншүүдийг сонгох;
- Хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст холбогдуулан зохион байгуулах ажил болон шаардагдах төсвийг боловсруулах;

Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага

1. Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах тодорхой туршлагатай байх хэрэгтэй болно. Иймд хэрэгжүүлэгч байгууллагын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан ажилтан байлгах хэрэгтэй. Хэрэв тухайн байгууллагад иймж ажилтангүй бол уг асуудалд харъяалагдах яам агентлагаас холбогдох ажилтныг оролцуулах талаар арга хэмжээ;
2. Тухайн орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ур чадварын сургалт, жижиг бизнесийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хууль тогтоомж, эрхзүйн бодлогын цар хүрээг тодорхойлох;

   Ихэнх тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хамаарах тайлан мэдээг ОУХБ эсвэл НҮБ-ын холбогдох агентлаг, яам, Хүний эрхийн комисс боловсруулсан байдаг тул тэдгээрийг мэдээллийн эх сурвалжаа болгох;
3. Хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай танилцаж байгууллагын аудитыг хийлгэж, боломжит нөөц бололцоо, хөрөнгийн эх үүсвэр, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тодорхойлж, эдгээрээс чухам ямар хэмжээтэй хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох үйл ажиллагаанд шаардлагатайг тооцоолж гаргах. Жишээ нь, тухайн байгууллага нь аль хэдийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сургалтад зориулж тодорхой мөнгө зарцуулсан эсвэл сургалт явуулахаар төлөвлөж байж болох юм. Зарим улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авсны нөхөн олговрыг компаниудад өгч урамшуулдаг явдал ч байдаг.
4. Олон улс орны Засгын газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг зохицуулах алба, зөвлөлүүдтэй байдаг бөгөөд хэрэв тийм алба байдаг бол тэдгээрийн үйл ажиллагааны ерөнхий чиг хандлага болон нөөц бололцоог судалж үзэх хэрэгтэй.

Үндэсний түвшний түншүүд

1. Үндэсний түншүүдийн үйл ажилагаатай танилцах явцад тэдгээр нь эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан дадлага туршлагатай эсэх талаар мэдээлэл цуглуулахын зэрэгцээ тухайн байгууллагууд нь хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй эсэхийг тодруулна.

2 Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагад аудитын дүн шинжилгээ шалгалттай адилхан аудитын дүн шинжилгээг хийлгэх

3. Хэрэв үндэсний түнш байгууллага нь аливаа түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагаанд оролцож байсан бол тэр үйл ажиллагааны чанар хүртээмж, үр дүнтэй танилцаж дүн шинжилгээг хийнэ.

4. Тухайн байгууллагын ажиллагчдын талаар мэдээлэл цуглуулах:

   - Тухайн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг уу?
   - Тухайн байгууллагын ажиллагчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан туршлагатай юу?
   - Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдолтой үйл ажиллагаа явуулж байсан бол шууд гүйцэтгэдэг байсан уу?

Байгууллагын сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах чадамжийг нэмэгдүүлэх хэрэгцээг тодорхойлох

Ихэнх байгууллагууд өөрийн үйл ажиллагаа явуулдаг цар хүрээнд тодорхой хэмжээний сүлжээ, харилцаа холбоо тогтоосон байдаг. Иймд тухайн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хамтран ажиллаж сүлжээ байгуулсан талаар тодорхойлох

Тухайн байгууллага нь ямар түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хамтарч ажиллах сонирхолтой байгааг тодорхойлох

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахад шаардлагатай мэдээлэл дутмаг байгааг тодорхойлж, энэ мэдээлэл нь орон нутгийн түнш байгууллагуудтай хамтарч ажилласнаар нөхөгдөх боломжтой эсэхийг тооцоолох

ХЭЗЧДС-ын үндэсний зөвлөлдөх хороо

1. Хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөх асуудалд чухал ач холбогдол өгсөн байх хэрэгтэй. Үүний тулд хорооны бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хамаарах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төлөөллийг оруулах бөгөөд холбогдох байгууллагууд ардчилсан зарчмаар аль байгууллагын төлөөллийг хороонд оруулахаа өөрсдөө шийднэ. Хорооны гишүүн төлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолой гэж тооцогдоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон ТББ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төлөөллөө болгох эсэхийг өөрсдөө шийднэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг оруулах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "*бидний тухайд зөвхөн бидэнтэй хамт* " гэсэн урианы илэрхийлэл юм.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага нь тодорхой төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгжүүлэгч нэгжийн бүрэлдэхүүнд оруулах санал гаргаж болно. Зарим тохиолдолд хөгжлийн бэхшээлтэй хүмүүсийн дунд улс төрч байхыг ч үгүйсгэх аргагүй бөгөөд тэднийг мөн үйл ажиллагаанд идэвхтэй татан оруулах нь зүйтэй.

3. Тухайн орны нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцох чадамжаас хамааран үндэсний зөвлөлд гишүүнчлэл байх эсэх нь янз янз байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэглэлүүд нь засгийн газрын зөвлөх хороо, ажлын хэсгүүдэд ихэвчлэн орсон байдаг боловч тухайн төлөөлөгчдийг тодорхой хэмжээний сургалтад хамруулж, чадваржуулах нь чухал байдаг. Ингэснээр тэд өөрсдийн оролцооны үүрэг хэрэгцээг ухамсарлаж, жинхэнэ утгаар нь бүрэн хэмжээний төлөөлөл болж чадна.

4. Зөвлөлдөх хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тодорхой хэмжээний ойлголттой байх бөгөөд уг хорооны гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлэл өгөх зорилгоор тусгайлсан сургалтыг зохион байгуулах нь зүйтэй. Иймд сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах талаар мэргэжсэн байгууллагуудаар зохион байгуулуулах нь зүйтэй.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахад дараах зүйлд анхаарал хандуулсан байх шаардлагатай:

   а) уулзалтыг зохион байгуулах газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ороход саад учруулахгүй байхаар сонгогдсон байна. Үүнд зөвхөн тэргэнцэр хэрэглэдэг хүмүүс хамаарахгүй бөгөөд үүнд мөн хараагүй, сонсголгүй хүмүүсийн асуудлыг бодолцож үзсэн байх хэрэгтэй.

   б) уулзалт болох газар нь хүрэхэд амар хялбар ойр байх хэрэгтэй.

   в) тээвэрлэлтийн асуудал гарах магадлалтай байдаг тул уулзалтын зарыг эртнээс тараасан байх хэрэгтэй.

   г) уулзалтыг удирдах, зохион байгуулах хүн нь хөгжлийн бэрхшээлийн талаар тодорхой мэдлэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зохистой харьцах ур чадвартай байх хэрэгтэй.

Төлөвлөлт

Үндэсний зөвлөлдөх хороо нь ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн төлөвлөлт болон шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбогдох чухал асуудлуудыг шийдвэрлэнэ. Иймд төлөвлөлт хийх явцад дараах асуудлуудад анхаарал хандуулсан байх хэрэгтэй:

- Зөвлөдөх хорооны уулзалтыг удирдаж байгаа хүн гишүүдийн оролцоог бүрэн хангаж, тэдгээрт санал бодлоо илэрхийлэх боломж олгож байх
- Нөөцийг зөв зохистой хувиарлаж, тодорхой онцгой шаардлагуудад тодорхой хэмжээний нөөцийг хувиарласан байх бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хамаарахаас гадна, дохионы хэлний зааварлагч, сургалтын тоног төхөөрөмжийг шаардлагад нийцүүлэх зардал, сургалтын материал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалтай холбогдуулан хүний нөөцийг чадваржуулах гэсэн зардал хамаарна.
- Төлөвлөлт нь мөн бичиг үсгийн мэдлэгийн доогуур түвшинтэй хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүст тайлбарлан таниулах сургалт, тусгайлан сургах хөтөлбөр, тэдний гэр бүл, бусад хамрагдах этгээдүүдэд зориулсан сургалт гэх мэт асуудлуудыг тусгасан байх хэрэгтэй.

ХЭЗЧДС-ын үндэсний түвшинд зохицуулах нэгж

Энэ баг нь үндэсний зөвлөлдөх хороо болон орон нутагт үйл ажиллагаа явуулах нэгжийг холбож өгөх үндсэн үүргийг хүлээх тул тухайн багийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах дадлага туршлагатай хүн байвал зохистой. Энэ ажилтан нь мөн орон нутгийн түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй тулж ажиллах чадвартай байх хэрэгтэй. Тухайн ажилтны гүйцэтгэх ажлын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг хариуцах явдал болно. Түүнчлэн уг ажилтан нь ажлын шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүн байж болох бөгөөд ийм тохиолдолд ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс уг асуудалд хэрхэн ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл болно.

ОУХБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих төслийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй тулж ажиллах сургагч, зохион байгуулагч нарт шаардлагатай ур чадварын жагсаалтыг гаргасан байна. Уг жагсаалтыг Африкт хэрэгжиж байсан төслийн туршлага ддээр суурилан гаргасан бөгөөд сонгогдох хүний нөөц нь дараах асуудал холбогдох практик мэдлэгтэй байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст биет болон үйлчилгээний орчин хэрхэн нөлөөлдөг талаар;
- Хөгжлийн бэршээлтэй хүмүүст шаардлагатай наад захын тоноглол;
- Хөжглийн бэрхшээлтэй хүмүүсийн өрөөнд тавигдах шаардлага;
- Хөгжлийн бэршээлтэй хүмүүсийг хамруулсан өргөн хүрээг хамарсан дасгал, сургалтын хөтөлбөрт холбогдох материал, гарын авлагын хэрхэн бэлтгэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоотой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх нэмэлт дэмжлэгийг зөв зохистой үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоотой, оролцоогүйгээр сургалтад хамрагдагчдын болон үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагаа нэгдмэл байдлыг хангах талаар;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөртөө итгэлтэй байдлыг зохистойгоор нэмэгдүүлэх;
- Сургалт болон бусад үйл ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг хэрхэн зохистойгор гаргаж ирэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд учирч буй тодорхой асуудал болон бэрхшээлүүдийг шийдвэрлэх;
- Дэмжлэг үзүүлэх болон зөвөлгөө өгөхөд шаардлагатай унших материалын эх сурвалжтай байх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хамаарах туршлагатай байхаас гадна ажиллагчид, түнш байгууллагууд, сургагчид нь холбогдох бусад асуудал, тухайлбал шашин болон соёлын асуудалд тодорхой хэмжээний мэдрэмжтэй хандах шаардлагатай.

Орон нутгийн баг болон зөвлөл

Орон нутгийн болон зөвлөлийн гишүүд, түнш байгууллагуудад дээр дурьдсантай ижил шаардлага тавигдахын зэрэгцээ тэдгээр нь дараах зүйлд анхаарал хандуулсан байх шаардлагатай.

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан ажилтныг түвшин бүрт байлгах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах дадлага туршлагатай түнш болон чадавхийг бий болгох үйл ажиллагааг холбож өгөх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүхий л төлөвлөлтийн үйл ажиллагаа болон зөвлөлийн уулзалтуудад оролцох;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах, тодорхой нөөцийг зарцуулах талаар төсөвлөх ч мөн орно.

Үйл ажиллагаа 2.Эдийн засгийн боломж, сургалтын хэрэгцээг тодорхойлох нь

ХЭЗЧДС-ын үйл ажиллагааны 2 дах үе шат нь төрөл бүрийн нийгэм эдийн засгийн судалгааг явуулах, үүний үр дүнд зорилтод бүлгүүдийн зах зээлийн боломж, сургалтын хэрэгцээг тодорхойлох зэрэг орно. Энэ үе шатанд дараах хөгжлийн бэрхшээлийн асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй.

- ямар төрлийн байгууллага засгийн газрын агентлаг, эсвэл албан бус байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд хамтарч ажиллах боломжтойг тодорхойлох;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг уг үйл ажиллагаанд бүрэн хамруулах талаар арга хэмжээ авах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг судалгаанд оролцуулж тэднийг үнэн зөв, бодитой мэдээлэл авах талд анхаарал хандуулах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ

шаардлага нь орон нутгийн судалгаа болон зах зээлийн судалгааны явцад тодорхойлогдож дурдагсан байх талаар арга хэмжээ авах;

- нөхцөл байдлын судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгах;
- оролцогч талуудын уулзалт олон бусад үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, нөөц бололцоо

Орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах тэдгээрийг төлөөлөх, үйлчлэх чиг үүрэг бүхий байгууллагууд олон байдаг. Дээрх байгууллагууд нь төрийн зүгээс санхүүжигдэг, Олон улсын байгууллага болон орон нутгийн ТББ-уудаар санхүүжигддэг байж болно. Зарим нутаг оронд нөхөн сэргээх хөтөлбөрүүд ч мөн үйл ажиллагаа явуулдаг байна.

Орон нутгийн оролцоог хангах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй:

- Зарим тохиолдолд өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж нийтэд мэдэгдэх хүсэлгүй байдаг. Иймд тэдний тухай ярихдаа явах, харах, сонсох эсвэл бусад төрлийн хүндрэлтэй гэж ярих нь зохистой байдаг бөгөөд энэ нь арай зөөлөн сонсогддог байж болох юм;
- Зарим гэр бүл нь ялангуяа хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдээ нуудаг;
- Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөлтэй уулзаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээллийг авч байх боломжтой. Гэхдээ энэ мэдээлэл нь төдийлөн нарийвчилсан байх боломжгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүн эсвэл түүний гэр бүлийнхэн ялгаварлан гадуурхахаас болгоомжлон хөгжлийн бэрхшээлтэй байдлаа нуудаг байж болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан зар сурталчилгааг аль болох олон сувгаар цацаж байх хэрэгтэй. Тухайлбал, радио, ам дамжсан яриа, хэвлэл мэдээлэл гэх мэт;
- Орон нутагт ам дамжсан яриа иргэдэд хүрэх магадлал илүү байдаг бөгөөд үүнийг дэмжиж ажиллах нь зүйтэй;
- Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийн төлөөлөл орон нутгийн үйл ажиллагаанд төдийлөн идэвхтэй оролцдоггүй бол тэдэнтэй уулзах уулзалтуудыг тусад нь зохион байгуулж, оролцоог хангах арга хэмжээг авч байх;
- Орон нутгийн судалгаанд хэрэглэгдэх арга хэрэгслүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийг цуглуулах боломжтой байхаар тооцоолж хийх;
- Орон нутгийн хэмжээнд оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээллийг цуглуулж, бүртгэлд оруулах нь тэднийг улсын хэмжээнд бүртгэлд оруулах ажлыг ихээхэн хялбаршуулах болно;
- Орон нутгийн судалгаа хийх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд анхаарал хандуулж тодорхой асуудлуудыг авч үзэж байх хэрэгтэй. Жишээ нь, орон нутгийн зах, нийтийн тээврийн хэрэгслийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрээмжтэй байгаа байдал гэх мэт;
- Гол мэдээлэгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тодорхой мэдээлэлтэй байх боломжийг бүрдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсээс ч мөн мэдээлэл авдаг байх хэрэгтэй;
- Гол мэдээлэгчээс мэдээлэл авахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшин, тэдгээр хүмүүсийн хүйс, нас, тодорхой оршин суугаа хаяг зэрэг мэдээллүүдийг авахыг эрмэлзэж байх;

Зах зээлийн судалгааны дүн шинжилгээ, нөхцөл байдлын судалгаа

Хэдийгээр асуусан асуултууд, цуглуулах мэдээлэл нь эдийн засгийн үйл ажиллагаа, зах зээлтэй холбогдох боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нь дүн шинжилгээний хэсэг болсон байх хэрэгтэй. Жишээ нь, хэрэв тодорхой салбар эсвэл зах зээлийн боломж хөгжлийн бэрхшээлтэй хмүүст бололцоотой бол үүнийг тэмдэглэж авах хэрэгтэй. Хүнсний үйлдвэрлэлийн боломж нь эрэлт хэрэгцээ ихтэй суралцахад амар байдаг бөгөөд ихэвчлэн бичиг үсгийн хувьд тааруухан мэдлэгтэй хүмүүс энэ салбарыг сонгодог бөгөөд ихэнх тохиолдолд сургуульд суралцаж байгаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирох боломжтой юм.

Орон нутгийн иргэдийн цуглаан

Орон нутгийн иргэдийн цуглаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг оролцуулж байх хэрэгтэй. Цуглааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэхэд орон нутгийн зүгээс хийж болох үйл ажиллагааны талаар санал солилцож байх нь зүйтэй. Уг цуглааныг зохион байгуулж, удирдаж

байгаа хүмүүс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цуглааны зорилго, ач холбогдолыг ойлгуулах талаар анхаарч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд санал бодлоо илэрхийлэх боломж олгож байх хэрэгтэй.

Сургалтын хэрэгцээг тодорхойлох

Сургалтын хэрэгцээг тодорхойлох арга хэрэгслүүдийг боломжит бусад хэлбэрээр хараагүй, сонсолгүй, бичиг үсгийн мэдлэггүй хүмүүст зориулж тэдгээрт энэ талаар мэдэгдэх арга хэмжээг авах хэрэгтэй. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй байдал нь тухайн хүний сургалтад оролцох боломжийг хязгаарлаагүй гэдгийг анхааралдаа авах нь зүйтэй. Судалгааг явуулж байгаа хүмүүс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тодорхой мэдээлэлтэй байж, хөгжлийн бэрхшээлд мэдрэмжтэй хандаж байх шаардлагатай.

Үйл ажиллагаа 3.Сургалтын загвар, зохион байгуулалт, сургалтыг хүргэх үйл ажилагаа

Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал энэ үе шат хүртэл зохистой журмаар явагдаж ирсэн бол сургалтыг зохион байгуулахад асуудал гарахгүй байх магадлалтай бөгөөд тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сургалтад хамрагдах болно. Сургалтын үйл ажиллагаатай холбогдох ерөнхий мэдээлэл өгөгдсөн байгаа учир энэ хэсэгт зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд тусгайлан анхаарал хандуулах болно.

Сургалтын дамжааны төлөвлөгөөг бэлтгэх

Сургалтын дамжааны төлөвлөгөөг бэлтгэхэд дараах зүйлд анхаарал хандуулсан байх хэрэгтэй. Үүнд:

- Над захын хэрэгцээ шаардлагыг хангахуйц тоноглол болон тоног төхөөрөмж болон сургалтын материал;
- Сургалт болох газрыг бэлтгэхэд тодорхой хэмжээний хөрөнгө төсөвлөх;
- Сургалтын төрөл бүрийн арга, аргачлалыг хэрэглэх боломж бүхий уян сургалтын хөтөлбөрийг боловсруулах;
- Сургалтын явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх хүмүүсийг тусгайлан бэлэн байлгах бөгөөд эдгээр нь сургагч, төслийн ажилтнуудаас бүрдэж болно;
- Тодорхой сургагчдын шаардлага хэрэгцээнд нийцсэн байдлаар сургалтын материал бэлтгэх.

Сургагч багш нарыг сонгож бэлтгэх

- Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан туршлага зайлшгүй шаардлагатай бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахад дэмжлэг үзүүлэхэд боломжтой байгууллагуудыг тодорхойлох. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан туршлага бүхий нэг сургагчийг дор хаяж сонгож авах нь хэрэгтэй бөгөөд энэ сургагч нь бусад сургагчдад туршлага нэвтрүүлж, зөвлөгөө өгөх боломжтой;
- Сургагчийн сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажиллах харилцааг уялдуулах;
- Сургагчийн сургалтад дадлагажуулах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах.

Сургагч нь хөгжлийн бэрхшээлийн талаар наад захын мэдлэгтэй байж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшинг тодорхойлох чадвартай байх хэрэгтэй. Дээрх төрлийн мэдээллийг тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг төрийн болон ТББ-ын төлөөллөөс авч болох бөгөөд энэ ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн харьцах, тэдэнтэй ажиллах, тулгарч болзошгүй бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвөлгөө өгөх боломжтой байна.

Суралцагчдыг сонгох

- сургалтад хамрагдах хүсэлт гаргах загварыг тэдэнд хүртээмжтэй болгох;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгож авахдаа тодорхой хэв шинжийг шаардсан нөхцлүүдийг тавихгүй бай;
- тэдгээр нь учирч болзошгүй бэрхшээл хүндрэлүүдийг хэрхэн даван туулах чиг хандлагатай байгаа талаар судлах;
- суралцах хүсэлт гаргагч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй шууд уулзаж, ямар нэгэн нэмэлт тоноглол, нөхцөл байдал шаардлагатай эсэхийг лавлах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй сургалтын хөтөлбөрийн түнш хэлбэрээр ярилцаж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хэрэв боломжтой бол сургалт эхлэхээс өмнө дээрх шаардлагуудыг хангах;
- хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн зөвшөөрөлтэйгээр түүний гэр бүлийнхэнтэй уулзаж, санал солилцож мэдээлэл авах;
- сургалтад хэд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулахыг хичээ. Ийм тохиолдолд тэд өөрсдийгөө тусгаарлагдсан, гадуурхагдсан гэсэн бодлоосоо хөндийрнэ. Ялангуяа дохионы хэллэгээс хамааралтай сонсголын бэрхшээлтэй хүмүүст илүү хамраалтай. Учир нь хэрэв өөр дохионы хэлээр ярьдаг хүн байхгүй бол бусадтайгаа харьцаж чадахгүй тусгаарлагдсан мэт сэтгэгдэл төрөх болно;
- сургалтад хамрагдах тухай хүсэлтийг зөвхөн ёс төдий хүлээн авах хэрэггүй, хүсэлт гаргагч чин сэтгэлээсээ сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа тохиолдолд хүлээн авах хэрэгтэй;

- хэрвээ тухайн хүн нь сургалтын явцад өөртөө итгэлгүй байдал, мэдлэг, эсвэл бусад тодорхой шалтгаанаар сургалтыг дуусгаж чадахгүй гэх магадлалтай байвал түүнийг ижил төрлийн магадлалтай бусад суралцагчидтай хамт байлгаж өөртөө итгэх итгэл, үйл ажиллагааны зааварчилгаа, ур чадварын анхан шатны мэдлэгийн талаар зааж, зоригжуул;
- ердийн сургалтад хамрагдах боломжгүй хүмүүст зориулж бусад боломжит сургалтын арга хэрэгслийн боловсруулах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн квот тогтоож тэднийг сургалтад бүрэн хамрагдах боломжийг бүрдлүүлэх арга хэмжээ авах. Гэхдээ хэт олон хүсэлт гарагчид байгаа тохиолдолд тэднээс баттай амжилтанд хүрнэ гэсэн магадлалтай хүмүүсийг түрүүлж сонгож авах хэрэгтэй.

Сургалт, хичээлийн төлөвлөгөө, сургалтын материал

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн сургалтын зарчим нь суралцагч төвтэй уян хатан байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүн үүний үр шимийг хүртэх ёстой. Хичээлийн төлөвлөгөө боловсруулахад дараах зүйлийг анхаарсан байвал зохино. Үүнд:

- материалын формат нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл авах бололцоотой байна;
- практик чиг хандлагыг ашиглах;
- хичээлийн явцад төрөл бүрийн арга хэмжээ болон хичээлийг ойлгуулах арга зүйг сонгож авсан байх хэрэгтэй бөгөөд суралцагчдад тусгайлан хандах хандлагыг боловсруулсан байна;
- хичээл заахад шаардлагатай туслах тоног төхөөрөмжийг урьдчилсан байдлаар тооцоолж бэлтгэсэн байх. Тухайлбал, хараагүй хүнд, бичиж авах боломжгүй хүнд зориулсан хуурцаг;
- тухайн суралцагчийн хөгжлийн бэрхшээлтэй байдалд тааруулж үнэлгээ өгөх арга боловсруулсан байх жишээ нь, хараагүй хүнээс амаар шалгалт авах, харин сонгосолгүй хүнээс бичгээр шалгалт авах;
- хөгжлийн бэрхшээлтэй эсвэл ангиас ерөнхий байдлаар хоцорч байгааг суралцагчидтай хэрхэн ажиллах талаар төлөвлгөөтай бай.

Сургалтыг хүргэх

Сургалтыг явуулах үндсэн аргууд нь дийлэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэглэж болохуйц байдаг. Харин тодорхой төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү онцлог арга хэрэгсэл хэрэглэх шаардлага гарна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нь лекц, тайлбар, биетээр үзүүлэх, дадлагажуулах, гарын авлага тараах хэлбэрээр заах асуудлыг шийдвэрлэх, даалгавар биелүүлэх зэргийг ерөнхийд нь гүйцэтгэх боломжтой байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандаж хичээл заах аргачлалыг тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшингөөс хамааран сонгож авна. Жишээ нь, сонгсолын бэрхшээлтэй иргэн тайлбарласныг ойлгож чадах боловч ямар нэгэн байдлаар унших, дохионы хэлээр, эсвэл уруулын хөдөлгөөнөөр үзсэн зүйлээ баталгаажуулж авна.

Ихэнх тохиолдолд биетээр үзүүлэх аргыг хэрэглэх боломжтой боловч энэ арга нь хараагүй хүний хувьд хэрэглэж болохгүй юм. Үүний оронд тус хараагүй хүний гарыг өөрөө удирдаж, хэрхэн хийх талаар зааварчилга өгнө. Хавсралт 8.4.-д төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн зааж болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байгаа.

Олон орнуудын хувьд боловсролын хөтөлбөрт нь багш олон зааварлагчдыг дээр дурьдсантай ижил нөхцөл байдлуудад хичээл заах аргыг оруулсан байдаг бөгөөд хэрэв шаардлагатай болон олон улсын туршлагаас судалж болно.

Сургалтыг явуулах

– хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ангийн бусад гишүүнтэй харьцдагтай адил харьцах;
– тэдний амжилтыг сайшааж урамшуулах, боломжтой тохиолдолд ангийн үйл ажилагаанд иэдвхтэй оролцуулах арга хэмжээ авах;
– хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй суралцагчид нь хоорондоо хэрхэн харьцаж байгаад байнга анхаарал хандуулж байх хэрэгтэй бөгөөд тэднийг хамтран ажиллуулах талаар уриал.

Үе шат 4. Бичил үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цалинтай хөдөлмөр эрхлэлтэд чиглэгдсэн сургалтын дараах дэмжлэг

Сургалтын дараах дэмжлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цаашдын үйл ажиллагааг амжилттай байлгах нөхцлийг бүрдүүлнэ.

Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өмнөх нийгмийн харилцаанд үндэслэн тодорхой дэмжлэгтэйгээр ажил хөдөлмөр эрхлэх эсвэл бизнесийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой. Гэхдээ нэгэнт хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, зээл авах зэрэг асуудалд ихэвчлэн хүндрэл бэрхшээлтэй учирч байдаг тул дээрх чиглэлүүдээр илүү их эрчимтэй дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

Төлөвлөлт

Төлөвлөлт хийхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тухайн орон нутгийн ард иргэдийн дундаас зохион байгуулбал илүү үр дүнтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сургалтын дараа дэмжлэг үзүүлэх нь дараах дэмжлэг болон хүмүүсийн оролцоог хангасан байна. Үүнд:

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын удирдлага, зааварлагч;
- албан болон албан бус тосгоны удирдлага;
- өөрийн үйл ажиллагааг эхлүүлэн явуулж байгаа орон нутгийн үйлдвэрлэгч;
- нөхөд болон гэр бүлийн гишүүд;
- орон нутгийн дэмжлэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслалцаа үзүүлэх ТББ-ын ажилтан;
- хамтран ажиллагч, шууд удирдах албан тушаалтан;
- өөр хөгжлийн бэрхшээлтэй хүн;
- хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө тодорхойлсон;
- бусад.

Цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цалинтай хөдөлмөр эрхлэлтийг баталгаажуулахын тулд ХЭЗЧДС-ын хөтөлбөрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

1. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, боломжийн талаар тайлбарлан таниулах;
2. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олоход нь туслах;
3. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст буцаж ажилдаа орох боломжийг бүрдүүлэх;
4. ажил олгогч, үйлдвэрчний эвлэл болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сүлжээнд хамаруулах арга хэмжээг авах;

1. Тайлбарлан таниулах

Ажил олгогчид тухайн орон нутгийн бусад хүмүүстай адил бөгөөд тэдгээрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлага нь ихэвчлэн адилхан байдаг. Хэрэв тухайн орон нутгийн зүгээс уг хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон нутгийн иргэдийн зүгээс өрөвдсөн дорд үзсэн байдлаар хандвал ажил олгогчид ч гэсэн тухайн байр сууринаас хандах болно. Олон ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг авч ажиллуулж байсан бөгөөд тэднийг сайн ажилчид гэж магтдаг байна.

➔ **Хавсралт 8.5-аас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд оруулах болон бусад хэрэгцээтэй мэдээллийг үзнэ үү.**

ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс ажил олгогчдод хандан тодорхой уулзалтууд, хамтран ажиллах гэрээ зэргийг танилцуулах зэргийн үйл ажилагааг явуулах бөгөөд тухайн хүн хөгжлийн бэрхшээлтэй гэгдэх боловч сургалтад хамрагдсаны үр дүнд тухайн байгууллагын шаардлагыг хангах боломжтой гэдгийг ойлгуулах нь зүйтэй

2. Ажилд ороход нь туслах

Зарим сургалтын түншүүд нь ажлын байр олж өгөх ажилтан, төрийн болон бусад ажил өгөх байгууллагуудтай холбоотой байж болно. Хөдөлмөр эрхлэх, ажилд оруулах үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд нь зарим тохиолдолд хөгжлийн бэршээлтэй хүмүүсийн талаар буруу ойлголттой байж болох бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цаашдын хөдөлмөр эрхлэх явцад муугаар нөлөөлдөг. ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн зүгээс төгсөгчдөд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй төгсөгчдийг ажлын байртай болгохыг хичээнэ.

Хөтөлбөрийн зүгээс дараах зүйлд анхаарал хандуулна:

- Хөгжлийн бэрхшээлтэй нөхцөл байдлаа уялдуулан ажил хайх ур чадварын талаар зааварчилгаа өгөх;
- Ажил хайхад шаардлагатай бичиг баримтын талаар мөн ажлын байрны талаарх мэдээллээр хангах;
- Тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхцөл байдалд таарах дүн шинжилгээг хийж өгөх;
- Тээвэрлэлт болон бусад бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Ажлын байран дээрх холбогдох тоноглолын талаар зохицуулалт хийх.

Шаардлагатай тоноглолын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах;

➔ **Хавсралт 8.1-ээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажил олоход дэмждэг үйл ажиллагаатай холбогдох арга хэрэгслүүдийг харна уу.**

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байраа хадгалах талаар дэмжлэг туслалцаа үзүүлэх

Нэгэнт тухайн хүн ажлын байртай болсон тохиолдолд ажил олгогчийг түүний онцлог нөхцөлд дасгах хэрэг гарна. Энэ хугацаанд тухайн ажилтан нь тавигдах шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж байх хэрэгтэй. Хөгжлийн бэршээлтэй хүн энэ талаар дараах зүйлийг мэдэж байх хэрэгтэй. Үүнд:

- наад захын хэрэгцээний хэрэгсэл тоноглол шаардлагатай эсэх;
- тухайн ажлын талаар зааварчилгаа өгөх, сургах маягаар дэмждэг, туслалцаа өгөх хүмүүсийг тодорхойлох;
- шинэ ажлын байранд зохицоход хэрэгцээтэй сэтгэл зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх;

4. Бусад агентлаг, нийгмийн түншүүдтэй сүлжээ тогтоох

Зарим орон нутагт хөгжлийн брэхшээлтэй хүмүүст цалинтай хөдөлмөр эрхлэх тусгай хөтөлбөр байдаг. Дээрх байгуулагуудын сүлжээнүүд зөвхөн ажлын байр олоход туслахаас гадна тухайн ажилд зохицах зааварчилгаа зөвлөмжөөр хангах байдлаар туслалцаа

дэмжлэг үзүүлдэг байна. Төгсөгчдийн цаашдын үйл ажиллагаанд судалгаа хийж байгаа болон сургалтын дараа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хариуцаж байгаа хүмүүс нь ажлын байран дээрээ бэхжиж авах тал дээр мөн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.

Бичил үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь

Өөрийн гэсэн бизнесийг эхлүүлэх гэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусдын адил бизнесийг хөгжүүлэх үйлчилгээ авах шаардлагатай байдаг. Ниймгээс гадуурхагдсан бусад хүмүүсийн адил тэд өөртөө итгэх итгэл багатай байх, тухайн ажлыг зөв зохион явуулах тал дээр эргэлздэг байна. Иймд тэдэнд сургалтын дараа дэмжлэг үзүүлэх баг нь дараах тодорхой асуудлаар дэмжлэг үзүүлэхийг шаардаж магадгүй. Үүнд:

- дэмжлэгийг зохион байгуулах;
- зээл авахдаа дэмжлэг үзүүлэх;
- үйлдвэрлэл эрхлэх боломжтой орон зайтай болоход туслалцаа үзүүлэх.

Хоршооллууд

Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хамтарч эсвэл түншлэх хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, хоршоолын үйл ажиллагаанд оролцох, гэр бүлийн гишүүдтэйгээ хамт ажиллаж болно. Хэрэв суралцагч нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй, цалинтай хөдөлмөр эрхлэлт, өөр бусад арга байхгүй бол ингэх нь хамгийн боломжтой хувилбар байж болох юм. Ажлыг хуваах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн, түншүүд эсвэл өөр гишүүд нь өөрсдийн боломжид нийцсэн хувь нэмэр оруулж, бизнесийн үйл ажиллагааг явуулж болно. Хан Хатчийг санаж байгаа биз, түүний хүү аавынхаа хийсэн бүтээгдэхүүнийг зах дээр аваачиж борлуулдаг байсан. Өөр бас нэг жишээнд Камбожид, оюун санааны хөгжлийн бэрхшээлтэй нэгэн бүсгүй бургасаар сагс нэхэж чадахгүй байхад нь сайн дураараа санал нийлсэн хэсэг хүмүүс түүнд туслаж хэрхэн сагс хийхийг зааж өгснөөр түүнийг энгийн бүтээгдэхүүнийг бие дааж хийх боломжийг бүрдүүлсэн байна. Ингэснээр тэр бүсгүй энгийн жижиг сагс хийж суран жижиг бүлгийн үйл ажиллагаанд хамтран оролцож, орлого олох болсон. Илүү чадварлаг сүлжигчид өөрсдийн цаг завыг түүнд зориулж, өөр загварын сагс хийхийг заажээ.

Зээл авах

Зээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хүндрэлтэй асуудал юм. Учир нь тэд ядуугийн ядуу байх магадлал ихтэй байдаг бөгөөд тэдэнд зээлийн барьцаанд тавих эд хөрөнгө ховор байдаг. Үүнээс гадна бичил санхүүгийн байгууллагууд нь тэднийг зээлээ төлнө гэдэгт эргэлзэж, зээл олгохдоо татгалздаг. Иймд ХЭЗЧДС-ын төслийн ажиллагчид дээрх санхүүгийн байгууллагуудын зүгээс таатай уур амьсгал бүрдүүлж бэрхшээлүүдийг арилгаж зээл авах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нэн ядуу хүмүүст зээл олгох аргуудыг боловсронгуй болгох талаар нилээд аргачлал боловсруулагдсан бөгөөд эдгээрийн нэг нь зээлийг баталгаажуулж өгөх, хадгаламжийн тойргийг бий болгох болон бусад арга хэлбэрүүд үүнд хамаарна:

Наад захын хэрэгцээг хангасан нөхцөл

Тухайн хүн өөрийн гэсэн бизнестэй гэдэг нь түүнд наад захын шаардлага хангасан ажлын нөхцөл шаардлагагүй гэсэн үг биш юм. Дараах зураг нь авхаалжтай зохион байгуулсан үсчний газрын шийдлийг харуулна. Энэ зохион байгуулалт нь түүнийг үндсэн ажлаа илүү амарханаар, таатай нөхцөлд хийх боломжийг бүрдүүлж байгаа юм. Наад захын хэрэгцээг хангасан нөхцлийг бий болгоход зориулалт бүхий өртгийг байнга тооцоолсон байх хэрэгтэй. Түүнчлэн дахин хүн нэмж авах боломжийг харгалзах ч мөн бодуушатай зүйл юм.

Үе шат 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, баримт бичиг хөтлөх үйл ажиллагаа дах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тооцож, бодолцож байх нь маш чухал. Ихэнх тохиолдолд хүмүүс тэднийг ядуус, эмзэг, гадуурхагдсан бүлэгт хамруулан ханддаг боловч үнэн хэрэгтээ зарим тохиолдолд орхигдсон хэсэгт хамаарагдах ч тохиолдол байна. Олон жилийн туршид тэднийг тоохгүй байсаар ирсэн нь “та нарыг тооцохгүй” гэсэн чиг хандлага нийгэмд суурьшсан. Эдгээр хүмүүс нь шинэ ур чадварт суралцаж өөрсдийгөө мэдрүүлж, өөрсдийнхээ хэрэгцээг шаардах хүртэл нилээд цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардагдах болно, гэхдээ одоо эхлэх цаг нь болсон санагдаж байна.

Хяналт-шинжилгээ

ХЭЗЧДС-ын төслийн явцын хяналт-шинжилгээний үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглүүлэн явуулж буй үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах ёстой. Зорилго нь тухайн орон нутгийн бүхий л бүрэлдэхүүн хэсгийг үйл ажиллагаанд хамруулах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь үүний нэг хэсэг юм. Хяналт-шинжилгээ нь ХЭЗЧДС-ын бүхий л асуудал болон үе шатад хамааралтай. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдэнд хамаарах асуудал нь Нэгдүгээр үе шатад хамаарах төлөвлөлт, зохион байгуулалтын бүрэлдэхүүн хэсэгт ороогүй бол дараа дараагийн шатууд амжилттай болно гэдэгт итгэхэд хүндрэлтэй. Иймд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ нь

анхны үе шатаас эхлэх ёстой.

Хяналт-шинжилгээ хийх, хяналт шинжилгээний үр дүнг эргэн харах үйл ажиллагаа нь тодорхой давтамжтайгаар байнга үргэлжилж байх үйл ажиллагаа юм. Хэрэв хяналт-шинжилгээний үр дүн тааламжтай биш байвал төслийн стратегид шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах хэрэгцээ гарна. Жишээ нь, хэрэв орон нутгийн уулзалтын зарыг хүргэх ажиллагаа саатснаас болоод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс уг хуралд оролцож чадаагүй бол хэл хүргэх болон холбоо барих арга барилд өөрчлөлт оруулах шаардлага гарна.

Үйл ажиллагаа бүрийн үр дүнг холбогдох мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат бүрд тооцож байх хэрэгтэй. Энэ ботид хөгжлийн бэрхшээлийн асуудалд ямар чиг хандлага баримтлах талаар дэлгэрэнгүй дурдаж, санал, зөвлөмж өгч байгаа боловч төсөл бүр тухайн орон нутгийн онцлог, бодит байдалд нийцүүлсэн тусгай арга хэмжээ, аргачлалыг боловсруулх нь зүйтэй.

Үнэлгээ

Хөгжлийн бэрхшээлийн чиг хандлагаас авч үзвэл ХЭЗЧДС нь хөтөлбөрт оролцогсод, тэдгээрийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулан, тэдэнд хэрэглэхүйц ур чадварыг бий болгож байгаа эсэх талаас нь үнэлгээ хийгдэж байх ёстой. Мэдээж амжилтыг хэмжих үзүүлэлтүүдийн нэг бол тухайн хүний ажлын байрыг хадгалж үлдээх эсвэл бизнесийн үйл ажиллагааг эхлүүлэх, тухайн ХЭЗЧДС-ын оролцогчийн бодит орлого нэмэгдсэн байх үзүүлэлт юм. Нийгмээс гадуурхагдсан бүлгүүдийн хувьд тэдэнд хамаарах үзүүлэлтүүдийн өөрөөр авч үзэх үзүүлэлт юм. Тухайлбал, өөртөө итгэлтэй байдал, гэр бүл, гэр бүлийн амьдралд гарсан өөрчлөлтүүд, нийгмийн, орон нутгийн үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, нийгэм эдийн засгийн хэмжигдэхүүн дээр үндэслэн тодорхойлж болох юм.

ХЭЗЧДС-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох асуудлын амжилтыг үнэлэхэд оролцогчдыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гэдгээр нь багцалж авч үзэхээс гадна хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшин зэргээс гадна тэдэнд үзүүлсэн үйлчилгээ, тэднийг суралцахад бэлтгэсэн орчин зэргийг харгалзаж үнэлгээ өгч байх нь зүйтэй юм. Ингэснээр тухайн төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүргэсэн эсэхийг харгалзан үнэлгээ дүгнэлт өгөх боломжтой болно.

Нэгэнт ХЭЗЧДС-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанд орон нутгийг чадавхижуулах арга хэмжээ хамаарч байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, тэдний үйл ажиллагааг дэмжиж буй байдал, чадавхижсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох тухайн орон нутагт шинээр бий болсон үйчилгээ зэргийг харгалзан дүгнэх хэрэгтэй.

Мэдлэгийг түгээх асуудалд үнэлгээ өгөхдөө мөн л тухайн үйл ажиллагааны онцлогт нийцсэн арга хэрэгслийг үнэлж, үнэлгээг тооцох аргачлалыг сонгох нь зүйтэй. Үнэлгээ өгөх явцад тодорхой асуулт асууж, түүнд хэрхэн хариулж байгаагаар үнэлгээ өгөх боломжтой. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөтөлбөрийн төлөвлөлт загварыг боловсруулах, үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагаанд оролцуулахын тулд ямар чиглэлийн үйл ажиллагааг ашигласан бэ? Ямар арга нь хамгийн үр дүнтэй байсан бэ? Оролцоог хангахын тулд ямар арга хэмжээ нь илүү үр дүнтэй бэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллахад ХЭЗЧДС-ын зохион байгуулагчид, түнш байгуллагууд, түнш байгууллагуудын ажилагчдад тулгарч байсан бэрхшээл хүндрэлүүд юу байсан бэ? Эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй стратеги аль нь вэ? Ямар сургалтын арга зүй нь төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн үр дүнтэйгээр нөлөөлсөн бэ? Ямар сургамжуудыг авсан бэ? Ямар шалтгаан ажил олгогчдод нөлөөлсөн бэ?

Бичиг баримтжуулах

Бичиг баримтжуулах үйл ажиллагаа нь олон талын ач холбогдолтой. Энэ нь хариуцлага тооцох, хяналт-шинжилгээ хийх, тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай мэдээллээр хангах, үнэлгээ хийх зэрэг бүхий л үйл ажиллагааны хувьд чухал. Бичиг баримтжуулах үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах,тайлан бичих зэргийг хамруулна. Хөгжлийн бэрхшээлийн чиг хандлагаас харвал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургалт, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамруулах тал дээр туршлага мэдлэг дутмаг байна. Ялангуяа энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах хөрөнгө санхүүгийн боломж хязгаарлагдмал хөгжиж буй орнуудын жишээн дээр илүү харагддаг. Иймээс бичиг баримтжуулах үйл ажиллагаанд дараах зүйлийг хамруулах хэрэгтэй. Үүнд:

- төслийн бичиг баримтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг иш татах;
- төслийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг жинхэнэ утгаар нь оролцуулах талаар дүрэм журам зааварчилгаатай байх;
- хөгжлийн бэрхшээлтэй холбогдох төслийн тайлан, уулзалтийн тэмдэглэл, судалгаа, дүн шинжилгээг баримтжуулах. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох боломжгүй бол ямар шалтгаан байсныг тодорхой баримтжуулах;
- хэрэв ямар нэг асуудал, хүндрэлтэй байдал, бэрхшээл нь хөгжлийн брхэшээлтэй хүнийг оролцуулахад хүндрэл учруулсан бол тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, цаашид энэ талаар ямар тодорхой арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байгааг баримтжуулах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүн төслийн төлөвлөлт, загвар боловсруулах үйл ажиллагаа, хурал, хяналт

шинжилгээ, бусад олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон талаар тэмдэглэл хөтөлж баримтжуулах;

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сургалтад хэрхэн оролцож байсан, ямар сургалтад идэвхтэй оролцсон, тулгарсан саад бэрхшээлийг арилгахад ямар чиг хандлагыг баримталсан, уг чиг хандлага хэрхэн нөлөөлсөн талаар тэмдэглэл хөтлөх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрхэн сургалтад хамрагдсан, юу сурсан, ямар ур чадвартай болсон талаар бодит жишээ;
- үлгэр дууриал болох амжилтын талаарх сурталчилах;
- сургалтын техник, үр шим, тулгарсан бэрхшээл,хүндрэлүүд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой баримтжуулх хэрэгтэй.

Хавсралт 8.1 Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зөвлөмж, лавлагаа

үнийг авахын тулд e-mail to disability@ilo.org эсвэл интернетээс дараах хаягаар татаж авна уу http://www.ilo.org/public/English/employement/skills/disability/publ/index.htm

Нөлөөллийн лавлагаа: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Олон улсын өдөр

Тайлан: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боломжтой ажил

03.12.2007. ОУХБ, 2008

Хөгжлийн бэрхшээлтнэй хүмүүст хөдөлмөр эрхлэлтийг олоход нь туслах: практик зөвлөмж Р. Херон ба Б. Мюррай

Ази Номхон далайн хэвлэл. ОУХБ, 2003 (эмхэтгэл I, II, 1997,Араб, Химер, Мандарин, Вьетнам болон Тай хэл дээр хэвлэгдсэн)

Биднийг оролцуулан тоол! Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хэрхэн оролцуулах боломжтой вэ. ОУХБ, 2008.

Хөдөлмөр эрхлэх боломж Ази Номхон Далайн бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөдөлмөр эрхлэлтийн зааварчилгаа. Д.А.Перри. ОУХБ, 2007

Ажилд орох: Хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдад зориулсан зөвлөмж, хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдад зориулсан сургалт явуулах сургагчийн гарын авлага. ОУХБ, 2008.

Ажилд орох: Хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдад зориулсан сургалт явуулах сургагчийн гарын авлага. ОУХБ, 2008.

Хөгжлийн бэршээлтэй охид, эмэгтэйчүүдийг мэргэжлийн сургалтад нэгтгэх нь: практик зөвлөмж. Пуу Гаик Сим ОУХБ, 1999

Ажил болон хөдөлмөрийн дүн шинжилгээ: хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж ажил тодорхойлох зааварчилгаа. ОУХБ. 2005,

Франц болон испани хэл дээх хэвлэгдсэн.

Амжилтыг удирдах: АППТ-ийн мэдээллийн сан болон менежментийн мэдээллийн системийн талаарх гарын авлага. ОУХБ. 2008

Урагшаа явах нь: Хөгжлийн бэршээлтэй хүмүүст боломжит ажлыг олгохын төлөө урагшаа. Ази болон Номхон далайн мэргэжлийн сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн жишээ, туршлага. Д.А.Перри. ОУХБ. 2003

Хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдыг ажлын байртай болгох: үр дүнтэй үйчилгээний элемент. Б.Мюррай ба Р.Херон. ОУХБ. 2003 Ази Номхон далайн хэвлэл. ОУХБ, 2003/2 дах эмхэтгэл 1997, Химер, Мандарин, Вьетнам болон Тай хэл дээр хэвлэгдсэн, Карибд мөн хэвлэгдсэн болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтад хамруулах талаар мэргэжлийн багуудын уулзалт. Тайланд 14-16. 02. 2006. ОУХБ.

Амжилтыг магтан дуулах нь: Камбожид хэрэгжсэн ядуурлыг албан бус сургалтаар бууруулах. (Видео) ОУХБ. 2008

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжит хөдөлмөрлөх эрх. Артур О'Релли, ОУХБ. 2007

Амжилтын төлөө сургах нь: албан бус сургалтын зааварчилгаа. ОУХБ. 2008.

Хавсралт 8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай тоноглолын жагсаалт

Төрөл	Хөгжлийн бэрхшээлийн жишээнүүд	Шаардлагатай тоног төхөөрөмжийн жишээ	Ажилахад хэрэгцээтэй тоноглол	Тоноглолын жишээ
Физологоийн хөгжлийн бэрхшээл: физологийн үйл ажиллагаатай холбогдох хязгаралалт (явах, хөдөлгөөн, эрч хүч гэх мэт)	Хөдлөх чадвараа алдах гэдэг нь: лимп алдагдах, нугасны болон нурууны гэмтэл гэх мэт. Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл гэдэг нь өвчин болон гэмтлээс үүссэн булчингийн сулрал гэх мэт. Эрч хүчний хөгжлийн бэрхшээл гэдэг нь төрөл бүрийн өвчний улмаас үүсс эн ерөнхий доройтол Нюрологын бэрхшээл нь татах, зан ааш хувирахад хүргэнэ	Тэргэнцэр: гурван дугуйт мотоцикль, лимп, унахыг хянах эм гэх мэт	Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамаарна.Ихэнх нь суралцах хүндрэлгүй байдаг боловч бусад нь тоног төхөөрөмж, суралцах орчиндоо дасан зохицох хэрэгтэй байдаг. Хүч чадал, хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүст тодорхой төрлийн ажил, мэргэжил сонгох хэрэгтэй.	Өндөрсөгсөн ажлын ширээ, ариун цэврийн өрөөний тусгай шаардлага, хонгил, орц-гарцанд тараах сад, бэрхшээлийг холдуулах, ашиглахад хялбар хаалга, шүүгээ, хөлөө тайруулсан хүмүүст зориулсан тусгай гишгүүрүүд.
Мэдрэх эрхтэний хөгжлийн бэрхшээл: харах, сонсох, ярих	Хараа муу байх, ихэвчлэн хөгжиж буй орнуудад илэрдэггүй эсвэл бүр сохор болдог, сонсголын бэрхшээлтэй эсвэл дүлий,	Хараагүй хүний гараар уншихад зориулж хэвлэсэн бичмэл, цагаан таяг, хараагүй хүнд зориулагдсан сургалт (орчин тойрондоо явах, хөдлөх), сонсголгүй хүмүүст зориулсан дохионы хэлний зааварлагч, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан сонсголын аппарат.	Суралцах тусгай аргууд: ихэнх хөгжлийн бэрхшээлд дасан зохицох хугацаа хэрэгтэй. Ярианы бэрхшээлтэй тохиодолд бичгийн компьютер хэрэгтэй эсвэл сонсож байгаа хүний талаас тэвчээр хэрэгтэй.	Хараагүй хүний гараар уншихад зориулж хэвлэсэн бичмэл, том, тод үсгээр бичсэн материал, дохионы хэл, хараагүй хүмүүст зориулсан саад, бэрхшээлгүй зам, сургагч эсвэл чанга яригчийн дэргэд суух тусгай суудал.
Оюун санааны : сурах боломж нь бусдынхтай адил хурдан биш байх бөгөөд мэдээлэл хадгалахад хүндрэлтэй, энэ төрөлхийн хөгжлийн бэрхшээл ихэнх тохиолдолд төрөлхийн тархины гэмтэл, тэжээлийн доройтол болон бусад хүчин зүйлүүд	Дауны синдром	Мэргэжлийн болон хараат бус амьдралын хэв маягийн талаарх сургалт	Оюун санааны бэрхшээлтэй хүмүүс суралцаж чадна, гэхдээ тэдгээрт олон давтамж хэрэгтэй болох байх эсвэл даалгаварыг олон жижиг хэсэгт хуваах хэрэгтэй.	Арай урт хугацааны сургалтын цаг, зураг болон зураг хуудас хэрэглэх, ганцаарчилсан ажлын дадлага болон сургалт.

Суралцах хөгжлийн бэрхшээл: эдгээр нь оюун санааны хувьд зүгээр боловч мэдээлэл боловсруулах, сурах явцад өөр байдаг. Жишээ нь тоог бодох , цээжилэх, бичсэн зүйлийг ойлгох, мэдээлэл боловсруулахад хүндрэлтэй байдаг	Анхаарал төвлөрдөггүй	Ур чадаварт суралцах тусгай сургалт, дасан зохицох (ихэвчлэн хөгжсөн орнуудад боломжтой) техник сургалт	Өөр өөр заах арга зүйг хүн тус бүр дээр хэрэглэх шаардлага гарч болно. Гэхдээ, олон хөгжиж буй орнуудад суралцах хөгжлийн бэрхшээл илэрдэггүй эсвэл оюун санааны бэрхшээлтэй андуурагддаг. Нэгэнт хүн болгон өөрийн гэсэн илүүд үздэг сурах аргатай байдаг тул төрөл бүрийн сургалтын аргыг хэрэглэж байх нь зүйтэй.	Тухайн хүний суралцах эсвэл мэдээлэл авах боломжинд тохирсон байдлаас хамааран бичмэл эсвэл дуу авианы бичлэгээр хийсэн хичээлийн зааварчилгаа.
Сэтгэлзүйн хөгжлийн бэрхшээл: энэ нь ер бусын болон өөр өөр зан, сэтгэл хөдлөл, бодох, сэтгэх сэтгэцийн өөрчлөлтэй бөгөөд энэ нь өдөр тутам болж байдаг.	Сэтгэл зүйн цохилт, цочрол, сэтгэл хөдлөл	Хөгжлийн бэрхшээлтэй байдалдаа дасан зохицхын тулд эмчийн болон зөвлөхийн байнгын хяналтад байх шаардлагатай	Сэтгэл хөдлөл, цочирол суралцах явцад нөлөөлөх магадлалтай тул дасан зохицуулахын тулд эхний үед ганцаарчилж сургах нь зүйтэй байж болох юм.	Ажлын дадлага: илүү амар, тайван орчин, үнэлгээний зохицуулалт, нэмэлт урамшуулал.

Санамж: Энэ мэдээллийг Эрх тэгш хөдөлмөр эрхлэлийн итгэл (Шинэ Зеланд) Англиийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгогчдын форумаас авсан болно.

Хавсралт 8.3. Зохистой хэл яриа

*Санамж: Энэ мэдээллийг Эрх тэгш хөдөлмөр эрхлэлийн итгэл (Шинэ Зеланд) Англий Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгогчдын форумаас авсан болно.*Веб сайт: *eeotrust.org.nz.www.employers-forum.co.uk*Татаж авах: *www.eeotrust.org.nztoolkits/disabilitycfm?=practicaltips*

Хэл нь бидний аранжинг харуулдаг бөгөөд эргэн тойронд байгаа хүмүүсийн үзэл бодол зан төлөвийг илэрхийлдэг. Хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ярьж, хэлэхэд хэл маш чухал үүрэг гүйцэтгэнэ, Учир нь өөрийгөө буруу илэрхийлэх сөрөг ур дагаварт хүргэж, ёс зүйн хувьд буруугаар нөлөөлөхийн зэрэгцээ ажлын байрны тав тухыг алдагдуулах болно.

Өнгөрсөн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааруулан хэрэглэгдсээр ирсэн хэл нь хувь хүнд хамаарахаасаа илүү өвчин эмгэгд нь илүү хамааралтай байсаар ирсэн байна. Энэ нь хүнийг үгүйсгэж байгаагийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямар нэгэн чадваргүй харагдуулахаар тодорхойлж байсан байна. Өнөөдөр, хэл нь хувь хүний хөгжлийн бэрхшээлтэйг илэрхийлэхээсээ илүү түүний нийгмийн байр суурийг илэрхийлж байх ёстой.

Хэл цаг хугацааны туршид өөрчлөгдөж, хүнээс хүнд шилжиж байдгийн хувьд нээлттэй байж хувь хүний тодорхойлолтод нийцэж байх нь зүйтэй. Хэрэв та ямар үгийн сонгож авахаа мэдэхгүй, итгэлгүй байвал тус хүн өөрөө сонгох зүйтэй.

Зөвөлгөө

- Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг үг нь “тахир дутуу” гэдгийн эсрэг утгатай үг. Гол учир нь аливаа хүн, хэсэг бүлэг хүнийг дандаа хүн гэдэг үүднээс хандах нь чухал бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүмүүс гэх нь зохистой. “Хөгжлийн бэрхшээлтэй” гэх тодорхой оновчтой бус үг хэллэг хэлэх нь тухай хүнийг үгүйсгэж, зөвхөн тахир дутууг нь илэрхийлэх болно;
- Хоцрогдсон “тахир дутуу” эсвэл “дутуу” гэсэн үгсийг хэрэглэхгүй байх. Хэдийгээр эдгээр үгнүүд нь өмнө хэрэглэгдэж байсан болох боловч, орчин үед ихэнх нь хүнийг басамжилсан, дорд үзсэн хэмээн тооцогдох болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай ярьж байгаа тохиолдолд дорой, хүчгүй байдлыг илэрхийлсэн “хохирогч” эсвэл “зовж байгаа” эсвэл “хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн...” гэх мэтийн сөрөг үг, хэллэгийг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Олон хүний хувьд хөгжлийн бэрхшээл гэдэг бол тэдний амьдралын нэг хэсэг ба эмгэнэлт явдал биш юм;
- Хүмүүсийг нэгтгэсэн ерөнхий нэг бүлэгт хамааруулсан үг хэллэгээс цээрэл. “Хөгжлийн бэрхшээлтэйчүүд” эсвэл “оюун ухааны сааталтай” гэх мэтийн бүгдийг нь хамруулсан хэллэгүүд нь тэдгээрийг хөгжлийн бэрхшээлийнх нь төрлөөс үл хамааруулан хамтатгаж нийгмээс тусгайлсан нэг бүлэг болгож байгаа мэт санагдана. Эдгээр нь хөгжлийн бэхшээлтэй хүмүүсийг сул дорой, өвчтнүүд гэсэн ойлгоц өгч байгаа мэт харагдуулах болно;
- Сонсголгүй хүмүүсийн хувьд “хэлгүй, дүлий” гэж хэлэхээс зайлсхийх хэрэгтэй. Энэ хэллэг нь хоцрогдсон бөгөөд басамжилсан шинжтэй. Ямар ч тохиолдолд сонсголгүй хүмүүс дуугай биш бөгөөд ярьж чаддаг байхын зэрэгцээ авиаг ашиглаж чаддаг;
- “Оюуны хомсдолтой” гэдэг нь хоцрогдсон хэллэг бөгөөд ямар ч тохиолдолд хүнийг дорд үзсэнд тооцогдоно. Үүний оронд оюун санааны хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлох нь зөв юм;
- Тэргэнцэр нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдлөх эрх чөлөөг олгодог. Иймээс “тэргэнцэрт хадаастай” эсвэл “ тэргэнцэрт шигдсэн” гэхийн оронд “тэргэнцэр хэрэглэдэг” гэж байх нь зүйтэй;
- Хүмүүсийн өдөр тутамд хэрэглэдэг “дараа уулзана” , “чи энэ тухай сонссон уу”, “за, за би гүйлээ” гэх зэргийн хэллэгийг хэрэглэхээс бүү ай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэдэнтэй бусдаас ялгасан байдлаар харьцахад дургүй байдаг бөгөөд ингэснээр тэднийг эвгүй байдалд оруулж болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандаж байгаа тохиолдолд та бусад хүмүүстэй энэ тохиолдолд яаж харьцах байсан, яг л тийм байдлаар харьцах хэрэгтэй. Том хүнтэй хүүхэдтэй харьцаж байгаа юм шиг харьцах хэрэггүй.

Хавсралт 8.4 Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зорилусан сургалтын арга зүй

Санамж: Энэ мэдээллийг "Амжилтын төлөө суралцах нь: Албан бус сургалтын зааварчилгаа" (ОУХБ, 2008) авсан болно. Үүнийг Камбожид хэрэгжүүлсэн Албан бус сургалтаар ядуурлыг бууруулах төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд уг төсөл нь хөдөөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг албан бус сургалтын аргаар, ганцаарчлан болон бүлгээр ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулсан болно. Сургагчид нь хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс бүрдэж байсан бөгөөд бизнесийн, техник мэдлэгээ бусдад албан бус орчинд, богино хугацаанд зааж өгсөн юм.

Хэрхэн заах: албан бус сургалтын арга зүйн аргачлалууд

Бусдад ур чадвар, мэдлэг, хандлагыг заахын тулд өөр өөр арга барил, арга зүй хэрэглэхийг талаар мэддэг байх нь чухал. Нэгэнт нилээн хэдэн арга мэддэг болсон хойно та суралцагчдын онцлогт таарсан арга зүйг сонгож авч болно. Бид дараах арга зүйг санал болгож байна:

1. тайлбарлах эсвэл лекц хэлбэрээр заах;
2. үзүүлэх болон биетээр зааж өгөх;
3. үйлдлийг гүйцэтгэж байж сурах буюу шинээр нээх, дадлагажуулах;
4. дүрд тоглох;
5. асуулт, даалгавар хэрэглэх;
6. газар дээр нь очиж үзэх.

Та эдгээр аргуудаас ашиглаж сурахын зэрэгцээ бусдад зааж ч болох юм. Эсвэл та эдгээр аргуудыг өөрөө ч мэдэлгүйгээр хүүхэддээ эсвэл найз нөхөддөө ямарваа нэгэн зүйлийг заасан байж болох юм.

Тайлбарлах эсвэл лекц хэлбэрээр заах

Тайлбарлах гэдэг нь хэн нэгэнд аливаа зүйлийг хэрхэн хийхийг хэлж өгөх эсвэл мэдээлэл хийхийг хэлнэ. Тайлбрыг ярих хэлбэрээр эсвэл бичгээр хийж болно. Олон хүнд тайлбар хийх үйлдлийг ихэвчлэн лекц гэнэ.

1. Хамгийн ур дүнтэй хэрэглээ

- Хэрэв суралцагчид уншиж чаддаг бол тайлбарлах эсвэл лекц хэлбэрээр хичээлийг заах нь тайлбарыг амаар, бичгээр хийх нь сайн арга. Хэрэв суралцагчид бичиж чаддаг бол тэдгээр нь тэмдэглэл хийж болно;
- Богино хугацааны сургалтад сайн бөгөөд зааж буй хичээлийн талаар аливаа урьдчилсан мэдлэггүй бол тайлбарлах нь оновчтой арга юм;
- Лекцийг ихэвчлэн том бүлгүүдэд албархуу байдлаар зохион байгуулна;
- Практик ур чадварыг дан ганц лекц ашиглаж заах нь төдийлөн ур дүнтэй биш. Гэхдээ тайлбарлах аргыг бусад аргуудтай хоршин хэрэглэх нь маш ур дүнтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

Сонсголын бэрхшээлтэй иргэд (бүрэн эсвэл хэсэгчлэн сонсголгүй):

- хэрэв суралцагчид уншиж чаддаг бол бичгээр заах;
- хэрэв сургагчид, суралцагчид дохионы хэлийг мэддэг бол түүнийг ашиглах;
- энэ авлагад үзүүлсэн зураг, зурмал үзүүлэнгүүд нь ойлгоход амархан байдаг. Харааны бэрхшээлтэй иргэд /бүрэн эсвэл хэсэгчлэн хардаггүй/;
- хэрэв суралцагч хэрэглэж чаддаг бол брайлее буюу гараар унших төхөөрөмж;
- хараагүй биш, хараа муутай иргэдэд бол тод, томруун үсгээр бичиж заах.

Зөвөлгөө

- энгийн хэл хэрэглэх;
- холбогдох жишээ дурьдах;
- мэдээллийг логик холбоотой танилцуулах;
- хэрэв боломжтой бол үгээр, бичгээр, самбар дээр дүрслэх, зурж үзүүлэх зэргийг хамтатгах;
- хэрэв суралцагчдын зүгээс боломжтой бол тайлбарласан зүйлийг хэрхэн ойлгосон талаар самбар дээр зурж, дүрслэж үзүүлэхийг хүсэх;
- асуулт асуух, яриа өдөх зэргээр суралцагчдыг тайлбарлах явцад идэвхитэй оролцуулах.

2. Үзүүлэх болон биетээр зааж өгөх

Үзүүлэх болон биетээр зааж өгөх нь та суралцагсдын чухам юу хийхийг өөрийн жишээн дээр үзүүлэхийг хэлнэ. Зарим тохиолдолд сургалцагч сургагчийн хийж байгааг зөвхөн хардаг. Үзүүлэх аргаар заах нь харааны бэрхшээлтэй хүмүүсээс бусад төрлийн бүхий л хүмүүст заахад тохиромжтой арга. Үзүүлэх арга нь ялангуяа сонсголын бэрхшээлтэй иргэдэд юм заахад чухал арга.

Хамгийн ур дүнтэй хэрэглээ

- Үзүүлэнгээ тайлбарлах нь сайн ур дүнтэй байдаг. Суралцагчид нь аливаа даалгаварыг хэрхэн

биелүүлэхийг биетээр үзсэн тохиолдолд маш сайн сурдаг;

- Үзүүлэх болон биетээр харуулах нь ялангуяа олон шаттай, төвөгтэй даалгавар, үйлдлүүдийг гүйцэтгэх аргыг сургахад чухал байдаг. Та үйлдлүүдийг нь хэсэгчлэн, хооронд нь зайтайгаар, нэг бүрчлэн үзүүлж болно. Үзүүлэх явцад суралцагчтдаар гүйцэтгүүлж үзэж хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

Харааны бэрхшээлтэй иргэд /бүрэн эсвэл хэсэгчлэн хардаггүй/:

- Харааны бэрхшээлтэй суралцагчдад чухам яг ямар үйлдэл хийж байгаагаа хийх зууpаа ойлгомжтой, тодорхой тайлбарлах;
- Гарыг нь хүргэх, бариулах зэргээр гарын мэдрэмжийг ашиглуулах арга хэрэглэх нь зүйтэй (дор дурьдах "үйлдлийг гүйцэтгэж байж сурах" аргыг харна уу.)

Зөвөлгөө

- Суралцагчдад юү заах гэж байгаа талаараа сайн бодож, урьдчилсан байдлаар төлөвлөх;
- Үзүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай материал, багаж зэргийг гарын ойр байлгах;
- Үзүүлэхдээ удаанаар тайлбартайгаа хийж байх. Түүнчлэн та суралцагсдаас тэдгээр нь хэрхэн ойлгож байгаа талаар лавлаж асууж болно;
- Үзүүлэх аргыг "үйлдлийг гүйцэтгэж байж сурах" зэрэг бусад аргуудтай хослон гүйцэтгэх;
- Суралцагчдаар өөрийн хийсэн үйлдлүүдийг давтан хийлгэх;
- Суралцагчид чухам яг ямар үйлдийг буруу хийгээд байгааг зааж өгч, зөв хийсэн үйлдлийг нь сайшаах;
- Үзүүлж буй үйлдлийг хэд хэдэн удаа үе шат бүрээр нь салгаж үзүүлэх.

Жишээ. Үзүүлэх болон биетээр зааж өгөх

Хатагтай Шен Сопек буурцаны сүү гаргаж авахыг заасан тухай

Хатагтай Шен Сопек 37 настай, хоёр хүүхдийн ээж бөгөөд тэсрэх бөмөг дээр гишгэсний улмаас 1986 онд зүүн хөлөө тайруулсан юм. Хатагтай Сопек шар буурцагны сүүний үйлдвэрлэл явуулдаг бизнес амжилттай эрхэлдэг бөгөөд энэ бизнесээ ОУХБ-ын төслийн хүрээнд анх эхэлж байсан байна. Тэрбээр өөр зургаан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст буурцагны сүү хэрхэн гаргаж авах талаар зааж өгч сургасан байна. Сопек бусдад заахдаа ихэвчлэн үзүүлэнгээ тайбарлах аргыг хэрэглэдэг байна. Тэрбээр сонсголын бэрхшээлтэй хүнд заахдаа өөр арга хэрэглэхээс гарцаагүй байдалд орж байсан боловч ухаалаг арга сэдсэн байна. "Эхлээд түүнтэй харилцахад хэцүү байсан, учир нь тэр эмэгтэй намайг сонсохгүй байсан" хэмээн тэр хуучилсан. Тэр эхлээд дохио зангаа, зарим бичмэл дүрсүүдийг хэрэглэхийн зэрэгцээ тоонуудыг хуруугаараа үзүүлж ярилгүйгээр буурцагны сүү хэрхэн хийх талаар тайлбарлаж байсан байна. Сургалт ердийн болдгоосоо арай илүү удаан болсон байна. Сопек сурагчид зааж өгөхийн тулд удаа дараа давтаж үзүүлсэн бөгөөд сурагчийгаа сайн хийж суртал ихэд хичээл зүтгэл гаргасан байна. "Би ОУХБ-ын надад тусалсны адил өөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрөө туслаж чаддаг зүйлээ зааж өгч байгаадаа бахархаж явдаг" гэж тэр хэлсэн.

Үйлдлийг гүйцэтгэж байж сурах буюу шинээр нээх, дадлагажуулах

Суралцагчдаар өөрсдөөр нь аливаа үйлдлийг биечлэн гүйцэтгүүлэх нь сургалтын бас нэг чухал, ач холбогдол бүхий аргуудын нэг юм. Энэ нь мөн сургалтын үр дүнг, суралцагчид хэрхэн суралцаж байгааг харж шалгах нэг арга юм. Үйлдэж байж сурах нь хэний ч хувьд сурахад дөхөмтэй арга мөн. Энэ аргыг боловсрол, суралцах чадварын хувьд хязгаарлагдмал хүмүүст заахад хэрэглэхэд тохиролжтой.

Энэ арга зүйн чиг хандлагуудыг дор дурдав:

а).Зааварчлах

Зааварчилгааг амаар, биетээр хийж болно. Амаар хийж байгаа тохиолдолд сургагч суралцагчид үйлдлийг хэхэн хийхийг хэлж өгнө. Сургагч нь тухайн хүнд үйлдлийн алхам бүрийг зааж өгнө. Биетээр үзүүлж байгаа тохиолдолд сургагч суралцагчийн гарыг / эсвэл тухайн үйлдлээс хамааран/ гарыг давхар барьж яг хэрхэн үйлдэхийг аярханаар үзүүлнэ. Та биетээр үзүүлэхээс өмнө суралцагчаас заавал зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

б).Шинээр нээх

Сургагч суралцагч өөрөө учрыг нь олж, хэрхэн хийх аргаыг тодорхойлох боломжтой нөхцлийг бүрдүүлнэ. Тухайлбал, суралцагсдыг зах дээр аваачиж ямарваа нэгэн холбогдол бүхий зүйлийг үзүүлж (жишээ нь: зарагдаж байгаа, бэлэн болсон хүзүүний зүүлт) хэрхэн хийсэн талаар асуух. Энэ арга нь юу хийхийг шаардаж байгаагаас хамааран хүндрэлтэй, толгой эргүүлсэн эсвэл шууд амжилтанд хүргэхгүй байж болох юм. Гэхдээ тодорхой, зөв чиглүүлсэний үндсэн дээр суралцагчийг аливаа даалгаварыг хэрхэн гүйцэтгэх боломжтой тодорхойлж болно.

в). Дадлагажуулах

Нэгэнт хэн нэгэн тухайн үйлдлийг хэрхэн гүйцэлдүүлэх талаар ойлгосон бол түүнийг ойлгосон зүйлээ бодитойгоор хийхийг хүсэж, удаа дараа хийлгэж шаардлагатай авхаалж самбаа, ур чадварыг хэвшүүлж болно. Дадлагажих сургуулилт нь сургалтын чухал арга гэдгийг ноён Хэм Хим хатагтай Шен Сопекийн жишээнээс харж болно.

Ноён Хэм Хим ноён Ханг Хатчид олс хэрхэн хийхийг заасан тухай

Ноён Хэм Хим 40 настай. Тэрбээр хараагүй ноён Ханг Хатчид мал аргамжих уяа хэрхэн хийхийг заасан. Хим урьд өмнө хэн нэгэнд зааж байгаагүй бөгөөд хэн нэгэнд өөрийн чаддаг юмаа заах, тэр бүү хэл хараагүй хүнд зааж чадна гэдэгт эргэлзэж байлаа. Тэрбээр ноён Хатчидийн суралцах, өөрийн заах авьяасыг хараад гайхсан байна. Хим дараах дөрвөн аргыг хэрэглэсэн талаараа ингэж ярьсан байна:

Биетээр үзүүлэх аргыг аль болох түлхүү хэрэглэх. Энэ нь харах боломжгүй хүмүүсийн хувьд үр дүнтэй. Би Хатчигийн гарын барьж байгаад олс хэрхэн томохыг заасан.

Суралцагчийн гарыг барьж хийж байгаа үйлдэл бүрээ алхам бүрээр нь, нэгт нэгэнгүй заасан.

Тэвчээртэй байж, эхэн үед хэцүү байна гэдгийг ойлгох хэрэгтэй. Ингэхийн тулд надад бас нилээн хугацаа шаардагдсан. Надад Хатчиг сургахад дадлага хийх шаардлага их гарсан. Хараагүй хүний хувьд түүхий эдийг тодорхойлох хэцүү, эхэн үед бүгд л адилхан санагдана.

Суралцагчийн гэр бүл, хөршүүд гэх харах боломжтой хүмүүсийн туслалцааг хэрэглэх хэрэгтэй. Жишээ нь би Хачигийн том хүүг аавдаа туслаг гээд бас жаахан юм зааж өгсөн.

Хамгийн үр дүнтэй хэрэглээ

- Аливаа юмыг хийж байгаад сурна гэдэг нь суралцагчийн ур чадварыг дадлагажуулах сайн арга
- Өөрөө хийж байж сурах нь дангаар, бусад аргатай хосолсон байж болно.
- Дадлагажиж суралцах нь хурд, чанарыг бий болгоход тусална.
- Зөв төлөвлөсөн сургалт нь суралцагчид өөртөө итгэх итгэлтэй болгоно.
- Хийх явцад суралцах нь мөн суралцагч хэрхэн суралцаж байгааг болон сургалтын явцыг үнэлэхэд хувь нэмэртэй

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

Сонсголын/ хэл ярианы бэрхшээлтэй суралцагчдад:

- Хийнгээ суралцах нь сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой. Энэ нь ярьж, хэлэхээс илүүтэйгээр харж сурах болмжийг олгодог.

Харааны бэрхшээлтэй хүмүүсийн хувьд:

- Биетээр хөтөлж үзүүлэх нь хараагүй хүмүүсийг сургахад сайн арга. Тэдгээрт үйлдвэрлэгдсэн, хийгдсэн бүтээгдэхүүнийг тэмтэрч мэдрэх боломжийг олгох хэрэгтэй. Та заах явцдаа тухайн үйлдлийг яах гэж хийж байгааг тайлбарлаж болно.

Суралцах чадварын хувьд хүндрэлтэй хүмүүст:

- Хязгаарлагдмал боловсрол болон сурахдаа удаан хүмүүст хийх явцдаа сурах нь чухал
- Үзүүлэх болон зааварчлах аргуудыг хослож заах нь зүйтэй. Эхлээд заах зүйлээ үе шатаар нь жижиг хэсэг хэсэг болгож хуваах. Суралцагчид үе шат бүрийг ажуухнаар үзүүлж, тухай бүрийг тайлбарлана. Үе шат бүрийг суралцагч ойлгож хийж чаддаг болтол нь давтах. Олон удаагийн давтамж хэрэг болох байх. Нэг үе шатыг дууссаны дараа дараачийн үе шатад дамжин орох. Дараа нь бүх үе шатуудыг нэгтгэж давтамж, дарааллыг зааж өгөх хэрэгтэй.

Зөвөлгөө

- Санаачлгатай байх хэрэгтэй. Хийнгээ суралцах аргыг олон янзаар гүйцэлдүүлж болно. Сурах явцыг сайжруулах, шаламгай, чанартай болгоход чиглэгдсэн маягаар сургалтын аргыг өөрчилж байх хэрэгтэй.
- Дадлагажуулах явцад дүгнэлт хийж, лавлагаа маягаар холбогдох асуултуудыг тавьж байх хэрэгтэй. Сайшааж магтах нь суралцагчийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж урам зоригтой болгох нь гарцаагүй. Алдаануудыг засах нь суралцагчийг буруу арга барилаар сурахаас урьдчилан сэргийлнэ.

Дүрд тоглох / жүжигчилсэн тоглолт

Дүрд тоглоно гэдэг нь тоглоом эсвэл жүжиглэлттэй адилхан байна. Энэ нь хөтөлбөр бэлдэх, дүрийг хуваарьлах болон жүжиглэхийг шаардах бөгөөд энэ суралцагчид суралцах боломжийг олгоход чиглэгдсэн байна. Дүрд тоглохыг олон нөхцөлд хэрэглэж болно. Жишээ нь, хэрэв та суралцагчийг хэрхэн үйлчлүүлэгчтэй харилцах талаар заах гэж байгаа бол жүжигчилсэн тоглолт зохион байгуулах

нь зүйтэй. Энэ тохиолдолд сургагч худалдан авагчийн дүрд орж (эсвэл өөр хүнээр тоглуулж болно) харин суралцагч нь дэлгүүрийн худалдагч/эзэн болно. Ингэснээр суралцагч худалдан авагч/үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцахыг сурах боломжтой болно. Өөр бас нэг жишээ бол суралцагчийг зах дээрээс түүхий эд худалдан авахад барааны үнийг буулгах талаар ярилцаж байгаагаар хийж болно. Сургагч нь дүрүүдэд оноогдох үүрэг, оролцоог нарийн боловсруулж, үйлдлүүдийг нь зохиосон байх хэрэгтэй бөгөөд оролцож байгаа суралцагч бүрийн үүрэг маш тодорхой байх хэрэгтэй. Дүрд тоглох хүмүүс уг асуудалд үнэн сэтгэлээсээ, ажил хэрэгч хандлагатай байлгах бүхий л арга хэмжээг авсан байна.

Хамгийн үр дүнтэй хэрэглээ

- Дүрд тоглох нь хүмүүсийг шинэ ур чадварт сургах сайн арга юм, ялангуяа бусадтай харилцах харилцааг сурахад хэрэгтэй. Хэрэв хүмүүс бусадтай харилцахдаа өөртэй итгэлтэй биш, ичимхий бол энэ аргыг хэрэглэснээр тэдгээрийг нүүрэмгий, өөртөө итгэлтэй байхыг заах боломж юм.
- Дүрийн тоглолт нь худалдаа эрхлэх зэргийн ээдрээтэй ур чадварыг суралцахад ихээхэн ач холбогдол бүхий арга. Худалдах, борлуулах үйл ажиллагаа нь хэн нэгэнтэй уулзах, тэдгээрийн хэрэгцээг тогтоох, санал болгож байгаа бараа, бүтээгдэхүүнээ бусдад сурталчлахыг шаардана. Эцэст нь борлуулагч нь худалдаагаа зогсоох эсвэл худалдан авагчаар бараа, үйлчилгээг худалдан авахуулна. Энэ нь үнэ, тээвэрлэлт, хүргэж өгөх хугацаа, бусад асуудлыг зохицуулахыг шаардана.
- Багаар хичээллэж байгаа тохиолдолд дүрд орж тоглох нь ур дүнтэй байхын зэрэгцээ зугаатай байх болно.
- Дүрд тоглохыг суралцагчдын мэдлэгийг сориход хэрэглэж болно. Жишээ нь, саяхан дурьдсан бараа борлуулах үйл явдлаас сургагч суралцагчийн хэл ярианы, борлуулах ур чадварыг үнэлэж болно. Сургагч мөн суралцагчийн борлуулахаар зорьж байгаа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үнэ өртгийн талаар хэрхэн мэдлэгтэй байгааг тодорхойлж болно.
- Дүрд тоглох нь мөн өөртөө итгэх итгэлийг бий болгож тодорхой хэвшмэл хэв маяг, тогтсон зан аашийг эвдэхэд тусална.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

Сонсголын/ хэл ярианы бэрхшээлтэй суралцагчдад:

- Суралцагч хир зэрэг бусадтай харилцах чадвартай байгааг бодолцож үзэх хэрэгтэй, учир нь дүрд тоглох нь ихэвчлэн ярианы болон бусад харилцааны хэлбэрүүдийг ихээхэн хэмжээгжкр шаарддаг.

Нийгэмших ур чадвар ядмаг суралцагчдад:

- Дүрд тоглохыг сонирхолтой, хөгжөөнтэй болгож оролцогчдыг зоригжуулах хэрэгтэй. Дүрд тоглох нь нийгмээс тусгаарлагдсан байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ниймийн харилцаа, сэтгэх ур чадварыг сайжруулахад хэрэгтэй байж болох юм.

Зөвөлгөө

Дүрд тоглох сургалтын арга нь дараах үе шаттай байж болно:

- Дүрд тоглох сургалтаар та юү сургах гэснийгээ тогтоож шийдвэрлэх хэрэгтэй. Энгийн тоглолтыг бэлтэг.
- Тоглолтын дүрүүдийг тогтоо. Танд хэдэн хүн хэрэгтэй, оролцогч болгон юү хийхийг талаар бодолц. Суралцагчид өөрсөдөө тоглож болно. Ер нь, тэдгээрийг өөрсөдийг нь тоглуулж, суралцуулах нь хамгийн зөв арга юм. Өөр хүмүүсийг бусад дүрүүдэд тоглуулах талаар тохиролц.
- Дүрд тоглох хүн бүр өөрөсдийн дүр, гол хэлэх зүйлээ мэдэж байх ёстой. Та сургалцагчдаас тусгайлан бэлдсэн нөхцлийг нууцалж болох юм. Жишээ нь, хэрэв та оролцогчийг түүхий эдийн барааны үнийг буулгахыг хүсэж байгаа бол худалдагчийн дүрд тоглох хүнд үнэ буулгахгүй байх тухай хэлсэн тухайгаа нөгөө хүнд нь мэдэгдэх хэрэггүй. Энэ маягаар суралцагч уйгагуй ярилцсаны эцэст юмны үнийг буулгаж болох талаар ойлголт авна.
- Тоглолт дууссаны дараа та суралцагчаас юуны тухай тоглолт байсан, юү сурсан талаар нь асууж, суралцагч ямар зүйлийг өөрөөр хийх байсан талаар саналыг нь сонсоно.
- Та дүрд тоглох тоглолтыг ур чадвар нэмэгдүүлэхийн тулд давтан ашиглаж болох бөгөөд энэ нь дадлагын хичээл шиг л байх болно.

Асуулт, даалгавар хэрэглэх

Асуулт асуух, даалгавар биелүүлэх арга нь ихэвчлэн өөр сургалтын аргуудтай хэрэглэгддэг. Асуулт, даалгаврыг хэрэглэх нь суралцагчдын идэвхитэй оролцоог хангах, тэдгээрийн мэддэг зүйл, таны заасан хичээлийг хэрхэн ойлгосоныг тодруулах сайн арга юм. Суралцагчид нь бие дааж таны асуултад хариулах эсвэл даалгаварыг биелүүлэх ёстой. Суралцагчид нь бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үйл ажиллагаа болон асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрсдийн мэдлэгийг ашиглан хариулна.

а)Асуултууд

Асуултууд бол суралцагч аливаа бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх суралцагчийн мэдлэгийг сорих боломж юм. Жишээ нь, та суралцагчаас ямар төрлийн хайч, тоног төхөөрөмжийг үйлчлүүлэгчийн үсийг засахад хэрэглэдэг талаар асууж болно.

Асуултууд нь илүү хүндрүүлсэн хэлбэртэй үйл явцтай байж болно. Жишээ нь, сургагч суралцагчаас тодорхой нөхцөл байдалын хувьд хэрхэн асуудлыг шийдвэрлэх тухай асууж болно. Тухайн нөхцөл байдал нь бодит эсвэл хийсвэр байж болно. Жишээ нь, сургагч гахай үржүүлэхийн тухай ярьж байгаад гэнэт гахайнууд өвчлөөд хорогдож эхлэх тухай яриад, энэ тохиолдолд яах тухай асууж болох болох юм. Гахай үржүүлж байгаа хүн яах ёстой вэ? Тэд хэнд хандах тусламж авах вэ? Сургагч бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар асууна. Өөр нэг жишээ бол бялуу хийдэг хүний тухай, тухайлбал Химер бялуу хийдэг хүнд хамааралтай байж болох юм. Сургагч Химер бялуу хийдэг хүн орцыг буруу хийчихсэн тухай ярь, яагаад бялуу амт муутай болсон шалтгааныг асууна. Энэ нь сурглцагч бялууны орцны тухай мэдэж байгаа эсэхийг мэдэхэд хэрэгтэй, хэрэв жорыг дагахгүй бол бизнес амжилттай байж чадахгүй. Хүмүүс амт муутай Химер бялууг авахгүй, харин суралцагч мөнгө болон цагаа дэмий үрэх болно.

б).Даалгавар

Суралцагчид өөрсдөө хийх даалгавар авна. Даалгавар нь олон зорилготой, жинхэнэ, тодорхой үр дагаваргүй байж болно. Даалгавар хийх нь өөрөө хийнгээ сурахтай адил болов ч арай хүндрэлтэй.Жишээ нь, сургагч тосгоноос эвдэрхий ундаг дугуй олж аваад засах даалгавар өгч болно. Даалгавар нь суралцагчид бизнест хэрэгцээтэй шинэ мэдээлэл авахад тусалдаг. Жишээ нь, суралцагч цамц хэрхэн оёхыг сурч, сургагч суралцагчийн тосгоны хүмүүс ямар өнгө, загварын цамц худалдан авах сонирхолтой байгааг мэдэх талаар даалгавар өгч болно. Энэ нь зах зээлийн эрэлт хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулахад сайн арга юм.

Хамгийн ур дүнтэй хэрэглээ

- Асуулт, даалгавар гүйцэтгүүлэх нь суралцагчдаас бодож, өөрсдөө хийхийг шаардана. Энэ аргаар суралцагчид юу хийхийгээ үнэхээр ойлгосон талаар мэдэж авах боломжтой. Энэ нь суралцагчидын бүтээлч санаа, санаачлагыг хөгжүүлнэ.
- Асуулт, даалгавар гүйцэтгүүлэх шалгалт, сургалтыг өндөр зарлага гаргалгүйгээр хийх боломж олгох боломжтой. Жишээ нь, Химерын бялуу хийх ажиллагааг заавал биечлэн хийлгэлгүйгээр зөвхөн орцыг нь зөв тааруулж байгаг, дарааллыг нь зөв баримтлаж байгааг шалгаж болно. Мөн энэ нь орцын хэмжээг буруу хэмжиж хийвэл ямар үр дүнд хүрэхийг харуулж болох юм.
- Энэ аргуудыг бизнесийн үйл ажиллагааг бий болгох, хэрэгцээтэй шинэ мэдээллийг олох зорилгоор ч мөн хэрэглэж болно. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ ихтэй байгаа өнгө, загварын цамцын талаар зах зээлийн судалгаа хийж мэдэж авах тухай ч даалгавар өгч болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

- Сонсголын/ хэл ярианы бэрхшээлтэй суралцагчдад:Асуулт болон даалгавар гүйцэтгүүлэх арга хэрэглэж байгаа тохиолдолд суралцагчийн бусадтай харилцах боломжийг бодолцож үзсэн байх хэрэгтэй. Сонсголын бэрхшээлтэй хүний хувьд зах зээлийн судалгаатай холбогдох асуудлалд хамааралтай даалгаврыг хамтрагчгүйгээр эсвэл бичгээр өгсөн тайлбар болон бусад материалгүйгээр гүйцэлдүүлэх нь хүндрэлтэй байж болох юм.
- Суралцах чадварын хүндрэлтэй хүмүүст:Даалгавар болон асуултуудыг ойлгомжтой байлгахын тулд маш энгийн хэлбэрээр бэлтгэх,Оюуны чадварын хувьд арай дээгүүр хүмүүст хүндрүүлсэн асуулт, даалгаварыг тусгайлан өгөх

Зөвөлгөө

- Сургалтын техникээс илүүтэйгээр асуултуудыг ашиглах
- Суралцагчийн ойлголтын шалгахын тулд энгийн дааргаваруудыг өгөх
- Суралцагчдын мэдлэгийг шалгахын тул арай хүндрүүлсэн асуулт, даалгаварыг хэрэглэх
- Хүндрүүлсэн нөхцөл байдалд даалгаваруудыг өгөхийн өмнө тодорхой хэмжээгээр дадлагажуулж туршлага хуримтлуулах боломж олгосон байх
- Суралцагчийн дадлагажсан байдлыг бодолцож үзэж байх. Хүнд асуулт, даалгаварууд нь ээдрээтэй байдлыг үүсгэж бүтэлгүйтэхэд хүргэж болох тул суралцагчийн өөртөө итгэлтэй байдлыг хөгжүүлэхэд анхаарч байх хэрэгтэй.

Газар дээр нь очиж үзэх

Газар дээр нь очиж үзүүлэх үйл ажиллагаа нь үйлдлийг гүйцэтгэж байж сурах буюу шинээр нээх, дадлагажуулахтай ерөнхийдөө төсөөтэй боловч арай өргөн хүрээтэй байдаг. Энэ үйл ажиллагаа нь бизнес амжилттай явагдаж байгаа газрын үйл ажилаагаатай газар дээр очиж танилцах, сонирхол, туршлага судлах боломжийг олгох боломж олгохын зэрэгцээ тодорхой ур чадварыг эзэмшихэд дөхөм байх болно. Жишээ нь, хэрэв та гахай үржүүлэх талаар зааж өгч байгаа бол гахай үржүүлдэг фермийн үйл ажиллагаатай танилцуулж болно. Эсвэл суралцагчдыг банкин дээр аваачиж зээлийг хэрхэн яаж, ямар нөхцөлтэйгээр олгодог талаар танилцуулж болох юм. Газар дээр нь очиж танилцах үйл ажиллагааг ихэвчлэн жижиг бүлгүүдээр зохион байгуулдаг боловч тусгайлсан ганцаарчилсан хэлбэрээр мөн зохион байгуулах боломжтой юм. Зарим төлийн танилцах үйл ажиллагаа мөн өндөр зардалтай байж болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хэрэв таны зааж буй бизнестэй холбогдуулан албан бус сургалт явагддагүй бол ойролцоо төрлийн бизнесийн үйл ажиллага эрхэлдэг бизнестэй ч мөн танилцуулж болно. Суралцагч нь бизнесийг хэрхэн зохион байгуулж, зохицуулж, үйл ажиллагааг нь явуулж байгаа байдалтай газар дээр нь танилцах хэрэгтэй. Суралцагч таны эрхэлдэг бизнест ажиллаж байгаа ч гэсэн түүнийг ойролцоо үйл ажиллагаа эрхэлдэг өөр байгууллагын үйл ажиллагаатай таницуулж байх нь зүйтэй. Жишээ нь, хэрэв та өөрийн суралцагчид мал аргамжих, уяах зэргэг хэрэглэгддэг уяа хийхийг зааж байгаа бол зах дээр аваачиж тус уяаг хэрхэн хэрэглэдэг, борлуудаг талаар танилцуулж байх нь зүйтэй.

Хамгийн үр дүнтэй хэрэглээ

- Газар дээр нь очиж үзүүлэх суралцагчдад нэг зүйлийг өөр өөр арга барилаар хийж болохын харах боломж олгодогоороо онцлогтой
- Энэ арга нь суралцагчдыг урам зоригтой, зорилготой болгоход тусална
- Газар дээр нь очиж үзүүлэх аргыг бусад сургалтын аргуудтай хослуулан хэрэглэж байх хэрэгтэй, тухайлбал асуулт асуух, даалгавар гүйцэлдүүлэх аргуудтай. Жишээ нь, суралцагч нь тухайн үйл ажиллагаатай танилцсан бизнесийн ашгийн тооцоог гаргаж болох юм. Эсвэл тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай үе шатуудын талаар асууж болно.
- Бизнесийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлтэй хамааралтай дадлага, туршлагатай суралцагчдын хувьд бизнесийг газар дээр нь очиж үзэх нь тэдгээрт асуулт тавих, зарим зүйлийг ойлгож авах зэрэг боломжуудыг олгох болно. Бизнесийн үйл ажиллагаа явуулаад эхэлчихсэн, өөрийн бизнесийг сайжруулах хүсэлтэй Суралцагчдад энэ нь мөн амжилттай явагдаж буй бизнесийн үйл ажиллагаатай танилцаж туршлага хуримтлуулах боломжийг олгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зааж байгаа тохиолдолд анхаарах зүйлс

Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн хувьд:

- Үйл ажиллагаатай нь танилцахаар товлосон газар нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орох, гарах нөхцлийг бүрдүүлсэн байх хэрэгтэй. Та түшлэг, саад, тээвэр, аюулгүй байдал, бусад холбогдох асуудлыг бодолцож үзсэн байх хэрэгтэй.

Сонсгол, хараа, ярианы эсвэл суралцах чадварын хувьд хүндрэлтэй хүмүүсийн хувьд:

- Сонсгол, хараа, ярианы эсвэл суралцах чадварын хувьд хүндрэлтэй хүмүүст зориулж нэмэлт тайлбар хийх, тусгайлан үзүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор зарим нэг туслалцааг зохион байгуулах.

Зөвөлгөө

- Үйл ажиллагаатай нь танилцахаар товлосон газрын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамран ажиллахад татгалзах, дургүйцэх зүйлгүй гэдгийг урьчилсан байдлаар мэдсэн байх хэрэгтэй бөгөөд тус байгууллагын төлөөлөл тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжиж зоригжуулж байх нь чухал.
- Тухайн үйл ажиллагаа нь бүлгийн зохион байгуулалттай явагдахаар бол энэ талаар холбогдох арга хэмжээг авсан байх хэрэгтэй. Танилцуулах үйл ажиллагаа нь сургагч өөрөө, эсвэл ур чадварын хувьд түүнтэй нэг төвшний хүн байх.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байхын зэрэгцээ үр дүнг урьдчилан тооцсон байх
- Суралцагч/суралцагчдыг газар дээр нь очиж үзэх, танилцах үйл ажиллагаанд урьдчилан бэлтэгсэн байж, тэдгээр уг үйл ажиллагааны ач холбогдол, зорилт, хүлээгдэж буй үр дүнгийн талаар мэдүүлсэн байхын зэрэгцээ асуулт асуух талаар зөвөлгөө өгөх
- Газар дээр нь очиж үзэх, танилцах үйл ажиллагааг дүгнэх, санал солилцоход суралцагчидыг идэвхийтэй оролцуулах арга хэмжээ авах.

Хавсралт 8.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах

Олон ажил олгочид хөгжлийн бэрхшээлтэй ажилчид болон ажиллагчдын үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдсээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах шинэ төрлийн хандлага нь компани, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар болон ерөнхий амжилттай байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулах боломжтой гэдгийг харуулж байна. Компаний нийгмийн ухамсарыг дээшлүүлэх, нийгэмд эерэг хувь нэмэр оруулах зарчмууд нь ажилчид, ажиллагчидын эгнээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оруулах хандлагыг бий болгож байна. Ингэх авцад ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сайн ажиллагчид байдаг юм байна гэдгийг ойлгох болжээ. Тэрч бүү хэл, судалгаанаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сахилга бат, бүтээмж, аюулгүй байдал зэрэг үзүүлэлтүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлгүй ажиллагчдаас давамгайлдаг байна. Түүнчлэн компаниуд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсанаар хамт олны ёс зүй болон багаар ажиллах чадвар дээшилсэн гэсэн үзүүлэлтүүд ч байдаг байна.

Ухаалаг бизнесийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн мөн үйлчлүүлэгч болдог байна. АНУ, Канад, Англи зэрэг улсуудын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 275 тэрбум долларын ашиг оруулсан тооцоо гарсан байгаа бөгөөд энэ нь бизнесийн зах зээлийн хувьд чамлахааргүй үзүүлэлт юм. Мөн хүн амын нас нэмэгдэх тусам зах зээл өснө гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авснаар дээрх зах зээлд нэвтрэн орох боломж нээгдэх болно.

Хэдийгээр зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд тусгай тоноглогдсон ажлын байр хэрэгцээтэй гэх боловч үнэ, өртгийн хувьд энэ нь төдийлөн өндөр биш байдаг бөгөөд тэр нь ихэвчлэн өндөрсөж намсдаг ширээ, арай урт хугацааны сургалт зэргээр л ихэвчлэн хязгаарлагддаг байна. Түүнчлэн эдийн засгийн хэмнэлтийн хувьд хөрөнгө оруулалт, дадлага туршлага, тогтвор суурьшилтай ажиллах зэрэг талаасаа илүү ашигтай тусдгийг дурьдах нь зүйтэй юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй, гэмтэсэн ажиллчид болон ажиллагчидад ажил олгох нь бизнесийн хувьд дараах талаараа эерэг байдаг байна:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сайн, найдвартай ажиллагчид байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сахилга бат, бүтээмж болон аюулгүй байдал гэх үзүүлэлтүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлгүй ажиллагчидаас давамгайлдаг гэх ажил олгогчид тодорхойлсон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тогтвор , суурьшилтай ажиллах магадлал илүү өндөр байдаг. Ихэнх ажил олгогчдын мэддэг ажилчид болон ажиллагчидыг солиход гардаг сургалт, сул зогсолт зэргийн хувьд хэмнэлттэй байдаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсанаар нийт ажиллагчидын ёс зүй дээшилдэг. Олон ажил олгогчид ёс зүй болон багаар ажиллах хүсэл эрмэлзэл тухай байгууллагын нийт ажиллагчидын хувьд нэмэгдсэн талаар мэдэгдсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь ур чадвар, авьяас билгийн эх сурвалж болдог. Олон улс, орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаарлагатай ур чадвар, бизнесийн шаардлага хангасан техник, өдөр тутмын асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээтэй ур ухаантай гэдгээ харуулсан байдаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь анзаарагдаагүй орхигдсон боловч олон тэрбумаар үнэлэгдэх том зах зээлийг бүрдүүлдэг. Энэ зах зээлд тэдгээрийн гэр бүлийн гишүүд, найз нөхөд хамаардаг байна. Тэдний нэг жилийн оруулдаг орлого АНУ-ын хувьд 200 тэрбум доллар байдаг бол Англид 50 тэрбум, Канадад 25 турбум доллар тус тус байдаг байна. Энэ зах зээлийг үл ойшооно гэдэг нь үйлчлүүлэгчийн хувьд зөвхөн тэднийг алдахаас гадна тэдний гэр бүлийн гишүүд, найз нөхдийг алдана гэсэн үг юм. Хүн амын нас ахих нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөөр байна. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй ажиллагчидтай байна гэдэг нь тэдэнд шаардлагатай, тэдний хэрэгцээг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэгтэй байх давуу талыг олгож байгаа юм.

Дараах мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үйлчлэх зорилго, чиглэл бүхий үйл ажиллагаа явуулдаг томоохон олон улсын хэмжээний ТББ-уудад хамааралтай бөгөөд эдгээр байгууллагуудаас хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн бэрхшээлтэй хамааралтай үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний байгууллагуудын талаарх мэдээлэл авах боломжтой.

Хөгжлийн бэрхшээл, хөгжлийн үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг дэмжих олон улсын хөгжлийн агентлаг, өөрийн улсын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тухай мэдээллийг тус агенлагийн вебсайтнаас авч болно. Вебсайт: www.add.org.uk

Хавсралт 8.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд

Ази Номхон далайн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн төв
Ази болон Номхон далайн бүс нутагт үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадавхижуулах, тэдэнд тулгарч буй саад, бэрхшээлийг арилгах чиглэлийн үйл ажиллагаа явуулах бүс нутгийн төв
Asia-Pacific Development Center on Disability Building
Rajavithi Rd. Rajthevee
Bangkok 10400, Tailand
Tel: +66(0)2354 7505, +66(0) 2354 3525 29
Fax: +66(0)2354 7507, +66(0) 2354 3530
Info@apcdproject.org
http://www.apcdproject.org

Хараагүй хүмүүсийн Загалмайтны нийгэмлэг
Бэрхшээлтэй хүмүүсийн багууллага (зөвхөн харааны хөгжлийн бэрхшээс гадна бусад хөгжлийн бэрхшээл хамаарна), вебсайтнаас өөрийн улсад хамаарах боломжтой мэдээллийг авна уу.
Nibelungenstrasse 124
64625 Bensheirn
Germany
Tel: +49 6251 131 392
Fax: +49 6251 131 338
http://www.cbm.org

Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын олон улсын сүлжээ. Гишүүн орнуудын талаар мэдээллийг вебсайтнаас харна уу.
874 Topsail Road
Mount Pearl
Newfoundland AIN 3J9
Canada
Tel: +1 709 747 7600
Fax: + 709 747 7603
Info@dpi.org
http://www.dpi.org

Олон улсын тахир дутуу иргэдийн байгууллага
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага. Төлөөлөгчийн газруудын талаарх мэдээллийг вебсайтнаас харна уу.
http://www.handicap-international.org

Оролцоо Итернэшинал
Оюун санааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийхэнд дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий байгууллага. Гишүүн орнуудын талаар мэдээллийг вебсайтнаас харна уу.
c/o The Rix Centre University of East London Docklands Campus London E16 2 RD, UK
Tel: + 44 (0) 208 223 7709 ; +44 (0) 208 223 7411
info@inclusion-international.org
http://www.inclusion-international.org

Юуны түрүүнд хүмүүсийг
Суралцах чадварын бэрхшээлтэй хүмүүсийн дэмжих үйл ажиллагаа эрхэлдэг, суралцах чадварын бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага.
Hampton House, 4th Floor
20 Albert Embankment
London SE1 7TJ, UK
Tel: +44 20 7820 6655
Fax: +44 20 7820 6621
general@peoplefirst.com
http://www.peoplefirst.com

Олон улсын нөхөн сэргээх байгууллага
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрт зориулсан үйлчилгээ, судалгаа, төрийн байгууллага, нөлөөлөлийн үйл ажиллагаа эрхэлсэн олон улсын байгууллага. Гишүүн байгууллагуудын талаарх мэдээллийг вебсайтнаас харна уу.
25 East 21 street, 4th Floor
New York, NY 10010, USA
Tel: +1 212 420 1500
Fax: 1 212 505 0871
ri@riglobal.org
http://www.riglobal.org

Хөдөлмөрлөх боломж Интернэшинал
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт болон халамж үйлчилгээг дэмжих чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага. Гишүүнчлэлийн талаах мэдээллийг вебсайтаас харна уу.
42, rue des Ecureuils
Asnieres, Sante Soline
79120, Deux Sevres, France
Tel/Fax: +33 (0) 5 49 29 54 38
secretariat@workability-international.org
http://www.workability-international.org

Дэлхийн хараагүй хүмүүсийн холбоо
Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын ТББ. Гишүүн байгууллагуудын талаарх мэдээллийг вебсайтаас харна уу.
World Blind Union Office
1929 Bayview Avenue
Toronto Ontario, Canada M4G 3E8
Tel: + 1 416 486 9698
Fax: + 1 416 486 7269
info@wbuoffice.org
http://www.worldblindunion.org

Дэлхийн санаачилга
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг хамруулсан гамшигт нэрвэгдэгчдэд тусламж үзүүлэх ТББ.
info@worldconcern.org
http://www.worldconcern.org

Оюун санааны өвчний дэлхийн холбоо
Оюун санааны өвчний ангаах, өвчтөнүүдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр байгууллага, хувь хүмүүстэй хамран ажиллах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг, энэ асуудлаарх боловсрол, өвсний үндэс хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага.
6564 Loisgate Court, Suite 301
Springfield, VA 22150-1812, USA
Tel: + 1 703 313 8680
Fax: + 1 703 313 8683
Info@wfmh.org
http://www.wfm.org

Дэлхийн сонсголгүй хүмүүсийн холбоо
Сонгсголгүй хүмүүсийн үндэсний байгууллагуудыг төлөөлөх олон улсын ТББ. Гишүүн орнуудын талаарх мэдээллийг вебсайтаас харна уу.
P.O.Box 65
FIN-00401
Helsinki, Finland
Fax: +358 580 3 572
Info@wfdeaf.org
http://www.wfdeaf.org

Дэхийн сонсголгүй болон хараагүй хүмүүсийн холбоо
Сонсголгүй болон хараагүй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах үндэсний байгууллагуудыг төлөөлөх олон улсын ТББ. Гишүүн орнуудын талаарх мэдээллийг вебсайтаас харна уу.
Snehvidevej 13
DK 9400 Noerresundby, Denmark
Tel: + 45 98 19 20 99
Fax: + 45 98 19 20 57
Lex.grandia@mail.dk
http://www.wfdb.org/

Сэтгэлзүйн өвчний олон улсын сүлжээ
Сэтгэлзүйн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллага болон хувь хүмүүсийн олон улсын байгууллага.
Store Glasvej 49
5000 Odense C, Denmark
Tel: +45 66 19 45 11
admin@wnusp.net
http://www.wnusp.net

Хавсралт 8.7. НЭР ТОМЬЁО

ХАМРАГДАХ БОЛОМЖ (МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ)
Ажилд шаардлагатай мэдлэг, ур чадварыг олж авах мэргэжлийн боловсролын сургалтын боломж нь хувь хүмүүс, бүлэг хүмүүс, үйлдвэрлэлд нээлттэй. Хамрагдах боломжийг боловсрол, сургалтын бодлого, системийн шудрага байдал тогтооно. Хамрагдах боломж нь элсэлтийн шалгуур үзүүлэлт (жишээ нь: боловсролын түвшин), бодит нөхцөл (сургалтын байгууллагын байршил), эдийн засгийн хүчин зүйлс (боловсролын,сургалтын үйл ажиллагааны өртөг), нийгэм, соёлын зан заншил (тодорхой бүлгүүдэд хандах хандлага), хувийн (хөгжлийн бэрхшээл) төлөв байдал зэргээс хамаарна.

ХАМРАГДАХ/ ОРОЛЦОХ НӨХЦӨЛ БОЛОЛЦОО
Хамрагдах нөхцөл бололцоо нь бусадтай эрх тэгш байдлын зарчим дээр бодит орчин, тээвэрлэлт, мэдээлэл, харилцаа, мэдээлэл харилцааны технологи, систем, бусад хот суурин газар, хөдөө орон нутагт бүх нийтэд нээлттэй барилга байгууламжид орох, үйлчилгээг хүртэх, хамрагдах байдал.

ХЭРЭГЦЭЭТЭЙ ОРЧНООР ХАНГАГДСАН БАЙХ
Наад захын хэрэгцээнд нийцсэн орчноор хангагдсан байх гэдгийг харна уу.

СУРГАЛТЫГ БАТЛАМЖЛАХ
Сургалтын дамжаа, хөтөлбөр, сургалт явуулахыг эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрч батлах.

ЭЕРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА
Боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн, өнгөрсөн үед байсан ялгаварлан гадуурхалыг арилгахад чиглэгдсэн тодорхой бодлого эсвэл хөтөлбөрийн цогц арга хэмжээ.

ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
Суралцагчид, сургагчид, сургалтын арга зүй, хөтөлбөр, сургалтыг зохион байгуулагч байгууллагын үйл ажиллагаа нь шаардлагатай стандартад нийцэж байгаа эсэхийг шалгахад чиглэгдсэн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх бүхий л аргачлалууд.

ШААРДЛАГА ХЭРХЭН ХАНГАЖ БАЙГААГ ТҮВШИНГ ТОГТООХ
Шаардлага хангасан байдал дээр үндэслэх гэх хэсгийг харна уу.

ТУСЛАХ ТӨХӨӨРӨМЖ
Тухайн хүнд тодорхой даалгаварыг гүйцэлдүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд зориулагдаж тодорхой загвар эсвэл хийц бүхий төхөөрөмж.

ДУУ АВИАНЫ БОЛОН ДҮРС БИЧЛЭГИЙН ТУСЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
Сургалтын явцад хэрэглэгдэх дуу авианы, дүрс бичлэгийн, суралтын зориулалт бүхий тусгай туслах тоног төхөөрөмж. Үүнд: зурагт, кино, слайд, дүрс бичлэг, дуу, авиатай слайд зэрэг хамаарна.

БРАИЛЛЕ
Хараагүй эсвэл харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан, гараар тэмтэрч уншдаг, тодорхой зай бүхий товгор цэгүүдээр тэмдэглэсэн бичвэр.

ГЭРЧИЛГЭЭ
Тодорхой төрлийн сургалтад амжилттай оролцож дүүргэсэн гэснийг албан ёсны нотлох баримт

ШААРДЛАГА ХАНГАХ
Тухайн ажил, мэргэжилд тавигдах стандартын шаардлагыг хангасан хэмжээнд даалгавар эсвэл үүргийн гүйцэтгэх чадвараа харуулсан байдал.

ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙДАЛ ДЭЭР ҮНДЭСЛЭХ
Тухайн хүн тавигдах зорилтыг биелүүлэхэд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг явуулж үйл ажиллагаа, эд мөрийн баримт дээр тулгуурлан хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр тогтоохыг хэлнэ. Тогтоосны үр дүнд тухай хүн уг ажлыг гүйцэтгэхэд “хангалттай ур чадвартай” эсвэл “одоогоор хангалттай ур чадваргүй” дүгнэлт гарна.

ТАВИГДАХ СТАНДАРТ ШААРДЛАГА
Тухайн салбар, мэргэжилд үр дүнтэй ажиллахад шаардлагатай ур чадвар, мэдлэг, тухайн ажилд хандах төлөв байдалд нийцсэн эсэхийг тодорхойлох шалгуур үзүүлэлүүдийн цогц.

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР
Сургалтын зорилго, агуулга, үргэлжлэх хугацаа, хүлээгдэж буй үр дүн, сургах, суралцах арга зүйн талаар тодорхой тусгасан баримт.

ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН СУРГАЛТ
Салбарын нийлүүлэлт, хэрэгцээгээр тодорхойлогдсон сургалт.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ
ОУХБ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дараах байдлаар тодорхойлсон: физиологийн болон оюун санаааны дутагдлаас чадвар нь үлэмж хэмжээнд багассан гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн, тодорхой хөдөлмөр эрхлэлтэд шаардагдах нөхцлийг хангах боломжгүй хүнийг хэлнэ. (ОУХБ-ын Мэргэжлийн Нөхөн Сэргээлт болон Хөдөлмөр Эрхлэлтийн Конвенц(Хөгжлийн бэрхшээлтэй хүн, (№159), 1983).

НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийн Конвенцид: Удаан хугацааны физологийн, оюун санаааны, сэтгэхүйн эсвэл мэдрэмжийн дутагдлаас болон өөрсдийн бүрэн хүчин чадлаар нийгмийн амьдралд бусадтай адил эрх тэгш байдлаар оролцох боломжгүй гэж тодорхойлсон байна. (НҮБ-ын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Конвенцийн Нэгдүгээр зүйл).

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сургалтын хэрэгцээг тодорхойлох, тухайн чиглэлээр сургалт явуулах байгууллагуудад зааварчилгаа өгөх чиг үүрэг бүхий багийн гишүүн бөгөөд түүний ажил үүргийн хуваарьт мөн сургалтыг зохион байгуулахад бүхий л төрлийн дэмжлэг үзүүлэх асуудал ч мөн хамаарна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ
Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ямарваа нэгэн байдлаар ялгаварлаж эсвэл дорд үзэх хандлагаар боломж олгох эсвэл адил тэгш харилцахыг үгүйсгэж байгаа үйлдлийг хэлнэ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ
Тухайн хүнд байгаа ажил, хөдөлмөр эрхлэх боломж, чадвар, боловсролын болон сургалтын явцад олж авсан ур чадварыг ашиглаж өөр нийцсэн ажил эрхлэх, үйлдвэрлэл , өөрчлөгдөж буй технологи, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагаар хөрвөж, өөрийн ажлаа хадгалан үлдэх чадамж.

ЭРХ ТЭГШ БОЛОМЖ
Өөрийн нийгэм-эдийн засгийн байдал, хүйс, нас, яс үндэс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх болон бусад суралцах нөхцлүүдээс үл хамааран бусадтай адил суралцах нөхцлөөр хангагдсан байх.

ШУДРАГА, ЭРХ ТЭГШ
Хөдөлмөр эрхлэлт, сургалтад эрх тэгш оролцох боломж.

ХӨГЖЛИЙН СААД
Сэтгэл зүйн болон физиолог (бие мах бодь)-ийн аливаа хэсгийн дутагдал эсвэл ер бусын байдал/дутуу хөгжил.

АЖИЛ
Орон тооны, цагийн, түр зуурын гэх аливаа хэлбэрийн хөдөлмөр эрхлэлт.

АЖЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ
Тухайн ажилд хамаарах ажлын агуулага, хүн авах гэж буй ажлын байрны тодорхойлолт, ажилд орох хүнд тавигдах шаардлага, тухайн ажилд орохыг хүсэгчдэд хамаарах зааварчилгаа, сургалт зэргийг тогтоох дүн шинжилгээ.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ
Салбарын хөдөлмөрт шаардлагатай, эрэлт хэрэгцээтэй байгаа хөдөлмөрийн хүчний нийлүүлэлт (ажил хайж буй хувь хүмүүс).

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ
Унших, бичих чадвар, (үүнд бичмэл материалыг уншиж ойлгох зэрэг хамаарна.) Жишээ нь номноос, хүснэгтээс эсвэл тэмдэглэл гэх мэт.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР
Тухайн хөгжлийн бэрхшээл эсвэл гэмтэл согог анагаах ухааны талаасаа бэрхшээл, хүндрэл хэмээн харагдаж байгаа, эмнэлгийн аргаар шийдвэрлэх арга зам, тухайн өвчтнийг “анагаах” эсвэл биеийн байдлыг дээрдүүлэх эм зүйн эсвэл нөхөөн сэргээх арга.

МНЕМОНИК / ТУС ДӨХӨМ
Мнемоник ойролцоо, харилцан хамаарал бүхий юмс эсвэл ямарваа нэгэн хамааралгүй, шинэ юмыг илэрхийлнэ. Жишээ нь, аливаа жагсаалттай юмсыг цээжлэх, санахад тухайн үгсийн эхний үсэг орсон үгээр томъёолж цээжлүүлэх, эсвэл тухай үгний утгыг илэхийлж байгаа санаатай холбогдож болох эд зүйлс, нэр, дүрс, зураг зүйлээр санаа авахуйц байдлаар цээжлүүлэх.

МОДУЛИАР СУРГАЛТ
Жижиг бие даасан бүрэлдэхүүн хэсэг болгон хуваасан сургалт. Эдгээр хэсгүүдийн тухайн хувь хүний хэрэгцээнд нийцүүлэх, сонгож авч сургалтын хөтөлбөр болгож болгодог.

МОДУЛЬ
Сургалтын нэг болон түүнээс олон тооны өвөрмөгц сургалтын нэгж эсвэл бүрэлдэхүүн хэсгүүдийг нэрлэх бөгөөд эдгээрийг нэгтгэж сургалтын курс болгодог байна.

ТООНЫ МЭДЛЭГ
Тоолох, хэмжих, тооцоолох, математик мэдээллийг боловсруулах чадвар.

МЭРГЭЖЛИЙН ЗААВАРЧИЛГАА
Тухайн хүнд ямар ч нас,амьдралын алива үед боловсрол олох, сургалтад хамрах, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаатай холбогдох сонголт хийх, уг ажил мэргэжлээрээ өсөж, дэвжихэд дэмжлэг үзүүлэх, хэрэгцээтэй үйлчилгээгээр хангах үйл ажиллагааг хэлнэ.

ҮР ДҮН
Хөдөлмөр эрхлэлт, албан тушаал дэвших, хөдөлмөр эрхлэлтийн хувьд өсөх зорилгоор тодорхой сургалтад хамрагдсны үр өгөөжийг хэлнэ.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН
Физиологийн болон оюун санааны дутагдлаас аюулгүй байдлаа хангах, бие авч явах, хөдөлмөр эрхлэлтийн боломж нь тодорхой хэмжээнд хязгаарлагдсан эсвэл үлэмж хэмжээнд багассан гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг хэлнэ.

БОЛОМЖИТ НААД ЗАХЫН ХЭРЭГЦЭЭТЭЙ ТОНОГЛОЛ
Зайлшгүй шаардлагатай, тохиргоо, нэмэлт хийсэн, зохистой, шаардлагагүй хүндрэлийг учруулахгүй байхад зориулагдсан тоноглолыг хэлнэ. Эдгээр тоног тоноглол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийн эрхэлж буй үйл ажиллагааг бусадтай адил нөхцөлд гүйцэлдүүлэх боломжийг олгох зориулалттай бөгөөд энэ нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг баталгаажуулах нэгэн арга юм.

ДОХИОНЫ ХЭЛ
Гарын хөдөлгөөн, нүүрний хувирал, бусад биеийн хэсгээр дохиж, зангах хэлбэрээр илэрхийлэгддэг хэл бөгөөд үүнийг ихэвчлэн сонсголгүй хүмүүс хэрэглэдэг байна.

ДОХИОНЫ ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧ
Дохионы хэлний орчуулагч гэдэг нь ярианы хэл болон дохионы хэл хоорондын орчуулгыг гүйцэтгэхээр сургагдсан хүнийг хэлнэ.

УР ЧАДВАР
Сургалт, дадлагын замаар олсон оюун санааны болон хөдөлгөөний чадварыг хэлнэ.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН НИЙГМИЙН ЗАГВАР
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхитэй, бүрэн дүүрэн оролцоход саад болж буй бэрхшээлүүдийг бий болгож байгаа загвар.

ДААЛГАВРЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ
Ажлын дүн шинжилгээний хэсэг болж болох, тухайн ажлыг гүйцэтгэхэд хийх шаардлагатай тодорхой үйлдлүүдийг тогтоож, тодорхойлох зорилгоор хийгддэг дүн шинжилгээ. Үүнд мөн үндсэн, давтан, ургэлжилсэн хэлбэрийн сургалтуудын асуудал хамаарахын зэрэгцээ ерөнхий боловсролын асуудал ч мөн үүнд хамаарч болно.

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН СУРГАГЧ
Суралцагчдад шаардлагатай техник, практик ур чадварын сургалтын явцад хяналт тавих үүрэг бүхий сургагч.